

АЙВЕНГО

Вальтер Скотт



Вальтер Скотт

Айвенго

www.kiebooks.com

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Цадталаа идэвч сэтгэл ханаагүй гахай
Чахлаж орилсоор хонууртаан дөхөж
Холын билчээрт гарсан сүрэг мал
Хотлох тэрхэн чөлөөнд ярилцжээ тэд*

Поп "Одиссея"

Хөгжүүн Англи ирж, ден голын усанд тэжээгдсэн таатай нутагт Шеффилд Донкастер хоёрын хоорондох уудам хөндий толгодыг урьдын цагт өргөн их ой бүрхэж байж билээ. Вентворын цайз, Уориклиффийн цэцэрлэг болон Ротергемийн орчимд тэрхүү сүрлэг ойн үлдэгдэл өнөө хүртэл бий бүлгээ. Урьд цагт цонтлейн үлгэрийн нэрт айхавтар луу энд орогнодог байсан домогтой, цагаан, улаан сарнайнуудын хоорондох дотоодын ширүүн тулалдаан энд явагддаг байсан. Мөн алдар гавьяа нь ардын дуунд магтагдсан зоригт тээрэмчдийн бүлгүүд энд бужигнаж байсан билээ. Манай туужийн үйл явдал ийм газарт болсон юм. Өгүүлэгдэх зүйл нь нэгдүгээр Ричардын хаанчлалын сүүлийн жилүүдэд, хааныг удтал олзлогдон байх зуур зүсэн бүрийн хавчлага дарлалд нухлагдан цөхөрсөн албат ардууд нь хаанаа эгэж ирэхийг хүсэх боловч нэгнээ боломж нөхцөлгүй ажил мэт санагдах болсон үед гарсан явдлууд юм.

Стефаны хаанчлалын үед зүйргүй их эрх мэдэл олж авсан феодалууд хоёрдугаар Генрихийн мэргэн бодлын үрээр хааны төрд хагас дугуу боловч захирагдах болж чадсанаа одоо дахин дур мэдэн аашлаж, английн төрийн зөвлөлөөс тэдний дур зоргоороо загнахыг хязгаарлах гэсэн сулбар оролдлогыг огтхон ч үл ойшоох болов. Феодалууд цайзаа бэхэлж, айл хөршийн хүмүүсийг албат хамсаатнаа болгон нэгтгэхээр ойртон буй төрийн самууны үед өөрсдийгөө жин нөлөөтэй хүн байлгахуйц хэмжээний цэрэг эртэй болохыг тус бүрдээ мэрийнэ. Жижиг эдлэнтэй тайж нарын байр суурь тэр цагт тун ч хөнгөн, тэднийг франклинууд гэж нэрийдэх бүлгээ. Жижиг тайж нар нутаг орныхоо нөлөөтэй ихсийн аль нэг өмөг түшигт багтаж гэр оронд нь алба хаах буюу харилцан туслах тэнхрүүлэх талаар хэлэлцэн тохирч цаад феодалын цэрэг дайны үйлд хүчин зүтгэвээс нэг хэсэгтээ амар жимэр байж болохсон бүлгээ. Ихэнх жижиг тайж нар ер нь тэгдэг ч байсан. Тэгэхийн хамт эрх чөлөөгөө золиосонд гаргаж, нэр төр хөөцөлдөгч өмөг түшгийнхээ элдэв хуудуу болчимгүй явдалд хамрагдан орох аюулд учирдаг байв. Нөгөө талаас хавчих дарангуйлах элдэв хүчирхэг арга зэвсэг бүхий өндөр язгууртан бээлүүд өөрсдийн эрх мэдэлд орохоос зайлсхийхийг оролдсон хүчин буурай айл хөршийнхнээ мөрдөж хяхсаар үгүйрүүлж дуусгах шалтаг ямагт олно. Феодалуудын дарангуйлал ихсэж дорд давхаргуудын зовлон гүнзгийрсээр хожим английг нормандын ван Вильгельмийн байлдан дагуулахад тус дөхөм үзүүлсэн бүлгээ.

Ганстингсийн тэнд болсон тулалдааны дараа засгийн эрх хэм хэмжээг яггүй хэтрүүлчихдэг норманы тайж нарын гарт шилжив.

Саксоны язгууртнуудын хамаг нь нэг бол хядагдаж, эсвэл эдлэн газраа хураалгав. Эцэг өвгийнхээ газрыг хадгалж үлдсэн саксоны жижиг өмчтөн ч цөөн газрыг хадгалж үлдсэн саксоны жижиг өмчтөн ч цөөн байлаа. Байлдан дагуулагчдыг мах цуснаасаа үзэн ядагч хүн амын хэсгийг хаад хууль, хууль бус элдэв арга хэрэглэн доройтуулах гэж ямагт хичээнэ.

Норман гаралтай хаадууд цөм норман албатуудыг илтэд дотночлон үзэж, сулавтар зөөлөн саксоны дэглэмийн үед үгүй байсан ангийн хууль зэрэг зааврууд ялагдсан орныхонд тулган мөрдүүлж феодалын дарлалыг улам хүндрүүлэв.

II Вильгельмийн хаанчлалын дараа англи саксоны ард түмний түүхэнд дайн, самуун зэрэг гойд үйл явдал гарсан нь тэмдэглэгдээгүй авч байлдан дагуулснаар учруулсан шарх сорви III Эдуардын хаанчлал хүртэл эдгэрээгүй билээ гэдгийг сануулахын тулд эдгээрийг би уншигчийн сонорт толилуулах нь хэрэгтэй гэж үзсэн билээ. Өнгөрсөн дурдатгал, өнөөгийн байдлын тухай бодлууд эдгээр шархыг сэдрээж дийлсэн норман, дийлдсэн саксончууд удам судрын хоорондын арилшгүй заагийг хадгалахад тус дөхөм болов.

Энэ бүлгийн эхэнд дурдсан ойн сахлаг ногоотой нэгэн зурвасны цаагуур наран жаргав. Булцруу болсон мөчрүүдээ хилэн ногоон хивсэн дээгүүр сунгасан олон зуун саглагар сайхан царс эртний ромын цэргийн сүрлэг аян дайныг үзэж өнгөрүүлсэн ч байж мэднэ. Царсны энд тэнд туулайн бөөр, элдэв бут, зулзган мод холилдон ургасан байх нь шигүү гэж хачин, шингэн нарны ташуу туяаг үл нэвтрүүлнэ. Зарим газраа мод ярагдан халз гарсан нь нүд булаам таатай. Улбар шаргал туяа навчис нэвлэн, мөчир, модны барсгар голыг гийгүүлж, эсвэл хилэн ногоон дээр зурайн тусна.

Эрт цагт энэ халзан дээрх чөлөөн дээр друндууд мөргөлөө үйлддэг байсан бололтой. Хүний гараар бүтсэн бололтой товчог энд товойж харагдах агаад орой дээр нь хагас дүгрэг том чулуунууд сүндэрлэнэ. Тэдгээрийн долоо нь босоо хэвээрээ, бусды нь христос шашны нэгэн их сүжигтэй хүн унагаасан бололтой зарим нь тэрүүхэн хавьдаа, зарим нь бэл рүү хүртэл өнхөрч довны ёроолоос ундрэн гарах жижиг горхины замыг боож намуун урсгалыг нь үл дуулдам боргиотуулах ажээ.

Энэхүү байгалийг амьжруулсан хоёр хүн байсан нь гадны байдлаас үзэхэд баруун Йоркширийн ойгоор нутагладаг борчуул бололтой. Сайхь хоёрын ахмад нь баргар догшин царайтай, тун энгийн хийцтэй хувцас өмсөх ажээ. Хувцас гэх юм нь ердөө ямар нэгэн ангийн ширийг элдэж үсийг нь гадагш харуулан хийсэн хүрэм, хоногийн удаанд элэгдэж үс нь холцорч дууссан хэсэг хэсэг үлдсэн бөөн үсээр нь чухам юуны арьс болохыг мэдэхүйеэ бэрх болжээ. Хүрмээ майхны цамц юм уу хуяг шиг углаж өмсөнө. Биендээ наалдацтай байлгахын тулд хүрмээ зэс гархитай өргөн суран бүсээр бүсэлжээ. Тэр бүснийхээ нэг талаас дайлан, нөгөө талаас хонины эвэр бүрээ дүүжилжээ. Эвэр иштэй өргөн урт хутга бүсний цаана хавчуулаастай, ийм хутгыг зэргэлдээ нутагт нь хийдэг "шеффильдийнх" гэдэг нэртэй бүлгээ. Баавгайн арьс зүсэж, хийсэн үдээстэй шаахай хөлдөө углажээ. Толгой дээр нь ширэлдэж хоцорсон өтгөн хүрэн шаргал үснээс нь өөр өмссөн зүйлгүй. Цааш сонирхолтой нэг чиег нь гэвэл нохойн хүзүүвч маягийн зэс цагираг хүзүүндээ бэх бат гагнан зүүжээ.

Амьсгаа авахад саад болохооргүй уужим боловч тайлж авах гэвэл дундуур нь тас хуурайдахаас өөр мэхгүй чухал ажээ. Энэ өвөрмөц хүзүүний чимгэн дээр саксоны үсгээр:

"Беовульфийн хүү Гурт бол Ротервудын Седрикийн унаган боол бүлгээ" гэж бичээстэй байв.

Гахайчингийн хажууд (юу гэвэл Гурт гахайчин байсан хүн) друндуудын нэг унамал чулуун дээр түүнээс арав орчим дүү бололтой нэг хүн сууна. Хувцас нь гахай хариулагчийнхаа

төсөөтэй авч янз маягаар илүү, сайн эдээр хийжээ. Хүрэм нь хурц улаан өнгөтэй, хачин эрээн мэрээн угалз чимэгтэй. Хүрэмний гадуур сүрхий тос толбо болсон авч хурц шар эмжээртэй ягаан өнгийн богино өргөн цэмбэн нөмрөгтэй. Гартаа мөнгөн бугуйвч, хүзүүндээ мөн "Уитлиссийн хүү Вамба бол Ротервудын Седрикийн боол бүлгээ" гэсэн бичигтэй мөнгөн хүзүүвч зүүжээ. Малгайн дээрээ анчин шонхорт зүүдгээс томгүй хонх хадсан нь толгойгоо хөдөлгөх бүрт дуугарна. Эзэн өөрөө бараг ганц ч хурам зүгээр суухгүй болохоор жингэнэх дуун чухамдаа үл тасарна. Энэ малгайн доод хатуулгатай арьсан хүрээг дээд талд нь шүд гарган огтлож нэвт угалз тавьсан нь хуралдааны гишүүний титэмтэй төсөөтэй болгосон ажээ. Тэр хүрээний дотор талд үзүүр нь өрөөсөн мөр хүртэл унжсан овоодой хадсанаар, мөн солиотойдуу мөртлөө залирхуу харцаар нь баячууд зүгээр сууж уйдахын цагт зугаа гаргуулдаг гэрийн алия салбадайннуудын нэг гэж гадарлаж болох ажээ.

Нөхрийнхээ нэгэн адил бүсэндээ дайлантай авч хутга, эвэр бүрээ аль алин нь үгүй, янз нь үзүүртэй иртэй зэвсэг гарт нь бариулж болшгүй хүний нэг гэж лав үзэгддэг бололтой.

Эдгээрийн оронд илбэчинд одоо цагийн тайзан дээр ид шидийн чадлаа үзүүлэхэд хэрэглэдэг шиг модон илд зүүжээ. Энэ хоёр хүний царай нүүрний нь төрх хувцаснаас нь багагүй ялгаатай аж. Хамжлагын царай баргар, гунигтай, уруу дорой байдлаас нь үзэхэд нүдэнд нь үе үе дүрс хийх оч дарлагдаж зовж буйгаа ухамсарлаж эсэргүүцэх эрмэлзлэлтэй байдгийг нь эс илчилвээс уул баргар зан нь түүнийг юм бүхэнд хайш хэрэг болгочихсон мэт санагдмаар. Вамбагийн нүүр царай бүр эрс ондоо. Иймэрхүү хүмүүсийн төрх болсон хэрэгт сониуч, туйлын тогтворгүй, аж амьдралдаа бүрэн сэтгэл хангалуун байдлыг илтгэх ажээ. Гахайчин тарж орхисон сүргээ эвэр цоороо чанга татан цуглуулах гэж дэмий баахан оролдсоны эцэст;

- Иш энэ бохир муусайн гахайнуудад Витольд гэгээн хараал буулгачихсан ч болоосой гэв. Дуудсаны хариуд гахайнууд, мөн дутахгүй аятайхаар тургилах авч туулайн бөөр, бургас зэрэг амтат зууш болон эргийн хагас нь шаварт хутгалдсан намгаас холдохыг тун яарахгүй эзнийхээ хашгирахыг үл тоомсорлоно.

Эднийг надтай цуг гэгээн Витольд ниргээд хаячихаасай гэж Гурт хэлээд өнөө шөнө эдний нилээд хэд нь ямар нэгэн хоёр хөлтэй чонын аманд үртэх бий. Фангс нааш ир! Эй, Фангс гэж дуулгаваргүй гахайнуудыг эргүүлж эзэндээ туслах санаатай хазганан гүйж яваа саглагар нохойг байдаг чадлаараа дуудав.

Эзнийхээ өгсөн дохиог эс ойлгосондоо юм уу, аль хар муу санааны үүднээс ч юм уу, тэр нохой гахайнуудыг тал тал тийш нь бутрааж хөөн тус болохын оронд ус болов.

- Чөтгөр, шүдий чинь цөм цохимор гэж Гурт үглээд нохойны хумс тайрч ажил төрөлд тэнцэхгүй болгочихдог энэ ойн манааг тонилгохоо чанаа!... Вамба босооч, сайн нөхрийн тус үзүүлж үз. Энэ хамрын цаагуур салхин талаас нь тойр. Тэндээс үргээгээд орхихын хамт л цаадуул чинь гэр рүүгээ хонь шиг номхон яваад өгнө гэв.

Вамба суусан газраасаа үл хөдлөн, нээрээ юу? Энэ тухайд би хөлтэйгээ зөвлөөд үзсэн чинь ийм шалбааганд өнгөлөг сайхан хувцсаа будах нь миний хаан хувцас, хаан эзний төрөлд, миний биенд гутамшиг зүйл болно гэж санаж байгаа юм байна. Иймд байна. Гурт чи Фангсыг дуудчих, сүрэг яавал өөрөө мэдэг. Энэ гахайнууд чинь баг цэрэг, бүлэг дээрэмчин,

хэсүүл бадарчингуудын алинтай ч дайралдлаа гэсэн ялгаа байгаа гэж үү? Өглөө болтол тэд чинь норман болон хувирах тавилангаасаа зайлж чадах юм биш. Тэгэхдээ энэ чинь чамд амар ашигтай зүйл шүү дээ гэв.

- Гахайнууд чинь яахын даваан дээр норман болж хувираад надад ямар ашиг болчихдог билээ? Тайлбарлаад өгөхгүй юу. Вамба. Одоогоор оньсого таагаад байх сэхээ надад тун алга гэж Гурт хэллээ.

- Чамаас тал тал тийшээ зугтаж гүйгээд байгаа энэ амьтдыг юу гэж нэрлэдэг юм бэ? гэж Вамба асуувал,

- Суайн, суайн л гэдэг шүү дээ, тэнэг минь. Адгийн тэнэг ч үүнийг андахгүй дэг гэж малчин хариулав.

- "Суайн" гэдэг чинь саксон үгш. За тэгвэл тэр гахайг чинь алж, өвчиж эвдээд хөлнөөс нь урвагч аятай дүүжилчихсэн байвал юу гэх вэ? гэвэл,

- Порк гэдэг гэв.

- Адгийн тэнэг хүртэл түүнийг мэддэг нь их таатай. Тэр "порк" гэдэг чинь франц-норман үг. Тэгэхлээр гахайг амьд байхад нь саксоны боол маллаж саксон хэлээр нэрлэдэг, харин эздийн цайз руу очиж, язгууртан ямбатны ширээнд тавигдах болохын цагт норманаар "порк" болчихдог хэрэг. Энэ тухай миний найз Гурт чи юу бодож байна? гэв.

- Юу үнэн вэ, тэр үнээн Вамба, найзаа. Ганцхан энэ үнэн зүйл яагаад чиний тэнэг толгойд орчихсоныг л би мэдэхгүй байна гэв.

Вамба тэр л барилаараа - чи дуулж бай, би бас нэг юм хэлье. Жишээ нь: Манай хөгшин бухын Ольдерманыг чам шиг боол маллаж байхад "Окс" гэдэг саксон нэртэйгээ байдаг. Тэгснээ амтлан үзэх өндөр төрөлтний аманд орох болохоор францын халуун цочмог, эелдэг нийцэнгүй баатар Беф гэгч болчихдог юм. Мөн иймэрхүү янзаар Каф гэгдэгч тугал маань де Во болчихдог малыг адгуулах ёстой байх цагт саксон байж байгаад зууш болохын даваан дээр норман нэртэй болчихдог юм гэлээ.

Дунстан гэгээний нэр барьж андгайлахад чи гунигтай авч үнэн юм ярьж байна гээд Гурт: Бидэнд амьсгаалах агаараас өөр юу ч үлдсэнгүй. Тэгэхдээ үүрүүлж байгаа ажил төрлийг нь хийж гүйцэтгүүлж чадахаа больчих болохоор л тэр агаарыг чинь биднээс арай нэг булаагаад авч орхиогүй байгаа хэрэг. Дорвитой шиг, тос өөхтэй шиг л бүсгүй бол тэдний өвөр түрийд орох учиртай. Бидний хамгийн эр зоригтой нэг маань харь хүний захиргаанд цэргийн албан хааж, харь хүний нутгийг ясаараа бордох болоход золгүй хөөрхий саксончуудыг өмгөөлөх хүч чадал, дур хүсэл ог үгүй хэдхэн хүн л үлдэх жишээтэй. Манай эзэн Седрик зоригтой цэрэг эрийн ёсоор биднийг өмгөөлж чадсан, урт наслах болтугай хөөрхий. Харин мөдхөн Реджинальд Фрон де Беф наашаа ирэх гэнэ билээ. Седрикийн энэ бүх ажил юу болж төгсөхийг тэгэхэд л үзье гэснээ гэнэт чангаар –Нааш ир! Нааш ир! гэж нохойгоо дуудаад – Уухай даа Фангс минь сайн болгоод өг цаадуулыгаа. За ашгүй бөөгнүүлээд авч одлоо. Мөн ч сайн нохой юмаа гэв. Али салбадай үүнд – Гурт, чи намайг бүр нэг усан тэнэг амьтан гэж

санадаг бололтой юм тэргүй бол чи толгойгоо миний ам руу шургуулаад байхгүйсэн.

Реджинальд фрон де Беф юм уу Филлин де Мальвуазенд чиний ингэж нормануудыг муулаад байгаа тухай үг цухуйлгаад л орхивол ихэс ноёдыг элдэвлэх дуртай бүхэнд сургамж болгон энэ моднуудын нэгнээс дор чинь дүүжлээд орхих бий гайгүй гэв.

- Муу нохой ! Чи намайг барьж өгөх юм гэж үү! Үгүй чи өөрөө хатгаж байж намайг тийм үг хэлүүлсэн шүү дээ? гэж Гурт дуу алдав.

- Чамайг барьж өгөх гэж үү? Үгүй! Ухаантай улс л тийм юм хийдэг юм, над шиг тэнэг хүн хаанаас чадах вэ?... Үгүй чимээгүй бай... хэн бидэн дээр морилон ирж байна вэ? гэж Вамба өөрөө өөрийнхөө үгийг таслан өгүүлээд ойрхон сонсогдож буй морин туурайн чимээг чагнав.

Хэн үүгээр явж байгаа нь чамд огт хамаагүй юм биш үү? гэж энэ хамаг сүргээ цуглуулж амаад Фангсийн тусламжтайгаар бүрэнхий татсан нэг чөлөөгөөр тууж явсан Гурт хэлэхэд Вамба хариуд нь:

- Үгүй би энэ морьтой улсыг заавал харах учиртай. Эд чинь ид шидийн орноос Оберон хааны зараалаар явж байж юу магад гэвэл гахайчин үгийг нь таслан:

- Амаа тат! Хэдхэн бээрийн цаана дуу цахилгаантай бороо орж байхад ийм юм ярьж чи бас чаднаа. Дуулж байна уу? Тас бууж байгааг нь. Үгүй энэ бороо! Зун цаг ийм том дусалтай бороо орж байхыг би насандаа ч үзээгүй. Хар л даа салхи байхгүй байна, царсууд тэгэхэд шуурга зөгнөж байгаа юм шиг шурчигнаж сүйд болж байна шүү дээ. Жаахан юм бод. Миний үгийг иэг, үер буухаас өмнө түргэхэн гэртээ харъя. Айхавтар муухай шөнө болно шүү гэв.

Вамба янз нь эдгээр үгсийн аргагүй үнэрийг мэдрэв бололтой, урт саваа барьж, сүрхий дуугаран сүргээ хөөн орох нөхрийнхөө араас дагав.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

*Ариун хийдийн байцаагч ламтан
Авхай, мөргөл, морь гурвыг
Ажлаас илүү эрхэмлэдэг байжээ.
Тийм ламыг амьтан өөлдөгч
Тэндээ нэг эрхэмсэг байсан биз
Адууны нь жүчээг хавь ойр нь мэднэ
Ахиулж цааш нь ярьвал хазаар хударга нь
Аялгуут сайхан хонх шиг жингэнэнэ.
Орон хийдийнхээ ашиг орлогыг
Өөрийн юм шиг дураар зарна.*

Чосер "Кентерберийн өгүүлэл"

Морин туурайн чимээ улам бүр ойртох бөгөөд нөхөр нь хэдий үнэмшүүлж, харж чагнавч морьтой улсыг бушуухан харахсан гэж хорхойтсон Вамба элдэв шалтгаар байн байн зогсох тул морьтой улс тэднийг мөдхөн гүйцээд ирлээ.

Арван хүн явж байв. Өмнө нь яваа хоёр, том улс бололтой, бусад нь тэдний дагуулууд ажээ. Түрүүчийн хоёрын нэгний зэрэг хэргэм, анги язгуурыг тогтооход бэрхгүй, илтэд том мяндагтай лам байв. Цистерцианын хийдийнхний хувраг хувцас уул хийдийн ёс гуриманд үл нийцэх сайхан эдээр хийж өмсчээ. Фламандын хамгийн нарийн цэмбээр хийсэн юүдэнтэй цув ламын ялихгүй тарган боловч аятайхан нуруу туруунд хээнцэр зохижээ. Хувцас хунар нь хоосон хорвоогийн эрээн мярааныг үл тоомсорлосны шинж нэгэнт үгүйн адил зүс царай нь мөн хувраг хүний санваарыг хатуужин сахисны шинж үгүй ажээ.

Унжсан зовхины дорхи нүд садар самуун явдалд сэмхэн хянуураар автагч болохыг нь илчлэн жоготой хачнаар гялалзах аваас нүдэнд дулаахан царайтай хүн байхсан ажээ. Эрхэлсэн ажил, эзэлсэн мяндаг тушаалынхаа дагуу хэрэгтэй цагт биеэ барин угийн наргианч хөнгөн, зөөлөн төрхтэй нүүр царайгаа ихэмсэг сүржин болгож сурчээ. Хийдийн гурим, ромын богд ламын лүндэнгээс гажиж их ламтны ханцуй хуниастай үнэт үсээр эмжсэн, жанч нь алтан тээгтэй ажээ.

Эрхэмсэг ламтан үнэт сайхан тоног хэрэгсэл бүхий эмээлтэй цатгалан луусаар морилох бөгөөд хазаарынхаа амгайг тэр цагийн зангаар мөнгөн хонхоор гоёжээ. Хуврагийн суудалд лам хүний эв дүйгүй байдал ер үгүй гэхээр үл барам харин ч моринд сайн хүний итгэл төгс хээнцэр барилтай жороо луусны явдал хэдий биенд зөөлөн таатай, тоног хэрэгсэл хээнцэр гоё авч дэгжин хувраг энэхүү тааруухан унааг зөвхөн ламын холыг бодож унан байгаа мэт харагдана. Бараа бологчдын нэг нь баяр ёслолын үед ламтны унадаг испани үйлдрийн сайхан азаргыг сул хөтөлж явлаа. Тэр сайхан морин дээр тохсон эмээл сэлтийг загалмай зэрэг шашны билэг тэмдгүүд олныг хатгамласан, бараг газар чирэм урт сайхан эдээр бүтээжээ. Өөр нэг дагуул ламтны юмыг ачсан болтой луус хөтөлж, уул хийдийн арай доогуур мяндагтай хоёр хүний хувраг бүгдийн сүүл барин явж бусад морьтой улсыг өчүүхэн ч үл хайхран инээдэм тоглоом хийж явлаа.

Хуврагийн хамт яваа хүн нь нуруу өндөр, туранхайвтар авч шөрмөслөг, чадалтай, дөч гаруй насны эр ажээ. Үргэлж хүч тамирын дасгал хийсний үрээр дан яс, булчин шөрмөсөөр бүрэлдсэн лут санагдах гоолиг бие нь үзтэл хүнд шалгавар олныг туулсан агаад мөн төдий хир олныг туулж чадах нь илт ажээ. Үнэт үс хадсан улаан малгай духдуулсан бөгөөд уулзсан хүн бүрийг сүрээрээ даран бишрүүлэхсэн гэсэн хүсэл нүүр царайнд нь илт харагдана. Халуун орны нарны илчинд бараг негр хүнийх шиг харалчихсан, ширүүн, эршүүд царай нь цочмог халуун тэчъяалд умбасны эцэст түр тогтсон төлөвтэй, гэвч магнайны нь гүрийсэн судас, дээд уруулын нь татвалзахыг харвал тэчъяал минут тутамд дахин дүрэлзэхэд тун төвдөхгүйг илчилнэ. Нэвт шувт ширтсэн зоримог хар нүдний нь харц туулж өнгөрсөн бэрхшээл, өнгөрүүлсэн зовлонг илтгэн ярих мэт. Эр зориг эрс шийдмэгээ гаргаж дайсныг замаасаа авч хаяхын тулд хүсэл зоригноосоо зөрөх тэрслэх сэтгэл хүнд төрүүлэхсэн гэж хүсэж байх аятай санагдана. Дээгүүр нь сорви дайрч гарсан нэг нүд нь үл мэдэг солир, харцыг нь зэвүүн сүртэй болгоно. Энэ морьтой хүн цуг яваа нөхрийнхөө адил хуврагийн урт цувтай авч улаан өнгөтэй байгаа нь гол дөрвөн хийдийн алинд ч үл хамаарагдахыг заана. Баруун мөрөн дээр нь тусгай жагсаал хувцасны тэмдэг болох цагаан цэмбээр загалмай оёжээ. Цувны дотуур маш жижиг төмөр цагиргуудаар туйлын уран, ханцуй, бээлий сэлттэй хийсэн торгон хөө хуяг өмссөн нь зөөлөн ноосоор нэхсэн бидний цамц адил биенд наалдан аятайхан тохирчээ. Цувны нугалааны цаанаас харагдахын хирээр ажваас мөн тийм хөө хуяг гуяыг нь бүрхэж, өвдгөө нарийн болд ялтсуудаар хамаалжээ. Хөө хуяган оймстой, зэвсэг гэх зүйл гэвэл бүсэндээ хавчуулсан том чинжаал хутга л байлаа.

Байлдааны, үүлдэр сайн морио гамнаж байгаа бололтой дагуулуудын нэгэнд сул хөтлүүлээд аян замын нэгэн морь унаж явав. Байлдааны бүрэн зэвсэг, дамаскийн сайхан хээ цоолбортой богино жад нэг талд нь, нөгөө талд нь одон чимэгтэй дуулга, хоёр ирт урт илд тэргүүтэн ганзагалжээ. Өөр нэг дагууз эзнийхээ мөн цэвэр дээр нь байгаатай адил загалмай хадсан, жижиг дарцаг уясан жад дээр өргөж явна. Тэр дагуул бас гурвалжин бамбайг улаан цэмбэн гэрэнд хийж барьсан түүн дээр байх учиртай сүлдийг далдалжээ. Энэ хоёр дагуулын хойноос бас хоёр зарц яваагийн хар царай, цагаан тоорцог хувцасны гойд янз маяг нь дорнодын орны хүмүүс болохыг илчилнэ. Ер нь энэ баатар, дагуулууды нь байдал нэг л харь нутгийн хээрийн задгайдуу галбир төрх байх ажээ. Дагуулууд нь хувцас баян хээнцэр, гял цал буусан, дорнотын орны тэдгээр зарц нар мөнгөн хүзүүвч, бараг нүцгэн шахуу гар хөлдөө мөн бугуйвч цагиргууд зүүжээ. Тэдний хатгамал хээ угалзтай торгон хувцас эзний нь өндөр язгуур баян чинээлгийг илчлэхийн хамт өөрийн нь байлдааны ангийн даруу хувцаснаас эрс ялгарч харагдах ажээ. Тэр алтан шармал хээ угалз бариултай, хуяг нь мөн чимэглэсэн тахир сэлэм, улам ч нарийн сайхан хийцтэй турк чинжаал хутга зүүсний гадна тус бүр дөрвөн төө хир урт ган зэвтэй сумнууд бүхий саадаг агсжээ. Дагуулууд араб үүлдийн хөл хөнгөнтэй, шөрмөслөг мяндас шиг дэлтэй Норманд, Фландрийд бүрэн зэвсэгтэй эр цэргийн хүний унаанд зориулан үржүүлдэг хүнд хөлтэй, янхигар том азрагануудаас эрс ялгагдах сайхан хөлгүүд унажээ. Тийм том биерхэг морьдын дэргэд арабын хурдан хөлгүүд бараг сүүдэр шиг хөнгөн шингэн санагдах бүлгээ. Энэ бүлэг морьтны гойд хачин байдал зөвхөн Вамбагийн төдийгүй, нилээд буурь суурьтай нөхрийн нь сонирхлыг хүртэл татжээ. Ламыг хармагц ан гөрөө, найр наргианд, тэр ч байтугай амьтны цуу үгэнд итгэх юм бол хувраг хүний санал санваартай илүү их харшлах шалиг балаг зүйлд ч дуртайгаараа хавь нутаг даяарт нэртэй Жорво хийдийн ширээт мөнийг даруй танив.

Тэр цагт лам хуврагуудын явдлыг хэт яандаар үздэггүй байсан тул Ширээт Эймер хийдийнхээ айл хөршийнхэнд сайн нэртэйн гадна зоргоороо наргианч сайхан ааш, нүгэл хилэнц тайлж өгөхдөө ямагт бэлхэн байдагт нь нутгийн тайж нар машид дуртай ажээ. Тэгээд ч өөрөө норманы өндөр язгуурт гэр бүлээс гаралтай тул тэдгээр тайж нарын олонхтой ураг, төрлийн холбоотой юм. Ялангуяа хатагтай нар гоо сайхан бүсгүйчүүлийг ямагт бахдан биширч байдгийн дээр эртний феодалуудын цайзны тэнхимд хэт олонтой автах байж ядам уйтгар нозоон байдлыг сэргээж өгөх онцгой чадвартай хүний авир аалийг онцын хатуугаар шүүж үзэх дургүй байдаг билээ. Ширээт ламтан ан гөрөөнд хорхойтой, бүхэл хойт мужид тэргүүн зэргийн шонхрууд, тайга ноходтой хүн. Энэ байдал залуу тайж нарын дунд түүний нэр алдрыг ихэд дээшлүүлэх бөгөөд ахмад нэгний нь дэргэд хэрэгтэй аваас огт өөр хүний дүр үзүүлэхийг бас сайн сурчээ. Эргэн тойрны харанхуй бүдүүлэг хүмүүсийг эрдэм номоороо бишрүүлж элсэг хүрэхүйц овоо юм гүйлгэж уншчихдагаас гадна гоолиг ихэмсэг бие бялдар болон сэм хийд, хуврагуудын нэр хүндийн тухай дөвийлгөсөн яриа хөөрөө нь ариун санваартанд тооцогдоход нь тус болно. Тэр ч байтугай дээд давхарганыхны үйл төрхийг бүхнээс илүүгээр өөрчилдөг энгийн ардууд хүртэл ширээт Эймерийн хөнгөмсөг авирлахыг хэлтрүүлэнгүйгээр үзэх бүлгээ. Хэргийн чухам учир гэвэл Эймер туйлын өглөг хүн, өгөөмөр хишиг хүртээснээр ихээхэн хилэнц хэлтэрдэг нь мэдээж хэрэг билээ. Хийдийн орлогын ихэнх нь ширээтийн мэдэлд байдаг нь хувийн цэнгэлд их юм зарцуулах төдийгүй айл хөршийн яриачид өгөөмөр тус үзүүлэх боломж өгдөг билээ. Ан гөрөөний үеэр Эймер хэт улайран давших юм уу, найр хуриман дээр дэндүү удаан суух эсвэл шөнө дөлөн унжирсан болзооны эцэст үүрээр хийдийнхээ явган хаалгаар сэм орж яваа нь харагдлаа гэхэд хүмүүс мөрөө хавчис хийсэн төдийгөөр ширээтийн осол эндэгдэлтэй эвлэрэн өнгөрөхдөө бусад санваартан нөхөд нь энэ лам шиг сайн чанаруудаар нүглээ огтхон ч үл хөнгөвчлөх мөртлөө мөн тийм хэрэг үйлдэж явдгийг дурсах жишээтэй. Ер нь нэг үгээр хэлэхэд ширээт Эймерийг манай саксоныхан эс андах бүлгээ. Тэд ламын өмнө эв дүйгүйхэн бөхийж, хариу адис хүртэнэ. Эймерийн хамт яваа хүн, бараа бологсдын гаж буруу байдал, гахайчин, Вамба хоёрыг алмайруулж орхисон учир ширээтийн асуусан зүйлийг сайтар сонссонгүй.

Ламтан арай өндөр дуугаар

- Шавь нараа, бурханд бишрэн эх болсон ариун шашинд сүсэглэн зүтгэх сэтгэлийн үүднээс уул шашинд хүлцэнгүйеэ хүчин зүтгэгч хоёр хүнийг зам яваа улсын хамт энэ шөнөдөө толгой хоргодуулан найр тавьж, хүч чадлаа сэлбэхэд туслах сайн хүн энэ хавьд байдаг болов уу гэж та нараас асууж байна? гэв. Уул үг нь хэдий даруу найрсаг авч үүнийгээ сүрхий ихэмсгээр өгүүллээ.

"Эх болсон сүм хийдийн хоёр хүлцэнгүйеэ хүчин зүтгэгч гэнээ,цаад ордны даамал, зуушны худалдагч зэрэг дээхнүүр зарц нар нь тэгвэл ямар шүү улс байх юм бол харахсан" Вамба дотроо бодсон авч санаагаа ил гаргаж хэлэхийг төвдсөнгүй.

Хараагаа цэх болгон ширээт рүү харж:

- Дээд багш ламтан нарт өег хоол, зөөлөн дэвсгэр хэрэгтэйсэн бол эндээс хэдхэн бээрийн цаана Бринсквортийн хийд гэж бий. Тэнд та бүхний мяндаг тушаалд тэнцэхүйц хүндтэйгээр угтан дайлах болно. Харин хилэнцээ наминчлан энэ оройг өнгөрүүлэе гэвэл тэр байгаа ойн зөргөөр явбал Компангерстийн төрөлд байдаг буйд овоохойд шуудхан хөтлөөд авч очно. Тэнд

сүсэгч даяанч та бүхнийг хорогдуулж, үдшийн залбирал хамт үйлдэх болно гэв. Энэ хоёр зөвлөлгөөнийг сонсоод ширээт толгой сэгсэрч:

- Сайн нөхөр минь, наад хонхны чинь дуу оюун ухааныг тань мангууруулч орхиогүйсэн бол санваартан хүмүүс бид нэг нь нөгөөгөөрөө зочлуулдаггүй, бурхны төлөө хүчээ өгөгч хүнд тус болж буян нь ари्वжих илүү нэг завшаан олгохын тулд харь хүмүүсийн буудаг учрыг чи мэдэх ёстой байсан гэвэл Вамба хариуд нь:

- Би илжиг, гэхдээ эрхэм багш ламтны луусных шиг яг адил хонх зүүх завшаан надад тохиолджээ. Гэхдээ эх болсон сүм хийд болон түүнд хүчин зүтгэгчдийн сайхан санаа нь бусад бүх хүмүүсийн нэгэн адил юуны өмнө халуун амин дундаа илүү ихээр илэрдэг байх гэж санасан билээ гэв.

Цаад зэр зэвсэгтэй хүн салбадайн дэмий үгийг ширүүнээр тас дайран:

- Хэрцгий авирлахаа тат, бүдүүлэг амьтан! гэж зандраад мэддэг юм бол цайз хүрэх зам бидэнд заагаад өг! Тэр жижиг тайжийг ширээт Эймер та хэн гэлээ? гэв.

- Седрик гэдэг юм. Седрик чинь саксон хүн. Ингэхэд найз минь тэднийхээс бид хол байна уу, чи бидэнд зам зааж өгч чадах уу? гэвэл Гурт анх удаа ярианд оролцон:

- Зам олоход хэцүүхэн л байх даа. Түүнээс гадна Седрикийнхэн чинь эрт унтчихдаг улс гэвэл дайчин эр өөдөөс нь:

- За битгий дэмий юм яриад бай! Бидэн шиг улсыг аян замд явж байхад босож болохтой байлгүй. Бид царай алдаж хоног гуйх гэж байгаа юм биш, аятай тавтай хүлээж авахыг шаардах эрхтэй элс гэлээ.

Гурт үүнд уруугаар:

- Мэдэхгүй юм даа. Бусад хүмүүс бол өршөөж гигүүлсэнд тооцох зүйлийг эрхийнхээ дагуу шаардах санаатай байгаа улсад эзнийдээ очих зам зааж өгөх ёстой юм уу үгүй юу гэвэл:

- Муу боол чи бас надтай маргалдах санаа байна уу? гэж дайчин эр дуу алдаад морио давиран цочмог эргүүлж тэсгэлгүй аашилсан харцыг залхаахаар ташуураар далайв.

Гурт өөдөөс нь хорсож өширхсөн байртай заналхийлэн хараад хэдий шийдмэг бус авч хутганыхаа ишнээс шүүрч авав. Гэвч яг энэ үеэр ширээт Эймер луустайгаа урагшлан баатар, гахайчин хоёрын хооронд орж зогсоод аюултай мөргөлдөөнд эс хүргэв.

- Үгүй, санваарт Бриан минь та одоо буруу номтон Турк болон сарациныхныг эзэрхэж байсан Палестинэд байгаа биш гэдгээ санахыг Марья хутагтын нэрийг барьж гуйя. Энд манай арал дээр бид зөөлөн нигүүлсэнгүй гараар цээрлүүлдэг ариун сүм хийдэд л зодуулахыг хүлцдэг юм гээд Вамба руу эргэж жижиг мөнгөн зоосоор тал засан

- Саксоны Седрикийн хүрэх замыг сайн санаат хүн та хэлж өгнө үү? Тийшээ очих замыг чи мэдэх ёстой тэгээд бидэн шиг санваартай улс байтугай явуулын аль ч хүнд зааж өгөх учиртай

билээ гэвэл, салбайдай өөдөөс нь:

- Үнэндээ шударга явдалт багш минь танай энэ хамт морилох өндөр дээд хүний сарацин толгойноос сүнсгүй айж гэртээ харих замыг таг мартчихлаа, нээрээ шүү... Тэр ч байтугай өнөөдөр өөрөө тийшээ очиж чадна уу, үгүй юу бүү мэд... гэвэл ширээт хариуд нь:

- Дэмий үг! дур чинь хүрвэл санах болно. Надтай санваар нэгтэй энэ эрхэм хүн христосын ариун шарилыг булааж авахын төлөө насан туршаа байлдаж яваа юм. Их сүмийн баатруудын хүрээний хүн, чи тэр тухай дуулсан ч байж магад, тэгээд нэг ёсны санваартан, нөгөө талаар бол баатар хүн гэв.

- Тал хувь ч гэсэн санваартан хүн юм болж гэм өөрсдөд нь үл хамаарах асуудлын хариуд удаан дуугарлаа хэмээн замд тааралдсан хүмүүстэй болчимгүй загнах учиргүйсэн гэвэл:

- Чамайг Седрикийнд очих зам зааж өгвөл яахан энэ тоглоом тохууг чинь би уучилж өнгөрөө гэж лам өгүүлэв.

- За яахав энэ зөргөөр явтал орой нь тохойноос хэтрэхгүй болтлоо суучихсан зоолттой загалмай дайралдана. Тэр загалмайгаас тал тал тийшээ салсан дөрвөн зам бий. Та харин зүүн тийшээ эргэнэ шүү, тэгвэл багш ламтан та үер буухаас өмнө хоноглох газраа лав хүрчих билээ гэв.

Цэцэн зөвлөгчид ламтан талархаад шөнийн үерээс урьтаж хоноглох газраа хүрэхийг хүмүүс яардагчилан цөм морьдоо давиран даруй давхиж одов. Морин туурай чимээ алсад тасармагц Гурт найздаа:

- Эрхэм багш ламтангууд чиний мэргэн зөвлөлгөөг дагах юм бол өнөөдөртөө Ротервудод арай ч хүрэхгүй болов уу даа гэлээ. Алиа салбадай үүнд доогтой инээвхийлэн: - Тиймээ тэгэхдээ тэд чинь аз дайрвал Шеффилд хүрч чадна, тэгсэн ч гэсэн тэдэнд боллоо биш үү. Шувуу бариулахыг эс хүсвэл хэвтрийг нь нохойд зааж өгөхөөр тийм муу ч ойн манаач би биш шүү гэхэд, Гурт:

- Чиний зөвөө. Эймер тэгээд Ровена хатагтайг үзвэл муу хэрэг болно. Седрик бас энэ дайчин гэлэнтэй муудах аваас, тэр лав тэгж таарах хүн, бүр ч муу юм болж магад. Харин чи бид хоёр дэмий чалчихгүй, сайн зарц нарын ёсоор харж сонсож л байя гэв.

Седрикийн боолуудаас төдөлгүй алс одсон явуулын хоёрыгоо эргэж үзье.

- Тэр дэггүй харчуул чухам яалгах гээд байсан юм бэ? гэж сүмийн баатар ламаас асуугаад яагаад та тэднийг цээрлүүлсэнгүй вэ? гэхэд,

- Ээ Бриан минь, тэдний нэг нь усан тэнэг амьтан, түүний тэнэгт хариуцлага тулгах гэдэг хачин зүйл байхсан, нөгөө бүдүүлэг этгээдийн тухайд гэвэл танд миний олон дахин ярьсан байлдан дагуулагдсан саксончуудын харгалзагчийн гарт байгаад л тэд чинь хүлцэнзэрлэгүүдийн нэг шүү дээ. Тохиромжтой учран гарсан тухай бүрт дийлэгчдийг жигшдэгээ үзүүлэхээс илүү таатай юм тэдэнд ер үгүй билээ гэв.

- Үгүй би бол эелдэг зан ёсыг даруй ойлгуулаад өгөх байсан. Би чинь тиймэрхүү хүмүүстэй орооцолдож сурсан хүн. Манай олзлогдсон туркууд гэдэг тэрслүүд омогтойн хувьд Одиноос хүртэл аймшигтай юм шиг санагддаг улс. Гэхдээ манай гэрт хоёр сар миний боолчуудын харгалзагчийн гарт байгаад л тэд чинь хүлцэнгүй дуулгавартай үйлчлэнгүй, тэр ч байтугай бөхөлзүүр болчихдог юм даа. Чухамдаа тэдэнтэй чинь тун сэрэмжтэй, хор хутга хоёроос айж байх хэрэгтэй юу гэвэл аятай учрал гарсан тухайд тэдний аль алиныг дуртайяа хэрэглэдэг улс гэж Бриан ярив.

Ширээт Эймер үүнд хариу марган

- Үгүй ард түмэн бүр өөрийн зан заншилтай шүү дээ. Тэр этгээдийг та зодчихлоо гэхэд бид Седрикийнд хүрэх замыг мэдэж чадахгүй байх байсан. Түүнээс гадна бид өөрсдөө тийшээ хүрч чаджээ ч гэсэн боолоо зодлоо гээд Седрик тантай заавал хэрүүл өдөх байсан. Миний ярьсныг санаж байна уу, тэр баян тайж чинь бардам түргэн зантай, хор шартай, уцаар, манай тайж нарт дургүй тэр ч байтугай авиргүй зантай хөрш Реджинальд фрон де Беф, Филипп Мальвуазен хоёртой хүртэл эвдрэд байгаа хүн. Долоон хаанчлалын эсрэг хамгийн цуутай тэмцэгчдийн нэг.

Хервардын шууд удам угсаа гэдгээрээ ихэд бахархаж, ураг удмынхаа эрхийн төлөө хатан баатар зогсдог хүн болохоор түүнийг чинь Саксоны Седрик гэхээс өөрөөр нэрлэдэггүй юм. Ялагдагсдын хувь тавилан болдог гай түйтгэрээс зайлсхийхийн тулд эднийхний олонхи нь ураг гарлаа дуртайяа үгүйсгэдэг тэр ард түмэнтэй цусан төрөл гэдгээрээ их гайхуулдаг хүн дээ гэв.

- Ширээт Эймер та бүсгүй хүний гоо сайхныг сайтар ялгах ялдам найрсгийн дээр хайр сэтгэлийн зүй тогтоолын талаар трубадуруудаас доргүй мэдэх хүн. Тэгэхлээр тэр мэргэн Ровена чинь таны үгээр өдий бүдүүлэг, тэслүү этгээд болох эцэг Седрикийн нь таалалд нийцэх гэж миний их өршөөл тэсвэр гаргасны шан болж чадахуйц ид шидийн гоо сайхан амьтан байж таарах нээ гэж баатар өгүүлэв.

- Седрик түүний эцэг биш зөвхөн холын хамаатан Ровена чинь Седрикээс ч илүү дээгүүр язгууртан гарлын хүн. Седрик өөрөө түүнийг халамжлан аваад, төрсөн охин нь байлаа ч гэсэн түүнээс цаашгүй сайн байдаг юм. Бүсгүйн гоо сайхныг та мөдхөн өөрөө цэгнэн үзэж болно. Ровенагийн царайны цасан цагаан өнгө, ихэмсэг мөртлөө угсал цэнхэр нүдний нь харц Паластаны хар нүдэн охидыг таны сэтгэлээс үлдэн хөөхгүй юм болж гэм би сүм хийдийн үнэнч хүү бас буруу номтон болог яахав гэвэл;

- Таны тэр цуутай гоо хүүхэн чинь төдий сайхан амьтан биш байвал юугаар мөрийцсөнөө мартаггүй биз гэж баатрыг асуухад,

- Миний алтан гинж, таны дэнчин гэвэл хиоссийн арван торх дарс. Бид тэднийг зооринд тавиастай, миний тахилч өвгөн Денис түлхүүрийг нь бариад явж байгаа мэт өөрийн гэж үзэж болох юмаа гэж лам хариулав.

- Гэхдээ мөрийг шийдэх эрхийг та надад олгож байгаа, өнгөрсөн оны гурван эрдэнийн баяраас хойш илүү сайхан хүүхэн хараагүй гэж өөрөө хүлээх юм бол л би мөрийгөө алдах

болно. Та бид хоёр тэгж ярилцсан байхаа? За ширээт алтан гинжнээсээ ч салж дуусчээ. Би түүнийг Ашбы-дел-зушид болох тулалдаанд тольтныхоо дээгүүр зүүнэ дээ гэлээ.

- Шударгаар хожвол зүгээрээ ямай. Таныг би эр баатар, санваартан хүн гэж үзэн үгэнд чинь итгэнэ. За юу ч гэсэн түнш минь миний зөвлөлгөөний дагаж жаал эелдэг байж үзээрэй, та чинь олзны буруу номтон юм уу, дорнот орнуудын боолчуудтай учрах гэж байсан биш шүү дээ. Саксоны Седрик чинь доромжлогдлоо л гэж өөрийгөө тооцвол энэ талаар угийн тун эмзэг шүү, тэгж л үзвэл таны эр баатар, миний өндөр дээд хэргэм ариун санваарыг үл харгалзан гадаа шөнө дунд болчихоод байлаа ч гэсэн гэрээсээ хөөгөөд гаргачих хүн.

Үүнээс гадна Ровена руу хэтэрхий гөлрөхөөс болгоомжлоорой түүнийгээ тун хартайгаар харж өмгөөлдөг юм. Энэ талаар л Седрикэд өчүүхэн төдий санаа зовох шалтаг өглөө бол та бид хоёр дүүрлээ гэсэн үг. Энэ гоо бүсгүйг хайрын нүдээр харж зүрхэлсэн төдийгөөр ганц хүүгээ гэрээсээ хөөгөөд явуулчихсан юм гэлцдэг. Янз нь тэр бүсгүйг зөвхөн холоос шохоорхон биширч болох бөгөөд хутагт дагинын гунгарваа руу очихдоо санадаг шигээ өөр бодол үл агуулах ойртохоос бусдыг зөвшөөрдөггүй бололтой гэв.

Сүмийн хорооны баатар үүнд

- За яая гэх вэ, биеэ сайн барьж ичимхий охин шиг л байхыг хичээе. Юу ч гэсэн хэн нэг хүн биднийг гэрээсээ хөөгөөд гаргачихаж чадах юм гэж бүү ай. Би дагуулууд, манай зарц Амет, Абдалл хоёртойгоо айлд аятайхан угтуулж авахаар хүчирхэг улс гэвэл,

- Үгүй бид тэгж дэндүү аашилж ер болохгүй гэж ширээт хариулаад – За нөгөө Салбадайн ярьдаг газарт шигдсэн загалмай чинь энэ байна. Гагцхүү тас харанхуй шөнө зам ялгаж харахад маш бэрх байна. Тэр чинь зүүн тийшээ эргэх хэрэгтэй гэсэн байхаа гэвэл,

- Үгүй баруун тийшээ. Баруун тийшээгээ гэсэн санагдаж байна гэж Бриан хэллээ.

- Зүүн тийшээ, зүүн тийшээ байлгүй яахав. Модон илднийхээ үзүүрээр яг зүүн тийш зааж байсныг би санаж байна гэхэд

- Тиймээ, гэхдээ илдээ зүүн гартаа урдуураа хөндлөн барьж эсрэг тал руугаа заасан шүү дээ гэж Бриан маргав. Иймэрхүү үед ямагт болдогчилон хоёул өөрсдийн саналыг барин тас зүтгээд, зарц нараасаа асуув. Гэвч бараа бологсод зайдуу зогсож байсан тул Вамба юу гэснийг дуулсангүй. Тэгж байтал Бриан харанхуй руу ширтсээр загалмайн ёроолд нэг хүний дүрс байхыг олж хараад:

- Энд нэг хүн хэвтэж байна. Нэг бол унтаж байгаа эсвэл үхчихсэн бололтой. Алив Гуго жадныхаа үзүүрээр нэг хүрээд орхиоч гэвэл дагуулыг хүрч амжихаас өмнө цаашд хүн босон харайж Франц элээр цэвэрхэн:

- Чи хэн ч байлаа гэсэн миний бодлыг ийнхүү сарниадаг чинь эелдэг бус авир мэт! гэж дуу алдав.

- Ротервудэд Саксоны Седрикийн гэрт хаахнуур явж хүрэх замыг л чамаас асуух гэсэн билээ

гэж ширээтийг хэлэхэд:

- Би өөрөө Ротервуд руу явж байна. Би морьтойсон бол тийшээ та бүхэнд газарчлаад өгөхсөн гэж үл таних хүн өгүүлэв.

- Биднийг Седрикийнд хүргээд өгвөл чамд гялайлаа гэх байна найз минь гэж лам хэлээд гэлэнгүүдийн нэгийг үл таних хүнд морио өгөөд испани азаргаа уна! гэж тушаав. Замчин Вамбагийн заасан эсрэг зүг рүү чиглэж зөрөг төдхөн ойн гүн рүү шургаж эргээрээ намагтай хэд хэдэн горхи гатлав. Горхинуудыг гэтлэхэд нилээд осолтой ажил байсан авч үл таних хүн хамгийн хуурайдуу аюул багатай гармыг зөнгөөр, сонгож олоод байх шиг санагдана. Хянуур урагшилсаар эцэстээ жижиг багийг өргөн чөлөө рүү гаргаж ирсний цаад үзүүрт нүсэр том, эв дүйгүйхэн байшин харагдлаа.

Газарч түүнийг гараараа заагаад ламд,

- За Саксоны Седрикийн гэр Ротервуд гэдэг чинь энэ дээ гэв.

Гойдын зүрхтэй бус болохоороо шигдүүр намган дундуур явах үед замчинтайгаа үг солих өчүүхэн ч хүсэлгүй болтлоо хэлмэгдэж явсан Эймер энэ үгэнд гойд их баярлав. Одоо харин сониуч зан нь сэргэж замчныхаа хэн болох, хаанаас явааг асуувал

- Би бадарчин хүн. Ариун орноос дөнгөж ирээд байна гэж цаадах нь хариулав.

- Бурхны гэгээн шарилыг булааж авахын тулд тэндээ тулалдахаар үлдсэн бол чинь дээр байхсан гэж сүмийн хорооны баатар өгүүлбэл баатрын зүс царайг сайн таних бололтой бадарчин үүнд:

- Эрхэм хүндэт ноён баатар таны зөв. Гэхдээ гэгээн бурхны шарилыг чөлөөлөхөд бүх амьдралаа зориулахаар андгай тавьсан хүн хүртэл ам тангарагныхаа дагуу тулалдан байвал зохих газраасаа алсад зоррчиж явахад над мэтийн эгэл дорд хүний гэрээ харьж ирсэнд гайхах явдал үгүй бизээ гэж хариу өчив.

Баатар энэ үгэнд догшин хариу өгөхөөр завдтал, ламтан ярианд оролцон газарчин одоо болтол ойн бүх зөргийг ийм сайн санаж байдагт гайхав.

- Үгүй би чинь энэ нутгийн хүн байхгүй юу гэж газарч хариулав.

Яг энэ үеэр тэд Седрикийн байшингийн өмнө ирчихлээ. Ардаа хэд хэдэн хашаа хоро бүхий нүсэр том, эв дүйгүй байшин ажээ. Байшингийн хэмжээ эзний чинээлэг баяныг үзүүлэх боловч норман тайж нарын чулуун хэрэм арзгар цамхгуудаар хамгаалсан өндөр цайзуудаас эрс ялгагдана.

Гэхдээ Ротервуд тийм ор хамгаалалтгүй ч биш ажээ. Тэр самуун цагт хамгаалалт бэхлэлтгүй ганц ч эдлэн байж чадахгүй, байх аваас даруй дээрэмдэгдэн шатаагдах байж билээ. Бүх эдлэнг тойруулж гүнзгий шуудуу татаад хажуу голын уснаас татаж дүүрэгжээ. Тэр шуудууны хоёр эргээр шовхолдсон дүнз давхарлан зоожээ. Гаднах хорооны баруун талд дааман гаргаж,

дотоод хороо тэр хоёрын хооронд дүүжин гүүр тавьжээ. Хаалганы хоёр талд тусгай өндөрлөсөн байртай нь дайсныг нумаар харвах, цахиур буугаар онь холбон цохих боломж өгөх ажээ. Даамангийн өмнө зогсоод баатар тэсэж ядсан байртай чангаар бүрээдэв. Энэ үеэр бороо хувингаар асгах мэт ширүүссэн тул яарах хэрэгтэй байлаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Хүрхрэн долгилох чимээнээс өөрийг сонсоогүй
Хүнгүй зэлүүд хойт тэнгисийн эргээс
Алтан нүдэт, цэнхэр үст Саксон хүү гарч ирээд
Аюул зовлон, гамшиг хөнөөл тарьчухай!*

Томсын "Эрх чөлөө"

Уудам боловч намхан өрөөнд харуулдаагүй царсан самбараар хийсэн том ширээн дээр Саксоны Седрикийн үдшийн зоог зэхжээ. Өрөөний булан бүрт том пийшин тавьсан авч янданг муу хийсэн болохоор ихэнх утаа нь дотроо суунаглана. Адрын дүнзэн нуруунууд байнга тортогт идүүлсээр зуузаан хөө суусан нь хар лак түрхсэн адил болжээ. Ханаар ан гэрээний элдэв хэрэгсэл, зэр зэвсэг өлгөсөн бөгөөд булангууд дахь хоёр самбарт хаалгууд том байшингийн бусад өрөөнүүдийг холбожээ.

Бүх тавьц хэрэгсэл Седрикийн бахархаж үздэг Саксоны энгийн төв байдалтай. Манайхны агуулахынхтэй адил зуурмаг шавар шалтай.

Өрөөний нэг булан дахь шалыг жаал өндөрлөснийг "хүндэт тавцан" гэх бөгөөд түүн дээр зөвхөн эр бүлгийн ахмад гишүүд, онцгой хүндэт зочин суух эрхтэй. Тавцан дээр хөндөлдүүлэн тавьсан, гоё улаан бүтээлэгтэй ширээний голоос уртааш нь залгасан нь бусад хүмүүс, зарц нарын хоолны ширээ байлаа.

- Иймэрхүү "Т" маягаар зассан хоолны ширээ одоо хүртэл Оксфорд, кембриджийн эртний их сургуулиудад үзэгддэг. Тавцан дээрх гол ширээг тойруулан бат бөх сандал, сийлмэл царсан зөөлөн сандлууд тавьжээ. Тавцангийн дээд талд цэмбэн асар барьсан нь тэнд суух эрхэмсэг хүмүүсийг муу дээврээр гоожих борооны дуслас зарим талаар хамгаалах ажээ.

Тавцан хавийн ханыг эрээн эдээр доторлож, шалан дээр хээтэй хивс дэвсжээ. Өрөөний бусад хэсэгт асар бүдүүн бараг шохойдсон хананд нь, дотор шавар шалан дээр нь дэвссэн хивс сэлт ер үгүй. Сандлын оронд урт вандангууд эгнүүлжээ.

Дээд ширээний голд, хоёр зөөлөн сандал арай өндөрлөн тавьсан нь гэрийн эзэн, эзэгтэй хоёрт зориулжээ. Энэ хоёр сандлын нэгэн дээр одоо Саксон Седрик үдшийн зоогоо унтууцан хүлээж сууна. Хэргэмийн хувьд өөрөө зөвхөн Тан хэдий боловч өдөр үдшийн зоог оройтоход эрт одоо цагийн алив дутуугүйгээр унтууцдаг бүлгээ.

Седрик хүртэл шулуун цэх, хүлээц муутай, түргэн зантай байрын царайтай. Нуруу дунд зэрэг, цээж ханхар, урт гартай, аян дайн ан гөрөөнд явж хатуужин сурсан хүний гойд чийрэг чадмаг биетэй. Толгойны хэлбэр аятайхан, том цэнхэр нүдтэй, өргөн нүүр нь эршүүд зоримгийн дээр тун ч хөгжүүн сэргэлэн авч байн байн дүрсхийх уур хилэнц автаж мэдэхүйц байртай. Харц бардам дээрэнгүй, байнга хянуур соргох байх шинжтэй, юу гэвэл энэ хүн бусдаас байнга халдах эрх мэдлээ насан турш тэмцэн хадгалж байгаа билээ. Седрикийн духнаасаа зулайгаа хүртэл эгц хагаран мөр рүүгээ унжсан урт хүрэн үс нь үл мэдэг буурал орж буй нь арга буюу дал насалсных ажээ.

Зах, хормойгоороо бор хүрэн эмжээртэй ногоон өнгийн хүрмэн цамц задгай өмссөний цаанаас биеий нь яг барьсан улаан цэмбэн цамц давхар харагдана. Мөн эдээр хийсэн өмд дөнгөж өвдөгт хүрэн, доошоо нүцгэн, эзний шаахай тариачдынхтай хийц адил авч савхи нь арай дээр, урдаа алтан гархи тээгтэй. Гартаа алтан бугуйвч, хүзүүндээ өргөн зүүлт зүүж, үнэт эрдэнийн чулуугаар баялаг чимсэн, бүсэндээ сүрхий хурц үзүүртэй хос урт богино илд зүүжээ. Зөөлөн сандлы нь ард үнэт үсээр эмжсэн цэмбэн урт цув. Сайхан хатгамалсан малгай өлгөөстэй байх нь баян газрын эзний зрдийн цагтаа өмсдөг хувцас нь билээ. Эзний сандлыг түшүүлэн тавьсан гялалзсан болд толгойтой богинохон ац зугаалгын үед таяг ч болдог зэвсэг ч болдог ажээ.

Эзний хээнцэр сайхан болон гахайчин Гуртийн бүдүүн бараг хувцасны дундыг барих аятай хувцасласан хэдэн зарц нэр харьяат эзнийхээ ямар тушаал буулгахыг хүлээн харцыг нь манан зогсоно. Тэдний хоёр гурван ахмад нь эзний ширээний ард тавцан дээр зогсож бусад нь өрөөний доод хэсэгт байна.

Энд мөн өөр төрлийн зарц нар байлцсан нь гурван сагсгар тайга зантгар толгой, бүдүүн хүзүү, урт чихтэй хэд хэдэн том, үнэрч ноход болон одоо хаванцар гэж нэрлэгдэх болсон хоёр жижиг нохой байв. Тэд оройн хоолоо хүлээж ядан байгаа авч эзний ааш тааруу байгааг гадарлан нам гүм баргар байдлыг эвдэж тэвдэхгүй байв. Дөрвөн хөлт зарц нарыг хэт шарваганаж төвөг удаад ирвэл хэрэглэхээр зэхэж эзний өмнө тавьсан цагаан саваанаас тэд айсан ч байж болох юм. Ганцхан хөгшин чоно ч эрх нохойн эрээгүй зангаар хүндэт зөөлөн сандалд ойртож суугаад саглагар том толгойгоо эзний өвдөг дээр нэг тавьж, гар руу нь хушуугаараа нэг чичин эзний анхаарлыг татаж зүрхэлнэ. Гэвч Седрик түүнийг хүртэл "Зайл, Больдер зайл! Одоо чамтай эрхлэхтэй биш байна" гэж зандран зайлуулав.

Юу гэвэл бидний дурдсанчлан Седрикийн стэгэл тавгүй байлаа. Алсхан нэгэн сүм рүү оройн мөргөлд очсон Ровена хатагтай дөнгөж сая гэртээ ирээд бороонд норсон хувцсаа сольж саатаад байлаа. Гурт сүргээ аль эрт тууж ирсэн байвал зохих атал ер сураг чимээ байдаггүй. Гэтэл дээрэмчинтэй дайралдаад юм уу, хувийн өмчийн эрхийг үл ойшоохоос буцахааргүй хүчирхэг хөрш бээлүүдийн нэг довтолсноос ийнхүү саатсан байж болох билээ. Саксоны газрын эздийн ялангуяа тэжээл сайнтай ойрхон нутагт эд хөрөнгөний дийлэнх хэсэг нь олон тооны гахай байдаг болохоор Седрикт сэтгэл зовох онцгой шалтгаан байв. Үүний дээр хошин шог үгээр эзний үдшийн зоогийг амтлан арх дарсыг хүртэл ангид болгож өгдөг хайртай салбадай Вамбыг саксоны эрхэмсэг тайж бас үгүйлээд байжээ. Үдшийн зоогийн цаг аль хэдийн өнгөрсөн бөгөөд Седрик бүр үдээс хойш идсэн юмгүй. Дургүй нь хүрч үе үе огцмоор дуу алдан аман дотроо үглэх буюу эзнээ тайтгаруулахаар байн байн мөнгөн аягатай дарс авч ирж барих өөрийн дагуулыг дуудна.

Ровена хатагтай яагаад ингэж их саатаад байна гэхэд зарц бүсгүйчүүдийн нэг, эзэгтэйн дотночлогдсон шивэгчин гэрийнхээ эзэнтэй хайш хэрэг ярилцдаг зангаар:

- Эзэгтэй дөнгөж малгайгаа сольж өмсчихөөд одоохон ирнэ. Хатагтайг зүгээр овоодойтой, дан банзалтай хоолон дээрээ ирээсэй гэж та өөрөө бодохгүй шүү дээ. Харин энэ хавийн нутагт манай Ровена хатагтай шиг хурдан хувцаслах бүсгүй ганц байхгүй дээ гэв.

Ийнхүү няцаашгүй дарлан хэлсэнд Седрик сэтгэл ханав бололтой аман дотроо нэг юм

дуугарсан болсноо дараа нь:

- Дараа түүнийг Иоаны хутагтын сүмд мөргөхөөр явахад тэнгэр сайхан байж хайрлах болтугай гээд дагуул руугаа эргэн, хэн нэгэн үл хариуцах хүнд уураа гаргаж болоход баярласан мэт гэнэт ширүүнээр, - Ингэхэд Гурт юугаа хийж өнөө болтол ирэхгүй байна вэ? Муу юм дуулж таарах бий. Урьд тун үнэнч, хянуур сайн зарц байсансан. Би түүнийг бүр дээгүүр тушаалд магадгүй бие хамгаалагчдынхаа тоонд оруулах гэж санаж байсан юм гэв.

Дагуул Освальд цаг тийм ч оройтоогүй, гал унтрах дохио өгснөөс хойш ганц цагаас ер хэтрээгүй билээ гэж даруухнаар өчвөл саксон хүний чихнээ тун ч халдац муутай үг хавчуулагдсан тул сайхь өмгөөлөгч нь үр дүнгээр бага болжээ. Седрик үүнд,

- Тэр дохионы чинь хонх, түүнийг бодож гаргасан тамлагч болон тэр тухай саксон хэлээр саксон хүний чихэнд ярьж зүрхэлдэг усан тархитай боолыг цөм шулам автугай!... гээд жаал дуугүй байсна. – Дохионы хонх шүү! Реджинальд фрон де Беф, Филипп де Мальвуазен хоёр дохионы хонхны ашгийг Вильгельм Ублоткаас өөрөөс нь авахуулаад Гастингсийн тэнд тулалдсан норманы бусад бүх новшуудаас доргүй мэдэх учиртай. Дээрэм хийхээс өөрөөр тэжээх аргагүй, сүрэг олон дээрэмчдээ өлбөрч үхэхээс аврахын тулд өмч хөрөнгийг минь булааж авлаа гэж аягүй бол дуулдах бий. Үнэнч боол маань алагдаж, хөрөнгө маань дээрэмдүүлэн, Вамба ... Вамба хаана яваа бол? Түүнийг бас Гурттэй цуг явсан гэж нэг хэлсэн байх шүү! гэвэл Освальд толгой дохив.

- За тэр шүү, цагаас цагт л дордох юм! Тэгвэл саксоны тэнэгийг хүртэл норман язгууртны албанд аваад явчихсан байх нээ. Үнэндээ гэвэл тэдэнд хүчин зүтгэхийг зөвшөөрснөөр бид цөм тэнэгүүд, харин угийн хагас дутуу ухаантай төрчихсөн бол биднийг элдэвлэх үндэс тэдэнд арай бага байхсан. Гэвч би өшөөгөө авъя! гэж өөрийгөө элэг барьсан байж болох тухай санахын хамт босон харайж, ацаа шүүрэн дуу алдаад, --Би ерөнхий зөвлөлд зарга мэдүүлнэ. Миний нөхөд, миний талд хамсаатан бий. Би тэр норманыг эр хүний ёсоор шударга тулалдаанд дуудна. Аймхай хүнд зориг нэмдэг хуяг дуулга бүх зэр зэвсгээ хэрэглэг. Иймэрхүү хануур жад тэдний байлдааны бамбайг бодвол хоёр дахин зузаан хаалт нэвт хатгаж явсан удаатай юмдаг. Тэд намайг өнгөрсөнд тооцож байгаа байж магад, гэхдээ би хэдий эр бие ганцаар, үр хүүхэдгүй хэдий авч Седрикийн судсаар юу ч болтугай Хервардын цус лугшиж байдгийг тэдэнд үзүүлж өгнө. Уильфред, Уильфред минь гэж гашуунаар дуугаран, -чи тэр болчимгүй тэчъяалаа барьж дийлж чаддагсан бол эцэг чинь хөгшин болсон хойноо нөмрөөд ирэх догшин шуурганы өөдөөс нугарч нүцгэрсэн мөчрөө сарвайлгасан өнчин царс мэт болж үлдэхгүйсэн дээ гэв.

Энэ бол янз нь түүний хилэнг дарж гунигт автуулав бололтой. Хануур жадаа хажуу тийш тавиад сууриндаа сууж тэргүүнээ гудайлган гүн бодолд дарагдав. Чанга бүрээдэх дуу гарч Седрикийн бодлыг сарниулахад ноход хариуд нь хуцаж боргоов. Нохдыг хорьж дуугүй болгоход зарц нар болон нөгөө цагаан саваа багагүй мэрийлт гаргахад хүрчээ.

Өрөөнд шуугиан намдаж, зарц нарын үгийг нь дуулахтай болмогц, алив зарц нар хаалга руу оч, энэ бүрэн дуу бидэнд юу дуулгах гэснийг мэдэж миний эдлэнд ямар гээч хулгай луйвар гарсныг үзье гэж Садрик хэлэв.

Гурван минутийн дараа зарц нар буцаж ирээд Жорво хийдийн ширээт лам Эймер, сүмийн хүндэт, эрэлхэг зоригт сайн үйлт баатар Бриан де Буагильбер, дагуул цөөн хүнийхээ хамт, нөгөөдөр эндээс холгүй Ашби-деля-Зушид болохоор тогтсон эр баатруудын сорилтонд очих зам зуураа хоноглоод явахыг зөвшөөрнө үү гэж байна хэмээн дуулгав.

--Эймер! Ширээт Эймер гэнээ? Бас Бриан де Буагильбер үү? Хоёул Норман... гэхдээ норман, саксон нь хамаагүй. Ротервуд хүн буухад дургүйцэх учиргүй. Энд хоноглох л гэснээс хойш тавтай морилохыг урья. Тэд цаашаа өнгөрсөн бол зүгээр л байхсан. Гэхдээ зочны хувьд норманууд ч гэсэн арай даруу байх байлгүй! гээд Седрик сандлы нь ард цагаан очир бариад зогсож байсан гэрийн даамал руугаа эргэн –Гундиберт чи зургаа долоон зарц дагуулж очоод ирсэн хүмүүсийг зочдын байранд оруул! Морь илжгийг нь авч малла, дагуул сэлт нэг ч хүнийг бүү юмаар гачигдуулаарай, хүсвэл солих хувцас өг, гал түл, нүүр гар угаах ус бэлтгэ, дарс ундаа барь. Хоолондоо жаал зугаа юм хүм бушуухан нэмэрлээд зочдыг бэлэн болмогц зоог бариарай гэж тогооч нарт хэл. Саксоны эзэн хааны гэр бүлийнхнээс бусад зочдыг тавцангаасаа гурван алхмаас хол үл угтах андгай тавиагүйсэн бол Седрик өөрөө та бүхнийг угтахсан билээ гэж тэдэнд дуулгаарай. За яв, цаад бардам этгээдүүд чинь хожим, нөгөө бүдүүлэг саксон чинь арчаагүй харамч амьтан билээ гэж ярихгүйгээр бүхнийг ёсчлон гүйцэтгэ гэв.

Гэрийн даамал эзний тушаалыг биелүүлэхээр хэдэн зарц нарын хамт гарч одоход Седрик дагуул Освальддаа хандан:

- Эймер ширээт гэдэг чинь, би эндүүрээгүй бол одоо Миддлегем ноёнтон гэгдэж буй Жиль де-Мольверерийн төрсөн дүү мөн байхаа гэвэл цаадах нь тийм гэж хүндэтгэнгүй толгой дохив.

- Түүний ах нь илүү их өндөр язгууртай. Ульфгор Миддлегер ноёнтны цайз, эдолэнг булаан эзэгнэсэн. Гэхдээ Норманы бүх тайж нар тэгдэг юм даа. Энэ ширээт чинь судар ном, хонхны дуунаас ангийн бүрээ, аяга дарсыг илүүтэйд үздэг сүрхий наргианч санваартан гэсэн. За яая гэх вэ орог, аятайхан сайхан дайлнаа. Нөгөө сүмийн хороны баатрыг нь хэн гэдэг гэв? Гэхэд,

- Бриан де Буагильбер гэдэг гэв.

- Буагильбер гэнээ? гэж Седрик хэн нэгэн хүнтэй маргаж буй мэт бодол болон давтаж хэлсэн нь үргэлж зарц нарынхаа л дунд байсаар юм ярихдаа голдуу өөрөөсөө асууж сурсных ажээ.

- Буагильбер? энэ чинь дуулдсан л нэр. Сайн муу олон л юм түүний тухай гэлцдэг. Цуу үгээр бол сүмийн хорооны хамгийн эр зоригт баатруудын нэг юм гэнэ билээ. Гэвч тэдний хэвшил болсон бардам, хэрцгий, харгис, биеэ хэт өргөмжилсөн нүглүүдэд баригдсан хатуу сэтгэлтэй газар, тэнгэрийн аль алинд айж эмээх ганц ч хүнгүй юм байх. Юу ч гэсэн Палестинаас эргэж ирсэн цөөн дайчид л түүний тухай ингэж ярьдаг юм билээ. Гэхдээ манайд ганц хоноод явах юм чинь, яая гэх вэ, түүнийг мөн морилж ор л гэхээс дээ. Освальд чи хамгийн хуучин сайн дарс нэг торхыг ханзла, хамгийн сайн бол чанга аль дарс, хөөсөрсөн сидр дарс, амтлаг пигмент дарс авч ирж аль том аягаа тавь. Баатар лам хоёул сайн дарс, том аяганд дуртай улс. Эльджитэ, чи Ровена хатагтайд очоод, өөрөө л онц дурлахгүй бол наашаа энэ танхимд заавал ирнэ гэж өнөөдөр хүлээхгүй гэдгийг дуулга гэвэл бүсгүй огтхон ч түгдрэлгүйгээр:

- Өнөөдөр авхайтан ирэх гэж онц дурлана даа. Палестинаас шинэ сонин дуулах гэж үргэлж мөрөөдөж байдаг юм чинь гэв. Аманцар шивэгчин рүү Седрик ширүүн харсан боловч Ровена авхайтан болон түүнд үйлчилдэг хүн бүр тусгай эрх эдэлж, эзний хилэнд үл үртэх бүлгээ. Тэгээд зөвхөн:

- Амаа жаахан татаж байгаарай! Явж миний үгийг эзэгтэйдээ дамжуул, хэрхэгийг өөрөө мэднэ биү. Гэсэн ч энд Альфредийн ач охин эзэн хатны ёсоор тушааж байж болно гэв.

Эльджита өрөөнөөс гарч одов.

Палестин!... Палестин... гэж Седрик дуугараад –Загалмайн аян дайнд задгай зайдан дайчид, хуурмаг мөргөлчдийн энэхүү гайтай орноос авч ирдэг цуу яриаг хичнээн хүний чих шохоорхон сонссон бол! Би ч гэсэн үүнд автаж, асууж сураглан эдгээр залихай тэнүүлчдийн бидний гэр оронд шургалан орж дайлуулахад тус болдог тэр хоосон яриаг сэтгэл түгшин сонсохсон билээ... Үгүй, миний үгийг эс дуулсан хүү миний хүү биш, түүний хувь заяаны тухай, энэ мөрөн дээрээ загалмай хадаад завхай зайдан явдалд авган, аллага таллага хийж түүнийгээ бас бурхны таалал гэж яваа өөдгүй хүмүүсийн аь адгийн нэгний нь хувь тавилангаас ч илүүгээр бодож сэтгэл зовохгүй дээ гээд хөмсөг зангидан шал руу гөлрөв.

Дээш хартал нөгөө талын хоёр самбарт хаалга цэлийтэл нээгдэн очир барьсан гэрийн даамал бамбар барьсан дөрвөн зарцын хойноос энэ оройн зочид өрөөнд орж ирэв.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

*Гахай ямаа, хонь малын цус урсжээ
Гантиг чулуун дээр үхрийн мах дэлгэжээ.
Улалзах түүдгийн галд нь махнаасаа шаржээ.
Улбар дарстай хундганд нь дөлөн туяа тусчээ.
Улисс найр хуриманд хүндэтгэлтэйгээр залрав.
Угтсан хаан, харин түүнийг өнчин ширээнээ суулгав.*

Поп "Одиссея"

Эймер ламтан аян замын хувцсаа үдшийн илүү хээнцэр сайхнаар солих завшааныг ажиглаад, дээгүүр нь уран тансаг хатгамалтай жанч нөмөрчээ. Мяндаг тушаалы нь илтгэл том алтан бөгжнөөс гадна хийдийн ёс гуримнаас хэдий ахлах авч бас хэд хэдэн үнэт эрдэнийн чулуутайг зүүж, Испанийн маш нарийн сарьсан гутал өмсжээ. Сахлаа богино тайрч, хусмал дагзан дээрээ үнэт хатгамалтай улаан малгай тавьжээ.

Баатар ч мөн хувцсаа сольж хуягаа тайлаад үнэт үсээр хажсан хүрэн улаан торгон цамц өмсөөд дээгүүр нь том том тууш нугалаатай цасан цагаан урт нөмрөг намируулжээ. Хорооныхоо тэмдэг болон найман үзүүрт хар хилэн загалмайг нөмөргөн дээрээ хадсан бөгөөд үнэт шовгор малгайгаа авсан нь баравгар царайнд нь зохисон өтгөн хар үс магнайг нь аятайхан чимэглэжээ. Хэмжээгүй эрх сурахдаа эрдэж сурсны шинж болсон дээрэнгүй царай үгүйсэн бол чилгэр сайхан бие, ихэмсэг эвлэгхэн алхаа гишгээ тун ч нүдэнд дулаахан баймаар ажээ.

Хүндэт зочдын араас зарц нар нь тэдний хойноос бадарчний ердийн хувцастай замчин өрөөнд орж ирсэн нь даруй энгийн байдалтай. Хар өнгийн өргөн торгомсог даавуун цуваар хамаг биеэ ороожээ. Бадарчны хувцас хэрэгсэл гэвэл нүцгэн хөлөндөө сураар багласан бүдүүн борог шаахай, өргөн хүрээгээр нь хясаа хадаж гоёсон бүрх малгай, дээд талд нь далдуу модны навч уяастай төмөрлөсөн таяг эдгээрхэн ажээ. Өрөөнд хамгийн сүүлд номойхон орж ирээд дорд ширээнд Седрикийн зарц нар зочдын дагуулуудад суудал хүрэлцэхтэй үгүйтэй байгааг үзэн гал руу очиж хүхээгний дорхи вандан дээр суув. Тэнд хувцсаа хатаан, аз болж ширээнд суудал сулрах юм уу, аягачин энүүхэн буйд буланд нь жаахан идэх юм авчирч өгөхийг тэсвэртэйгээ хүлээнэ.

Седрик ихэмсэг найртайгаар зочдыг угтан босож хүндэт тавцангаас буун гурав алхаад зогсов.

- Миний өгсөн андгай, багш ламтан таны адил эрхэм зочин болоод энэ эр зоригт баатрын өөдөөс илүү хол угтахыг цаазалж байгаад их харамсаж байна, хүндэт ширээт лам гуай. Миний ийм найрсаг бус мэт үзэгдэж буй шалтгийг манай гэрийн даамал танд тайлбарлаж өгсөн байх учиртай билээ гэвэл:

- Андгайг чинь хүндэт тайж гуай гэх үү хэдий жаахан хуучирсан хэргэм боловч хүндэт захирагч гуай биелүүлж байвал зохино. Андгай гэдэг чухамдаа биднийг дээд тэнгэртэй холбож буй уяа мөний тул манай эх болсон ариун сүм хийд л эс тайлсан аваас түрүүчийн хэлсэнчлэн хатан баатар мөрдөж биелүүлэх учиртай гэлээ.

Седрик өөрийнхөө ширээний хажуу дахь дорд хоёр сандал дээр зочдыг урьж суулгаад зоог барь гэв. Энэ үеэр Гурт, хамт явсан Вамба хоёр өрөөнд дөнгөж орж ирээд байсныг харж.:

- Алив тэр олхиогүй амьтдыг нааш нь дууд! гэж Седрик тэсэж чадалгүй зандрав. Осолдсон боолчууд тавцан руу ойртож ирсэнд,

- За юу гэсэн үгэ вэ энэ чинь новшнууд аа? Гурт чи яагаад өнөөдөр ингэж оройтов? Чи сүргээ хурааж ирэв үү, аль тэнүүлчин дээрэмчин этгээдүүдийн хоол болгоод хаячихав уу? гэхэд

- Өршөөлт эзний тааллаар сүрэг маань бүрэн бүтэн байгаа гэж Гурт хариулав.

- Тэгвэл бүтэн хоёр цаг сэтгэл түгшин, элдэв муу юм бодон, айл хөршийнхний үйлдээгүй гэм хорын нь төлөө өс хонзон өвөрлөж суух миний таалалд огт нийцэхгүй байна, новш минь. Дахиад ийм хэрэг үйлдвэл дөнгө, шоронгоор залхаах болно шүү, сайхан мэдээрэй! гэв.

Эзнийхээ түргэн занг мэддэг болохоор Гурт биеэ зөвтгөх гэж оролдсон ч үгүй, харин олон юм үзэж өнгөрүүлсэн эзэн сүрхий өршөөнгүй байдаг болохоор нөхрийнхөө болоод өөрийнхөө өмнөөс хариулахыг зшрхлэн:

- Седрик өвгөө, та өнөөдөр үнэхээр ташаа юм ярьж байна шүү гэв.

- Юу гэнээ хөө? Чамайг наад тэнэг амаа дураар тавиад байвал манааны шовгорт аваачиж бэрээд гэж тушаана шүү гэхэд Вамба:

- Мэргэн хүн гуай нэг хүний осол буруугийн төлөө хүнийг цээрлүүлнэ гэдэг шударга хэрэг үү үгүй юу гэдгийг эхлээд хариулж аль? Гэвэл:

- Үгүй байлгүй яах вэ тэнэгээ гэлээ.

- Тэгвэл Гуртын нохой Фангсын буруу гэмийн төлөө хөөрхий Гуртыг гавална гэж та юунд сүрдүүлнэ вэ? Сүргээ цуглуулснаас хойш бид ганц ч хувь саатаагүй гэдгийг би одоо даруй андгайлж хэлэхэд бэлэн байна. Харин Фангс үдшийн мөргөлийн хонх дуугарч байхад л сая цуглуулж дууссан гэлээ.

- За тэгвэл Фангсыг дүүжилж орхи, нохой буруу байж. Өөр нохой олж ав гэж Седрик Гуртэд хэлбэл салбадай мөн оролцож:

- Өвгөө жаахан азнаарай, юу гэвэл энэ шийдвэр чинь төдий л шударга биш байна. Фангсийн хөл нь доголоод сүрэг даруй цуглуулж чадахгүй байсан тул түүний онцын буруу нь юу бана? Энэ чинь урд хөлийн нь хумсыг суга татсан тэр хүний л буруу, хэрэв Фангсаас өөрөөс нь асуусан бол хөөрхий амьтан лав зөвшөөрөхгүй байсан даа гэв.

Саксон тайжийн хилэн дороо дүрсхийж, --Миний боолын нохойг хэн тэгж зэрэмдэглэж зүрхлээ вэ? гэвэл Вамба хариуд нь:

--Хэн юу байхав. Филипп Мальвуазен гуайн ангийн даамал өвгөн Губерт л зэрэмдэглэсэн байна билээ. Фангсыг модон дотор барьж аваад буга хөөж байсан гэж гэнэ. Тэгэхийг эзэн нь

хориглосон юм гэх шив. Тэр өөрөө ойн манаач, тэгээд л ... гэтэл Седрик дуу алдан:

- Тэр Мальвуазенг манаач сэлттэй нь чөтгөр алгавал таарна! Энэ мод, ойн их хуулиар ангийн дархалсан газруудын тоонд ороогүйг би тэдэнд баталж өгнө!.. За, одоо энэ тухай ярихаа больё. Яв, зальхай амьтан, сууриндаа суу. Гурт чи өөр нохой олж ав, тэр манаач дахиад түүнд гар хүрсэн байвал би нум сумаар харвахыг нь бүр мартуулаад өгнөө гайгүй. Баруун гары нь эрхий хурууг огтолж хаяхгүй юм бол би хараал идсэн муу хулчгар амьтан болог, эс тэгвэл дахин харвахаа болих бий... Хүндэт зочид минь уучлаарай, манай хөршийнхөн буруу номтноос дор айхавтар улс даа, баатар гуай. Гэвч манай өчүүхэн зоог нэгэнт та бүхний өмнө тавиастай байна. Зооглож хайрла, бидний дайлах гэсэн үнэн сэтгэл хомс дутууг нь нөхөж өгөх болтугай гэлээ.

Ширээн дээр тавиастай зоогийг харвал харин гэрийн эзний манж үгний хэрэг үгүй ажээ. Хэд хэдэн янзаар бэлтгэсэн гахайн мах, гэрийн шувууны махаар хийсэн олон янзын хоол болон том талх, боов, амттан сэлтийг үл өгүүлэн, буга, ишиг, туулайн мах янз янзын загас тэргүүтэн өрөөстэй байв. Жижиг шувуудыг тавган дээр бус модон тор, шарсан төмөртэй чигээр нь тавьжээ. Хиа зарц нар зочдод эрэмбэ дараагаар барин хүмүүс идэх хирээрээ авна. Зочин бүрийн дэргэд мөнгөн аяга тавиастай байх бөгөөд дээд ширээн дээр том том эврээр дарс ууцгаана. Дөнгөж хоол идэхээр завдтал гэрийн даамал очир өргөн өндөр дуугаар:

- Уучлал гуйя. Ровена хатагтайд суудал тавиарай гэж дуулгав.

Хүндэт ширээний ар талын булан дахь хажуугийн жижиг үүд нээгдэн Ровена хатагтай дөрвөн шивэгчингийн хамт тавцан дээр гарч ирэв. Хүмүүжүүлсэн авхай нь иймэрхүү нөхцөлд эдгээр хүмүүсийг байхад хүрч ирсэнд нь Седрик гайхан, дургүйхэн байлаа. Хэдий тийм авч өөдөөс нь яаран босож гараас нь хөтлөн баруун гар талынхаа өндөр суудал руу ёсорхуугаар авч явав. Авхайг орж ирмэгц цөм босоход эелдэг ёсны энэ илрэлийн хариуд бүсгүй дуугүй мэхэсхийгээд суудал руугаа намбатай гэгч алхлаа. Авхайг сууж амжаагүй байтал баатар ламд шивэгнэн:

- Эрүүл тулалдаан дээр таны алтан гинжийг би зүүхгүй нь, хиоссийн дарс таных болжээ гэлээ. Лам үүнд, би танд юу гэлээ? Гэхдээ наад сэтгэлээ жаал дараарай, тайж гуай таныг ажиж байна шүү гэв. Зөвхөн хувийнхээ хүсэл сэтгэлийн дагуу явж сурсан Бриан де Буагильбер энэхүү сэрэмжийг үл хайхран дорно дахины хатагтай нартай огт адилгүйн улмаас ч гойд гайхалтай санагдсан байж болох саксоны гоо авхай руу гөлөрчээ.

Ровена гоолиг, өндөр нуруутай гэхдээ нүдэнд тусам ч их өндөр биш аж. Царай нь гойд гялбам тунгалаг, боровгор туяатай жирэвгэр хөмсөгний дор тунгалаг цэнхэр нүд дүрэлзэнэ. Энэ нүдэнд хүний сэтгэлийг хөөрүүлэх, номхтгох, тушаах, гуйх, чадал аль алин бүрэлдсэн мэт. Дөлгөөн дүр нүүр царайнд нь зохих ажээ. Гэхдээ хүн болгон өмнө нь биширч, орчин тойрноо захирч сурсан зан саксоны энэ хүүхэнд гойд ихэмсэг төрх суулгажээ. Цайвар боровгор өнгийн өтгөн үсээ хээнцрээр мушгируулан унжуулж эрдэнийн чулуугаар чимэн сүлжсэн нь мөрөө сул нөмөрч язгуур угсаатайг давхар илтгэнэ. Хүзүүнд нь алтан гинжтэй жижиг алтан хөлөг онгоц зүүлттэй, нүцгэн гартаа бугуйвч хийжээ. Далайн усны өнгөтэй торгон даашинзны гадуур өөр нэг, газар хүрсэн урт, уужуу тохойгоо хүрсэн асар өргөн ханцуйтай уут маягийн хувцас нөмөрчээ. Гал улаан өнгийн энэ хувцсыг хамгийн нарийн ноосоор нэхжээ. Үүний

заханд алтан хатгамалтай сиймгэр торгон татуурга залган хадсан бөгөөд дуртай цагтаа үүгээр нүүр цээжээ бүтээх юм уу мөрөн дээр хаячихаж болох ажээ. Сүмийн хорооны баатрын нүд цогны оч мэт гялалзсан өөдөөсөө ширтэхийг Ровена авхай хармагцаа ийнхүү гөлрөх өөрт нь таагүй байгааг илтгэн татуургаараа нүүрээ ихэмсэг гэгч бүтээж орхилоо. Седрик энэ хөдөлгөөнийг харж шалтгааныг гадарлан:

- Эрхэм баатраа, манай саксон нутгийн охидын нүүр нарны илч тун ховор үздэг болохоор загалмайтны нэвт шувт харцыг даахгүй шүү гэвэл Бриан үүнд:

- Би осолдсон болж гэм танаас уучлал гуйя, чухам гэвэл Ровена хатагтай намайг хэлтрүүлж үзнэ үү. Үүнээс цааш илүү их хүлцлийг би хүлээж үл чадах хүн билээ гэв.

- Ровена хатагтай миний нөхрийн зоримгийг цээрлүүлэх гээд бид бүгдийг залхаачихлаа. Бид эрүүл тулалдааны үед учрах ихэс дээдсийн хувьд арай тийм хатуу сэтгэлтэй байхгүй болов уу гэж горилно гэж ламтанг өгүүлэхэд:

- Бид эрүүл тулалдаан үзэхээр явах эсэхээ би шийдээгүй л байна. Английг чөлөөт байх үед манай өвөг дээдсийн мэддэггүй байсан энэ хоосон цэнгэлд би төдий л дуртай биш хүн гэж Седрик дуугарав.

- Гэлээ гэхдээ манай багийг дандаа тийшээ очихыг зүрхлэх болов уу гэж би найдах байна. Зам өдий осолтой байхад Бриан де Буагильбер гуайтай цуг явах завшааныг багад үзэж болохгүй гэж лам хэллээ.

Саксоны тайж: - ширээт гуай энэ оронд хаана нь ч аялж явахдаа өнөө хүртэл би өөрийнхөө сайн илд, үнэнч зарц нараасаа өөр хэний ч өмгөөллийг эрж яваагүй билээ. Тэгээд ч бид Ашби-де-ля-Зуш орох боллоо гэхэд манай өндөр язгуурт хөрш Ательстан Конингсбург хань болох тул дээрэмчид, дайсан феодалуудын аль алинаас бид айх явдал үнэхээр үгүй. Энэ хундагыг ширээт таны эрүүл энхийн төлөө өргөө. Миний дарс танд таалагдах болов уу гэж горилно. Таны эелдэгт бас баярлалаа гэснээ нэмэн –Та харин хийдийнхээ гуримыг хатуу мөрдөж цийдэм уухыг илүүтэйд үздэг бол сэтгэл зоволгүй найрсаг ёсыг бодсон төдийгөөр дарс уухгүй байсан болов уу гэвэл, ширээт инээд алдан хариуд нь:

- Үгүй, бид чинь зөвхөн хийдийнхээ хооронд л шинэ сүү юм уу цийдэм уудаг болохоос гадуур бол энгийн хүмүүстэй адил явдаг. Иймээс би таны найрсаг хундаганы хариуд мөн адил жинд дарс өргөн арай сулавтар ундааг танхилчдаа тохооё гэв.

Баатар мөн аяга дүүргэн – Би гоо сайхан Ровенагийн төлөө ууя. Таны нэр нэгт бүсгүй, Английн хөрсөн дээр шингэсэн дурсгалт өдрөөс хойш энэ орон биширвэл зохих илүү сайхан бүсгүй лав үзээгүй. Нэр төрөө барьж андгайлахад би хөөрхий золгүй Вортигерныг одоо бүр сайн ойлгож байна. Бидний нүдэн үзэж байгаа гоо сайхны ядаж алсын төсөө ч билээ түүний дэргэд байсан гэвэл нэр төр, хаант улсаа мартахад энэ чинь хүрэлцээтэй юм байна гэхэд Ровена татуурга үл сөхөн ихэмсгээр:

- Таныг өдий их ялдам урсгал үг урсгаасай гэж би хүсэхгүй байна баатар гуай. Харин таны эелдгийг ашиглан Палестины тухай сүүлчийн сонин зүйл дуулгахыг гуйя. Энэ яриа чинь

англи бидний чихэнд таны франц хүмүүжлийн нөлөөгөөр урсгаж байгаа магтаал үгнээс илүү халдацтай билээ гэв.

Бриан де Буагильбер үүнд: - Сонирхолтой юм олныг хатагтай танд дуулгаж чадахгүй байх Саладинтай түр найрамдал байгуулсан үнэн гэдгийг баталж чадна гэвэл Вамба ярианд оролцон тасалж орхив.

Салбадай эзнийхээ зөөлөн сандлын ард суух бөгөөд Седрик байн байн тавагнаасаа хишиг авч өгнө. Түшлэгэн дээрээ илжгэн чих сийлсэн тусгай сандал дээр жижиг ширээний ард суун нүүрээ чинэртэл нугдайн нүдээ хагас аньжээ. Өөрт нь зүгээр өнгөрдөг аль нэгээр дүрсгүйтэх завшааныг цалгардаж өнгөрүүлэхгүйн тулд харин цаг ямагт чих тавин суужээ.

- Үгүй энэ, түр найрамдал уу? Намайг бүр хөгшрүүлж гүйцлээ гээч гэж Вамба дуу алдсанд Седрик тэнэгийн ямар үү хошин үг хэлэхийг хүлээн илтэд тааламжтайгаар:

- Юу гэнээ, залихай минь! Юу гэсэн үг вэ? гэж асуувал вамба өөдөөс нь:

- Тэгэлгүй яах вэ, энэ насанд маань гурван ийм түр найрамдал байгуулагдсаны тус бүр нь тавин жилээр шүү. Тэгэхлээр чинь би одоо зуун тавь хүрчихсэн болж таарах нээ гэв. Ойд учирсан танилаа баатар таниад - Чи хөгширч нас барахгүй гэдгийг би батална. Чи өнөөдөр ширээт бид хоёрт зам заасан шигээ явуулын хүмүүст цаашид зам зааж өгөөд байвал зуурдын үхлээр өнгөрөх төөрөгтэй гэсэн үг гэлээ.

--Юу гэсэн үг вэ, муу хогоо! гэж Седрик дуу алдан явуулын хүмүүсийг зам төөрүүлнэ гэнээ? Чамайг торлох хэрэгтэй юм байна, чи чинь тэнэгийнхээ дайны махчин амьтан байх нээ гэлээ.

- Өвгөө минь өршөөл үзүүл, энэ удаа миний овжин гэгдсэнийг тэнэгээр минь хэлтрүүлж үз. Би ганцхан баруун зүүн гараа сольж орхисонд л хамаг буруу маань байж. Тэнэг хүнээс заавар зөвлөлгөө эрсэн хүн өөрөө бас ухаарсан байлтай гэв.

Тэгтэл хаалгач гадаа явуулын хүн ирээд хонуулахыг гуйж байгааг дуулгахаар явуулсан зарц ирж яриа тасалдав.

- Хэн ч байлаа гэсэн ялгаагүй оруул гэж Седрик хэлээд – Гадаа шуурч ийм сүрхий шөнө зэрлэг араатан хүртэл сүрэгт нийлэн хорогдож догшин шуурганд эрсдэхгүйн тулд өштөн дайсан болох хүнээс хүртэл өмгөөлөл эрдэг юм. Юу хэрэгтэй бүхнийг нь өгөөрэй. Освальд чи сайн асарч амруул гэв.

Дагуул даруй өрөөнөөс гаран эзний тушаалыг биелүүлэхээр одлоо.

ТАВДУГААР БҮЛЭГ

*Еврей хүнд харах нүд ч үгүй буюу?
Еврей хүнд гар бие, зүрх сэтгэл, хүсэл шунал үгүй буюу?
Өөр хоолон иднэ үү?*

*Англид зэмсэгт хорлогдох уу?
Тусгай өвчинд нэрвэгдэнэ үү,
Өвлийн хүйтэнд эс даарна уу,*

Зуны наран түүнийг христос шашинтны гэгээн адил үлдээнэ үү?

Шекспир "Венецийн худалдаачин"

Освальд буцаж ирээд эзнийхээ чих рүү бөхийж,

- Тэр чинь еврей хүн байна. Йоркийн Исаак гэж нэрээ хэллээ. Нааш нь шууд оруулаад ирвэл зүгээр болов уу гэж шивнэхэд Вамба хажуунаас нь:

- Энэ удаа үүргийг чинь Гурт биелүүлэг, еврейг гахайчин дагуулж ирэх нь яг таарна гэв.

Ламтан загалмайлан залбираад – Мария хутагт минь ийм хүмүүс дээр еврей оруулж ирэх гэж үү? Гэхэд

- Юу! Гэгээн шарил хамгаалагч хүнтэй муу еврей нохойн нэг өрөөнд суух гэж үү хэмээн баатар хариу дуугарав.

Вамба тэгэхэд нь харав уу, хөөш сүмийн хорооны баатар гэдэг чинь еврейгийн мөнгөнд бол дуртай, өөрсөдтэй нь хамт байхыг таалдаггүй байх нээ гэв.

- Яая гэх вэ хүндэт зочид минь, та бүхний таалалд нийцүүлэн эелдэг зочломтгой ёсыг зөрчиж би чадашгүй. Бурхан багш буруу шажин тууштай шүтэгч бүхэл ард түмнийг олон зуунаар байлгаж тэсээд байгаа хойно бид ганц еврей хүнийг цөөн цаг тэсвэрлээд өнгөрөөж болох биз. Тэндээ тэр хүнтэй ярьж хөөр гэж би хэнийг ч албадахгүй. Түүнд тусгай ширээ засаж өгөөд ангид нь хооллочих гээд инээмсэглэн - үгүй тэр цаламтай харь нутгийнхан түүнийг дэргэдээ авч магад юм даа гэж нэмж хэлэхэд сүмийн хорооны баатар хариуд нь:

- Эрхэм тайж гуай, миний сарацины боолчууд Мусульман шашиндаа их сүсэгтэй, еврей нарыг христос шашинтнаас дургүй үзэн яддаг улс гэвэл:

- Тангараглаж хэлэхэд Махмуд Термагант нарын сургаалыг баримтлагчид, бурхан багшийн урьд нэгэн цагт өөрөө сонгон авсан тэр ард түмнээс юугаараа дээр юм, би огт мэдэхгүй юм гэж Вамба ярианд оролцов.

--За яах вэ, цаадах чинь чамтай хамт сууг, цуглаачин тэнэг хоёр таарсан хос биш үү гэж Седрик хэлсэнд Вамба гахайн ууцны яс авч дээш өргөн сэгсрээд,

- Тэнэг ч харин шулаачингаас амиа аргалаад тусгаарлачихна үү гэв.

- За дуугүй!.. Цаадах чинь ирж явна гэж Седрик хэллээ.

Өрөөнд алив ёс төр гэлгүй ирсэн өндөр туранхай өвгөн хулгаж, айсан байртай алхан, алхам бүрдээ дор мэхийн ёсолно. Ийнхүү бөхийсөөр нэгэнт дадсан тул өөрийнхөө нурууны хирээс нам юм шиг харагдана. Царай төрх шулуун аятай бүргэд хамар, хянуур хурц хар нүд, үрчлээ суусан өргөн магнай, урт буурал үс, их сахал сэлт цөм аятайхан сэтгэгдэл төрүүлж болмоор. Гэтэл тэрхүү харанхуй бүдүүлэг цагт сүсэг бишрэлт мунхаг эгэл хүмүүсийг жигшлийг төрүүлж, ашиг завшаан эрэлхийлэгч ховдог шунахай тайж нарын зүгээс хатуугаар мөрдөн хяхагдаж байсан үндэстний хүн гэдэг нь тун хартал ил төржээ.

Еврейгийн хувцас гэж хүрэн улаан өнгийн энгийн нэг бор цув ажээ. Ангийн үсээр эмжсэн том гуталтай, бүсэндээ хутга, бичгийн хэрэгсэл бүхий хайрцаг хоёр хавчуулжээ. Дөрвөн талтай, өвөрмөц хийж бүхий гозгор шар малгай толгой дээрээ тавьсан нь христос шашинтнаас ялгарах тэмдэг болгон өмсөх хуультай ажээ.

Седрикийн гэрт эл хүнийг хүлээж авсан байдал Израилийн энэ омгийг голгүй өширхөн дайсагнагч хүний боловч бахыг хангахаар болов. Еврейг олон олон мэхийн ёсолсны хариуд Седрик өөрөө зөвхөн толгой дохиод ширээний дрд өнцөг рүү зангав. Гэтэл тэнд зай тавьж өгөхөөр хөдөлсөн хүн ер үгүй. Тэгэхэд хүн хүн рүү царайчилж, дальдарч харсаар ширээний дагуу явахад саксон тайжийн зарц нар зориуд тохойгоо тэлж мөрөө өргөөд шинэ айлчинг огтхон ч үл хайхран үдшийн хоолоо идэцгээнэ. Хийдийн тахилчид хилмэгдэн зэвүүцсэн байртай еврей рүү эргэж хөрөн загалмайж, залбирах бөгөөд сарацинууд хүртэл Исаакийг хажуугаараа өнгөрөх үед ууртайгаар сахлаа имрэн, гинжаал хутгаа тэмтэрцгээн түүний ойртохоос бүхий л аргаар сэрэмжлэхэд бэлтгэх мэт. Буруу үзэгдсэн ард түмний үр садыг гэртээ хорогдуулсан тэр шалтгааныхаа үүднээс өөрийнхөө хүмүүсийг Исаактай эелдэг бай гэж Седрик шаардаж тун магад байсан боловч яг энэ үеэр ламтан дуртай нохдын нь тухай маш сонин яриа үүсгэсэн тул нэг еврей оройн хоолтой унтах уу үгүй юу гэдэг асуудлаас хавьгүй илүү чухал хэрэг гарлаа ч гэсэн Седрик таслахгүйсэн ажээ.

Исаак суугаад жаахан амарчих газар олдох болов уу гэж дэмий горилон олноос зайдуу зогссоор байтал зуухны дэргэдэх яндан дээр сууж байсан бадарч эцсийн эцэст өрөвдөж суудлаасаа босон:

- Өвгөөн, миний хувцас хатаж орхилоо. Би нэгэнт цадлаа, та харин нэвг норчихсон өлөн байна гэв.

Ингэж хэлээд унтарч буй галын цуцлуудыг уужим голомтын дунд цуглуулаад хурц гал ноцоов. Дараа нь ширээ рүү очиж ишигний чанасан мах, халуун хоол авч ирж өөрийнхөө хоол идсэн ширээн дээр тавьж өгөөд, еврейг баярлалаа барилаа гэхээс урьтаж өрөөний нөгөө булан руу очлоо. Тус болсон хүнтэйгээ ярьж хөөрөхөөс дургүйцсэн ч юм уу, хүндэт тавцан руу зүгээр жаал ойртоё ч гэсэн байж болох юм.

Тэр цагт иймэрхүү сэдвийг гаргаж харуулж чаддаг уран зураач байсансан бол гал руу тонгойн бээрч чичирсан гараа ээж байгаа энэ еврейн байдал хорвоогийн цаг улирлыг муугүй илтгэн үзүүлэхээр ажээ. Жаахан дулаацаж аваад уур савссан хоолыг хавьд юм амсаагүй аятай яарч сандран илтэд амтархан идэж орхив.

Энэ зуур ламтан ан гөрөөний тухай Седриктэй яриа дэлгэж Ровена авхайтан шивэгчингүүдийнхээ нэгтэй аминчлан хөөрөлдөхөд сүмийн хорооны дээрэнгүй баатар еврей рүү нэг харж, Саксоны гоо сайхан бүсгүй рүү нэг харж аминдаа маш сонин чухал нэгэн зүйлийн тухай бодол болж байх аятай.

- Ан авын ур чадварын тухай ярихад франц норман хэл бүх талаар давууг хүлээн зөвшөөрөх зориг хүрэхгүй байгаад тань гайхаж байна, хүндэт Седрик гуай. Ой талын ан авын аль алины хувьд өдий өгөөмөр олон тусгай нэр ус сэлт өөр ганц ч хэлэнд үгүй гэж ламыг хэлэхэд Седрик хариуд нь:

- Үгүй сайхан сэтгэлт ширээт минь, би тэр далайн цаадах орны нарийн ширийн занг дуурайх гэж огтхон ч хөөцөлддөг хүн биш, тэргүйгээр би ойд цагийг тун таатай өнгөрүүлдэг. Эврээр бүрээдэж чадна, ноход ан руу турхирч мэднэ, ангийн арьсыг яаж аятайхан өвчиж дэлгэхийг андахгүй, тэгээд тэр үлгэрийн эрхэмсэг Тристрамын галбирын элдэв хээнцэр чалчаа үгний хэрэггүйгээр сайхан болоод байдаг юм гэв. Сүмийн хорооны баатар дээрэнгүйгээр дуугаа өндөрсгөн:

- Франц хэл гэдэг зөвхөн ан авд төдийгүй хайр сэтгэл, цэрэг дайны үйлд тохирсон цор ганц олигтэй хэл мөн. Энэ хэлээр л бүсгүйн сэтгэлийг татаж, өстөнгөө тулалдаанд дуудаж байвал зохино гэвэл Седрик өөдөөс нь:

- Эрхэм баатар тантай нэг нэг аяга дарс уучихъя. Аа бас ламтанд хундагалчих, тэр зуур би гучин жилийн өмнө болсон нэгэн явдал ярьж өгье. Тэр цагт саксоны Седрикийн францын янаг амрагийн шүлэг бичигчдээс зээлдэж авсан чимэг сэлтгүй жирийн англи яриа гоо бүсгүйчүүдийн чихэнд таатай байсан. Бид Норталлертоны талд тулалдаж байхад Шотландын цэргийн эгнээ саксончуудын дайны тухай норманы хамгийн эрэлхэг бээлүүдийн дайчин уухайнаас дутуугүй сонсогдож байсан. Тэнд байсан эрэлхэг дайчдыг дурсан нэг аяга дарс уучихъя, зочид минь хамтраад барьчих гэв.

Седрик аягатай нэгмөсөн хөнтөрч орхиод яриандаа ихэд улайран цааш нь:

- Мөн ч олон бамбай тэр өдөр тас цавчигдаа биз дээ? Эрэлхэгчүүдийн дайнд толгой дээгүүр зуу зуун туг намираад л цус гол мэт урсан, үхэл гэдэг ухарч зугтахаас илүү сайхан санагдаж байсансан. Саксоны яруу найрагчид тэр өдрийг илд сэлмийн баяр гэж нэрлэсэн юм. Сүрэг бүргэд олз ав руу ханаран дайрч, хатан бат хушуугаараа дайсны бамбай дуулга руу тогшиж байсан бөгөөд дайны уухай яруу найрагчдад хуримын дуунаас илүү наргиантай санагдаж байсан билээ. Гэвч одоо манайд яруу найрагчид үгүй болсон. Манай алдар гавьяаг өөр ард түмний үйл хэрэг арчин арилгаж манай хэл, бидний нэр хүртэл мөдхөн мартагдах болно. Ганцаардмал өвгөн надаас өөр үүнд харамсах хүн ер алга... Алив, дагуул залхуу золиг чи дарс дүүргээч! Аль омгийн болов, ямар ч хэлээр ярьдаг гэсэн дайнд эрэлхэг зоригтны төлөө ууя, эрхэм баатраа Загалмайг өмгөөлөн Палестины цэргийн эгнээнд бүхнээс эрэлхгээр тулалдагсдын төлөө барья гэв.

Бриан де Буагильбер үүнд – Би өөрөө загалмай зүүж яваа тул энэ тухай ярихад тийм ч тааламжтай биш юм, гэвч загалмайтны дотроос бурхан багшийн шарилыг үнэнчээр хамгаалагч сүмийн хорооны баатруудаас бус хэнийг тэргүүнд үзэх билээ гэвэл лам:

- Иоаннитуудыг гэж болно. Манай ах энэ хороонд орсон юм гэлээ.

- Би тэдний алдар гавьяаг үгүйсгэх гээгүй гэвч ... гэж баатрыг хэлэхэд Вамба ярианд оролцон:

- Ингэхэд байнаа, Седрик өвгөө, арслан зоригт Ричард арай илүү ухаалаг, тэнэг миний үгийг дуулсан бол зугаатай англичуудтайгаа хамт гэртээ сууж, Иерусалимыг бууж эзлүүлсэн баатруудаар нь чөлөөлүүлэхээр орхисон бол дээр байхсан гэв.

- Английн цэргүүдийн дотор сүмийн хорооны юм уу, ионнитуудын баатруудтай чацуугаар нэр нь дуурсагдаж болох хүн ер үгүй байлаа гэж үү? Гэж Ровена хатагтай гэнэт асуусанд Буагильбер хариуд нь:

- Хатагтай намайг уучлаарай, английн хаан Палестинд зөвхөн ариун газрыг цаг үргэлж цээжээрээ хамгаалж байгаа хүмүүсээс л эр зоригоор дутах олон эрэлхэг дайчид дагуулж очсон гэв.

Ойрхон зогсож энэ яриаг тэсэж ядан чагнаж байсан бадарчин: Тэд хэнээс ч эр зоригоор дутаагүй гэв. Энэ гэнэтийн зоримог дуу гарсан зүг бүхний хараа чиглэв. Бадарчин эршүүд чанга дуугаар –Арин газрыг хамгаалахаар илдээ сугалсан хүмүүсийн хэнээс ч английн баатрууд дутаагүй. Түүнээс гадна Сен-Уанд акр цайзыг эзлэн авсны дараа Ричард хаан таван баатруудынхаа хамт бүх хүсэлтэн эрчүүлийг эрүүл тулалдаанд дуудсаныг дурдъя. Би үүнийг нүдээр үзсэн болохоор ярьж байна. Тэр өдөр тэдгээр баатар тус бүр гурван удаа талбайд гарч тухай бүр дийлж байсан. Тэдний эрсэг тулалдагсдын долоо нь сүмийн хорооны баатрууд байсан бөгөөд Бриан де Буагильбер үүнийг сайн мэдэж байгаа болохоор миний үгийг баталж өгнө байх гэв.

Баатрын барайсан бор царайнд эгшин зуур уур хилэн дүрэлзэж ирэв. Бачимдан чичирхийлсэн гараар илднийхээ бариулыг шүүрч авсан боловч ийм газар, иймэрхүү гэрч нарын дэргэд бадарсан хилэнгийнхээ эрхшээлд автах хир их аюултай болохыг ухамсарласны улмаас арай л сугалж зүрхэлсэнгүй бололтой. Харин энгийн эршүүд шулаан зантай элдэв юмны тухай нэгэн зэрэг бодож үл чадах Седрик өөрсдийнхөө эрэлхэг гавьяаны тухай сонсоод хэт баярласандаа зочныхоо ийнхүү их зэвүүрхсэнийг ажсангүй.

- Манай зугаа наргиант Англи орны нэр алдрыг тэгж сайхнаар хадгалсан баатруудын нэрийг хэлж өгвөл би энэ алтан бугуйвчийн дуртайяа өгөх байна гэж Седрик хэлсэнд:

- Тэдний нэрийг дуртайяа хэлье. Харин ямар ч бэлэг сэлт хэрэггүй. Нэг хэсэгтээ алтанд гар хүрэхгүй андгай юм би гэж бадарчин хариулав.

- Эр зориг, цэргийн эрдмээр тэргүүн баатар нь Английн хаан зоригт Ричард байсан юм гээд бадарчинг хэлтэл Седрик тосон авч:

- Би түүнийг уучиллаа! Эзэрхэн дарангуйлагч Вильгельм хун тайжийн удам угсаа мөн болохыг нь уучиллаа! гэж дуу алдав.

- Удаах нь Лейстер гүн, гуравдах нь Гильслендийн Томас Мультон гуай байлаа гэхэд:

--Тэр чинь ёстой нэг саксон эр дээ! гэж Седрик бахдан дуугарлаа.

- Дөрөв дэх нь Фульк Дойли гуай гэхэд үг бүрийг нь хомхойрон чангаж байсан Седрик –Тэр чинь мөн л дор хаяад эхийнхээ удмаар саксон хүн дээ гэлээ. Английн эзэн хаан, төрөлх нэгэн арлынхныхаа ялж дийлсэн тухайд баярлаж хөөрсөндөө норманчуудыг үзэн яддангаа ч бараг мартчихаж, -За тав дахь хэн байв даа? гэж асуув.

- Тав дахь нь Эдвин Тронхем гуай гэхэд:

- Ёстой цэвэр саксон хүн, Хенгистийн сүнсийг барьж андгайлъя! гэж

хашгираад - Үгүй зургаа дахь. Зургаа дахь баатрын нь нэр хэн бэ? гэвэл бадарчин санахыг хичээх байртай түр зуур дуугүй байснаа:

- Зургаа дахь нь нэрд их гараагүй арай доогуур язгууртан залуухан баатар байсан. Энэ баатруудын эгнээнд түүнийг эр зоригтойд нь ч биш, тоо гүйцээхийн тулд л оруулсан юм билээ. Нэр нь одоо мартагдаад орхижээ гэлээ.

Бриан де Буагильбер: Бадарчин гуай та нэгэнт өдий олон юм санаж амжсаныхаа эцэст ингэж хуурамчаар мартагчин болдог чинь үл үнэмшигдэнэ. Золгүй тохиолдлын уршгаар, миний морины буруугаас болж намайг эмээл дээрээс минь ховх татаж хаясан баатрын нэрийг би өөрөө нэрлэж өгнө. Тэр хүнийг Айвенго баатар гэдэг. Айвенго нас залуу хэдий авч түүний нөхдийн нэг нь ч зэр зэвсэг эзэмшихдээ түүнээс давж чадаагүй билээ. Гэвч Айвенго Англид байгаад одоо болох гэж байгаа тулалдаан дээр Сен-Жан д Акрэд хийсэн дуудлагаа давтал зэвсэг сонгож авах эрхийг түүнд өгөн тулалдахад бэлхэн байгаагаа олны өмнө чангаар мэдэгдэж байна. Одоо эзэмшиж байгаа морь зэмсэгтэй байхдаа тулалдааны үр дүнг хааш нь болохыг өөрөө багтай хариуцна гэхэд бадарчин:

- Таны өштөн энд байсансан бол таны энэ дуудлагыг дор нь хариулах агсан билээ. Одоогийн нөхцөл байдалд харин энэ амгалан айл гэрийн амар тайвныг эвдэж хараахан болохуйяа хэцүү тулалдаанд дийлэхээрээ гайхуулахын хэрэг үгүй бизээ. Харин Айвенго нэгэн цагт Палестинд эргэж ирвэл тантай тулалдах болно гэдгийг би баталж хэлье гэлээ.

- Сүрхий ч баталгаа бол доо! гэж баатар үл тоомсорлоод та надтай юугаар дэнчин тавьж чадах юм бэ? гэхэд бадарчин цуван дороосоо заяаны ясан жижиг хайрцаг гаргаж ирэн загалмайлаад:

- Энэ сахиусан дотор Монт-Кармелийн хийдээс авч ирсэн жинхэнэ бурхны хадагдсан загалмайн хэлтэрхий байгаа юм гэв.

Жорво хийдийн ширээт мөн загалмайлан залбираад "эцэг болсон

Бурхан багшийг " чангаар сүсэглэн уншив. Сүмийн хорооны баатар, мусульман шажинтан, еврей гурваас бусад нь мөн дагалдав. Баатар гэгээн сахиусыг хүндэтгэх байр огт үзүүлэн

хүзүүнээсээ алтан гинж тайлан авч ширээн дээр чулуудаад:

- Эймер ламтан та миний дэнчин болоод энэ нэр усгүй тэнүүлчингийн дэнчиг британийн дөрвөн тэнгисээр угаагдаж байгаа газарт Айвенго баатрыг хөл тавимагц Бриан де Буагильбер эрүүл тулалдаанд дуудахын бэлэг тэмдэг болгон хадгалж үз. Хэрэв дурдсан баатар энэхүү дуудлаганд эс хариулбал сүмийн хорооны, Европод байдаг бүх төв газруудын өндөрлөг хананаас би түүнийг аймхай хулчгар амьтан гэж тунхаглах болно гэлээ. Ровена хатагай удтал дуугүй сууснаа ам нээн –Тэгэхэд хэрхэвч хүрэхгүй бий. Энэ гэрт үүнийг өмгөөлөх хүсэлтэй хүн байхгүй аваас үгүй байгаа Айвенгог хамгаалж би дуугаръя. Шударга эрүүл тулалдаанд урьсан бүх дуудлагыг Айвенго хүлээж авна гэдгийг дуулгая. Миний энэ өчүүхэн баталгаа энэхүү үнэн явдалт бадарчингийн тавьсан өгүүлшгүй үнэт дэнчингийн жинг ихэсгэж чадахтай бол Айвенго энэхүү бардам баатарт хүссэн хариултыг нь өгч чадна гэж өөрийн нэр, сайн алдраараа батлах байна гэв. Седрикийн дотор эсрэг тэсрэг сэтгэлд машид үймэрсэн тул энэ маргааны үед ганц ч үг хэлж чадсангүй. Түүний шударга цайлган царайнд баяр бахархал, хилэн зовнисон дүр тал дээгүүр гүйн өнгөрөх үүлэн сүүдэр адил солигдож байв. Айвенгогийн нэр гялбах цахилгаан адил хурц сэтгэгдэл төрүүлсэн эдний зарц нар амьсгаа даран цаанаа юу болохыг хүлээж, гэрийн эзнээс нүд үл салгана. Харин Ровена ам нээсэнд дуу нь Седрикийг сэргээж үг дуугарахад хүргэв бололтой.

- Ровена хатагтай, тэгэхийн хэрэг үгүй. Хэрэв өөр дэнчин хэрэгтэй болж гэм Айвенго хэдий намайг муухайгаар доромжилсон боловч түүний нэр төрийн ариуныг өөрийнхөө нэр төрөөр дарахад би бэлэн. Гэвч тавьсан дэнчин ингэхэд норманы эр баатруудын сүрхий ярвигтай дүрэм гуримын дагуу ч гэлээ лав хүрэлцээтэй болов бололтой, миний хэлдэг зөв үү, үгүй Эймер багштан? Гэхэд ширээт санал нийлэн:

- Яриагүй зөв. Ариун сахиуст энэ хайрцаг үнэт гинж хоёрыг би хийдэд аваачиж, энэ хэрэг нэгэн тийшээ болтол тахилынхаа саванд хадгалах болно гэлээ. Ламтан дахин хэд загалмайж олон олон өвдөг сөхөрсний эцэст сахиусыг дагалдан яваа дэргэдэх лам Амвроси хуврагт өгөөд дараа нь элдвээр ёсорхож бариагүй боловч магадгүй дотроо багагүй тааламжтайгаар алтан гинжийг ширээн дээрээс хумиж аван бүсэн дэх анхилуун үнэрт сарьсан хэтэвчинд хийчихлээ.

- За Седрик гуай танай сайн дарс тун хатуу болохоор миний чихэнд үдшийн мөргөлийн хонх нэгэнт тохиод байна. Ровена хатагтайн эрүүл энхийн төлөө дахин нэг хундага өргөхийг таалаад биднийг явуулж унтуулна уу гэхэд Седрик:

- Бромхолийн загалмайг барьж андгайлахад ширээт та сайн алдраа жаахан гутааж байна. Таныг улс амьтан түвшин явдалт санваартан, сайн дарснаас бол өглөөний мөргөлийн хонх дуугарахаас нааш хагацдаггүй хүн гэлцдэг, би тэгээд хөгшин болсон хойноо тантай халз суугаад шившгээ тарих болов уу гэж айсан билээ. Нэр төрөө барьж ам алдахад бидний үед бол Саксоны арван хоёр настай хүү хүртэл ширээнд үүнээс арай удаан суух байсан гэлээ.

- Гэвч энэ удаад хир хэмжээг хэлбэрэлтгүй баримтлах шалтгаан ширээтэд байсан нь зөвхөн хэргэм мяндгийн хувьд улс амьтныг эвлэрүүлэгч төдийгүй үнэнээсээ алив хэрүүл мөргөлдөөнийг үзэж чаддаггүй хүн билээ. Хөгшин тайжийн саксон түргэн зангаас болгоомжилсон хэрэг бөгөөд сүмийн хорооны баатрын нэг биш удаа нэгнээ илрэн цухалзсан

цочмог дээрэнгүй зан явж явж тун ч эвгүй хэрүүлд хүргэх байв. Иймд дарс уухын хувьд толгой сайнтай саксончуудтай эн тэнцэх өөр үндэстэн ер үгүй гэж баахан үг дэлгээд өөрийнхөө ариун өндөр мяндгийн тухай үгийг далим маягаар нэг цухуйлгаж, эцэст нь явж амрахыг зөвшөөрөхийг давтан гуйв. Үүний дараа төгсгөлийн дугараа барьцгаав.

Зочид гэрийн эзэн, Ровена хатагтай хоёрт мэхийн ёслоод босоо өрөөнүүдээр тархав. Эзэд дотно зарц нараа дагуулан өөрсдийнхөө өрөөнд орлоо.

Баатар Еврей Исаакийн хажуугаар өнгөрөхдөө -Бузар нохой чи бас эрүүл тулалдааны газар руу тэмцэж явна уу? гэхэд Исаак хүлцэнгүйеэ мэхийж:

- Тиймээ, эрхэм хүндэт баатар таны таалбал тийшээ очиж явна гэлээ.

- Тэгэлгүй яах вэ. Элдэв заль булхайгаар тайж нарын аль байдгийг сорох, бүсгүйчүүл хүүхдүүдийг муу сайн гялгар цалгар юмаар хуурч хоослох л гэж яваа биз. Чи хэтэвчээ зоосоор пиг дүүрэн яваа гэж ам алдахад ч бэлэн байна гэхэд еврей гараа алдлаад:

- Ганц ч зоос, цорын ганц ч зоос, тал зоос ч байхгүйг аврам бурхан мэднэ. Еврей нарын тэнхимээс оногдуулсан алба татварын төлөхөөр тусламж амьтан ах дүүгээс цуглуулах гэж явна. Өвөг эцэг Иаков маань аз хийморь хайрлагугай. Би бүр хоосорч гүйцсэн. Миний энэ өмсөж яваа цувьг хүртэл Тадкастерийн Рейбен түр өмсүүлсэн юм гэв.

Баатар үүнд ярвайн инээвхийлээд:

- Ямар хараал хүрсэн муухай худалч амьтан бэ? гэж хэлээд еврейгээс холдон тэнд байгсдын хэний нь ч үлд мэдэх хэлээр мусульман боолчууддаа нэг юм хэллээ. Хөөрхий өвгөн дайчин гэлэнгийн үгэнд хариугүй балмагдаад өрөөний нөгөө буланд очсон хойно нь сай нэг тэргүүнээ өргөж хүлцэнгүйеэ мэлхийлгэсэн нуруугаа тэнийлгэв. Тэгээд эцэст цэх болон эргэн тойрон харахдаа тэнгэрийн дуунд дөжирч аянганд ниргүүлсэн хүний адил мэлэрч гүйцсэн царатай болчихжээ.

Үүний дараа баатар, лам хоёр гаргаж өгсөн нойрсох өрөө рүү явахад гэрийн даамал, эзний дагуул хоёр бараа болов. Тэр хоёр тус бүрдээ бамбар барьсан хоёр хоёр зарцтай, бас хоёр зарц сэрүүцүүлэх ундаан бүхий тавиур барин дагалдана. Бусад зарц нар энэ зуур лам баатар хоёрын бараа бологсод болон бусад зочдод бэлтгэсэн өрөөдийг зааж өгч байлаа.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

*Итгэл найдвар олохоор
Үүнтэй бих нөхөрлөе.
Урагштай юм болбол сайн
Үгүй болж гэм ямай.
Харин намайг тэглээ гээд
Харааж бүү муулаарай*

Шекспир "Венецийн худалдаачин"

Бадарчин бамбартай зарц дагуулан том байшингийн ээдрээтэй хонгилоор алхана. Тэгтэл эзний дагуул гүйцэж ирээд өрөөндөө орж аяга сайхан бал дарс уухад дургүйцэхгүй бол ариун газрын тухай, ялангуяа Айвенго баатрын тухай яриа сонсохоор гэрийнхнээс олон хүн цугларна гэж дуулгав. Дагуулын араас Вамба ирж шөнө дунд өнгөрсөн хойно уусан нэг аяга дарс чинь гэрэл унтраах дохио өгсний дараахан уусан гуравтай дүйдэг гэж мөн л ятгалаа.

Өдий их учир мэдэх хүний баталж хэлсэн үгийг үл марган эелдгээр урьсан явдалд хоёуланд нь талархаад, эзний ширээний ард ярьж болохгүй зүйлийг гал зууханд ч ярихгүй гэж андгай тавьсан тул болохгүй гэлээ.

Вамба дагуул руу эргэн –Зарц хүн ийм андгай тавьсан байж арай зохилтойгүй гэлээ.

- Би үүнд тээр дээврийн тэнд нэг өрөө өгөхөөр зэхэж байсан юм. Үнэн сүсэгт христос хүмүүстэй нийлэхээс дургүйцэж байгаа хойно Исаактай цуг унтаг гэж дагуул хэлээд бамбар барьсан зарцад –Энвольд чи бадарчинг зүүн хонгил руу хүргэж өг. Баяртай бадарчин гуай, таны онц эелдэг биш аашилсанд талархаж чадахгүй байна гэлээ.

- Тайван норсоорой, хутагт дарь эх та нарыг эвээх болтугай гэж бадарчин төлөвхөн өгүүлээд зам заах хүнийхээ араас одов. Гудамны эцэс, тал талдаа хэд хэдэн хаалгатай газар хүртэл Ровена хатагтайн шивэгчин тэднийг зогсоож эзэгтэйгээ бадарчинтай юм ярих таалалтай байна гэж тушаангуй дуугарав. Тэгээд Энвольдийн гараас бамбар авч эргэж иртлээ хүлээж байхыг тушаагаад бадарчинг хойноосоо дага гэж зангав. Энэ урилганаас түрүүчийн адил татгалзахыг бадарчин зохисгүйд үзсэн бололтой юу ч гэсэн элдэв цааргалсан үг хэлэлгүй дагав. Жижиг хонгил, бүдүүн царсан дүнзээр шат өнгөрөн Ровенагийн өрөөнд орвол гэрийн эзэн бүсгүйг хүндлэн үздэгийн хирээр тансаг сайхан зассан ажээ. Бүх ханыг алт мөнгө утас сүлжилдүүлэн нохой болоод шонхроор ан ав хийж буй янз янзын зураг хатгамалсан торгоор өнгө харшуулан доторложээ. Улбар хөшгин доорхи ор үнэт магнаг бүтээлгэтэы ажээ. Сандлууд дээр өнгө өнгийн олбогтой,арай өндөрхөн нэг сандлын өмнө нарийн сийлбэртэй зааны ясан жижиг вандан байна. Мөнгөн тавиуртай дөрвөн лаван бамбар өрөөг гэрэлтүүлнэ. Гэхдээ өнөө цагийн ганган бүсгүйчүүл саксоны гүнжийн тансаг тавьц хэрэгсэлд атаархахын хэрэггүй. Ханыг тун тааруухан чигжсэн том том антай, үнэт сайхан хөшиг шөнийн салхинд намилзана. Муухан хаалт маягийн юм бамбарыг нэвт үлээх салхинаас хамгаалах боловч дөл байнга сүүмэлзэнэ. Өрөөний тавил хэрэгслийг харахад баян хээнцэр тансаг, тэр ч байтугай зарим талаар хээнцэр байдал илт байвч тохитой байдлын ор ч үгүй ажээ. Энэ тухай тэр цагт

тухайлдаг хүн ерөөс үгүй байсан болохоор тав муутайг огт үл ажина.

Гурван шивэгчин Ровена авхайн ард зогсоод үсийг нь шөнийн маягаар самнана. Авхай өөрөө ямбаны суудал маягийн өндөр сандал дээр суух нь хүн бүрийг өөртөө бишрүүлж байхын тулд л хорвоод мэндэлсэн юм шиг санагдана. Бадарчин авхайн энэ эрхийг даруй хүлээн өмнө нь өвдөг нугалав.

Ровена эелдгээр –Бадарчин гуай та бос. Үгүй байгаа нэгнийг өмгөөлөгч хүн үнэн шударгыг эрхэмлэж, эр зоригийг хүндлэгч хүн бүрт эелдгээр угтагдах эрхтэй билээ гээд бараа бологсод руугаа эргэн:

--Эльджитээс бусад нь холд. Би ариун явдалт бадарчинтай юм ярина гэв.

Шивэгчингүүд өрөөний нөгөө булан руу очиж, хананд наалдуулан тавьсан нарийн вандан дээр суув.

Ровена авхай чухам юунаас эхлэхээ мэдэхгүй байгаа бололтой хувь хир дуугүй байснаа,

- Бадарчин та өнөө орой нэг хүний нэр дурдсан гээд хүчлэх байртайгаар, - Би Айвенгогийн тухай ярьж байна. Хорвоогийн жам ёс, ураг төрлийн барилдаагаар Айвенго энэ гэрт илүү дотноор дурсагдах учиртай хүн боловч хувь тавилан гэгч хачин, тэр нэрийг дуулаад олоон хүний зүрх догдолсон нь лавтай боловч тэр дурдсан хүнээсээ чухам хаана салсан тухай чинь ганц би л асууж зүрхэлж байна. Өвчнөөс болж Палестинд саатаад, английн цэрэг тэндээс явсны дараа Францын намын зүгээс хавчлага мөрдлөг үзлээ гэж дуулсан, мөн сүмийн хорооныхон тэр намд байдгийг бид мэднэ гэлээ.

- Айвенго баатрын тухай би бага мэднэ. Харин та түүний хувь заяаг сонирхож байгаа хойно би илүү сайн мэдэхсэн гэж хүснэ. Палестинд дайснуудынхаа мөрдлөгөөс мулгарч чадаад Англид эргэж ирэхээр завдаж байсан байхаа. Тэр хүн энд жаргал эдлэх горьдлого байдаг эсэхийг хатагтай та надаас илүү сайн мэдэх учиртай гэж бадарчин зовонгуй дуугарав.

Ровена хатагтай гүнээ санаа алдаад Айвенго баатрыг чухам хэдийд орон нутагтаа эргэж ирнэ гэж хүлээвэл зохих, мөн эх орондоо эргэж ирэх зам зуураа их аюултай тулгарах болов уу гэдэг тухайд хэлж өгөх юм байна уу? гэж асуулаа.

Айвенгогийн эргэж ирэх цаг хугацааны тухайд бадарчин хэлэх юм үгүй, харин авхайн хоёр дахь асуудлын хувьд гэвэл Венец, Генуй, цаашаа францаар дайраад англид ирвэл аян зам нь аюулгүй байж болно гэв.

--Айвенго франц хэл, зан суртахуун тун сайн мэдэх болохоор энэ аян замын зуурт ямар ч аюул занал байхгүй гэж бадарчинг хэлэхэд, Ровена авхай:

- Бурхны авралаар аян замдаа эсэн мэнд яваад энэ орны бүх баатар

эрчүүл эр зорир, эрдэм чадвараа үзүүлэх гэж байгаа мөд болох эрүүл тулалдаанд оролцож чадахтай байгаасай. Үүний шагналыг Конингсбургийн Ательстан хүртвэл Англид буцаж

ирээд Айвенго муу сураг дуулж болох осолтой. Таныг сүүлчийн удаа уулзахад бие байдал нь ямар шүү байсныг, харь нутгийн хүн гуай та хэлж өгөөч. Өвчин зовлон биеийн хүч чадал, гоо сайхны нь бууруулаагүй биз? гэж асуув.

- Кипр арлаас Арслан зүрхт Ричардын бараа бологсодтой Палестинд

очсоноосоо хойш турж, гандаж борлосон байна билээ. Гүн их гунигт автсан царайтай юм шиг байсан. Гэхдээ би танил биш болохоор нүүр учирч байгаагүй гэв.

- Их нутагтаа ирээд үзэх зүйл нүүр царайны нь баргар сүүдрийг арилгаж өгөхгүй болов уу гэж байж байна гэж Ровена хатагтай дуугараад – Багын минь найзын тухай дуулгасанд сайн санаат бадарчин танд гялайлаа гээд шивэгчингүүд рүү эргэн – Хүүхнүүдээ энэ ариун явдалт хүнд оройн хундага барьчих. Амраах цаг болж, би цаашаа саатуулахыг хүсэхгүй байна гэв.

Хүүхнүүдийн нэг нь халуун ногоо тэргүүтэн хольж бүлээтгэсэн мөнгөн аягатай дарс авч ирвэл Ровена түүнд дөнгөж ураал хүргээд бадарчинд барьсанд тосон авч хэд балгав.

Ровена алтан зоос өгөн – Та энэ өглөгийг авч үз. Таны хүнд хүчир зүтгэн, очиж үзсэн ариун сахиусын чинь хүндэтгэж байгаагийн билэг тэмдэг юм шүү гэв.

Бадарчин өглөгийг авч дахин дор мэхийн ёслоод Эльджитийн даган өрөөнөөс гарч одлоо. Хонгилд түүнийг Энвольд зарц хүлээж байлаа. Шивэгчин бүсгүйн гараас бамбарыг авч харц гарлын зочид доогуур зарц нарын унтах олон жижиг тасалгаатай байшинд гаднаас нь залгасан нэмэлт барилга руу даруй дагуулж очив.

- Нөгөө еврей хаана унтаж байна? гэж бадарчин асуухад,

- Бузар нохой, энэ шөнийг гэлэн гуай таны зэрэгцээ тасалгаанд өнгөрүүлэх юм гэнэ билээ гэж Энвольд хариуллаа.

- Гахайчин Гурт хаана унтаж байгаа вэ? гэв явуулын хүн асуусанд зарц хариуд нь:

- Гурт таны баруун гар талынханд, еврей зүүн гар талын тасалгаанд бий. Та уул нь Освальдийн урихад очсон бол арай өөдтэй байр өгөх л байсан дээ гэв.

- Зүгээр, энд ч надад таатай байх болно гээд зарцаас бамбарыг нь авч баярлалаа. Сайхан нойрсоорой гээд жижиг пинд оров. Бамбараа модон дээр хатгаад үүд хааж, буурай пингээ эргэлдүүлэн харлаа. Бүх эд хогшил гэвэл майжгий мандал, шинэ сүрэл дотор дэвссэн модон хашлага хоёр ажээ.

Бадарчин тэр бүдүүн бараг хэвтэр дээр бүхлээрээ хэвтэн унтлаа. Юу ч гэсэн л мандах нарны эхний туяа жижиг сараалжин цонхоор тустал хөдлөлгүй хэвтэв. Тэгээд босож өглөөний залбирал уншиж, хувцас хунараа засаад үүдээ аяархан нээгээд еврейгийн өрөөнд орлоо.

Бадарчингийн өөөрий нь шөнө өнгөрүүлсэнтэй яг адил хэвтэр дээр Исаак зовуурилангуй унтана. Их л хилмэгдэн зовсон царатай нэг аймшигтай хий юмтай тэмцэлдэж буй мэт гар нь үе үе татвалзана. Еврей хэлээрээ нэг юм дуугарч байснаа "Авраамов бурхан минь, золгүй

өвгөнийг өршөөж хайрла" гэв үү гэж гадарлаж болмоор бүтэн бүтэн өгүүлбэр нутгийн хэлээр бас хутган хэлэх ажээ. Исаакийн сэрэхийг бадарчин хүлээсэнгүй замд барих савааныхаа үзүүрээр аяархан хүргэв. Ийнхүү хүрсэн нь унтаж байгаа өвгөний зүүдтэй уялдав бололтой даруй босон харайхад толгойны нь үс өрвийж, хурц хар нүд өмнөө зогсох тэнүүлчинг хилмэгдэн сүрдэж, гайхах байртай ширтэв.

- Исаак чи надаас бүү ай. Би нөхөрсөг санаа өвөрлөж ирлээ гэж бадарчинг хэлэхэд еврейн дотор онгойн:

- Израилийн бурхан таныг ивээг. Өвөг эцэг Авраам минь бурхны авралд багтаг, энэ чинь ашгүй зүүд байж гэснээ гэнэт бүрэн сэрж,

- Өршөөлт танд ядуу еврейгээс өдий эрт юу хэрэгтэй юм бол? гэж ердийнхөө дуугаар асуув.

Бадарчин хариуд нь одоо даруйхан энэ айлаас явж, аль болох хурднаар, аль болох холхон шиг зайлахыг хичээхгүй юм бол зам зуур чинь чамд их гай учрах бий гэдгийг л дуулгах гэсэн юм гэвэл:

- Ариун явдалт гэлэн гуай, над шиг ийм өчүүхэн ядуу хүнд халдах гэж хэн бодох юм бэ? гэж Исаак дуу алдлаа.

- Чи өөрөө мэдэж байгаа байлгүй. Гэхдээ үүнийг мэдэж ав . Сүмийн

хорооны баатар өчигдөр орой өрөөн дотуур явж өнгөрөх зуураа өнөө өглөө хаашаа явахыг чинь тандаж байгаад энэ эдлэнгээс нилээн холдмогц чинь барьж филипп де Мальвуазен юм уу Реджинальд фрон де Бефийн цайзад хүрэг гэж мусульман боолчууддаа миний сайн мэдэх сарацин хэлээр тушаана билээ гэв.

Үүнийг дуулаад еврейгийн хилмэгдэж сандарсныг гарган өгүүлэхийн арга үгүй. Өвгөний гар доош алдран, толгой цээж рүүгээ гуйвч, хөл нь солбиод явчихлаа. Исаак бадарчингийн хөлд сөхрөх нь өвдөг нугалан хүндэтгэх байраар биш далдын хүчинд автан газарт наалдатлаа нам даруулах мэт унав.

Үрчлээтэй гараараа залбиран буурал толгойгоо шалнаас өндийлгэлгүй, - Авраам бурхан минь! Оо Моисей минь! Ариун явдалт Аарон минь! Ийм юм зүүдэлдэг чинь учиртай байх. Тэнд шандсыг минь бахиар сугалж байгаа нь одоо хүртэл мэдэгдээд байх шиг. Бүх биеэр маань арзгар дугуй өнхрүүлж Раббынхан болоод Аммоновынхны биеийг урж байсан самнуур, төмөр балт, хурц хөрөө адил шигтгэж байх мэт гэлээ.

Түүний шаналгааныг бадарчин өрөвдөнгүйгээр харж бос Исаак, миний үгийг сонс. Хаан хүү тайж нар танайхнаас мөнгө шахаж гаргуулах гэхээрээ хайр найргүй тарчилдаг болохоор миний айж тэвдэж байгааг би ойлгож байна. За, бос, гайнаас яаж мултрах зам би зааж өгье. Зарц сэлт өчигдөр оройн наргианаас болоод бөх унтацгааж байна, босоогүй дээр нь энэ айлаас бушуухан зайл, ойн аль ч манаачаас доргүй сайн мэдэх ойн нууц зөргөөр би чамайг гаргаж өгье гэлээ.

Эдгээр үгийг сонсохын хирээр Исаак шалнаас алгуур өндийсөөр босов. Урт буурал үсээ гэдрэг илж, сахлаа засаад нэвт шувт харах нүдээр бадарчинг хянуур гэгч ширтлээ. Харцанд нь айж сүрдэх, итгэх горилох зэрэгцэнэ. Гэнэт сэжигч зан нь бусад бүх сэтгэлээ дийлж өвгөн:

- Залуу хүү чинь буян бодож намайг бүү барьж өг! Еврей буруу номтон, израилийн хүвгүүд, израилын хөвгүүдийг цөөн нэгэн адил бүтээсэн бид бүгдийн тэнгэр эцгийг санан намайг бүү өштөнд барьж өгөөч гээд элдвээр аргадан гуйж бадарчингийн цувнаас зуурав.

Хэсүүлчин - үүнд сэтгэл тайвшир, би юу боллоо гэж чамайг хорлох юм бэ? Гэхдээ намайг цуг явах гэж зууралдаад байна гэж бүү бод, хүсвэл эндээ үлд, Саксоны Седрик чамайг өмгөөлж чадна гэхэд еврей дуу алдан:

- Үгүй дээ, харла! Намайг тэр бараа бологсодтойгоо цуг явуулахгүй, Саксон норман аль алин нь ядуу еврейг жигжин үзнэ. Ганцаараа тэгээд филипп де Мальвуазен юм уу, Реджинальд фрон де Бефийн эдлэнгээр явах гэдэг... Ай чааваас! ... сайн залуу минь би чамтай цуг явкя. Түрэглэе. Саваа чинь энэ байна... За яав аа, бушуухан явж үзье. Чи вундаа хөдөлж ядаад байна вэ? гэхэд,

- Би хөдөлж ядсан юмгүй. Гэхдээ юуны өмнө эндээс гарах арга сүвэгчлэх хэрэгтэй. Миний хойноос дагаарай гэж бадарчин өгүүлэв.

Тэгээд уншигч авгай нарын мэдэж байгаачлан Гуртын унтаж байсан зэргэлдээ өрөөнд орлоо.

- Гурт босоорой бушуухан шиг босож үз. Арын даамангийн явган хаалгыг онгойлгоод биднийг эндээс гаргаадаг гэж бадарчин хэлэв. Эрхэлсэн ажил нь Англид тэр цагтаа сүрхий хүндтэйд тооцогдож байсан Гуртэд бадарчингийн ийнхүү тушаангуй байраар ярих нь эгдүүтэй зүйл санагдсанд өрөөсөн тохойн дээрээ өндийн дээрэнхүйгээр:

- Еврей Ротервудээс явах, бадарчин мөн ханиндаа одохоор зэхэж байгаа юм шив дээ гэлээ. Энэ үеэр тэнд түр ороод ирсэн Вамба гал тогооны газраас гахайн мах дэлсэж орхиод эдлэнгээс зайлж одох гэж байна л би бол бодох нь байна гэхэд Гурт дэр орлосон тайрдсан дээр дахин толгойгоо тавиад:

- Юу ч байлаа гэсэн тэр, надад үүнийг гүйцэтгүүлж өгөхөөс чамайг татгалзахгүй болов уу гэж санана гэж бадарчин захирангуй дуугараад хэвтэж байсан гахайчин руу бөхийн чихэнд нь саксоноор хэдэн үг шивнэлээ. Гурт даруй босон харайхад бадарчин хянуур болгоомжтой байхыг сануулан долоовор хуруугаа гозойлгоод:

- Гурт болгоомжлоорой. Чи угийн хянуур хүн байсансан. Бусдыг хожим хэлнэ гэв.

Гурт ер бусын шалмагаар үгэнд орон явахад Вамба еврей хоёр гахайчны зан ааш ийнхүү түргэн хувирсанд гайхсаар түүний араас дагалдав.

Тэд явган хаалгаар гармагц еврей:

- Миний луус! Миний луус хаана байна? гэж дуу алдлаа.

- Үүний луусыг орж ирээд өгчих, дашрамд нь надад ч нэг луус олоод ир, энэ хавиас холдотлоо би үүнд ханилаад явна. Дараа нь тэр луусыг би Ашбийд Седрикийн дагуулуудын нэгэнд эсэн мэнд хүлээлгэж өгөмц. Чи өөрөө харин... гээд бусад үгээ бадарчин Гуртын чихэнд өгүүлэв.

- Бүгдийг дуртай гүйцэтгэе гэж Гурт хариулаад даалгасныг биелүүлэхээр гүйж одоход нөхрийгөө далд орсны дараа Вамба:

- Залбирал унших, нүглээ наминчлах, бие махбодоо мацаг барьж, мөргөл залбирал удаан хийж дарахад сургадаг юм тэнэг минь гэж бадарчин хариулав.

Салбадай:

- Үгүй, үүнээс арай хэцүүхэн юманд сургадаг байж таарна. Мөргөл, наминчиллаар Гуртын сайхан аашийг хөдөлгөх юм уу, тэвчээр наминчлал гаргасан төдийгөөр хэн нэг хүнд түүнийг луус өгөх болгоно гэдэг ер үзэгдэж харагдсан зүйл үү, та минь! Чи түүний хайртай хар нохойд мөн мацаг мөргөлийн тухай ярилаа гэхэд чанар адил л байх ёстойсон гэв.

- Ёстой нэг саксон тэнэг амьтан байна гэдэг чинь л мэдэгдэж байна даа, чааваас! гэж бадарчин өгүүлтэл шуудууны нөгөө эрэг дээр Гурт хоёр луус хөтөлсөөр гарч ирэх нь харагдлаа. Явуулын хүмүүс шуудууг өргөмөл нарийн гүүрээр гараад цаад эрэгт хүрмэгц еврейгээс өндөр болсон гэлтгүй шалмагаар эмээл дээрээ давхийн мордлоо.

Бадарчин мөн л луусан дээр мордоод хөдлөхдөө Гурт руу гараа сунгавал цаадах нь их л бишрэх байртай гары нь үнслээ. Гахайчин тийнхүү явуулын хүмүүсийг ойн гүн рүү далд ортол үдэн харж зогстол Вамбагийн дээ эцэстээ түүнийг гүн бодлоос гаргаж,

- Ингэхэд байнаа найз минь, өнөөдөр чи ер бусын эелдэг ааш гойд их буянч бишрэнгүйгээ үзүүллээ. Чиний энэ гайхалтай хүндэтгэл, хичээнгүй зүтгэлийг хүлээхийн тулд би хувраг юм уу, хөл нүцгэн бадарчин болох юмсан. Харин би гараа үнсүүлэх төдийгөөр зогсоогүй юмсан гэж хүсэх нь лавтай гэж салбадайг өгүүлэхэд Гурт өөдөөс нь:

- Вамба, чи тэнэг бус үг хэллээ, гэхдээ чи өнгөн талаас нь үзэж байна. Маш ухаалаг хүмүүс ч мөн тэгж л байдаг... Харин би сүргээ маллаг цаг болчихлоо гэв. Ийнхүү өгүүлээд гахайчин эдлэн рүү эргэж одоход салбадай араас нь гэлдрэв.

Энэ зуур явуулын хоёр цааш гойд хурдлан одох нь еврейгийн ихэд эмээснийг гэрчилнэ. Энэ өвгөний насан дээр хүмүүс голдуу ийнхүү хурдлахыг үл дурлах бүлгээ. Түрүүлж яваа бадарчин ойн бүх зөргүүдийг огт үл андах байртай зориуд тойруу буйд зам сонгон авах нь угийн хартай Исаакад аль нэг өстний үүрт аваачих гээд байгаа юм биш болов уу гэдэг бодол хүртэл төрүүлж байлаа.

Тэр цагт еврей омгийнхон шиг бүх нийтийн байнга өрөвдөх энэрэхийг үл мэдэх хатуу хавчилганд байсан ганц ч төрлийн амьд амьтан хорвоо дээр үгүй байсан болохоор ийнхүү айдаг нь ч бас ойлгомжтой. Норман, саксон, Дани, Британыхан өөр хоорондоо хэдий өширхөвч еврей нарыг өширхөх нэгэн сэтгэл дээр нийлж, тэдгээрийг бүхий л аргаар элэг доог барьж, шахаж хавчих, дээрэмдэхийг өөрсдийн шашин шүтлэгийн шууд үүрэг мэтээр

ҮЗНЭ.

Норманы хаанчлалын үеийн хаад тэднийг дуурайсан язгууртнууд хамгийн аминч хар сэтгэлд автах энэ ард түмнийг элдвээр дор үзэж хавчин мөрдөх бүлгээ. Жон хаан нэг баян еврейг цаазандаа хориод өдөр бүр нэг шүдийг нь суга татаж бай гэж тушаасныг хэн бүхэн мэдэх билээ. Тэгсээр хөөрхий израил нутгийн хүн шүднийхээ талыг сугалуулаад хааны гаргуулж авахаар тулгаад байсан асар их мөнгийг төлөхөөр зөвшөөртлөө тийнхүү суусан гэдэг. Тайж нар мөн эзнийхээ үлгэрийг авахаас зовохгүй ерей нараас хавчлагын элдэв арга эрүү шүүлтийг хүртэл хэрэглэн байж мөнгө шахаж гаргуулна.

Еврей нарын хянуур, хартай, аймхай мөртөө шургуу овжин зан чанар бүрэлдэхэд нөлөөлдөг нөхцөлүүд иймэрхүү байлаа. Тойруу буйд зөргүүдээр удтал дуугүй явсны эцэст бадарчин сая ам нээж:

- Энэ хатсан хуучин царсыг харж байна уу? Энэ бол Фрон де Бецийн эдлэнгийн зах. Бид Мальвуазений газрыг аль эрт өнгөрсөн. Одоо цөмд хүний хөөхөөс айх юм огт үгүй гэхэд еврей өөдөөс нь:

- Фараонуудын тэрэгний дугуй хэмх үсэрсний үлгэрээр тэдний тэрэгний дугуйнууд бут үсэртүгэй. Харин сайн санаат бадарчин та намайг битгий хая. Хэрцгий баатар, Сарацины боолчуудын тухай санаад үз. Тэд чинь хил зааг, эдлэн, эзэмшсэн эзний нь хэргэм цолыг ер хайхрахгүй шүү гэв.

- Энэ газраас эхлээд бидний зам салах учиртай. Миний зэргийн хэргэмтэй хүн, аргагүй чуал хэрэгцээтэй газраас чамтай цуг таарахгүй. Тэгээд ч энгийн нэг мөргөлчин хүнийг зэвсэглэсэн хоёр буруу номтноос өөрийгөө яаж өмгөөлж чадна гэж бодно вэ? гэхэд,

- Сайн санаат залуу минь гэж еврей дуу алдаад - чи намайг өмгөөлж чадна би мэдэж байна өмгөөлөх ч байсан. Би хэдий ядуу боловч чиний тусыг хариулж чадна гэхэд бадарчин үгий нь таслан:

- Чамаас ямар ч мөнгө, шан авах хэрэг надад үгүй гэж би нэгэнт хэлсэн билээ. Яахав жаал хань болж өгч болно. Сарацинуудаас еврей хүнийг өмгөөлөхөд христос шашинтан хүнд харшлах юм бараг үгүй тул би чамайг хамгаалж ч чадна. Тэгэхлээр чамайг олигтой хамгаалагч нар олж авч чадах газар хүртэл гаргаж өгье. Бид одоо Шеффильд хотод хүртэл ойрхон байна. Тэнд чи үндэснийхээ хүн олонтой дайралдаж, тэднийхэнд хорогдож болно гэлээ.

- Сайн санаат залуу чамайг Иаков ямагт ивгээж явах болтугай. Шеффильдэд би өөрийн садан Заретийнд толгой хорогдоод цаашаа аюулгүй явах арга тэнд сүвэгчилнэ гэж еврейг хэлэхэд бадарчин:

- За сайн. Шеффильдэд бид сална. Хагас цагийн дараа энэ хотод очно гэв.

- Энэ хагас цагийн туршид хоёул ганц ч үг сольсонгүй, онцын хэрэгцээгүйгээр еврейтэй юм ярихыг бадарчин өөртөө гутамшигт хэрэгт тооцсон ч байж болох, цаадах нь мөн бурхны

ариун шарил руу мөргөлөөр ярьж ирсэн болохоор зарим талаар ариунд тооцогдож болох хүнтэй яриа дэлгэх гэж улайраад байхыг эс зүрхлэв. Налуу толгойн орой дээр зогсоод бэлд нь зурагтай Шеффильд хотыг заан:

- За бид энд салах болж дээ гэхэд:

- Гэхдээ ядуу муу еврей танд ач тус санаснаа илэрхийлсний дараа шүү гэв.

- Ямар ч шан хэрэггүй гэж би түрүүн чамд хэлсэн билээ гэхэд, Исаак хормойноос нь шүүрэн авч дуу алдан:

- Зогсооч, жаахан хүлээ! Миний хир ядуу хүн болохыг бурхан мэднэ... Исаак өөрийн нэг үндэстний дотор гуйлгачин хүн. Харин яг одоо танд хамгаас илүү хэрэгтэй зүйлийг би таах гэж оролдоод үзье та уучлаарай гэв.

- Надад хамгаас хэрэгтэй зүйлийг таалаа гэсэн ч ялгаагүй чи түүнийг надад олж өгч чадахгүй гэхэд Исаак хариу марган:

- Чи эндүүрч байна. Юугаар гачигдаж байгааг чинь би мэдэж байна. Магадгүй түүнийг олж өгч чадах ч байж. Одоо чи юунаас түрүүн морь, зэр зэвсэгтэй болохсон гэж байгаа гэв.

Бадарчин өөрийн эрхгүй давхийж, еврей рүү цочмог эргэн:

- Чи яаж таав аа? гэж тэвдүүхэн асуулаа.

- Миний яаж таасан нь хамаагүй, миний таавар л үнэн байв аа барж. Чамд юу хэрэгтэйг нэгэнт мэдсэн хойно би бүгдийг олж өгнө гэхэд,

- Миний цол хэргэм, миний эдлэх хувцас хунар, өгсөн андгайг харгалзаарай... гэвэл еврей хариу өгүүлрүүн:

- Христос шашинтан та нарыг би мэднэ. Та нарын дотроос хамгийн өндөр язгууртан хүртэл бадарчингийн таяг аваад алс холын оронд үхсэн хүмүүсийн шарилд мөргөхөөр явган оддогийг би бас мэднэ гэхэд,

- Нүгэлтэй муу үгийг битгий ярь! гэж мөргөлчин ширүүнээр тас зогсоов.

- Уучлаарай гэж Исаак дуугараад—би болчимгүй үг хэлчихлээ. Харин өчигдөр орой, өнөөдөр өглөө чиний амнаас гарсан хэдэн үр цахиураас улсхийх очны адил сэтгэл зүрхийг чинь надад гийгүүлсэн билээ. Түүнээс гадна чиний наад мөргөлчний хцвасны дор баатрын шинж, алтан давируул нуучихсан байна. Өнөө өглөө миний дэвсгэр рүү бөхийхэд чинь тэд гялсхийн харагдсан гэв.

Бадарчин тэсэлгүй инээмсэглэн:

- Чиний хувцасны дотор тал руу мөн тиймэрхүү гярхай нүдээр харвал юу байхсан бол. Исаак? Чинийхэд ч мөн сонин юм багагүй байхсан болов уу гэхэд еврей царай хувьсхийн:

- Энэ тухай яриад юу хийх вэ гэв.

Исаак хэтэвчнээсээ бичгийн хэрэгсэл яаран гаргаж шар малгайгаа эмээл дээрээ тавиад хуудас цаас дээр нь дэлгэн юм бичиж гарав. Бичиж дуусаад захидлаа Бадарчинд өгөн:

- Лейстр хотод баян чинээлгээрээ бүхэнд нэртэй Ломбардийн Кирджат Жайрам гэгч еврей бий. Энэ захиаг түүнд өгөөрэй. Тэднийд одоо баатрын зургаан зарах хэрэгсэл байгаа. Хамгийн мууг нь хаан язгуурын хүн өмсөхөд болохтой, мөн арван азарга байгаагийн хамгийг мууг нь хаан унаад гарахад ичихээргүй амьтан. Энэ зурвасыг аваад Кирджа чамд дуртай баатрын хэрэгсэл, морийг чинь сонгуулж авахуулна. Түүнээс гадна мөд болох эрүүл тулалдаанд хэрэгтэй бүх зүйлийг тэр бэлтгэж өгнө. Хэрэгцээ өнгөрсний эцэст нэг бол юмыг нь бүрэн бүтэн эргүүлж өгөөрэй, чадвал бүх үнийг бүрэн төлнө биз гэлээ. Бадарчин үүнд инээмсэглэн:

--Баатрыг эрүүл тулалдааны үед эмээлээс нь ховх цохиод унагаачихвал морь, зэр зэвсэг нь дийлсэн хүнийх болдгийг Исаак би мэдэхгүй гэж үү? Тийм гай надад ч дайрч болохоос гадна морь, зэр зэвсгийн үнийг төлж би хүч хүрэхгүй гэв.

- Үгүй, үгүй, үгүй. Тийм гай дайрч болшгүй энэ тухай би сонсох ч дургүй байна. Чиний жад чинь Монсеевын очир шиг л агуу хүчээр дүүрэн байх болно гэж хэлээд еврей луусаа эргүүлэн хөдлөх гэсэнд бадарчин өөрөө мөн цувнаас нь барьж аван:

--Үгүй, Исаак азнаж бай, чи юунд хүрч болохоо сайн мэдэхгүй байна. морь алагдаж, хуяг дуулга тас цавчигдаж болох, юу гэвэл хүнийг ч морийг ч хайрлахгүй. Тэгээд ч танай үндэсний хүмүүс хүнд зүгээр юм хийж өгдөггүй улс. Эд хөрөнгө хохирсныг ямар нэг юмаар төлөх л хэрэгтэй болох шүү дээ гэвэл,

- Ялгаагүй санаа зовох юм алга. Намайг явуул даа. Гарз учирчээ гэхэд чи түүнийг хариуцахгүй, Кирджат Жайрам тэр өрийг өөрийн садан Исаакийг бодоод уучлах болно. За баяртай эсэн мэнд яваарай. Тэгэхэд байнаа, сайн санаат залуу чинь, дуулж бай гэж дахин эргэж, - Тэр тулалдаан болоход чи битгий хэтэрхий ил улайраарай. Чамайг хуяг дуулга, морио гамнаасай гэж хэлж байгаа юм биш, амь насаа хадгалж бие махбодоо бүрэн бүтэн байлгаасай гэсэндээ хэлж байгаа юм шүү гэлээ.

- Бадарчин инээмсэглэж: - За, миний төлөө санаа тавьсанд баярлалаа. Чиний эелдэг найрсгийг би хүлээж аваад юу ч болов хожим ачийг чинь хариулахыг хичээнэ гэж хэллээ. Тэд ийнхүү салж хоёр өөр замаар Шиффильд рүү чиглэв.

ДОЛДУГААР БҮЛЭГ

*Баатрууд хуяг дуулгаа гялалзуулан дагуултайгаа цувралдана
Бамбай жад барьсан хөтөч нар санд мэнд гүйлдэнэ.
Агт морьд агсамнан амгай зуузай хэмлэнэ.
Алх, билүүтэй хөтөч нар зэр зэвсгийг дархлана.
Хүнд бороохой барьцаасан дээрэнгүй баячуул
Хүч түрэн олны дундуур бардамнан алхацгаана.*

Драйден. "Пламон Арсита хоёр"

Английн ард түмэн энэ үед сүрхий хөөрхийлөлтэй байдалд байлаа. Арслан зоригт Ричард өөрөө Австрийн хорон санаат, харгис хатуу тайжийнд олзлогдоод байлаа. Ричардын хоригдож байгаа газар хүртэл нууж, эзгүй хойгуур нь хүнд дарлалд нэрвэгдэн байгаа албатуудын олонхи хааны хувь заяаны тухай юу ч мэдэхгүй байв.

Австрийн хун тайжид нөлөөтэй байснаа хаан хүү Жон ашиглан ахыгаа аль болох удаанаар байлгахыг хичээж байлаа. Энэ зуур Жон олон хүн талдаа элсүүлэн авч Ричардыг нас барах аваас хууль ёсоор хаан ширээ залгамжлах учиртай их ах Жофруагийн хүү, өөрийнхөө ач Бретаны Артуртай хаан ширээ булаацалдах санаа өвөрлөж байв. Хов будлианд чадмаг найр наргианч хаан хүү Жон, эзгүй хойгуур нь үйлдсэн гэмт хэрэгтээ Ричардын хилэнгээс эмээх шалтгаантай хүмүүсийг төдийгүй, загалмайн аян дайнд түрүүн оролцсон олон тооны "даруулгаа барсан танхайчуудыг" өөрийнхөө талд онц бэрхшээлгүйгээр татан авчээ. Эдгээр хүмүүс дорно дахины элдэв нүглийг ихээр сурч аваад сохор зоосгүй нутаг орондоо эргэж ирсэн, ажил төрлөө дээшлүүлэхийн тулд дотоодын самуун дайн гаргахыг л хүлээж байгаа ажээ.

Нийтийн үймээн, түгшүүр төрүүлсэн шаналгаануудын тоонд феодалуудын хирээс хэтэрсэн шахалт хавчилт болон ойг хамгаалах тухай хуулийг хайр найргүй мөрдөн хэцүүдүүлсний улмаас олон тооны тариачид том том багууд болон нэгдэж нутгийн засаг захиргаанаас огт үл эмээн ой хөвч, зэлүүд газруудад эзэгнэх болсон байдал бас орно. Биеэ даасан эзэд болж гайхуулах дуртай тайж нар өөрсдийнхөө дэргэд дээрэмчин бүлгүүдээс тун ялихгүй ялгаатай бүхэл бүтэн багууд цугларуулах болжээ.

Английн ард түмэн одоогоор асар гай түйтгэр амсхийн хамт цаашид улам дордохоос эмээх бүрэн үндэстэй байлаа. Бүх зовлон зүдгүүрийг нэг аюулт халдвартай өвчин бүх орон даяар тархлаа. Нийгмийн доод давхрагуудын амьдралын хүнд нөхцөлд таатай ул суурь олсон энэ өвчин олон хүний амь насанд хүрсэн бөгөөд ойртон буй гай түйтгэрээс ангижирсан талийгаач нартаа амьд үлдсэн нэг нь атаархах удаа цөөнгүй байв. Гэвч эдгээр зовлон зүдгүүрийг үл харгалзан Мадридийн гуйлгачин иргэд бүх улайруулахыг шунан сонирхдогийн адил мөд болох эрүүл тулалдааныг баян хоосон, харц тайжгүй машид шохоорхож байв. Нэрд гарсан баатруудын хооронд тэгээд бас хаан хүү Жонын нүүрэн дээр болох энэ эрүүл тулалдаан бүх нийтийн анхаарлыг татаад бүх төрөл язгууртан үй олон хүн болзоот өдөр тогтсон газарт цугларчээ.

Тулалдаан болох газар гойд үзэсгэлэнтэй. Ашби хотоос нэгэн бээрийн газар, их ойн цоорхой болон өргөн талбай нэг талаасаа өтгөн ойгоор эмжигдэж, нөгөө талаар нь тармаг хөгшин царсууд сүндэрлэжээ. Налуу хамруудын бэл явсаар дундаа өргөн тэгш талбай болсныг бат бэх хашаагаар хүрээлжээ. Хашаа дөрвөлжин хэлбэртэй авч үзэгчдэд таатай болгон өнцгүүдийг нь дугуйруулсан ажээ.

Дайчдыг оруулах хоёр морьтой хүн элбэг зэрэгцэн орж багтах өргөн хаалга хашааны хойт хоёр талд гаргажээ Хаалга болгоны дэргэд хоёр зарц, зургаан бүрээч том баг цэрэг зогсоно. Зарц нар тулалдахыг хүссэн баатруудын цол хэргэмийг шалгаж талбай дээр ёс гурим сахиулах үүрэгтэй. Зүүн талын хаалганы гадна бяцхан төвгөр дээр бор, хар өнгийн далбаагаар чимсэн таван үзэсгэлэнтэй гоё майхан байлаа. Эрүүл тулалдаанд бусдыг дуудсан баатруудын сонгож авсан өнгө нь энэ бөгөөд бүх таван майхны бүч сэлт мөн тийм өнгөтэй. Майхан бүрийн өмнө уул эзэн баатрын нь бамбай өлгөөстэй, бамбайн дэргэд дагуул зэрлэг амьтан юм уу аль өөр нэг үлгэрийн амьтан болгон хувцасласан хүн зогсоно.

Дунд талын хамгийн хүндэт майханд Бриан де Буагильберийг суулгажээ. Эр баатарчуудын бүх сургуульд гойд чадмаг гэдэг цуу энэ эрүүл тулалдааныг сэдэгчдэд түүнийг зөвхөн эгнээндээ оруулж авах төдийгүй бүр толгойлогчоо зэрэгцэн нэг талд нь Реджинальд фрон де Беф, Филипп де Мальвуазен хоёрын майхан нөгөө талд нь бээл Гуго де Граимениль гэгч өвөг дээдсийн нэг байлдан дагуулагч Вильгельм, түүний хүү Шар Вильгельм нарын үед Английн Жонон явсан өндөр сурвалжит хүний майхан байв. Тав дахь майханд Ионнит хорооны баатар Ральф де Випонт гэгч Ашби-де ля-Зушээс холгүй орших Гэсер гэгч газарт их хэмжээний газар эзэмшигч хүн буужээ. Майхантай төвгөрийг бөх бат хашаа хатган хүрээлж налууухан уруудсаар тулалдах талбарын хаалга руу очсон мөн хашаа бүхий өргөн замаар холбожээ. Хашааны дагуу манаач нар зогсоно. Хойт талын хаалганы ард мөн тийм хашаа бүхий төвгөр дээр эрүүл тулалдаан сэдсэн хүмүүсийн эсрэг үзэлцэхийг хүссэн баатруудад зориулсан майхнууд байна. Энд бүх төрлийн амттай зууш ундаан зэхэж, хажууханд нь төмрийн дархан, зэвсгийн дархан зэрэг урчуул, минут тутам дайчин эрст зохих тусламж үзүүлэхэд бэлэн үйлчлэгчид байрлажээ. Хашааны дагуу тусгай тавцан засаж хөшиг сэлт унжуулан, хивс дэвссэн язгууртан үзэгчид аль болох тавлагаар сууг гэж дээгүүр нь олбогууд хаяжээ. Тавцан хашаан хоёрын хоорондох нарийн зурвас зайг жижиг газар эдлэнгүүдийн эзэн номенууд гэгчид зориулжээ. Харц ардуудын хувьд гэвэл ойрох хамрын эгнээгээр зассан явган суудлуудыг эзлэх учиртай ажээ. Түүнээс гадна хэдэн зуун талбайг эмжсэн моддын мөчир дээр хүртэл үзэгчид шавааралджээ. Өмнө зүгийн тавцангийн төв дунд талбайн яг голыг харалдуулан асартай өндөр тавцан дотор хааны суудал маягийн юм засаж хаан сүлдээр чимжээ. Энэ хүндэт суудлын хавиар гоё сайхан хувцастай хиа, дагуул, харуул манааны хүмүүс үймэлдэж, хаан хүү Жон түүний бараа бологсдод зориулагдсан болох нь юм бүхнээс үзтэл ил байлаа. Хааны суудлын эсрэг баруун тавцангийн голд мөн тийм асрыг хэдий илүү тансаг бус авч арай эрээн мяраанаар чимжээ. Тэнд гал улаан, ногоон эдээр бүрсэн өндөр суудалтай, олон тооны хиа нар болон улаан ногоон өнгийн гаж буруу хачин хувцсаар оёсон, сонгон олж болох хамгийн гоё хүүхнүүд олноор тойрон үймэлдэнэ. Асрыг туг далбаануудаар чимэглэсний дээр нэвт хатгуулсан зүрх, дөл бадарсан зүрх, цус нь дуслан дуусаж буй зүрх нум сумтай саадаг зэрэг билэг тэмдгүүд сийлжээ. Мөн тэрүүхэнд нь энэ хүндэт суудал хайр сэтгэл, гоо сайхны хатан хаанд зориулагдана гэж сайхнаар бичээстэй байв. Энэхүү хатан хааны үүргийг гүйцэтгэх хүн одоогоор үл мэдэгдэнэ.

Энэ зуур элдэв зэрлэг зиндааны хүмүүс талбай руу бөөн бөөнөөрөө цувна. Олон хүн зиндаа дээгүүр суудалд залрах гэснээс болж цөөнгүй хэрүүл маргаан гарчээ. Ихэнх учирлыг харуулынхаа илдний бариул жадны иш хэрэглэн онцын ёсорхол хүндэтгэлгүйгээр шийднэ. Суудлын тухай маргаан нилээн чухал хүмүүсийн дунд дэгдвэл тэдний гомдлыг торгон цэргийн хорооны хоёр маршал Уильям де Вивил, Стивено де Мартивал хоёр таслана. Энэ хоёр маршал, хөлөөсөө толгой хүртэл зэвсэглээд талбайгаар урагш хойш холхин олны дунд чанд журам сахиулна. Тавцанд баатар, тайж нар алгуураар дүүрч тэдний бараан өнгийн урт нөмөргүүд эрэгтэйчүүдээсээ олон байгаа бүсгүйчүүдийн илүү өнгөлөг гэгээн хувцсуудтай аятайхнаар өнгө хослоно. Дорд тавцан зай завсар мөдхөн ядуу хоосондоо юм уу дээдсийн дунд байр суурь өгүүлэхийн эрхээр илүү хүндэт суудалд залрахыг эс зүрхлэсэн жижиг тайж нар баян Иоменуудаар пиг дүүрчээ. Олны, тухайлан энэ хэсэгт ахлах эрхийн үүднээс илүү их зөрөлдөөн гарч байсан нь аргагүй учиртай. Элэгдсэн хувцас нь ядуу хоосныг гэрчлэх боловч ташаан дахь илд, бүсэнд хавчуулсан чинжээл хутга, хүзүүн дахь алтан гинж тэргүүтэн язгуур сурвалжтайг нь үзүүлсэн хижээл насны хүн-Бузар нохой! Чонын бэлтрэг, чи яагаад христос шашны тэгээд бас Мондидье тайжийн ариун угсаатны норман хүнийг түлхэж зүрхлэв хөө? гэж загана.

Энэ ширүүн үгийг бидний танил, энэ удаа баян сайхан хувцаслаж, үнэт цув нөмөрсан гоо сайхан охин Ровекка дээ доод тавцангийн урд эгнээнд суудал олж өгөхөөр олон дундуур түлхэлцэн яваа Исаакад хэлжээ. Хүүхэн эцэг дээрээ, Ашбид ирсэн одоо гараас нь зууран яваа эцгийг нь ийнхүү аашилж байгаад зэвцүүсэн бололтой олны дургүйцлээс айн ийш тийшээ сэтгэл түгшин харна. Харин айх юм үгүйг Исаак сайн мэдэж байлаа. Өдий олон хүн цугларсан газарт хамгийн хар санаат хорсол өвөрлөсөн өштөн нь хүртэл өөрийг нь гомдоохыг үл түвдэх бүлгээ. Иймэрхүү цуглаан дээр еврей нар нийтийн адил хуулийн өмгөөлөлд байх бөгөөд энэ багадахад хүрвэл тайж нарын дотор хувийн ашиг завшааныг болон тэднийг өмгөөлөх дээд язгуурт бээлүүд заавал хэд хэд гарч ирдэг ажээ. Түүнээс гадна хаан хүү Жон өөрийн Йоркийн баян еврей нараас үнэт эрдсийн чулуу, газар эдлэнгээр дэнчин тавин их эмжээний мөнгө зээлэхээр хөөцөлдөж байгааг Исаак сайн мэдэж байлаа. Исаак өөрөө энэ хэрэгт шууд холбоотойн дээр хаан хүү уул ажлыг бушуухан дуусгах гэж хүсэж байгааг мэднэ. Тэгээд эвгүй зөрөлдөөн гарвал хаан хүү заавал өөрийг нь өмөөрнө гэдэгт бат итгэж байлаа.

Иймд Исаак зоримгоор урагш зүтгэсээр норман тайжийг болгоомжгүйгээр түлхэв. Гэтэл өвгөний гомдолсон үг олны дургүйцлийг хүргэж, нэг ногоон цэмбэн хувцастай цэлгэр нуруутай, бөөн сум бүсэндээ хавчуулан мөнгөн тэмдэг цээжиндээ зүүсэн зургаан төө урт нумтай Йомен айхавтар сүрдүүлж хахир дуугаар зандран ширүүн харж Еврейг гэдрэг ухруулав. Энэ аюултай хүнтэй ойрхон байхаас төвөгшөөн Исаак холхон зайлж мэдэх байсан боловч энэ үеэр хаан хүү Жон олон тооны наргиантай бараа бологсдынхоо хамт талбар дээр гарч ирэн нийтийн анхаарлыг татав. Бараа бологсдын хагас нь хар, зарим нь хувраг хүмүүс авч наад нөхдөөсөө дутуугүй гоё хээнцрийн дээр задгай зайлан байдалтай байцгаана. Бараа бологч хуврагуудын дотор Жорвогийн ширээт мяндаг тушаалынхаа дээд хирээр хамгийн дэгжин хувцасласан явна. Хувцсаа алтаар ихэд хатгамалдаж, үнэт үсээр эмжсэн, гутлын нь хамар хэт дээшээ эргэсэн нь тэр цагийн зохисгүй галбирыг хүртэл хэтрүүлчихжээ. Тэр эргэсэн хамрыг барьж өвдөгтэйгээ биш бүр бүсэндээ хавчуулахад хүрсэн нь дөрөөнд хөл хийхэд саад болох авч хээнцэр ламтан үүнийг үйл хайхрана. Өдий олон хүн ялангуяа бүсгүйчүүлийн дэргэд дөрөө хэрэглэлгүйгээр морь сайн унадаг чадвараа үзүүлэх завшаан

тохиолдсонд бүр баяртай ч байж мэдэх. Хаан хүү Жоны бусад бараа бологсод нь хөлсний цэргийн дарга нар, хэдэн бээл, ордны бараа бологч сүрэг завхай зайданчуд, сүмийн хороо, ионнитийн хорооны баатрууд зэрэг дотно хүмүүс нь ажээ.

Эдгээр хоёр хорооны баатрууд Ричардийн өштөнд тооцогддог байсныг энд дурдахад илүүдэхгүй болов уу. Палестинд францын Филипп, английн хаан хоёрын хооронд эх төгсгөлгүй явагдах тэмцэлдээ эд Филиппийн талыг барьжээ. Тухайлан энэ тэмцэлдээний уршгаар Ричардын сарацинуудыг дийлсэн бүх ялалтууд үр дүнгүй болж, Иерусалимыг авах гэсэн оролдлого нь бүтэлгүйдсэн болохыг хэн бүхэн мэднэ. Ариун газарт байгаа хань нөхдийнхөө баримталдаг бодлогыг баатрууд хаан хүү Жоны намд нийлжээ.

Өөрийн зүгээс хаан хүү Жон саксоны үлдэж хоцорсон язгууртныг өширхөн дорд үзэж бүхий л талаар доош дарахыг хичээнэ. Саксоны феодалууд Английн бусад Саксон олны хамтаар эртний эрх тархаа цаашид хязгуурлуулахаас, ялангуяа хаан хүү Жон шиг хир даруулан байхгүй эзэрхэг этгээдийн хавчлагаас эмээн элдэв булхай явууллагыг нь дайсагнан үздэг гэдгийг Жон өөрөө ойлгож байна. Хаан хүү Жон бор зүсмийн агсам морьтой, хань хамсаатнуудаараа хүрээлүүлэн талбай дээр гарч ирэхдээ алтан хатгамалтай гал улаан өнгийн маш сайхан хувцастай, эрдэнийн чулуугаар чимсэн үнэт үсэн малгай толгой дээрээ тавьжээ. Түрүүлэн явж, тойрсон хүмүүстэйгээ чанга ярилцан инээд хөөр болж, дээд тавцангийн чимэг болсон гоо бүсгүйчүүлийг хаан хүний зоримог зоргоор байраар ажиглана.

Хаан хүүгийн царай тун ихэмсэг ярвагар бусад хүмүүсийн сэтгэлийг огтхон ч үл ойшоох шинжтэй авч яриа хөөрөө нь цаанаа нэг гойд энгийн, гоёч засалгүй байдалтай. Энэ нь шулаан, цагаахан зангийн илрэл мэт санагдавч, үнэндээ сэтгэлийн мөн чанараас үл хамааран удам, сурвалж, эд хөрөнгө юм уу, аль өөр ямар нэгэн тохиолдлын давуу талаар бусдаас дээгүүр гарснаа ухамсарласан хүний хэнэггүй хааш хэрэг, даруулгагүй задгай зан цаана нь нуудаж байх нь олонтой бүлгээ.

Гэхдээ үзэгч олны ихэнх нь иймэрхүү гүнзгийгээр юмыг үл эрэгцүүлнэ. Тэдний хувьд бол хаан хүү Жон сайхан үст малгай, үнэт булгаар эмжсэн хээнцэр нөмрөг, алтан давируултай сарьсан гутал болоод морин дээр чадмаг дэгжнээр явааг харахад сэтгэл хөөрөн чанга хашгиралдан баяр хүргэхэд хүрэлцээтэй зүйл ажээ.

Хаан хүү талбайг тойрон хөгжүүнээр ханхалзан явснаа Исаакийн илүү сайн суудал руу анхаарал нь татагдав. Жоны хурд нүд еврейг дор нь таньснаас гадна хөгшин эцгийнхээ гарт хилмэгдэнгүй наалдсан Сионы сайхан охин илүү ч таатай сэтгэгдэл түүнд төрүүлэв. Үнэхээр ч Жон шиг нарийн цэгнэж мэдэх хүний нүдэнд хүртэл гоо Ревекка английн хамгийн нэрд гарсан сайхан бүсгүйчүүлтэй зүйрлүүлэн үзэхэд лавтай давж гарахаар төржээ. Гайхам гоолиг биенд нь дорно дахины хийцтэй хувцас гойд зохижээ. Шар торгон тоорцог боровгор царайны нь боровгор туяатай сайхан дүйж, нүд нь цогтой, нарийхан хөмсөг ихэмсэг байртай нумран зурайж, цагаан шүд сувдан өнгөөр гялалзан, дээр нь гал улаан перс торгоор цэцэг хатгамлан хийсэн урт ууж нөмөрсөн мөр, цээжээр нь өтгөн хар үс намиран унжжээ. Эд бүхэн тун ч гайхан бишрэм санагдах тул эргэн тойронд суугаа гоо сайхан хүүхнүүдийн хэнтэй нь ч Ревекка өнгө булаалцалдаж чадахаар ажээ. Хүүхний хувцас сувдан товчтой, дээд гурван товч нь халуун өдөр тул задгай, ил гарсан хүзүүнд зүүлт унжуурга бүхий асар үнэтэй очир алмас зүүлт тод харагдана. Тоорцгон дээр том хатгамалаар тээглэн тогтоосон тэмээн хяруулан

өдтэй аж. Бас дээд тавцан дээр суугаа ихэмсэг хатагтай нар нүдэнд нь тусах сайхан еврей бүсгүйг үл ойшоох байртай ажиглавч гоо үзэсгэлэн, эд баялагт нь сэмхэн атаархам ажээ.

Авраамын халзанг барьж андгайлахад энэ еврей хүүхэн лав мэргэнээс мэргэн хаадыг ухаан алдуулдаг бүх төгс сайхны хурсан биелэл байж таарах нээ. Ширээт Эймер чи юу гэж бодож байна? Манай ах Ричардын эзлэн авч яагаад ч хүч хүрэхгүй байгаа мэргэн Салмоны тэр сүмийг барьж андгайлахад энэ чинь дуудын дуунд гардаг бэр мэт сайхан хүн юм гэж хаан хүү Жон өгүүлэв.

- Шароны саргай, Долинийн замбага цэцэг мөн дөө. Гэхдээ гэгээн дээдэс та үүний нааш ч үгүй цааш ч үгүй еврей хүүхэн гэдгийг мартаж болохгүй гэж ширээт хариулвал Жон энэ үгийг өчүүхэн ч эс анхааран:

- Уухай! Миний бузар явдалт бүдүүн хэтэвч... энэ байж байна. Зоосны бээс мөнгөн зооснуудын бээл, хүндэт суудлаас болон кармаанд нь лав ганц сохор зоос байдаггүй ноорхойчуултай хэрүүл хийж байх шив. Гэгээн Маркийн нэрийг барьж андгайлахад миний мөнгөний эрхэм дээдэс, гоо еврей бүсгүйнхээ хамт одоохон дээд тавцан дээр суудал олох болно... Хөөе Исаак наадах чинь хэн бэ? Чиний юу юм бэ? Дорнодын ямар гээч дагиныг чи хамаг баялгаа агуулсан хайрцаг мэт сугандаа хавчуулчихаад явна вэ? гэлээ

- Гэгээн дээд минь, энэ миний охин Ревекка гэж хаан хүүгийн тоглоом тохуу, эелдэг зөөлөн хосолсон мэндчилгээнд ер сандраагүй еврей дор мэхийн хариу өчив.

- Үгүй чи мөн их мэргэн хүн юм аа! гэж хаан хүү инээхэд дагалдагсад нь даруй бялдуучлан дууриаж хөхрөлдөв. За охин ч бай, эхнэр ч бай ялгаагүй чиний гавьяа зүтгэл хүүхний гоо сайханд тэнцэхээр түүнийг хүндэтгэх учиртай.. Хөөе тэр дээр хэн сууж байна?гээд тавцанг эрэгцүүлэн харснаа, саксоны бүдүүлгүүд... үгүй тэр тэрийгээд суучихсныг нь. Жаахан шахаж суугаад миний мөнгө хүүлгийн ноёнтон сайхан охин хоёрт зай гаргаадах. Энэ харанхуй мунхгуудад синагогийн хамгийн сайн суудлыг тэд синагогийн зүй ёсны эзэд болох хүмүүстэй хуваалцах ёстой гэдгийг үзүүлж өгнөө гайгүй гэлээ.

Энэхүү ширүүн доромжлолын үг, үзэгчээр гэр орныхонтой суусан саксоны Седрик болон түүний холбоотон ураг төрөл, Саксоны сүүлчийн хааны удам угсааны хувьд хойт Английн иргэд бүх саксончуудын зшээс гүн хүндэтгэл хүлээдэг Конингсбургийн Ательстан нар байлаа. Ательстан өвөг дээдсийнхээ хаан язгуурын цусны хамт нилээд олон сул талыг нь өвлөн авчээ. Нуруу өндөр, бие бялдар чийрэг ид залуу авч сайхан царай нь хэтэрхий ноомой, нүд нь нойрмог гөлгөрдүү, хөдлөх барихдаа залхуу болохоор хөшүүн Ательстан гэж хочилжээ. Энэхүү ноомой эр зориг дутсаных биш зөвхөн шийдмэг зориггүйнх гэж олон нөхөд нь тайлбарладаг билээ. Бусад хүмүүсийн бодлоор бол өв уламжилсан муу чанар болох хөлчүүрдгэсээ болоод эр зориг залхуурангуй цайлган зангаас бусад бүх олигтой чанаруудаа алдаж гүйцсэн ажээ.

Тэгээд тухайлан түүнийг хажуу тийш болж Исаак Ревекка хоёрт зай гаргаж өг гэж хаан хүү Жон тушаалаа. Тэр цагийн байдал, ойлголтоор үзэгдэж дуулдаагүй их доромжлол болох тийм шаардлагыг дуулаад алмайрч орхисон Ательстан хаан хүүгийн тушаалыг дагах дур огт үгүй байлаа. Гэхдээ иймэрхүү тушаалын хариуд юу гэж хариулбал зохихоо үл мэднэ.

Зөвхөн л хаан хүүгийн өөдөөс хачин инээд хүрэм удаан гайхан ширтэнэ. Гэтэл хүлээц муутай Жон инээхтэй мантай болов.

- Саксоны энэ гахайчин нэг бол унтаж байна, эсвэл миний үгийг дуулсангүй. Алив де Браси чи түүнийг жадаараа жаахан гижигдээд орхиоч гэж хажуудаа явсан хөлсний цэргүүдий нь захирагч болох баатар руу эргэж хэллээ. Хаан хүүгийн бараа бологсод дунд хүртэл дургүйцэх шуугиан дэгдэв. Харин эрхэлсэн мэргэжлийнхээ дагуу зовох аягүйрхэх гэгчийг үл мэдэх де Браси урт жадаа сунгаад, цахилгаан мэт түргэнээр богино илдээ суга татан, Седрикийг ганц далайлтаар ган зэвийг нь тав цавчаагүйгэсэн бол хөшүүн Ательстаныг мэснээс булгаж амжихаас өмнө хаан хүүгийн тушаалыг биелүүлчих байсан болов уу?

Хаан хүү Жоны царай уласхийгээд явчихлаа. Муухай хараагаад илүү айхавтар заналын үг урсгах гэсэн авч нэгд бараа бологсод нь элдвээр тайвшруулж ятгасан нөгөө талаар цугларсан олон Седрик ган зэвийг нь тас цавчсаныг чанга хашгиралдан сайшаасан тул дуугүй болов. Хилэнгээ гаргах арай илүү хариу муутай хүн ирэх мэт үзэгсдийг зэвүүрхэн эрэгцүүлж хартал харваач дээр харц нь санамсаргүй тусав. Тэр хүн Седрикийг сайшааж байгаагаа илтэд эгдүүтэй чангаар илэрхийлж байхыг үзээд юунд ингэж хашгирч байгааг нь асуувал Йомен хариуд нь:

- Би, сайн харвалт, зоригтой цавчилт харах бүрдээ дандаа ингэж "уухайлдаг" юм гэв.

- Тийм бий! Магадгүй чи өөрөө бас сүрхий сайн ононо биз? гэж хаан хүүг дуугарахад,

- Тиймээ ойн аль ч харваачаас доргүй гэж Йомен хариулав.

- Үүнд чинь Уат Триррелийн байг тавиад өглөө гэхэд зуун алхмын газраас алдахгүй гэж арын эгнээнээс нэг дуу гарсан боловч чухам хэн хэлснийг мэдэхийн эрхгүй. Авга ах Шар Вильгельмийн нь хувь заяаны тухай цухуйлгасан энэ үг хаан хүүгийн уурыг хүргэхийн хамт бас айлгав.

Энэ гайхууламтгай Йоменийг харж байгаарай гэж манаач нарт тушаасан төдийгөөр хязгаарлан:

- Хутагт Гризельдагийн нэр барьж андгайхад, бусдын гавьяаг бахдагч энэ хүний өөрийн нь эрхэм чадварыг бид шалгаж үзэх болно гэж хэлэхэд Йомен ердийнхөө төлөв байдлаар,

- Тэгж сориулахаас татгалзах юм надад үгүй гэв.

- За яав тэгээд Саксоны бүдүүлэг та нар яагаад босохгүй байна? Тэнгэрийг барьж андгайлахад, нэгэнт би хэлснээс л хойш та нартай еврей цуг суух болно гэж шар нь хөөрсөн хаан хүү дуу алдахад,

- Яаж болох юм бэ? Гэгээн дээдэс та өршөө, ийм эрхэмсэг ноёдтой бид зэрэгцэн сууж үнэхээр зохигүй гэж Исаак учирлав.

- Дээшээ авир бузар нохой? Тэргүй бол арьсыг чинь хуулж морины тоног хэрэгсэл хийхээр

зүсүүлэх болно шүү гэж хаан хүү Жон хашгирав.

Ийм уриалга аваад Исаак нарийн эгц шатаар дээд талын тавцан руу өгсөж эхлэв.

- Хэн үүнийг зогсоож, зүрхлэх нь вэ, харъя гэж Жон еврейг толгойгоор нь доошоо авч хаяхаар илтэд завдан байгаа мэт Седрикийг ширтэн байж өгүүлэв. Тэгтэл Салбадай Вамба ярианд оролцож гай зовлонг зайлууллаа. Босон харайж эзэн Исаак хоёрын хооронд зогсон:

- За алив нэг туршаад үзье! гэж дуу алдан цувныхаа хормой дороос том гэгч гахайны мах гарган Исаакийн бүр хамар руу нь ойртуулав.

Эрүүл тулалдаан өөрийн нь хоолгүй тэсэж чадах хирээс илүү ихээр удахад хүрвэл хэрэглэхээр ийнхүү хүнсний нөц авч гарсан нь илт байв. Өмнөө жигшин цээрлэдэг энэ зүйлийгүзэж, мөн салбадай модон илдээ толгой дээр нь далайсан байхыг хараад Исаак гэнэт гэдрэг ухран хөл алдаж шатан дээрээс ойчлоо. Үзэгч олон элгээ хөштөл инээд болоход хаан хүү Жон ч мөн бараа бологсдынхоо хамт үнэхээр хөхрөв.

Вамба модон илдээ нэг гартаа, нөгөө гартаа гахайн бөөн мах эргэлдүүлэн байж, --За хаан хүү, найз минь надад шагнал аваад ир: Би дайснаа шударга тулалдаанд илд бамбайны хүчээр дийллээ гэж хашгирав.

Жон инээсээр --Чи хэн гэгч вэ, хаанаас гараад ирэв. Дайчин сайн эр минь? гэж асуухад,

- Би угийн тэнэг төрчихсөн хүн, нэр Вамба гэдэг гэж салбадай хариуллаа.

- За еврейд дорд тавцангийн урьд нүүрэнд суудал гаргаж өг, гэж хаан хүү Жон түрүүчийнхээ тушаалыг өөрчилж болох учрал гарсанд баярласан ч байж магадгүйгээр хэлээд дийлсэн дийлдсэн хоёрыг хамт яаж суулгах вэ? Энэ чинь эр баатруудын ёсноос гажна гэв.

- Мэхчинг тэнэгтэй, еврейг гахайн махтай зэрэгцүүлж суулгахаас дор юм гэж ерөөсөө үгүй шүү гэхэд хаан хүү Жон:

- Баярлалаа, залуу минь, чи бүр инээд барчихав гээч! Алив Исаак чи надад ганц атга зоос зээлүүлээд орхи гэв! Энэ гуйлтанд хийрдхийсэндээ Исаак бүсэнд хавчуулаастай байгаа үнэт үсэн хавтгаа удтал тэмтрэн уудлав. Хаан хүү гэнэт бөхийн еврейн гараас хавтгыг нь шүүрч аваад хоёр алтан зоос гаргаж Вамбад хаяж өгөөд тулалдааны талбарын захаар цааш давхиж одов. Үзэгч олон еврейг элдвээр шоолон доромжилж, хаан хүүг шударга ариун явдал үйлдсэн юм шиг сайшаан хашгиралдана.

НАЙМДУГААР БҮЛЭГ

*Харших тулаанд дуулагчийн
Бүрээн дуу цууриалахуйяа
Хариуд нь баатар эр
бүрээгээ татав.
Байгаль дэлхий хүн хурмаст
Цуурайг нь давтахуйяа
Баатрууд мордоцгоон, халхавчаа буулган
Зэр зэвсгээ агсав.
Омголон хөлгүүд өөд өөдөөсөө
Дайран давшихуйяа
Онцгойрч хоёр дайчин эр
Халз тулаанд оров.*

Драйден "Паламон Арсита хоёр"

Талбайг цаашид эргэн явах зуураа хаан хүү Жон гэнэт морио зогсоон Эймер лам руу эргэн энэ өндрийн гол ажлыг мартчихаад байгаа юм байна гэв.

Гэгээн багш нар минь, бид чинь өнөөдрийн шагналыг цагаан гараараа тарааж өгөх учиртай хайр сэтгэл, гоо сайхны хатан хааныг томилохоо мартаж орхиж шүү дээ. Ингэхэд ширээт минь, миний хувьд гэвэл би хар нүдэн Ревеккад саналаа өгөх юм байна гэвэл,

- Ариун дарь эх минь гэж ширээт лам тэнгэр өөд хараад – еврей хүүнийг үү дээ? тэгэх юм бол биднийг заавал чулуугаар нүүлгэж талбараас хөөж гаргана. Гэтэл би тарчилж амь тэвчигчийн алдрыг хүлээж авахад арай нас залуу байгаа юмсан. Тэгээд ч гэгээн өмгөөлөгчдийнхээ нэрийг барьж андгайлахад Ревекка гоо сайхны хувьд Саксоны гоо үзэсгэлэнт бүсгүй Ровенагаас хол дор юм гэв.

- Саксон ч бай, еврей ч бай, нохой гахай хоёр ямар ялгаатай юм бэ? Энэ ямар ач холбогдолтой юм бэ? Адаглаад Саксоны бүдүүлэг харчуулын дургүйг сайн шүү хөдгөлөхийн тул нээрээ Ревеккаг сонгож орхие гэж хаан хүү хариулав. Тэгтэл хаан хүүгийн бараа бологсод хүртэл дургүйцэн шуугилдав.

- Эрхэм дээдсээ энэ чинь тоглоомын хирээс хэтэрлээ. Энд хүрсэн олныг тийнхүү элэг барих юм бол жадаа өргөх эр баатар хүн ганц ч олдохгүй болно гэж де Браси өгүүлэхэд бараа бологсод дотроос хамгийн жин нөлөөтэй, ахмад настны нэг Вальдемар Фицурс гэгч үүнд:

- Тэгээд энэ чинь тун болчимгүй явдал болно. Иймэрхүү янзаар аашилбал гэгээн дээс таны санасан хэрэг бүтэхэд саад тотгор болж мэднэ гэв.

Хаан хүү мориныхоо амыг татан түүн рүү эргэж хараад дээрэнхүйгээр:

- Эрхэм ээ, би таныг миний бараа бологсдын тоонд орно уу гэж гуйсан болохоос надад зөвлөлгөө өгч бай гэж гуйгаагүйсэн билээ гэвэл:

- Гэгээн дээдэс таны энэхүү сонгож авсан замаар чинь дагаж яваа хэн бүхэнд танд зөвлөлгөө өгөх эрхтэй болж байгаа юм. Юу гэвэл таны ашиг сонирхол, аюулгүй байдал бидний өөрсдийнхтэй салшгүй холбоотой билээ гэж Вальдемар дуугаа намсган хэлэв.

Энэ үгийг тун ч хэлбэршгүй өнгөөр өгүүлсэн тул хаан хүү дотно нөхдийнхөө аяыг эрхгүй дагах хэрэгтэй болов гэж үзээд,

- Би зүгээр тоглосон чинь та нар хорт могойд хатгуулсан юм шиг над руу дайрцгаах юм. Чөтгөр алгад хэн дуртайгаа сонгож ав гэлээ.

- Үгүй, үгүй хатны ширээг эзэнгүй орхичихно. Дийлж гарсан хүн өөрөө гоо сайхан хатныг сонгож авна. Энэ чинь ялалтын эд бахыг нэмэгдүүлж, сайн үйлт баатруудын хайр сэтгэлийг сайхан бүсгүйчүүл илүү ихээр үнэлэн үздэг болгож сургах юм гэж де Браси хэллээ.

- Хэрэв Бриан де Буагильбер ялж гарах юм болж гэм хайр сэтгэл, гоо сайхны хатан хаан хэн болохыг би урьдаас мэдэж байна гэж ширээт өгүүлэхэд,

- Буагильбер сайн дайчин, гэвч энд түүнтэй хүч сорилцохоос үл эмээх баатрууд цөөнгүй дэг. Ширээт гуай гэж де Браси хариулав.

- За ноёдоо дуугаа татъя, хаан хүү суудлаа эзлэг, үзэгчид ч гэсэн дайчин эрс ч билээ тэсэж ядаж байна, цаг оройтлоо, эрүүл тулалдаан аль эрт эхлэх болчихож гэж Вальдемар шаардлаа. Хаан хүү Жон хэдийгээр хараахан хэмжээгүй эрт хаан бус боловч Вальдемар Фицурсийн гайгаар эзэндээ зүтгэхийг зөвшөөрөх авч өөрийн тааллыг заавал харгалздаг дотно сайн тэргүүн сайд гэгчтэй байхын эвгүй талыг эдүгээгээс амсаж л байлаа. Хаан хүү жижиг зүйл дээр зөрүүд аашлах дуртай авч энэ удаа ая дагав. Суудалдаа залраад бараа бологчдоо тойрон цуглармагц зарц нарт эрүүл тулалдааны гуимыг дуудаж танилцуулах дохио өгөв. Тэрхүү гурим нь гэвэл ийн ажээ.

Тулалдааныг сэдсэн таван баатрууд бүх хүсэх хүмүүсийг үзэлцэхээр дуудна.

Эрүүл тулалдаанд оролцохыг хүссэн баатар бүр энэхүү таван хүний дотроос аль дуртайгаа сонгож авах эрхтэй. Үүний тулд жадаараа бамбайнд нь хүрэх бөгөөд иш талаар нь хүртэл уг баатар мохоо зэвсгээр өөрөөр хэлбэл мөлгөр модон зэвгэй жадаар үзэлцье гэсний тэмдэг. Харин уул баатар үзүүр талаар нь бамбайнд хүрвэл жинхэнэ байлдааны нэгэн адил үхтэл тулалдъя гэсэн үг болно.

Таван оролцогч тус бүрдээ жадаа тав таван удаа хугалсны эцэст тэдний хэн нь дийлсэн болохыг хаан хүү шүүж шагнал болох гайхал сайхан, зүйргүй эрмэг чадалтай байлдааны хөлгийг гардуулж өгөх аж. Энэ шагналын нэмэр дээр дийлсэн хүн хайр сэтгэл, гоо сайхны хатан хааныг өөрөө сонгох тусгай хүндэт эрх олж авна.

Эцэст нь дараа өдөр бүх нийтийн эрүүл тулалдаан болох бөгөөд энд байгаа бүх баатрууд түүнд оролцож болохыг дуулгав. Баатрууд хоёр тэнцүү тал болон хуваагдаж хаан хүү Жоныг тулалдаан зогсоох дохио өгтөл шударга зоригтойгоор үзэлцэх болно. Үүний дараа урьд өдөр нь сонгож авсан хайр сэтгэл, гоо сайхны хатан хаан, хаан хүүгийн хамгаас илүү гарамгайд

тооцсон баатарт алтан титэм өмсүүлнэ.

Гурав дахь өдөр нь сур харвах, бух улайруулах зэрэг энгийн ард олонд зориулсан бусад цэнгэл явагдана гэв. Ийм баяр наадам зохиосноор хаан хүү дээрэнхүй бардам аашилж сэтгэл санааг нь байнга доромжлогч хүмүүсийнхээ сэтгэлийг өөрөө татах гэж боджээ.

Зарц эдгээр бүх гуримуудыг уншиж дуусаад ердийн заншлаар "эрэлхэг баатруудаа өгөөмөр, өглөг, өгөөмөр өглөг!" гэж хашгирсны хариуд бүх тавцангаас алт мөнгөн зоосууд урсан хуралдаж ирэв. Зарц нар эрүүл тулалдааны намтрыг бичдэг болохоор баатрууд өөрсдийн алдар гавьяаныхаа түүх бичигчдэд мөнгө өгөхдөө гар үл татна. Шан хишиг хүртсэний ачинд зарц нар: "Бүсгүйчүүдийг янаглая! Өстөнд үхэл! Өгөөмөр сэтгэлийг магтая! Эр зоригтны алдар бадраг!" гэж хашгирна. Бүрээчид хөгжмийнхээ дайчин дуугаар агаар цуурайтуулахад үзэгч олон зүгээр л хөхөн хөөрсөн уухайгаар дуу нийлүүлнэ. Энэ бүх шуугиан намдсаны дараа гоё сайхан зарц нар цувран талбайгаас гарч одов. Ганцхан маршалууд л байлданы бүрэн зэвсэгтэй өвч хуягалсан морьдтой талбайн хоёр хажуугийн хаалганы дэргэд хөшөө адил нам ихэмсэг зогсоно.

Энэ үеэр хойт хаалганы тэндэх хашаатай талбайд эрүүл тулалдаан сэдэгчидтэй хүч үзэлцэх гэсэн хүсэлтэй олон баатруудаар дүүрэв. Дээд тавцангаас харахад тэнд намирах өд, гялалзах дуулга, урт жад үй түм мэт санагдах ажээ. Эцэстээ хаалга нээгдэж сугалаагаар таарсан таван баатар талбар руу нэг нь түрүүлж, бусад нь хос хосоор дагалдан алгуурхан орж ирэв_ Тэд цөм гойд сайхан зэвсэглэсэн, надад гарын авлага болж байгаа Саксоны он тооллын бичиг зохиогч тэдний дуудлага, хувцас хунарын өнгө зүс, тэр ч байтугай морины нь нөмрөг дээрх хатгамлыг хүртэл маш нарийвчлан зуржээ. Өнөө цагийн нэгэн яруу найрагчийн үгээр хэлэхэд,

Эр баатрууд үгүй болж

Ирт мэс зэвэрчээ

Эрэлхэг дайчдын сүнс

Энэ хорвоог орхижээ.

Баатруудын сүлд цайзнуудын хананаас ул мөргүй арилж, цайзууд ч гэсэн ногоон толгод хөөрхийлэлтэй балагсууд болчихсон, урьд нэгэн цагт эдгээр хүчирхэг феодал эздийн ноёрхож агсөн нутагт тэр үеэс хойш олон үе улиран солигджээ. Тэдний нэр байлдааны дуудлага уншигч авгай нарт юун сонин байх билээ.

Дайчид тэр талбар дээр гарч ирлээ. Хөгжимчид нуугдан суусан урд талын майхнуудын цаанаас зэрлэг хачин хөгжим хангинав. Энэ заншил дорно дахины гаралтай, баатрууд түүнийг палестинаас авч иржээ. Хөгжим болон хонхнуудаас бүрэлдсэн эрүүл тулалдаан сэдэгчид ойртож яваа баатруудад баяр хүрргэхийн хамт хүч үзэлцэхээр дуудах мэт сэтгэгдэл төрүүлэх аятай. Үзэгч олны нүдэн дээр таван баатар талбай гатлан өнгөрч сэдэгч нарын майхан байгаа гүвээн дээр гаран салаад тулалдаж үзэх гэсэн хүнийхээ бамбайд жадны ишээр аяархан хүрлээ. Энгийн үзэгч олон, тэр ч байтугай нилээн дээгүүр суудалтай олон хүмүүс зарим нэг хагагтай нар баатруудын ийнхүү мухар үзүүрт зэвсгээр тулалдах гэсэнд баахан

урам хугарав.

Баатрууд талбайн нөгөө талд гараад эгнэн жагсав. Тэмцэгч сэдэгчид майхнасаа гарч мордон Бриан де Буагильберээр түрүүлүүлэн гүвээн дээрээс бууж ирээд тус бүр бамбайндаа хүрсэн баатрын тушаа эгнэн зогсов.

Бүрээ цоор хангинаж өстөнгүүд өөд өөдөөсөө дайрлаа. Тулалдаан төдий удаан үргэлжилсэнгүй. Сэдэгчпийн аз, сургууль их байсан тул Буагильбер Мальвуазен Фрон де Беф нарын өрсөлдөгчид дороо мориноосоо хөсөр өнхрөв.

Гранменилийн өрсөлдөгчид жадаа дайсны дуулга юм уу бамбай руу чиглүүлэхийн оронд баатруудын их бие рүү хатган хутгалсан нь мориноос унаснаас илүү шившигтэйд тооцогдох зүйл боллоо. Унахыг тохиолдол гэж үзэж болохтой гэвэл энэ нь чадмаг бус, тэр ч байтугай зэвсгээ эзэмшиж чадахгүй байгааг үзүүлэх ажээ. Ганцхан тав дахь дайчин л эр баатруудын нэрийг хадгалж Иоаннитийн хорооны баатартай үзэлцэн хоёул жадаа хугалаад салахдаа аль алин нь давуутай байж чадсангүй. Үзэгчдийн хашгиралдаан, зарц нарын дуу алдах, бүрээ хангинах шуугиан дийлэгчдийн эд хав дийлдэгсдийн ялагдлыг дуурсгана. Ялагсад майхандаа буцаж, ялагдагсад газраас арай чарай босоод талбараас ичгүүртэйгээр зайлав. Тэд одоо эрүүл тулалдааны дүрмээр дийлдэгсдийн олз болсон морь, зэр зэвсгээ худалдан авах талаар дийлэгчидтэйгээ хэлэлцээр хийх учиртай болжээ.

Зөвхөн тав дахь баатрыг үзэгчид алга ташин үдсэн явдал нөхдийн нь шившийг улам гүнзгийрүүлсэн нь лавтай. Эхний багийн дараа хоёр, гурав дахь баг баатрууд талбай дээр гарч дайчин азаа туршив. Гэвч ялалт сэдэгч нарын талд багтай үлдсээр ажээ. Тэдний нэг нь ч мориноос унасангүй, жадаараа ичгүүртэй хий хатгасангүй харин өрсөлдөгч нарт тийм осол үргэлж гарсаар байв. Иймд үзэгчдийн сэдэгч нарт үл талархагч хэсэг ийнхүү ямагт амжилт хийморьтой байгааг нь үзэн сүрхий гутарч байлаа. Дөрөв дэх ээлжинд дөнгөж гурван баатар гараад Буагильбер, Фрон де Беф хоёрын бамбайнаас тойрон эрдэм чадвар хүчээр арай дутуу санагдах үлдсэн гурвыг нь өрсөлдөөнд дуудав. Гэвч энэ болгоомжлол юунд ч хүргэсэнгүй сэдэгчид урьдын адил бүрэн дийлж гарав. Өштөнгүүдийн нэг нь хөсөр унаж хоёр нь хий хатгаад салав.

Дөрөв дэх ээлжийн дараа нилээн удаан завсарласан нь тулалдааныг үргэлжлүүлэх хүсэлтэй хүмүүс олдохгүй байгаа бололтой. Үзэгч олон дургүйцэн шуугилдаж эхэллээ. Юу гэвэл сэдэгч тавын дотроос Мальвуазен, Фрон де Беф хоёр зан авираараа олонд ад үзэгддэг, Гранменилээс бусад нь харь хүмүүс тул дургүй ажээ.

Эрүүл тулалдааны үр дүнд Саксоны Седрик шиг их гутарсан хүн ер үгүй, норманы баатруудын амжилт бүрийг английн нэр төрийн шинэ доромжлол гэж үзэж байв. Өөрийн эр зориг, хатан батыг дайнд нэг удаа үзүүлж явсан боловч залуугаасаа аван баатруудын энэ маягийн зэвсэг эзэмших эрдэмд сураагүй билээ. Энэ шинэ маягийн эрдэмд суралцаж байсан Ательстан руу одоо асуух байртай үе үе харна. Сүмийн хорооны баатар түүний нөхдийн гараас ялалтыг Ательстан булаан авахаар оролдоосой гэж хүсэх байртай. Гэтэл Ательстан хэдий хүч чадалтай, эр зориг бүхий авч нэр төр эрмэлзэх хүслэн ог үгүй тул Седрикийн хүлээж найдаж байгаа бололтой гавьяаг байгуулж үл чадах ажээ.

- Эрхэм ноёнтон, өнөөдөр Англид аз дайрсангүй. Танд жадаа барьж авах хорхой хүргэхгүй байна уу? гэж Седрик учиртай гэгч асуухад,

- Энэ хариултанд Ательстаны эх орныхоо нэр төрийг хайш хэргээр үздэг нь илэрсэн авч Седрикийн өөрийн нь гүнээ хүндэтгэдэг хүмүүсийг хэлсэн болохоор энэ шийдвэрийг нь буруушаахыг бодсонгүй. Гэхдээ Вамба үгээ ярианд хавчуулах гэж яарсан учир тэгэх завч Седрикэд байсангүй.

- Яриагүй зөв! Уг нь хэдий бэрх боловч хоёр хүний тэргүүн нь байхаас зуун хүний тэргүүн байх гэдэг илүү хүндтэй зүйл гэв.

- Энэ үгийг Ательстан үнэнээсээ хэлсэн магтаал үг санасан боловч салбадайн далд санааг Седрик ойлгон заналхийлсэн ширүүн харцаар харав. Вамбагийн аз болоход цаг нөхцөх байдал барьж аваад залхаан үзүүлэхэд түүнд саад боллоо. Өрсөлдөөн дахин сэргэхгүй, зөвхөн зарц нар л,

- Бүсгүйчүүдийг янаглая! Жадаа хугалцгаа! Эрэлхэг баатруудаа гарч ир! Сайхан мэлмий та нарын үйл хэргийг тольдож байна гэж дуудах сонсогдоно.

Үе үе хөгжимчид ялалтын ид бах, тулалдах дуудлага илэрхийлсэн хачин аяар агаар доргиулна. Арай хийж ганц баярын өдөр дайралдахад үзэх сайхан юм ганц ч байдаггүй гэж үзэгч олон үглэж байв. Хөгшин баатрууд хичээл тайж нар залуу насныхаа дийлж явсан ид хавыг санан өөр хоорондоо шивнэн ярилац, эр баатрын зориг бүрмөсөн мохож байгааг гомдоллон, одоо чинь хуучин цагт дайчдыг зоригжуулж байсан гялбам сайхан бүсгүйчүүл үгүй болжээ гэдэгт санал нийлнэ. Хаан хүү Жон шадар хүмүүстэйгээ найр хуриманд бэлтгэх нэгэн жадаар хоёр хүнийг эмээлээс ховх авч хаян гуравдахий нь дийлсэн Бриан де Буагильберт шагнал олгох тухай ярилцаж эхлэв. Эцэст нь Сарацины хөгжимчид ямар нэгэн удаан дайны хөгжим дахин тоглож гүйцсэний дараа талбайн хойт өнцөгт хашааны цаанаас тулалдаанд дуудсан ганц бүрээ тасхийв. Хэн гээч шинэ баатар ирсэн тухай мэдэгдэж байгааг харахаар бүхний хараа тийшээ чиглэв. Хаалга яаран онгойлгосонд баатар тулалдааны талбарт орж ирэв.

Байлдааны өвч хуяг дуулга өмссөн хүнийг болох хирээр ажиглаваас шинэ ирсэн дайчин, нуруу бусдаас арай өндөр чийрэг боловч хээнцэрдүү бие бялдартай хүн ажээ. Баян сайхан алтан хээ тавьсан давтамал болд хуягтай, бамбай дээрх сүлд гэвэл үндсээр нь сугалан авсан залуу царс модон, дор нь Испани хэлээр "дездичадо" гэж бичээстэй байгаа нь "Өв хөрөнгө үгүй" гэсэн утгатай үг ажээ. Тэр сайхан хар морь унажээ. Тавцангийн дагуу явахдаа бүсгүйчүүл, хаан хүүг хүндэтгэн жадаа хээнцэр хөдөлгөөнөөр бөхөс хийлгэв. Морио чадмаг захирч байгаа болоод идэр залуу хүний уян сайхан хөдөлгөөн ихэнх үзэгчдийн сэтгэлийг даруй татаж олны дундаас:

- Жадаараа Ральд де Випонгийн бамбайг хөнд! Ионнитийг дууд, эмээл дээрээ бат суудалгүй, дийлэхэд хялбар байх бий гэж орилолдох дуу гарав. Иймэрхүү сайныг ерөөсөн зөвлөлгөөний дор баатар тавцан дээр гарч дунд асарт ойртон жадныхаа үзүүр талаар Бриан де Буагильберийн бамбайг хүчтэй дэлссэнд үзэгч олон ихэд гайхав. Хүмүүс цөм ийм их зүрх гаргасанд туйлын гайхсан боловч догшин баатар өөрөө бүхнээс илүү их гайхжээ. Өдий шийдмэг хадлага ирнэ гэж огтхон ч санаагүй энэ үед майхныхаа үүдэн дээр тун ч хэнэггүй

байртай зогсож байсан бүлгээ.

- Найз минь чи өнөөдөр нүглээ начинчилсан уу? Амь насаа ингэж зоримог золиосонд гаргаж байгааг үзэхэд сүмд очиж мөргөл үйлдсэн биз гэж Буагильбер асуухад,

- Би үхэлд чамаас илүү сайн бэлтгэсэн гэж өв хөрөнгө үгүй баатар хариулав. Энэ нэрээр эрүүл тулалдаанд оролцогчдын жагсаалтанд бүртгүүлсэн ажээ.

- За тэгвэл талбай дээр очиж байрандаа зогс, тэгээд чи сүүлчийн удаа нар сайн харж ав! Юу гэвэл чи өнөө оройдоо диваажинд очсон байх болно гэж Буагильберыг хэлэхэд өв хөрөнгөгүй баатар хариуд нь,

- Сануулсанд баярлалаа. Надаас мөн сайн зөвлөлгөөн сонсож ав. Шинэ жад барьж морь сольж унаарай, юу гэвэл нэр төрөө барьж андгайлахад аль алин нь чамд хэрэг болно шүү гэв. Ингэж хэлээд морио бөгсөөр нь ухраасаар гүвээ дээрээс буун бүр хойт хаалга хүртэл бүх талбайг хөндлөн ийнхүү ухраав. Тэгээд өштөнөө хүлээн газар зоолттой юм шиг зогсоход морио ийнхүү гайхан чадмаг захирахыг нь үзсэн олны ихэнх чанга хашгиралдан баяр хүргэв. Өштөнийхөө зөвлөлгөөг сонсоод де Буагильберт хэдий хорсолтой байсан авч ёсчлон дагав. Одоо болох тэмцээний үр дүнгээс нэр төр нь хамаарах тул амжилтанд нь тус болох юухныг ч үл тоомсорлож чадахгүй байлаа. Бие амар, сайн морь эмээллүүлж, шинэ бат сайн жад сонгож аваад, түрүүчийн тулалдаануудад гэмтсэн бамбайгаа солив. Эхний нь бамбайн дээр сүмийн хорооны баатруудын ердийн сүлд тэмдэг болох хүлцэнгүй ядууг илтгэж нэгэн морин дээр сундалсан хоёр баатрын дүрс байсан билээ.

Эхний үед сүмийн хорооныхны чухал шинж гэж үзэгдэж байсан эдгээр дээрэнгүй авир хар амиа хичээсэн зангаараа ялгарах болсон ажээ. Буагильберийн шинэ бамбайн дээр хохимой толгой савартаа атган нисэж буй хэрээний дор "Хэрээнээс болгоомжил" гэж бичжээ. Талбайн эсрэг захад өштөн хоёр зэрэгцэн зогсоход үзэгч олны түгшин хүлээх нь туйлдаан хүрэв. Өв хөрөнгө үгүй баатрын тухайд тэмцээн сайнаар өнгөрөх магад гэж бодох хүн цөөн байв. Гэвч түүний эр зориг, хийморь золбоо үзэгчдийн олонхий нь талархлыг татжээ.

Бүрээ тасхийн дохио дуугармагц өштөн хоёр цахилгаан мэт довтлон талбайн дунд аянгын их хүчээр мөргөлдөв. Тэдний жад хутга үсрэн бариулаа хүртэл салбараад хэдэн хурам хиртэй баатрууд хоёул уначихсан юм шиг санагдан морьд нь дээш цоройн гэдрэг ухарлаа. Моринд чадмаг хоёр жолоо, давируулаа ашиглан морио тэнцүүлээд дуулганы халхавчны завсраар дөл оч цацруулах мэт харцаар бие биеэ тас ширтэв. Тэгснээ хоёул морьдоо эргүүлэн тус тусын зүгт явж хаалганы дэргэд дагуулуудаасаа шинэ жад авлаа.

Цугларсан олон хүний чанга хашгиралдах нь тэмцээнийг хир шохоорхон харж байгааг илтгэх бөгөөд энэ өдөр эр чадал самбаа эрдмээр эн тэнцүү ийм хоёр дайчин анх удаа талбай дээр гарч иржээ. Тэд дахин эсрэгцэн зогсмогц орилолдох, алга таших тасарч хачин нам гүм болоод үзэгчид амьсгаа авахаасаа айж байв.

Морь, хүнд амсхийх хэдэн хурмын зай өгөөд хаан хүү Жон бүрээчид дохио татахыг дохилоо. Хоёр дахь удаагаа өштөнгүүд талбайн төв рүү хурдалж түрүүчийнхээ хурд хүч овсгоотойгоор мөргөлдөв. Энэ удаа сүмийн хорооны баатар дайсныхаа бамбайн гол руу чиглүүлж маш

мэргэн, асар хүчтэй хатгасанд жад сэлэм үсрээд өв хөрөнгө үгүй баатар эмээл дээрээ дайвалзав. Өөрийн ээлжинд эхлээд мөн Буагильберийн бамбай руу онолдуулах гэж явсан энэ баатар эцсийн хурманд бодлоо өөрчлөн дайсны дуулга руу хатгав. Энэ нилээд хэцүү зүйл боловч онож чадвал бараг гарцаагүй хатгалт байлаа. Үнэхээр ч өв хөрөнгө үгүй баатар норманы яг нүүрний халхавч руу жадныхаа хурц үзүүрээр хатгаж чадав. Гэвч сүмийн хорооны баатар үүнд хүртэл самбаа эс алдан алдар нэрээ хадгалж чадлаа. Гайгаар эмээлийн нь олом тасраагүйсэн бол баатар өөрөө унахгүй байхсан. Гэтэл эмээл, морь хүн гурвуул хөсөр тэрийн бөөн тоосон дотор далд орлоо. Дөрөөгөө мулталж, унасан морин дороосоо гаран босон харайх нь сүмийн хорооны баатарт хоромхон зуурын ажил ажээ. Уур хорсолдоо багтран ялангуяа үзэгч олон өөрийн нь унасанд чанга хашгиралдан тавлаж байгаад шатаад илдээ суга татан дийлэгчийнхээ зүг өдөх байртай даллав. Өв хөрөнгө үгүй баатар мориноосоо үсрэн бууж мөн илдээ сугалав. Гэвч маршалууд морио давиран давхиж очоод эрүүл тулалдааны гуримын дагуу иймэрхүү янзаар үзэлцэх эрх үгүйг санууллаа.

- Бодоход бид эрх биш дахин уулзах байгаа, тэгэхдээ хэн ч саад болохооргүй газарт шүү гэж сүмийн хорооны баатар өштөн рүүгээ хилэнт харцаар ширтэн өгүүлэхэд,

- Уулздаггүй юмаа гэхэд миний буруугаас болохгүй бий. Морьтой, явган, жад, балт, илдний аливаар хэзээ боловч чамтай тулалдахад би бэлэн гэж өв хөрөнгө үгүй баатар хариуллаа.

Маршалууд жадаа зөрүүлэн албаар салгаагүй бол тэд удтал ширүүн үг хаялцах байсан байх. Өв хөрөнгө үгүй баатар хуучин байрандаа очиж Бриан де Буагильбер майхандаа буцан бүх өдрийг цөхрөн давчдан өнгөрөөв.

Дийлсэн хүн мориноосоо буулгүйгээр аяга дарс авч ирүүлээд халхавчныхаа эрүүвчийг тайлан "бүх шударга англи сэтгэлийн төлөө, харийн дарангуй харгисууд сөнөтүгэй! гэж ууя" гэв. Үүний дараа бүрээчээ сэдэгчдийг тулалдаанд дуудаж бүрээд гээд хэнийг ч сонгож авах дургүй байна. Өөрсдийн нь тогтоосон дэс дараагаар үзэлцэхэд бэлэн байна гэж тэдэнд дуулгана уу гэж зарцаас гуйлаа.

Талбай дээр хар давтмал хуяг, цагаан бамбай бүхий аварга биет баатар Фрон де Беф түрүүлэн гарч ирэв. Бамбай дээр нь хар бухын толгойны дор "болгоомжлоорой би ирлээ!" гэсэн давилуун бичиг байв. Энэ дайсныг өв хөрөнгөгүй баатар хялбар боловч маргаангүйгээр дийлэв. Хоёр баатрын жад хуга үсэрсэн авч Фрон де Беф дөрөөгөө алдсан тул шүүгч түүнийг дийлсэнд тооцов.

Гурав дахь удаагаа үл танигдах баатар филипп де Мальвуазентай үзэлцэхэд мөн л амжилттай, бээлийн дуулга руу жадаараа их хүчтэй хатгасанд бүч нь тас үсрэн дуулга хөсөр ойчсоны ачаар Мальвуазен өөрөө мориноосоо ойчсонгүй, гэвч ялагдлаа гэж зарлагдав.

Дөрөв дэх удаагаа Гранменилтэй тулалдах боллоо. Тэгэхэд өв хөрөнгө үгүй баатар өдий хүртэл эр зоригтой, чадмаг байсан шигээ их эелдэг өгөөмөр зан гаргав. Гранменилийн морь бага, хэт догшин тул мөргөлдөх үед хажуу тийшээ бусган унасан хүн нь дайснаа олж хатгах боломжгүй болов. Өштөн нь харин энэ ашигтай нөхцөлийг ашиглахын оронд жадаа өргөн өнгөрөөд талбайн зах байрандаа очиж зогсон хүчээ дахин үзэлцье гэж зарцаар Гранменильд хэлүүлэв. Харин цаадах нь өрсөлдөгчийнхээ эрдэм чадлаас илүү эелдэг аашинд нь өөрийгөө

дийлэгдсэнд тооцов. Үл танигдах баатрын ялалтын тоог Ралиф де Випонт хамар амаараа цус олгойдтол асар хүчтэй газар өнхрөн унаж ахиулав. Түүнийг талбараас ухаангүйгээр дамжилж одов. Хаан хүү болоод маршалууд энэ өдрийн шагналыг өв хөрөнгө үгүй баатарт олгохоор санал нэгтэй шийдсэнийг мянга мянган хүн баяртайгаар хашгиралдан сайшаав.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

... Олон бүсгүйчүүл дунд
Онцын сүрлэг зогсоно
Ганцхан энэ хүүхэн л
Хатан хаан байхуйц юм

.....
Энэ тэнцэхээр гоо бүсгүй
Эгээ л тэнд байсангүй.

Эдлэл чимэг, баярын хувцас нь
Хэний ч өмссөнөөс аятайхан
Энгийн төв мөртөө сайхан
Элдэв маяггүй мөртлөө баялаг.

Барьсан мөчир нь түүний гарт цав цагаан
Бүсгүй түүнийг эрх мэдлийн тэмдэг болон өргөв.

Драйден "Цэцэг навчис"

Эрүүл тулалдааны маршал Уильям де Вивиль, Стивен де Мартиваль хоёр дийлэгчид түрүүлэн баяр хүргэв.

Хаан хүү Жонд очиж бараалхан түүний гараас шагналаа авахын тулд дуулгаа авах юм уу халхавчаа сөхнө үү? гэж гуйсан авч өв хөрөнгөгүй баатар өөгүй эелдэг үгээр тэдний гуйлтыг няцаав. Тулалдааны талбарт гараараа зарц нарт тайлбарласан шалтгааны үүднээс энэ удаа царайгаа ил гаргаж бараалхаж чадахгүй байна гэв. Тэр цагт баатрууд хамгийн хачин андгай тавьдаг байсны дотор тодорхой хугацаагаар тас нуугдах явдал байсан болохоор энэ хариулт маршалуудад бүрэн хангалттай санагдав. Иймд дийлэгчийн биеэ үл таниулах гэсний учрыг олох гэж шалгаасангүй, зүгээр л тэр тухай хаан хүү Жонд айлтгаад уул баатарт шагналыг нь гардуулахын тулд өөрт нь бараалхуулах зөвшөөрөл гуйлаа. Нууцархсан явдлын учрыг олохсон гэдэг хүсэл Жонд хүчтэйгээр төрлөө. Өөрийн нь дотно сайн нөхөд болох сэдэгчид ганц баатрын гарт дараалан дийлдсэн уул тулалдааны үр дүнд дургүй нь хүрчихээд байсан болохоор маршалууд ихэмсэг дээрэнгүйгээр хариулсан нь:

- Хутагт дарь эхийг барьж андгайлахад, бидний өмнө нүүрээ нуун бараалхах гэж байгааг үзэхэд энэ баатар өв хөрөнгөө алдсан төдийгүй эелдэг ёсгүй хүн байх нээ? гээд бараа бологсод руугаа эргэж энэ зоригт эр хэн байж болох вэ? Ноёд та нар юу гэж бодож байна? гэлээ.

Де Браси үүнд – таах арга алгаа. Англи орныг угааж байгаа дөрвөн далайн хүрээнд энэ таван баатрыг нэг өдөр дийлэх дайчин эр байна гэж даанч санасангүй. Де Випонт руу явж дайрч орсныг нь би үүрд мартажгүй, нэр төрөө барьж андгайлъя. Хөөрхий Иоганнитийн хорооны баатар эмээлээсээ зүгээр дүүгүүрийн чулуу шиг суга шидэгдсэн шүү гэхэд Ионнитийн хорооны нэг баатар:

- За тэр тухай нэг их нуршаад байх юм алга. Сүмийн хорооныхон ч мөн юм хүртсэн. Танай

алдарт Буагильбер чинь газраар гурав хөлбөрч тухай бүр бөөн элс хаман атгаж байхыг би нүдээрээ харсан гэлээ.

Сүмийн хорооныхонтой сайн байдаг Де Браси үүнд хариу маргахаар завдтал хаан хүү Жон түүнийг зогсоон:

- Дуугүй байцгаа эрхэм үү дээ! Юунд та нар дэмий маргаад байгаа юм бэ?

- Дийлэгч, гэгээн дээдэс таны шийдвэрийг хүлээсээр байна гэж Маршал де Вивиль дуугарав.

- Түүний нэр, цолыг таах хэн нэг хүн гартал түүнийг бид хүлээлгэх таалалтай байна. Шөнө болтол хүлээж зогсоход хүрлээ ч гэсэн өдий их халууцталаа хөдөлсний дараа бээрхийн зовлон үгүй бизээ гэж Жоныг хариулахад Вальдемер Фицурс өөдөөс нь:

- Та чинь дийлсэн баатрыг муугаар хүндэтгэж байх шив дээ. Бидний огтхон ч гадарлахгүй байгаа зүйлийг танд хэлэн хэлтэл түүнийг хүлээлгэх санаатай байна уу. Би л хувьдаа бодоод бодоод мухардаж байна. Ричард хааныг дагаж Палестинд яваад одоо ариун газраас гэр орноо тэмцэн ирж байгаа зоригт дайчдын л нэг биш байдаг юм бол? гэв.

- Солебери гүн биш байгаа? Нуруугаар адил юм байна гэж де Брасийг хэлэхэд Фицурс:

- Жильслендийн баатар Томас де Мультон л байж магадгүй. Солебери чинь өргөн ясархуу байхдаг шүү гэв. Гэнэт бараа бологсдын дунд:

- Үгүй энэ чинь хаан биш биз? Арслан зоригт Ричард хаан өөрөө байж магадгүй гэсэн бүүр түүр яриа дэгдэв. Хаан хүү Жон дэргэдээ цахилгаан буухыг үзэх адил ухран үхдэл мэт зэвхий даагаад – Бурхан өршөө! Вальдемер... Браси... та бүх зоригтон баатрууд, эрхэм ноёд амалснаа бүү мартаарай, миний үнэнч холбоотой байх болно шүү гэвэл Вальдемар Фицурс:

- Айх юм огт алга! Эцгийнхээ төрсөн хүүгийн баатар том биетэйг мартаж орхиод энэ дачин эрийн давгмал хуяганд багтана гэж саналаа гэж үү дээ. Де Вивиль, Мартиваль та хоёр дийлэгчийг одоо даруйхан хаан ширээний өмнө авч ирж, их дээдсийн царайг үнсэн цагаан болгож орхисон энэ сэлтийг тасалбал хаан хүүд их тус үзүүлэх болно гээд хаан хүү рүү эргэн – та сайн хараарай, тэгвэл Ричард хаанаас гурван сөөм нам, мөрөөрөө хоёр дахин нарийн байх бий. Унасан морь нь хүртэл Ричард хааны хүнд биеийг даахааргүй юм байна гэв. Энэ ярианы үеэр маршалууд өв хөрөнгө үгүй баатрыг хаан хүүгийн суудал өөд гарсан модон шат руу дагуулж ирэв. Өөрт нь олон талаар ач болж, өөрөө олон дахин гомтгосон хаан ах нь гүрэн улсаад гэнэт эргээд ирсэнд Жоны сэтгэл машид харлаад, Фицурсийн бүх учирласан үг хүртэл хардлагыг нь бүрэн сарниулж чадахгүй байв. Хаан хүү чичирхийлсэн дуугаар өв хөрөнгө үгүй эрэлхэг баатрыг магтсан хэдэн үг хэлээд дийлэгчийг шагнахаар зэхсэн байлдааны хөлгийг авч ир гэж тушаав. Энэхүү өвч ган хуягтай баатрын дуулганы халхавчин цаанаас арслан зоригт Ричардийн баргил аймшигтай дуу гарах болов уу гэж цаг үргэлж түгшин хүлээсээр байв.

Харин өв хөрөнгө үгүй баатар хаан хүүгийн баяр хүргэсний хариуд ганц ч үг дуугаралгүй зөвхөн дор мэхийн ёслов. Гоё сайхан хувцастай хоёр агтчин хамгийн нарийн сайн хийцтэй байлдааны бүрэн хэрэгсэл бүхий бахдам сайхан хөлөг хөтөлж ирэв. Өв хөрөнгө үгүй баатар

эмээл дээр өрөөсөн гараараа тулан дөрөөнд хүрэлгүйгээр үсрэн мордоод жадаа өргөн талбайг хоёр тойрохдоо мориныхоо явдлыг олон сольж, янз бүрээр аашлуулна.

Өөр нөхцөл байдалд бол зүгээр сайрхах бодлоор ингэж байна гэж бодуштай авч одоо бол бэлгэнд авсан мориныхоо бүх сайн чанаруудыг даруй таних гэсэн зүй ёсны хүслэн байгааг ойлгон үзэгч олон баатрыг дахин сайшааж хашгиралдав.

Энэ зуур шалуур зантай ширээт Эймер дийлсэн баатар одоо эр чадлаа биш, тавцангуудын чимэг болсон гоо бүсгүйчүүлийн дундаас хайр сэтгэл, гоо сайхны хатан хааны ширээг эзлэн маргаашийн эрүүл тулалдааны шагнал гардуулах хүнийг сонгон авч гоо үзэсгэлэнг ялган таних хараагаа шалгуулах цаг ирснийг хаан хүүд шивнэн сануулав. Иймд баатар хоёр дахь удаагаа талбайг тойрон өөрийн нь суудалтай зэрэгцэн ирмэгц хаан хүү Жон очироо өргөв. Баатар морио даруй эргүүлж, жадаа газар хүртэл шахуу бөхийлгэн хаан хүүгийн цаашдын тушаалыг хүлээх байртай нам зогсов. Хөөрч морио эгшин зуур захирч, хөшөө адил хөдөлгөөнгүй зогсоож чадах эрдмийг нь цөм бахархав. Хаан хүү Жон:

- Эрхэм өв хөрөнгө үгүй баатар та, хайр сэтгэл, гоо сайхны хатан хааны ширээг эзэлж маргаашийн эрүүл тулалдааныг зонхилох гоо хатагтайг сонгож олох хүндэт үүрэг танд оногдлоо. Та харийн хүн болоод сонгож авах зовлонтой тул бусад хүнээс зөвлөлгөөн дуулмаар байвал эрэлхэг баатар Вальдемар Фицурсийн охин Алисия авхай манай оронд эртнээс аван тэргүүн бүсгүйд тооцогдсоор ирснийг зөвхөн дуулгаж болох юм. Гэхдээ та энэ титмийг хэн дуртай хүндээ гардуулах бүрэн эрхтэй. Таны л гардуулсан тэр бүсгүй маргаашийн тулалдааны хатан хаан болно. Та жадаа өргөнө үү гээд хаан хүү Жон жадны нь үзүүрт алтан гарихаар хүрээлсэн зүрх, сумны зэв маягаар шүд гарган чимсэн ногоон торгон титэм өлгөв.

Вальдемар Фицурсийн охины тухай баатарт дуулгаснаар Жон хэд хэдэн зорилгот нэгэн зэрэг хүрэхийг эрмэлзжээ. Нэгд Ревеккийн талаар зохисгүй тоглоом тохуу хийснийгээ бараа бологсдын сэтгэлээс цагаатган хоёрт өөрөө баахан эмээдэг Алисийн эцэг Вальдемартай эвлэрэх гэжээ. Мөн Алисияд өөрт нь таалагдахад ч гэсэн дургүй биш байлаа. Нэмэр дээр нь өөрөө тун их дургүй хүрч байгаа өв хөрөнгө үгүй баатар охиныг нь сонгож авахгүй бол (тэгж тун магадгүй) Вальдемар Фицурс доромжлогдсонд тооцно. Тэгээд баатар хүчирхэг лут өштөнтэй болох бий гэж боджээ.

Үнэхээр ч яг тийм боллоо. Өв хөрөнгө үгүй баатар Алисия авхайн суудлыг өнгөрч, энэ гялалзсан олны чимэг олон гоо бүсгүйчүүлийг нарийн ажиглах эрхээ эдлэн тавцангийн дагуу алгуур хөдлөв.

Энэ сонголтын үед хүүхнүүд хир олон янз аашлахыг харахад сонин, зарим нэг нь улайж, нөгөө нь ихэмсэг, халдашгүй дүр үзүүлэхийг оролдоно. Бас эгц урагшаа ширтээд юу ч анзаарахгүй байгаа дүр үзүүлэх хүн ч байлаа. Олонхи нь магадгүй жаахан маяг оролцсон ч байж, ихэд айсан дүртэй гэдэргээ болж байхад мишээлтээ арай чүү нууж байгаа хүн, мөн инээд алдчихаж байгаа хоёр гурван ч зэрэг хүн байв. Бас гоо царайгаа бушуухан нуухыг яарах ч хүмүүс байсан нь саксоны он тооллын бичиг гэрчилж байгаагаар гоо сайхан нь олны дунд арав гаруй жил алдаршсан бүсгүйчүүл ажээ. Хорвоогийн хоосон үймээнээс нэгэнт уйдчихаад байгаа арай залуу нэгүүд найр тавьж өгөн өөрсдийнхөө эрхийг эдлэхээс сайн дураар татгалзаж байж болох юм.

Эцэст нь баатар, Ровена авхайн сууж байгаа тагтны өмнө зогссонд олны шохоорхон хүлээж ядах нь бүр дээд хэмжээнд хүрэв.

Тавцангийн, тухайлан энэ хэсэгт өв хөрөнгө үгүй баатрын амжилтыг гойд халуунаар талархаж байсныг хүлээх учиртай Саксоны Седрик сүмийн хорооны баатар дийлсэнд бахдаж хар санаат хөрш Фрон де Беф, Мальвуазен хоёрын бүр ч муугаа үзэхийг хараад тагтны хашлаган дээгүүр бөхийн дийлэгчийн гавьяа гүнээ сэтгэл догдолж талархан ажиж байв. Ровена хатагтай мөн энэ өдрийн явдлуудыг, хэдий сэтгэл догдолсноо ил үзүүлэхгүй авч Седрикээс доргүй шохоорхож байлаа. Тэр ч байтугай амарлангүй Ательстан хүртэл ердийн нозоорсон байдлаа орхин том аяга мускат дарс авч ирүүлэн өв хөрөнгөгүй баатрын төлөө ууя гэв. Саксончуудын эзэлсэн тагтны яг дор суусан өөр нэг бүлэг хүмүүс эрүүл тулалдааны дүнг тэднээс доргүй сонирхож байв.

Сүмийн хорооны баатар, өв хөрөнгө үгүй баатар хоёрын анхны мөргөлдөөн болж байхад Йоркийн Исаак-Өвөг эцэг Авраам минь! Энэ христос шашинтан мөн айхавтар давхиж байнаа? Сайн морийг алс газраас, бүр Берберийгээс авч ирсэн байхад тэр зүгээр нэг муу илжиг аятай эдэлж байна. Миланы зэр зэвсгийн худалдаачин Иосиф Перейрийн асар өндөр үнээр авсан гоц сайхан хуяг дуулгыг яана! Түүнийг ч гэсэн мөн их зам дээрээс олсон юм аятай огт тоохгүй байна гээч! гэхэд Ревекка хариуд нь:

- Үгүй тэр чинь өөрийн амь нас, бие махбодоо ийм аюултай тулалдаанд оролцон дүйж байгаа юм чинь морь, хуяг, дуулганы бүрэн бүтний тухай санаа тавих гэж бодох ч хэрэг алга гэв. Исаак үүнд унтууцан – хүү минь чи юу ярьж байгаагаа мэдэхгүй байна. Түүний бие махбод амь нас бол өөрийн нь юм. Тэгэхэд морь зэр зэвсэг... Гэхдээ тэр чинь сайн залуу. Хараач, Ревекка хар даа! Цаадах чинь тэр Филистимляинтай дахин тулалдахаар завдаж байна. Эцгийн минь тахисан шүтээн! Ялчихлаа шүү!

Бузар явдалт Филистимлянин түүний жаданд дарагдав. За одоо тэр тэдний алт , бүгд түүний олз! гэж байлаа.

Түтгэлзсэндээ юм уу, өөр ямар нэгэн шалтгааны улмаас дийлсэн баатар хувь хир хөдлөмгүй зогсов. Түүний алхам бүрийг үзэгч олон нам чимээгүй, догдлон анхаарч ажиглана. Тэгээд алгуур эвлэг хөдөлгөөнөөр жадаа бөхийлгөн титмээ сайхан Ровенагийн хөл дор тавив. Энэ эгшинд бүрээ хангинаж, зарц нар Ровена авхайг хайр сэтгэл, гоо сайхны хатан хаанд өргөмжлөн зарлаад хатны зарлигаас давж зүрхэлсэн хүн бүхнийг цээрлүүлнэ гэж сүрдүүлэв. Дараа нь тэд ердийнхөө өглөг өгөхийг дуудсанд Седрик сэтгэл хөөрсөндөө их мөнгө атгуулав. Ательстан ч мөн төдий шалмаг бус боловч зэгсэн хишиг хүртээлээ.

Эр баатрын тоглоомд ялагдаж сураагүй норман баатруудын адил өөрсдийг нь саксон бүсгүйчүүдээс дорд сайтар дасаагүй норман хүүхнүүдийн дотор дургүйцэн бүүр түүр шуугиан дэгдэв. Гэвч энэхүү дургүйцлийн илэрхийлэл үзэгч олны "хайр сэтгэл гоо сайхны хатан хаан Ровена авхай мандтугай!" гэсэн чанга хашгиралдаанд дарагдлаа. Энгийн ардуудын дотроос "саксоны хатан хаан мандтугай. Үүрдийн алдарт Альфредийн ураг удам мандтугай!" гэж хашгирах дуу гарна.

Иймэрхүү хашгиралдаан дуулаад хаан хүү Жонд хэдий аягүй байсан боловч дийлсэн баатар

зүй гуримын дагуу сонголт хийснийг хүлээх учиртай байв. Морьд авч ир гэж тушаагаад суудлаасаа буун, хөлгөө унаж бараа бологсдоо дагуулан дахин талбай дээр гарч ирэв. Алисис авхайн сууж байгаа тавцангийн өмнө түр зогсоод сууж их л эелдгээр мэнд ус мэдэж хажууд байгаа хүмүүст хандан,

- Гэгээн багш нарыг барьж андгайлахад, энэ баатрын байгуулсан гавьяа түүний булчин шөрмөс чангатайг өнөөдөр бидэнд үзүүлсэн боловч хатан хаан сонгож авсныг нь үзвэл нүд нь төдийл хурц биш дэг шүү эрмүүдээ гэв.

Хаан хүү Жон бүх насан туршаа тал засах гэсэн хүмүүсийнхээ зан араншиг гадарлаж чаддаггүй муу заяатай явсанчлангаа энэ удаа бас оносонгүй.

Охиныг үл тоомсорлосон явдлыг хаан хүү ингэж тодоор онцлон хэлсэнд Вальдемар Фицурс баярлалаа гэхээсээ илүү гомдож орхив.

Эрх чөлөөт эр баатар хүнд сэтгэлийн хүнээ өөрөө мэдэж сонгон авах эрхээс илүү эр баатарчуудын үнэтэй чухал дагах гуримыг би л нэгийг ч мэдэхгүй юм байна. Миний охин хэнийг ч өөрийгөө илүүтэйд үзээсэй гэж хүсэхгүй, өөрсдийнхэн дундаа бол ямагт хир тааруу хэмжээгээр хүндлэгдэж бишрэгдэж байх болно гэж Фицурс хэллээ.

Хаан хүү Жон юу ч хэлсэнгүй, хамаг уураа мориндоо гаргах гэсэн аятай тас давирсанд морь ухасхийн хурамхан зуур титам хөл дор нь тавиастай хэвээр байгаа Ровена авхайн сууж буй тавцангийн дэргэд хүрэв.

- Гоо авхайтан, хаан эрх мэдлийнхээ билэг тэмдгийг хүлээж ав, үүнд чинь Анжуйн хаан хүү Жоноос илүү үнэн сэтгэлээсээ захирагдах хүн үгүй. Маргааш бид бүгд захирагдан дагах хатан хаантай илүү сайн танилцах боломж олгож, өнөөдөр Ашбийн цайзнаа болох найранд өөрийн сайн язгуурт төрөл садан, нөхдийн хамт залран чимэг болж хайрлахгүйсэн болов уу гэж хаан хүү хэлэв.

Ровена дуугүй хэвээр суухад, Седрик орноос нь өөрийнхөө төрөлх хэлээр,

- Ровена авхайтан таны эелдэг үгний хариуг хэлж таарах байсан тэр хэлийг мэдэхгүй юм. Мөн тэр учраас авхай танай найранд оролцож чадахгүй. Би өөрөө сайн язгуурт Конингсбургийн Ательстан ялгаагүй зөвхөн өвгөд дээдсийнхээ хэлээр ярьж зан заншлыг дагадаг улс. Иймд өндөр дээдэс таны эелдгээр урьж гийгүүлсэнд баярлавч очиж амжихгүй. Харин Ровена хатагтай маргааш дийлсэн баатар өөрийн хүслээр сонгож, ард олны сайшаалтаар батлагдсан тэр хэргэмтэй уялдах үүргийг гүйцэтгэнэ гэж хариулаад шалан дээрээс титэм авч, Ровенагийн толгой дээр тавьсан нь түр эрхийг хүлээн авсны тэмдэг ажээ.

Хаан хүү Жон саксон хэл хэдий сайн мэдэх авч үл мэдэх дүр үзүүлэн:

- Энэ юу гэж байна? гэв.

Седрикийн ярианы утгыг түүнд францаар хэлж өгөв.

- За яах вэ, энэ дуугүй хатныг хүндэт суудал руу нь бид өөрсдөө зална гээд тавцангийн өмнө зогсоор байсан дийлэгч рүү эргэж – Адаглаад эрхэм баатар та өнөөдөр бидэнтэй хамт зоог барих болов уу? гэлээ.

Баатар үүнд анх удаа ам нээж, ядарсны дээр маргааш болох тэмцээнд зарим бэлтгэл хийх чухал хэрэгтэй гэдгээр шалтаг заан намуун дуугаар хаан хүүгээс уучлалт гуйв.

Хаан хүү Жон ихэмсгээр –За яах вэ, бид ийнхүү татгалзахад дасаагүй хэдий авч, тулалдаанд хамгаас шалгарсан баатар, түүний сонгож авсан гоо сайхны хатан хааны аль алин нь байлцаж гийгүүлэхийг эс таалсныг үл харгалзан хоолоо яаж ийгээд нэг шингээхийг оролдож үзэхээс дээ гэв. Ийнхүү хэлээд тайлбарыг орхиж явахаар завдан морио эргүүлсэн нь тулалдаан төгссөний дохио билээ.

Гэвч давтагдаж хөндөгдсөн бардам зан, ялангуяа бүтэлгүй явдалдаа ихээр эмзэглэж байгаа үед их өширхөж байдаг билээ. Жон гурван алхам холдоогүй байхдаа эргэж өглөө уурыг нь айхавтар их хүргэсэн нөгөө Йомен руу хилэнтэй харц чулуудан харуулын хэнд захирангуйгаар:

- Энэ сайн эр зулбаад алга болчихвол чи толгойгоороо хариуна шүү гэв.

Хаан хүүгийн догшин харцыг Йомен тайван, хатуугаар тэсвэрлэж инээмсэглэн:

- Би ер нь нөгөөдөр болтол Ашбигаас явах гээгүй байгаа шүү. Стаффордшир, Лейстер нутгийнхан хир сайн харвадгийг үзмээр байна. Нидвуд, Чарнвудийн ойд сайн харваачид байдаг л байх учиртай гэв.

Хаан хүү Жон шууд Йоменд хандалгүй шадар хүмүүстээ:

- Өөрөө хир харвадгийг нь бид үзнээ, эрдэм чадвар нь энэ тэсгэлгүй аашийг нь бага боловч эс зөвтгөх юм бол хохь нь болох бий гэж хэлэв.

- Энэ харцуудын хэн нэгийг санамж болтол сайн гэсгээх цаг бүр болоод байна. Эд арай хэтэрхий танхай болоод байна шүү гэс де Браси хэллээ.

Вальдемар Фицурс зөвхөн мөрөө хавчисхийгээд юу ч дуугарсангүй. Эзнийгээ алдар нэрэнд хүрэхээс ангид зам шилж авлаа гэж дотроо бодсон бололтой. Хаан хүү Жон цааш хөдлөн талбайгаас гарч одоход хойноос нь бүх үзэгчид хашаагаар багшран цував.

Олны ихэнхи нь олон язгууртан, зочид суудаг Ашби рүү явлаа. Бусад нь хот дотор байр олсон ажээ. Тулалдаанд оролцсон юм уу, маргаашийн тэмцээнд оролцохоор завдаж байгаа баатруудын ихэнх мөн эдний тоонд орно. Тэд энэ өдрийн явдлыг хоорондоо ширүүн хэлэлцсээр гэлдрэхэд хажуугаар өнгөрөх ардууд баяр хүргэж чанга хашгиралдана. Хаан хүү Жоныг мөн иймэрхүү хашгиралдан үлдсэн нь ганцхан өөрийн нь сайн сайхан чанарыг гэхээсээ хувцасны хээнцэр дэгжин, гял цал болсон бараа бологсдын сүр жавхааг үзээд баяр хүргэсэн хэрэг байв. Дийлэгчийг хүмүүс нэгэн санаагаар үнэн сэтгэлээсээ талархан хашгиралдаж угтав. Харин баатар өөрөө сайн сайхан сэтгэлээ ийнхүү илчилж байгаа олны

нүднээс даруй далд орохыг хүсэх тул хашааны цаад өнцөгт байгаа майхнуудын нэгийг эзэлнэ үү гэж тулалдааны талбарын маршалууд эелдгээр урьсныг талархан зөвшөөрөв. Түүнийг майханд ормогц харж шохоорхох, элдэв таавар бодлоо солилцох санаатай цугларсан олон ардууд тарж одов.

Олон хүн цугларахад заавал байдаг шуугиан хөдөлгөөн бага багаар замхрав. Нэг хэсэгтээ зүг зүг салах хүмүүсийн яриа дуулдаж байснаа төдхөн холдсоор тасарлаа. Одоо зөвхөн шөнөдөө хивс олбог хурааж байгаа зарц нарын дуу, өдрийн турш үзэгч олонд зөөсөн дарс, элдэв зууны үлдэгдлийн мөрөөс хэрүүл маргаан хийх нь дуулдана.

Хашааны гадаа зүлгэн дээр олон дархчууд байрласан бөгөөд үдшийн бүрэнхий ихсэж ирэхийн хирээр дархны гал улам улам хурж гялалзаж харагдана. Зэвсгийн дархчууд маргааш хэрэглэх зэр зэвсэг засаж янзлах ажлаар шөнө дөлөн оролдож хононо гэсэн үг ажээ.

Зэвсэглэсэн хүчирхэг баг харуул хоёр цаг тутам солигдсоор тулалдааны талбайг шөнөжин маналаа.

АРАВДУГААР БҮЛЭГ

*Муу зөнч, зэвүүн илч хэрээ
Нам гүм шөнийн харанхуйд нисэн
Өвчтөн хүнийг эрлэгтэй учруулах халдвар
Өрөвгөр хар далавчнаас нь
Хөөрхий Варрава хилмэгдэн зугтааж
Христос шажинтанг үеийн үед зүхнэ.*

Марло "Мальтийн еврей"

Өв хөрөнгө үгүй баатар майхандаа дөнгөж ормогц дагуул, хиа бусад зарц хүмүүс ирж хуяг дуулгаа тайлах, шинэ хувцас солих, халуун усанд орж амрахад туслахыг хичээнэ. Тэдний энэ эелдэг аашны цаана, нэгэн өдрийн дотор өдий их алдар нэрийг олно. Хаан хүү Жоныг тушааж байхад хүртэл жинхэнэ нэрээ хэлээгүй энэ баатрыг танихсан гэсэн хүсэл лав нуугдаж байсан бизээ.

Өв хөрөнгө үгүй баатар өөрөө дагуултай гээд алив тус үйлчилгээ хийлгэхээс эрс татгалзав. Хөдөлгөөн болхидуу зарц нь өргөн хар эсгий цувтай агаад хар үстэй норман малгайгаа хүнд танигдахаас айсан байртай дух руугаа дарж өмсчээ. Гадна бүх хүмүүсийг майхнаас гараад зарц баатрын хүнд хуяг дуулгыг тайлж өмнө нь хоол, дарс тавьсан нь энэ өдрийн нүсэр хүнд хөдөлмөрийн дараа илүүдэхгүй зүйл байв.

Баатар яаруухан идэж ууж амжтал таван үл таних хүн тус бүр байлдааны бүрэн хэрэгсэлтэй морь хөтөлж ирээд уулзъя гэж байна гэж дуулгав. Баатар хуяг дуулгаа тайлаад урт хэвнэг нөмөрч дуулганы халхавчнаас доргүй том юүлэн дотор нь нүүрээ сайнаар нууж болохоор ажээ. Гэвч нэгэнт харанхуй болчихсон, баатрыг тун дотнын нь хүн л таньж магадгүй тул царай зүсээ тийнхүү далдлахын хэрэггүй байв.

Иймд өв хөрөнгө үгүй баатар майхнаас зоволтгүй гарвал үүдний нь өмнө таван сэдэгчийн дагуул зогсож байгааг хар хүрэн өнгийн хувцас, мөн тус бүр эзнийхээ хуяг дуулга сэлт ачсан морь барин зогсож байгаагаар танилаа. Эхний дагуул ам нээж, --эр баатруудын дагах гурим ёсоор догшин баатар Бриан де Буагильберийн дагуул Балдуин де Ойлей би эзнийхээ нэрийн өмнөөс эдүгээ өв хөрөнгө үгүй баатар гэгдэж байгаа танд өнөөдөр болсон тулалдааны үед дээр дурдсан Бриан де Буагильберийн эдэлж явсан морь зэр зэвсгийг өгөхөөр хүргэж ирлээ. Эдгээрийг авах юм уу, төлбөрийг нь авах эрх таных билээ. Тулалдааны талбарын гурим ийм ажээ гэв.

Бусад дөрвөн дагуул бараг ийм үгү хэлж, өв хөрөнгө үгүй баатрын шийдийг хүлээн эгнэж зогсов.

- Эрхмүүдээ, та дөрөв болоод танай хүндэт эрэлхэг эздэд миний хэлэх хариу ижил сайн үйлт баатруудад баяр хүргэж байгааг минь дамжуулаад, тэднээс илүү эрэлхэг эзэгнэж сайн чадах хүмүүс ер үгүй энэ морьд, зэр зэвсгийг би авбал муу юм үйлдэнэ гэсэн үг гэж байна гээрэй. Харамсалтай нь би ийм үг хэлсэн төдийгөөр хязгаарлаж чадахгүй. Би зөвхөн нэр төдий биш үнэндээ хөрөнгө үгүй болсон болохоор эрхэм баатрууд зэр зэвсэг морио төлөөслөн авбал

надад их тус үзүүлэхсэн гэдгийг хүлээхэд хүрч байна гэж баатар хэллээ.

Реджинальд фрон де Бефийн дагуул үүнд,

- Морь бүрийг зэр зэвсэгтэй нь зуун алтан зоосоор төлөөслөн авья гэж танд хэлээрэй гэж бидэнд даалгасан билээ гэвэл, баатар хариуд нь:

- Энэ чинь яриагүй болно. Нөхцөл байдлаас болоод би энэ мөнгөний талыг авахад хүрч байна. Үлдсэн мөнгөний хагасыг эрхэм дагуул та нар адил хуваан авч нөгөө хагасыг зарц, мэдээчин зэрэг бусад үйлчлэгч хүмүүст тарааж өгнө үү! гэв.

Ийм үзэгдээгүй их өгөөмөр билэг хайрласанд дагуулууд малгайгаа аван мэхийн гүнээ талархав. Дараа нь баатар Бриан де Буагильберийн дагуул Балдуинд хандан:

- Т анай эзнээс би зэр зэвсэг, төлбөр алиныг ч авахгүй. Бид илд жад, явган морьтой дахин үзэлцэхээс нааш бидний тулалдаан дуусаагүй гэж миний нэрийн өмнөөс дуулгаарай. Тэр өөрөө намайг үхлийн тулалдаанд дуудсан түүнийг би хэзээ ч мартахгүй. Харилцан эелдэг зан гаргахад таатай байгаа бусад нөхөдтэй нь түүнийг адигүй өөрийн ясны өштөн гэж үздэгийг тэр мэдэж аваг гэвэл Балдуин хариу өчихдөө:

- Миний эзэн жигшлийг жигшлээр, цохилтыг цохилтоор эелдэг найрсагт найрсагаар хариулдаг хүн. Бусад баатруудын зэр зэвсэгт тогтоосон үнэнийхээ талыг ч болов авахгүй бол морь зэр зэвсгийг нь би энд үлдээхээс өөр замгүй. Миний эзэн хэзээ ч дахиад энэ морийг унаж энэ зэр зэвсгийг эдэлж нэрээ гутаахгүй гэдэгт би бат итгэж байна гэв.

- Сайхан хэллээ, сайн дагуул байна! гэж өв хөрөнгө үгүй баатар өгүүлээд, эзгүй байгаа эзнийхээ өмнөөс хариу хэлж байгаа хүнд зохисон зоримог цочмог үг байна. Гэлээ гэхдээ морь, зэр зэвсгийг надад үлдээлгүй эзэнд нь аваачиж өг. Хэрэв тэр өөрөө авахыг үл хүсвэл найз минь чи аваад эдэлж хэрэглэ! Нэгэнт л би мэдэх эрхтэйгээс хойш эднийг дуртайяа чамд бэлэглэж орхие гэлээ.

Балдуин дор мэхийн ёслоод бусдын хамт явж өв хөрөнгө үгүй баатар майхандаа орлоо. Тэгээд зарцдаа:

- Гурт аа, английн эр баатарчуулын нэр төр миний гарт хугарсангүй гэхэд Гурт сайрхан:

- Саксоны гахайчин гэхэд норман дагуулын оронд муугүй тоглов шив би чинь гэв.

Өв хөрөнгө үгүй баатар хариуд нь тэр үнэн, гэхдээ чиний наад эв дүйгүй бие чинь танигдаад орхих болов уу гэж би цаг үргэлж сэтгэл түгшиж байгаа гэв.

- Үгүй түүнээс би өчүүхэн ч айхгүй. Намайг таньж мэдэх хүн гэвэл салбадай Вамба бөгөөд тэнэг юмуу овжин эр үү гэдгийг өнөө хүртэл түүнийг би таниагүй л яваа юм. Манай хөгшин эзэн Гуртийг эндээс олон бээрийн цаана Ротервудийн бут намган дотор гахайгаа хариулж л яваа гэж бодсоор хажуугаар тун ойрхон өнгөрөхөд инээдээ барих хэцүү байсан шүү. Хэрэв намайг танивал... гэтэл баатар үгийг нь таслан:

- За энэ тухай яриад хэрэггүй, чамд юу амалсныг чи мэдэж байгаа шүү дээ гэв.

- Тэр тухай харин ярихын хэрэг байхгүй! Цээрлэл үзэхээс эмээж нөхрөөсөө урвах хүн би биш, миний арьс зузаан, торлог сэлтийг миний сүргийн аль ч бодонгоос доргүй дааж өнгөрүүлнэ гэвэл,

- Гурт, миний өмнөөс өөрийгөө ингэж зүрхлэх аюултай байдалд оруулж байгаагийн ачийг би хариулж чадна, нээрээ шүү. Аа одоогоор май, арван алтан зоос авч үз гэхэд Гурт уул мөнгийг хэтэвчиндээ далд хийх зуур:

- Би одоо аль ч боол юм уу гахайчингаас баян боллоо гэв. Эзэн нь үргэлжлүүлэн:

- Харин энэ ууттай мөнгийг Ашби руу авч од. Очоод Йоркийн Исаакийг ирж ол. Надад зээлээр олж өгсөн морь, хуяг дуулга сэлтийнхээ үнийг үүнээс мэдээд аваг гэхэд,

- Үгүй, гэгээн Дүнстаны нэрийг барьж андгайлахад би үүнийг хийхгүй гэж Гурт дуу алдав.

- Юу гэнээ ээ зальхай амьтан чи! Чи миний тушаалыг давж яаж зүрхлэнэ вэ? гэж баатрыг асуухад,

- Таны шударга, зөв ухаалаг, христос шашинтан хүний ёсоор тушаасан бүхнийг би гүйцэтгэнэ. Энэ тэгэхэд юу болж байнаа! Еврейг өөрөө мэдээд өөрөө ав гэдэг чинь шударга биш явдал, эзнийгээ мэхлэхтэй адил үг мөн ухаалаг биш хэрэг, юу гэвэл энэ чинь давагдаж хоцрох гэсэн үг гэж Гурт хариу өчив.

- За зөрүүд хар минь адаглаад сэтгэлд нь ханасан үнэ өгч үз! гэж өв хөрөнгө үгүй баатрыг өгүүлэхэд,

- Би үүнийг гүйцэтгэнэ, гэж Гурт дуугараад мөнгийг хэвнэгэн дороо нуулаа.

Гэвч майхнаас гараад аман дотроо:

- Исаакад амалсан үнэний нь хагасыг авахуулж салахгүй бол би, би биш болно доо гэж үглэв.

Ингэж хэлээд хувийнхаа ажил төрлийн тухай бодолд автан суугаа өв хөрөнгө үгүй баатрыг орхин явж одлоо. Одоохондоо уншигч авхай нарт тайлж өгч үл чадах олон шалтгааны улмаас энэ нь гунигтай хүнд бодол ажээ.

Одоо бид Ашбид, чухам эсвэл Исаак охин, зарц нарынхаа хамт түр сууж байгаа хот хавийн нэг баян еврейгийн эдлэнд очоод байна гэж саная.

Дорнодын маягаар хээнцэр зассан жижиг өрөөнд Ревекка хатгамал дэрнүүд дээр сууна. Гутарч догдолсон байртай өрөөн дотуур нааш цааш алхах эцгийнхээ хөдөлгөөнийг сэтгэл түгшин бүсгүй хүний энхрийлсэн харцаар ажиглана. Өвгөн үе үе гараа алдасхийн, гүн их гай зовлонд учирсан хүний байртай дээш адар өөд харан:

- Ээ, Иаков, манай омгийн үнэн ариун явдалт бүхэн арван хоёр үгийн өвөг дээдэс минь!

Моисеевын зааврын бх өчүүхэн жижиг боловч гурим ёсыг би цөм дагаж яваагүй гэж үү? Юунд надад ийм хатуу цээрлэл ирэв ээ? Харин дарангуй этгээдийн савар тавин алтас зоосыг минь булаагаад авчихлаа гэв.

- Үгүй аав та хаан хүү Жонд алтаа дуртайяа өгсөн шиг надад санагдсан гэж Ревека хэлбэл:

- Дуртай гэнээ? Тэр хүнд египетийн газрын юм гартугай! Дуртай өгсөн гэж чи хэлнэ гэнээ? Урьд нэг цагт их шуурганы үеэр хөлөг онгоцны ачааг хөнгөлөхийн тулд эд бараагаа Лионын хойгт усанд хаяж байсан шигээ л дуртай өгсөн дөө. Тэгэхэд би хуйларсан давалгааг хамгийн сайн торгоороо хувцаслаж, хөөс цацарсан мандлыг нь анхилуун дарсаар аргадаж, газар царсан мандлыг нь анхилуун дарсаар аргадаж, газар доорхи агуйнуудыг алт мөнгөн эдлэлээр чимсэн юм. Би өөрийнхөө гараар тийм алтан золиос өргөсөн авч тэр бол өчүүхэн гаргашгүй их гаслангийн үе байж билээ гэхэд охин:

- Гэхдээ тэр гарз чинь бидний амь насыг аврахад чухал байсан, тэр цагаас хойш манай өвгөдийн бурхан худалдаа арилжааг чинь өршөөж эд баялгийг тань арвижуулаагүй гэж үү? гэв.

- Тийм байх яахав. Гэтэл дарангуйлагч этгээд түүнд савраа дүрэхийг бодож, намайг дээрэмдэж байхдаа бас албаар инээмсэглэх болговол яах вэ? Охин минь, бид хоёр чинь хохирч хавчигдсан хоргодох газаргүй тэнэмлүүд дээ. Манай овгийн хамгийн адгийн гай гэвэл биднийг доромжилж, дээрэмдэж байхад эргэн тойрон хүмүүс инээлдэж бид тэгэхэд доромжлолыг дуугүй хүлээн хүлцэнгүйгээр инээмсэглэж байх учиртай гэв.

- Больж үз аав аа. Бидэнд танд ч зарим нэг давуу тал бий. Энэ буруу номтонгууд биднийг хатуугаар хяхан хавчдаг үнэн боловч хорвоогоор нэг тархан сууж жигшигдэн мөрдөгдөж байдаг Сионы хүүхдүүдээс тэд тодорхой хэмжээгээр шүтэж байдаг билээ. Бидний эд баялаг байхгүй бол эд дайны цагт цэрэг тэжээж чадахгүй, ялалтын дараа хурим найр хийж ч чадахгүй байхсан. Бидний эдэнд өгсөн алт өсөн нэмэгдээд эргэж авдрандаа ордог шүү дээ. Бид чинь их гишгэлэхийн хирээр улам сайхан ургадаг өвстэй адил улс. Өнөөдрийн гялалзсан сайхан эрүүл тулалдаан хүртэл шигшигдмэл муу еврейн тусламжгүйгээр өнгөрсөнгүй, зөвхөн түүний өршөөлөөр л боллоо шүү дээ гэж Ревеккаг хэлэхэд,

- Охин минь чи миний гуниглах бас нэгэн судсыг хөндлөө. Кирджат Жайрамтгай Лейстерт хийсэн наймааны маань бүх цэвэр хонжоо болсон сайн морь, үнэт сайхан хуяг дуулга үрэгдлээ. Бүтэн долоо хоногийн ажлын маань хөлс болох зүйл оргүй алга боллоо. Гэхдээ бас харнаа энэ хэрэг арай дээрээр ч төгсөж магадгүй. Тэр чинь үнэхээр сайн залуу шүү! гэж Исаак өгүүлэв.

- Тэр баатрын үзүүлсэн сайн тусыг хариулсандаа чи арай хар бууж байгаа биш биз дээ гэж Ревеккаг дургүйцэхэд,

- Тэр ч тиймээ охин минь, гэхдээ христос шашинтны хамгийн сайн цэг нь ч гэсэн өөрөө сайн дураараа өгнө гэдэгт би шинэ сүмийн цамхаг ханыг өөрийн нүдээрээ сайн харж байгаа шигээ бага итгэж байна шүү гэж Исаак хэлэв.

Ингэж хэлээд өрөөн дотуур дахин гутрангуй байртай холхиход эцгийгээ тайтгаруулах гэсэн оролдлого нь дахин шинэ шинэ гай зовлон ярьж гомдоллон сэтгэлийг нь улам ураа баргар болж байгааг Ревекка үзээд цаашид элдвийг ярихаас түдгэлзэв.

Энэ зуур бүр харанхуй болж зарц орж ирж ширээн дээр хоёр сайхан үнэрт тос бүхий асаасан зул тавьж өөр нэг зарц үнэт дарс, нарийн тансаг зууш оруулж ирэн мөнгөн хээтэй жижиг хар зандан ширээн дээн өрлөө. Тэгэхийн хамт нэг христос шашинтан хүн уулзах гэж байгааг дуулгав. Наймаа арилжаагаар амь зуудаг хүн бүх цагаа сураглаж ирсэн хүмүүст зориулах учиртай дөнгөж уруул хүргээд байсан грек дарстай хундгаа Исаак яаран тавьж "Ревекка нүүрнийхээ татуургыг буулга" гэж охиндоо хэлээд ирсэн хүнийг оруул гэж зарцад тушаалаа.

Ревекка гоо сайхан царайгаа мөнгөлөг сиймгэр урт татуургаар дөнгөж нууж амжтал үүд нээгдэн Гурт орж ирэв. Гадаад байдал нь итгэл төрүүлэхээсээ илүү сэжигтэй санагдам, орж ирээд малгайгаа авахын оронд хөмсөг зангидан духайн доош харан:

- Йоркийн Исаак гэж чи юу? гэж Гуртийг асуухад,

- Тиймээ би байна, чи юун хүн бэ? гэж хариуллаа.

- Энэ бол чамд хамаатай хэрг биш гэж Гурт хэллээ.

- Чамд миний нэр хэрэгтэйн хирээр л мэдэх учиртай. Чиний хэн болохыг мэдэхгүй байж, би яаж чамтай ярилцах билээ гэвэл,

- Маш хялбархан, мөнгө төлөхдөө би чухам эзэнд нь мөн үү, үгүй юу гэдгийг мэдэх учиртай. Чамд бол хэний гараас авах нь огт хамаагүй болов уу гэж санаж байна гэвэл еврей,

- Өө чи надад мөнгө авч ирсэн юм уу? Тэгвэл огт өөр хэрэг. Ямар хүн өгүүлээ вэ? гэв.

- Өв хөрөнгө үгүй баатар өгүүлсэн. Тэр өнөөдрийн тулалдаанд ялж гарсан. Лейстерт суудаг Кирджат Жайрам чиний бичгээр олж өгсөн хуяг дуулга сэлтийн мөнгө ирүүлжээ. Морь нэгэнт танай саравчинд зогсож байгаа. Одоо тэгэхлээр зэр зэвсгийн төлөө хэдэн зоос төлөх учиртайг би дуулах хэрэгтэй байна гэв.

Исаак сэтгэл хөөрч баярласандаа, - түүнийг сайн залуу гэж би хэлсэн шүү дээ! гэж дуу алдаад, - Аяга дарс чамд хор болохгүйдэг хэмээн Гуртийн энэ насандаа амсаж үзээгүй сайхан ундаан нэгэн аягыг бариад, - Чи тэгээд хэдий хир мөнгө авч ирсэн юм дээ? гэхэд Гурт:

- Би хэдий хир мөнгө авч ирсэн вэ гэж үү? Цөөн юмаа, гэхдээ чамд лав хангалттай хүрэхээр, Исаак чи бодож үзээрэй, хүн чанар гэж бас байх учиртай шүү гэв.

- Яагаад тэр билээ, танай эзэн сайн жадныхаа хүчээр сайхан морьд, үнэт зэр зэвсэг дийлж авсан шүү дээ. Би морь зэр зэвсэг өрөндөө аваад илүү гарах мөнгийг нь эргүүлж өгье гэв.

- Миний эзэн тэр бүх барааг борлуулж орхисон гэж Гуртыг хэлэхэд еврей харамсан:

- Тэр чинь дэмий юм болжээ! Эндхийн христос шашинтны хэн ч гэсэн нэг амиар төдий олон

морь, зэр зэвсэг худалдан авч чадахгүй. Гэвч чиний энэ хавтган дотор лав зуун алтан зоос байгаа билээ гэж Исаак дагуулан хивгэнэн дотор руу нь шагайж өгүүлэв.

- Миний энд чинь сумны зэв байгаа юм гэж Гурт огт түгдрэлгүй худлаа хэлбэл Исаак ашиг хонжоо олох шунал, өгөөмөр сэтгэл гаргах гэнэт төрсөн хүслэн хоёрын хооронд тээнэгэлзэн байж,

- За яах вэ, сайн морь үнэт зэр зэвсгийн оронд зөвхөн наян алтан зоос авна гэвэл надад ганц ч сохор зоосны ашиг үл гарна. Надтай ер салахын тулд чамд төдий хир мөнгө байх уу? гэвэл еврей хэдийгээр өөрийн нь хүлээж байснаас ихээ доогуур үнэ хэлсэн авч,

- Төдий хир зоос дөнгөж данган гарах бий гэв.

- За дахин нэг аяга дарс өөртөө хийчих. Ингэхэд морь ямар ч гэмтэл олоогүй биз? Үгүй мөн ч аюултай ширүүн тулалдаан болов оо? Гэхэд,

- Морь ямар ч гэмтэлгүй эрүүл байгаа, чи өөрөө очиж үзэж болно гэж Гурт хариулав.

Ширээн дээр наян алтан зоос гаргаж тавихад Исаак мөнгийг алгуурхан тоолоод морь, зэр зэвсэгний үнэ авсан тухай гарын үсэг өглөө.

Гурт гарын үсгийг авч малгай дотроо нямбай гэгч хадгалаад:

- Харин сайхан мэдээрэй, гарын үсэг буруу бичсэн байвал сахлыг чинь хуулна шүү гээд гуйлгаж барилгүй гурав дахь аяга дарс өөрөө хийж уугаад салах ёс үйлдэлгүй гарч одов.

Ревекка, мориныхоо хурд, Голиафийн жад шиг, нэхмэлийн ээрүүлтэй хурдаараа дүйх жадныхаа ган батын ачаар энэ баатар алт мөнгө олж чадсанд би баярлаж байна гэж еврей хэлэв.

Охиныхоо хариу үгийг хүлээн эргэтэл харин өрөө эзгүй, Гурттэй үнэ хаялцаж байх зуур Ревекка гараад явчихсан байлаа. Энэ зуур Гурт үүдний харанхуй өрөөнд ороод үүд чухам хаана байгааг эргэлзэн ийш тийш харж байснаа гэнэт мөн зул барьсан цагаан хувцастай бүсгүйг харлаа. Тэр бүсгүй хойноосоо дагаж хажуу өрөөнд ор гэж дохилоо. Гурт эхлээд гэдрэг ухарлаа. Бие бодитой хүчин заналхийлж ирэх тухай бүрт Гурт бодон гахай шиг ширүүн, аймшиггүй байдаг боловч савдаг, буг цагаан хувцастай бүсгүй зэрэг Саксоны сүсэг бишрэлтэй холбогдсон юм бүр дээр аймхай ажээ. Гэвч хувь хиртэй түдгэлзсэний эцэст хий юмны өгсөн дохиог дагав. Дагаж өрөөнд ороод тэр хий юм гэсэн нь дөнгөж сая эцгий нь өрөөнд үзсэн, мөн өдөр эрүүл тулалдааны үед харсан гоо еврей бүсгүй байхыг үзэж баярлан гайхав.

Исаактай ямар шүү байдлаар өр салсныг асуусанд Гурт нэгд нэгэнгүй ярьж өглөө.

- Сайн хүн танаар манай эцэг зөвхөн тоглоом хийсэн байна. Аль нэг морь зэр зэвсэгнээс хавьгүй их өр эзэнд чинь тавьсан юм. Чи сая эцэст хэдэн зоос төлөв? гэж Ревекка сонирхов.

Энэ асуултанд Гурт гайхаж, наян зоос гэлээ.

- Энэ хавтан дотор зуун алтан зоос бий. Эзэндээ очвол зохихыг эргүүлж өгөөд үлдсэний нь өөрөө аваарай, явдаа бушуухан яв талархал хэлж цаг бүү үр, хянуур яваарай хотоор өнгөрөхөд хэтэвч төдийгүй амь насаа амархан алдаж болно шүү гэж алга ташиж зарц дуудаад,

- Рейбин, зочинд зам гэрэлтүүлж , гэрээс гаргаж өгөөд үүд хаалгаа түгж гэв.

Рейбин үг дагаж бамбар аван гэрийн гадаа хаалгыг тайлан Гуртийг чулуу дэвссэн хашаан дотуур дагуулан гол даамангийн хажуу дахь явган хаалгаар гаргав. Дараа нь хаалгаа хааж шоронд ч гэсэн элбэг болохуйц лут түгжээ гинжүүд хангинуулан түгжив.

Гурт харанхуйд бүдэрч замаа тэмтчин олж явахдаа:

- Гэгээн Дунстаны нэр барьж андгайлахад энэ чинь еврей бүсгүй биш зүгээр тэнгэрийн дагина юм байна. Залуу сайн эзнээсээ арван алтан зоос авсан, дээр нь бас Сионы энэ сувднаас хорийг авлаа. Үгүй бас их азтай өдөр надад дайрлаа гээч! Дахиад ганц ийм өдөр дайрвал Гурт чи боол байхаа болино. Төлөөсөө төлөөд аль тайжаас доргүй чөлөөт хүн болно. Тэгэх юм бол ч малчны цоор, шилбүүр хоёроос салж дахин гахай хариулахгүй, сайн илд бамбай хоёр аваад цаашид нүүр царай, нэрээ нуулгүйгээр залуу эзэндээ алба хаах болно гэж байв.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нэгдэх дээрэмчин:

-Зогс? Юү байгаагаа бидэнд ац! үгүй бол

Хармааныг чинь нэгжих болно шүү

Спид: -Эрхмээ бид баларлаа!

Эд чинь хүн бүхнийг айлгаж байдаг

Нөгөө новшууд байна.

Валентин: -Найз нар минь...

Нэгдэх дээрэмчин: -Үгүй эрхмээ бид таны дайснууд

Хоёр дахь дээрэмчин: -Байз үүний хэлэх үгийг дуулъя.

Гурав дахь дээрэмчин: -Тэгэлгүй яах юм. Энэ хүн надад аятай санагдлаа.

Шекспир "Вероны хоёр"

Гуртийн адал явдал үүгээр төгссөнгүй. Суурингийн зах дахь нэг хоёрын зэрэг эдлэнг өнгөрөөд өргөн жалга руу орсон хойноо өөрөө ч мөн тэгнэ байх гэж бодож эхлэв. Хоёр талын налуу эрэг хоёул бут сөөгтэй, энд тэнд навтгархан царсууд зөрөг дээгүүр мөчрөө сарвайжээ. Энэ бүхэн маш шигүү болохоор намрын сарны бүүдгэр туяа огт үл нэвтэрнэ. Алс сууринаас найр наргианы чимээ, чанга хөхрөлдөх, орилолдох, зэрлэг хачин хөгжмийн цуурай сэлт сонсогдоно. Энэ бүх шуугиан Гуртийн сэтгэлийг сүрхий зовоож эхлэв.

"Еврей бүсгүйн зөв байж шүү. Энэ мөнгөтэйгээ гэртээ эсэн мэнд хүрэхэд бүрэн, гэгээн Дунстан тусалж хайрла! Энд чинь жинхэнэ хулгайгаар зогсохгүй тэнүүлчин баатрууд, тэнүүлчин залуучууд, хэрмэл салбадай, илбэчингүүд учиргүй олноор цуглараад бүтэн уут алтан зоостой гахайчин битгий хэл хармаандаа ганц зоостой ямар ч хүн аймаар байлаа. Энэ золигийн буут сөөгийг бушуухан өнгөрөх юмсан. Тэгвэл тэр чөтгөрүүдийг мөрөн дээр мордоод авахаас нь өмнө ядаж харахсан" гэж дотроо бодож явлаа.

Гурт жалганаас ил талбай руу гарах гэж алхаагаа нэмлээ. Гэвч гарч амжсангүй жалган дотор тал талаас нь хоёр хоёроороо дөрвөн хүн дайран ирж гараас нь барьж авлаа.

- За алив авч яваа юмаа аль, бид тусч сайн улс, хүн бүрийг илүү дутуу ачаанаас нь салгаж өгдөг юм гэж тэдний нэг нь дуугарав.

Шууд тулгарсан аюулын өмнө хүртэл томорхох дургүй шударга Гурт үүнд уруугаар,

- Та нарыг адаглаад гурван удаа шилэн дундуур чинь байлгаж чадсансан бол миний юмыг тийм ч амархан хөнгөлөхгүйсэн гэв.

- За үзэмц гэж дээрэмчин хэлээд Наадхыгаа ой руу чирээд яв. Янз нь наад залуу чинь толгойгоо ч цоо цохиулж, хэтэвчээ ч хураалгах дуртай байгаа бололтой гэв.

Гуртийг тунч эрээ цээргүйгээр толгойн налуу эргээр энэ хөндийг ил талаас тусгаарласан өтгөн төгөл рүү чирч одлоо. Догшин замч нарынхаа аяар өөрийн эрхгүй хамгийн шигүү сөөг рүү ороход хүрлээ. Гэнэт тэд сарны гэрэл туссан ойн цоорхой дээр зогсоход мөн эдний

бүлгийн байртай хоёр хүн ирж нийлэв. Тэд ташаандаа багаж илд зүүж хүнд муна барьжээ. Зургуул багажтай байгааг Гурт ажлаа.

- За залуу чи хэдий хир мөнгөтэй яваа вэ? гэж нэг нь асуулаа.

- Миний хувийн гучин алтан зоос байна гэж Гурт уруугаар дуугарахад дээрэмчид:

- Хурааж авъя, хурааж авъя! Саксон хүн өвөртөө гучин алтан зоостой байж сууринаас юм уугаагүй буцаж явна. Энд ярилцаад байх юм ер алга. Хуу цөлмөөд авчихъя. Заавал авах хэрэгтэй гэж хашгиралдав.

- Би энэ мөнгийг чөлөөтэй болох төлөөсөндөө өгөхөөр хуримтлуулж байсан юм гэж Гуртийг хэлэхэд дээрэмчдийн нэг нь:

- За чиний тэнэг чинь мэдэгдэж байна. Нэг ваар сайн эль дарс уучихсан бол эзнээсээ, магадгүй тэр чинь чам шиг согтсон хүн бол түүнээсээ ч илүү чөлөөтэй болчих байсан хэрэг гэв.

- Энэ чинь гашуун үнэн билээ. Харин энэ гучин алтан зоосоор би та бүхнээс амиа аварч болох бол миний гарыг тавь, би одоохон та нарт тоолоод өгье гэж Гуртийг хариулахад, хартал дарга байртай нэг нь:

- Байз! Чиний энд бас уут байна, чиний цуван дор гарт тэмтрэгдсэн, үүнд хэлж байгаагаас чинь илүү мөнгө байх шиг санагдаад байна гэв.

- Тэр чинь миний эзэн баатрын мөнгө, та бүхэн миний өөрт оногдохыг аваад болсон бол би энэ мөнгөний тухай үг цухуйлгахгүйсэн гэвэл,

- Хараач, яасан сүрхий үнэнч зарц вэ? Энэ чинь сайн байна. Гэвч бид чиний гучин зоосонд шунахайрхаар чөтгөрт биширчихсэн улсууд арай биш. Ганцхан бүх үнэнээ бидэнд сайхан ярь. Харин одоогоор хүүдийгээ нааш нь өгчих гэв. Ингэж хэлээд Гуртийн өврөөс үлдсэн зоосны нь хамт Ревеккагийн өгсөн хавтагатай арьсан хүүдийг суга татан аваад байцаалт үргэлжлэв.

- Чиний эзэн хэн бэ? гэхэд,

- Өв хөрөнгө үгүй баатар гэж Гурт хариуллаа.

Өнгөрсөн эрүүл тулалдаан дээр жадныхаа сайнаар дийлж шагнал хүртсэн хүн үү? гэж дээрэмчин асуугаад, - Үгүй ингэхэд нэр нь хэн гэдэг юм, ямар удам судрын хүн бэ? гэвэл Гурт өөдөөс нь:

- Тэр өөрөө үүнийгээ нуух таалалтай юм. Гэтэл би нууцыг нь задруулж байж таарах уу даа? Гэв.

- Чиний нэр хэн бэ? гэхэд

- Би өөрийнхөө нэрийг та нарт хэлж орхивол эзний минь нэрийг мөн гадарлачих байхаа гэвэл

дээрэмчин:

- Ингэхэд чи чинь сүрхий танхай этгээд байх нээ? За эн тухай дараа ярья. Харин эзэн чинь яаж ийм их мөнгөтэй болсон юм? Өв хөрөнгө залгамжилж авсан юм уу? Өөрөө олсон хэрэг үү? гэхэд Гурт:

- Жадныхаа сайнаар олсон юм. Энэ уутан дотор дөрвөн сайн морь, дөрвөн баатрын өвч зэр зэвсэгний төлөөс мөнгө байгаа юм гэлээ.

- Энд нийт хэдэн зоос байгаа юм гэж асуухад:

- Хоёр зуун алтан зоос гэв.

- Дөнгөж хоёр зуу юу? Танай эзэн дийлдсэн улсуудад өгөөмөр хандаж тун бага төлөөс авчээ. Чухам хэнээс энэ мөнгө авсныг нэрээр нь тоол гэвэл Гурт баатруудын нэрийг тоочив.

- Сүмийн хорооны баатар Бриан де Буагильберийн зэр зэвсэг, морь яасан бэ? Үүний төлөөсөнд хичнээн зоос тогтоосон? Намайг хуурч болохгүйг чи мэдэж байгаа биз? гэв.

Миний эзэн сүмийн хорооны баатраас юу ч авахгүй гэсэн гэвэл, - Зөвхөн цусыг нь гаргахыг хүсчээ. Тэд хоорондоо ясны өштөн тул энгийн харилцаа тэдний дунд байж таарахгүй гэнэ гэлээ.

Дээрэмчин түр бодол болсноо --Чи өдий их мөнгө хадгалж байгаад сая Ашбийд юу хийж очсон юм бэ? гэхэд:

- Би Йоркоос ирсэн еврей Исаакад энэ тулалдаанд эзний эдлэх зэр зэвсэг олж өгсний мөнгийг төлөх гэж очсон юм гэж Гурт өчив.

- Энэ уутны хүндээр бодоход чи Исаакад хэдэн зоос төлсөн бэ? гэхэд

- Исаакад би наян зоос төлсөн, тэр эргүүлээд надад зууг өгсөн гэж Гурт хэлэв. Дээрэмчид нэгэн зэргээр, юу? Яалаа гэнээ? гэж дуу алдан, - Чи ийм байж болохгүй дэмий юм ярьж бид нараар тоглоом тохуу хийх гэж арай санаагүй биз хөө? гэхэд Гурт:

- Миний хэлсэн бүхэн тэнгэрт сар гийж байгаатай адил ариун үнэн зүйл. Өөрсдөө таагаад үзэж болно. Энэ уутан дотор бусад зоосноос тусдаа яг зуун алтан зоос энэ хавтган дотор байж байгаа гэв.

- Алив даруйхан гэрэл гаргаад орхи гэж ахлах дээрэмчин тушаагаад - үүний уутан дотор юу байгаа үзье. Хэрэв энэ залуу үнэн хэлсэн бол еврейгийн өгөөмөр зан гаргасан нь түүний эцэг өвгөд цөл газар чулуунаас шахаж гаргасан устай адил ид шидийн зүйл байна гэв.

Эгшин зуур гэрэл гаргаад дээрэмчин уутыг үзэж эхлэхэд бусад нь тойрч, Гуртийг барьж байсан хоёр хүртэл бусдыгаа дуурайн олзлогдсон хүнийг хайхрахаа болилоо. Гурт тэдний хайш хэргийг ашиглаж нэг сайн сэгсрэн мулт үсрээд, эзнийхээ мөнгийг хаячихаад зугтааж амжих байв. Гэвч огт тэгэхээргүй хүн ажээ. Дээрэмчдийн нэгний нь шийдмийг шүүрч аваад

толгойлогчийг нь ийм дайралт ирнэ гэж огт санаагүй байх тэр үед толгой руу нь буулгав. Гурт уутаа шүүрээд авах байсан боловч дээрэмжингүүд даруй сэхээ авч уут, үнэнч дагуул хоёрыг дахин эрхэндээ оруулав.

Толгойлогч босож ирээд, - Үгүй, муу хар зальхай амьтан! Толгойгий минь хага цохиж орхилоо шүү! Бидний адил иймэрхүү ажил эрхэлдэг өөр хүмүүсийн гарт орсон бол ингэж тэсгэлгүй аашилсандаа их муу юм үзэх байсан! Харин чи одоо юу болохыг үзнэ дээ. Эхлээд танай эзний тухай ярилцъя. Баатар хүн эр баатруудын гурим дүрмийн дагуу дагуулынхаа түрүүнд орох учиртай. Томоотой зогс! Дахиад хөдлөх л юм болж гэм бид үүрд тайвшруулаад өгнө шүү гээд бүлгийнхэн рүүгээ эргэн,

- Найз нар минь хавтганд еврей үсэг хатгамалсан байна. Энэ Йомен үнэнийг өгүүлжээ гэж би бодно. Үүний эзэн, тэнүүчлэгч баатар бидний гараар алба түрээсгүй өнгөрөх учиртай, түүний мөнгөөр бид ашиг завшаан хийхээргүй бидэнтэй тун адилхан хүн. Үнэг, чоно элбэгтэй газар ноход хүртэл өөр хоорондоо уралцдаггүй шүү дээ гэв.

Дээрэмчдийн нэг тэр чинь юугаараа бидэнтэй адил юм бэ? Үүнийг яаж үнэмшүүлж болохыг би дуулахсан гэвэл, толгойлогч хариуд нь:

- Чи тэнэг хүн юмаа? Энэ баатар бидний нэгэн адил хувь муутай ядуу хүн биш гэж үү? Амин тэжээлээ хурц илдний нэрээр олж байгаа юм биш үү? Бидний дарахыг яг хүссэн дагуу фрон де Беф, Мальвуазен хоёрыг цохиод өгсөн биш гэж үү? Бид олон шалтгаанаар эмээж байгаа Бриан де Буагильбертэй яс махны өшөө зарласан хүн тэр биш үү? Бузар еврейд хүртэл бий болсон хүнч сэтгэл бидэнд байхгүй гэж үү? Гэхэд нэг дээрэмчин:

- Үгүй, тэгвэл бидэнд үнэхээр хэтэрхий ичгүүртэй хэрэг байхсан. Гэхдээ булиа хөгшин Ганделипын бүлэгт байхад бид иймэрхүү нарийн юм ер тооцож үздэггүй байсан. Харин энэ давилуун эрийг яах ва? Ингээд л гэм хоргүй тавиад явуулчих гэж үү? гэвэл толгойлогч хариуд нь:

- Алив чи өөрөө наадхыгаа сургаад өг л дөө гээд Гуртэд хандан --чи дуулж бай! Чи шийдэм ийм дуртай шүүрч авч байгааг үзэхэд хэрэглэж чаддаг байх нээ? гэж асуухад:

- Тэр тухай чи л сайн мэдүүштэй гэж Гурт өчихөд толгойлогч:

- Тиймээ, үнэнийг хэлэхэд чи намайг айхтар чанга цохисон шүү. Энэ залууг мөн тэгж дэлсэхийг хичээ, тэгвэл дөрвөн зүгийн аль дуртай тийшээ явж болно. Харин дийлэхгүй бол байна шүү... За яая гэх вэ, чи тун сайн хүн байна, би өөрөө орноос чинь төлөөс төлж болох юм. За дээрэмчин шийдмээ барь, толгойгоо сайн хамгаалаарай, та нар олзлогдогчийг тавиад мөн тийм шийдэм өг. Энэ одоогоор энэ хоёр нэг нэгнийгээ сайхан балбаад өгч элбэг болохоор гэрэлтэй байна гэв.

Адил шийдмээр зэвсэглэсэн тулалдах хоёр цоорхойгоор туссан гэрэлтэй талбайн төв дунд гарч, дээрэмчингүүд тойрон зогсов.

Дээрэмчин шийдмийнхээ тэхий дундаас атган толгой дээгүүрээ эргүүлж Гуртийг сайрхуу

байртай халз тулалдахыг урин:

- За тулалдах эр минь гараад ир! ойртоод ирж зүрхлээрэй гайгүй, миний гарт үртэх ямар байдгийг үзүүлээд өгнө би гэв. Гурт шийдмээ мөн төдий чинээ чадмаг эргүүлэн:

- Чи үнэхээр тээрэмчин мөн юм бол давхар луйвар хийдэг этгээд юм байна. Би шударга хүний хувьд чамайг тулалдаанд дуудлаа гэж хариулав.

Ингээд эсрэг хоёр ойртож хэдэн минутийн туршид ижилхэн хүч зоригтойгоор нэг нэгийгээ цохиж, хааж байв. Үүнийг тун чадмаг хурдан хийх тул ойн цоорхойгоор нэг тачигнаан болж холоос тэнд дор хаяад зургаан хүн тулалдаж байгаа мэт санагдахаар Үүнээс шургуу бус, аюул цөөнгүй билээ. Тэднийг зоригжуулах яруу найрагч үгүй байсны улмаас дээрэмчний Гурттэй тулалдсан нь дуулагдалгүй өнгөрөх юм. Хэдийгээр шийдмээр тулалдах заншил орхигдсон боловч бид уран шүлгээр биш юмаа гэхэд энгийн үгээр эдгээр зоригт дайчдыг зүй ёсоор магтахыг оролдоё.

Удтал тэд ана мана үзэлцлээ. Эцэстээ ийм шаргуу эсэргүүцэлтэй тулгарч нөхдийнхөө инээлдэхийг сонсоод дээрэмчин хор нь хөдөлж эхлэв. Илүү самбаатай нь дийлдэг. Энэ сайхан цэнгээний үед сэтгэл тийнхүү бачуудах тун таарамж муутай тул уул байдал Гуртэд давуу тал олгосон бөгөөд Гурт ч өштөнийхөө алдааг ховор чадмагаар ашиглав.

Тээрэмчин улайран дайрч шийдэмнийхээ хоёр үзүүрээр балбан улам ойртохыг хичээнэ. Гурт зөвхөн гараа сунган шийдмээ эргүүлж хамгаална. Ийм хамгаалах байдалд дайчнаа амьсгаадаж ирэхийг мэдэгдтэл барьж байгаад гэнэт шийдмээ далайв. Дээрэмчин энэ цохилтыг завдан байтал Гурт шийдмээ баруун гараараа хурдан гэгч шүүрч аваад байдаг хүчээрээ толгой дундуур нь буулгав. Дээрэмчин өвсөн дээр дороо тэрийж уналаа.

Дээрэмчингүүд үүнд, - Сайн эр, шударгаар дийллээ. Сайхан цэнгэл, өвгөн Англи орон урт удаан орштугай. Саксон эр мөнгө, биеэ бүрэн бүтэн авч одох боллоо. Дээрэмчний чадал дутлаадаа гэж хашгиралдав. Толгойлогч Гуртэд хандан –За найз минь мөрөөрөө явж болно. Хоёр нөхрөөрөө чамайг хүргүүлье. Тэд чамайг хамгийн дөт замаар эзний чинь майханд хүргэж, бидэн шиг нинжин сэтгэл үгүй шөнийн тэнүүлчдээс хамгаалж өгнө. Өнөө шөнө тэд үүгээр их тэнэж байна. Харин болгоомжлоорой. Чи бидэнд нэрээ хэлээгүй шүү дээ. Тэгэхлээр бидний нэрийг ч бүү асуу, мөн хаанахын юун улс болохыг мэдэх гэж бүү оролд. Хэрэв оролдох юм бол өөртөө гомдоорой, өнөөдөр учирснаас их дор юм үзэх байх шүү гэлээ.

Гурт толгойлогчийн эелдэгт тал өгч, зөвлөлгөөн дагахаа амлав. Хоёр дээрэмчин шийдмээ авч Гуртыг балар зөргөөр төгөл дайран доош жалга руу дагуулан зөргөөр төгөл дайран доош жалга руу дагуулан явав. Цоорхой дээрээс тэдний өөдөөс хоёр хүн гарч ирээд замч хоёртой хэдэн үг солин дахин ойн гүн рүү далд оров. Үүнээс уул дээрэмчдийн бүлэг том үүрээ сайн чанд харан хамгаадгийг Гурт мэдлээ.

Дээрэмчид түүнийг жижиг толгой дээр шууд дагуулж гаргаагүй бол жанжуу гүйлс ургасан ил талд гарч ирсэн хойноо чухам хаашаа явахаа Гурт мэдэхгүй байхсан ажээ. Толгойн орой дээрээс тулалдааны талбайг хүрээлсэн хашаа, хоёр талд нь шаасан майхнууд тэдний дээр намирах далбаа сэлт харагдаж байлаа. Шөнийн манаанд зогсож байгаа харуулуудын аялах дуу

хүртэл Гуртэд дуулдаж байв. Дээрэмчид зогслоо. Тэдний нэг нь:

- Бид наашаа явахгүй, тэгвэл горьгүйдэнэ. Юу гэж чамд хэлснийг санаж, өнөөдөр чамд юу тохиолдсон тухай амаа хавчаарай тэгвэл бүх хэрэг сайн болно шүү. Хэрэв бидний зөвлөлгөөнийг мартчихвал Тауэрт очиж нуугдлаа ч гэсэн өшөө авахуулахаас мултарч чадахгүй шүү гэв.

- Өршөөлт эрхмүүдээ сайхан нойрсоорой, би та бүхний тушаалыг мартажгүй, харин та бүхнийг арай аюул багатай цагаан ажил төрөл эрхлээсэй гэж хүсвэл доромжилсонд үзэхгүй биз дээ гэж найдана гэж Гурт хэлэв. Ингээд тэд салав. Дээрэмчид гэдрэг буцаж Гурт эзнийхээ майхан чиглэж, дөнгөж сая сонссон сэрэмжлэлийг үл хайхран бүх адал явдлаа даруй ярихыг яаравчилна.

Ревеккагийн өгөөмөр аашилсанд өв хөрөнгө үгүй баатар дээрэмчдийн хүн мөс гаргаснаас багагүй гайхав. Гэвч даруй хэвтэж унтахаар завдаж байгаа тул энэ хачин явдлуудын тухай удаанаар бодсон ч үгүй. Маргаашийн эрүүл тулалдаанд хүч сэлбэхийн тулд сайн амарч авах нь чухал байлаа. Тэгээд баатар майханд нь бэлтгэсэн тансаг сайхан дэвсгэр дээр хэвтэж, үнэнч Гурт хэн ч өөрийг нь сэрээлгүйгээр үл орог гэж бүр үүдэнд хивсний оронд дэвссэн баавгайн арьсан дээр хэвглээ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Талбайгаас зайлсан зарц нар

Тулаанд дуудан бүрээгээ татна.

Баруун зүгээс дайчин эрс

Барьсан жадаа зэхэн давшихад бэлтгэнэ

Давируулын хурц үзүүрээр морьдыг шавдуулна

Дайрч оруут эр зоригоор үзэлцэнэ.

Баатруудын цээжнээ ирт мэс хүрэв.

Бамбайн зузаанд жадны үзүүр шантарна.

Хугарсан мэс ойн, далайсан илд гялалзан

Хуяг дуулга сийчигдэн, улаан цус олгойдно.

Чосер "Кентерберийн үгүүллэгүүд"

Бүртийх үүлгүй тунгалаг сайхан өглөө болов. Нар дөнгөж мандахад наадамчин олон тал талаас номин талаар тулалдааны талбар руу эртхэн таатай суудал эзлэхээр цуврав. Тэдний дараа маршалууд зарц нарынхаа хамт ирлээ. Нийтийн тулалдаанд оролцох хүмүүсийн нэрсийг жагсаах учиртай, баатар бүр хэний талд орохоо хэлж өгөх ёстой байлаа. Энэхүү сэрэмжилсэн арга нь тулалдах хүмүүсийг тэнцүү хувааж аль аль талыг нь тооны хувьд давуу байлгахгүй гэсэн хэрэг ажээ.

Өв хөрөнгө үгүй баатрыг нэгдүгээр багийн тэргүүн, урьд өдрийн тулалдаанд түүний дараа орсон дайчин Бриан де Буагильберийг хоёрдугаар багийн тэргүүн болгожээ. Эдний талд өчигдрийн унаснаасаа сайн тэнхрээгүй байгаа Ральфа де Випонтоос бусад бүх сэдэгч нар орсон нь мэдээж.

Нийтийн тулалдаан халз тулалдаанаас аюулаар их хэдий боловч баатрууд үүнд дуртай байдаг ажээ. Сэдэгч нэрт баатруудын хэн нэгтэй халз үзэлцэж зүрхлээгүй олон баатрууд хир тэнцүү дайсан сонгон олж болох нийтийн тулалдаанд дуртайяа оролцдог билээ. Энэ удаа мөн ялгаагүй баг бүрт нь тавин баатар бүртгэж аваад цаашаа хэнийг ч оролцуулж чадахгүй гэж маршалууд дуулгахад хожигдсон нь ихэд унтууцав.

Арван цаг гэхэд талаар дүүрэн хүмүүс явган морьтой тулалдааны газар руу яаран цувж байв. Төдөлгүй бүрээ хангинаж хаан хүү Жон бараа бологсодтойгоо ирснийг мэдэгдэв.

Энэ үеэр Саксоны Седрик, Ровена авхайн хамт ирлээ. Ательстан байлцсангүй, хуяг дуулга өмсөж дайчдын жагсаалд орно гэжээ. Тэгээд Бриан де Буагильберийн багт бичүүлсэнд

Саксоны Седрик багагүй гайхав.

Нөхрийнхөө зохисгүй тал сонгож авсны эсрэг Седрик эрс дургүйцсэн авч Ательстаны хариулт угийн зөрүүдийнг дээр үйлдсэнээ зөвтгөж үл чаддагий нь харуулав.

Сүмийн хорооны баатрын талд нийлэх тусгай шалтгаан түүнд байсан авч тэр тухайгаа дуулгахаас болгоомжилжээ. Угийн ноозгой зангасаа болон Ровена авхайд гойд сайнаа юугаар нь эс үзүүлэх авч гоо сайханд нь сэтгэл их татагдан явдаг ажээ. Гоо бүсгүйн бусад хамаатан садан болоод Седрик нэгэнт зөвшөөрөх болохоор Ровенатай суухыгаа нэгэнт шийдсэн хэрэгт тооцдог байжээ. Иймд Конинсбургийн бардам ихэмсэг эзэн өчигдөр өдрийн баатар дийлсэн эрхийнхээ дагуу Ровенаг баяр цэнгэлийн хатан хаанд өргөмжлөхийг дотроо тааламжгүй харж байв. Төдий зоримгоор Ровенад халдсаны төлөө баатрыг залхаахаар шийджээ. Өөрийнхөө дийлдэшгүй хүчин чадалд итгэж өв хөрөнгө үгүй баатарт хүчин туслах байтугай учрал тохиолдоход байлдааныхаа бэлтгэл хамаг хүчээр түүнийг сүйдлэхээр зэхжээ.

Сэдэгчийн багийг ялуулахсан гэж хүсэж байгаа тухайгаа хаан Жон үг цухуйлгасан болохоор де Браси болоод бусад хаан хүүд ойр дотно баатрууд өөрийн нь багт бичүүлэв. Нөгөө талаас олон алдарт сайн баатрууд гарамгай дайчин болохоо үзүүлсэн өв хөрөнгө үгүй баатрын удирдлагын дор тулалдахыг хүсэн эсрэг талын багт бичүүлэв.

Эрүүл тулалдааны сонгогдсон хатан хаан талбар руу хүрч ирэхийг хаан хүү Жон хармагцаа хамгийн эелдэг дүрээр угтан давхиж очоод мориноос түшиж буулган хүний дээр бүх бараа бологсод нь малгайгаа авч том том хэргэмтний морины жолоо барин зогсоно.

Ингэхээр хайр сэтгэл, гоо сайхан хатан хааныг албат ёсоор даган хүндлэхийн үлгэрийг бид түрүүлэн үзүүлж өөрсдөө хаан суудалд залж байгааг харж буй бизээ гэж хаан хүү Жон хэлээд тавцан өөд эргэн, сайн төрөлт хатагтаөй нараа та бүхэн мөн ийм хүндлэл хүлээе гэх аваас энэ найз бүсгүйдээ шадарлагтун гэв.

Ингэж хэлээд хаан хүү Ровена авхайг хатан хааны суудал өөд залан авч очиход тэнд байсан бүсгүйчүүлийн хамгийн гоо сайхан язгуур өндөө нь түр хугацааны эзэн хатныхаа дэргэд аль болох ойр суудал эзлэхээр араас нь яарав.

Ровена авхайг суудлаа эзэлмэгц ёслолын хөгжим эгшиглэн, хурсан олны баяр хүргэн хашгирах дуунд дарагдаж байв. Баатруудын гялалзсан зэр зэвсэг, хуяг дуулга нь хурцаар гялалзаж дайчид талбайн, хоёр захаар өөгнөрөн хүчээ хэрхэн хуваарилах тухай чухалчлан хэлэлцэнэ. Зарц нар эрүүл тулалдааны гуримыг унших зуур чимээгүй байхыг хүсэв. Баатруудын ирлэсэн илд, үзүүрлэсэн жадаар тулалдах ёстой тэмцээний аюулыг аль болохоор багасгахын тулд эдгээр гуримыг тогтоожээ.

Дайчид илдээр хатгаж болохгүй зөвхөн цавчина. Балт муна хэрэглэхийг зөвшөөрөвч чинжаалыг хориглоно. Мориноос унасан хүн зөвхөн дайсантай явган тулж болно. Морьтонгууд явган хүн рүү дайрахыг хориглоно. Аль нэг баатар өштөнөө талбайн нөгөө зах руу хавчиж шахаж чадаад өөрөө юмуу зэвсэг нь хашаанд хшрэх юм бол өштөн нь дийлдсэнээ хүлээж морь зэр зэвсгээ дийлэгчдэд өгөх учиртай. Эмээлээс ховх цохиулсан бол өөрөө босож хүч хүрэхгүй болбол хиа дагуулууд нь талбай руу очиж эзнээ олны хөлөөс зайлуулах эрхтэй.

Тэгвэл уул баатар дийлдсэнд тооцогдож морь зэр зэвсгээ мөн алдана. Хаан хүү Жон очир юмуу таягаа талбай дээр хаямагц тулалдаан даруй зогсох ёстой. Энэ нь тэмцээн хэт цус асгаруулсан болох юмуу удаан үргэлжлэвэл сэрэмжлэх арга ажээ. Эрүүл тулалдааны гурим зөрчих юмуу эр баатруудын ёсноос аль нэг замаар гажсан дайчин бүрийг зэр зэвсгийг нь хурааж хашаан дээр мордуулж олны шившиг болгох ажээ.

Эдгээр гуримыг чанга дуугаар дуудаад зарц нар байрандаа очиж зогсов. Талбайн хоёр өнцгөөс баатрууд урт цуваагаар хөдлөн өөд өөдөөсөө эсрэгцэн хоёр хоёр эгнээ жагсав. Баг бүрийн тэргүүлэгч түрүүн эгнээний дунд байраа эзэлнэ.

Агсам хөлгүүд унаж үнэт зэр зэвсэг агсан аймшигтай тулалдаанд дайран орохоор зэхсэн эдгээр баатруудыг харахад аймаар атлаа үзэсгэлэн жавхаа төгс ажээ. Тэд төмөр хөтөл адил дайны эмээл дээрээ овойлцон хангитал янцгааж, хөлөө дэвслэн тогтож ядах хөлөгдийнхөө адил тулалдах дохиог байж ядан хүлээх ажээ.

Баатрууд урт удаа өргөхөд хурц зэвсгүүд нарнаа гялалзан хуар цацаг дуулгууд дээр манжлага мэт намирна. Маршалууд хоёр багийн тоо адил эсэхийг үзэхээр эгнээнүүдийг шалгах зуур баатрууд ийнхүү зогсож байлаа. Тоо үнэн зөв ажээ. Маршалууд талбайгаас гарч Уильям де Вивиль чанга дуугаар:

- Дайрцгаа! гэж хашгирав.

Бүрээ хангинаж тулгуурт углаастай жадууд зэрэг бөхөсхийн давируул морьдын хавирга руу шигдэн хоёр багийн тэргүүн эгнээ зэрэг өөд өөдөөсөө довтлон бүтэн бээрийн газарт дуулдам их чимээтэйгээр талбайн төвд мөргөлдөв.

Үүний дараа өөрсдийнхнийгөө дэмжихээр арын эгнээ хөдөллөө.

Өтгөн тоос боссон болохоор тулалдааны дүнгийн тухай даруйдаа хэлэх юмгүй байв. Зөвхөн минутын дараа догдолсон наадамчид тулалдааны талбарт юу болж байгааг харах боломжтой боллоо. Хоёр багийн баатруудын тэн хагаст эмээлээсээ ховх цохиулсан ажээ. Зарим нь жадны хатгалтанд унаж, нөгөө нь эсрэг талынхаа тэнцүүргүй их хүчинд дарагдан босож чадахгүй талбай дээр хэвтэх бөгөөд зарим нэг нь босон харайж амжаад мөн тийм гай дайрсан эсрэг талынхантайгаа гардан тулалдаж байгаа үзэгдэв. Хүнд шарх олсон гурав дахь хэсэг нь асгарах цусаа ороомжоор даран олны хөлөөс зайлахыг оролдоно.

Үлдсэн морьтонгууд хатуу тулалдаанд жадаа хугалж мухардаад дахин эгнэж илдээ сугалан дайчин уухай хашгирсаар харилцан дайрч улайран цавчилдах нь энэ тулалдааны үр дүнгээс тэдний нэр төр амь нас хамаарах мэт ажээ.

Нөхдөө дэмжиж туслахаар ухасхийсэн ар эгнээ тулалдаж буй газарт хүрэлцэн ирмэгч хөл үймээн улам ширүүсэв. Бриан де Буагильберийн талынхан "Боссеан, боссеан! Сүмийн төлөө! Сүмийн төлөө!" гэж хашгиралдахад дайснууд нь тэргүүлэгчийнхээ бамбайн дээр бичээстэй дуудлагыг авч дайчин уухай болгон "дездичадо! дездичадо!" гэж хариу хашгиралдав. Тулалдааны дуу алдах бүрээн дуутай нийлэн сүрдэм айхавтар чимээ болж талбай дээр арчаагүй тэрийн хэвтэх шархдагсдын ёолох чимээг дарна. Баатруудын илбэнхэн өнгөт хуяг

дуулга илд балтын цавчилт бүрт ан цав гаран хэлтийж, тоос цусанд будагдлаа. Дуулганаас тав цавчигдсан гоё сайхан өөдөс цасан ширхэг адил унана. Баатар цэргүүдийн сүр жавхаа оргүй арилан айх өрөвдөх сэтгэл төрүүлэхээс цаашгүй боллоо.

Гэвч сурсан заншил хүчтэй тул тавцанг дүүргэсэн язгууртан бүсгүйчүүл хүртэл энэ алалдааныг түгшин сонирхож нүд салгалгүй ширтэнэ. Хэн нэгний нь сэтгэлтэй хүн, ах, эр нөхөр мориноосоо гэнэт унахад гоо сайхан царай нь зэвхийрч, хэлмэгдэн дуу алдах сонсогдоно. Гэхдээ ихэнх бүсгүйчүүл дайчдыг алга ташиж алчуур ороолтоор даллан "Лут жад ирт илд!" гэж чадамгай цавчилт харах бүр дуу алдан зоригжуулах ажээ.

Цуст цэнгээнийг бүсгүйчүүл хүртэл ийнхүү шохоорхон сонирхож байсан болохоор эрэгтэйчүүд хир их шунан ажиглаж байсныг төсөөлөхөд хялбар билээ. Тулалдааны шинэ эргэлт бүрийд чангаар хашгиралдан сэтгэл догдолж талбай дээр болж байгаа зүйлээс нүд үл салгана. Үзэгч олныг харахад тэд өөрсдөө баруун зүүнгүй цавчиж цавчуулж байх мэт.

- Зоригт баатруудаа тулалд! Хүн үхдэг, харин алдар нэр мөнх! Тулалдцагаа! Үхэл ялагдлаас дээр! Эрэлхэг баатруудаа үзэлцэцээ, гоо сайхан мэлмий та бүхний гавьяат үйлсийг тольдож байна! гэж түр намас хийх үед зарц нар чангаар дуудах сонсогдоно.

Үзэгч нэг бүр тулалдааны хамаг гол нөхдөө биеийн үлгэр, уриа уухайгаараа зоригжуулан тулалдаж буй тэргүүлэгч хоёрыг олж харахыг мэрийнэ. Хоёул алдар гавьяа байгуулж, хоёул бусад баатруудын дунд эн тэнцэх хүн олохгүй явна. Харилцан өширхөх сэтгэлд түлхэгдэн тэргүүлэгчдийн хэн нэг унах гэдэг шийдвэртэй яллаа гэсэн үг, тэднийг сайн ойлгон хоёул учрах гэж цаг ямагт хичээсээр байв. Гэвч тулалдааны эсэн үеийн үймээн эмх замбараагүй байсан тул тэдний мэрийлт тун ч үр дүн олохгүй тулалдаанд оролцогч бусад хүмүүс багийн удирдагчтай хүч үзэлцэхийг хичээн байнга тэмүүлцгээнэ.

Гэвч тулалдагсдын эгнээ бага багаар шингэрэн зарим нь ялагдсанаа хүлээж бусдын эсрэг талын хашаанд шахаж дийлэн, гурав дахь хэсэг нь шархдаад хөсөр хэвтэнэ. Тэгээд сүмийн хорооны дайчин, хөрөнгө үгүй баатар хоёр нүүр нүүрээр тулгарав.

Өрсөлдөгч хоёр цусан өсөт хүмүүсийн хар хилэнтэйгээр тулалдав. Тэдний цавчих, хаах эрдэм сургууль өгүүлшгүй гайхам тул үзэгч олон өөрийн эрхгүй нэгэн зэрэг бахдан гайхаж хашгиралдана.

Яг энэ үеэр өв хөрөнгө үгүй баатрын баг тун хүнд байдалд орлоо. Эдний талынхныг нэг жигүүрээс Реджинальд фрон де Бецийн лут гар хяргаж нөгөө жигүүрт хүчирхэг Ательстан замдаа дайралдсан бүхнийг өнхрүүлэн саринааж явав. Тэгсээр энэ хоёр баатар бүх дайснаа дийлээд сүмийн хорооны дайчинд туслахыг яаран морьдоо зэрэг эргүүлж өв хөрөнгө үгүй баатар руу дайрав.

- Өв хөрөнгө үгүй баатар гуай болгоомжлоорой! сэргийлээрэй! гэж үзэгчид тал талаас хашгирсанд баатар шинэ дайснуудаа ашгүй харжээ.

Буагильберийг бүх хүчээрээ нэг цохиод морио зогсоон эргүүлж Ательстан Реджинальд Фрон де Беф хоёрын дайралтнаас бултсанд мориныхоо амыг татаж чадалгүй хоёул мөргөлдөх

дөхөөд өштөн хоёрын дундуур давхин өнгөрөв. Гэвч эндэгдлээ даруй засаж Бриан де Буагильбеортэй гурвуул өв хөрөнгө үгүй баатар руу дайрлаа.

Өмнө нь шагналд авсан аргамаг хөлгийн гайхам хүч чадал, хурдан хөл үгүйсэн бол өв хөрөнгө үшүй баатрыг юу ч аварч чадахгүй ажээ. Буагильберийн морь шарх олсон, Ательстан, Реджинальд Фрон де Беф хоёрын морь хүнд хуяг дуулга өмссөн лут биет эздийнхээ жинд цуцаж байсан болохоор морины сайн маш чухал байлаа. Өв хөрөнгө үгүй баатар морио гойд чадмаг залж үүлдэр сайнт амьтан тун түргэн, ам зөөлөнтэй тул хэсэг зууртаа гурвын гурван дайсантай бултан үзэлцэж байлаа. Дайснаас шонхор адил түргэн бултан аль нэг рүү нь дайрч илдээр цавчсанд даруй холдож байлаа.

Үзэгчид баатрын эрдэм чадалд бишрэн алга нижигнүүлнэ. Гэвч гурвын гурван дайчны түрэлтийн дор баатар эцэстээ дийлдэж таарах нь илт байв. Тэгэхэд хаан хүү Жоныг тойрч байсан бүх язгууртнууд, очироо талбай дээр хаяж зоригт баатрын тоогоор давуу дайснуудад муугаар ялагдахаас аварч үз гэж сэтгэл нэгтэй гуйж эхлэв.

- Хаан хүү Жон үүнд, Үгүй, тэнгэрийг барьж андгайлъя. Нэр усаа нууж, бидний дайллагыг үл ойшоосон энэ эр нэгэнт шан авсан, одоо өөр хүн ялж аваг гэж хариулав.

Энэ үгийг дөнгөж хэлж дуустал санамсаргүй учрал эрүүл тулалдааны хувь заяаг шийдвэрлэв.

Дездичадогийн талынхан дотор өөртэй нь тэнцэм хүчирхэг чадалтай бололтой хөө хар морь унасан, хар өнгийн хуяг дуулгатай нэг баатар байлаа. Энэ баатрын бамбайн дээр ямар ч дуудлага байхгүй, одоо хүртэл учирсан ганц нэг хүний довтолгоог няцаагаад тулалдаанд бараг оролцохгүй байв. Энэ байдал үзэгч олноос түүнийг залхуу хар гэж хочлох шалтаг болжээ. Одоо тэр баатар гэнэт сэргэх аятай боллоо. Өөрий нь багийн тэргүүлэгчийг сүрий тэвдүүлж байгааг үзээд мориныхоо хажуу руу давируулаа шигтгэн нөхөртөө туслахаар цахилгаан мэт хуйларч ирээд:

- Дездичадо! тусльа гэж цээлхэн дуунаар уухайлав.

Үнэхээр ч туслах цаг мөн байлаа. Өв хөрөнгө үгүй баатар сүмийн хорооны дайчинтай тулж байх зуур Фрон де Беф түүн рүү илд далайв. Гэвч Фрон де Бефийг цавчиж амжихаас урьд хар баатар өөрий нь толгой дундуур буулгалаа. Илд гөлгөр дуулганаас хальтарч морины хуяган дээр маш хүчтэй буухад Фрон де Беф морьтойгоо хөсөр өнхрөв. Тэгээд залхуу хар Конингсбургийн Ательстан руу эргэв. Хугарсан сэлмээ хаяж орхиод гөжүүн болхи Саксоны баатрын гараас хүнд балтыг нь суга татан авч дуулганы нь орой руу Ательстаныг ухаан алдан хөсөр тэрийтэл буулгав.

Хар баатар дахиад бүхнийг үл анзааран тайвшрах мэт болж, тэргүүлэгчээ өөрөө Бриан де Буагильберийг аргалаг гэж орхин талбайн хойт хэсэг рүү тайван алхуулав. Одоо бүх зүйл түрүүчийнх шиг хүнд биш болжээ. Сүмийн хорооны дайчны их цус алдсан морь нь хөрөнгө үгүй баатартай сүүлчийн удаа мөргөлдөхийг давсангүй ойчиход Бриан де Буагильбер мөн хөсөр ойчихдоо дөрөөнөөсөө салж чадсангүй. Өштөн нь эгшин зуур буун харайгаад дийлэгдсэн дайсны толгой дээр илдээ далайн даруй бууж өгөхийг шаардав. Сүмийн хорооны баатарт хар сүрхий аюул тулгарсныг мэдэж сэтгэл догдолсон хаан хүү Жон түүнийг

дийлэгдсэнээ хүлээх шившгээс аврав. Хаан хүү очироо талбай дээр хаяж тэмцээнийг дуусгав.

Гэхдээ тулалдааны сүүлч аяндаа намдаж талбай дээр үлдсэн ихэнх баатрууд харилцан зөвшөөрөлцсөн мэт цаашдын тэмцлээс түдгэлзэн хувь заяаг хэрхэн шийдэхийг тэргүүлэгч нарт тохоож байлаа.

Тулалдааны үеэр эзэддээ тусламж үзүүлэхээс болгоомжлон хүлээж байсан дагуулууд бөөнөөрөө талбай руу шархдагсдыг авахаар ухасхийв.

Ашби-де-ля-Зушад болсон цэрэг эрсийн дурсгалт цэнгээн, тэр цагийн хамгийн гялалзсан том эрүүл тулалдааны нэг тийнхүү төгслөө. Үнэндээ дөрөвхөн баатар тулалдааны талбарт амь үрэгдсэний нэг нь зүгээр давтмал хуяган дотроо бүтэж үхсэн байв. Харин гуч дөчин хүн хүнд шарх гэмтэл олсны дөрөв тав нь төдөлгүй үхэж, олон хүн насан туршаа тахир дутуу болон үлджээ. Иймээс ч эртний он тооллын бичигт энэ эрүүл тулалдаан "Ашбайд болсон цэрэг эрийн зугаатай сайхан наадам" гэж нэрлэгджээ.

Баатруудын хэн нь тулалдаанд илүү их шалгарсныг хаан хүү Жон тогтоох учиртай болсонд ард олноос залхуу хар гэж нэрлэсэн тэр баатарт тэргүүн шан хүртээхээр шийдэв.

Байлцсан улсын зарим нь маргаж эрүүл тулалдаанд дийлсэн нэр төр өв хөрөнгө үгүй баатарт аргагүй оногдохыг зааж, ганцаараа зургаан дайснаа дийлж эсрэг багийн удирдагчийг хөсөр ойчуулсныг дурдахад хаан хүү Жон өөрийнхөөрөө зүтгэн, хар хуяг дуулгатай хүчирхэг баатар амжин ирж дэмжээгүйсэн бол өв хөрөнгө үгүй баатар, түүний талынхан зайлшгүй тэмцээнийг алдах байсан. Иймээс шагналыг түүнд олгох учиртай гэж маргав.

Гэтэл хар баатрыг хаанаас ч ирээд олсонгүйд байлцсан бүх хүмүүс ихэд гайхав. Тэмцээн дуусмагц хар баатар талбайгаас одож хажуугийн ой руу алгуур тайван орохыг үзэгчдийн зарим нь харжээ. Хоёр удаа бүрээдэж, түүнийг гарч ир гэж зарц нар чангаар дуудсан боловч ирсэнгүй.

Шагнал хэнд олгохыг хаан хүү Жон дахин шийдэх болов. Өв хөрөнгө үгүй баатрын эрхийг цаашид хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй болсонд тэр өдрийн гоц шалгарагч мөн гэж зарлагдав.

Маршалууд цус бялхам зэр зэвсгийн хугархай хөглөрсөн, үхсэн морьд хэвтэж байгаа талбайгаар явж ялагчийг хаан хүү Жоны ширээний өмнө дагуулж очив. Хаан хүү Жон,

- Өв хөрөнгө үгүй баатар та өөрийнхөө жинхэнэ нэрийг бидэнд бас л дуулгах дургүй байгаа бол энэ нэрийн чинь дор таныг дахин эрүүл тулалдааны дийлэгч гэж хүлээн тогтоож, хайр сэтгэл, гоо сайхны хатан хааны гараас эр баатраараа арга буюу олж авсан хүндэт титмээ хүлээн авах эрхтэйг мэдэгдье гэв.

Баатар хүндэтгэнгүй, хээнцрээр мэхэс хийсэн авч үг дуугарсангүй.

Дахин бүрээ хангинаж зоригтны магтаал, ялагчийн яруу алдрыг зарц нар чангаар алдаршуулна. Бүсгүйчүүл торгон алчуур хатгамалтай татуур зэргээрээ даллан олон язгуурын

наадамчид нэгэн зэрэг бахдал хөөрөө илэрхийлнэ. Маршалууд баатрыг Ровена хатагтайн сууж байсан хүндэт суудлын өмнө хөтөлж очлоо.

Ялагчийг суудлын дорд гишгүүр дээр сөхрүүлэв. Тулалдаан дууссан үеэс аван баатар өөрийн дур хүслээр хөдөлж чадахгүй, тойрсон хүмүүсийн аяыг дагах мэт болжээ. Талбай дундуур түүнийг хоёр дахь удаа хөтлөн явахад гуйвж байхыг нь зарим хүмүүс ажжээ. Ровена ихэмсэг алхан хатан суудлаас бууж ирээд гартаа байсан титмийг баатрын дуулган дээр тавих гэтэл маршалууд цөм нэгэн зэргээр:

- Тэгж болохгүй. Баатар тэргүүнээ ил гаргах учиртай гэж дуу алдав.

Баатар хэдэн үг аман дотроо дуугарсан нь халхавчны цаанаас бүгд, учир сайн ойлгогдохооргүй дуулав. Дуулгаа битгий тайл гэж гуйж байгааг ил гадарлаж болохтой ажээ.

Гэтэл маршалууд бүх хэв гуримыг дагах хүслийн үүднээс ч юмуу хэрэгт дуралсандаа ч тэр үү, энэ үгийг нь үл хайрхан дуулгын нь бүчийг тас огтлон хуягны хүзүүвчний боолтыг тайлж тэргүүнийг нь ил гаргав. Цугларсан олны өмнө хорин тав орчим насны идэр эрийн, цайвар үс дух руу нь эмжин унжсан сайхан царай харагдав. Царай маш цонхигор, нэг хоёр газарт цусан толбо болжээ.

Түүнийг хармагцаа Ровенагийн цээжнээс өөрийн эрхгүй аяархан дуу алдах чимээ гарав. Гэвч тэвчиж сэтгэлийн догдлолоо барьсандаа бүх бие нь чичирсээр уул үүргээ албадан байж гүйцэтгэв. Өмнөө бөхийсэн баатрын тэргүүн дээр дийлэгчид шагнахаар зэхсэн сайхан титэм тавиад үгээ зөөн ухацтайгаар:

- Өнөөдрийн эрүүл тулалдаанд эрэлхгээр ялсан хүнд өгөх учиртай энэ титмийг эрхэм баатар танд хайрлъя гээд хэдэн минут хиртэй дуугүй болсноо дуу нь төв болж:

- Ер нь эр баатруудын титмээс илүү болохуйц сайхан тэргүүнийг чимж байгаагүй билээ гэв.

Эр зоригийн шагнал хүртээсэн гоо хатны гарыг баатар үнэссэнээ гэнэт урагш тонгойж хөлий нь өмнө унав. Хамаг амьтан сандарч эхэллээ. Хөөгдсөн хүүгээ гэнэт гараад ирэхэд алмайрч орхисон Седрик түүнийг Ровенагаас холдуулах гэсэн аятай ухасхийх гэтэл Айвенгогийн унасан шалтгааныг гадарласан маршалууд урьдаж давтамал хуягийг нь даржй тайлан үзвэл жаданд сүлбүүлсэн шарх хажуу талд нь онгойж байлаа.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Эрдэм чадлаар төгс хэн бүхэн

Ойртож наашаа ирэг.

Эрс хатуу шүүлтээс үл эмээх

Эрхэм баатрууд над дээр цуглараг.

Хэн бүхнээс илүү харваачид би,

Хуртай тарган бухаар шагнана.

Пон "Илиад"

Айвенгогийн нэр мэдэгдэхийн хамт ам амнаас дамжин төдөлгүй хаан хүү Жон, шадар бараа бологчдын сонорт хүрлээ. Хаан хүү дуулсан дороо дургүйцэн хөмсөг зангидсан боловч дараа нь эрэгцүүлэн харж, тоомсоргүй байдлаар:

- Ноёд оо, ялангуяа эрхэм ширээт та, хүнд сайн муу байх төрөлхийн зөнгөөс болдог тухай эрдэмтдийн санааг ер юу гэж үздэг вэ? Энэ сүрхий эрийн хуяг дуулган дор ахын минь шадар дотно хүн байх юм гэж санаандгүй байсан хэдий авч эхнээсээ аваад нэг л төдгүй байсан минь зүгээр хэрэг биш байж гээч гэв.

Эрүүл тулалдаанд оролцож үүргээ нэр төртэй биелүүлээд дуулга бамбайгаа тайлж, хаан хүүгийн бараа бологчдотой нийлж амжсан де Браси тэгээд, Фрон де Беф янз нь эдлэнгээ Айвенгод буцааж өгөхөд бэлтгэх хэрэгтэй болж байна гэвэл Вальдемар Фицурс тосож аван, - Тиймээ, энэ дайчин лав Ричард өөрт нь хайрласан бөгөөд хожим эрхэм дээдэс таны өгөөмөр сайны ачаар Фрон де Бефэд шилжсэн эдлэн, цайз сэлтээ эргүүлж нэхэх л байх даа гэлээ.

Хаан хүү Жон хариуд нь Фрон де Беф чинь Айвенгогийнх шиг тийм эдлэн нэг ч болов буцааж өгөхөөсөө дахиад гурвыг залгичихаж чадахуйц хүн дээ. Гэвч харь орноор тэнүүчилж олигтой сайнаар алба хаан зүтгэх ч үгүй, үнэнч сайнаа бидэнд үзүүлэх ч чадваргүй хэсүүлчдийг бодвол намайг тойрон нягтарч эр цэргийн хүний ёсоор зүтгэхэд бэлэн байгаа үнэнч зарц нартаа газар эдлэн хайрлах эрхийг минь үгүйсгэх хүн та нарын дотор үгүй байхаа гэв.

Тойрсон хүмүүсийн ашиг сонирхол уул асуудалтай гүн холбоотой болохоор хаан хүүгийн энэ хуурмаг эрхийг үгүйсгэн маргах гэж хаанаас бодох билээ.

- Манай хаан хүү ёстой өгөөмөр хүн! Өөрийн талын үнэнч хүмүүсийн хүчин зүтгэлийг хөхүүлэн шагнадаг, чухамхүү шударга сайн эзэн! гэж хаан хүүгийн шадар бараа бологчдотой шуугилдав. Ричард хааны шадар дотно хүмүүс, түүний талынхны эв эдлэнгээс хүн бүр хувь хүртэл завшихыг хичээдэг, олонхи нь нэгэнт амжаад байгаа ажээ.

Вальдемар хэрэгт дурлан Айвенгог очиж үзэж ирээд, тэр зоригт эр эрхэм дээдэс танд төвөг удааж чадах ч үгүй л болов уу, Фрон де Беф эдлэнгээ сэтгэл амар эзэмшиж сууж болно, баатар тун хүнд шарх олжээ гэв.

- Тэр хүний хувь заяа ямар байлаа ч гэсэн өнөөдрийн тулалдаанд дийлсэн хүн, бидний хамгийн аюултай өшгөн юмуу, манай ахын хамгийн үнэнч сайн нөхдийн нэг байлаа гэхэд, уул энэ хоёр бараг ижил үг л дээ, түүний шархыг эдгэрүүлж өгөх хэрэгтэй. Манай өөрийн эмч түүнийг анагааг гэж хаан хүү Жон хэлээд уруулаа зэвүүн гэгч мушийлган инээвхийлэв. Вальдемар Айвенгог талбайгаас авч одон нөхөд нь сувилан буйг яаран дуулгав. Тэгээд цаашаа – Хайр сэтгэл, гоо сайхны хатан хааны гүн их гунигийг харахад зовлонтой санагдлаа. Тэр бүсгүйд хатан суудал ганцхан өдрийн турш эдлэн тавилан оногдсон бөгөөд энэ явдлын уршгаар тэр нь бас гаслангийн өдөр болдог байна. Бүсгүй хүний гуниг гасланд уярчихаар хүн би хэдий бишээ. Харин Ровена авхайтан гаслан гунигаа ёстой хүн шиг барьж чадах юмаа. Тас атгасан гар, хөл дор нь ухаан алдаад хэвтэж байгаа хүнийг харж, хуурай авч анивчин байгаа нүдийг эс ажиглавал ер хүн гадарлахаар үгүй ажээ гэв.

- Ингэж олны амнаас салахаа байсан Ровена хатан гэдэг чинь хэн юм бэ? гэж хаан хүү Жон асуусанд,

- Саксоны өндөр язгуурт, маш их баян айлын өв залгамжлах охин, ангилуун үнэрт мянган үрлийн хамгийн сайхан нь, өгүүлшгүй үнэт сувд, гоо сайхны саргай цэцэг мөн билээ гэж ширээт лам Эймер өгүүлэв.

- Тэгвэл бид сэтгэлийн гунигийг тайтгаруулахын хамт норман хүнтэй суулгаж удам угсааг нь сайжруулъя. Бүсгүй лав насанд хүрээгүй байх учиртай, тэгэхлээр бид эзэн хааны хувьд мэдээд хүнд өгөх эрхтэй. Де Браси чи энэ тухайд юу гэж бодож байна? Саксон бүсгүйтэй ханилан газар эдлэн, эд хөрөнгөтэй болохыг хүсэх үү? Гэж хаан хүүг асуувал де Браси өөдөөс нь:

- Газар эдлэн нь сэтгэлд таарвал, хүүхэн ч лав таалагдана, тэгээд өндөр дээдэс таны энэ сайн үйлийг би гүнээ талархаж явах болно. Үнэнч зарц, албатдаа таны бүх амалсан зүйл үүгээр хувь илүү биелэгдэх юм гэв.

Хаан хүү Жон үүнд, - Бид үүнийг мартахгүй. Цаг дэмий үрэхгүйн тулд, өнөө оройны найран дээр Ровена авхайг байлцуулах тушаал өг гэж манай захирагчид хэл. Тэр өмөг түшиг болдог эр, мөн саяын тэмцээн дээр хар баатрын цохиж унагаадаг саксон бухыг хамт урь гэж захирагч руугаа эргэн, - Де Бигот бидний дахин урьж байгааг Саксоны хямсгар занд нь нийцэж бас дахин ирэхээс татгалзахын эрхгүй эелдэг үгээр дамжуул. Бекетон ариун шарилыг барьж андгайлахад тэнд эелдэг зан гаргах гэдэг чухамдаа гахайн өмнө чинчүү шидэх адил хэрэг билээ гэв.

Ингэж хэлээд хаан хүү Жон тулалдааны талбараас хөдлөх дохио өгөх гэтэл жижиг зурвас түүнд гардуулав. Авчирсан хүн рүү эргээд хаанаас ирэв? гэж асуухад зарц:

- Хилийн цаанаас иржээ эзэнтэн. Чухам хаанаас юм мэдэхгүй. Үүнийг өндөр дээдэс танд гардуулахаар өдөр шөнөгүй тавьсан нэг франц хүн авч иржээ гэв.

Хаан хүү Жон хуяг, хуйлаастай цаасыг боож нийлүүлэн лацадсан торгон бүч сэлтийг хянуур ажиглав. Лацны тамган дээр гурван замбага цэцэг зураастай ажээ. Хаан хүү илтэд сэтгэл хөдлөх байртай захиаг задалж гүйлгэн уншаад улам ч илүү догдолсон байртай боллоо. Эд зурвасанд бичсэн: "Шулам гинжнээс мултарсан, болгоомжлоорой" гэжээ. Хаан хүүгийн царай үхсэн хүний царай адил зэвхий даан доош харснаа цаазаар аваачигдах ял дөнгөж сая дуулсан хүн аятай тэнгэр өөд харав. Гэнэт хилмэгдлээс жаахан гарч сэхээ аваад Вальдемар Фицурс, де Браси хоёрыг хажуу тийш авч очин уул зурвасыг ээлжлэн уншуулав.

- Энэ чинь миний ах Ричард эрх чөлөө олжээ гэсэн үг байх нээ гэж дорой дуугарав.

- Үгүй энэ минь хуурмаг түгшүүр юм уу, зохиомол захидал биш байгаа гэж де Браси асуухад,

- Үгүй энэ минь францын хааны өөрийн нь бичиг, тамга мөн байна гэж хаан хүү Жон маргалаа.

- Тийм болж гэм манай намынхан, нэг газарт, жишээ нь Йоркод цугларах цаг болжээ. Хэдэн өдрийн дараа гэвэл лав хэт оройтох байх шүү. Өндөр дэдэс та энэ зугаа цэнгэлийг зогсоовол таарна гэж Фицурс санал гаргахад,

- Энгийн ардууд, Йоменуудыг цэнгэлд үл оролцуулан сэтгэл дундуур тархааж бас болохгүй гэж де Браси өгүүлэв. Вальдемар үүнд, яах вэ шөнө болтол өдий байна, харваачид бай руу хэдэн арван сум тавиад орхиг, дараа нь шагнал олгож болно. Тэгвэл саксоны сүрэг боолчуудад хаан хүүгийн амалсан бүхэн үүнээс цаашгүй сайнаар биелэгдэх нь тэр гэв.

- Вальдемар чамд гялайлаа, тэгээд л өчигдөр дээд язгуурт биднийг доромжилж зүрхэлсэн тэр харцыг би бас залхаах учиртай байгааг санууллаа. Оройн найр наргиан яахав тогтсон ёсоороо л явагддаг, миний эзэгнэх сүүлчийн цаг байлаа ч гэсэн үүнийг би өшөө тайлах цэнгэлд зориулна гэв.

Төдхөн тархаж эхэлж байсан үзэгч олныг бүррэн дуу дахин цуглуулав. Тэгээд чухаг ажил гарсны улмаас хаан хүү Жон маргаашийн баяр цэнгэлийг өөрчлөхөд хүрлээ. Гэвч сайн санаат Йоменуудыг авхаалж, эрдэм чадлыг нь үзэлгүйгээр тараах дургүй байна. Иймд маргааш болохоор тогтсон сур харвалтыг өнөөдөр нар шингэтэл явуулахаар шийдлээ. Хамгийн мэргэн харваачид мөнгөн тоногтой эвэр цоор, гоё сайхан хатгамалсан торгон мөрөвч, ан гөрөөний бурхан гэгээн Губертийн хөрөгтэй сахиусаар шагнана гэж зарлав.

Эхлээд гуч гаруй Йоменууд тэмцээнд гарч ирэв. Тэдний дунд Нидвуд, Чарнвудийн ойн хааны манаач нар байв. Гэвч хэнтэй өрсөлдөх болж байгаагаа мэдмэгц илт л хожигдохыг дурлах хүн үгүй тул хориод хүн даруй больж орхилоо. Тэр үед мэргэн харваач бүр бүх мужуудаар зартай байдаг байсан болохоор тэмцэлдэгч болгон хэн хэнийхээ хирийг мэдэх ажээ. Хэдий тийм авч Йоменуудын нэрсийн жагсаалтанд найман өрсөлдөгч үлджээ.

Энэ шилдэг харваачдыг ойроос харах гэж хаан хүү Жон талбай дээр бууж ирлээ. Үзэж ханаад, өштөн Йоменыг хайн ийш тийшээ харвал өчигдөр байсан газартаа тайван гэгч зогсож байх ажээ.

- Хөөе сайн эр! Би чамайг жинхэнэ харваач биш, хоосон сайрхагч байх гэж бодсон юм. Чи янз нь тэр хүмүүстэй эгнэн зогсохоос айж байх шив гэж хаан хүү хэлбэл Йомен өөдөөс нь:

- Эрхэм та уучлаарай, надад тэгэх тусгай шалтгаан байна гэж өчив.

- Чухам ямар шалтгаан байна вэ? гэж хаан хүү асуув. Өөрөө сайн мэдэлгүйгэр энэ хүнийг хачин шохоорхох болов.

Йомен үүнд, нэгд энэ харваачид миний дассан байг шагайж сурсан юм уу, үгүй юу мэдэхгүй байна. Хоёрт, гурав дахь шагнал мөн гайгаар таны таалалд эс нийцсэн хүнд олгогдоход хүрьэл гэгээн дээдэс танд аятай байна гэдэгт эргэлзэж байна гэв. Хаан хүү Жоны царай улайж:

- Чиний нэр хэн гэдэг вэ? гэвэл,

- Локсли гэж Йомен хариулав.

Хаан хүү үүнд:

- За Локсли чи энэ Йоменууд эрдэм чадлаа үзүүлсний дараа заавал тэмцээнд оролц. Хэрэв шагнал авах юм бол би харин зоос дээрээс нь нэмж өгнө, харж алдах юм болж гэм ногоон цамцыг чинь тайлаад, талбайгаас ичгүүр сонжуургүй бардам этгээд гэж ташуурдан хөөж зайлуулна шүү гэв.

- Ийм нөхцөлтэйгэр харвах дургүй байвал яана? Өршөөлт эрхэм та хүчирхэг их хүн, ярих ч юм алга. Та өдий олон зэвсэгт шадар цэргүүдтэй болохоор миний хувцсыг тайлж ташуурдахад зовлонгүй. Гэвч намайг албаар нум татуулж харвуулах нөхцөл алга шүү дээ гэвэл хаан хүү Жон:

- Хэрэв чи миний үгнээс зөрөх юм болж гэм ахлагч чиний нум сумыг хугалж, өөрийг чинь аймхай хулчгар амьтан гэж эндээс хөөж гаргана гэлээ.

Йомен үүнд, - ихэмсэг хаан хүү онцын шударга бусаар намайг хавчиж байна. Та намайг Лейстер, Стаффирдширийн шилдэг харваачидтай албаар үзүүлж, аз дутвал шившиглэнэ гэж сүрдүүлж байна. Гэхдээ би таны зарлигийг дагая даа гэлээ.

- Цэргүүд та нар үүнийг сайн харж бай! Энэ нэгэнт хулчийж байна, үүнийг тэмцээнээс зайлсхийлгэхийг би ер хүсэхгүй. Ай сайн эрчүүд та нар зоригтойхон шиг харва. Шарсан буга, торх дарс та нарт зориулан тэр майханд бэлтгээд байгаа. Шагнал олгосны дараа та бүхэн жаал хүч тэнхээгээ сэлбэж болох юм шүү гэв. Тулалдааны талбарын өмнөт гарцын дээд талд бай тавьж тэмцээнд оролцогсод гарцын дээд үзүүрт ээлжээр зогсон гурав гурван сум тавих, ээлжийг сугалгаагаар тогтоох учиртай ажээ. Сурын цувааг доод тушаалын ахлагч эрхлэн явуулах нь эрүүл тулалдааны маршалууд Йоменуудын цэнгэлийг удирдаж явуулахыг дор гутамшигт зүйлд тооцсоных ажээ.

Харваачид хойно хойноосоо гаран бай руу сурамгаар сумаа тавьцгаав. Хорин дөрвөн сумнаас арав байнд зоогдож бусад нь тун ойрхон туссан оноо сайн байна гэж үзэж болохтой ажээ.

Байнд зоогдсон арванг сумнаас хоёр дотоод тойрогт туссан нь хоёул Мальвуазены ойн манаач Гулбертийнх байсанд даруй дийлсэн гэж тооцогдов.

Хаан хүү Жон зоримог Йомен руу харж хүйтнээр инээмсэглэн:

- За Локсли яах вэ? Губерттэй хүч үзэлцэх үү аль саадаг нумаа шуудхан өгсөн нь дээр гэж үзэж байна уу? гэхэд,

- Өөр арга үгүй юм бол азаа туршихаас дургүйцэх юм алга. Тэгэхдээ ганцхан болзол байна. Би Губертын байг хоёр дахин ижил онох юм болж гэм тэр миний сонгож авсан байг харвах ёстой болно шүү гэв.

- Энэ шударга шаардлага, бид зөвшөөрнө. Губерт чи энэ сайрхуу эрийг дийлэх юм бол би эвэр дүүрэн мөнгө хийж өгнө гэж хаан хүү Жон хэлэхэд Губерт хариуд нь:

- Хүн ер нь хирдээ л тохирсон юм хийж чадна. Гастингсийн тулалдаанд миний өвөг эцэг гойд сайн харваж байсан юм, би бас түүний нэрийг гутаахгүй болов уу л гэж найдана гэв.

Анхны байг авч өөр яг адилыг тавив. Губерт түрүүчийн тэмцээнд ялсны хувьд эхэлж харвав. Нумаа тэлж татаад удтал шагайлаа. Тэгж тэгж урагшаа нэг алхан хөвчөө улам татаад тавихад, сум агаарт исгэрэн дугуй дотор зоогдохдоо ялихгүй гол алдав.

Өрсөлдөгч нь нумаа тэлэх зуур, Губерт чи салхины чигийг бодсонгүй тэргүй бол илт илүү сайн онох байсан юм гэв. Ингэж хэлээд Локсли зурааст газарт очиж зогсон сумаа ажиггүй царайгаар бараг шагайлгүй тавьчихлаа. Гэсэн мөртлөө гүүний сум гол руу Губертийнхээс хоёр сөөм ойр тусав.

Хаан хүү Жон үүнд, - Тэнгэрийг зааж андгайлахад энэ муу новшид чи дийлдэж муугаа үзвээс чамайг дүүжлэхэд болохтой юм гэв.

Гэтэл юм бүхэнд Губерт ганц л хариулт өгөх ажээ. Өндөр дээдэстэн та дүүжилсэн ч яах вэ. Хүн хирдээ тэнцэх л юмыг хийж чадна. Харин миний өвөг эцэг харвахдаа тун гойд... гэтэл Жон үгийг нь таслан:

- Чиний тэр өвөг эцэг, үр удмыг чөтгөр алгадаг! Зальхай амьтан чи харва, харж олигтойхон харваарай, үгүй бол чамд муу болох байх шүү гэв.

Иймэрхүү янзаар шавдуулан байж Губерт дахин байранд очиж зогсоод өрсөлдөгчийнхөө зөвлөлгөөг санан дөнгөж сая сэвэлзсэн зөөлөн салхийг тооцоолоод шагайн сжмаа тавьсан нь тун азтай, байны яг голд тусав.

Таних хүндээ үл таних хүнээс илүү талтай байсан үзэгч олон – Айдаа Губерт! Мөн дөө Губерт! яг голд нь шүү! Тэхий голд нь гээч! Губерт мандтугай! Гэж хашгиралдав. Хаан хүү бах нь ханаж зэвүүнээр инээмсэглэн, үүнээс илүү сайн онож чи чадахгүй дээр. Локсли гэхэд,

- За би үүний сумыг унагаачихья гэж хариулаад шагайн тавьж байнд гозойж байсан Губертийн сумыг цууртал нь харвав.

Йоменууд хоорондоо энэ лав хүн биш чөтгөр байж таарах нь. Англид нум сум буй болсноос хойш ингэж харвахыг хүн ер үзээгүй дээ гэж шивнэлдэв.

- Одоо манай хойт нутагт хэрэглэж заншсан бай тавих зөвшөөрөл өршөөлт эрхэм танаас гуйя. Гоо бүсгүйнхээ инээмсэглэхийг харъя гэсэн золбоот Йомен бүр түүнийг онох гэж оролдоод үзэг гэж Локсли хэлээд хашаанаас гарч явснаа эргэж,

- Та хүсвэл надтай цуг манаач нараасаа явуул л даа. Би ойролцоо модноос мөчир огтлох хэрэгтэй байна гэлээ. Хаан хүү Жон харуулуудад дагаж яв гэж дохио өгөх гэтэл тал бүрээс хүмүүс "Шившиг! шившиг!" гэж хашгиралдсанд хаан хүү тэр гутамшигт шийдвэрээ өөрчлөхөд хүрэв. Минутын дараа Локсли зургаан сөөм хиртэй өндөр хурууны дайтай бүдүүн шулуухан саваа барьсаар эргэж ирэв. Тэгээд зурваслах зуураа саяны тавьсан шиг байг харвана гэдэг бол олигтойхон харваачийг дооглох гэсэн үг. Манай нутагт юм болж гэм, тэгэхэд хүртэл Артур хааны далан хүн тойрч суудаг дугуй ширээгээр бай хийчих юм биш үү гэж хэн бүхэн хэлэх бий гэж байв.

- Манай тэнд долоон настай хүүхэд мухар булцуутай сумаар саяных шиг бай онодог юм шүү гэж хэллээ.

Тэгээд тавиун алхаж талбайн нөгөө талд очоод шинэ саваагаа газарт цэх хатгаад,

- Энэ савааг зуун алхмын цаанаас оносон хүнийг эзэн хааны дэргэд, алдарт Ричардын өөрий нь дэргэд ч гэсэн саадаг нум агсаж явж болох хүн гэж би нэрлэнэ гэж Локсли хэлэхэд Губерт хариуд нь:

- Миний өвөг эцэг Гистингсийн тулалдааны үед лут харваж байсан хүн. Гэхдээ ийм бай харваж яваагүй, би ч гэсэн харвахгүй. Энэ Йомен ийм саваа онодог болж гэм үүнд, чухам гэвэл үүний хүрмийг өмсөж яваа чөтгөрт тэргүүн байрыг дуртайяа өгье юу гэвэл хүн ер тэгж харваж чадахгүй. Хүн зөвхөн хирдээ тохирсон юмыг л хийнэ. Лавтай алдахаа өөрөө мэдэж байгаа хойно би харвахгүй. Энэ чинь тонгорогны ир юм уу нарны сүрэл цацраг онохоор харвана гэсэн үг байна шүү дээ... Тэр цагаан чөтгөр даанч нарийн, би ядаж сайн олж харах ч үгүй байна шүү гэв.

- Муу аймхай нохой! гэж хаан хүү Жон дуу алдаад, - За Локсли, зальхай амьтан чи адаглаад өөрөө харва. Ийм бай онох юм бол анх чадсан хүн чамайг гэж би хэлнэ. Давуу эрдэм чинь ажил хэргээр нотлогдоогүй цагт чиний сайрхахыг би хүлээхгүй гэвэл Локсли өөдөөс нь:

- Би юу чадахаа хийе. Губертийн хэлснээр хүний хирээс хэтэрсэн их юм шаардаж болохгүй гэв.

Ингэж хэлээд дахин нумаа авахдаа хөвч нь түрүүчийн хоёр харвалтанд жаахан сунаж бөөрөнхий биш болжээ гэж үзээд солив. Энэ удаа нилээд хянуур шагайсанд олон түмэн юу болохыг хүлээн амьсгаа дарж зогсоно. Мэргэн эрдэм чадалд нь олны биширсэн итгэлийг биелүүлж сум уул тавьсан савааг салам цохилоо. Улсын бахдан хашгиралдах нь өгүүлэхийн аргагүй. Хаан хүү Жон хүртэл хэсэгхэн зууртаа эрдэм чадалд нь машид бишрэн гайхсандаа Локслийд дургүйгээ мартаж орхижээ.

- За май, хорин зоос, анчны эвэр цоор ав. Чи шагналыг аргагүй эрдмээрээ авлаа. Манай жагсаал хувцас өмсөж, бидний бие хамгаалагч болохыг зөвшөөрвөл чамд тавин зоос олгоно. Урьд өмнө хэзээ ч чамаас өөр хэнд ч ийм чийрэг гар, хурц нүд ер байгаагүй билээ гэж хаан хүү Жоныг өгүүлэхэд,

- Дээд төрөлт хаан хүү та уучлаарай. Хэзээ нэгэн цагт албанд орох болбол зөвхөн өндөр дээдэс таны хаан ах Ричард хаанаас өөр хүнд хүчин зүтгэхгүй гэж андгайлсан билээ. Энэ хорин зоосыг би Губертэд өглөө. Өнөөдөр Губерт Гастингсийн тулалдааны үед талийгаач өвгийнхөө байснаас огтхон ч дор оносонгүй. Губерт даруу зангаас болж тэмцээнээс татгалзаагүйсэн бол савааг надтай адилхан онох л байсан.

Губерт толгой сэгсэрч, үл таних хүний өгөөмөр бэлгийг дурамжхан хүлээж авав. Үүний дараа Локсли олны анхаарлаас холдох гэж цугларсан олны дунд хутгалдан орж дахин үзэгдэхээ болив.

Хаан хүү Жон энэ үед илүү чухаг түгшүүр бодолд автаад байгаагүйсэнг бол ялсан харваач хаан хүүгээс өдий амархан зайлж одохгүй байсан байж мэдэх билээ. Тэмцээн дуусгах дохио өгөөд шадар зарцаа дуудаж даруй Ашби орж еврей Исаакийг тэндээс эрж олохыг тушаав.

- Тэр муу нохойд, өнөөдөр нар шингэхийн өмнө надад хоёр мянган төгрөг заавал ирүүл хэл хэл. Миний юугаар барьцаа тавихыг тэр мэднэ, гэхдээ өөрийг чинь миний өмнөөс яваад эргэлзүүлэхгүйн тулд энэ бөгжийг үзүүлээрэй. Үлдсэн мөнгийг надад Йоркод зургаан өдрөөс хожигдуулалгүй авч очиг. Энэ тушаалыг эс биелүүлбэл би түүний арьсыг хуулна. Хянуур харж яв, замдаа харалгүй өнгөрүүлчихэв. Тэр бузар амьтан өнөөдөрхөн бидний өмнө хулгайлсан гоёлоороо гайхуулж байсандаг гэв.

Ийнхүү хэлээд хаан хүү мориндоо мордон Ашби руу одсонд бусад үзэгчид цөм тархаж эхлэв.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Цэрэг эрсийн өмсгөл сүртэй сайхан,

Цэнгэл зугаа нь эр баатарт дүйнэ.

Бүсгүйчүүл дайчид цөм хурж

Бүгд тойрон найр зохиоход

Эвэр цоорын эгшигт уянга

Эртний цайзнаас цуурайтан дуурсана.

Уортон

Тэр цагт Ашби эдлэн Ричардтай цуг Палестина руу одсон Винчестерийн гүн Роджер, де Квинсийнх байсан бүлгээ. Хаан хүү Жон түүний цайзыг эзэгнэн эд хөрөнгийг нь сэтгэл зовохгүйгээр хэрэглэх ажээ. Зочломтгой, баян өгөөмрөөрөө олонд гайхагдах гэж хөлтэйхэн найр бэлтгэхийг тушаажээ.

Хаан хүүгийн нярвууд эзэн хааны эрх мэдлийг эдлэн хавь орчинг хоосолно. Олон зочид уригдсаны дотор нутгийн ард иргэдийн дунд нэр хүнд олохын үүднээс хаан хүү Жон Саксон, дани үндэсний хэд хэдэн сурвалжит гэр бүлийг оролцуулжээ. Дарлагдан доромжлогдогч Саксончууд тоогоор олон тул ойртож буй самууны үед аймшигт хүчин болох учиртай билээ. Иймд улс төрийн бодлын үүднээс эдний төлөөлөгчдийн дэмжлэг түшгийг урьдаас олж авах нь чухаг байлаа.

Үүний улмаас хаан хүү Жон өөрийн зочин саксончуудаа гойд найрсаг сайн байхаар шийджээ. Гэтэл санаагаа хар муу бодолдоо хэнээс ч илүү хялбархан захируулж чаддаг авч уул төрсөн төрх нь болсон хөнгөмсөг түргэн авир, хуурмаг царай гаргаж байж олсон бүх амжилтыг нь ямагт үгүйсгэж хаях бүлгээ.

Түүний эцэг хоёрдугаар Генрих хаан түүнийг дөнгөж сая англид нэгтгээд байсан Ирланд руу нутгийн ардын сэтгэл санааг татуулах зорилгоор илгээхэд энэ чанар нь маш тод харагдаж билээ. Угтаж уулзсан Ирландийн тэргүүлэгчидтэй эелдэг найрсаг байхын оронд хаан хүү Жон болоод бараа бологсод нь тэдний урт сахлаас зулгаахсан гэж хорхой нь хүрээд болж өгсөнгүй. Иймэрхүүгээр авирласан нь Ирландийн дээд язгууртны төлөөлөгчдийг асар ихээр доромжилж, энэ орноос английн ноёрхлыг хүлцэн харьцаанд гайтайгаар нөлөөлөв. Найр наргиан дээр түүний хэрхэн аашилсны учрыг олохын тулд энэ туушгүй хачин чанарыг нь санаж байх хэрэгтэй юм.

Хянуур тайван үед шийдсэнийхээ дагуу хаан хүү Жон Седрик, Ательстан хоёрыг машид эелдгээр угтан авч Ровена авхайтан лагшин тунгалаг бусын эрхээр урьсны дагуу хүрэлцэн ирж эс чадсан тухайд Седрикийг уучлал гуйхад хилэгнэсэнгүй, зөвхөн харамсаж байгаагаа хэлэв.

Седрик Ательстан хоёр эртний саксон хувцастай иржээ. Үнэт эдээр оёсон хувцас нь үнэндээ хийц галбир муухайтай биш ажээ. Бусад зочны хувцаснаас даан ч гаж буруу тул хаан хүү, Вальдемар Фицурс хоёрын хараад инээдээ арай ядан барьж байсан хэдий авч, сайтар хянан үзэх ахуул Саксончуудын бариу богино цамц, урт нөмрөг нь норманчуудын дээрээс нь оодон цув нөмөрдөг урт, өргөн хүрмийг бодвол илүү үзэмжтэй биенд эвтэйхэн ажээ. Тэр оодон цув бороо хур хүйтнээс огт хамгаалахгүй, зөвхөн оёдолчны багтаах хирээр эрдэнийн чулуу үнэт үс сэлт хадахад хэрэг болох ажээ. Хаан сууж ахуй цагт нь ийм оодон цув анх өмсөх болсонд их Карл хаан ямар ч ашиггүйг үзэн ихэд гайхаж байжээ. "Үгүй энэ оодон цув юунд хэрэгтэйг хэлээд өгч үзээч. Унтахад хучиж болшгүй, морин дээр бороо салхинаас халхалшгүй, суугаа гэхэд чийг хүйтнээс хол хамгаалшгүй дээ" гэж байжээ.

Гэлээ гэхдээ л тэр цагт, ялангуяа Анжугийн хаан хөвүүдийн ордныхон дотор оодон цув гоёд тооцогдож байлаа. Хаан хүү Жоны дагуулууд их өмсөх бүлгээ. Иймд саксончуудын гадуур хувцас болох урт нөмрөг энд их инээдтэй харагдах нь аргагүй.

Зочид амттан зуушны элбэгт хотолзсон ширээ тойрон сууцгаажээ. Хаан хүүг дагалдан олон тооны тогооч нар ширээн дээр тавих зуушуудыг олон янз болгохын үүднээс ер бусаар хийх ажээ. Гэрт хийсэн зуушнаас гадна харь нутгаас авч ирсэн элдэв агтан багагүй ажээ. Нутгийн болоод гадаад дарсаар найр бялхаж байлаа.

Их идэж уун согтуурахыг ялагдсан саксончуудын онцлог гэж норманууд үзэх хэдий авч хаан хүү Жон, түүнийг мууг дууриаж шадар хүмүүс нь өөрсдөө мөн энэ талаар хэтрүүлэх тийшээ хазайдаг улс ажээ. Ер нь хаан хүү Жон жүрж их идэж шинэхэн эсгэсэн пивоор даруулж ууснаас болоод нас барсан түүхтэй шүү дээ.

Иймэрхүү найр наргианд дасаагүй Седрик, Ательстан хоёрын цагаахнаар ууж идэхийг норман баатарчууд, тайж нар хааяа нэг нэгэндээ нууц дохиж, ихэмсэг, залирхуугаар ажиглана. Боловсрол дорой хоёр саксон ихэс дээдсийн дунд тогтсон зан заншлаас хэдэн удаа гажжээ.

Седрик гараа угаасны дараа хээнцрээр хөдөлгөн байж хатаахын оронд алчуураар арчсан байв. Ательстан гадаадаас авч ирсэн шувууны сайхан махаар амталсан, тэр цагт Карумпай гэдэг нэртэй байсан лут том жигнэсэн боов ганцаараа цааш нь харуулчихсан нь илүү их инээдтэй байжээ. Харин асууж шалгаасны эцэст Конингсбургийн тайж чухам юу идэж орхисон тухайгаа мэдсэн юм ер үгүй, үнэндээ алтан гургалдайн махаар амталсан Карум-пайг тагтааны мах гэж санаад идчихсэнээ дуулаад уул ховдоггосноосоо илүүгээр олны элэг доог болов.

Удаан найр арайхийж дуусаж, зочид хундага дарс уухын завсар саяны эрүүл тулалдааны гавьяат үйлс, үл танигдах тэргүүн харваач болоод зүй ёсоор олсон алдар хүндэтгэлээс зайлсхийсэн хар баатар, асар өндөр үнээр ялж гарсан Айвенгогийн эрэлхэг баатарлагийн тухай ярилцав.

Бүхний тухай эр цэргийн хүмүүсийн эрс шулуун зангаар хөөрөх бөгөөд хошин үг инээд танхимаар дүүрэн цуурайтна. Ганцхан хаан хүү Жон баргар царайлж, хөмсөг зангидан суух нь ямар нэгэн хүнд зовлон сэтгэл шаналгаа байртай. Хааяа шадар хүмүүсийнхээ ятгалгаар орчинд болж байгаа зүйлийг минут хиртэй албаар сонирхоно. Давхийж, ширээн дээрээс

хундагатай дарс шүүрч аван нэгэн амьсгаагаар хөнтрөөд нийтийн ярианд үг оруулахдаа онож нийцүүлэхгүй байх нь олон.

Энэ хундагыг бид өнөөдрийн тулалдааны баатар Уильфред Айвенгогийн төлөө өргөө. Бидний энэ найран дээр байлцахад түүний шарх саад болсонд харамана. Хүн бүхэн надтай цаг баатрын эрүүл мэндийн төлөө ууг. Ялангуяа өдий их ирээдүйтэй хүүгийн хүндэт эцэг Ротервудийн Седрик ууг гэж хаан хүү хэлэв.

Седрик босож, уугаагүй дарсаа эргүүлж тавин, - Үгүй их эзэнтэн, дуулгаваргүй миний үгнээс даван эцэг өвгөдийн зан заншлыг умартсан залууг хойшид би хүүгээ гэж үзэхгүй гэвэл хаан хүү Жон ихэд гайхсан дүр үзүүлж,

- Хаанаас тийм байж таарах вэ? Өдий их эрэлхэг баатар дуулгаваргүй, муу хүү байж таарах уу? гэвэл Седрик хариуд нь:

- Тиймээ эзэнтэн, Уильфред тийм хүн. Тэр эцгийнхээ гэр орныг орхиж, манай ахын бараа бологсод болох хөнгөмсөг хүмүүстэй нийлсэн юм. Тэнд л энэ та бүхнийг өндрөөр үнэлж үздэг морин эрдэмд сурсан хэрэг. Намайг хориглосоор байтал орхиод явсан. Альфред хааны үед болж гэм үүнийг дуулгаваргүйд тооцоод зогсохгүй чанд шийтгэдэг гэмт хэрэгт үзэх агсан билээ гэв.

Хаан хүү Жон хуурмагаар өрөвдсөн дүр үзүүлж гүнээ санаа алдаад, - Тоогүй! Танай хүү миний золгүй ахтай нийлснээс хойш эцэг эхээ үл хүндлэх зан хаана, хэнээс сурсныг асуухын ч хэрэг алга даа гэлээ.

Хоёрдугаар Генрихийн бүх хүүхдүүд дотор чухам өөрөө л гойд дуулгаваргүй зантай, эцгийнхээ ачийг үл санах хүн гэдгээ зориуд мартан өгүүлэх ажээ.

Хэсэг зуур дуугүй байснаа, - Шадар сайн хүндээ манай ах баян эдлэн бэлэглэх санаатай байсан шиг санагдана гэхэд Седрик хариуд нь,

- Нэгэнт бэлэглэсэн. Миний хүүтэйгээ муудсан гол шалтгаануудын нэг бол урьд өвөг дээдэс нь хэний ч дур хүслэнгээс үл хамааран эрхийнхээ дагуу бүрэн эзэмшиж байсан тэр эдлэнг албат хүний хувиар хүлээн авахыг зөвшөөрсөн явдал бүлгээ гэв.

- Тэгвэл тэр эдлэнг британы хаанаас газар бэлгэнд авахад үл дургүйцэх хүнд олговол та татгалзахгүй юм шив дээ гээд бээл рүү эргэж, - Эрхэм Реджинальд фрон де Беф та бодвол Айвенгогийн бэлийн зэрэгт эдлэн гартаа аваад байж чадах бизээ. Тэгвэл эрхэм Уильфред энэхүү эдлэнг эзэгнэж эцгийнхээ хилэнг дахин хөдөлгөхгүй юм байна гэв.

Хар хөмсөгт баатар үүнд, - Гэгээн Антонийн нэрээр андгайлахад таны надад хайрласан эдлэнг Седрик юм уу Уильфред болон өөр нэг хамгийн өндөр сурвалжит англи хүн булаагаад авчидаг юм болж гэм өндөр дээдэс та намайг Саксон хүнд тооцоход болно гэж хариулав.

Энэ үгэнд Седрик гомдож, - Эрхэм бээл таныг Саксон хүн гэж хэн нэг нь нэрлэхэд хүрвэл өөрт чинь зүй бусаар дайрсан нэр төргүй хэрэг болохсон билээ гэв.

Фрон де Беф хариу маргах гэтэл угийн хөнгөмсөг зантай хаан хүү Жон дээрэнхүйгээр тас дайран:

- Сайн төрөлт Седрикийн зөв шүү эрхэм ноёдоо. Эднийхний удам судар чинь удам судрын бичгийн уртаар, өмсөх нөмрөгийнхээ ч уртаар нэгэн адил биднийхээс дээгүүр юм шүү гэв.

- Мөн тулалдааны талбарт ч гэсэн эд чинь нохойны өмнө гүйх ан адил биднээс түрүүлээд байгаа юм гэж Мальвуазенг хэлэхэд ширээт Эймер тосож аваад,

- Эд чинь биднээс түрүүлж явах учиртай улс. Эдний намба галбиртай, ёс гурим илүү сайн мэддэгийг мартаж болохгүй гэлээ.

де Браси мөн өөрийг нь Саксон бүсгүйтэй суулгахаар амалсныг умартан,

- Бас идэж уухад ховдог биш, архи дарсанд үл шунадгийг сана гэв.

- Гастингс болоод бусад газар эд чинь эр зоригоороо шалгарсан улс гэж Бриан де Буагильбер үг нэмэрлэв.

Ордны шадарчууд эелдгээр инээмсэглэн ам уралдаж тоглоом тохуурхлын үг урсгаж байхад Седрикийн царай хорсол бадран улайж, доромжлогчид руу ээлж дараагаар хилэнт харц чулуудна. Тарчлаагчиддаа ээрэгдсэн бух аятай чухам хэнд нь уур хорслоо гаргахыг даруй шийдэж чадахгүй байх шиг харагдана. Эцэст нь уур хилэндээ багтран байж хаан хүү Жон:

- Манай овог ямар ч муу дутагдалтай байлаа гэсэн өндөр дээдэс таны энэ байгаа шиг, гэр орондоо ирсэн гэм хоргүй зочинг ингэж доромжлуулах ахуул Саксон хүн бүр өөрийгөө шившигтэйд тооцох бүлгээ. Түүнээс гадна Гастингсийн тулалдаанд манай өвгөд дээдсийн аз дутсан хэдий боловч дөнгөж хэдхэн цагийн өмнө Саксон хүний жаданд хатгуулан эмээлээсээ нэг биш удаа ховх хаяуулж байсан хүмүүс тэр тухай дурсаагүй нь дээр байсан бизээ гээд Фрон де Беф сүмийн хорооны баатар хоёр өөд харлаа.

Хаан хүү Жон: Бурхны нэрээр андгайлахад хортой айхавтар үг байна! Эрхэм ноёд та бүхэнд хир тааламжтай байна? Манай Саксон албатууд цэцэн мэргэн, эр чадлаар их боловсронгуй болж байгаа юм байна. Мөн ч хэцүү цаг болжээ! Эрхэм ноёдуудаа хэлэх үг байна уу? Нарыг барьж андгайлахад бид эрхтэн хөлөг онгоцон дээр суугаад Норманддаа эсэн мэнд буцах юм биш үү? гэвэл де Браси инээд алдан тосож аваад,

- Саксончуудаас айсандаа тэр үү? Энэ муусайн гахайнуудыг хөөж хашихад агнуурын ацнаас өөр зэвсэг бидэнд хэрэггүй гэв.

Фицурс ярианд оролцон, - Тоглоцгоохоо больж үз, эрхэм баатруудаа. Бидний дэмий цэцэрхэх дасаагүй хүнд гомдмоор санагдаж болох авч, тиймэрхүү тоглоом тохууны үгэнд доромжлолтын зүйл эрхэм Седрик ер үгүй гэдгийг үнэмшүүлж хэлэх цаг болжээ, өндөр дээдсээ гэв.

Хаан хүү Жон дахин машид ялдам болоод – Гомдохоо! Би өөрийнхөө дэргэд зочноо

гомдоохыг хүлцэх гэж бодох хүн арай үгүй бизээ гэж найднам. Седрик хүүгийнхээ тухай уухыг нэгэнт татгалзаж байгаа болохоор би дахин хундагаа дүүргээд өөрий нь эрүүл энхийн төлөө ууя гэв.

Эрүүл энхийн дугараа дахин тойрч, ордныхны зусарч үг урсгасан нь Седрикт санасны адил гойд таалагдсангүй. Төрөлхийн онц ухаалаг биш ч гэсэн энэ бялдууч гоёч үгэнд хууртахааргүй соргог хүн билээ. Хаан хүүгийн дараачийн "Конингсбургийн Ательстаны эрүүл энхийн төлөө" гээд хундага өргөхийг дуугүй чагнаж байгаад бүгдтэй хамт уулаа.

Ательстан өөрөө ийнхүү хүндэтгэсний хариуд зөвхөн мэхэсхийгээд лут том хундагыг ганцхан амьсгалаар хоосолчихов. Уусан дарс хаан хүү Жоны толгойд гарч мансууруулж эхэлсэнд,

- За эрхмүүд ээ, бид манай саксончуудад зохих хүндэтгэл үзүүллээ. Одоо хариу эелдэг үг хэлэх ээлж эднийх гээд Седрик рүү харан, - Хүндэт тайж таны дургүйгээс бусдаас арай багаар хүргэдэг норман хүний төлөө нэр зааж хундага өргөхгүй юу. Тэр чинь таны уруулд бас л гашуун санагдвал аяга сайн дарсаар түүнийгээ даруулчихаарай гэв.

Фицурс суудлаасаа босож, Седрикийн сандлын ард ирж зогсон хаан хүү Жоны нэрийг хэлж хоёр овгийн хоорондын эв найрамдлыг сэргээх энэ тохиолдлыг алдаж болохгүй гэв.

Энэхүү тал зассан явууллаганд саксон Седрик хариу юу ч дуугарсангүй, босож хундага дүүрэн дарс аягалаад хаан хүү Жон өөд харан,

- Энэ найран дээр дурсагдахад болохуйц норман хүнийг нэрлэ гэж өндөр дээдэс та айлдлаа. Энэ чинь надад тун бэрх тулгалт боллоо. Боол хүн эзнээ магтах байлдан эзлэгдсэний бүх гай уршгийг амсан байгаа ялагдагч дийлэгчээ сайшаан дуулахтай адил гэсэн үг. Гэвч өөрийнхөө овог удмын хамгийн шилдэг сайн, эрэлхэгүүдийн дунд тэргүүн, зэрэг хэргэмээр хамгаас өндөр, сайн санаат норман хүнийг нэрлэе. Хэн нэг хүн түүний зүй ёсны алдар гавьяаг надтай цуг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал түүнийг би худалч, нэр төрөө барсан этгээд гэж нэрлээд түүнийхээ төлөө амь насаараа хариуцахад болох юм. Хундагаа би арслан зоригт Ричардийн төлөө өргөө! гэв.

Саксон тайж үгнийхээ төгсгөлд өөрий нь нэрийг дурдана гэж хүлээж байсан хаан хүү Жон өөрий нь доромжилсон ахынхаа нэрийг сонсоод зарасхийв. Хундагатай дарс өвч өөрөө мэдэлгүй уруулдаа хүргэснээ энэ гэнэтийн хундагыг зочид хэрхэн угтахыг ажихаар даруй ширээн дээр эргүүлж тавив. Бусад хүмүүс илүү сайхан сэтгэлд хөтлөгдөн "Хаан Ричард мандтугай!" "Бурхны авралаар бушуухан эргэж ирэх болтугай!" гэж хашгиралдав. Зарим хүмүүс, тэдний дотор Фрон де Беф, сүмийн хорооны баатар хоёр хундагандаа гар хүрсэн ч үгүй жигшингүй баргар царайлан сууна. Гэвч хууль ёсны эзэн хааны төлөө өргөсөн хундагыг илэрхий эсэргүүцэж зүрхлэх хүн ганц ч гарсангүй. Давж дийлдсэндээ Седрик сайтар бах ханаад хамт яваа нөхөртөө:

- Сайн төрөлт Ательстан гуай явья. Зочломтгой баян найрандаа эелдгээр урьсан хаан хүү Жоны найрсаг хүндэтгэлийн хариуг барилаа, энд их ч саатлаа. Манай саксончуудын эгэл бор хэв заншилтай танилцъя гэсэн хүн эцэг өвгөдийн маань орон гэрт морилоорой. Хааны найр наргианыг харж ханалаа. Норманы эелдэг аашийг үзэж чадлаа гэв.

Ингэж хэлээд босож тэнхимээс гарахад араас нь Ательстан босоод хаан хүү Жон, шадар бараа бологчдын элэг доог болсон өөрсдийгөө мөн доромжлогдсонд үзсэн зарим саксон зочид мөн гарч одлоо.

Тэднийг явсны дараа хаан хүү Жон,

- Ариун Фомын ясыг барьж андгайлахад энэ саксоны дүлий годилууд чинь өнөөдөр эрүүл тулалдаан дээр гарамгайлаад бас найран дээрээс давчихаад гарлаа шүү? гэв.

- За бид ханатлаа уулаа, их ч хашгиралдлаа. Хундагаа амраах цаг болоо шив гэж ширээт Эймер өгүүлэхэд:

- Лам өнөө шөнө нэг гоо бүсгүйн наминчлал дуулах гэж байгаа даг. Тэгээд л бушуухан явах гэж яараад байнаа гэж де Браси хэллээ.

- Үгүй баатар та эндүүрч байна, би өнөөдөртөө гэртээ харих учиртай юм гэж ширээт хариулав.

Хаан хүү Фицурст шивнэн:

- Зугтан тархаж эхэллээ. Эртнээс хулчийж байна. Энэ муу новшийн ширээт эн тэргүүн намайг орхиж байнаа гэв.

Вальдемар үүнд, - Их эзэн та битгий сэтгэл зов, биднийг Йоркод цугларахад манай талд орохын гарцаагүй чухлыг өөрөө ухаартал нь үг хэлж өгнө. Эрхэм ширээт таныг мөрдөхөөс өмнө би тантай аминчилж ярих үг байна гэв.

- Энэ зуур бусад зочид тархав. Хаан хүүгийн намд багтсан хүмүүс, зарц нар л үлдэв.

Хаан хүү хилэнтэйгээр Фицурс руу эргэж, - Таны зөвлөлгөөний үр дүн энэ байна. Миний өөрийн ширээний ард согтуу, мангуу саксон этгээд намайг давж, миний ахын ганц нэрийг дуулсан төдийгөөр хүмүүс надаас халдварт тахаас зугтаах аятай дүрвэж одлоо гэхэд зөвлөгч нь:

- Их эзэн та тэвчиж үз. Таны ийнхүү зэмлэсний хариуд өөрийн чинь хөнгөмсөг авир миний төлөвлөгөөг эвдэж, таныг ухаалаг хянуур байдлаас гарган алгууруулсан гэж хариу маргаж болохсон билээ. Гэвч одоо чинь нэг нэгнийгээ зэмлэж ёуух цаг биш, де Браси бид хоёр одоо тэр тээнэгэлзсэн аймхайчууд дээр очиж биднээс зайлж одно гэхэд хэт гүн орооцолдсоныг нь нотолж өгөхийг оролдоно гэв.

Хаан хүү Жон сэтгэл ихэд хөдлөн цааш нааш холхих зуур – Дэмий, үүнээс юу ч болохгүй. Харин дээр байсан бичгийг эд уншсан, элсэн дээр арслангийн саварны мөр үзсэн ой мод донсолгосон арслангийн хүрхрэхийг дуулсан. Эдний мохож ирсэн эр зоригийг одоо юу ч сэргээж үл чадна гэв.

Фицурс де Брасид шивнэн – Бурхан өршөөж өөрөө л битгий айж орхиосой. Ахынхаа нэрийг дуулсан төдийд л чичрээд явчих юм. Сайн муу аль ч үйлст нэг чиг барьж хатуу зогсож үл

чадах хаан хүүгийн зөвлөгч байх гэдэг базаахгүй жил байна даа гэлээ.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Зөвхөн зэвсэг, зарцаа гэж бодох нь

Зүгээр хөгийн хэрэг юм даа!

Харин ч бодож л байг яахав.

Хорт өдгийн аашнаас нь үлдсэн

Үймээн самуун, гамшгийн үеэр

Өндөр зорилготой хүрэх замаа олохыг

Өөтүүлж хэн буруушаах юм бэ?

"Базиль" эмгэнэлт жүжиг

Хаан хүү Жоны тархаж задарсан нэгэн санаатныг цуглуулахын тулд Вальдемар Фицурсийн гаргасан их зүтгэлтэй тэнцэх хүчийг урагдсан тороо дахин нэхье гэсэн ганц ч аалз хэзээч ер гаргаагүй билээ. Фицурс тэдний эдэлж байсан илүү эрх ашгийг сануулж шинэ ашиг завшаан олгохоор амлахад хүрэв.

Завхай зайдан залуу тайж нарыг эх хязгааргүй наргиан цэнгэлийн тухай ярьж хорхойтуулан, эрх тушаалд дуртай нэгд хэргэм зэрэг амалж, шунахай хөвгүүдэд эд баялаг болоод газар эдлэн арвижуулж өгнө гэж байв. Хөлсний багуудын тэргүүлэгчид мөнгөн шагнал ч авав. Эргэлзсэн хүмүүсийн түдгэлзээг арилгаж, зүрх дутсан нэгийг урамшуулахад хэрэгтэй бүхнийг хийв.

Фицурсийн хань хамсаатнууд Ричардийн буцаж ирэхээс хамгийн их айх тул тэглээ гэхэд өөрсдийнхөө эрх ашгаас ухрах явдал үгүй ятган үнэмшүүлж гарав.

"Ричард хань нөхөд үгүй ганцаараа ирнэ. Түүний баатар цэргүүдийн яс, Палестины элсээр нэг дүүрсэн, эх орондоо буцаж ирсэн талы нь ганц нэг хүмүүс Уильфред Айвенго шиг тэнэмэл гуйлгачингууд болсон"

"Ричардын хаан ширээ эзлэх эрхийн тухай та нар юунд ярина вэ? гэж Фицурс энэ тухайд зовсон хүмүүстэй марган, - Байлдан дагуулагч Вильгельмийн их хүү хун тайж Роберт мөн тийм эрхтэй байгаагүй гэж үү? Гэтэл хаан ширээг бага дүү нар нь эзлэн, өөрөө кардиффийн цайзанд олзлогдон байгаад нас барж билээ. Хааны ураг цусны хөвгүүд дотроос тайж нарт бусдаасаа илүү ашигтай сайн байх хүнийг сонгож тавих нь бидний эрх Ричард хувийн эрдэм чадлаар хаан хүү Жоноос илүү байж магад. Гэвч Ричард илд барьж өшөө авахаар ирэх, харин Жон шагнал, эрх ямба, эд баялаг, нэр хүнд бидэнд хангаж өгнө гэдгийг хянан үзвэл тайж нар бид энэ хоёрын алиныг дэмжих ёстойгоо ойлгох билээ " гэж байлаа.

Иймэрхүү ятгалгаа хаан хүү Жоны намд нийлсэн тайж нарт зохих сэтгэгдэл төрүүлж олонхи нь Йоркод очихоор зөвшөөрөв. Тэнд тайж нар хаан хүү Жоныг хаан ширээнээ залах

бэлтгэлийн талаар ярилцан тохирох учиртай байжээ. Үдэш орой болсон хойно Вальдемар Фицурс энэ бүхнээр хөөцөлдөн туйлдсан боловч ажлынхаа үр дүнд сэтгэл хангалуунаар Ашби цайзанд хүрч ирэв. Тэнхимүүдийн нэгэнд орж иртэл сайхан гоёлоо халж богинохон ногоон цамц, мөн өнгийн өмд, савхин малгай өмсөж, ташаандаа богино илд зүүж мөрнөөсөө анчны эвэр цоор өлгөн, бүсэндээ баахан сум хавчуулж, урт нум барьсан де Браситай дайралдав. Фицурс түүнтэй үүдний өрөөнд тулгарсан болж гэм жирийн нэг харуулын цэрэг гэж бодохсон билээ. Энд харин хянуур сайн ажигласан хүнд английн Йомены хувцастай норман баатар байхыг танилаа.

- Юун маяг вэ дээ Браси? гэж Фицурс унтууцан хэлээд, - Манай удирдагч хаан хүү Жоны хувь заяа шийдвэрлэгдэж байхад багт наадам болж байгаа юм шиг хувцас хунар сольж маяглаж байх цаг уу? Ричард хааны, нэрийг нь дуулаад сарацин хүүхнүүдээс доргүй их айдаг аймхай хулчгар амьтан руу юунд надтай цуг явсангүй вэ? гэвэл де Браси тайвнаар,

- Фицурс таны өөрийнхөө санал төрлийг хөөцөлдсөний нэгэн адил би бас хувийнхаа ажил төрлөөр хөөцөлдөж байлаа гэв.

- Би тэгж аминыхаа ажлыг хөөцөлдлөө гэж үү? үгүй бидний аль алины эзэн хаан хүү Жоны ажил төрлийг бүтээж явсан шүү гэж Вальдемар дуу алдав.

- Үгүй чи тэгж явахдаа аминыхаа ашиг завшаанаас өөр ямар нэг юм бодож явсан гэж үү? Больж үз дээ, Фицурс чи бид хоёр бие биенийгээ ойлгоно. Чи эрх тушаал эрмэлзэж, би цэнгэл хөөдөг хүн. Хаан хүү Жоны тухай бид мөн адилхан бололтой. Эрс шийдмэг эзэн хаан болно гэхэд хэтэрхий сулхан, дорой, аятайхан эзэн болно гэхэд хэт эзэрхэг, нэр төртэй эзэн болно гэхэд дэндүү биеэ тоосон, хэрцгий, урт удаан хугацаагаар хаан ширээ эзэлнэ гэхэд даанч туйлбаргүй хулчгар хүн юм. Гэхдээ хаан суухад нь Фицурс, де Браси хоёр дээш гарч мандах найдлагатай эзэн мөний тулд та улс төрийн бодлогоороо, би сайн дурын цэргүүдийнхээ хүчит жадны хүчээр түүнийг дэмжиж байгаа хэрэг гэхэд Фицурс унтууцан,

- Сүрхий сайн холбоотон байх гэж! Хамгийг шийдвэрлэх цагт амиа бодох болж маяглаж байдаг! Чи өдий чухал цагт ямар зорилгоор ингэж тэнэгээр зүс буруулж байгаа хэрэг вэ? гэвэл,

- Эхнэр олж авахын тулд гэж де Браси хэнэггүй өчив.

- Эхнэр олж авах аа? Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Фицурс асуувал де Браси хариуд нь:

- Юу гэсэн үг вэ гэвэл энэ хувцастайгаа би Ашбигаас өнөөдөр мөрдсөн саксоны сүрэг бухууд руу дайрч, гоо сайхан Ровенаг тэднээс булааж авах гэж байгаа юм гэлээ.

- де Браси чи солиороо юу? Бодож үзээч, тэд чинь баян, нөлөөтэй хүмүүс. Омог отгийнхон дундаа нэр хүнд ихтэй улс. Язгууртан Саксончууд тун цөөн үлдсэн шүү дээ гэвэл,

- Нэг ч үлдэхгүй байх нь хэрэгтэй юм. Байлдан дагуулсан үйлийг туйлд нь хүргэх ёстой гэж де Браси хэллээ.

- Ямар ч гэсэн одоо тэр тухай санаа тавих цаг биш. Самуун ойртож байна. Бид ард олны талархлыг баттай хүлээх нь чухал. Ард олны хайрыг татсан хүмүүсийг гомдоосон хэнийг боловч хаан хүү Жон залхаахад хүрнэ гэдгийг санаарай гэж Фицурсийг хэлэхэд,

- Яаж тэгж зүрхлэхийг нь харъя! Тэгвэл минийх шиг сайн эрчүүл, тэр саксоны бүлэг тэнэгүүдийн дэмжлэг хир ялгаатайг мэдэх болно. Гэхдээ би өөрийнхөө нэр, цолыг даруй дуулгах гээгүй. Энэ хувцастай байхдаа би эвэр цоор зоримгоор үлдээдэг зоригт анчинтай адилгүй байна гэж үү? Бүх хэрэг Йоркширийн ойн дээрэмчдэд тохогдоно. Би миний тагнуулчид найдвартай, Саксончуудын хаашаа яаж явахыг би мэдэж байна. Өнөө шөнө тэд Трент дахь Буртоны гэгээн Витольдийн сүмд хоноглох юм. Маргааш тэд яг бидний отооны газарт хүрч бид шонхор аятай дайрна. Тэгтэл би гэнэт ердийнхөө хувцастай гарч ирэн золгүй гоо бүсгүйг бүдүүлэг дээрэмчдийн гараас суллана. Ровенаг би Фрон де Бефийн цайзанд хүргэх юм уу хэрэг болбол Норман руу авч одно. Тэгээд Морис де Брасийн хууль ёсны гэргий болтол төрөл саданд нь үзүүлэхгүй дээ гэв.

- Үгүй юу ч гэх вэ, сүрхий л төлөвлөгөө байна. Тэр ч байтугай чи өөрөө үүнийг бодож олоогүй болов уу? гэж санагдах юм. Үүнийг чамд хэн зааж өгсөн, хэн чамд туслахаар болсныг де Браси чи илэн далангүй хэлчих. Чиний өөрийн цэрэг эндээс хол, бараг Йоркод шахуу байгаа байхаа? гэв.

- Үүнийг заавал мэдэхсэн гэж хүсээд байгаа бол тэг л дээ. Энэ ажлыг Бриан де Буагильбер сэдсэн билээ. Буагильбер өөрийнхөө хүмүүстэй дээрэмчид болж довлоход тус болох, би сүүлд нь хувцсаа солиод гоо бүсгүйг тэндээс булааж авах юм гэв.

- Сүнсээ барьж андгайлахад та нарын тэнэг толгойтой дүүсэн төлөвлөгөө байна даа. Гоо бүсгүйгээ хүндэт нөхрийнхөө гар дээр үлдээх гэж байгаад де Браси чиний хянуур болгоомжтой чинь гойд тодорхой харагдаж байна. Саксончуудаас чи бүсгүйг булаагаад авчих аз байж мэднэ, харин түүнийгээ Буагильберийн савраас шүүрээд авч чадна гэдэг тун горьдлого багатай зүйл байна. Цаадах чинь өөрөө мөн шувуу гөрөөлж, олсон олзоо барьж заншчихсан лут шонхор шүү дээ гэвэл де Браси өөдөөс нь:

- Үгүй тэр чинь сүмийн хорооны баатар шүү дээ. Тэгэхлээр тэр саксоны өв хөрөнгөт авхайтай сууж болохгүй. Тэр чинь надтай өрсөлдөгч байхын хэрэг алга_ Харин миний ханилах хүний нэр төрийг бузарлах гэж оролдоно гэвэл... Үгүй түүнийг бүх хороо нь өмгөөлж байлаа ч гэсэн намайг тийнхүү доромжилж эс зүрхлэнэ гэдэгт тэнгэрийг барьж андгайлъя! гэв.

- За би юу ч хэлээд нэмэр алга юм байна. Чиний зөрүүдийг би андахгүй. Ганцхан гуйхад цаг битгий дэмий үр наад цаг үеэ олоогүй тэнэг явдал чинь бушуухан шиг төгсөг гэж Фицурс өгүүлэв.

- Хэдхэн цагийн дараа бүх явдал төгссөн байна, нээрээ шүү. Би сайн эрчүүлтэйгээ Йоркод цагтаа амжиж очоод чиний алив явууллагыг дэмжинэ... За миний нөхөд өдийд цугларчихсан байх учиртай. Арын хашаан дотор тэдний морьдын янцгаах болоод морин төвөргөөн дуулдаж байна. Баяртай. Жинхэнэ эр баатар хүний хувьд гоо бүсгүйг инээмсэглүүлэхээр давхилаа гэв.

Фицурс хойноос нь харан, --"Жинхэнэ эр баатар гэнэ шүү! Чухамдаа гэвэл тэнэг амьтан шиг, хажуугаар нь хийсэн өнгөрөх шувууны өдийг барихаар чухал ажлаа орхидог хүүхэд шиг амьтан. Иймэрхүү улсуудтай нийлж хөдлөх болж байдаг, хэний төлөө тэр билээ тэгээд? энэ хөнгөмсөг завхай зайдан хаан хүүг ширээнд залж өгөв гэж тэр үү, гэтэл дуулгавар муутай хүү, хүний ёсноос этгээд муу дүү байсан шигээ л ач тусыг үл бодох эзэн хаан болох нь магад биз. Үгүй тэгэхдээ тэр чинь өөрөө миний гарт зэвсэг болж өгч байгаагаас цаашгүй хүн шүү дээ. Өндөр язгуураараа хэдий хямсаганавч миний хүслээс явах гэвэл дор нь юм амтагдуулаад өгөх билээ гэв. "

Тэгтэл дотор өрөөнөөс,

- Сайн төрөлт Вальдемар Фицурс! гэж дуудах хаан хүүгийн дуу гарч энэхүү төрийн зүтгэлтний бодлыг сарниулав.

Тэгээд ирээдүйн тэргүүн сайд малгайгаа аваад ирээдүйн эзэн хааны дуудсанаар яаран оров. Тухайлан ийм тушаалд хүрэхийг л энэ овжин норман хичээдэг байлаа.

АРВАН ЗУРАДУГААР БҮЛЭГ

Хорвоогийн үймээнээс хол буйдад

Даянчийн буянт өдрүүд ээлжлэнэ.

Ховор живрээр урцад суун хөвд дэвсэж

Дан жимс, булгийн усаар ундлана.

Бурхан шашинд сүсэглэн хүмүүсээс зайлсхийж

Бүх сэтгэл ганц залбиралд автжээ.

Парнелл

Эрүүл тулалдаан, эхлээд хайш хэрэг, хөшүүнээрээ залхуу хар гэдэг нэр авсан үл таних баатар оролцсоноор үр дүн нь шийдэгдсэнийг уншигч авгай нар мартаагүй бизээ. Айвенгог тэнхрүүлээд баатар даруй талбайг орхин одсонд зарц нар эр зоригий нь шагналыг гардуулах гэж эрээд хаанаас ч олоогүй билээ.

Ийнхүү эрэл болж байх зуур баатар аль хэдийн хойт зүг чиглэн ойн гүн рүү их замаас зайлсхийсээр алс одсон байлаа. Тэрээр их замаас зайдуу байх жижиг буудалд хоноглов. Тэнэмэл хөгжимчнөөс эрүүл тулалдаан чухам хэрхэн төгссөн тухай дуулав.

Дараа өдөр баатар алс зам туулахаар зорин эрт мордов. Урьд өдөр нь морио машид хайрлаж байсны ачаар одоо сааталгүй явах бүрэн боломжтой байлаа. Гэвч зөрөг зам даанч ээдрээтэй тул зорьсонд нь саад болно. Бүрэнхий болж ирэхэд дөнгөж Йоркширийн баруун зах хүрсэн ажээ. Хурдан харанхуй болж, морь нь их сульдав. Хоноглох газрын тухай бодохоос өөр аргагүй болжээ.

Баатрын хүрсэн тэр нутагт хорогдох орон, үдшийн хоол олгох газар даан ч үгүй байлаа. Морио тавьж идээшлүүлээд өөрөө царс модон дээр хэвтэхээс өөр аргагүй болов бололтой.

Өнөө хүртэл баатар нараар замаа баримжаалж явсан атал Дербиширийн толгодын цаагуур нэгэнт шингэсэн болохоор зам төөрөхөд хялбар болов. Одоо дардан зам олж, малчны овоохой, ойн манаачийн байшин дайралдах болов уу гэж дэмий горилно. Бүх оролдлого дэмий болохоор баатар нэгэнт өөртөө итгэхийг больж мориныхоо зөнд итгэхээр шийдэв. Морь зөв зам олох зөнгөөр маш сайн байдгийг баатар өөрийнхөө туршлаганаас мэдэх бүлгээ.

Байлдааны өвч хуяг дуулгатай эзнийхээ хүндэд туйлдаж явсан сайн хөлөг жолоо суларснаар замыг өөрөө мэдэх болсныг гадарлаад хүч чадал хувь илүү сэргэж ирэх мэт болов. Өнөө болтол давирах шавдуулахын хариуд өрөвдөлтэйгээр янцгааж байсан бол одоо итгэл хүлээлгэсэнд бахдах мэт чихээ солбин алхаагаа нэмлээ. Сонгож авсан зөрөг нь түрүүчийн замаас эрт хазайлаа. Морио маш итгэлтэй алхахыг хараад баатар жолоогоо залсангүй.

Ийнхүү найдсан явдал зөв байсан нь сүүлдээ мэдэгдэж зөрөг төдхөн дардан зам болов. Том хонхны бүгт дуу гарах нь ойр нэгэн газар мал сүрэг юм уу харуул байгааг гэрчилнэ.

Төдөлгүй баатар талбай руу гарч ирсний цаад талд салхинд идэгдсэн цавчим бор хажуутай зузаан хаганд дарагдсан том цохио харагдав. Хаа нэг газар царс, бут ургасан нь энэ сүрлэг хаданд баатрын ган дуулган дээрх цацаг адил хээнцэр чимэг болох ажээ. Цохионы бэлд хажуугийн ойгоос авсан дүнзээр барьсан овоохой байв. Үүдний өмнө мөчирлөсөн залуу нарс хатгаад дээр нь хөндөл хийж загалмай болгосон харагдана. Жаахан баруун тийшээ цохионы ангаас тунгалаг булаг ундарч тогоо маягтай болон элэгдсэн том чулуун дээр гоожсон ажээ. Булгийн тэнд дээвэр нь унаж, нурчихсан жижиг дуган харагдах бөгөөд энэхүү дээр цагийн мөргөлийн газарт орох намхан үүдийг чулуун шүд гарган чимжээ. Дөрвөн жижиг баганын дээрх цамхаган дотор цагийн удаанаас бороонд ногоорсон хонх дүүжлээтэй харагдана. Энэ хонхны сулхан дууг Хар баатар ойгоос чагнажээ. Явуулын хүний нүдэнд энэ амар тайван байдал үдшийн бүрэг барагт харагдаж, ойд нямбалан суух санваартны нэг үүрэг нь оройтсон явуулын хүмүүс юм уу, төөрсөн улсыг хоноглуулах явдал байдаг болохоор хорогдох газар оллоо гэдэг бат итгэл төрүүлжээ.

Явуулын баатар мориноосоо буун харайгаад найдвартай хорогдох газар олгож хайрласан явуулын хүмүүсийг ивээгч гэгээн Юлиад талархаж залбирав. Тэгээд жадныхаа ишээр овоохойны үүдийг тогшив.

Өнө болтол хэн ч хариу дуугарсангүй. Тэгж тэгж дотор талаас сөөнгө бүдүүн дуугаар,

- Явж өнгөр, гэгээн Дунстан болоод бурхны өчүүхэн санваартны оройн залбиралд бүү саад бол гэх нь сонсогдов.

Баатар үүнд, - Багш ламтан, би энэ ойд төөрсөн явуулын нэг ядуу хүн байна. Өршөөл, өглөгөөр хүнд тус болж буян үйлдэх завшааныг та ашиглана уу? гэв.

- Овоохойн эзэн хариуд нь сайн хүн гуай дарь эх болоод гэгээн Дунстаны тааллаар би өглөг хишиг хүртээх нь байтугай өөрөө бусдаас горилох учиртай болжээ. Би нохой ч тоож шиншихгүй юмаар гол зогоож, эздийн саравчинд сурсан ямар ч морь үл тоох хатуу дэвсгэр дээр унтдаг билээ. Иймд замаараа өнгөр, бурхан таныг өршөөх болтугай гэв.

Баатар үүнд, - Ийм их ой хөвчид, бас тэгээд харанхуй шөнө болчихсон хойно би яаж зам олох билээ? Шударга явдалт багш та христос шашинтан хүн мөн ахуул үүдээ тайлж, аль зүгт явбал зохихыг ядаж зааж өгнө үү гэвэл нямбаны лам өөдөөс нь:

- Нэгэнт шажинт хүн та өршөөж, намайг бүү шал! Адгийн нүгэлт хүн би тавьсан андгайныхаа дагуу сар мандтал унших учиртай байсан мөргөлд та нэгэнт их саад боллоо гэв.

Баатрын дэргүй хүрч, Зам! Зам заагаад аль! Илүү их юмаар итгүүлдэггүй юмаа гэхэд зам заагаад өгч үз! гэж хашгирав.

- Зам заахад амархан. Зөргөө дагаж явсаар ойгоос гармагц намаг бий. Цаана нь гол дайралдана. Ойрын өдрүүдэд бороо ороогүй, гатлаад гарчихаж болох байх. Гармаар гараад

зүүн эргээ дагаад яв, харин доошоо уначихав. Их хэцүү шүү. Бас зөрөг, зарим газраа нураад, гэтэл баатар үгийг нь таслан:

- Энэ чинь юу гэсэн үг вэ, зам нурсан, хэц, гарам дээр нь бас намаг байдаг! Үгүй, даяанч гуай та гэгээн хувилгаан хүн байлаа ч гэсэн ийм замаар шөнө гаргаж чадахгүй би учир ярьж байна... Чи айл хөршийнхний өглөгөөр амь зуудаг болохоор төөрсөн явуулын хүнийг хоргодуулахаас татгалзах эрхгүй. Үүдээ бушуухан онгойлго, үгүй бол бурхны нэр барьж андгайлахад би хэмх цохиод орно шүү! гэв.

- Нөхөр минь надад тээр болохоо больж үз. Чи намайг албадаж байж, ердийн зэр зэвсгээр биеэ хамгаалахад хүргэвэл өөрт чинь муу болох байх шүү гэлээ. Яг энэ зээр бүгдхэн архирч, хуцаж байгаа нь явуулын хүнд аль түрүүний дуулдаж байсан ноход боргоож эхлэхэд хүчээр орно гэж сүрлдүүлсэнд айсандаа даянч дуган дотор байсан нохдоо дуудсаныг гадарлаад, ийнхүү зэхсэнд нь уурлаж овоохойн хана, баганыг доригтол айхавтар өшиглөв.

Даянч үүдээ дахин ингэж өшиглүүлэхээс болгоомжлов бололтой чанга дуугаар,

- Жаахан тэсэж үзээч! Явуулын сайн хүн та хүлээзнэ. Би одоохон үүд тайлж өгнө. Харин үүгээр таныг баярлуулна гэж баттай хэлж чадахгүй дээ гэж хашгирав.

- Үүд нээгдэж даяанч баатрын өмнө гарч ирсэн нь нуруу өндөр, чийрэг, урт таар мушигмал сүрлээр бүслэн өмсчээ. Нэг гартаа асаатай бамбар, нөгөө гартаа бүдүүн том шийдэм барьсан бөгөөд хоёр талд нь сахлаг том хоёр нохой эзнийгээ дохио өгмөгц урилгагүй зочин руу дайрахад бэлхэн зогсоно. Харин бамбарын гэрэлд өндөр дуулга, баатрын алтан давируул гялсхийхэд даяанч анхны санаагаа орхиж, давшилсан нохдоо хориод, гэгээн дарь эх, хутагт Дунстанд үл шүтэх учир ариун явдалт даяанч нарыг үл өршөөх хулгай, дээрэмчдээс айгаад үүдээ нээхээс татгалзсан билээ гээд баатрыг орно уу гэж эелдгээр урив.

Хоёр бүдүүн бараг вандан сандал, ширээ, судар, модон загалмай, дэвсгэр болох бөөн хуурай навчиснаас өөр юу ч үгүй овоохойн дотоод байдлыг ажигласан баатар, - Гэхдээ багш та тун ядуу, дээрэмчдээс айх зүйлгүй юм шиг санагдана. Тэгээд ч танай ноход чинь хүнийг байтугай буга барьчихаар айхавтар амьтад байна шүү дээ гэсэнд даяанч хариуд нв:

- Ойн манаач нэг сайн хүн цаг тайван болтол надад хань болгож эднийг авч ирж өгсөн юм гэлээ.

Ингэж хэлээд бамбараа тавиур болох тахир төмөрт суулгаад гурван хөлтэй царсан ширээ галд ойртуулж тавин унтарч байгаа цогон дээр хэдэн хуурай цуцал хаяад сандал ширээ рүү дөхүүлэн баатрыг өөдөөсөө харан суухыг урив.

Хоёул суугаад хэсэг зуур бие биеэ хянуур ажиглав. Энэ үед өмнөө сууж байгаа шиг ийм булиа хүнтэй ховорхон дайралдсан тухай тус бүрдээ бодож байлаа. Эзэн рүү удтал хянуур харж байсан баатар ам нээж,

- Эрхэм даянч ламтан таны буянт бодолд дахин нэг саад болохыг зөвшөөрнө үү. Гэгээн багш танаас гурван зүйл асуумаар байна. Нэгд морио хаана тавих вэ, хоёрт идмээр юм байна уу,

гуравт би хаахна хэвтгэж болох вэ? гэвэл даяанч хариуд нь:

- Дохиогоор ойлголцож болох зүйл дээр үг хэрэглэхгүй гэдэг ёс баримталдаг болохоор би зангаж хариульга гээд овоохойныхоо хоёр хаяа руу заан – Морины саравч, хэвтгэх газар чинь тэр байна, оройн хоол гэвэл энэ дээ гээд тавиур дээрээс хоёр атга хир хатаасан вандуйтай таваг авч ширээн дээр тавилаа.

Баатар мөрөө хавчисхийгээд гарч морио оруулж эмээлийг нь аятайхан авч цуваараа нэмнэв.

Үл таних хүн морио нямбайлж чадмагаар арчлах нь даянчид таалагдав бололтой. Ойн манаачийн моринд өгөөд үлдсэн өвсний тухай нэг юм амандаа хэлээд нэг газраас баглаа өвс авч ирэн баатрын моринд тавьж өглөө. Мөн нэг тэвэр хуурай ойм авч ирж баатрын унтах газар хаяв. Түүний ингэж сайхан зан гаргасанд баатар эелдгээр талархав.

Эд бүгдийг хийж дуусаад вандуйтай таваг тавьсан ширээнд хоёул дахин суулаа. Даянч урт залбирал уншиж дуусаад амандаа гурав дөрвөн ширхэг вандуй хийж сайн үлгэр өгүүлэв. Гахайн соёо шиг бат цагаан шүдэнд, энэ вандуйн даанч бага, ийм том сайн тээрмэнд тун ч ялигүй тариа гэжээ.

Энэ сайшаалтай үлгэрийг чагнахаар зочин дуулга, хуяг болон ихэнх өмсгөлөө тайлав. Даянчийн өмнө цайвардуу буржгар хүрэн үс, бүргэд хамартай сэргэлэн гялалзсан цэнхэр нүдтэй, үснээсээ арай харавтар сахал бүхий цэвэрхэн уруултай бүх төрх галбир нь эрс зоримог, авхаалжит хүн болохыг илтгэсэн сайхан дайчин эр гарч ирэв.

Зочны итгэмтгийд мөн цагаан зангаар хариулахыг хүсэн даянч юүдэнгээ ар тийш унагааж бөмбөг шиг бөөрөнхий толгойгоо ил гаргав. Толгойныхоо оройг хусаж, ширүүн хар үс тойруулан ургуулсан нь төсөөтэй болжээ. Царай нүүр нь хувраг хүний ширүүн дүр, санваар сахисан онцлог шинж үгүй ажээ. Харин ч эршүүд эрүүл саруул хүний улаа бутарсан царайтай, хөмсөг харж, бужгар хар сахал ургуулжээ. Даянчийн энэ нүүр царай, булиа хүдэр биеийг үзвэл вандуй шош төдийхэн иддэг биш амттай сайхан мах гахайн өөх л идэж байдаг байж таармаар. Энэ авцалдаагүй байдал зочинд үл анхаарагдан өнгөрсөнгүй.

Атга хир хуурай вандуй арайхийн идсэний дараа хойноос нь уух юм өгөхийг ариун явдалт эзнээс гуйхад хүрэв. Даянч том аяга дүүрэн булгийн мэлтэлзсэн тунгалаг ус өмнө нь тавив.

- Энэ чинь гэгээн Дунстаны дуганаас авсан юм шүү. Ганцхан өдөр наран мандахаас аваад шингэх хугацаанд гэгээнтэн тэнд буруу номтон дани, британи таван зуун хүнийг үнэн шажинд оруулан загалмай зүүлгэж байсан түүхтэй юм гэв.

Ийнхүү хэлээд хар сахлаа аяганд наан бага шиг балгав. Баатар үүнд, - Эрхэм багш таны тачиг хоол, ариун боловч амтгүй энэ ундаа танд гайхалтай сайхан ариун боловч амтгүй энэ ундаа танд гайхалтай сайхан зохидог юм байна. Өөрийг тань харахад буйд газар нямбалан сууж мөргөл үйлдэн хуурай вандуй хүйтэн усаар гол зогоож суухаасаа илүү шударга юм уу шийдмээр үзэлцэж явахад зохисон хүн харагдана гэвэл даянч өөдөөс нь:

- Ээ эрхэм баатар та мөн учир үл ухах хар хүмүүсийн нэгэн адил зөвхөн махбод л гэж ойлгож

байна. Би бүгдийн эзэн дарь эх болоод миний гэгээн тэтгэгч нар таалж ховор тачиг хоол ундыг чинь адислаж гийгүүлдэг юм гэв.

- Ариун явдалт багш аа! бурхан үнэхээр таныг ивээн ид шид үзүүлдэг ажээ. Иймд нүгэлт муу хар хүнд алдрыг тань мэдэхийг зөвшөөрнө үү? гэж баатрыг хэлэхэд,

- Намайг Копмангерст тахилчин гэж дуудаж болно гэвэл, эндэх нутгийнхан тэгж нэрлэдэг билээ. Үнэндээ энэ нэрэн дээр бас ариун явдалт гэдэг үг нэмдэг боловч ийнхүү өргөмжлүүлэхэд өөрийн биеийг өчүүхэнд үзэн заавал тийнхүү дуудуулахыг хичээхгүй. Харин хүндэт зочноо би хэрхэн дуудвал зохихыг эрэлхэг баатар та надад хэлж өгөхгүйсэн болов уу гэв.

- Копмангерстийн ариун явдалт тахилчин гуай, энэ нутагт намайг хар баатар гэдэг бөгөөд бас олон хүн дээр нь залхуу гэдэг цол нэмэрлэдэг авч би мөн ялгаагүй үүнийг заавал хэлүүлэх ч гэж хичээхгүй гэв.

Ийм хариу дуулаад даянч арайхийн инээмсэглэлээ нууж өнгөрөв.

- Залхуу баатар та ухаалаг хянуур хүн харагдана, тэгээд ч хувраг хүний тачиг муу хоол сэтгэлд чинь эс таалагдах бололтой. Ордны элбэг хээнцэр амьдрал хот газрын хэт бялхаж цалигсан байдалд дассан хүн байж болох ... Эндхийн ойн манаач энэ нохдыг надад хүргэж ирээд цамхгийн тэнд мориныхоо тэжээлийг тавьж байхдаа жаал идэж уух юмны нөөц энд үлдээсэн шиг санагдах юм, эрхэм залхуу гуай. Би өөрөө тийм юм хэрэглэдэггүй болохоор бараг таг мартчих дөхөж гэв.

- Лав тийш байж таарна! гэж баатар дуу алдаад, - Ариун явдалт тахилчин таныг юүдэнгээ авсан цагаас аван энд илүү сайхан хоол байдаг юм байна гэдэгт үнэмшсэн билээ. Чиний тэр манаач чинь сэтгэл сайхантай, наргианч эрч болов уу гэж бодогдоно. Ер нь тэгээд чиний бат сайхан шүд энэ вандуйг мэргэ, энэ тунгалаг ус балгаж суугааг чинь харсан хэнд боловч ийнхүү морины тэжээлээр гол зогоосон хэвээр орхилгүй арай амтлаг юм авч ирж өгөх санаа төрөх бизээ. За тэр манаач юу авчирсныг бушуухан шиг гаргаач гэлээ.

Даянч энэхүү зочинтой илэн далангүй загнах нь зөв эсэхийг үл мэдэн тээнэгэлзэх байртай баатар өөд хянуур гэгч харав. Баатар зоримог цайлган царайтай, наргианч цагаахнаар инээмсэглэх нь өөрийн эрхгүй эзэнд таалагдан итгэл төрүүлнэ.

Хоёул дуугүй бие биенээ харснаа даянч овоохойны хойт мухарт очиж нууц пин онгойлгон тугалган тавган дээр жигнэсэн лут том бялуу гаргаж ирлээ. Бялууг ширээн дээр тавихад зочин цаг үрэлгүйгээр хальсыг нь чинжаал хутгаараа зүсэн дотор нь юу хийсэнтэй нь танилцав.

- Тэр сайн манаач наашаа ирээд хир удаж байгаа юм дээ? гэж нэмэлт хоолноос баатар үмхэх зуур эзнээс асуухад даянч:

- Хоёр сар хиртэй өнгөрч байгаа байхаа гэж хариулав.

- Чухамхүү бурхныг барьж андгайлахад чиний овоохойд байн байн л ид шидийн зүйлтэй тулгарах юм. Энэ бялууг өөхөөр нь амталсан тарган буга саяхан болтол ойгоор гүйж явсан гэдэгт би тангараг тавихад ч бэлэн байна гэв.

Даянч үүнд жаал тулгамдаж зочны ум хумгүй дайран дороо багасгаж байгаа бялууг харан тун ч өрөвдөлтэй суух ажээ. Мацаг барьдаг тухай өдий төдий юм ярьсны эцэст бялуу руу зочинтой уралдаад орчиход эвгүй байжээ

Баатар гэнэт идэхээ болиод, - тахилч гуай, бие Палестинад очсон хүн, тэгээд тэндхийн заншлаар бол гэрийн эзэн хүн зочноо дайлахдаа хоолонд хор байхгүй гэдэгт итгүүлэхийн тулд өөрөө заавал идэлцдэг учиртай нь санаанд оров. Ариун явдалт хүнийг урвагч муу үйлд би хардаж хэдийгээр зүрхлэхгүй авч дорнотын энэ заншлыг та дагас аваас ихэд баярлах байна гэв.

- Эрхэм баатар таны энэ зохисгүй сэжгийг арилгахын тулд энэ удаа би санваараа зөрчихийг зөвшөөрье гээд тэр цагт сэрээ гэж үгүй байсан болохоор хуруугаа даруй бялууны доторхи руу дүрэв.

Эвгүйрхэх байдал ийнхүү арилж, ёсорхог занг орхимогц эзэн, гийчин хоёр хэн хэн нь овоо шиг иддэг эр болохоо үзүүлэхээр өрсөлдөж гарав. Зочин хэдийгээр өлсөж явсан нь илт авч даянч түүнээс нилээд давуутай идэх ажээ.

Баатар идэж цадаад, - Ариун явдалт тахилчин гуай, энэ сайхан хоол идүүлж гийгүүлсэн тэр манаач, ийм амтлаг хоолыг зүй ёсоор дагуулж уух шил дарс юмуу торх дарс мэтийн юм заавал үлдээсэн гэж би морио сохор зоостой дүйн мөрийцэхэд бэлэн байна. Энэ тун өчүүхэн явдал болохоор өнө удаан мацаг барьж сурсан хүний ой тойнд лав өршөөж үлдээгүй бизээ. Харин чи тэр пиндээ олигтойхон шиг эрж үзвэл миний тааварласан лав зөв болохыг үнэмших бий гэв.

Даянч хариу хэлэхийн оронд инээвхийлээд авдран дотроосоо хагас хувингийн хир багтаамжтай ширэн борив гаргаж ирлээ. Дараа нь шарын эврээр хийсэн, мөнгөн тоногтой, хоёр том хундага авч ирж мэлтэлзтэл дүүргээд "Эрхэм залхуу баатар таны эрүүл энхийн төлөө!" гэж хэлээд нэг амьсгаагаар хөнтөрч орхисон нь одоо зовж нэрэлэхийн хэрэг нэгэнт үгүй гэж үзжээ.

- Конмангерстийн ариун явдалт тахилч таны эрүүл энхийн төлөө гэж баатар хариу дуугараад хундагаа мөн хоослов.

Дараа нь явуулын хүн өгүүлрүүн, - Ингэхэд ариун явдалт тахилчин гуай тань шиг ийм эрүүл чийрэг, идэж уухдаа сайн лут эр, буйд газар ганцаар сууя гэж юунд бодсоныг яагаа ч ойлгохгүй юм. Миний бодоход чи цайзанд сууж өвч усаар өл залгах юм уу аль нэг манаачийн өглөгөөр гол зогоохын оронд өөх тостойг идэж, хатуу чангаас ууж явмаар хүн санагдана... Би ч чиний оронд байсан бол хааны анг агнан зугаа цэнгэл, хоол хүнс олж байхсан. Энэ ойд хамгийн сүрэг баян, тэр дундаас гэгээн Дунстаны санваартны хүнсэнд орсон бугыг үгүйлэх хүн ер байхгүй гэвэл,

- Залхуу баатар та аюултай санаа хүнд төрүүлж байна шүү. Иймэрхүү үг хэлээгүй нь дээр. Би эзэн хаан, хууль зүйн өмнө үнэхээр даянч хүн. Би эзнийхээ ан гөрөөг завших гэвэл шоронгоос, магадгүй дүүжлүүрээс хэлтрэхгүйд хүрэх шүү дээ гэв.

Баатар үүнд, - Гэлээ гэхдээ би л чиний оронд байсан болж гэм ойн харгалзагч, манаач нар унтаад өгдөг сартай шөнөөр гарч, залбирал уншсаар ногоон зүлгэн дээр билчигч зэгэл буганы сүрэг рүү ганц нэг сум тэсэлгүй тавьчихаад байхсан. Ариун явдалт тахилчин та миний эргэлзээг тайлж өг, үнэхээр чи иймэрхүү ажил хэдийд ч үйлдээгүй гэж үү? Гэхэд,

- Залхуу найз минь, чи миний аж ахуйн тухай бүгдийг тэр ч байтугай хүчээр дайрч орж ирсэн зочны мэдвэл зохихоос илүүг олж мэдсэн билээ. Миний үгэнд итэг, бурхны илгээсэн зүйлийг хаанаас гарч ирснийг нь асууж шалгаалгүй зоогло. Сэтгэлээ ханатал хундагаа дүүргэж, танхай асуудал тавихаа больж үз. Эсвэл, миний сайн дур байгаагүйсэн бол чи хорогдох газар олохгүй байсан гэдгийг үзүүлж үнэмшүүлэх болно шүү гэлээ.

- Үгүй нээрээ эд бүгд улам ч хэрэгт дурлах сэтгэл төрүүлж байна гээч. Урьд өмнө учирч байгаагүй их нууц, учиртай даянч юмаа чи. Салахаасаа өмнө чамтай ойр дотно танилцмаар байх юм. Харин сүрдүүлж байгаагийн чинь тухайд гэвэл аюулыг хаана байгаа газраас нь эрж олох гэдэг миний эрхлэх ажил бүлгээ, ариун явдалт хүн гуай гэв.

- Даянч үүнд, - Залхуу баатар таны эрүүл энхийн төлөө ууя! Би чиний эр зоригийг ихэд үнэлэвч даруу зангаар тун муу хүн юм гэж ойлгож байна. Хэрэв надтай адил зэвсгээр үзэлцэх юм болж гэм, нөхөр ах дүүсэг сэтгэлээр бүтэн арван хоёр сар хэт хэрэгт дурлах муу нүглээс ангижиртал чинь болгож тавих билээ гэв.

Баатар цуг ууж, ямар шүү зэвсэг сонгож авахаа хэлнэ үү гэвэл даянч хариуд нь:

- Чамтай үзэлцэхэд хир дутах тийм зэвсэг гэж ер үгүй... зэвсэг сонгох эрхийг чи надад олгож байгаа болохоор иймэрхүү нэг яльгүй юмны тухайд юу гэх вэ? найз минь гээд өөр нэг пин онгойлгон Йоменүүдийн хэрэглэдэг хоёр илд, хоёр бамбай гаргаж ирэв. Хөдлөхийг нь ажиглаж байсан баатар хоёр дахь нууц пин дотор хоёр гурван сайн нум, цахиур буу, хэд хэдэн овоо, хараа зургаан ширхэг сум бүхий саадаг байхыг харав. Хувраг хүнд байж зохихгүй бусад хрэгслүүдийн дотор харанхуй пингийн гүнд босоо ятга хөгжим байх нь нүдэнд туслаа.

- За тахилч найз минь, цаашид сэтгэлд чинь таагүй юм шалахаа болих ам өгье. Энэ шүүгээнд байгаа юмс миний бүх гайхаж байсан зүйлсийг аяндаа тайллаа. Түүнээс гадна энд би нэг юм үзлээ, гээд бөхийж ятгыг аван - Үүгээр би өөртэй чинь сэлэмнээс илүү дуртайяа үзэлцмээр байна гэв.

- Эрхэм баатар таныг залхуу гэж дэмий нэрэлсэн бололтой. Үнэнийг хэлэхэд чи ер нь тун сэжигтэй хүн шиг санагдана. Гэлээ гэхдээ чи манайд гийчин болохоор чиний эр зоригийг өөрийг чинь хүсэхээс нааш туршиж үзэхгүй. Суу хундагаа дүүрэг, ууж дуулж наргия. Сайхан дуу мэддэг бол гэгээн Дунстаны дуганд намайг даамал байх цагт л хэзээд таатай зочин байх болно. Энэ чинь бурхан таалбал миний бор жанчийг тайлж, ногоон хөвдөөр хучих хүртэл үргэлжилж болно. Чи юунд уухгүй байна, аягаа дүүрэг, наад ятгыг чинь мөд хөглөж амжихгүй. Аяга сайн дарснаас илүү хоолой засаж, чих сонор болгодог зүйл ер үгүй. Миний

хувьд гэвэл дарс хурууны үзүүрийг хүртэл ирвэгнүүлж ирэхэд би дуртай, тэгвэл ч овоо хөгжимддөг хүн гэв.

Урцандаа би оройн цагаар

Унтахын өмнө ном уншдаг

Ариун гэгээн явдлын тухай номонд нь

Аль олныг өгүүлсэн байдаг юм

Харин би гэрлээ унтраасан хойно

Хийдийн сүлд магтаал намуун дууддаг.

.....

Бадарчин саваа авч бариад

Бүх цэнгэлээс хэн эс зугтаахав.

Алив хоосон зугаа үймээнээс

Амар тайвныг хэн илүү эс үзэх болов?

Уортон

Гийчин зочломтгой даянчийн үгийг ёсчлон дагасан авч ятгыг хөглөх гэж арай ядан их л удаан оролдов.

- Ариун явдалт багштан, миний бодоход нэг утас энд үгүйгээс гадна, байгаа нь их муудсан юм шиг гэвэл даянч өөдөөс нь,

- Уухай чи үүнийг бас ажиг уу? Тэгвэл чи үүнд сайн хүн байж таарах нь гээд даянч ихэмсгээр тэнгэр өөд харан алимны шүүс, дарс хоёр л хамаг юманд гай болсон хэрэг_ Хойт зүгийн нэг дуучин Лоцинын Алленд долоон аяга дарс уусны сүүлд ятга хөгжимд гар хүрээгүй нь дээр гэж хэлсэн билээ. Тэгэхгүй бол эвдэнэ гэсэн үг. Тэр гэж хачин зөрүүд, үг нийлэхийн аргагүй амьтан... За найз минь таныг сайхан хөгжимдөхийн төлөө ууя гээд шотландын тэр дуучны хир хэмжээ үл тохируулдгийг санан толгой сэгсрэн байж аягаа ихэмсгээр хоослов.

Энэ зуур баатар утсуудыг оролдон байж янзлаад хэдэн аяга дарсны дараа провансалийн сирвентыг юмуу францын виремийг дуулах уу, аль эсвэл английн уянгын дуу дуулах уу, алинд нь дуртай вэ? гэж эзнээс асуувал даянч хариуд нь,

- Уянгын дуу, уянгын дуу, эрхэм баатар минь би цэвэр Англи хүн. Миний ивээлт гэгээн Дунстан шиг л англи хүн. Миний байранд зөвхөн Английн дуу л дуулж болдог юм гэв. Баатар санал нийлж, - За сайн, ариун газарт танилцсан нэг саксон хүний зохиосон уянгын дууг санахыг оролдъё гэв.

Баатар айхавгар сайн дуучин гэгдэхгүй ч гэсэн сайн багш нарын нөлөөгөөр дунд талтай болжээ. Угаас бүдүүн баргилдуу цуурай багатай хоолойгоо сайтар зүгшрүүлэн тогтоожээ. Иймд манай даянчаас илүү чанд өөлөх уянга ч хүнд ч гэсэн таалагдахаар дуулах ажээ.

Дайчин алдраа мандуулсаар

Палестинаас тэр иржээ.

Дайн тулааны шуурган дунд

Загалмайнхаа алдрыг мандуулжээ.

Ирт мэсийн үзүүрээр

Бамбайд нь хортон суужээ.

Ирэхдээ тэр, үүрийн бүрийгээр

Ийнхүү нэгийг дуулжээ.

“Харийн орноос чамдаа би хүрч ирлээ.

Хайрт минь! олз омог над ер хүртсэнгүй.

Сайн хөлөг, жад илднээс өөр баялаггүй би

Сайхан чамдаа эр цагийн инээмсэглэл л авчирлаа.

Элэг зүрхнээсээ чамайгаа бодож дайтаж явлаа.

Эзний оронд чи л ганцаараа хайрлагдаж суулаа.

Олны сэтгэл татсан ганцхан чиний төлөө

Омог эрс жадаа зөрүүлснийг зарц нар дуулна.

Хаан Султаныг ус уух хувь заяа дутахад

Магомет бурхан чи аварч чадсангүй.

Харин чиний үгнээс олон буруу номтонг

Миний илд тонилгон дарж чадсан юм.

Хонгор минь ялалтынхаа алдрыг чамдаа бэлэглэе.

Хойшдоо нэр төр над ер хэрэггүй.

Шөнийн шүүдэр цэцэрлэгт буучлаа.

Хаалгаа шалав нээгээч!

Сери нутгийн халуунд дасчээ.

Жавар хайрч байна.

Өргөөнийхөө үүдийг нээж түргэхэн оруулач!

Өр зүрхнийхээ бэлэг болгож алдар нэрээ өргөө.

Энэ дууг аялж байх зуур нямбаны лам шинэ дуурийн анхны тоглолтон дээр байгаа мэргэжлийн шүүмжлэгч шиг аашилж суудлынхаа арыг налан нүдээ аньсхийн хуруу гараа хөдөлгөж байснаа гараа нэг алдасхийн хөгмжийн аяар намуухан дохино. Зарим ая өндөрсөж, нарийн нугалаа хийхэд баатрын дуу сайн хүрэхгүй мэт санагдсан газарт нөгөө хоолой нийлүүлэн өргөлцөнө. Уянгын дууг дуустал дуулмагц сайхан дуу, гойд сайн дууллаа гэж даянч шуудхан дүгнэв.

- Ганцхан чамд хэлэхэд, манай нутгийн саксончууд хэт удаан норманчуудтай хутгалдсаар байгаад норман галбирын гунигт дуу зохиох болсон шиг санагдана. Сайн баатар юугаа хийж орон гэрээсээ явсан хэрэг вэ? Эзгүй хойгуур хайртай бүсгүй нь өрсөлдөгчтэй нь гэрэлчихнэ гэж бодсонгүй гэж үү? Гэхдээ эрхэм баатар таны эрүүл энх болоод бүх үнэнхүү хайр сэтгэлтнүүдийн амжилтын төлөө уяа гэснээ сэтгэлийн энэ олон үгэнд толгой нь дөжирч эхлэх шиг болсон баатар хундагаа дарсаар биш аягатай уснаас хийж дүүргэхийг үзээд, - харин таныг тэдний нэг биш биз гэж би айж байна хэмээн нэмж хэлэв. Баатар үүнд, - Үгүй чи л үүнийг өөрийгөө өршөөн хамгаалагч Дунстан гэгээний ариулсан булгийн рашаан гэж надад хэлсэн биш билүү? гэхэд Даянч хариуд нь:

- Тийм нь ч тийм. Гэгээн буруу номтныг хэдэн зуугаар нь энэ усаар ариутган загалмай зүүлгэж байсан. Гэхдээ өөрөө харин энэ уснаас ууж байсан гэдгийг би ер дуулаагүй. Энэ хорвоо дээр цаг, юм бүхэн өөрийн зохиосон орон цаг, тавилантай байдаг билээ. Дунстан гэгээн наргиантайгаар санваар сахих гуримыг лав биднээс дор мэдэж байгаагүй дэгээ гэв.

Ингэж хэлээд ятга хөгжим авч доорхи учиртай дууг аялж зочноо зугаацуулав.

Хөл нүцгэн гэлэнгийн дуу

Хэдхэн жилд хорвоо, ертөнцийг тойрч

Испани, Визянтин орлоо ч гэсэн чи

Хэт хол далай тэнгисийг гаталж

Хэн хүнгүй уулзан учирлаа ч чи

Хөл нүцгэн гэлэнгээс илүү жаргалтай

Хүн амьтныг олж харж чадахгүй

Сайхан бүсгүйн төлөө дайлаар мордсон эрчүүлийг

Шархлаад ирвэл гэлэн л хойтохы нь уншина.

Хөөрхий тэр бүсгүй нь нулимс унагаан байвал

Хөл нүцгэн гэлэн л тайтгаруулан сууна.

Хаад ноёд, эрхэмсэг гоёлоо гэлэнгийн жанчаар солих ёс буй

Харин, тэгтэл хааны суудалд суух гэлэн гэгч үгүй

Амьдрал нь чөлөөтэй, юм бүхэн түүнийх

Айл бүрд залагдан, дуртай газраа хононо.

Амтаг хоол өрүүлж хүндэт зочин шиг дайлуулна.

Аагтай дарс сөгнүүлэн, зөөлөн хөнжил засуулна.

Энэ бүхэн шашин номын тэмдэг

Элэгдэж салбарсан муу жанчны нь л ач аа.

Аяа, гагцхүү хөл нүцгэн гэлэн гээч мөөн!

Баатар энэ дууг сонсоод үнэхээр наргиантай сайхан дуулж, бадарчин нэрээ зохих ёсоор мандуулж чадлаа. Үгүй чөтгөр гэхээс яг нэг иймэрхүү хилэнцэт үйл үйлдэж суух үеэр чинь танайд биеэрээ морилоод ирж магад гэж ариун явдалт тахилч та айхгүй байх юм уу? гэвэл даянч дургүйцэж,

- Хилэнцэт гэнээ? Би санваараа умартаж байна гэж үү? Өдөр бүр би дугандаа хоёр удаагийн мөргөл, үдэш оройн залбирал, цагуудын уншлага, үдшийн сан, тэргүүтнийг ёсчлон сайнаар гүйцэтгэдэг билээ гэв.

- Ан гөрөө хийхэд тохиромжтой сартай шөнөөс бусад цагт л тэр биз дээ? гэж зочин өгүүлэхэд даянч латинаар

- Бусдын үзэгдэл зохихоос бусад цагт гэж хариулаад хийдийн бүх журам гуримыг яг нарийн баримталдаг эсэх тухай хувраг бус хэгжүүн этгээд асуувал ингэж хариулж байгаарай гэж манай хөгшин гэлэн зааж өгсөн билээ гэв.

- Энэ зөвөө ариун явдалт ламтан. Гэхдээ чөтгөр биднийг тухайлан иймэрхүү үйлийн цагаар отоож байдаг. Чөтгөр архиран тэнэх арслан лугаа адил газар сайгүй шиншлэн гүйдгийг чи өөрөө мэднэ шүү дээ гэхэд,

- Яах вэ архирч зүрхлэх юм бол тэгж л байг. Миний олсны амтыг үзээд Дунстан гэгээнд бэрээдүүлэн чарлаж байсан шигээ бархирах бий. Би төрсөн цагаасаа хойш ганц ч хүнээс айж яваагүй, чөтгөр, түүний хамсаатнуудаас ер айхгүй дээ. Гэгээн Дунстан, Дубрик гэгээн, Винибальд гэгээн, Сунберт гэгээн, Уиллик гэгээн, мөн Кентийн фом гэгээний таринууд, дээр нь бурхны өмнө байгуулсан өөрийн багагүй гавьяаг бодоод сүүлтэй ч тэр сүүлгүй ч тэр чөтгөрүүдийг би ер юман чинээ санадаггүй. Гэхдээ найз чамд аминчлаад хэлчихэд иймэрхүү юм ер нь өглөөний залбирал өнгөртөл дурсдаггүй билээ гэв.

Даянч яриагаа өөрчлөн сархдаа сайхан үргэлжлүүлэн сөгнөв. Хоёул ихээ олон ая барьчихаад байтал урцны үүдийг машинд чанга цохин наргианыг таслав. Энэ сээд чухам юунаас болж учирсныг бид манай өгүүллэгийн өөр баатруудын үйл явдлыг эргэн үзэж байж сая тайлбарлах болно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Хангал буга согооныхоо хойноос гүйх

Харанхуй царс нарны гэрлийг битүү хаах

Ойгоор тайгаар явцгаа!

Сайн хүн залах жолоог атгаж байхад

Санасан зөргөөр урагшлахуйяа хэнч таатай

Хуурмагаар гийгч Дианы үйлс нь төдгүй

Суудал нь бас батгүй.

"Эттрискийной"

Ашбийн тулалдааны талбар дээр хүүгээ ухаан алдан унахыг Саксон Седрик үзээд даруй хүмүүсээ явуулан асруулах санаа төржээ. Гэвч тэр үг аманд нь тээглэж орхиод гарсангүй. Өдий олон хүний нүдэн дээр гэр орноосоо хөөж, өв хөрөнгө өгөхгүй болгосон хүүгээ даруй хүлээн авч эс чадлаа. Гэвч бараа алдалгүй дагаж яваад, хамжлагын хоёр зарцтай хамсан улс амьтан тармагц Ашбид авч очихыг Освальдад тушаав. Харин энэ хэлснийг нь Освальд гүйцэтгэхдээ цалгарджээ. Улс амьтан тарж дуусахад баатар хаана ч байсангүй.

Седрикийн дагуул залуу эзнийхээ хаашаа орчихсоныг гайхан ийш тийшээ эргэлдэнэ. Залуу баатрын хэвтэж байсан газарт цусан толбо байгаа нь харагдавч үгүй болжээ. Баатрын дагуул маягаар хувцасласан хүний төрх галбир гэнэт нүдэнд нь тусан өөрийн найз Гурт байхыг таниагүйсэн болж гэм Саксончууд ихэд сүшиг бишрэлтэй улс болохоор Айвенгогийн алга болсныг Освальд дотроо тухайлан ингэж тайлбарлаж магад байсан билээ. Эзнийхээ үгүй болсонд мухардан зовсон угийн гахайчин алив болгомжийг умартан газар сайгүй эрж, биеэ тоглоомгүй хүнд осолд учруулж явав. Гуртыг оргодол боол гэж баривчлахыг Освальд өөрийн үүрэг гэж үзэв.

Айвенго хаашаа явсныг мэдэх хүн байна уу үгүй юу гэж Освальд дайралдсан хүн бүрээс асуусаар байж, тулалдаан дээр байсан нэг бүсгүйн хувцас хунар сайнтай хэдэн зарц шархан баатрыг дамнуурган дээр хичээнгүйлэн тавиад даруй хашаанаас авч одсон гэдгийг эцэст дуулжээ. Ийм сураг сонсоод Освальд эзэн дээрээ очиж цаашид хэрхэн талаар үг дуулахаар шийдэв.

Саксоны Седрик хүүгийнхээ төлөө ихэд зовж овог үндсээ хайрлах, үр хүүхдээ өрөвдөх хоёр сэтгэл тэмцэлдэн байснаа эцэг хүний хайр яван явсаар дийлж байв. Гэвч Айвенгог нөхөд нь авч асарч байгаа янзтай үг дуулмагц доромжлогдсон бардам сэтгэл дургүйцэл нь цухалдаж ирсэн эцэг хүний сэтгэлийг давж гарлаа.

- Өөрийнхөө замаар одог. Төлөө нь зүтгэж, шарх олгосон улсуудаараа эмнүүлэг. Манай эх

орны хуучин сайн зэмсэг болох илд барин английн өвөг дээдсийн нэр төр, яруу алдрыг дэмжин хамгаалахаасаа норман баатруудын зохиосон элдэв аяг зүйлд л гарамгай юм шив гэж Седрик хэлсэнд, тэнд байлцсан Ровена:

- Өвөг дээдсийн нэр төрийг хадгалахын тулд ажил төрөл зөвлөхдөө мэргэн, дайн тулалдаанд эрэлхэг, эр зоригтны дунд хатан зүрхээрээ тэргүүн, сайн санааны дунд сүү шиг сайн хүүний эцгээс өөр... гэтэл,

- Ровена авхайтан та дуугүй бай! Энэ тухай би тантай ярилцахыг хүсэхгүй байна. Хаан хүүгийн оройн найр наргианд очихоор бэлд. Гастингсийн тулалдааны ёрт муу өдрөөс хойш Саксончуудын ер үзэж дуулдаагүй их хүндэтгэлтэйгээр энэ удаа залж байна. Наад зах нь тэдний хамгийн эрэлхэг дайчдыг дийлж гарсан хүүгийн минь хувь заяа надад ер онц хамаагүй зүйл гэдгийг бардам нормануудад үзүүлэхийн тулд би даруй тийшээ очно гэж Седрик өгүүлэв.

- Би харин тийшээ очихгүй. Харин таны тэр эрс хатуу зан, эр зориг гэж үзэж байгаа чанаруудыг зүгээр л харгис хатуу сэтгэл гээд нэрлэж болохыг анхаарна уу гэж танаас гуйя хэмээн Ровена хатагтайг хэлэхэд Седрик өөдөөс нь:

- Тэгвэл хүний ачийг үл мэдэгч миь гэртээ үлд! Золгүй, хавчигдан хяхагдаж байгаа ард түмний эрх ашгийг өөрийнхөө хоосон, ёс бус сэтгэлээ бодон золиосон гаргаж байгаа бол чи л харин хатуу харгис сэтгэлтэй хүн байна. Би сайн төрөлт Ательстаныг дайран авч хоёул хамт Анжуйгийн хаан хүү Жоны найранд очлоо гэв.

Ингээд гол үйл явдлыг нь бид дээр өгүүлсэн найранд очихоор морджээ. Цайзнаас эргэж ирээд саксоны тайж нар бүх дагалт сэлтийнхээ хамт мордов. Мордохоор хөл үймээн болж байх үед оргодол Гурт анх удаа Седрикийн нүдэнд харагдав. Сайн санаат саксон тайж найран дээрээс төдий аятайхан зантай эргэж ирээгүйг бид мэднэ, хэн нэг хүнд уураа гаргах шалтаг хайж байжээ.

Гав гинж зүүлэг! Гавал үүнийг! Освальд! Гундиберт! Муу хар нохдууд мини! Энэ муу новш яагаад өнөө хүртэл хүлэггүй байж байгаа юм бэ гэж хашгирав.

Гуртийн нөхөд үг зөрж зүрхлэхгүй даруй гар дор дайралдсан жолоогоор Гуртийг хүлэхэд цаадах нь огт эсэргүүцсэнгүй харин эзэн рүүгээ зэмлэнгүй харж зөвхөн,

- Таны цус махны тасархайг өөрийнхээсээ илүү ихээр хайрлаж үзэх гэдэг ийм юм байдаг байж гэж дуугарав.

- Мориндоо мордоод урагшаа! гэж Седрик хашгирвал

- Аль түрүүний цаг болсон. Бид яарахгүй бол хүндэт Вальтофф ламтны үдшийн зоогонд зэхсэн хамаг хоол муудчихаж мэднэ гэж би айж байна шүү хэмээн өндөр төрөлт Ательстан өгүүлэв.

Гэвч аяныхан машид түргэн явсан болохоор Ательстаны зовж явсан зүйлийг тохиолдохоос нь

өмнө гэгээн Витольдийн хийдэд амжиж хүрэв. Эртний саксоны сурвалжит гэр бүлээс гаралтай хийдийн ширээт саксоны язгууртан гийчдийг машид гар тавин дайлсанд зочид үдшийн зоогон дээрээ шөнө орой болтол, чухам юу гэвэл үүр хаяартал суужээ. Дараа өдөр нь мөн өглөөний тансаг сайхан зууш барьсны эцэст сая зочломтгой эзнийхээс мордлоо.

Морьтой хүмүүс хийдийн хаалгаар гарч явах үед саксончуудын сэтгэлийг жаахан түгшүүрлэсэн явдал гарав. Тэр цагт европод оршин сууж агсан үндэстнүүдийн дотор алив ер шинжийг саксончуудтай адил их анхаардаг ганц ч овог ястан үгүй байсан билээ.

Энэ удаа гай зовлонг хашаан дотор сууж байсан асар том гуриатсан хар нохой ёролсон нь машид хүндэтгэл багатай зөнч ажээ. Түрүүчийн хүмүүс хаалгаар гарч байх үед өрөвдөлтэйгээр ульснаас дараа нь хуцаж тал тал тийшээ гүйн, явж байгаа хүмүүсийг илтэд дагаж байлаа.

- Седрик ааваа, энэ хөгжим надад тун таалагдахгүй байна гэж Ательстан хэллээ. Хүндэтгэлийн үүднээс өвгөнийг ийнхүү дууддаг байжээ. Вамба мөн:

- Өвгөө би бас л үүнд дургүй байна. Бид үүний гайг эдлэхэд хүрэх бий гэж зовж байна гэв.

Ширээтийн дарс Ательстанд аятайхан дурдатгал үлдээсэн тул, - Миний бодоход үдийн хоол болтол амбаныд эргэж орж айлчилсан маань дээр айхаа. Лам хүн зам хөндлөн гарах, туулай гүйж өнгөрөх юм уу нохой улих аваас замд гарч хэрэггүй. Дараачийн хоол зоог өнгөртөл хүлээх нь дээр гэдэг гэв.

Седрик унтууцан, - Дэмий яриа! Тэртэй тэргүй би их цаг алдаад байна. Тэр нохойг би танина. Тэр чинь миний оргодол боол Гуртийнх, эзэн шигээ ашиггүй муу хоолны сав байгаа юм гэлээ.

Ингэж хэлээд Седрик дөрөөн дээрээ өндийн газар сайгүй эзнийгээ дагаж явдаг хөөрхий фангс руу жад чулуудав. Энэ нь үнэхээр Фангс мөн байсан бөгөөд богино жад мөрий нь онож золтой л газартай хадаж орхиоснгүй. Золгүй нохой улам ч чангаар гаслан, хилэгнэсэн тайжийн замаас хар хурдаараа зайлан одов.

Энэ явдлыг хараад Гуртийн зүрх шимшрээд явчихлаа. Седрик түүний үнэнч нөхөр, туслагчийн алах гэсэн нь дөнгөж сая өөрөө тэсэж өнгөрүүлсэн хатуу шийтгэлээс илүү ихээр гомдоожээ. Нүдээ арчих гэж дэмий баахан оролдоод сүүлдээ эзнийхээ ааш муутай байгааг үзээд холхон явахыг дээрд үзсэн Вамбад,

- Алив тус болж цувныхаа хормойгоор нүд арчаад өгөөч! Бүр шороо дүүрч гүйцлээ, хүлээстэй гар хүрч өгөхгүй байна гэв.

Вамба гуйсан тусыг хийж өгөөд хэсэг зуур дуугүй зэрэгцэн явлаа. Гурт үг дуугүй, баргар царайлна. Тэгж тэгж тэсэж чадалгүй доорхи үгийг хэлж, сэтгэлээ уужруулав.

- Вамба найзаа, Седрикэд зүтгэж байгаа бүх тэнэгүүдийн дотроос ганц чи л тэнэгээрээ түүний сэтгэлд таалагдаж чаддаг овжин хүн. Тэгэхлээр явж очоод байнаа. Гурт үнэнч сайны

үүднээс ч гэсэн айж эмээх сэтгэлээс ч тэр хойшид түүнд зарагдахгүй. Толгойгий минь авч, ташуурдаж, гинжилж болох юм, харин энэ цагаас аваад түүний зарц бишээ. Беовульфийн хүү Гурт түүнд зүтгэхээс татгалзлаа гэж хэлж үз гэвэл Вамба өөдөөс нь,

- Би хэдийгээр тэнэг боловч ийм дэмий үг түүнд хэрхэвч дуулгахгүй. Седрикийн бүсэнд бас нилээд олон хөнгөн жад үлдсэн. Заримдаа сүрхий мэргэн чулууддагийг чи мэднэ шүү дээ гэв.

- Одоо ч намайг алсан ер хамаа алга. Өчигдөр миний залуу эзэн Уильфредийг тэр талбай дээр цусан дотор нь хэвтүүлээд хаясан, өнөөдөр надад сайн байдаг ганц амьд амьтанг алах гэлээ. Саксоны удам судрын бүх гэгээд Эдмунд гэгээн, Дунстан гэгээн, Витольд гэгээн, гэгээн номлогч Эдуард (саксон гарлын бус гэгээдийн нэрийг Седрик хэзээ ч үл дурсах тул гэр орныхон нь мөн л цөөн гэгээдэд залбирах болсныг дурдалтай) . Нарыг гэрч барин андгайлахад үүнийг нь би хэзээ ч уучилж үзэхгүй гэлээ.

Эвлэрүүлэх үүрэг цөөнгүй гүйцэтгэдэг Вамба: - Миний бодоход Седрик үнэндээ Фангсийг алах гээгүй зөвхөн айлгах л гэсэн дэг шүү. Хөнгөн жадаа толгой дээгүүр нь чулуудах гэсэн юм шиг дөрөөн дээрээ боссоныг нь чи ажсан уу, гай болж энэ үеэр Фангс дээш үсрээд орхисон юм. Тэгээд л жаахан шүргүүлээд авлаа. Түүнийг нь би давирхайгаар дор нь эдгээж орхиноо гэв.

- Үнэхээр тийм байсан бол, би тэгж бодож болохтой байсансан... Үгүй тийм биш! Түүний хянуур сайн шагайхыг харж, хорон муу санаагаар шидэгдсэн хойноо хүртэл оноогүйдээ дургүйцсэн юм шиг чичирхийлж байсан. Үгүй Антон гэгээний хайртай гахайг барьж андгайлаад би түүнд одоо зарагдахгүй гэж Гурт хэлэв.

Ингээд зэвүүрхсэн гахайчин дахин баргар царайлан таг болчихоод алиа салбадай оролдоод оролдоод ам нээлгэж эс чадав.

Энэ зуур тэргүүнд явсан Седрик Ательстан хоёр улс орны байдал, хааны гэр бүлийнхний эв нийцгүй байгаа болоод норман тайж нар хоорондоо дайсагналцдаг тухай хүүрнэн ойртож байгаа самуун дайны үеэр саксончууд норманы дарлалаас мултарч болох магадгүй гэж хэлэлцэнэ.

Иймэрхүү юмны тухай ярихдаа Седрик ямагт сэргэж ирнэ. Саксончуудын тусгаар тогтнолыг сэргээх гэдэг түүний цорын ганц бодол бөгөөд гэр бүлийнхээ аз жаргал, хүүгийнхээ хувь заяаг бодолдоо сайн дураараа золиосолсон билээ. Жинхэнэ англичуудын төлөө энэ үндсэн эргэлтийг хийхийн тулд нэгдэж, нэгэн жолоодогчийн удирдлагын дор хөдлөх хэрэгтэй бөгөөд тэрхүү удирдагч эртний хаадын удам угсаа байх учиртай байлаа. Седрик нууц бодол горьдлоо итгэж илчилсэн хүмүүст ийм шаардлага тавьдаг байлаа. Энэ шаардлаганд нийцэх хүн Ательстан байв. Оюун ухаанаар гойд биш алив гялалзсан авьяас билэг үгүй хэдий авч бие бялдар нилээн сүр буурьтай, аймхай хулчгар бус, цэргийн алив эрдэмд чадмаг мөн өөрөөсөө ухаалаг улсын зөвлөлгөөг дуртайяа авдаг байртай хүн бүлгээ. Үүнээс гадна өглөг зочломтгой сэтгэл сайнтай хүн гэдгийг улс мэднэ, гэхдээ Ательстан сайн чанартай хэдий авч саксончуудын олонхи нь Ровена авхайд илүүд үзэгдэх төлөвтэй билээ. Авхай өөрөө Альфред хааны удам, эцэг нь мэргэн ухаан, эр зориг, түвшин сайн авираараа ихэд алдаршсан тул нэгэн үндэстэнгүүд түүний дурдатгалыг өндрөөр үнэлдэг ажээ.

Седрик өөрөө хүсэх ахуул бусад хоёроосоо багагүй хүчирхэг гурав дахь намыг толгойлоход хялбар байлаа. Ательстан, Ровена авхай хоёр хааны удам судраараа давуу талтай авч Седрик хариуд нь эр зориг, ажилч хөөцөлдөнгүй, зан төрх болоод гол нь үйл хэрэгтэй саксоных гэж нэр авглаа чин үнэнчээр зүтгэдгээрээ хүндтэй билээ. Язгуур гарлын хувьд мөн Ательстан, хүмүүжүүлэгч бүсгүй хоёроосоо өөр хэнээс ч дутуугүй өндөр сурвалжит хүн. Гэхдээ алив нэр төр горилох дээгүүр сэтгэлийн зах ч Седрикэд үгүй, өөрийн нам байгуулж тэртэй тэргүй хүч султай ард түмнээ улам сарниахын оронд Ровена хатагтайг Ательстантай гэрлүүлэн бүх намуудыг нэгтгэн нягтруулахыг эрмэлздэг байлаа. Түүний гол мөрөөдөл энэ ажээ. Үүнийг гүйцэтгэхэд Ровена авхай хүү хоёрын харилцан сэтгэл саад болж Уильфредийн эцэг эхийнхээ гэрээс хөөгдөх гол шалтаг энэ болжээ.

Уильфредийг үгүй хойгуур Ровена сэтгэлээ хувиргаж магад гэж Седрик горилон ийм ширүүн арга хэрэглэнэ гэсэн чинь эндүүрэл болов. Ровена хэлбэршгүй байдгийн зарим учир хүмүүжсэн байдлаар нь тайлбарлагдах ажээ. Седрикийн нүдэнд Альфред нэгэн ёсны бурхан мэт санагдах тул түүний ураг удмын эцсийн энэ бүсгүйд онцгойлон сайн байдаг билээ. Эднийд Ровенагийн хүслэн бүр хууль болж, бүсгүйд албат харьяат мэт захирагддагаа Седрик өөрөө бахархах бүлгээ.

Ийм янзаар Ровена багаасаа аван өөрийнхөө дураар аашилж сурсан, хувь заяаг нь шийдэх гэсэн Седрикийн алив оролдлогыг шургуугаар эсэргүүцэж чадах ажээ. Элдвээр ятгахад нь Ровена эрс татгалзах тул бүсгүйн бүх хүслэнг боол мэт дагаж заншсан хөөрхий хүмүүжүүлэгч юу хийхээ үл мэднэ.

Бүсгүйн сэтгэлийг ирээдүйн хаан их эрх ямбаны сайхнаар татах гэж дэмий оролдож үзлээ. Юмыг ихээ саруулаар авч үздэг зантай Ровена Седрикийн төлөвлөгөөг огт үл биелэгдэхийн гадна хувьдаа бол хүсүүштэй зүйл биш гэж үзнэ. Уильфред Айвенгод илүү сайн байдгаа Ровена нуух гэж ер бодсонгүй. Тэр ч байтугай Ательстантай хаан ширээ хуваан суухыг зөвшөөрнө гэхээсээ хийдэд очиж сууна гэж нэг биш удаа дуулгажээ.

Конингсбургийн эзэн тайжийг угийн үл ойшоодог байснаа түүнээс болж өдий төдий их зовлон амссан хойноо бараг үзэн ядах маягтай болжээ.

Хэдий тийм авч энэ айл гэрийг бүтээснээр саксоны тусгаар тогтнолын төлөө тэмцэлд чухал тус хүргэнэ гэж Седрик бодон, бүсгүй хүний тууштай сэтгэлд онц итгэдэггүй болохоор бүтээж бүрэлдүүлэх гэж бүхий л аргаар хөөцөлдөнө. Ашбийн эрүүл тулалдаан дээр хүү нь гэнэт гарч ирсэн явдал бүх горьдлого найдварт нь шийдмэг цохилт боллоо гэж аргагүй үндэстэйгээр санагджээ. Эцэг хүний хайр хурамхан зуур бардам авир саксоны үйл хэрэгт үнэнч сэтгэлийг дийлсэн нь үнэнтэй. Гэвч энэ хоёр сэтгэл төдхөн бодол санааг нь дахин эзэмдэж Ательстан Ровена хоёрыг бушуухан нийлүүлэхэд хүчээ тавихаар шийдэв.

Одоо Ательстан саксоны үйл хэргийн тухай хүүрнэнэ. Энэ ярианы үед Седрик Готсперийн адил өдий чухал хэргийг ийм өөдгүй амьтанд даалгах болов гэж нэг биш удаа харамсахад хүрэв. Ательстан үнэндээ нэр төрд дуртай, өндөр төрөлтэй язгуур гарлынхаа хувьд хүндэтгэл хүлээж, эрх мэдэл эзлэх учиртайн тухай яриа дуулах түүнд аятайхан ажээ. Гэвч гэр орныхоо болоод хүрээлж байгаа саксончуудын үзүүлэх хүндэтгэлд өчүүхэн ихэрхүү зан нь бүрэн тайвширч сууна. Аюулыг Ательстан аймшиггүй угтах боловч сайн дураараа түүнийг

эрхээргүй залхуу билээ. Саксончууд тусгаар тогтнолоо байлдан авбал зохих тухай Седриктэй санал бүрэн нийлнэ. Тэр тусгаар тогтнолыг байлдан авсан хойноо саксончуудын хаан байхыг бүр ч дуртай зөвшөөрнө. Гагцхүү өөрийг нь хаан ширээнд өргөмжлөх төлөвлөгөөг хэлэлцэж эхлэхийн хамт нөгөө л эв дүй муутай, шийдмэг бус овсгоо хийморь муутай "хөшүүн Ательстан" болчихно. Түүний хойрго зан авирт Седрикийн халуун цочмог үг яриа онц нөлөөлөхгүй, их бууны улайдсан сум хүйтэн усанд орж хэсэг шуугиж утаа савсаад хөрчихдөгийн үлгэр адил байх ажээ.

Ательстаныг ятгах гэдэг эцсэн морь давирах юм уу хүйтэн төмөр давтахтай адил болохыг үзээд Седрик хүмүүжүүлсэн бүсгүй рүүгээ ойртолоо. Гэвч бүсгүйтэй өдсөн яриа бараг илүү ч таагүй болов. Седрикийн ойртож ирснээр Ровена авхай дотно шивэгчинтэйгээ эр зоригт Уильфред, түүний хувь заяаны тухай яриаг тасалсан тул үүний нь өшинд тулалдааны талбар дээр Ательстаны эмээлээсээ хэрхэн ховх цохиулаад тэрийж хэвтсэн тухай Эльджита даруй дурсан гарав. Гэтэл энэ шившигт явдлын тухай дурсах нь Седрикэд нь гойд аягүй байжээ. Иймэрхүү янзаар уул аялал шударга саксон тайжид элдэв аягүй явдал, гутралаар дүүрэн байв. Эрүүл тулалдаан, түүнийг зохиож гаргасан хүн болоод тийшээ очих гэж болчимгүй хөдөлсөн өөрийгөө дотроо байн байн харааж байлаа.

Үдийн алдад Ательстаны хүслээр морьдоо амраах, зочломтгой ламтны замд төхөөрч өгсөн хоол унднаас идэж ууж тэнхээ сэлбэхээр голын эрэг дээрх нэгэн төгөл дотор үдлэв. Үдлэлт ихэд удаж бусад саад ч замд бишгүй гарсан тул Ротервудэд гэрэлтэй байхад хүрэх горьдлого тасарлаа. Энэ байдал тэднийг яаруулж түрүүчийнхээсээ сүрхий хурдан явахад хүргэв.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Сэм чагнасан ярианаас мэдсэнээр

Сурвалжит бүсгүйн дагуул болох

Цэргийн тэр эрчүүл одоо

Цайзанд бүр ойртож ирээд

Шөнөдөө тэнд хоноглох гэнэ

"Орра" гэдэг эмгэнэлт жүжгээс

Аяныхан одоо дээрэмчин олонтойн улмаас асар аюултайд тооцогдох ойн гүн рүү орох учиртай боллоо. Үзээгүй ядуурал, хавчилганд мухардсан зовсон тариачид ойд бүгэн нутгийн хүч султай цагдаа нар яаж ч чадахгүй олон тооны хүчирхэг бүлгүүд болон нийлэх болжээ. Гэхдээ цаг хэдий оройтсон авч Седрик Ательстан хоёр сайтар зэвсэглэсэн арван зарц дагуултай эдгээр дээрэмчдийн довтлохоос онц их эмээхгүй явлаа. Дээрэмчид гэж голдуу саксоны гарлын номен тариачид ойн болоод ангийн онц хатуу хуулийн гайгаар ийнхүү цөхөрсөн хэрмэл янзаар амь зуухад хүрсэн хүмүүс тул өөрийн омгийн хүмүүст бараг гар хүрдэггүй заншилтайд бас найдаж явлаа.

Гэнэт манай явуулын хүмүүс хүн чанга бархирахыг сонсож дуу гарсан тэр газар руу дөхөж очвол морин дамнуурга өвсөн дээр хэвтэхийг үзэж гайхав. Хажууд нь хээнцэр сайхан еврей хувцастай залуу бүсгүй сууж, мөн шар малгайг нь харвал еврей хүн байж таарах нэг өвгөн цаахна нь байгаа харагдав. Эхлээд Ательстан, Седрик хоёрын асуултанд хөгшин еврей зөвхөн бурхны судрын хараалаар хариу өчихтэй байснаа эцэстээ жаал сэхээ оров. Энэ хүн бидний хуучин танил Йоркийн Исаак байсан бөгөөд Эшбийд зургаан зэвсэг бүхий дагуул, өвчтэй нөхрөө авч явахаар хөлсөлж авсан, хөлсөлсөн хүмүүс тэднийг Донкастер оруулж өгөх ёстой байсныг арайхийж тайлбарлав. Өнөө хүртэл гэмгүй сайн явж байсан чинь энэ том бүлэг дээрэмчид ойд бүгсэн тухай замд дайралдсан түлээчин дуулгасанд хөлсний зарц нар айж морьдоо буулгаж аван Исаакийг охинтой нь заяа мэдэн хаяад зугтаажээ.

Исаак гүнээ хүлцэнгүй доор дуугаар өндөр дээд, өршөөлт эрхмүүд таалбал та бүхний хамгаалалтанд багтах замдаа орохыг бидэнд зөвшөөрнө үү? Ёс гуримаа барьж андгайлахад тийм их өршөөлийн ачийг бид үзэгдээгүй өгөөмрөөр хариулахсан билээ гэв.

Элдэв жижиг хяхууг Ательстан гойд сайн санаж явдаг болохоор – Аа муу нохой! Тулалдааны талбарын тавцангийн өмнө хир их дээрэнгүй авирлаж байсныг би хараахан мартаагүй байна. Дуртай бол биеэ хамгаал, зугтаа, эсвэл дээрэмчдэд төлөөс төл, харин биднээс бүү тусламж горьд. Дээрэмчид зөвхөн л ертөнц дахиныг цөлмөгч та нарыг цөлөмдөгсөн бол би тэднийг хамгийн шударга хүмүүс гэж тооцохсон билээ гэв. Харин Ательстаны энэ хатуу шийдвэртэй Седрик санал нийлсэнгүй.

- Бид ингэвэл дээр юм байна. Дагуулуудаасаа хоёр хүн хоёр морьтой өгөөд ойролцоох

сууринд хүргүүлнэ. Үүнд бид онц хохирох юм үгүй, сайн төрөлт Ательстан таны хурц илдний ачаар, бусад зарц нартайгаа хоёр зуун тэнүүлчдийг ч бид хялбархан дийлнэ гэв.

Ровена дээрэмчдээс хэдий их айх боловч хүмүүжүүлэгчийнхээ саналыг халуунаар дэмжив. Тэгтэл өнөө хүртэл дуугүй суусан Ревекка босож олон зарц нар дундуур сүлжин Ровенагийн морины дэргэд ирээд өвдөг сөгдөн дорно зүгийн заншлаар саксон авхайн хувцасны хормойг үнсэв.

Дараа нь босож нүүрнийхээ татуургыг сөхөөд хоёул ижил шүтдэг дээд бурхны нэр барин өөрсдийгөө өрөвдөж багийнхаа хамгаалалтын дор цуг явахыг зөвшөөрнө үү гэж гуйж гарав.

- Би өөрийнхөө төлөө юм уу, энэ хөөрхий хөгшний тулд ийм өршөөл үзүүлэхийг гуйж байгаа юм бишээ. Манай овгийн хүмүүсийг гомдоох, цөлөмхийг христос шашинтан хүмүүс хилэнц биш бараг гавьяат үйл шахуугаар үздэгийг би мэднэ. Энэ өвчтэй хүн таны өмгөөллийн дор цаашаа явахыг зөвшөөрч үз. Энэ хүнд гай учирвал та бүх насан туршаа тэр тухай харамсах болно гэв.

Энэ үгийг ихэд ёсорхуу ихэмсгээр хэлсэн нь гоо Саксон бүсгүйд их сэтгэгдэл төрүүлжээ.

Ровена хүмүүжүүлэгчдээ, энэ өвгөн тун дорой, арчаагүй, энэ хүүхэн маш залуу, царайлаг хүн байна. Тэгээд ч бас эдний гар дээр хүнд өвчтэй хүн байна. Эд хэдийгээр еврей нар боловч бид христос шашинтны хувьд эднийг ийм үед хаячихаж таарахгүй. Хоёр луусны ачааг буулга гэж тушаана уу? Луусуудыг дамнуурганд хөллөж болно. Өвгөн, хүүхэн хоёрт хөтөлгөө морьдоос хоёрыг унуулж болох юм гэв.

Седрик энэ саналыг дуртай зөвшөөрч, Ательстан харин еврейг бүхний хойно гахайн махан бамбайгаа барьсан Вамбыг дагуулан яв гэж шаардав.

Салбадай үүнд, - Би бамбайгаа тулалдааны талбар дээр орхисон. Надаас ч лут олонхи баатруудын тавилан тийм хойно гэв.

Эрүүл тулалдааны хоёр дахь өдөр өөрт нь мөн тийш тавилан дайрсан болохоор Ательстан час улайчихав. Ровена авхай харин болчихон бишрэгчийнхээ гашуун үгийг зөөллөх санаатай Ревеккаг хажуудаа цуг явна уу гэж гуйв.

- Би тэгж зохихгүй. Надтай хамт явах ивээгч бүсгүйд минь ч ичгүүртэй санагдаж болно гэж Ревекка хүлцэнгүй авч нухацтайгаар өгүүлэв.

Ачааг тун хурдан шилжүүллээ. Дээрэмчид ойролцоо байна гэдэг сураг дуулсан төдийгөөр л зарц нар яарч, улам харанхуй болж байгаа нь энэ үгийг бүр их жинтэй болгожээ. Үймээний үед Гуртийг мориноос буулгасанд тэрхэн хурмыг ашиглан салбадайгаас гарынхаа хүлгийг сулруулж өгөхийг гуйвал Вамба тэгж өглөө. Салбадай дахин зориуд хааш хэрэг зангидсан ч байж магадгүй. Юу гэвэл Гурт онцын бэрхшээлгүй гараа суллаж аваад бут руу шургачихав. Түүний зугтаасныг анзаарсан хүн ер үгүй, дээрэмчид довтолж магад гэдэг ганц бодол хүн бүрийг тэгтэл догдлуулсан ажээ.

Аяныхны яваа зам улам нарийсаж, хоёроос илүү хүн зэрэгцэж багтахгүй боллоо. Энэ зөрөг цаашаа намагтай эгц эрэг бүхий горхи урссан жалга руу орно. Энэ харанхуй жалгын дотор дайрвал хир их аюултай болохыг түрүүнд явсан Седрик Ательстан хоёр ойлгож байв. Гэвч хэн хэн нь дайтах туршлагаар бага болохоор жалгаар бушуухан давхин өнгөрвөл дээр гэж шийдэв. Ямар ч эрэмбэ замбараагүйгээр цөм урагшаа ухасхийв. Гэвч тэргүүлэгчид дагуулуудынхаа хагастай голоор гаталмагц дээрэмчид гэнэт дайрсанд эсэргүүцэх ямар ч арга байсангүй. Тал бүрээс саксоны дээрэмчид болж довтлогчдын хашгиралдах дуу гарав.

- Цагаан луу! Цагаан луу! Хуучин Английг гэгээн Георгий ивээнэ ! гэж орилолдоно. Саксоны хоёр удирдагч зэрэг баривчлагдав. Түрүүчийн дайсныг хармагцаа Седрик хөнгөн жадаа энэ удаа тун мэргэн чулуудаж, ард нь байсан царс модтой хадаж орхив. Ийнхүү нэгийг цааш нь харуулаад нөгөөгийн өөдөөс дайрч улайрсандаа илдээ онц хүчтэй далайсан нь хажуу модны бүдүүн мөчирт тээглэн дүйгүй хөдөлсний гайгаар өөрөө өөрийгөө зэвсэггүй болгож орхилоо. Хоёр юм уу гурван дээрэмчин, дайран ирж мориноос татан буулгаад олзлох нь тэр. Ательстан хамгаалан үзэлцэхээр зэхэж амжаагүй байтал эмээлээс нь угз татаж буулгаад хүлчихлээ. Седриктэй бараг нэгэн зэрэг баригджээ. Энэ багийнхнаас ганц Вамба л баригдалгүй гарч амжив. Тэгэхдээ өөрөсөө ухаалаг гэж үзэгддэг хүмүүсээс ихээ эр зориг гаргасан билээ. Зарц нарын нэгний илдийг шүүрэн авч эргүүлэн довтлогчдыг ухраагаад дараа нь Седрикийг очиж тэнхрүүлэх гэж зоригтой авч оролдлого хийж үзсэнээ арга үгүй болохыг үнэмшин аятайхан нөхцөлийг харж байгаад буун харайж бут руу шургав.

Гэхдээ аюулаас мултарсан хойноо зоригт салбадай хэд хэд дахин тээнэгэлзэн зогсож эргэж очоод үнэхээр сайн байдаг эзнийхээ хувь заяаг хуваалцвал дээргүй болов уу гэж эрэгцүүлэн байв.

- Хүмүүс эрх чөлөөг магтан дуулахыг би сонссон. Харин тэр эрх чөлөөгөөр одоо чухам яахыг нэгэн мэргэн хүн надад зааж өгөөсэй гэж би хүсэх байна гэж салбадай үглэнэ. Энэ үгийг нилээд чанга хэлчихжээ. Тэгтэл гэнэт хажуухан нь болгоомжтой аяархнаар "Вамба" гэх дуу гарсан даруй хар нохой давхиж ирсэн нь Фангс байхыг дороо танилаа.

- Гурт! гэж Вамба болгоомжлон шивнэсэнд гахайчин даруй гарч ирэв.

- Энэ юу болж байнаа? Юун хашгиралдаан, илд хангиналдаан болоод байнаа? гэж Гурт яаран асуувал Вамба хариуд нь:

- Ердийн явдал. Бүгдийг олзлоод авчихлаа гэв.

- Хэнийг олзолчихлоо гэж? хэмээн Гурт тэвдэн дуу алдахад,

- Манай эзэн, Ровена авхай, Ательстан, Гундиберг, Освольд... цөмийг! гэв.

- Бурхан өршөө! Яагаад тэд олзлогдож орхидог билээ, хэн тэр вэ? гэхэд салбадай өгүүлсэн нь:

- Манай эзэн даруй тулалдаж гарсан. Ательстан амжсангүй, бусад нь ч бүр мэдээж хэрэг. Тэднийг ногоон хүрэм, хар багтай хүмүүс олзолж авлаа. Чиний гахайндаа тэжээл болгох гэж мод сэгсрэхэд бөндийн унадаг зэрлэг алимууд аятай тэд одоо ногоон дээр хүлээстэй

хэвгэцгээж байгаа, үнэхээр инээдтэй юм! Нулимс гараад байгаа бишсэн бол би инээхсэн гээд шударга сайн салбадай уйлчихав.

Гуртийн царай сэргэж:

- Вамба чи зэвсэгтэй, эр зориг чамд ухаанаасаа илүү их юм байна. Чи бид хоёр хэдий хоёулхнаа боловч зоригтой хүмүүсийг гэнэт дайрвал ихэд өөрчлөж мэднэ. Явья! гэв.

- Хаашаа, яах гэж? хэмээн салбадайг асуухад,

- Седрикийг аврая гэлээ.

- Үгүй чи түүнд зүтгэхээс саяхан л татгалзаад байсан хүн чинь чи биш билүү? гэвэл Гурт хариуд нь марган,

- Одоо бол бүх юм өөр. Одоо түүнд гай дайраад байна... Явья! гэв.

Салбадай энэ үгийг дагахаар завдтал өмнө нь нэг хүн гарч ирээд тэднийг зогс гэж тушаав. Зэр зэвсэг, хувцас сэлтийг нь үзээд Вамба анхандаа түүнийг эзнийгээ олзлон авсан дээрэмчдийн нэг гэж бодлоо. Гэвч анчны эвэр цоортой гоё мөрөвч, тайван тогтуун, галбир, захирангуй байр төрх, харваачдыг тэмцээн дээр түрүүлсэн Локсли гэгч нэртэй нөгөө Йомен мөн болохыг дуугаар нь даруй танилаа.

- Энэ юун шуугиан бэ? Энэ ойд хэн дээрэм хүчирхийлэл явуулж зүрхэлж байна вэ? гэж Локсли асуувал Вамба өөдөөс нь:

- Тэдний хүрмийг ойрхноос хар. Чиний хүмүүс биш биз, юу гэвэл хувцас нь чинийхтэй яг л вандуйн хоёр ногоон хальс шиг ижилхэн юм гэв. Үүнийг би одоо мэдээд орхив. Одоогоор та нар эндээсээ хөдөлж үл болно. Намайг эргэж иртэл эндээ байж бай. Та нар, танай эзэд миний үгэнд орсон нь дээр шүү. Гэвч жаахан азнаарай, эхлээд энэ дээрэмчидтэй адил хувцаслах хэрэгтэй гэв.

Ийнхүү хэлээд мөрөвчөө мулталж, малгайныхаа өдийг хуу татан Вамбад бариулав. Тэгээд богцон дотроос баг гаргаж өмсөн байрнаасаа бүү хөдөл гэж дахин тушаагаад тагнаж ирэхээр одов.

- Үүнийг хүлээх үү, аль оргох гэж оролдоод үзэх үү? гэж Вамба асуугаад, - Шударга хүн байна гэхэд дээрэмчний хэрэгсэл сэлт нь даанч бэлэн явна шүү гэвэл,

- Үгүй нөгөө чөтгөр гэгч нь биеэрээ байлаа ч гэсэн яадаг юм. Түүнийг хүлээлээ гээд бидэнд муу болох юмгүй. Өөрөө энэ бүлгийн хүн болж гэм өдийд сэрэмжилж амжсан, бид дайрч зугтааж ч амжихгүй. Тэгээд сүүлийн үед жинхэнэ дээрэмчид хамгийн муу хүмүүс биш гэдэгт би үнэмшсэн билээ гэв.

Хэдэн хувийн дараа Йомен эргэж ирлээ.

- За Гурт найз минь би сая энэ этгээдүүд дээр очоод ирлээ. Юун хүмүүс, хашаа одох гэж

байгааг мэдлээ. Тэд олзолсон хүмүүсээ алах санаагүй шиг байна. Гурвуул тэдэн рүү дайрна гэж огт гэнэн явдал, юу гэвэл тэд чинь жинхэнэ цэргийн туршлага бүхий хүмүүс болохоор харуул манаа тавьжээ. Ойртох гэж оролдсон даруйд түгшүүр дэгдээнэ. Гэвч би эднийг хэдий их сэрэмжлэвч дийлж чадахуйц баг цуглуулж чадах болов уу? гэж найдана. Та хоёр английн эрх ашгийг хамгаалагч саксоны Седрикийн үнэнч зарц нар шиг надад санагдана. Түүнийг гайгаас гаргаж авах англи хүмүүсийн гар хүрэлцэх тоогоор олдох бий. Миний хойноос яв гэлээ. Ингэж хэлээд цаашаа хурдан алхсанд гахайчин, салбадай хоёр үг дуугүй хойноос нь дагав. Гэвч Вамба дуугүй байж чадсангүй. Гартаа барьсаар буй мөрөвч цоор хоёрыг үзэн, - Энэ сайхан шагналыг хүртсэн мэргэн сум нисэж явахыг би өөрийнхөө нүдээр харсан, тэр явдал саяхан болсон юм шиг санагдана гэвэл Гурт тосож аваад,

- Шагналыг дийлж явсан сайн Йомены дууг дуулж байна. Энэ дууг би өдөр, мөн шөнийн цагаар дуулж байсан, түүнээс хойш сар гурав хоногоос илүүгээр хуучирч амжаагүй байгаа гэж сүнсээ барьж андгайлахад бэлэн байна гэлээ.

Йомен тэдэн рүү эргэн, - Миний хэн болох, хаанаас ирснийг одоо шалгах цаг бишээ, эелдэг нөхөд минь. Танай эзнийг аварч өгч чадвал та нар зүй ёсоор намайг сайн нөхрөө гэж үзэх болно. Миний нэр хэн болох, малчдаас илүү сайн харваж үнэхээр чаддаг эсэх, өдөр шөнө хэдийд зугаалах дуртай зэрэг бол та бүхэнд хамаагүй асуудлууд, тэгснээр толгойгоо дэмий эргүүлээд яах вэ гэв.

- За бид ч арслангийн аманд оржээ! Одоо яах вэ? гэж Вамба нөхрөөсөө асуувал,

- Чимээгүй! дуугүй байж үз? Тэнэг юм донгосч үүний уурыг л бүү хүргэчих, бүх юм сайнаар төгсөнө хараад байгаарай гэв.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

Намрын орой бүрхэг

Баргар ой хуглийнэ

Төөрч ядарсан аяны хүнд

Даянчийн дуу чихний чимэг

Сэтгэл санаа, тэнийн

Жигүүр дэлгэн дуулах мэт

Үүрийн гэгээг магтах жсиргээн шиг

Уг дуу тэнгэр өөд хөвнө.

"Даянч ба гэгээн Клементийн горхи"

Седрикийн зарц нар учир нь үл ухагдах замчнаа даган гурван цаг хир яваад ойн доторхи жижиг цооронхой хүрэв. Төв дунд нь аварга царс лут мөчрүүдээ тал тал тийш нь дэлгэжээ. Модон дорхи ногоон дээр дөрөв юм уу таван Йомен хэвтэж, манаач дэргэдүүр нь алгуурхан холхино.

Хүний хөлийн чимээ ойртож байгааг дуулмагцаа түгшүүр дэгдээв. Унтаж байгсад даруй босон харайж цөм нумаа зэрэг онилов. Зургаан сум хөвчлөгдөж шуржигнах чимээ гарсан зүгт чиглэсэн авч дагуулж ирсэн хүнийг харж танимагцаа гүнээ хүндэтгэх байдлаар амар мэндийг нь эрэв.

Нэн тэргүүнд, - Тээрэмчин хаана байна? гэж асуувал,

- Ротергемийн зам дээр байгаа гэв.

- Хэдэн хүн цуг яваа вэ? гэж тэргүүлэгч асуув. Энэ хүний хэргэм тэргүүлэгч байж таарав бололтой.

- Зургаан хүн, Николай бурхан ивгээвэл овоо олз олох найдлага байгаа гэхэд Локсли өөдөөс нь,

- Сүсэгтэй аятайхан хэллээ. Жалгын Аллен хаана байгаа вэ? гэж асуусанд,

- Уотлингийн зам руу Жорвогын ширээтийг отохоор явсан гэв.

- Энэ ч бас л зөв хийж гэж тэргүүлэгч хэлээд, - Гэлэн хаана байгаа вэ? гэвэл,

- Гэртээ, урцандаа бий гэв.

- Локсли үүнд, - Тиймээ би өөрөө очно. Та нар тал тал тийшээ явж манай бүх нөхдийг цуглуул. Мөрдөж ажихад хэцүү мөртлөө бас хаздаг том анд санаатай болохоор аль болох олон хүн цуглуулахыг хичээгээрэй. Үүрээр цөм энд ир, би байж байна гэснээ нэмж, - Байз, байз, би гол юмаа золтой мартаж орхисонгүй. Та нарын хоёр минь Торкильстонд фрон де Бефийн цайз руу яв. Яг бидний адил хувцаслаж зүсээ буруулсан бүлэг зоригтон эрчүүл олзны хэдэн хүн авч яваа. Тэдний хойноос нүд алдалгүй ажигла. Биднийг хүчээ хуримтлуулж амжихаас өмнө тэд цайз хүрлээ ч гэсэн нэр төрөө бодож тэднийг цээрлүүлэх учиртай. Тэгэхлээр тэднийг сайн тандаж, аль шалмаг нэг чинь тэдний юу болж байгаа тухай мэдээ надад хүргэж ирээрэй гэлээ.

Харваачид бүгдийг яг ёсчлон биелүүлнэ гэж амлаад зүг зүг тийшээ тархав. Энэ зуур тэдний тэргүүлэгч, одоо өөрийг нь машинд хүндэтгэж, жаал сүрдэх байртай болсон саксоны зарц нар копмангерстийн төгөл дахь дуган руу очих замдаа оров.

Сарны гэрэлд гийсэн ойн цоорхой хүрч хагас нурсан дуганын үлдэгдэл, түүний хажууд дахь даянчийн ядуу урц үзэгдмэгц Вамба Гуртийн чихэнд шивнэн:

- Хэрэв энд үнэхээр хулгайч суудаг байвал хийдэд хэдий ойр тутам бурхнаас төчнөөн хол гэдэг үг үнэн байж таарлаа. Ер нь тийм гэж би малгайгаа тавин мөрийцэхэд бэлэн байна. Сонсооч, даянчийн урцанд юун дуу дуулаад байна вэ? гэв.

Энэ үеэр даянч зочинтойгоо эртний найрын дуу байдаг хоолойгоороо аялж байв. Тэр дууны дахилт нь:

Найз хонгор минь хундагаа авч ир

Найр наргианаа бид эхлэв.

Нааш нь хундагаа авч ир

Найрлан наргия та минь

Женкин чи уухдаа овоо юм.

Жигтэй овжин, сүрхий найрч байна

Нааш нь хундага авч ир.

Найрлан наргия та минь.

Вамба дагаж дуулахыг оролдон, - Үгүй нээрээ муугүй дуулж байна гээч. Шөнө дөл болсон хойно даянчийн урцнаас ийм дуу гарахыг сонсоно гэж хэн бодохсон билээ гэхэд Гурт хариуд нь:

- Энд гайхаад байх юу байна вэ? Эндхийн тахилч гэж наргианч эр байдаг, энэ хавиар дайралдах ангийн тал хувийг намнадаг гэдгийг хүн болгон мэднэ. Ойн манаач түүнийг цаашаа дарга нартаа ховолсон, даянчийг томоотой байхгүй бол хувраг, хувцас, мяндаг сэлтийг

нь авна гэсэн юм гэж ярьдаг шүү дээ гэв.

Энэ хоёрыг ярилцаж байх зуур Локсли үүдийг маш чанга шавдан цохисонд даянч, зочин хоёр арай гэж сонсжээ. Даянч хангинасан дуугаа гэнэт таслан, - Ариун эрхээ барьж андгайлахад нэг хүн үүд цохиж байна гээч! Ийм юм хийж суугаагаа тэдэнд харуулахыг би хүсэхгүй юмсан. Хүндэт залуу минь, хэнд ч гэсэн ул шагайх хүн гэж байдаг болохоор ядарч туйлдсан явуулын хүнийг дайлж, шөнө гурван цаг хир түүнтэй цуг суусныг архидсан завхарсанп тооцох хүн гарч юу магад гэв.

Баатар үүнд, - Үгүй юун муухай бузар гүтгэлэг вэ тэр чинь! Тэднийг бол би сайхан залхаагаад өгөх юмсан. Харин хүн бүрд өштөн бий гэдэг яриагүй үнэн, ариун явдалт тахилч гуай. Энэ нутагт ил нүүрээр ярилцсанаас дуулганы халхавчин цаанаас үг солиход дуртай байх хүмүүс надад бий гэв.

- За тэгвэл залхуу найз минь төмөр хувингаа бушуухан толгойдоо углаж үз, тэгээд чадлынхаа хирээр шалмаг хөдлөхийг бодоорой. Энэ зуур би энэ тугалган дашмагуудыг хураачихъя. Эдэн дотор байгаа зүйл одоо миний толгой дотор нэг хачинаар цүлхэлзээд байна. Миний гар үнэхээр жаахан чичрээд байна. Тэгээд сав суулганы чимээг дарахын тулд миний одоо эхлэх дууг өргөж үзээрэй. Үг нь чухал биш би өөрөө ч гэсэн төдий сайн мэддэггүй юм гэв.

Ингэж хэлээд өндөр дуугаар, "Ёроолгүй гүний адгаас залбирав..." гэдэг уншлага уянгалуулан наргиж суусны ул мөрийг арилгаж гарав. Баатар үнэн голоосоо инээн байж хуяг дуулгаа өмсөн инээдээ арай чамай барьж чадсан тухай бүрдээ эзний уншлагыг өргөж байлаа.

- Өдий орой болсон хойно та юун чөтгөрийн уншлага болоод байгаа юм бэ? гэх дуу үүдний цаана гарахад, дэгдсэн их чимээ шуугианаас юм уу согтсондоо болоод ихээ сайн таних дууг даянч танилгүйгээр: - Явуулын эрхэм таныг бурхан өршөөх болтугай. Бурхан болоод гэгээн Дунстаныг бодон замаараа явж үз, нэгэн санваарт гэлэн бид хоёрын уншлагад бү саад бол гэж хариулбал гаднаас,

- Лам чи солиорч орхиогүй биз? Үүдээ тайл, би Локсли байна гэлээ.

- Аа – а! за яамай, зовох юм алга гэж даянч зочиндоо өгүүлэв.

- Энэ юун хүн бэ? Би үүнийг мэдэх учиртай шүү гэж Хар баатрыг асуухад,

- Юун хүн гэж? Миний нөхөр гэж би чамд хэлж байна шүү дээ гэж даянч хариулав.

- Юун нөхөр вэ гэнээ? Энэ чинь асуухад амар, хариулахад хэцүү зүйл байна шүү. Юун нөхөр вэ гэнээ? Үгүй ингээд сайн эрэгцүүлэх юм бол энэ чинь түрүүчийн чамд ярьдаг сайхан зантай шударга ойн манаач чинь мөн гэв.

- За мэдлээ, тэгвэл чиний ариун санваарт гэлэн мөний адил л шударга сайн манаач юм биз дээ. Үүдээ тайлж өг дөө, тэгэхгүй бол хэмх татна шүү гэв.

Энэ зуур эхлээд сүрхий боргоож гарсан ноход одоо янз нь үүдний цаана зогсож байгаа хүний

дуугаар нь танив бололтой хуцахаа болиод, ирсэн хүнийг даруй оруулах гэсэн мэт үүд маажлан гайхана. Даянч түгжээ мултлан Локслийг хамт яваа хоёртой нь оруулав. Йомен орж ирээд баатрыг харан, ингэхэд багш маань хэнтэй наргиж байгаа юм бэ? гэж асуув.

- Энэ манай хүрээний хувраг. Бид хоёр шөнө турш ном уншлаа гэж даянч толгойгоо ганхуулан байж өгүүлэв.

- Тэгвэл дайтагч сүм хийдэд зүтгэдэг хүн байж таарах нь. Ийм улс одоо газар сайгүй дайралдах болжээ. За гэлэн таныг би эрхээ хойш тавиад шийдэм ав гэх гэж байна. Одоо бидэнд лам ч бий харч бий хүн бүр чухал болоод байна гэснээ даянчийг хажуу тийш дагуулж очин нам дуугаар, - Чиний ухаан санаа балартаж орхисон юм шив дээ. Огт үл таних баатрыг оруулж дайлж яаж болдог юм бэ? Чи миний дүрмийн зүйл ангийг мартсан гэж үү гэлээ.

Лам үүнд зоримгоор – Юун үл таних гэж. Үүнийг чинь гуйлгачин аягаа таньдгаас илүү эс андах хүн гэж хариулав.

- Нэр нь хэн гэдэг юм? гэж Локсли асуувал,

- Нэр нь хэн гэдэг юм бэ гэж үү? гэж даянч давтан асуугаад, - Үүний нэрийг эрхэм Антони Скрэбльстон гуай гэдэг юм. Ингэхэд хүний нэрий нь мэдэхгүй байж би хамт дарс ууна гэж үү дээ! гэв.

- Найз минь чи өнөөдөр хэтэрхий их уужээ, аягүй бол тэгээд хэтэрхий олон юм чалчсандаа гэж Йомен хэлэв. Баатар тэдэнд ойртон ирээд, - Йомен найз минь энэ наргианч эзэнд үл уурла. Намайг найрсгаар дайлсан үнэн, гэхдээ энд оруулахыг зөвшөөрөөгүйсэн бол би албаар орох байсан билээ гэв.

- Чи албадах байсан гэнээ? гэж даянч өгүүлэн, - За хүлээж бай, би энэ бор навтсаа ногоон хүрмээр солиод орхив. Тэгээд шийдмээр чиний толгойг хага цохидоггүй юм болж гэм, шударга лам, сайн ойн манаачийн аль нь ч биш болог гээд өргөн жанчаа даруй мултлан хаяж ногоон хүрэм, мөн өнгийн өмд өмсөв.

- Энэ бүх дэгээ гогцоог хийлцээд өгөөч шанд нь нэг аяга сайн дарс өгмөгц гэж Вамбагаас гуйвал,

- Эелдэг үгэнд чинь баярлалаа, харин ариун явдалт даянчаас ойн хэрмэл болж хувирахад чинь туслах гэдэг нүгэл биш байгаа гэхэд,

- Бүү ай! Миний ногоон хүрэмний нүглийг мөн өөрийн минь бор жанчид наминчлаад орхихын хамт хамаг хэрэг болох нь тэр гэв.

- Болтугай! гэж салбадай хэлээд цэмбэн нүгэлтэн ер нь тааран багштай байх нь зохистой, тэгэхлээр чиний жанч мөн миний ч гэсэн хүрэмний хилэнцийг арилгаж өгөг гэлээ. Ингэж хэлээд хүрэм өмд хоёрыг холбосон тоогүй олон дэгээ гогцоог товчлоход тусалж өгөв.

Эднийг үүтэйгээ ноцолдож байх зуур Локсли баатрыг хажуу тийш авч очин:

- Ашбийд болсон эрүүл тулалдааны хоёр дахь өдөр англичуудыг ялахад хүргэсэн баатар та мөн байна, бүү үгүй гээрэй эрхэм баатраа гэхэд,
- Йомен найз чи төв таажээ гэхэд юу гэх вэ? гэж баатар асуулаа
- Тийм бол би таныг дорой талын хүнд тооцож болох нээ? гэв.
- Жинхэнэ баатар хүн бүрийн шууд үүрэг тэр бүлгээ. Миний тухай өөрөөр бодох болбол надад гунигтай байхсан билээ гэж хар баатар өгүүлэв.
- Миний зорилгод бол таны зөвхөн сайн журамт баатар байх нь хангалтгүй, дээр нь чи бас англидаа, үнэхээр элэгтэй хүн байх учиртай. Чамтай миний ярих санаатай байгаа зүйл бол чухамдаа шударга хүн бүрд хамаатай хэрэг мөн авч энэ орны шударга хүвгүүдэд бол онцгой чухаг зүйл юм гэвэл баатар өөдөөс нь,
- Англи орон, англи хүн бүрийн амь насыг надаас илүү үнэтэй үзэх хүн ер олдох болов уу гэв.
- Үүнд дуртайяа итгэж байна. Манай оронд хайрлаж энэрэх хүмүүсийн тусламж өдий их хэрэгтэй байсан цагт ор үгүй билээ. Дуулж бай, би нэг хэрэг явдлын тухай өөрт чинь ярья. Та надад санагдаж байгаа шигээ хүн мөн бол энэ хэрэгт голлон оролцож болох юм. Уул хэрэг ийм билээ. Бүлэг новшийн этгээдүүд, саксоны Седрик гэгч сурвалжит англи хүнийг түүний хүмүүжүүлэгч бүсгүй, найз нөхөр Конингсбургийн Ательстаны нь хамтаар олзлон авсан байна. Тэднийг зэргэлдээх цайзуудын нэг Торкильстон гэгч рүү авч оджээ. Сайн баатар, энэ элэгт англи хүний хувьд тэднийг гаргаж авахад туслах дуртай байгаа эсэхээ хэлнэ үү гэв.
- Тавьсан андгайнахаа ёсоор би үүнийг хийх учиртай, гэхдээ тэдэнд туслаач гэж хэн гуйж байгааг би мэдмээр байна гэвэл Йомен хариуд нь,
- Би өндөр сурвалжит хүн бус. Гэхдээ эх орон түүндээ хайртай хүмүүсийн нөхөр мөн. Миний хэн болох тухай үүнийг дуулсаар сэтгэл ханаж үзнэ үү, тэгээд ч та өөрөө мөн нэр усаа нуух хүсэлтэй байгаа шүү дээ. Гэхдээ харин миний ам алдсан үг алтан даюируул зүүсэн хүнийхтэй адил ган бат гэдгийг мэдтүгэй гэлээ.
- Үүнд би дуртай үнэмшиж байна. Чиний царай шулуун шударга зан, хатан зоригийг илтгэж байна. Иймд би цаашаа юуны ч тухай асууж шалгаахгүй тэр золгүй олзныхныг суллаж тавихад тус больё. Тэнд хоёул арай дотно танилцаж, хэн хэндээ сайн болох биз гэж горилно гэв. Энэ зуур даянч хувцсаа сольж дуусаад Вамба урцны нөгөө булан руу очих замдаа ярианы сүүлчийг дуулжээ.
- Ингэхэд бид шинэ холбоотонтой болох нээ? Энэ баатрын эр чадал даянчийн ариун явдалт, Йомены шударга шулаан шиг л хуурамч зоос битгий байгаасай гэж Гуртэд шивнээд,
- Ээ Локсли надад төрөлхөөсөө хүний юмны хойноос гүйж сурсан хүн, лам гэж хуурмаг наргианч амьтан шиг санагдана гэвэл Гурт хариуд нь,
- Вамба минь өршөөж наад хэл амаа татаж үз. Уг нь тийм байж болох л юм гэхдээ эвэрт

чөтгөр өөрөө одоо хүрч ирээд Седрик, Ровена авхай хоёрыг гайгаас мултлахад тус больё гэвэл тэр тусыг үл авахуйц сүсэг бишрэл надад үгүй болов ээ гэж айж байна гэлээ.

Энэ зуур даянч жинхэнэ Йомены ёсоор илд, бамбай нум саадаг тэргүүтэн агсаж хүнд шийдэм мөрөн дээрээ тавьжээ. Тэрээр урцнаас түрүүлж гараад дараа нь үүдээ нямбайлан хааж түлхүүрээ босгон доогуур шургуулав.

- За найз минь хэрэг явдалд нэмэр болохтой байна уу? Эсвэл толгой чинь мансуурсан хэвээрээ л байх юм уу? гэж Локсли асуусанд лам өөдөөс нь,

- Мансуурлыг гаргахын тулд Дунстан гэгээний сувраганы уснаас ганц балгахад л боллоо. Үнэндээ толгойд нэг юм шуугиж, хөл баахан дуулгавар муутай байх авч хурамхан зуур зүгээр болно биз гэв.

Ингэж хэлээд чулуун хашлага руу очиж булгийг тэр аяар нь шавхах гэсэн юм шиг амаараа удаан залгилав.

- Копмангерстийн ариун тахилчин танд урьд ийм их ус уух явдал тохиолдож байсан уу? гэж Хар баатрын асуухад,

- Зөвхөн ганц л удаа миний дарсны торх хагсаж, дарс маань хий гоожиж орхисон үед л уснаас өөр уух юм надад даанч байгаагүй дээ гэв. Тэгээд гараа, дараа нь толгойгоо усанд дүрж шөнө дөлөн уусныхаа ул мөрийг угааж орхилоо.

Согтуу нь бүрэн гарсан хойноо наргианч даянч хүнд шийдмээ гурван хуруугаар барин толгой дээгүүрээ таяг адил эргүүлж:

- Хүүхэн хүнийг хүчээр авч оддог өөдгүй хар хулгайч нар хаана байна? Тийм муусайн новшнуудыг бүтэн арваар нь дийлэхгүй юм бол намайг чөтгөр аваг! гэж хашгирав.

- Ариун явдалт тахилчин та бас харааж чадах юмаа? гэж Хар баатрыг өгүүлэхэд,

- Намайг тахилчинд тооцохоо больж үз гэж зүсээ хувиргасан лам дургүйцээд, - Би чинь мөрөнд жанч нөмрөөстэй байх цагт л хувраг гэдгийг Георги гэгээн, түүний луунуудыг барьж андгайлъя. Ногоон хүрэм өсөхийн хамт согтуурч хараал тавьж аль ч ойн манаачаас дутахгүй хүүхнүүдийн хойноос гүйж чадна шүү би гэв.

- Түрүүлээд яв яриа хар минь, амаа жаахан хамхиж үз, өнөөдөр чи цагаан сарын орой хамба ламтныг унтаад өгсний дараа шуугилдаж байгаа бүтэн бүлэг хуврагууд шиг их шуугиан тарьж байна шүү. Явъя нөхдөө удаашраад байх юм алга. Хүчээ бушуухан цуглуулах хэрэгтэй, гэсэн ч Режинальд фрон де Бефийн цайзыг дайрч эзлэхэд хүн цөөдөх л байх гэж Локслийг өгүүлэхэд,

- Юу? гэж Хар баатар дуу алдан, - Үгүй тэгвэл Фрон де Беф их зам отоож хааны эзний албат харьяат нарыг олзолж авдаг болсон хэрэг үү? Тэр чинь тэгээд хулгайч, хяхан хавчигч болоо юу гэв.

- Хяхан хавчигч ч хэзээний л байсан хэрэг гэж Локсли өгүүлэхэд,

- Хулгайлахын хувьд гэвэл миний танил хулгайч нарын шударга сайн талд ч болов хүрнэ гэвэл юмаа тэр чинь гэж лам тосож аван өгүүлбэл Йомен түүнд:

- Яв, яв лам чи дуугүйхэн түрүүл, ёс зүй бодоод ч гэлээ, мөн хянуур болгоомжийн үүднээс ч тэр ярихад эвгүй зүйлийн тухай илүү үг ярихын оронд биднийг цугларах газарт шалавхан шиг дагуулаад очвол сайн байна гэв.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Дэнгийн гэрэлд гийсэн ширээт

Тойрч суугаад найралдаг цаг

Огтхон ч эргэж ирсэнгүй

Харин үдшийн бүрэнхий болоход

Ханхар өндөр өрөөнүүд дотор

Урьд дээр шарилаа орон нойрсогчдын

Удаан алгуур шивнэлдэх

Улирсан эрт цагийн хүүрнээс

Одоо ч болов дуулдах шиг болдог.

"Орра" гэдэг эмгэнэлт жүжгээс

Седрик болоод хань нөхдийг нь суллах эдгээр бэлтгэл ажлуудыг хийж байх зуур тэднийг олзлон авсан зэвсэглэсэн бүлэг хорьж байхаар шийдсэн бат цайз руугаа яарж байв. Төдөлгүй хав харанхуй болсон бөгөөд хулгайлсан хүмүүс ойн зөргийг төдий сайн мэддэггүй бололтой. Хэд хэдэн удаа зогсож, хоёр ч дахин хуучин газар руугаа эргэж ирэв. Тэднийг зөв замд ороогүй байхад зуны шөнө өнгөрч үүр цайсанд тэд урагшаа хурдлан одов. Энэ үеэр хоёр тэргүүлэгчдийн хооронд ийм яриа гарлаа.

- Морис гуай та биднээс салж одох цаг боллоо, та аврагчийн дүр үзүүлэх учиртай шүү дэ гэж сүмийн хорооны баатар де Брасид хэлбэл өөдөөс нь,

- Үгүй, би бодлоо өөрчилсөн, олзоо Фрон де Бефийн цайзанд хүрэгтэл чамаас салахгүй. Тэнд би Ровена хатагтайн өмнө үнэн дүрээр очиж ийнхүү хүч хэрэглэсэн явдал миний хайр сэтгэлийн халуунаас боллоо гэдэгт итгүүлж чадах болов уу гэж найдана гэв.

- де Браси чи юунаас болж анхныхаа төлөвлөгөөг өөрчлөх болов? Гэж сүмийн хорооны баатрыг асуухад,

- Гэхдээ эрхэм баатар та намайг бузар булай сэтгэл өвөрлөлөө гэж хардсанаас ийм өөрчлөлт гараагүй болов уу гэж найдана гэхэд де Браси өөдөөс нь:

- Миний бодол дотроо л үлдэг. Нэг хулгайч нөгөөгөө цөлөмхөд чөтгөр баярладаг гэж ярилцдаг сүмийн хорооны баатрын зоргоороо аашлахад ямар ч чөтгөр саад хийж хүч хүрэхгүй бас хэн бүхэн мэднэ гэвэл цаадах нь тосон аваад,

- Хөлсний багийн тэргүүлэгч өөрөө хорвоо дээр хүн болгонд тарьдаг гайг нөхрөөсөө ирнэ

гэж сэжиглэхэд мөн юу ч саад болохгүй гэв. де Браси үүнд, - Нэг-нэгнийгээ дэмий зэмлээд яах вэ? Сүмийн хорооны баатруудын зан суртахууны тухай би төсөөлөлтэй бөгөөд өдий их аюул учирсан байж олсон гоо бүсгүйгээ булааж авах боломж чамд олгох дургүй байна гэв.

- Дэмий үг! Чамд айх юм юу байгаа юм бэ? Манай хороо ямар шүү санваарт захирагдаггийг чи мэднэ шүү дээ гэвэл,

- Мэдэлгүй яах вэ? Харин тэр санваарыг хэрхэн сахидгийг би бас мэднэ. Больж үз дээ эрхэм баатар. Бүсгүйчүүлд үйлчлэх гэдэг ойлголт Палестинд тун өргөн утгаар ойлгогддог, шуудхан хэлэхэд чиний үнэнч шударгат би юун дээр ч итгэж зүрхлэхгүй шүү гэв.

- Тэгвэл танай тэр саксон гоо бүсгүйг би огтхон ч сонирхохгүй байгааг мэдэж ав. Цуг яваа өөр нэг бүсгүй л надад илүү их таалагдаж байна гэлээ.

- Чи үнэхээр тэр гоо еврей хүүхний тухай ярьж байна гэж үү? гэж де Браси асуусанд,

- Тийм байлаа гэхэд энэ хэрэгт хэн надад саад хийж юм бэ? гэж Буагильбер өгүүлсэнд де Браси асуусанд нь,

- Гэрлэхгүй гэж өргөсөн андгай чинь л үгүй юм болж гэм миний мэдэж

байгаагаар өөр юу ч саад болохгүй. Эсвэл еврей хүүхэнтэй явдал учир болоход хүнч сэтгэл чинь төвдөхгүй байж мэдэх юм даа гэв.

- Санваарын хувьд гэвэл би богд багшаасаа зөвшөөрөлтэй, хүнч сэтгэлийн хувьд гэвэл өөрийн гараар гурван зуу шахам сарацин алсан хүн жижиг нүглийг хайхрахгүй байж болох дог. Би ямар улаан нүдэн пүрэв гаригт анх удаа нүглээ наминчлахаар явж байгаа тосгоны хүүхэн биш гэвэл де Браси,

- Чиний эрх мэдэл хир их болохыг чи өөрөө мэдэх учиртай. Гэхдээ би харин мөнгө хүүлэгч хөгшин, мөнгөний тулам чиний сэтгэлийг охины нь хар нүпгээс илүү татаж байсан гэж андгайлахад бэлэн байсан юм гэв.

- Аль аль нь сэтгэлд нийцтэй. Гэхдээ хөгшин еврей чинь зөвхөн тал хувь л миний олз юм шүү. Түүнийг Реджинальд Фрон де Бефтэй хуваалцахад хүрнэ. Цайздаа зүгээр хорогдуулахыг цаадах чинь зөвшөөрөхгүй шүү дээ. Тэгээд чи хувь авахаас гадна, гоо сайхан еврей хүүхэн хувааригүй миний олз болог гэж шийдсэн. Одоо чи миний санааг мэдэж байгаа бол анхныхаа төлөвлөсөн ёсоор үйлдэж болно. Миний оролцооноос айх юм алга гэдгийг өөрөө үзэж байна шүү дээ гэвэл де Браси өөдөөс нь:

- Үгүй юу ч гэсэн би олзныхоо ойролцоо л байна. Чиний хэлж байгаа бүхэн яриагүй зөв зүйтэй, гэхдээ багшийн чинь өгсөн зөвшөөрөл болоод гурван зуун сарацин алсны үүднээс эдлэх онцгой эрх чинь миний сэтгэлийг зовоож байна. Алив хэрэг үйлдэхэд хэлтрүүлэн өнгөрөөнө гэж чи хэт итгэлтэй байгаа болохоор аар саар юман дээр их ёсорхохгүй хүн байна шүү дээ гэв.

Хоёр баатрын хооронд ийм яриа явагдаж байх зуур Седрик чухам юун хүмүүс ямар зорилгоор довтолсон болох талаар хүрээлж байгаа хуягуудаас үг дуулах гэж элдвээр мэрийлээ.

- Та нарыг гаднаас харахад англичууд шиг мөртлөө нэг нутгийнхан руугаа ёстой норманууд шиг дайрсан. Хэрэв та нар миний хөрш болж гэм миний нөхөд байж таана, манай англи хөршүүдийн дотроос хэзээ нэг цагт надад дайсагнаж байсан хүн ер байсан гэж үү? Йоменуудаа та нарын дотроос дээрмийн бузар хэрэгт оролцсон нэгэнд ч би өршөөл ивээл үзүүлж, тэдний ядуу зүдүү байдлыг ойлгож үзэж харгисаар хяхан мөрдөгчид, хүнч сэтгэлгүй тайж нарыг тэдний хамт зүхдэг билээ. Та нарт надаас юу хэрэгтэй юм бэ? Яагаад надад ийм хүчирхийлэл хэрэглэж байна. Та бүхний авирлаж байгаа чинь араатнаас ер ялгаа багатай болохыг харуулж байна. Та нар хэл амгүй араатныг бүр хэл амгүйгий нь хүртэл бас дуурайя гэж саналаа гэж үү дээ? гэж асуув.

Энэ бүх яриа үр дүн эс өгөв. Хуягуудад нь ам нээж үл болох хүндэт шалтгаан олон байсан болохоор уур хилэн ятгалгын алинаар ч тэднийг аргалж болшгүй байжээ. Тэд Седрикийг урагш авч давхисаар эцэсдээ өргөн замын цаад үзүүрт тэрхэн үед Реджинальд Фрон де Бефийн эзэмшиж байсан, Торкильстон хэмээх эртний цайзны бараа харагдав. Энэ цайз нь өндөр дөрвөлжин бөгөөд арай намхан барилгуудаар хүрээлүүлсэн, гадуураа, баг хэрэмтэй том цамхаг бүлгээ. Хэрэмний гадуур дүүрэн устай гүн шуудуу татаж Фрон де Беф айл хөршийнхэнтэйгээ дайсагнах нь их тул хэрэмний гадаа өнцөг бүрд дахин нэг цамхаг нэмж барин цайзаа батаар хамгаалжээ. Орох хаалга нь тэр цагийн бүх бэхлэлтүүдийн нэгэн адил нум хэлбэрийн саравчин дор хоёр талдаа жижиг цамхаг бүхий ажээ.

Цайзны орчны ой модноос дээш сүндэрлэн байх хөвд ургасан хөрөөний их хэлбэртэй хэрэмний барааг Седрик хармагцаа чухам ямар хэрэг явдал болсныг даруй ойлголоо.

- Энэ адгийн луйварчингуудыг хулгайч дээрэмчдийн бүлгийн хүмүүс гэж бодон тэднийг гомдоожээ. Энэ чинь манай ойн үнэгийг францын цөөвөр чононуудтай адилтгана гэсэн үг. Танай эзэн чинь миний амь насанд тэрслээ юу, эд хөрөнгөнд шунаа юу, хэл! Муусайн нохдууд! Энэ оронд газар эзэмшдэг хоёр саксон хүн, өндөр төрөлт Ательстан бид хоёр үлдсэнд тэр хорсдог байх. Тэгвэл биднийг алаад буруу хар үйлээ гүйцээж орхи! Та нар бидний эрх чөлөөг хассан, одоо амь насыг чинь авцгаа. Саксоны Седрик Английг аврах хүч үгүй авч түүний төлөө амиа өгөхөд бэлэн. Ганцхан Ровена хатагтайг л элдвээр гомдоолгүй тавьж явуулахыг намайг гуйж байна гэж цаад хүний үнэргүй эзэндээ хэл! Ровена бүсгүй хүн, түүнд айх юм үгүй бид үхсэнээр энэ авхайг өмөөрдөг эцсийн дайчин эр үхэж байгаа нь тэр гэв.

Хуягууд энэ үгэнд ч мөн хариу дуугарсангүй, энэ зуур тэд цайзны хаалганы өмнө ирж зогсон, де Браси гурав дахин бүрээдэв. Тэгмэгц тэдний бараагаар хэрмэн дээр овоорч ирсэн харваачид яаран доош бууж дүүжлүүр гүүр буулган айлчдыг цайзанд оруулав. Хуягууд олзны хүмүүсийг мориноос буулган танхимд оруулж өглөөний хоол ид гэсэнд Ательстанаас өөр хэн ч хоолонд ам хүрсэнгүй. Гэхдээ буянч хааны удмын энэ хүнд ч амтат зууш олигтойхон зооглох зав өгсөнгүй. Седрик тэр хоёрыг Ровена авхайгаас тусад нь өрөөнд оруулна гэж хуягууд ирж дуулгав. Эсэргүүцээд тусгүй. Өнөө хүртэл манайд эртний хийдэд үзэгддэг саксоны болхи баганууд дээр тулгуурласан нуман дээвэр нь хоолны өрөөтэй төстэй санагдах том тасалгаанд тэднийг хүчээр оруулав. Дараа нь Ровена хатагтайг шивэгчингүүдээс нь салган онц эелдгээр

боловч саналыг нь асуулгүйгээр тусгай өрөөнд оруулав. Эцэг нь гуйж цөхрөнгөө барсан хэдий авч Ревеккад мөн иймэрхүү эргэлзээтэй хүндэтгэл үзүүлэв. Охиноо хамт л үлдээвэл мөнгө ч билээ өгье гэж цөхөрсөн өвгөн хэлж байв.

Манаач нарын нэг нь - Чамд ямар шүү үүр бэлтгэснийг үзэхээрээ охиноо хамт үлдээхийг чи өөрөө ч гэсэн хүсэхгүй болно, бузар новш! гэв.

Ингээд цаашаа илүү дутуу үггүйгээр хөгшин Исаакийг олзны бусад хүмүүсээс салган өөр тийш нь чирч одов. Зарц нар нарийвчлан нэгжиж, зэвсэг сэлтийг хураан тусгай байранд цоожлов. Ровена хатагтайд шивэгчин Эльджитаг хүртэл үйлчлэх эрхийг нь хасав.

Саксоны хоёр удирдагчийг оруулсан өрөө урьд гол танхим байсан хэдий авч тэр цагт харуулын байр маягтай байжээ. Цайзны эзэн өөртөө норман хээ угалзаар чимсэн нуман дээвэр, хээнцэр хөнгөн багана дээр тулгуурласан шинэ сайхан танхим бариулжээ.

Седрикийн уур хилэн бадарч, сэтгэл догдлон өрөөн дотуур хойш урагш холхиж байхад төрөлхийн хөшүүн зан нь тэсвэр, хайш хэрэг хатан сэтгэлийг нь орлох болсон Ательстан аар саар гачигдлаас бусад зүйлийг үл хайхрах ажээ. Үүнд ч онц зовохгүй болохоор Седрикийн догдлонгуй халуун цочмог үгний хариуд хааяа нэг хариулаад ихэнхдээ дуугүй байна.

Седрик өөр зуураа эрэгцүүлэхийн хамт Ательстанд хандан, - Ингэхэд, яг энэ танхимд миний өвөг эцэг эрэлхэг баатар авч золгүй Гарольдийг дайлж байсан Торкил Вольфгангертай хамт найрлаж байсан бүлгээ. Гарольд тэгэхэд самуун дэгдээгч Тостийн удирдлагын дор тэрслэн боссон норвегуудтай байлдахаар мордох гэж байсан юм. Энэ танхимд Гарольд дургүйцэн тэрсэлсэн дүүгийнхээ элчийг хүлээж авсан юм. Тэр тухай эцэг надад хичнээн удаа сэтгэл хөөрөн ярьдаг байсан билээ! Тостийн явуулсан хүнийг саксоны өндөр сурвалжит тэргүүлэгчид дүүрэн сууж, эзэн хаанаа тойрон улаан дарс ууж байсан танхимд оруулж ирсэн юм гэв.

Энэ нарийн зүйлийг дуулсан Ательстан сэргэж бидэнд дарс, идэх юм ирүүлэхээ эд мартахгүй байгаа гэж найдана. Өглөөний хоолонд бид дөнгөж ам хүрч амжсан, тэгээд ч мориор явж ирсэн даруйдаа их юм идэх их сайхан гэж эмч нар хэлдэг авч надад бол төдий сайн зохидоггүй юм гэв.

Энэ үгийг Седрик үл хайхран яриагаа үргэлжлүүлж,

- Тостийн элч, тал бүрээс нь ширтэх ширүүн харцнаас үл эмээн танхим дундуур явж Гарольд хааны ширээний өмнө очиж зогсоод мэхийн ёслоод,

"Танай дүү Тости зэвсгээ хурааж, найрамдахыг хүсвэл ямар нөхцөл тавихыг эзэн хаан та айлдаж хайрлана уу?" гэжээ.

Өгөөмөр сэтгэлт Гарольд үүнд, "Миний ах ёсны найран дээр Нортумберлендскийн сайхан хушууг өгнө!" гэж дуу алдав. Хэрэв Тости тийм нөхцөлийг зөвшөөрвөл түүний үнэнч холбоотон норвегийн хаан Хардрадад ямар газар эдлэн шагнах вэ? гэж элчийг асуухад, Гарольдийн уур хилэн дүрсхийж, "Долоон ямх англи газар! Тэр Хардрад үнэхээр тийм баатар

том биетэй юм болж гэм бас арван хоёр сөөмийг нэмж ч болно" гэлээ.

Бүх танхимаар нэг бахдан хашгиралдах дуу гарч, хундага, эвэр тэргүүтнийг дарсаар дүүргэв. Тэр Норвег "Англи газраа" бушуу эзэмдэх болтугай гэж тэргүүлэгчид хундага өргөцгөөжээ гэхэд Ательстан:

- Би тэдэнтэй их л дуртай хамтран уухсан, юу гэвэл миний хоолой үнэхээр хатаж гүйцлээ гэв. Сонсогч уул яриаг өчүүхэн ч сонирхох шинж үгүй байсан авч Седрик их л хөхүүнээр цааш нь:

- Элч зовонгуйрч, Тости түүний холбоотон хоёрт доромжлогдсон ахын нь ёозгүй хариуг дуулгахаар оджээ. Тэгээд л Йоркийн цамхаг Дервентийн цусанд улбартсан урсгал хоёр харгис ширүүн тулалдааны гэрч болсон бүлгээ. Энэ тулалдааны үед норвегийн хаан Тости хоёр эрэлхэг баатрын гайхамшгийг үзүүлэн арван мянган шилдэг цэаргийнхээ хамт дарагдсан билээ. Тэр их ялалт байгуулсан мөн өдөр саксоны ялгуусан тугийг намируулсан салхи норманы давалгааг үлээн Суссекийн гайт эрэг рүү хөлөг онгоц хөтөлж байсныг хэн мэдэх билээ. Хэдхэн өдрийн дараа Гарольд өөрөө хаант улсаа алдаж оронд нь норвегийн хаад өөрөө тогтоож өгсөн шигээ хэмжээний англи газар эзэмших болно гэж хэн санах билээ. Эр зоригт Гарольд хааны үр сад өндөр төрөлт Ательстан чи, мөн саксоны хаан төрийг хамгаас эрэлхгээр хамгаалагчдын нэгний хүү болох миний бие адгийн муу норманд олзлогдон манай эцэг дээдэс өдий ёсорхог сайхан хурим найр зохиож байсан тэр танхимд хоригдон байх юм гэж хэн бодох билээ? гэвэл Ательстан өөдөөс нь,

- Тиймээ, энэ чинь сүрхий гунигтай явдал. Гэхдээ эд тааруу нэг золиос байлгүй. Юу ч гэсэн эд биднийг өлсгөж зовоох санаа арай үгүй бизээ. Гэхдээ үд дунд лав болсон байх харин хоол өгөхөөр бэлтгэж байгаа юм надад ер харагдахгүй байна. Өндөр төрөлт Седрик та цонхоор харж өдөр дунд ойртсон эсэхийг сүүдрээр гадарлахыг оролдоно уу гэв.

Седрик үүнд, - Ойртсон ч байж мэдэх юм харин энэ хээ хуар болсон цонхыг хараад бидний аар саархан гачигдлын тухай бус огт өөр зүйлийн тухай бодож байна. Эрхэм нөхөр минь, энэ цонхыг гаргаж байхад манай эрэлхэг эцэг дээдс ажил хийх ухаан, тэр дундаа түүнийг гоёох аргыг бүр ч мэддэггүй байж. Вальфгангерийн бардам зантай эцэг энэ танхимийг шинэ жилээр гоёхын тулд нормандаас зурагчин дууджээ. Тэр жилүүд өдрийн алтлаг гэрлийг элдвэр маягиын өнгөтэй болгон тусгана. Харийн тэр зурагчин нь, адгийн муу зарцын өмнө хүртэл мэхэлзэхэд бэлэн зусарч бөхөлзөнгүй ядуу гуйлгачин ирээд эндээс өөхөлж гүйцсэн их амьтан буцаж, саксон тайж нарын цагаан цайлган зан барил, цаглашгүй их эд баялгийн тухай өөрийн үндэсний шунаг хар сэтгэлтэнгүүдэд ярьжээ. Хуучны бүдүүн бор зан суртахууныг зориуд хадгалан дэмжиж байсан Хенгистын үр сад болоод баатар дайчдын аль эртнээс урьдчилан харж байсан их алдаа тэр байсан юм даа, Ательстан. Тэр харийн хүмүүсийг бид найр тавин угтаж авдаг. Тэд бидний сайн нөхөд ч болдог, итгэлт зарц ч байдаг тэдний ур дархчуудыг залан эрдэм заалгадаг байсан тэг тэгсээр яруу алдарт өвөг дээдсийнхээ шударга борог байдлыг бид үл ойшоох болж норманы зэр зэвсэг биднийг дагуулахаас өмнө норманы тансаг байдалд бид автан танхил болчихсон байжээ. Уул нь бид далайн чанад дахь орнуудын элдэв амтанд дассанд орвол гэрийнхээ зуушийг амар чөлөөтэй уугаад суувал их дээр байхсан билээ гэвэл, Ательстан хариуд нь:

- Одоо хамгийн бааз хоол тансаг идээ мэт санагдахаар байна. Эрхэм Седрик та өнгөрснийг

өдий сайн санаж байх мөртлөө үдийн хоол идэх цаг болсныг мартчихдагт би гайхаж байна гэлээ.

Хоолноос өөр юмны тухай ярьвал дэмий цаг үрнэ гэсэн үг байна гэж Седрик амандаа унтуужан үглээд,

- Янз нь хардиканутын сүнс үүнд ирж амилсан бололтой. Идэж уухаас өөр бодох юм гэж Ательстан руу харамсангүй хараад цааш нь, - Ийм сайхан биенд өдий хайш яаш сэтгэл заяадаг нь тоогүй. Английг дахин сэргээх өдий их хэрэг ийм өөдгүй хөшүүрэгний ажиллагаанаас шалтгаалах нь мөн ч хэцүүеэ! Хэрэв Ровенатай суучих ахуул авхайн өндөр сайхан сэтгэлэг, түүний зан төрхийн сайн талыг сэргээж магад юм даа. Гэтэл Ровена, Ательстан, би өөрөө цөм энэ зэрлэг дээрэмчид олзлогдоод байхад юуны хурим найр байхсан билээ ? гэж бодов.

Саксон тайжийг иймэрхүү гунигт бодолд автан байтал шорон болсон өрөөний нь үүд нээгдэж цагаан очир барьсан зуушны даамал орж ирэв. Энэхүү өндөр хэргэмтэн өрөөнд ихэмсгээр алхан орж ирэхэд хойноос нь дөрвөн зарц, Ательстаны дотор түрүүчийн төрсөн сэтгэгдлийг дурай арилгахуйц сайхан үзэмж, үнэртэй идээ хоол тавьсан ширээ дамжлан оруулав. Хоол авч ирсэн зарц нар цөм цув өмссөн, багтай ажээ. Ательстан,

- Юунд зүсээ буруулав? Танай эзний цайзанд байгаагаас хойш хэн биднийг олзлон авсныг мэднэ гэж бодоогүй биз дээ? гээд хэлэлцээр хийх завшааныг ашиглан бидний хөрөнгөөр зүй бус баяжих ганц хүслийн үүднээс ийнхүү хүчирхийлэл явуулж байна гэж бид үзэж байна гэдгийг Реджинальд фрон де Бефд дуулга. Иймэрхүү байдал жинхэнэ дээрэмчдэд золиос төлдгийн адил түүний шуналыг хангахад бид бэлэн байгааг мөн хэл. Биднийг чөлөөлөхөд авах золиосны хэмжээг тогтоог, тэр нь бидний хөрөнгө зоорийн хирнээс хэтрэхгүй бол төлж өгнө гэв.

Зуушны даамал хариуд нь зөвхөн толгой дохив. Ательстан ам нээж, --Намайг үхлийн эрүүл тулалдаанд дуудаж байна, биднийг суллан тавьсны дараа найм дахь хоног дээр үзэлцье гэж байна гэж Реджинальд Фрон де Бефд хэл. Тэр үнэхээр эр баатар хүн л юм болж гэм миний хүсэлтийг үл хүлээж авах юм уу тулалдааныг хойшлуулж зүрхлэхгүй байх гэв.

Зуушны даамал үүнд, - Таны дуудлагыг баатарт уламжилъя одоогоор та бүхэн хоол зооглоно уу? гэв.

Ательстан бөөн мах хичээнгүйлэн зажилж байсан болохоор угийн ээрүүдүүг нь улам их болгож дээрэнгүй үгний нь төрүүлэх сэтгэгдлийг ихэд буруулан уул дуудлага айхавтар сүртэй болж өгсөнгүй. Хэдий тийм авч Седрик үүнийг цуг яваа нөхрийнхөө дайчин зоригт сэргэж байгаагийн шинж яриангүй мөн гэж үзэж баяр хүргэв.

Бүрэн сайшааж байгаагаа илчлэн халуун сэтгэлээр гар барьснаа "хоолонд өдий их сармис хийдэг энэ цайзнаас гарахын тулд Фрон де Беф шиг арван хэдэн эрчүүлтэй ч тулалдахад бэлэн байна" гэхийг нь дуулан баахан урам гутрав.

Ательстан угийн хайш хэрэг ховдог зандаа орсныг Седрик үл хайхран өөдөөс нь харж суугаад

эх орныхоо гай зовлонг болон хоол ундны тухай мартаж чадах авч саксон удмуудаа дууриан хоолонд мөн зэгснээ төдөлгүй үзүүлэв.

Олзлогдсон хоёр өглөөний зоогоо сайн идэж завдалгүй байтал цайзны өмнө бүрэн дуу тасхийж, энэхүү чухаг ажлаас анхаарлыг нь салгав. Бүрэн дуу гурав дахин маш чанга цууриатсан нь үлгэрийн баатар ид шидтэй цайзны өмнө ирж шидийн хүчийг хэрэм, цайз харвах онь тэргүүтнийг өглөөний манан шиг сарниулах гэсэн мэт ажээ.

Саксончууд давхийн босон харайж цонх руу яаран очвол уул цонх цайзны арын хашаа руу харсан тул юу ч үзэгдсэнгүй. Гэвч тэр даруй цайзан дотор сүрхий хөл хөдөлгөөн дэгдээснийг үзвэл ямар нэгэн чухал үйл явдал болсон нь илт ажээ.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

"Миний охин! мөнгө зоос!"

Христос шашинтаас минь!

Хичнээн хураасан мөнгө зоос!

Хайртай охин мөнгө зоосийг олж өгөх

Хууль ёс шүүх цааз хаана байнаа"

Шекспир "Венецийн худалдаачин"

Саксоны толгойлогчдыг саатал орсон зоогоо үргэлжлүүлэх бизээ хэмээн орхиод илүү их зовлонтой олзны хүн Йоркийн Исаак юу болж байгааг өгүүлье. Хөөрхий еврейг газар дор гүн орших чийгтэй хар гянданд хаяжээ. Олзны хүн гар үл хүрэх өндөрт гаргасан нэг хоёр жижиг нүхээр л гэрэл сүүмийнэ. Хурц гэрэлтэй өдрийн цагт хүртэл тэдгээр нүхээр маш өчүүхэн гэгээ орох тул нар шингэхээс аль өмнө зооринд харанхуй болно. Түрүүчийн хоригдлуудыг тамалсан гинж, дөнгөнүүд, гяндангийн ханаар дүүжлээстэй харагдана. Нэгэн дөнгөний нүхнээс хүний хөлийн дутуухан илжирсэн сүг цухуйх нь хоригдлуудын нэг энд үхэж амжсан төдийгүй хүүр нь араг яс болж өнгөрсөн бололтой.

Энэхүү зэвүүн зоорины нэг өнцөгт ил гал түлэн өргөн зуухны дээр зэвэрсэн төмөр сараалж дүүжлээстэй байна.

Гядангийн зэвүүн ёозгүй байдал Исаакаас ч зоригтой эрийг айж хэлмэгдүүлэхээр байсан боловч жинхэнэ аюул тулгараад ирсэн хойно Исаак түрүүн хий юмнаас сүрдэж явсныгаа бодвол илүү их тайвширсан байлаа. Тэгээд ч Исаак иймэрхүү юм нэг биш удаа үзэж өнгөрүүлсэн, нилээд туршлагатай хүн болохоор энэ удаа ч мөн гай зовлонгоос аргацаан мултрах найдлага агуулж байжээ.

Чийгнээс биеэ хамгаалж цуваа нягтлан нөмрөөд зоорины нэгэн буланд очиж суусанд элгээ эвхэж байгаагаар арзайсан үс, сахал, үстэй нөмрөг цув, гозгор малгай сэлт нь бүүдгэр муу гэрэлд Рембрандтад уран зургийн сайхан сэдэв болж өгмөөр харагдана. Исаак ийнхүү нэгэн янзаар гурван цаг орчим нам суулаа. Гэнэт нүхэн зоорь руу орох шатаар хөлийн чимээ гарч үүдний түгжээ чихран, зэвэрч гүйцсэн дэгээ хяхтнан мултарч намхан хаалга нээгдэн Реджинальд фрон де Беф гянданд Буагильберийн сарацины боолчуудаас хоёрыг дагуулсаар орж ирлээ.

Фрон де Беф нуруу өндөр, чийрэг булиа биетэй эр байлаа. Бүх насаа аян дайн буюу айл хөрштэйгээ дайсагналцан өнгөрөөхдөө феодал эрх мэдлээ өргөтгөхийн тулд юунаас ч буцдаггүй, мөн нүүр царай нь хүртэл зан авирт нь нийцэж гол нь харгис хэрцгий хилэн хорслыг илтгэнэ. Шархны олон сорви царайг нь улам л догшин дүртэй, улс ч аймаар болгох бүлгээ. Энэхүү догшин бээл биеэ барьсан савхин хүрэм өмссөн нь хуяганд нь халцарчээ. Баруун ташаанаасаа унжих хэлхээ түлхүүрүүдтэй тэнцүүлсэн хутганаас өөр зэвсэг үгүй.

Бээлтэй хамт ирсэн хар арьстан боолчуудын хувцас гэвэл урт цамц, бүдүүн ёрог мод төдий аж. Бойны газарт ажиллаж байгаа яргачин шиг ханцуйгаа тохойноосоо дээш эргүүлжээ. Хоёул нэг нэг сагс барьжээ. Тэр хоёр гянданд орж ирмэгцээ Фрон де Бефийн гараар хичээгүйлэн хаасан үүдний хоёр талд зогсов. Урьдчилан сэргийлэх энэхүү арга хэмжээг аваад бүхэл зоорийг хөндлөн алгуурхан алхаж, эгцлэн ширтсээр Исаак дээр хүрч очлоо. Энэ харцаараа еврейн хамаг зоригийг мохоох гэсэн байртай. Үнэхээр ч бээлийн хөөрхий олзны хүнийг тийнхүү үхүүлэх чадалтай мэт. Исаак амаа ангайн нам сууж догшин баатар руу гүнээ хилмэгдэн харж, харгис хатуу норманыг тас ширтэхэд хамаг бие нь атирч байв. Хөөрхий Исаак босож мэхийх тэнхээгүйгээр барахгүй хээгүй байв. Одоо эрүү шүүлт эхэлж, үхтэл нь тамлаж магадгүйг бат мэдэж байв. Золгүй еврейн атиралдаж суугаа буланд баатар гурван алхам тулж ирэн зогсоод боолчуудын нэгийг ир гэж зангав. Хар арьстан зарц хүрч ирж сагсан дотроосоо жин, том бага туухайнууд гаргаж ирээд Фрон де Бефийн хөл дор тавин дахин үүд рүү холдов.

Фрон де Беф эхлээд олзлогдсон үйлийн үрт хүн рүү хандан,

- Хараал хүрсэн муу нохой чи! Энэ жинг харж байна уу? гэж аргил ширүүн дуугарахад хөндий зоорь аягүй муухайгаар хүнгэнэн цуурайтав.

Золгүй Исаак зөвхөн тэргүүнээ улам доош бөхийлгөв.

Энэрэх сэтгэлгүй бээл цааш, - Яг энэ жин дээр чи надад Лондон дахь эзэн хааны тоо бүртгэлийн газраас баталсан нарийн тоо хэмжээний дагуу мянган фунт мөнгө дэнсэлж өгнө дөө хөө гэв.

- Өвөг эцэг Авраам минь! гэж еврей дуу алдаад, - Өдий их мөнгө нэхэх гэж урьд хожид дуулдсан хэрэг үү? Яруу найрагчдын дуунд хүртэл мянган фунт мөнгөний тухай дуулдаггүй билээ. Хүний нүд ер нэгэн цагт тийм сайхан юмыг үзсэн болов уу? Үгүй бүх Йорк хотод миний бүх гэр орон, нэгэн үндэстнүүдийн маань гэр орныг хуу нэгжээд үзэхэд ч чиний надаас шаардаж байгаа мөнгөний аравны нэг хувь ч гарахгүй шүү! гэвэл Фрон де Беф хариуд нь:

- Би ухаантай хүн, танд мөнгө хүрэлцэхгүй байвал алт авч ч болно. Нэг цэн алтыг зургаан фунт мөнгөнд тооцон төлөөд наад бузар арьсаа урьд хожид зүүдэнд чинь ер багтахгүй айхавтар эрүүнээс аварч болох юм гэв.

- Сайн явдалт баатар та намайг өршөөж үз. Би хөгшин ядуу, арчаа тасарсан амьтан! намайг дийлсний өндөр гэж их бус бизээ. Чийгний хорхойг няц дарахад онцын гавьяа үгүй билээ гэвэл баатар,

- Чиний хөгшин гэдэг үнэн. Мөн дорой гэдэг чинь ч ортой байж болохтой. Харин чиний баян гэдгийг хэн бүхэн мэднэ гэв.

- Сайн үйлт баатар танд бүх тахиж шүтдэг бүхнээ барьж, та бидний адилхан сүсэглэгч бурхныг барьж андгайлахад... гэж Исаакийг дуу алдтал, Норман тас дайран:

- Хуурамч андгай бүү тавь! Дэмий зөрж байж хувь тавилангаа урьдаас бүү муугаар шийд, эхлээд чухам юу чамайг хүлээж байгааг сайн мэдэж ав. Чамайг зөвхөн айлгаж аймхай жигшүүрт занг чинь ашиглах санаатай байна гэж бүү бодоорой. Чиний үл итгэх манай сүм хийдийн тахих бурхны суурийг барьж бүхнийг тайлах түүний мэргэн их чадал хүчийг барьж андгайлахад миний шийдвэр хатуу, няцашгүй билээ. Газар дорхи энэ зоорь тоглоом тохууны газар бишээ. Энд чамаас арав дахин илүү дээгүүр хүмүүс хоригдож байгаад үхэхэд хэн ч хэзээ ч тэр тухай мэдэж байгаагүй. Харин чи алгуур, их тарчилж үхэх бөгөөд түрүүчийн улс үүнийг бодвол хялбархан үхэж байсан билээ гэв.

Дахин гараараа зангаж боолчуудыг дуудаад тэдний хэлээр нэг юм шивэгнэв. Фрон де Беф урьд Палестинад байж үзсэн, ийм бүдүүлэг хэрцгий юмыг тухайлан тэндээс сурсан байж мэдэх юм. Сараци боолууд сагсан дотроосоо жаал чулуун нүүрс, хөөрөг, шар тостой лонх гаргаж ирлээ. Нэг нь хэт цохиж гал гаргаад, нөгөө нь дээр яригдаж байсан өргөн ханан зууханд нүүрс зэрэглэн асааж улайтал нь хөөрөгдөв.

Фрон де Беф: - За Исаак, энэ улайсан нүүрсэн дээрх төмөр сараалжийг харж байна уу? Энэ дулаахан дэвсгэр дээр чамайг нүцгэлээд хэвтүүлэх болно. Хоёр боолыг нэг гал хөөрөгдөж, шарах махаа түлчихгүйн тулд нөгөөтөх нь тос дээрээс чинь асгаж байх болно. Улайдсан дэвсгэр дээр хэвтэх үү, мянган фунт мөнгө надад төлөх үү, аль нь дээр байна сонгож автугай, эцгийнхээ тэргүүнийг барьж андгайлахад өөр зам чамд үгүй гэхэд золгүй еврей дуу алдан:

- Байж болшгүй хэрэг! Та үнэхээр ингэх санаатай байна гэж бодохгүй! Өршөөнгүй сэтгэлт бурхан өдий харгис хатуу үйл хийх зүрх арай төрүүлээгүй байх учиртай гэв.

Фрон де Беф үүнд, - Исаак чи дэмий тэгж бодож байна. Энэ бол чиний том алдаа мөн. Бүхэл бүтэн хотыг дээрэмдүүлэхээр тавьж өгч байхыг, нэгэн христос шашинт олон мянган нөхөд маань ирж мэсэнд эрсдэж, гал усанд осолдож байхыг үзсэн миний бие нэг муу еврегийн чарлахаас болоод санаснаасаа ухрах юм гэж бодлоо гэж үү дээ?

Хөгшин чи ухаантай хөдөлж, эд баялгийнхөө хагасаас салж үз. Үүнээс болоод хэтэвч чинь хэт шалчийжээ гэхэд чи дахин дүүргэж чадна. Харин энэ сараалжин дээр хэвтсэн хойно түлэгдэн арьс, махыг чинь эдгэрүүлэх эм, тус болох сайн эм нэгэнт үгүй шүү. Золиос төлөхийг даруй зөвшөөрч хүн амьд гарах нь ховор энэ харанхуй гяндангаас өдий хялбар мултарсандаа баярлаж үз. Илүү үг чамтай дахиж ярихгүй. Чиний мах цус, алтны аль нь чамд үнэтэй чухаг болохыг сонгож ав. Чи юу гэж шийднэ, тлүүгээр чинь больё гэлээ.

- Тэгээд яах вэ, Авраам. Иаков болоод манай өвгийн бүх өвөг эцэг намайг ивээх болтугай. Би сонгож авч чадахгүй, юу гэвэл таны хирээс хэтэрсэн шаардлагыг биелүүлж өгөх боломж надад үгүй билээ гэв.

- Боолчууд үүнийг барьж ав. Тэр өвгийн нь эцэг дээдэс үүнд яаж тусалдагсан өөрсдөө мэдэг! гэлээ.

Боолчууд Исаак руу очиж, зовлонт амьтныг шүүрч аван босгоод түшин байж эзнийхээ цаашдын тушаалыг хүлээв. Өчүүхэн ч болов өрөвдөх сэтгэлийн тэмдэг олж харах санаатай зовлонт еврей бээл болон боолчуудын царайг ээлжлэн ширтэхэд Фрон де Беф харгис эрүү

шүүлтээ эхэлсэн нөгөө л хүйтэн ёозгүй янзаараа инээмсэглэн байхад Сарацин боолчуудын догшин муухай харц нь сайхан юм үзэх гэж бах нь ханан баярлаж байх янзтэй ажээ. Тэгэхэд Исаак дээр нь хэвтүүлэх гэж буй улайдсан зуух руу харж, тамлагчийн няцашгүйд үнэмшээд хамаг зориг нь алдрав.

- Би мянган фунт мөнгө төлье гээд түр дуугүй байснаа, - Гэхдээ омог отгийнхныхоо тусламжтайгаар гэдэг мэдээж. Юу гэвэл ийм үзэгдэж дуулдаагүй их мөнгө төлөхийн тулд би өөрийнхөө тэргүүлэгчийн газрын үүдэнд очиж гуйлга гуйх учиртай болно. Хэдийд, хаана тэр мөнгийг авч ирэх вэ? гэвэл Фрон де Беф хариуд нь,

- Энд, энд яг энэ шалан дээр чи түүнийг тоо ёсоор дэнсэлж төлнө. Золиос авахаас өмнө чамаас сална гэж арай бодоогүй биз! гэхэд,

- Уул золиосыг төлсний дараа би суллагдана гэдгийн баталгаа юу вэ? гэж Исаак асуув.

- Мөнгө хүүлэгч хар санаат минь Норман тайжийн баттай үг яамд хүрэлцээтэй болно. Норман тайжийн нэр төр танай бүх овгийн эзэгнэж байгаа алт мөнгөнөөс арай ч цэвэр байх бий гэж хариулав.

Исаак хүлцэнгүйгээр, - Ариун үйлт баатар танаас өршөөл гуйя. Таныг надад өчүүхэн төдий ч итгэхгүй байхад би яагаад таны үгэнд үнэмших учиртай юм бэ? гэвэл,

- Яагаад гэвэл еврей чамд өөр зам байхгүй гэж баатар ширүүнээр өгүүлээд, - Энэ мөчид чи Йорк дахь агуулахад байгаа чиний зоосыг зээлж авах гэж би гуйж очсон бол эргүүлж төлөх хугацаа, баталгаа сэлтийг тогтоох нь чиний хэрэг байхсан. Гэтэл энэ чинь миний агуулах. Энд чи миний эрхшээлд байна, тэгээд чамайг суллаж тавих нөхцөлийг бид давтан өгүүлэхгүй гэв.

Исаак муухайгаар ёолов.

- Намайг суллахдаа миний замчнаар явсан хүмүүст мөн эрх чөлөө олго. Тэд намайг еврей гэж жигшин үзэж байгаа авч миний арчаагүй байдлыг үзэн өрөвдөж, надаас болон зам зуур саатаж надад учирсан гайд үртсэн юм. Түүнээс гадна миний золиосны хагасыг төлөлцөж мэднэ гэв.

- Чи тэр саксоны мулгуучуудыг хэлж байгаа бол тэднээс өр төлөөс шаардах болно гэдгийг мэдэж ав. Хувиа л хичээ, бусдын хэрэгт бүү оролц гэв.

- Тэгвэл чи намайг миний шархадсан нөхөртэй цуг л суллах гэж байгаа юм шив? гэж Исаакийг асуухад,

- Хувиа хичээж бусдын хэрэгт үл оролц гэдгийг би Израил нутгийн энэ хүнд давтан хэлэх учиртай болж байна гэж үү? гэж Фрон де Беф дуу алдаад, - Чи нэгэнт яахаа сонгож авсан хойно золиосоо л бушуухан төлөх болоод байна гэв.

- Ингэхэд, чи өөрийнхөө ... надаас шаардаж байгаа энэ золиосоо олж авахын тулд... хэмээн

догшин Норманыг уурлуулахаа айн түгдэрсэнд Фрон де Беф инээд алдан хэлж зүрхлээгүй үгийг нь хэлж өгөв.

- Хүн чанарыг баран байж гэж Исаак чи хэлэх гэв үү? Чи юунд түгдрэв? Би юмны учир мэдэх хүн гэдгээ чамд хэлсэн билээ. Хожигдсон талын, тэр нь еврей омгийн хүн байлаа ч гэсэн зэм үгийг нь онц хэрэгсдэггүй юм... Харин чи Жак Фицдоттренийг элдэв бузар овоороос бүрэн үгүйрүүлж орхиод цус сорогч, мөнгө хүүлэгч гэж хэллээ гээд гомдол мэдүүлэх үедээ Исаак чи тийм тэсвэртэй байгаагүй шүү гэлээ.

- Талмуудыг барьж андгайлахад өршөөлт эрхэм та эндүүрч байна. Зээлсэн мөнгөө эргүүлж өгнө үү гэж гуйсанд Фицдоттрель миний өөрийн өрөөнд над руу хутга далайсан юм. Гэтэл өрөө төлөх хугацаа нь бүр улаан өндөгний баяраар өнгөрчихөөд байсан шүү гэв.

- За энэ надад хамаагүй хэрэг. Би харин мөнгөө хэдийд авах нь сонин байна. Исаак чи хэдийд надад зоос авчирч өгөх вэ? гэхэд Исаак хариуд нь:

- Миний охин Ревекка ариун явдалт баатар таны албатуудаар харгалзуулан Йорк руу яваг. Морьтой хүн тэндээс аль болох түргэн эргээд ирж амжих хугацаанд л мөнгө хүргэгдэж ирэх бөгөөд та энэ шалан дээр жигнэж хэмжиж болно гэв.

- Чиний охин гэнээ? гэж Фрон де Беф гайхсан царай гарган өгүүлээд, - Би үүнийг мэдээгүй байсан нь тун харамсалтай юм болжээ. Исаак тэр хар хөмсөгт бүсгүйг би чиний татвар эм юм гэж бодоод эрхэм Бриан де Буагильберт зарцаар өгчихсөн юмсан гэв.

Баатрын энэ үгийг дуулаад Исаакийн цээжнээс гарсан муухай орилох дуу бүх байшингаар нэг цууриатаж хоёр сарацин боолыг машид гайхуулсанд золгүй еврейг өөрийн эрхгүй тавьчихлаа. Исаак үүнийг ашиглан Реджинальд Фрон де Бефийн өвдгийг тэврэн ойчиж,

- Эрхэм баатар та шаардсан юмаа бүрэн ав. Арав дахин илүү авч намайг бүрмөсөн үгүйрүүлнэ. Үгүй! Наад чинжаал хутгаараа намайг огтчиж энэ гал дээрээ шар, ганцхан охиныг минь өршөөж бузарлалгүй тавьж явуул. Таныг төрүүлсэн бүсгүйн нэрээр гуйж мөргөө, өмгөөлөх хүнгүй охины нэр төрийг хайрлаж үз! Ревекка чинь миний талийгаач Рахилийн амьд хөрөг байгаа юм. Ганц бие бэлэвсэн эрийг тэтгэгч ганц охиныг бүү хөнөө. Төрсөн эцэг нь ганц охиноо манай өвгөд дээдсийн бунханд эхтэйгээ цэг хэвтэх болтугай гэж хүсэхгүй гэж чи бодлоо гэж үү дээ? хэмээн гуйха Норман баатар нээрээ ч сэтгэл уярсан янз үзүүлэн,

- Тун тоогүй, энэ тухай би түрүүн мэдээгүй нь харамсалтай. Танай авгынхныг би хүүдийтэй мөнгөнөөсөө өөр юм ер хайрладаггүй улс гэж бодсон юмсан гэв.

Өрөвдөх мэт үзэгдсэн энэ мөчийг Исаак ашиглах гэж яаран:

- Бид хэдий еврей боловч бидний тухай тэгтэл битгий дордоор бод. Авлагдан мухардсан үнэг, тарчилж гүйцсэн мануул хүртэл, хавчигдан хяхагдсан авраамын удам угсаагаа үр хүүхдээ хайрладгийн адил зулзгаа гэдэг шүү дээ гэв.

- Тийм байг гэж бодъё. Исаак чамайг бодоод цаашид б үүнийг мэдэж явах болно. Одоо харин оройтжээ. Нэгэнт болсон юм уу болох учиртай зүйлийг би өөрчлөж үл чадна. Зэвсэг нэгтэй нөхөртөө би нэгэнт ам өгсөн, өөрийнхөө үгийг би арван еврей дээр арван еврей хүүхэн нэмдэг юмаа ч гэсэн няцахгүй. Ингэхэд чи охиноо заавал гай зовлонд учирна гэж яагаад бодож байгаа юм бэ? гэвэл,

- Заавал гай учирна! гэж Исаак ихэд шаналангуйгаар хуруугаа мушиглан байж дуу алдаад эм хүнд хатуу харгис авирлаж бүсгүй хүнийг бузарлахаас өөрөөр яана гэж сүмийн хорооны баатрыг бодох юм бэ? гэв. Фрон де Беф, хилэгнэх шалтаг олдсонд баярласан ч байж магадгүй, ширүүн харж,

- Бузар нохой чи Сионийн ариун сүмийн баатруудын хороог доромжилж, бүү зүрхэл! Амалсан золиосоо төлөх аргаа бодож ол, тэгэхгүй бол ... амыг чинь таглах арга би олно шүү! гэлээ.

Еврей дуу тавин, - Дээрэмчин муу новш! Чамд юу ч өгөхгүй! Охиныг чинь цэвэр ариун, доромжилж гутаалгүйгээр буцааж өгөхөөс нааш надаас ганц ч мөнгөн зоос олж харахгүй шүү! гэв.

- Еврей чи өөрийн ухаантай байна уу? гэж Норман баатар ширүүн зандраад, - Чиний мах цус чинь улайдсан төмрийн эсрэг увьдистай юм уу? гэв.

Эцэг хүний сэтгэл нь доромжлогдсонд цөхрөн цухалдсандаа дуу тавин,

- Надад ялгаа байхгүй, намайг яахыг дураараа бол, чухамхүү мах цусны тасархай охин минь надад чиний тарчлаах гэж сүрдүүлж байгаа муу биенээс мянга дахин илүү чухаг. Чи миний мөнгийг олж харахгүй! Гэмт хэрэг үйлдэж тамд орох тавилантай болсон чиний хараалт сүнс аврагдах эсэх нь түүнээс хамаарах боллоо гэхэд би ганц ч мөнгөн зоос өгөхгүй. Дуртай бол миний амийг ав, тэгээд сүүлд нь еврей хүн алив эрүү шүүлтийг үл харгалзан христос шашинтан хүнд хор хүргэж чадсан тухай яриарай гэв.

- За яах вэ үзье. Танай хараал хүрсэн хар овог омгийнхны сэжиглэдэг ивээлт арун загалмайг барьж андгайлахад чамд би гал, эрт мэсний амт үзүүлнээ. Боолчууд үүний хувцсыг тайлж, сараалжтай барьж хүл гэж Фрон де Беф тушаав.

Өвгөн хирээрээ эсэргүүцэх аядсан авч сарацин боолчууд гадуур хувцсыг нь хуу татан, юу юугүй бүр нүцгэлэхээр завдтал гэнэт гурав дахин бүрээн дуу тасхийсэн нь зоорины гүнд хүртэл нэвтрэхээр чанга цуурайтав.

Тэр даруй эрхэм Реджинальд Фрон де Бефийг дуудах дуун гарлаа. Догшин бээл иймэрхүү шулмын ажил үйлдэж байгаагаа хүнд харуулахыг үл дурлан еврейг дахин хувцаслах дохио боолчуудад өгөөд тэдний хамт харанхуй гяндангаас гарч одов. Исаак аврагдсандаа бурханд залбирах буюу охиныхоо хувь заяанд гашуудан уйлахыг өөрөө мэдэх боллоо.

"Энхрий үгэнд уяран

Энэ биенд минь эс дурласан

Сэтгэлтэй бус цэрэг хүний ёсоор

Сайнаар бус албаар дурлуулна. "

Шекспир "Верон хотын хоёр"

Ровена авхайг оруулсан өрөөг хээнцэр болгох гэж болхидуу оролдон засжээ. Авхайг энд оруулахдаа бусад олзныхныг бодвол онцгойлон анхаарч хүндэтгэх үзүүлэх гэсэн бололтой. Гэвч энэ өрөөнд суудаг өгсөн Фрон де Бефийн эхнэр аль эрт нас барсан, түүний тааллын дагуу хийгдсэн зарим нэг чимэглэл зэвэрч амжжээ. Хананы дотор энд тэндээ урагдаж ноорон унжих бөгөөд хааяа зарим газар наранд гандаж, цагийн удаанд өгөрчээ. Энэ өрөө хэдий зэвэрсэн байдалтай авч саксоны баян инжит авхайг хүлээж авахад болохтой ганц тасалгаа л энэ ажээ. Энэ ёозгүй жүжгийн жүжигчид нь оногдсон зүйлдээ тоглохоор бэлтгэж байх зуур хувь заяаныхаа тухай эрэгцүүлж сууг хэмээн энд нь үлдээв. Уул жүжигт хэрхэн оролцож тоглохоо Реджинальд Фрон де Беф, де Браси, сүмийн хорооны баатар гурав зөвлөн байж хуваарилав. Тус бүрдээ оногдох ашиг олзны тухай удтал маргалдаж байгаад сүүлдээ олзны хүмүүсийн хувь заяаг шийдэв.

Үд дундын алдад уул хэрэг явдлыг өдүүлсэн гол эзэн санасандаа хүрэхээр, чухам гэвэл Ровена авхайтай гэрлэж өв инжийг нь эзэмшихээр хүрч ирлээ.

Бүх цагаа хамсаантайгаа зөвлөж байж өнгөрөөгөөгүй нь илт харагдаж, юу гэвэл тэр цагийн хамгийн шинэ дэгжин галбираар хувцаслаж амжжээ. Ногоон хэрэм баг сэлтээ тайлжээ. Урт өтгөн үс үнэт үсээр хажсан тансаг сайхан нөмөргөн дээр мушгиралдан унжина. Сахлаа мөлчийтөл хуссан байв. Хэрэм нь өвдөгнөөс өнгөрсөн, урт хүнд сэлэм зүүсэн бүс нь алтан хатгамал тээгтэй ажээ. Тэр цагийн дэгжин гэгдэх гутал тун хөгийн байсан тухай бид дурдсан билээ. Харин Морис де Брасийн шаахайны хонины эвэр мэт эргэсэн хушуу нь хөгийн тэнэгээр хйсэн хувцас хунарын уралдаанд тэргүүн шагнал авахуйц зүйл ажээ. Тэр цагийн дэгжин шаавай эрийн гоёл ийм байжээ.

Баатрын өөрийн бие бялдар гоолиг, төрх галбир ордны эелдэг найрсаг зан, цэргийн хүний эрээ цээргүй шулуун ааштай хосолсон, царайлаг тул уул төрсөн сэтгэгдлийг улам ч гүнзгийрүүлэх ажээ.

Ровенагийн өмнө Михаил бурхны алтан хөргөөр чимсэн хилэн тоорцгоо авч мэндлэх зуур гараараа эвлэгхэн зангах суухыг урив. Авхай зогссон хэвээр байсан баруун гарынхаа бээлийг аваад зөөлөн сандал руу өөрөө хөтлөн аваачихыг завдлаа. Гэвч авхай хэрэггүй гэж занган ийнхүү эелдэг загнахыг болиулаад,

- Эрхэм баатар гуай, хэрэв би шоронд хорьсон хүнийхээ дэргэд байгаа бол, хоригдол хүн ялаа

зогсож байгаад дуулах нь зохимжтой санагдана. Нөхцөл байдал өөрөө бодохын эрхгүй байна гэвэл де Браси хариуд нь,

- Үгүй, гоо Ровена та гянданд хорьсон хүнийхээ өмнө биш танд олзлогдсон хүний өмнө байна. Таны сайхан нүд л де Брасийн хувь заяаг шийдэж өгөх болоод байна гэв. Авхай доромжлогдсон гоо сайхан язгууртан бүсгүйн бардам байдлаар цэх зогсож, - Эрхэм таныг би мэдэхгүй. Таныг танихгүй. Шүлэгчдийн сул үгээр надтай хэт давруун задгай ярьж байгаа чинь дээрэмчин шиг хүчирхийлэл хэрэглэснийг огт үл зөгнөнө гэв.

- Өөрийн чинь гоо сайхан намайг эзэн хатагтай, хоёр нүднийхээ чимэг болгон сонгож авсан хүнийхээ хувьд онцын хүндэтгэлгүй мэт буруу үйл үйлдүүлэхэд хүргэсэн юм гэхэд,

- Эрхэм баатар таныг үл танихаа дахин хэлье. Эр баатрын гинж, давируул зүүсэн ганц ч хүн өмгөөлөх хүнгүй бүсгүйд албаар наалдаад байх эрхгүйг танд сануулья гэлээ.

- Таны үл танихад л миний хамаг зовлон байна. Гэвч де Брасийн нэр яруу найрагчийн дүү болоод дайны буюу тулалдааны талбар дээр зарц нар баатруудыг магтан дуулахад дуулдаж л байсан болов уу гэж горилоно гэвэл,

- Тэгвэл, дууч, зарц нар л өөрийг чинь магтаж байг л даа, эрхэм баатар гуай. Ингэх нь таны өөрийгөө магтсанаас арай илүү зохимжтой. Энэ шөнийн дурсагдвал зохих гавьяаг аймхай хэдэн зарцтай хөгшин хүнийг дийлсэн их ялалт болоод дур хүслийн нь эсрэг хүчээр дээрэмчний цайз руу авч ирүүлсэн, дийлэгчийн олз болох зовлонт бүсгүйн тухай тэр дуучдын хэн нь магтан дуулахыг надад хэлж өгөхгүй юу гэв.

Баатар жаал зовонгуйрч, ердийнхөө ширүүн дуугаар,

- Ровена авхай таны буруу байна шүү. Та өөрөө хүнд сайн бус болохоороо хүний халуун цочмог сэтгэлийг, уул сатгэл таны гоо сайхнаас болж оргилсон байлаа ч гэсэн хүнийг зөвтгөж бодохгүй байна гавал Ровена өөдөөс нь:

- Эрхэм таныг энэ яриагаа болино уу гэж гуйя. Энэ үгс чинь хэрмэл дуучдад зохихоор эр баатар, тайж хүмүүст ер нийцэшгүй... Би үнэхээр суухаас өөр арга алга, юу гэвэл та гудамжны адгийн дуучин хүртэл дуусахгүй урсгаж чадах залхаг үг урсгаж гүйцэхгүй нь шив гэлээ.

Хамаг нандин эелдэг үгсийг нь авхай огтхон ч үл тоомсорлолыг де Браси үзээд унтууцан – Бардам зантай хүүхэн, бардам авхай танд миний ааш ч мөн өөрийнхөөс чинь доргүй бардам хэцүү болохыг үзүүлээд өгнөө. Өөрийн чинь зан авирт илүү сайн тохирох аргаар би хань ижлээ болгох оролдлого хийснийг мэдэж ав. Чи өөрөө иймэрхүү ааштай болохоор нийтийн заншил болох эелдэг зөөлөн үгээр бус гартаа зэвсэг барин чамайг дагуулж авахад хялбар байх юм гэв.

- Эелдэг үгс бүдүүлэг муухай хэргийн халх болж байхдаа өөдгүй боолын биенд байгаа эр баатрын бүс адил би барихад танд хүнд байгаад би гайхахгүй байна. Та уул нь хулгайн муу үйлийг эелдэг үг, нийцэрхэг сайхан аашаар халхлахын оронд дээрэмчний хувцас, үг яриаг

хэвээр хэрэглэсэн бол дээр байхсан гэж Ровена хэллээ.

Норман тайж үүнд, - чи сайн зөвлөлгөө өглөө. Зоримог үйлийг зөвтгөдөг түс тас үгээр хэлэхэд энэ цайзнаас нэг бол чи ерөөсөө гарахгүй, эсвэл Морис де Брасийн гэргий болж гарна. Үйл ажил маань бүтэхгүй байхад би дасаангүйн дээр Норманы тайж Саксон хүүхнийг хань ижлээ болгож авах гэж гуйн гийгүүлж байгаа мөртлөө бие зөвтгөж оролдоод байх юм ер үгүй. Ровена чи бардам зантай юм, тэр тусмаа миний эхнэр байж тэнцэнэ. Надтай ханилахаас өөр ямар замаар чи дээд хүндлэлийг үзэх болно гэж бодож байна? Саксончууд хамаг баялаг нь болох гахайтайгаа холилдоод унтдаг хөдөөгийн муу саравчнаа суух амьдралаас өөрөөр яаж ангижрая гэж чи бодож байна? Англид байгаа хамаг хүчирхэг гоо сайхныг хуримтлуулан барьсан бүлгийн дотор өөрийн зохих хүндэт байрыг өөрөөр яаж эзлэе гэж бодож байна? гэв.

Ровена үүний хариуд, - Эрхэм баатар таны өдий их басамжлангуйгаар уурсан байгаа тэр саравч бага наснаас минь аван надад найдвартай орон гэр байсан бүлгээ. Нэгэн цагт би түүнийг орхин гарах болжээ гэхэд миний өсөж хүмүүжсэн орон байрыг үл ойшоон ярихааргүй тийм хүний л өмөг түшгийн дор гарна гэдэгт үнэмшиж үз гэв.

- Та хэдийгээр миний ойлгох хирээс их дээгүүр өгүүллээ гэж бодож байж болох авч авхайтан таны санааг би гадарлалаа. Гэвч арслан зоригт Ричард хаан нэг цагт ширээндээ эргэж сууна гэж бүү санаарай. Түүний шадар хүн Уильфред Айвенг таныг хаан ширээ рүү хөтлөн очоод түүнд таныг гэргийгээ гэж танилцуулна гэдэг бүр ч бүтэхгүйеэ бэрх хэрэг. Харин тэр бага цагийн бүтэшгүй хоосон дурлалын тухай бодол миний шийдвэрт нөлөөлж чадахгүй. Тэр өрсөлдөгч миний гарт байгаа гэдгийг авхайтан мэдтүгэй, түүний энэ цайзанд байгаагийн нууцыг Реджинальд Фрон де Бефэд хэлж өгөх эсэх надаас хамаарах бөгөөд бээл энэ тухай мэдэх ахуул түүний жөтөөрхөл минийхээс маш муу хор уршигтай байх болно гэв.

- Уильфред энд байгаа гэж үү? гэж Ровена үйл ойшоон дуугараад, - Энэ чинь Фрон де Беф түүний өрсөлдөгч мөн гэдэгтэй чинь дүйхгүйн үнэн зүйл байгаа бизээ гэв. Де Браси хувь хиртэй бүсгүйн өөдөөс хянуур ширтсэнээ:

- Чи энэ тухай үнэхээр мэдэхгүй байсан гэж үү? Исаак дамнуурган дотроо Уильфред Айвенгог авч явсныг чи мэдээгүй байх нээ. Эрэлхэг гараараа бурхны шарилыг байлдан авна гэж христосын аян дайнд мордсон хүн гэхэд зам явах аятайхан арга олсон хэрэг шүү! гэж жигшингүйгээр инээд алдлаа.

Айж зовох сэтгэлд авган шаналж байвч Ровена хайш хэрэг байдлаар ярихыг хичээн:

- Үгүй Айвенго энд байлаа ч гэсэн юугаараа тэр Фрон де Бефийн өрсөлдөгч нь болох юм бэ? Энэ цайзанд түр хоригдож байгаад эр баатруудын дундын заншлаар олигтойхон золиос төлөхөөс өөр айх юм юу байгаа юм бэ? гэвэл,

- Ровена чи мөн бусад бүх хүүхнүүдийн адил та нарын гоо сайхнаас өөр өрсөлдүүлэх юм хорвоо дээр үгүй гэж санадаг гэж үү? Нэр алдар ашиг завшаан хөөцөлдөх сэтгэл бас хайр сэтгэлээс багагүй жөтөөрхөл төрүүлдийг чи үнэхээр мэдэхгүй гэж үү? Манай эзэн Фрон де Беф чинь Айвенгогийн бээлийн зэрэгт баян эдлэнг эзэгнэх эрхээ аль нэгэн цэнхэр нүдэн

хүүхний хайр дурлалын хэргээс илүү шамдан хамгаалах болжээ. За, наашаа инээмсэглэн, миний гэрлэх гэж гуйж байгааг таалан үз, тэгвэл шархадсан баатарт Реджинальд Фрон де Бефээс айх юм үгүй болно. Эс тэгвэл чи түүний хойноос уйлахад хүрнэ. Юу гэвэл Айвенго өрөвдөх сэтгэл гэгчийг хэзээ ч үл мэдэх хүний гарт орно гэв. Хайрт хүнд нь аюул заналхийлж байгааг бодохоос Ровена хэлмэгдэн хамаг бие нь хүйтэн оргиж хатуу зориг нь шантраад,

- Бурхныг бодоод түүний амийг аварч үзээч гэв.

- Би үүнийг хийж чадна, хийнэ ч, Ровена де Брасийн гэргий болохыг зөвшөөрсөн хойно авхайн ураг төрөл, өмөг түшиг бологч хүний нь хүү, цуг өссөн хүнд хэн хүч хэрэглэж зүрхлэх юм бэ? Ганцхан чиний хайр сэтгэл л намайг түүний өмөг түшиг болгож чадна. Хожим миний азтай өрсөлдөгч болж болох хүний амийг аврах юм уу, хувь заяаг нь засаж өгөхөөр тэнэг хүн би бишээ. Өөрөө надад нөлөөтэй байгаагаа түүний тулд ашигла, тэгвэл Айвенго аврагдах болно. Хэрэв чи тэгэхийг хүсэхгүй бол Уильфред үхнэ, харин чи тэглээ гээд илүү эрх чөлөөтэй болж чадахгүй шүү гэвэл Ровена хариуд нь,

- Чиний хүйтэн сэтгэлээр өгүүлж байгаа зүйл уул агуулгатайгаа нэг л сайн авцалдаж өгөхгүй оргиод байна. Чиний өвөрлөсөн санаа ийм харгис хатуу юм уу, чиний эрх мэдэл төдий их гэдэгт би итгэхгүй байна гэв.

- За яах вэ, аргагүй үнэмшлээ ийм горьдлогоор сэтгэлээ зогоож бай! Чиний хайрт хүн энэ цайзны хэрмэн дотор шархтай хэвтэж байгаа. Фрон де Бефэд нэр төр, гоо сайхнаас илүүгээр чухагчлан зорих зүйлд нь Айвенго саад болж болох юм. Хутга жадаар ганц бүлээд өрсөлдөгчөө үгүй хийхээд юу түүнд саад болох юм бэ? Фрон де Беф тийм юм үйлдэж эс зүрхэлсэн гэхэд эмч эмээ эндүүрчих юм уу зарц өвчтөний дэрийг суга татаад авчихвал уул хэрэг цус урсалтгүйгээр бүтэх юмаа. Уильфред одоо төдий хир юмнаас бодоод үхэж мэдэхүйж байдалд байна. Седрик мөн... гэтэл,

- Мөн Седрик... гэж Ровена давган дуугараад, - Миний сайн санаат, өгөөмөр сэтгэлт өмөг түшиг! Хүүгийн нь тухай бодсоор атал Седрикийн хувь заяаны тухай мартсан бол энэ дайрсан зовлонг амсахдаа таарсан хүн юмаа би гэлээ.

- Чиний шийдвэрээс Седрикийн хувь заяа мөн хамаарна. Энэ тухай сайтар бодохыг чамд зөвлөе гэж де Браси өгүүлэв. Аюулыг онцын ноцтой, гарцаагүй бишид тооцож байсан болохоор өнөө хүртэл Ровена хэлбэршгүй хатуугаар аашлаж чадаж байлаа. Угийн номхон, ичимхий төрсөн боловч хүмүүжлийнхээ дагуу зан төрх нь өөрчлөгджээ. Хүн болгон өмнө нь бөхөлздгийн нөлөөгөөр өөртөө нилээд итгэлтэй болсон ажээ. Өөрийн нь дур хүслээс зөрөх юм уу хүслэн гуйлтыг нь үл гүйцэтгэж ер болшгүй мэт авхайд санагдах болсон байжээ.

Авхайн өөртөө итгэсэн ихэмсэг байдлын цаана энхрий зөөлөн сэтгэл нуугдаж байв. Тэгээд өөрт болоод ойр дотно хүмүүст нь аюул тулсан гай дайрч, зориг хүсэл нь хүчтэй, шийдмэг, ичгүүр сонжуургүй хүний зориг хүсэлтэй мөргөлдөхийн хамт авхай сэтгэлээр унаж балмагдав.

Авхай тусламж горилох бололтой ийш тийшээ харж, хэд дахин цочмоогоор дуу алдаад атгасан гараа дээш өргөн гашуун нулимс асгаруулав. Энэ сайхан бүсгүйн у гашууг үзээд сэтгэл

уярахгүй байхын эрхгүй бөгөөд де Браси хэдий өрөвдөхөөсөө илүү зовонгуйрах авч мөн сэтгэл нь уярчээ. Айж хирдхийсэн бүсгүйг тайвшруулах гэж де Браси дэмий оролдон өрөөн дотуур хойш урагш холхиж одоо юу хийвэл таарах вэ гэдгээ эрэгцүүлэн бодно.

"Энэ хүүхний нулимсанд би уярч хоцрох юм бол ийм осолтой хэрэгт орооцолдон байж тавьсан сайхан найдлагаа алдаад юугаар нөхөх юм бэ? Нэмэр дээр нь хаан хүү, түүний наргиантай хамсаатнууд дооглож инээлдэх болно. Гэхдээ би өөртөө үүрч авсан энэ ажилд тэнцэхгүй бололтой санагдаад байна. Энэлж хачин болсон энэ сайхан царай, нулимсанд умбаж байгаа энэ гайхалтай нүдийг сэтгэл амирлангуй харж байж чадахгүй нээ. Авхай дээрэнгүй ихэмсэг аашилсан хэвээрээ байх юм уу, Фрон де Бефийг тэсвэр хатуу сэтгэлийн зууны нэг хувийг ч болов би эзэлж авсансан бол дээр байх байжээ " гэж бодов.

Ийм бодолд автан сэтгэл догдолсондоо де Браси одоогоор ийнхүү цөхрөн уй болох үндэс огт үгүй байгааг дурдан хөөрхий Ровенаг тайвшруулах гэж оролдохоос цаашгүй байв. Гэвч энэ яриа мөн гэнэт анчны эвэр бүрээний чанга дуугаар тасалдав. де Браси гоо бүсгүйг орхиж нийтийн танхим руу яарах учиртай боллоо. Гэхдээ үүнд де Браси нэг их харамссан нь юу бол, Ровена хатагтай тэр хоёрын яриа өөрийнхөөрөө зүтгэхэд ч хэцүү уул санаанаасаа няцаахад ч хэцүү байдалд ороод байлаа.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

-Би арслан байна, би өөрөө учралт хүүхнээ авна.

Дуглас

Бидний дүрслэж өгүүлсэн үйл явдлууд цайзны энэ тэр хэсэгт болж байхад еврей хүүхэн Ревекка булангийн буйдхан цамхагт түгжүүлээд хувь тавилангаа хүлээж байв. Баг өмссөн хоёр зарц энд авч иржээ. Ревекка тэнд юм нэхэж, шалан дээгүүр тонгочих ээрүүлийнхээ хөдөлгөөнтэй тааруулан саксон дуу хамраараа аялсан шүү суугаа хөгшин шуламтай халз учрав. Ревеккаг орохын хамт хөгшин эмгэн толгой өндийлгөж шулмын араншит муухай царай гарган идэр залуу гоо сайхныг үзэн ядах хорсол атаархлын харцаар хөөрхий еврей хүүхнийг тас ширтэв.

Ревеккаг авч ирсэн хүмүүсийн нэг нь:

- Хөгшин цох минь эндээс тонил. Манай сайн үйлт эзэн тушааж байна. Чамаас арай цэвэр сайхан зочинд энэ өрөөгөө гараж өг гэхэд эмгэн өөдөөс нь:

- Мөөн, зүтгэлийг одоо ингэж шагнадаг болоо бий. Намайг ганц үг дуугарахад л та нарын хамгийн олигтойг ч эмээлээс чинь буулгаад л албанаас хөөчихдөг цаг байсан. Одоо тэгэхэд аль дайралдсан зарцын тушаалаар би өөрөө хөөгдөх цаг ирсэн юм шив дээ гэж үгэллээ.

Нөгөө зарц – Урфрида илүү үг яриад байх хэрэг алга. Гарч үз, өөр юмгүй. Эзний тушаалыг шалмаг гүйцэтгэх учиртай. Чамд гэрэлт сайхан өдрүүд байсан, одоо чиний нар хэвийжээ. Чи одоо хоосон газар идэшлүүлэхээр тавьсан аян дайны хөгшин морь гэсэн үг. Урьд чи сайхан цогидог байсан одоо зүгээр нэг шогшино гэдэг сайн хэрэг. За алив бушуул гэв.

- Муу ёр та хоёрыг үргэлж мөрдөг! Хоёулаа нохой шиг муу үүрэн дотор үхэг! Би нэхүүрээ дуусахаас нааш өөрийнхөө өрөөнөөс гарвал чөтгөр намайг алгадаг! гэж эмгэн хэлэв.

- Энэ талаар хөгшин шулам минь чи өөрөө эзэнтэй ярилцаж болно гэж зарц хариулаад Ревеккаг эмгэнтэй хамт орхиод нөхрөө дагуулан гарч одов.

Эмгэн Ревекка рүү зэвүүнээр хялалзахын завсар аман дотроо – Бас юун хар нүгэл үйлдэхээр тэд сэдээ юм бол? Гэвч гадарлаж ядах юм алга. Сайхан нүдтэй, хар үс, цаас шиг цагаан царай, энэ буйдхан цамхагт юунд үүнийг авч ирэв гэдэг тааж ядах зүйл биш. Гоо охин минь энд чиний ойр хавьд ганцхан шар шувуу л байдаг юм даа. Чиний орилохыг шар шувууны дуугарахаас илүүгээр хайхрахгүй гээд Ревеккагийн хувцас хунарыг ажиж хараад, - Харь орны хүн шив дээ. Аль орноос ирсэн бэ? Сарацин уу, египтийнх үү? Чи юунд хариу хэлэхгүй байна? Уйлж чадаж өайгаа хойно лав ярьж чаддаг биз гэв.

- Эмээ та бүү уурла гэж Ревеккаг дуугарахад,

- За за цааш нь асуух ч хэрэг алга, еврей хүүхэн байна. Харалгүй аялгуугаар нь шууд таньж байна гэж Урфрида өгүүлэв.

- Их өршөөл үзүүлж цаашид юу надад учирч болохыг хэлж өгнө үү? Намайг нааш нь хүчээр чирч ирлээ, намайг еврейн шашин шүтдэг гэж алахаар завдаж байгаа юм болов уу? Хэрэв тийм болж гэм би амь насаа шашныхаа төлөө дуртайяа өгнө гэж Ревеккаг хэлэхэд эмгэн хариуд нь:

- Чиний амь нас шүү, хонгор минь! Чамайг алах гэдэг тэнэд юун их баяр баясгалан байх билээ. Үгүй миний үгэнд итгэ, чиний аминд аюул учирсан зүйл огт үгүй. Сурвалжит саксон бүсгүйчүүлийг яаж байлаа, чамайг мөн тэгэх л болно. Саксон хүүхнүүдэд сүрхий сайнд тооцогдож байсан зүйл еврей хүүхэндшившигтэй байна гэж үү? Намайг хар л даа. Би бас бага залуу чамаас хувь илүү гоо сайхан явахад фрон де Беф одоогийн Реджинальдийн эцэг нормануудтайгаа энэ цайзыг дайран эзэлж авсан билээ. Миний эцэг долоон хүүгийнхээ хамт гэр орноо улайран хамгаалсан. Урссан цуснаас больж хальтрахгүй өрөө, шатны гишгүүр гэж ганц ч үгүй. Тэндээс ганц ч үлдэлгүй үхэж дуусаад биес нь хөрч, цус нь хатаж амжаагүй байхад би дийлэгчийн гарын алчуур зугаа болж билээ гэж ярилаа.

- Яаж ийгээд аврагдах арга үгүй юу? Эндээс зугтаах зам ер үгүй гэж үү? Тус үзүүлсний чинь хариуг өгөөмрөөр, үгүй хичнээн их өгөөмрөөр хариулна гэж санана гэвэл эмгэн:

—Бодохын ч хэрэг үгүй. Эндээс зайлах ганц зам бий. Энэ бол үхэл. Үхэл тэгэхэд удтал, өнө болтол ирж өгдөггүй юм гэж буурал толгойгоо сэгсрэн өгүүлээд гэвч биднийг үхсэний дараа бусад хүмүүс мөн л ингэж зовох юм даа. За баяртай еврей хүүхэн минь! Еврей буруу номтон хоёр нэг үг. Чамайг тийм л хувь тохиол хүлээж байгаа юм гэвэл чи өрөвдөх сэртгэл хүн чанарын аль алин нь үгүй хүмүүсийн гарт оржээ.

Баяртай! Миний нэхмэл, нэгэнт дууслаа, чинийх харин дөнгөж эхэлж байна гэв.

- Байзаач, бурхныг бодож хүлээ? гэж Ревекка аргадаад, - Эндээ үлдээч! Намайг харааж зүх, гагцхүү бүү яв! Таны энд байх чинь надад бага боловч өмгөөлөл болно шүү дээ гэв.

- Дарь эх өөрөө байлаа ч гэсэн чамайг өмгөөлж үл чадах бүлгээ гэж эмгэн буланд байсан Мария дагинын хөргийг зааж өгүүлэхэд,

- Тэр байж байна, хувь тавиланг чинь хэтрүүлэх нь үү үгүй юу үз дээ гэв.

Ийнхүү өгүүлээд тавлан инээвхийлсээр гарч одлоо. Гарахдаа хаалга түгжсэн бөгөөд эгц шатаар буух зуур харааж зүхэж байгаа нь Ревеккад удтал дуулдав.

Ревеккад Ровена авхайг бодвол илүү айхавтар гамшиг учрахаар завдаж байлаа. Саксоны баян гоо бүсгүй өөртэйгээ эрх биш зарим талаар эелдэг хандана гэж бодож болохтой бол еврей хүүхэнтэй хамгийн бүдүүлэг дээрэнгүй авирлах нь лавтай. Харин Ревеккагийн давуутай тал гэвэл угийн зориг хатуу хүн. Багаасаа аван гойд эрс зоримог ажигламтгай ухаантай билээ. Эцэг нь баян хээнцэр байдалд умбуулж бусад баян еврей нарын гэр орон мөн тийм байдал явдал өөрийн нь омог овгийнхон хир түшиц тулгуур муутай амьдарч байгааг ойлгоход саад болсонгүй. Дурсгалт найран дээр сууж байсан Дамоклийн адил овгийнхны нь толгой дээр хялгасан тороостой илд дүүжлээстэй байгааг энэ хээнцэр байдлын дунд Ревекка ямагт мэдэрсээр байлаа.

Иймэрхүү бодол аажимдаа амьдралыг үнэн зөвөөр харах болгож өөр нөхцөл байдалд болж гэм дээрэнгүй зөрүүд болж мэдэх агсан зан чанарыг нь зөөлрүүлжээ.

Эцгийн нь сургамж дууриал Ревеккаг хэн бүхэнтэй жигдтүвшин хаилцаж сургажээ. Угийн аймхай бус төрсөн болохоор ч эцгийнхээ зусар бөхөлзүүр занг үнэндээ дууриаж эс чадах бүлгээ. Жигшигдэгч овгоос гаралтай муу нөхцөлд захирагдан даруу боловч толгой дээгүүр явахын хамт шашны мухар хавчилгын гайгаар эдлэх ёстой тавилангаасаа дээгүүр сайн яву болохтой гэдгээ өөрөө мэддэг байлаа.

Иймэрхүү янзаар алив гэнэтийн гай зовлон дайрч болохыг мэддэг байсны ачаар энэ удаад мөн самгардсангүй. Юуны өмнө өрөөг сайтар нягтлан үзээд оргож аврагдахын горьдол үгүйг ойлгов. Өрөөнд нууж хаалга огт үгүй зузаан ханатай цамхагт байдаг цайзны бусад тасалгаануудтай холбогдоогүй бололтой. Үүд нь дотор талаасаа түгжээ сэлт ер үгүй. Ганц цонх нь хөрөөн хана бүхий дээд талын талбар руу харжээ. Энэ талбай нь харвах нүх бүхий хашилттай тавцан маягийн зүйл бөгөөд бусад гадуур бэхлэлтээс тусгаар ажээ. Ийнхүү тэсвэр эр зориг гаргахаас өөр зам Ревеккад үгүй байлаа.

Шатаар хүний хөлийн чимээ гарахад хоригдол бүсгүйн бие зарсхийж цонхийгоод явчихлаа. Үүд аяархан нээгдэж өндөр нуруутай гай зовлонгийн нь шалтгаан болсон дээрэмчдийн нэгэн адил хувцас бүхий эрэгтэй хүн өрөөнд орж ирээд үүд хаав. Малгайгаа духдуулж өмссөн нь царайны дээд талыг халхалжээ. Нөмөргөөр биеэ ороогоод айж мэгдсэн Ревеккагийн өмнө дуугүй зоосноно. Хийхээр завдаж буй зүйлээсээ өөрөө ичиж, ирсэн зорилгоо тайлбарлах үг олодохгүй байгаа бололтой. Эцэстээ Ревекка өөрөө ам нээхээр шийдлээ. Түрүүн тайлчихаад байсан хоёр үнэт бугуйвч хүзүүний чимгээ дээрэмчин рүү сарвайн:

- Май үүнийг ав сайн нөхөр минь хөгшин эцэг бид хоёрыг нийгүүсэлж үз! Энэ үнэт эдлэлүүд боловч цайзнаас билнийг гомдоолгүйгээр тавьж явуулбал эцгийн чамд өгөх юмны дэргэд юу ч бишэнэ гэв.

- Дорнодын энэ сувд Палестинын гоо цэцэг чиний цагаан шүднээс өнгө муутай ажээ. Энэ нь очир алмас гялалзах авч чиний нүдтэй зүйрлэшгүй. Би энэ бэрх ажил эрхлэх болохдоо гоо сайхныг эд баялгаас ямагт илүүд үзэх андгай тавьсан билээ гэж дээрэмчин хариулав.

Хойт насандаа илүү нүгэл бүү хураа. Золиос аваад өршөөнгүй байж үз! Чамд алт алив баяр баясгаланг өгөх атал биднийг гомтгох ахуул гэмшихийн зовлонг эдлэх болно. Чиний шаардсан бүхнийг эцэг дуртайяа өгнө. Мөнгөтэй болоод чи дахин шударга хүмүүсийн дунд орж түрүүчийн үйлдсэн гэм буруугаа цагаатгуулж чадаад дахин аргагүй нүгэл үйлдэх шахалтнаас ангижрах болно гэж Ревекка хэлэхэд дээрэмчин францаар өөдөөс нь:

- Онож хэллээ! гэж дуугараад – Цагаан саранин цэцэг минь чиний эцэг хувилахуйн ухаанд тун чадмаг хүний гарт орсныг мэдэж ав. Тэр хувилахуй ухааны эрдэмтэн гяндангийн зэвтэй сараалжийг ч мөнгө алт болгож чадна. Хүндэт Исаак гуайг миний гуйлт чиний мөргөлт үгүйгээр хамг үнэтэй цайтай бүхнийг нь шавхаад авчих нандин тогоонд нэрэх болно. Чиний золиос харин ганц гоо сайхан хайр сэтгэл хоёроор л төлөгдөх учиртай өр төлбөрийг би үл хэрэгсэнэ гэв.

Ревекка мөн франц хэлээр - Чи дээрэмчин биш байна. Ийм шангаас татгалзах дээрэмчин ганц ч үгүй. Энэ нутгийн ганц ч дээрэмчин чиний наад хэлээр ярьж чадахгүй. Чи дээрэмчин биш энгийн норман хүн тэгэхдээ язгууртан гаралтай ч байж магадгүй. Үнэн хэрэг дээрээ сайн үйлт болж харгислал хүчирхийллийн наад аймаар багаа аваад хачих! гэв.

Бриан де Буагильбер нүүрээ халхлан байсан нөмөргөө сөхөөд - Чи тун сайн тааж чадаж байна. Израил нутгийн жирийн нэг охин лав бишээ. Чи өдий бага залуу гоо сайхан биш байсансан бол чамайг би Эндорийн шидтэн бүсгүй гэхсэн билээ. Шароны гоо сайхан намуун цэцэг минь би дээрэмчин бишээ. Чиний энэ чимэг зүүлтийг авахын оронд гар хүзүүг чинь сувд алмасаар чимэж чадах хүн гэв.

- Эд баялаг биш юм бол өөр тэгээд надаас юу танд хэрэгтэй вч бэ? Бидний дунд нийцэх зүйл ор үгүй чи христос шашинтай би еврей хүн. Бид хоёрын холбоо танай шашин манай шашны аль алинд харш үзэгдэнэ шүү дээ хэмээн Ревекка хэлэв.

Сүмийн хорооны баатар үүнд инээд алдан – Яриагүй гэв. Еврей хүүхэнтэй гэрлэх гэж үү! Савскийн хатан хаан байлаа гэсэн үгүй! Тэгээд ч хамгийн агриун христос шашинтай хаан христосын сүсэгт гүнжээ надад эхнэр болгож ав гэж Лангедокийг нэмэр болгож өглөө ч гэсэн би гэрлэж чадахгүй байхсан гэдгийг Сионы гоо охин чи мэдтүгэй. Би гэр бүлийн холбоог тогтоож өөртөө дарамт болгохгүй андгай өргөсөн билээ. Харин чамд сайн болжээ. Би сүмийн хорооны баатар. Миний ариун хорооны загалмай энэ байна хар гэв.

- Чи тэгээд үүгээрээ ийм үед гэрч барьж зүрхлэнээ гэж !Ревекка дуу алдав.

- Би тэгэж байгаа хойно чамд ямар хамаатай юм бэ? Бидний хойт насыг аврах энэ ариун билэгт чи шүтдэггүй шүү дээ гэв.

Ревекка өөдөөс нь: - Надад зааж өгсөн зүйлд би сүсэглэдэг, миний шүтлэг буруу аваас бурхан өршөөх болтугай. Хамгийн гол андгайнаасаа няцахаар завдаж байхдаа дээд ариун зүйлээ барьж гэрж татаж байгааг үзэхэд эрхэм баатар таны шашин чинь ямар шүү юм бэ дээ? гэж маргав.

- Еврей бүсгүй чи тун цэцэн цэлмэгээр сургаал айлдаж байна. Гэхдээ гоо сайхан номч чинь чиний еврей мухар сүсэг чинь манай өндөр өргөмжлөлийг олж харахад саад болжээ. Гэрлэх гэдэг сүмийн ал ойр байгаа нүглийн тухайд бол манай сүмийн аль ойр байгаа нүгэл наминчлах газарт очоод даруй даатгуулчихаж чадна. Соломонб сүмийг хамгаалагчид таны төгс мэргэн хааны Соломоныг магтан дуулсан зугаа цэнгэлийг эдэлж болох юм гэв.

- Ариун сургаалыг чи зөвхөн өөрийнхөө хуулиас гажуу завхай зайдан явдлаа зөвтгөхийн тулд ч уншдаг юм болж гэм хамгийн ашигтай эрүүл сайхан өвснөөс хор гаргаж авдаг этгээдүүдтэй адил ялт хэрэг өдүүлсэн буруутан мөн гэж еврей бүсгүй хэлэхэд энэхүү зэмлэлийг сонсоод сүмийн хорооны баатрын харц хилэнгээр дүрсхийв.

- Ревекка чи сонсож бай! Өнөө хүртэл чамтай би зөөлөн байлаа. Одоо би дийлсэн хүний ёсоор ягрина. Чамайг би нум сум жадаараа байлдан олж авсан бүх улс орон ард тлмний мөрддөг заншлын дагуу чи миний үгийг дагах учиртай. Өөрийнхөө эрхийг эдлэх юм уу чиний

гуйхад чиний татгалзан байгаа зүйлийг хүчээр гүйцэтгэхээс би төдий ч ухрах санаагүй байна гэж Брианыг хэлэхэд:

- Цаашаа бол! Ийм амьдын хар нүгэл үйлдэхээр шийдэхийнхээ өмнө цаашихнаа болоод миний үгийг сонс. Чи намайг мэдээжээр дийлж чадна юу гэвэл бурхан бүсгүй хүнийг эрчүүлийн ивээлд даатгал сул доройгоор төрүүлжээ. Харин би сүмийн хорооны баатар чиний өөдгүй явдлыг бүх европоор нэг тараана. Танай хань нөхдийн чинь сүсэг бишрэл миний өрөвдүүлэх гэж хичээгээд үл чадах зүйлд хүргэж болно. Чиний хийдийн дацан чамайг еврей хүүхэнтэй нүгэл үйлдсэн шашны дайсан гэж мэдэх болно. Чиний гэмт үйлийг дуулаад дотор нь зарсхийгээгүй хүмүүс ч гэсэн миний өвөг омгийн бүсгүйтэй орооцолдон зүүж яваа загалмайгаа бузарласан гэж чамд зэм өгөх брлно гэв.

Өөрийн энэ өдүүлсэн явуулга мэтийн зүйлийг хатуу шийтгэхээр далайлган хориглосон зүйл хийдийн нь гуриманд үнэхээр бий,Ревекка үнэн үг хэлж айна гэдгийг сүмийн хорооны баатар сайтар ухааран, - Ревекка чи их ухаалаг хүн юм! Чи тун ухаалаг байна. Гэхдээ энэ цайзны хүрээнээс гадагшаа чинь гарч дуулдаг гэвэл мөн ч чанга хашгирч дуулдах нээ.

Энэ цайзны хахан дотор чи уйлж ёолж хүн амьтан дуулдаж хичнээн орилж болно. Түүнд чинь хариу ер дуулдахгүй шүү. Ревекка чамайг аврах ганцхан зүйл байна. Хувь тавиландаа захирагдаж манай шашинд ор. Тэгтэл ариун сүмийн эрэлхэг хамгаалагчдын сайн баатрын хайрт бүсгүйн гоо сайхан гялалзсан байдалд норманы олон хатагтай нар атаархахаар өндөр сууринд хүрнэ гэлээ.

- Хувь тавиландаа захирагдах!Чиний шажинд орох гэнэ! Ийм новшийг ивээж байдгаас хойш юун шашин юм бэ тэр чнь? Юу гэнээ! Сүмийн хорооны дайчдын дотор чи сайн нь юм уу? Чи адаг шаарын баатар санваараа умартсан гэлэн хулчгар новш! Чамайг жигшиж чамаас сэжиглэж байна! Энэ бузар булай гүнээр хүртэл аврагдах замыг авраамын тэнгэр надад нээж өглөө! гэж Ревекка дуу алдаад цамхагийн дээд тавцан руу харсан сараалжин цонхыг нээж халхавчин дээр ёроолгүй хэцийн яг ирмэг дээр зогслоо. Өдий зоримог юм хийнэ гэж бодоогүй байсан болохоор Буагильбер хүүхнийг барьж зогсоож ч адсангүй. Хүүхэн рүү ухас хийхээр оролдсонд Ревекка:

- Бардам зантай баатар та тэндээ бай, дуртай бол ойртоод ир! Харин урагшаа нэг л алхвал би доошоо үсрэнэ шүү. Чиний бурангуй тачъяалын зугаа болохоос өмнө миний бие энэ хашааны чулаан дээр хэмх үсрэх болно гэв.

Ингэж хэлээд сүнсээ даатгах аятай зангидсан гараа тэнгэр өөд өргөлөө. Сүмийн хорооны баатар тээнэгэлзэв. Өрөвдөх сэтгэл гэгчийг үл мэдэх хэний ч зовлон гаслангийн өмнө зөөлөрч явж үзээгүй эрс шийдмэг нь бүсгүйн хатан зоригийг бахдах сэтгэлээр солигдов.

- Солиотой хүүхэн чи буу, доошоо бууж ир. Газар тэнгэр тэнгис далайг барьж андгайлахад би чамайг өчүүхэн ч гомдоохгүй! гэж гуйв.

- Сүмийн хорооны баатар чамд би итгэхгүй. Чиний хийдийн сайн үйлийг зохих хирээр үнэлэхийг чи надад сүмд наманчлаад цагаатгана гэнээ, тэгээд энэ чинь адгийн муу еврей хүүхний тухай явдал шүү гэлээ.

Буагильбер халуун цочмогоор, - Миний хувьд чи шударга биш байна шүү! Зүүж яваа нэр цээжин дээр байгаа загалмай, өвөг дээдсийнхээ тайж сүлдийг барьж чамд андгайлъя! Өөрийнхөө төлөө биш юмаа гэхэд эцгийгээ бодоод доош буу. Би түүнд нөхөр больё, энд энэ цайзан дотор түүнд хүчирхэг өмгөөлөгч хэрэгтэй шүү гэлээ.

- Үнээн, би үүнийг мэдэж байна. Харин чамд итгэж болох юм уу даа? гэж Ревеккаг хэлэхэд Бриан де Буагильбер:

- Чамд гомдоллох шалтаг өгөх юм болж гэм миний сүлдийг урвуулан эргүүлэг, миний нэрийг олны өмнө бузарлаг! Би олон хуулийг зөрчиж, олон сургаалыг давж байсан, харин хэлсэн үгээ хэзээ ч няцаж яваагүй юм шүү гэв.

- За яах вэ, би чамд итгэж байна гэж Ревекка хананы ирмэгээс үсрэн бууж харвах нүхнүүдийн нэгний дэргэд зогсоод, - Би энд зогсоно, чи тэр байгаа газраасаа бүү хөдөл. Харин чи нэг л алхам урагшлах юм болж гэм еврей хүүхэн нэр төрөө сүмийн хорооны баатарт найдахаас өмнө сүнсээ бурханд даатгахыг үзэж болно гэлээ.

Ревеккагийн ингэж хэлж байгаа нь сэтгэл хөөрөн эр зориг шулуудсан нь түүний бие, дуу харцыг гойд ихэмсэг сайхан болгосонд бараг энэ хорвоогийн бус амьтан шиг санагдаж байв. Харцанд нь мэгдсэн шинж орж, хацар нь зэвхийрсэнгүй, харин ч хувь заяандаа өөрөө эзэн болсноо ухааран цонхигор царай нь улаа бутран нүд нь цогтой гялалзана. Бардам, эрэлхэг хүн болох Буагильбер өдий ихэмсэг хийморьлиг гоо сайхан хүнийг ер үзээгүй гэж болов.

- Эвлэрье гэж Бриан хэлэв.

- Дуртай бол эвлэрье, гагцхүү ийм зайнаас л хоёул эвлэрье гэж Ревеккаг хариулахад:

- Цаашид надаас айх юм чамд үгүй гэж Буагильбер өгүүлэв.

- Чамаас айсан ч юм алга. Энэ цамхагийг өдий өндөр барьсан хүний өршөөлөөр, түүний болоод Израилев бурхны өршөөлөөр би чамаас айхгүй байна гэв.

Сүмийн хорооны баатар үүнд, - Миний хувьд ч шударга биш байна шүү. Газар тэнгэр тэнгис далайг барьж андгайлахад чи намайг буруугаар үзэж байна. Уг нь би чамд харагдаж байгаа шигээ харгис, биеэ өргөмжилсөн, энэрэх сэтгэлгүйгээр төрсөн хүн бишээ. Хатуу харгис сэтгэл гаргахыг бүсгүй хүн надад сургасан тул бүсгүйчүүлээс ямагт өшөө авдаг байсан, гэхдээ чам шиг хүүхнээс биш шүү. Миний хайртай хүндээ үнэнч сайн байсан шиг төдий сайхан сэтгэлтэйгээр байлдааны жад барьсан баатар ганц үгүй. Жижиг газрын эзэн бээлийн охин байсан юм. Тэдний бүх хөрөнгө хогшил гэвэл хагас нурсан цамхаг, ургац муутай усан үзмийн цэцэрлэг, Бордогийн захад хэдхэн га шим муутай газартай байлаа.

Гэтэл тэр хүүхний нэр бүхэл бүтэн гүнгийн зэрэгт хушуу инжинд нь өгөхөөр амалсан олон хүүхнүүдийнхээс илүү их алдаршив гээд тэрээр нарийнхан талбар дээгүүр хойш урагш холхин Ревеккаг мартчихсан юм шиг сэтгэл нь догдлон, - Миний байгуулсан гавьяа, үзэж өнгөрүүлсэн аюул, урсгасан цус Аделаида де Монтемарын нэрийг Кастилиас Византи хүртэл цууриатуулж билээ. Үүний ачийг тэр хүүхэн яаж хариулсан гэж санана. Өөрийнхөө хөдөлмөр,

цусаараа нэр хүнд олж аваад түүн рүү эргэж иртэл тэр эмэгтэй нэгэн жижиг тайжтай гэрэлчихээд байлаа. Би түүнд үнэхээр сайн байсан үнэнч сэтгэлийг минь элэг барьсны өшөөгөө хатуу авсан. Гэтэл тэр өшөө авалт хамгийн хүндээр өөрт минь тусч тэр өдрөөс аван би хүний ёсоор амьдрах хүнтэй сайн сайхан холбоотой явахаас татгалзах болсон билээ. Өөрийн гал голомт гэж юу байдгийг би хэзээ ч мэдэхгүй. Хөгшин болохын цагт өөрийн дулаахан орон гэж байхгүй. Ганцааранг минь л аваачаад оршуулчихна. Миний хойно Буагильберийн эртний удам судрыг залгамжлах үр хүүхэд үлдэхгүй. Бие дааж амьдрах бүх эрхээ эвдэж, үгүйсгэж, хувийн тусгаар тогтнолоосоо татгалзан билээ. Сүмийн хорооны баатар гэгч зөвхөн нэр нь боол биш, болохоос өөр хүний эрхшээл, тушаал заавраар амьдарч, хөдөлж, амьсгалж байдаг юм гэж ярилаа.

- Аль байдгаа ийнхүү огоорсны орыг ямар гээч ашиг завшаанар нөхдөг м бэ? гэж Ревекка асуув.

- Өшөө авах боломжтой эрх тушаал дэвших бодол агуулахад уудам их чөлөөтэй юм, Ревекка гэж сүмийн хорооны баатар хэлэв.

Хүүхэн үүнд, - Хүнд хамгийн үнэтэй чухаг бүхнийг огоорсны хариуд муухан л шан юм даа гэвэл,

- Тэгж битгий ярь! гэж сүмийн хорооны баатар дуу алдаад, - үгүй шүү, өшөө авах гэдэг бурхдын баясгалан. Үүнийг бурхад өөрсдийн хувийн эрх болгодог лам нарын хэлдэг үнэн ахуул жирийн үхэх үйлтэнд олгоход хэтэрхий их чухаг давуутай зүйлд тооцдог байх нээ. Эрх мэдэл! Энэ чинь энхжингийн жаргалд умбаж байхад хүртэл хүний сэтгэлийг уймруулан хорхойсуулж чадахтай зүйл шүү гэв.

Хувь хиртэй дуугүй байснаа цааш нь:

- Нэр төрөө бузарласанд орохноо үхэхийг илүүтэйд бодсон Ревекка чи бурхны нэр барьж андгайлахад бардам эрс сэтгэлтэй байж таарах учиртай. Чи минийх болох учиртай гэснээ,

- Үгүй бүү ай, минийх гэхдээ би сайн дураараа, өөрийнхөө хүслээр болохыг хэлж байна. Хаан ширээний өндрөөс нээгдэж харагдахаас илүү дээд найдлагыг надтай хуваалцахыг чи зөвшөөрөх учиртай. Хариу хэлэхийнхээ өмнө миний үгийг дуулж, татгалзахаасаа өмнө бодож үз. Чи зөвөөр өгүүлсэнчилэн сүмийн хорооны баатар нийгмийн бүх эрхээ, биеэ даан ажиллах хамаг боломжоо алддаг нь үнэн. Гэхдээ хаад хүртэл өмнө нь чичрэх лут хүчирхэг нөхөрлөлийн гишүүн болдог юм. Гэтэл би энэ хүчирхэг хийдийн эгэл нэг гишүүн огтхон ч бишээ. Би түүний зонхилох эрх баригчдын нэг бөгөөд алсдаа тэргүүлэгчийн очирьг атгах найдлагатай юм. Унасан эзэн хааны хүзүүн дээр өсгийгээрээ гишгэсэн төдийдз сүмийн хорооны баатрууд сэтгэл амардаггүй, сүлжмэл олсон шаахай өмссөн гэлэн бүхэн чадна. Бидний нүсэр хөл хаан ширээний гишгүүрээр өгсөж, манай төмөр бээлий титэмтний гараас эрх мэдлийг нь булаан авна. Та нарын хийд дэмий хүлээн байдаг Мессийн удмынхан миний дэгүүр санаа эрмэлзэж байгаа шиг их хүчирхэг байж чадахгүй юм шүү. Би ганцхан өөртэйгээ нэгэн төрөл сэтгэлтэн хүн ирж байсан, харин ч яг тийм хүн байхыг олж авлаа гэхэд,

- Үүнийг чи миний овгийн бүсгүйд ярина гэж үү? Бодож үзээч! гэж Ревекка дуу алдав. Бриан

де Буагильбер үгийг нь таслан, - Манай шүтлэг өөр болохыг надад бүү дурс. Манай хийдийн нууц зөвлөлгөөн дээр энэ хүүхдийн үлгэр шиг зүйлийг бид шоолж инээлддэг юм. Биеийн шаналан буян үйлдэхийн тулд амьдралын хамаг цэнгэлээс татгалз гэж манай үндэслэн байгуулагч нарын сургасан тэнэг зүйлийг бид удтал сохроор дагасан гэж бүү бод. Манай хийд илүү зориимог, явцуу бусаар үздэг. Европын бүс хаант улсуудын бүх том эдлэнгүүд орон бүхнээр цууриатаж, христос шашинтны хамаг эр баатруудын охь манлайг манай талд татаж оруулдаг дайчин алдар сэлт цөм миний буян ном үндэслэгчдийн зүүднээ ч ороогүй зүйлд зориулагддаг юм. За манай нууцыг чиний өмнө цаашид дэлгэхээ больё. Бүрээн дуу дуулдаж байна. Би заавал байлцах хэрэгтэй. Миний чамд хэлсэн зүйлийн тухай бодоорой. Баяртай! Үүний ачаар би чиний сэтгэлийг танилаа. Цэвэр алтыг зөвхөн улайтгаж байж таньдаг билээ. Би удахгүй ирж, бид дахин ярилцнаа гэв.

Буагильбер өрөөн дотуур өнгөрч гаран Ревеккаг ганцааранг нь үлдээн шатаар доош бууж эхлэв. Өөртөө оногдуулахаар шийдсэн аюулт үхлийн өмнө хүртэл гарт нь орсон энэ зоримог муу үйлт этгээдийн эрх тушаал үүсэн эрмэлзэх хүйтэн шуналыг үзээд хилмэгдсэн шигээ айгаагүй ажээ. Цамхагийн өрөөнд орж ирмэгцээ өршөөл тэргүүн нигүүслэл үзүүлсэн бурханд мөргөөд өөрийгөө болоод эцгийгээ ивээлдээ цаашид ч багтааж байна уу гэж залбирлаа. Өөр нэг нэр бүсгүйн залбиралд орон дурдагдсан нь шарх олсны дээр хувь заяаны эргэлтээр цусанд дуртай, өөрийнхөө өштөн дайснуудын гарт орсон христос шашинт хүн байв. Бурхан шүтээнд хандаж, сүсэглэн залбирахдаа өөртэйгээ хэзээд ч холбоотой болж үл чадахын дээр буруу номтон хшний тухай дурдсандаа сэтгэл нь бас ч зовж байв. Гэвч нэгэнт залбирч орхисон, Ревекка ч түүнээсээ няцах дур үнэндээ үгүй байв.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

"Амьдралдаа би ер ийм хачин

муу эрээн цаас ер үзээгүй.

Үүний чинь учрыг чөтгөр ч

билээ олиггүй!"

Гольдсмит "Эндүүрлийн шөнө"

Цайзны их танхимд сүмийн хорооны баатрыг ороход де Браси тэнд байв.

Энэ янгинасан дуу янз нь таны янаг амрагийн явдалд миний нэгэн адил саад болжээ дээ гэж де Браси хэлээд, - Гэхдээ та надаас хожуу илтгэд дургүйгээр хүрч ирлээ. Үүнээс үзэхэд таны уулзалт минийхийг бодвол ихээ илүү таатай байсан байж таарах нь гэж би дүгнэж өйна гэвэл,

- Тэгвэл та баян инжит гуай Саксон бүсгүйтэй гэрлэхээр гуйгаад амжилтгүй гэсэн үг үү? гэж Буагильбер асуусанд,

де Браси хариуд нь – Фом Бакетийн ясыг барьж андгайлахад миний, бүсгүй хүний нулимс харж ед чаддаггүй тухай энэ Ровена авхай лав дуулж шүү гэлээ.

Сүмийн хорооны баатар, үүнд, - Үгүй хачин хэргээ! Хөлсний багийн тэргүүлэгч, бүсгүй хүний нулимсыг хайхрах уу? Гайхмаар юм. Хайр сэтгэлийн бамбар дээр хэдэн дусал дахиад уналаа ч гэсэн дөл улам ч хурцаар бадрах болно гэв.

Хэдхэн дусал гэсэнд баярлалаа! гэж де Браси хариу маргаж тэр хүүхэн чинь бүхэл бүтэн түүдэг гал унтраачихаар их нулимс урсгалаа шүү дээ. Ширээт Эймерын бидэнд ярьж өгсөн Ниоба гэгээний үеэс хойш ийм айхавтар уй гашуу, бөөн нулимс ер үзээгүй дэг. Сайхан Саксон хүүхэнд намгийн шулам шүгэлчихсэн юм аятай л байлаа шүү гэв.

Сүмийн хорооны баатар: Миний еврей хүүхэнд ч бас бүхэл бүтэн баг чөтгөрүүд шүгэлсэн байх нээ, юу гэвэл ганц чөтгөр тэгэхдээ Аполлион өөрөө байлаа ч гэсэн өдий их цаглашгүй бардам сэтгэл, шийдмэг зан түүнд төрүүлж арай ч чадахгүй байсан болов уу, Фрон де Беф хаана байна вэ? Энэ бүрээ улам чанга, дөжрөм болж байна гэвэл де Браси хэнэггүйгээр,

- Тэр лав Исаакаар оролдож байгаа байлгүй, Исаакийн орилох энэ бүрээн дууг дарж байж мэднэ. Гэхдээ эзний хойноос явуулах цаг болжээ гэв.

Харгис хатуу үйлээ үйлдэж байхад нь түгшээсэнд фрон де Беф мөн төдөлгүй хүрч ирлээ. Зарц нарт зохих тушаал буулган танхим руу ирэх зам зуураа жаахан саатжээ.

- Энэ чөтгөрийн шуугианы учир юу болохыг одоо үзье. Энэ захидал ирүүлж, эндүүрээгүй бол

саксоноор бичсэн юм шиги байна гэж фрон де Беф хэлээд захидлыг гартаа эргүүлж тойруулан утгыг нь олж тайлах гэсэн янзтай байв.

Тэгж тэгж Морис де Браси өгөв.

- Юун ч далд учиртай тэмдгүүд юм бүү мэд гэж тэр цагийн ихэнх баатруудын адил бичиг үсэг үл мэдэх де Браси өгүүлэхэд, - Манай багш ламтан намайг бичиг сургах гэж оролдсон, тэгсэн чинь минийх үсэгний оронд жадны үзүүр, сэлэмний ир зурагдчихаад болж өгдөггүй тэгэхлээр хөгшин лам намайг тоолгүй орхичихсон юм гэв.

Алив захидлаа нааш нь өг, жаал зугаа ном үздэгээрээ хуврагтай бага боловч төсөөтэй шүү гэж сүмийн хорооны баатар хэллээ.

- Тэгвэл бид таны эрхэм эрдмийг ашиглая. Энэ хуйлаастай юман дээр юу гэж бичээстэй байна? гэж де Браси асуусанд сүмийн хорооны баатар өөдөөс нь:

- Энэ захидал чинь ёс гуримын дагуу хийсэн тулалдах дуудлага байна. Гэхдээ Вифлеемскийн дарь эхийг барьж андгайлахад энэ чинь тоглоом биш юм бол бээлийн цайзны татуурган хөөргөн дээгүүр урьд хожид илгээж байсан дуудлагуудын дотор хамгийн хачин нь юмаа гэв.

- "Тоглох гэнээ! гэж фрон де Беф дуу алдаад, - Иймэрхүү янзаар хэн надтай тоглож зүрхлэхийг би мэдэх юмсан. Бриан де гуай та уншиж өгнө үүгэхэд сүмийн хорооны баатар захиаг дуудаж эхэлсэн нь:

- Уитлиссийн хүү Вамба би саксоны хэмээгдэх өндөр төрөлт, сурвалжит тайж Ротервуудын Седрикийн гэрийн алиа салбадай бүлгээ. Мөн Беовульфийн хүү гахайчин Гурт би..." гэтэл фрон де Беф тас дайран,

- Чи солиоров уу? хэмээн дуу алдав.

- Ариун номыг барьж андгайлахад энд тэгж бичжээ гэж сүмийн хорооны баатар хариулаад, цааш нь "... Беовульфийн хүү Гурт би дээр дурдсан Седрикийн эдлэнд гахай хариулдаг бөгөөд энэ хэрэгт бидэнтэй хүчин хавсарч холбоотон болсон нэгэн санаатнууд, тухайлбал залхуу хар хэмээгдэх зоригт баатар, мэргэн харваач хэмээгдэх шударга сайн Йомен, Роберт Локсли нар түшиглэн Реджинальд фрон де Беф чамд чиний дэргэд байгаа элдэв хань хамсаатан нарт мэдэгдэж байна. Юу гэвэл та бидний эзэн ноён дээр дурдсан Седрик, өндөр төрөлт Харгостанстидийн Ровена авхай, мөн Конингсбургийн өндөр төрөлт тайж Ательстан, мөн тэдэнд албан хааж явсан чөлөөт хэдэн иргэд, түүнчлэн хамжлагын хэдэн боолчууд, мөн Йоркийн Исаак хэмээх еврейг охинтой нь ямар ч шалтгаангүйгээр, дайсагналцах тухай дуулгалгүй ов залиг хэрэглэн морь луус тэргүүтний хамт олзлон авсан. Эдгээр өндөр төрөлт эрхмүүд зарц боолчуудтайгаа дээр дурдсан еврей охиныхоо хамт их эзэн хааны үнэнч албатын ёсоор хааны замаар тайван явж байсан бүлгээ. Иймд дурдсан өндөр төрөлт эрхмүүд, Ротервудын Седрик, Харгостанстидийн Ровена авхай, мөн Конингсбургийн Ательстан нар зарц боолчууд, морь луус тэргүүтний хамт еврей мөн охин болоод эд хогшилтой нь энэ бичгийг гардаж авснаас хойш нэгэн цагаас хэтрүүлэлгүй бидэнд буюу бие махбод, эд хогшлын талаар бүрэн бүтэн хохирол гэмтэлгүй хүлээж ав гэж бидний томилсон хүмүүст

хүлээлгэн өгөхийг хүсэн шаардаж байна. Эс ингэвээс та нарыг урвагч, луйварчид гэж үзэн та натай тулалдах бүслэлт дайралт хийж түйвэргээх, бүх талаар хохирол гарз учруулах санаатай байгаагаа дуулгаж байна. Үүний тулд бурхан та нарыг өршөөтүгэй гэж залбирнам. Витольд гэгээний мэндэлсэн баярын өмнө Бугийн хамар дээрх цугларах царсны дор бичив. Энэ үгсийг бурхан дархь эх, Дунстан гэгээнд сүсэглэн Копмангерстийн ойн цамхагт тахилчин, хувраг бөгөөд шударга явдалт хүн бичив " гэжээ.

Бичигний доод талд залаа нь боссон эр тахианы толгой хам хум дүрслээд Уитлиссийн хүү Вамбын тамга энэ бүлгээ гэж бичжээ. Энэхүү хүндэт билэг тэмдэгний дор загалмай зурсан нь Беовульфийн хүү Гуртийн гарын үсэг мөн. Дараа нь "залхуу хар" гэж гаргацтай томоор бичсэний дор нилээд чадмаг зурсан сум Йомен Локслийн гарын үсэг ажээ.

Баатрууд энэхүү ер бусын бичгийг дуустал чагнан чухам юу болохыг үл ойлгон өөд өөдөөсөө гайхан харав. Нам гүм байдлыг де Браси анх эвдэн тачигнатал инээхэд сүмийн хорооны баатар дагаж инээв. Эндний энэ цаг үеэ олоогүй наргианч зан Фрон де Беф дургүй байх янзтай:

- Одоогийн энэ нөхцөл байдалд хөнгөмсөг наргианч занд автах бус ноцтойгоор бодож үзвэл зохино гэдгийг эрхмүүдэд сануулья гэж фрон де Беф өгүүллээ.

- Мориноос ховох цохиулж унаснаас хойш фрон де Беф сэхээ авч чадахгүй байна. Тулалдаанд дуудах гэдэг үгийг дуулахад л тэр дуудлагыг алиа салбадай, гахайчин хийлээ ч гэсэн дотроо зэвүүцдэг болжээ гэж де Браси өгүүлэхэд фрон де Беф хариуд нь,

- Гэгээн Михаилыг барьж андгайлахад энэ өдүүлсэн хэргийнхээ төлөө де Браси чи ганцаараа хариуцдаг бол тун сайн юмсан. Энэ өчүүхэн амьтдад дээрэмчний хүчирхэг бүлэг амжиж туслаагүй бол надад ийм хэт ичгүүргүй юм илгээж зүрхлэхгүйсэн. Энэ ойд тэнүүлчид олон. Би ангаа чанд хамгаалдаг гэж цөм надад өстэй. Нэг хар хүүг би зөвхөн ганц удаа газар дээр нь барьж авсан. Тэр хар хүүгийн гар цустай хэвээрээ байсанд би зэрлэг бугын эвэрт барьж хүл гэж тушаасан. Үнэндээ ч буга тавхан минутын дотор тас татаад хаячихсан л даа. Тэгээд тэр цагаас хойш намайг Ашбид байсан бай аятай хичнээн олон удаа харвасан гэж санана... гээд зарц нарын нэгийг дуудан – Эй залуу, энэ дуудлага илгээсэн хүмүүс чухам ямар шүү хүчинд тулгуурлаж байгааг мэдэхээр хүн явуулсан уу? Үгүй юу? гэж асуувал

- Дор хаяад л хоёр зуун хүн ойд цугларсан байна гэж зарц асуулаа.

- Их догь! Ажил төрлөө сэмхэн бүтээж үл чадах улсад цайзаа ашиглуулах гэдэг ийм л байгаа юм! Энэ хэдэгнийн үүрийг хөндөх хэрэг юу байв аа? гэж фрон де Бефийг өгүүлэхэд,

- Хэдэгний үүр гэнээ? гэж де Браси хэлээд – Зүгээр муу сайн хатгах хушуугүй ажилчин зөгийнүүд. Тэд чинь цөм залхуурч гүйцсэн ажлаас зугтааж дээрэм тонуул хийхийн тулд ой руу зугтаасан боолчууд шүү дээ гэлээ.

- Хутгах хушуу үгүй гэнээ? гэж фрон де Беф дургүйцэн өгүүлээд, - Салаа үзүүртэй, гурван тохой урт францын жижиг зоосыг алдалгүй онох сум гэдэг зэгсэн хушуу мөн байхаа гэв.

Сүмийн хорооны баатар үүнд, - Эрхэм баатар та ичээч! гэж дуу алдаад, - Хүмүүсээ цуглуулаад гарч тэдний эсрэг дайралт хийе, нэг баатар, тэр ч байтугай зэр зэвсэгтэй эр цэргийн хүн бүр хорин тийм эрчүүлтэй тэнцэнэ шүү дээ гэвэл де Браси тосон авч,

- Тэгэлгүй яах вэ, жад барьж тэдэн рүү дайрахаасаа би бүр ичиж байна гэлээ. фрон де Беф үүнд, - эрхэм сэмийн хорооны баатар гуай эд туркууд юм уу маврууд байсансан бол мөн францын аймхай тариачид байсан бол де Браси гуай энэ үнэн байхсан, гэтэл энэ чинь английн номенүүд шүү дээ. Бидний ганц давуу тал гэвэл баатрын хуяг дуулга, байлдааны хөлөг билээ. Гэтэл ойн зөрөг дээр эд чинь онцын нэмрээр бага. Чи гарч дайралт хийе гэнээ? Бид чинь дөнгөж л цайзаа хамгаалж хүрэхтэй үгүйтэй хэдхэн хүнтэй байна шүү дээ? Миний хамаг сайн эрчүүл Йоркод байгаа, де Браси чиний баг бүхлээрээ тэнд байдаг. Та нарын солиорсон хэрэг явдалд оролцсон хэдхэн хүнээс гадна цайзанд хорин хүн байна уу? Үгүй шүү дээ гэлээ.

Цайз руу довглохоор олон хүн цугларсан гэж чи айж байна гэж үү? гэж Буагильберийг асуухад,

- Үгүй, Бриан гуай. Энэ тун эрэлхэг даргатай боловч бүслэлтийн туршлагатай тэргүүлэгч сэлт үгүйгээр миний цайзыг тэд яаж ч хүч хүрч дийлэхгүй гэлээ.

- Айл хөршийхэндээ элч мордуул, Реджинальд фрон де Беф бээлийн цайзнаа алиа салбадай, гахайчин, нарт бүслэгдсэн гурван баатрыг тэнхрүүлэхээр яарч ирэг гэж сүмийн хорооны баатрыг өгүүлэхэд бээл өөдөөс нь:

- Эрхэм баатар та тоглож байна уу? Хэн рүү элч мордуулах юм бэ? Мальвуазен өдийд Йорк руу хүмүүсээ аваад хөдөлж лав амжсан. Миний бусд холбоотнууд мөн адил, энэ хараалын муу ажил гараагүйсэн бол би ч мөн тэнд очсон байх уичртай хүзн гэв.

Де Браси үүнд, - Тэгвэл Йорк руу явуулж манай хүмүүсийг дууд л даа. Энэ хэрмэлүүд миний туг, миний харваачдыг хараад тарж зугтаахгүй юм болж гэм ногоон ойн урьд хожид сум тавьж байсан дээрэмчдийн хамгийн эрэлхэг нь юм гэж би хэлнэ гэлээ.

- Тийм урилгыг хэн хүргэж өгөх вэ? Цаадуул чинь зөрөг болгон дээр отоож байгаад элчийг барьж, өвөр дэх захидлы нь гаргаж авна... гээд түр бодол болсноо, - Эрхэм сүмийн хорооны баатар, та зөвхөн захидал дуудах биш бас бичиж чадна. Надад нэг бодол төрлөө. Гагцхүү ноднин гэгээн Дунстаны баярын наргиан ид дундаа байхад нас барсан манай багш гэлэнгийн бийр нянтайг олохсон болов уу гэв.

Эзнийхээ өмнө зогссоор байсан дагуул, ярианд оролцон,

- Зүрхэлж айлтгахад Урфрид эмгэн багшийнхаа дурсгал болгон тэднийг хадгалж байдаг шиг санагдана гэлээ.

- Тэгвэл Энгельред чи явж тэр хэрэгтэй юмыг аваад ир. Эрхэм сүмийн хорооны баатар чи тэдний тэр танхай дуудлаганд хариу бич гэж фрон де Беф өгүүлэв.

- Бид уг нь тэдэнд бийрээр биш илдээр хариу барихыг дээрдүзнэ. Гэвч өөрөө мэд, таныхоор болъё гэж Буагильбер хэлээд ширээн дээр сууж франц хэлээр доорхи агуулгатай захидлыг бичив.

"Эрхэм Реджинальд фрон де Беф болоод түүний нэгэн санаат холбоотон өндөр төрөлт баатрууд, боол, хамжлага, оргодол хүмүүсийн дуудлагыг үл хүлээж авна. Өөрийгөө залхуу хар хэмээгч нь үнэхээр эр баатруудын зиндааны хүчтэй ахуул иймэрхүү хүмүүстэй холбогдсоноор өөрийгөө гутаан өндөр гарал язгуурт хүмүүсийн зүгээс хүндэтгэх хүлээж чадахгүй болсноо өөрөө мэдэх учиртай. Олзны хүмүүсийн хувьд гэвэл бид христос шашинтны өгөөмөр сэтгэл баримтлан тэдний наминчиллыг сонсон хойтохыг нь засах хувраг хүн ирүүлэхийг та нараас хүсье. Юу гэвэл бид тэднийг өнөөдөр үдийн өмнө цаазлан, өмгөөлөхөөр ирсэн хүмүүсийг нь хир үл тоомсорлож байгаагаа үзүүлэхийн тулд толгойг нь цайзны ханан дээр өлгөхөөр шийдсэн билээ. Иймд дээр өгүүлсэнчлэн эдний сүнсийг даатгах хувраг хүн ирүүлэхийг хүсье. Бидний хүссэнийг биелүүлснээр та бүхэн эдгээр олзны хүмүүст хорвоогийн амьдралд нь сүүлчийн тусыг үзүүлэх болно" гэжээ.

Фрон де Беф захидлыг авч эвхээд ирсэн захидлынхаа хариуг хүлээн үүдэн дээр зогсож байгаа элчид зарцаар өгүүлэв. Уул даалгаврыг гүйцэтгэсэн Йомен цайзнаас гурван нум харвах газарт, сахлаг өвгөн царсан дор байрласан холбоотны ерөнхий захирах газарт эргэж очив. Тэнд Вамба, Гурт, Хар баатар, Локсли болоод наргианч даянч цөм дуудлагынхаа хариуг тэсэж ядан хүлээж байлаа. Арай цаахна, нар салхинд боролсон царай, ногоон хувцсаар нь чухам ямар шүү ажил эрхэлдэг болох нь илт олон йоменүүд харагдана. Нэгэнт хоёр зуу гаруй хүн цугларсны дээрээс шинэ шинэ багууд ирж нийлсээр ажээ.

Эдгээр бүлгүүдээс гадна ойролцоо нутгийн саксончууд, мөн эзнээ гаргаж авахаар Седрикийн өргөн уудам эдлэнгээс хамжлагынхан, зарц нар хүчин туслахаар иржээ. Эд гол төлөв сэрээ, хадуур, гинж зэрэг аж ахуйн багаж хэрэгсэл барьж иржээ. Норманууд байлдан дагуулагч нарын бодлогыг баримтлан ялагдсан саксончуудад илд жад хэрэглэхийг хориглодог байлаа. Энэ шалтгаанаас болон саксончуудын үнэн хэргийн төлөө яваадаа онц зоригжин мэрийж байгаа болоод бие бялдар чийрэг, тоо олныг нь эс тооцвол бүслэгдэгсдэд төдий л аймшигтай санагдахааргүй бүлгээ. Энэ цоохор цэргийн тэргүүнүүдэд сүмийн хорооны баатрын бичсэн захидлыг гардуулав. Чухам юу бичсэнийг уншуулахаар эхлээд даянчид өглөө.

--Энд юу гэж бичсэнийг та нарт дуудаж өгч чадахгүйгээр үл барам франц хэлээр юм уу арабаар бичсэн алин болохыг мэдэхгүй гэдгээ гэгээн Дунстаны бэрээг барьж андгайлъя гэж хүндэт гэлэн өгүүлсэн бөгөөд уул бэрээгээр чухамдаа нэг ч гэгээн энхжингийн оронд цуглуулаагүй олон шавь нар хуралдуулсан хүн бүлгээ.

Ингэж хэлээд захиаг Гуртэд гардуулбал цаадах нь урвуу царайтагаар толгой сэгсрээд Вамбад өглөө. Салбадай залирхуу инээвхийлэн цаасны бүх дөрвөн өнцгийг нягтлан үзээд хий үсэрснээ захидлыг Лекслийд дамжуулав.

--Урт үсэг нь нум, богино нь сум байсан болж гэм би яаж ийгээд гадарлахсан гэж шударга йомен өгүүлэв.

--Би та нарт дуудаж тус болохоос доо гэж Хар баатар өгүүлээд Локслийн гараас захиаг авч

эхлээд өөрөө уншиж үзсэнээ агуулгыг нь холбоотнууддаа саксоноор хэлж өгөв.

--Өндөр төрөлт Седрикийг цаазлах гэнээ! гэж Вамба дуу алдаад, - Загалмай барьж андгайлахад эрхэм баатар чи эндүүрсэн байхаа гэв.

--Үгүй, хүндэт найз чинь энд бичсэн зүйлийг би яг дамжуулж өгсөн гэж баатар хариулав.

--Тийм бол цайзны чулууг улаан гараараа нураахад хүрлээ ч гэсэн дайрч эзлэх хэрэгтэйг гэгээн Фомын нэрээр андгайल्या гэж Гуртыг хэлэхэд Вамба өөдөөс нь:

--Чи бид хоёр өөр барих зэвсэг ч үгүй, ганцхан миний гар энэ хэрэгт тохирно шүү гэв.

--Тэд зүгээр цаг хожихын тулд ингэж хэлж байна. Сүүлд нь толгойгоороо хариулахад хүрэх ийм хэрэг хийж тэд төвдөхгүй гэж Локсли өгүүлэв.

Хар баатар үүнд, - Хэрэг ажил чухам хаашаа болж байгааг мэдэхийн тулд та нарын нэг цайзанд залилаад нэвтэрч орвол сайн юм сан. Наманчлах сонсгох хувраг хүн ирүүлэхийг тэд гуйжээ. Миний бодоход манай ариун явдалт даянч энэ буянт үйлийг гүйцэтгэхийн хамт бидэнд хэрэгтэй мэдээ авч ирж болмоор байна гэлээ.

Ариун явдалт даянч үүнд, - Чамайг наад зөвлөлгөөтэй чинь хамт чөтгөр аваг! гэж дуу алдаад – Жанчаа тайлахын хамт би хувраг болдог, миний хамаг ариун чадал, латин ном эрдэм хүртэл мартагддаг гэж эрхэм залхуу танд би хэлсэн шүү дээ. Ногоон хүрэм өмсөхийн хамт би нэг христос хүний наминчлалыг сонсохоосоо хорин буга харваж чадахтай болдог юм гэв.

--Наманчлал сонсгох багш ламтан болчихмоор хүн энд ер олдохгүй л болов уу даа гэж хар баатрыг өгүүлэхэд хүмүүс цөм өөд өөдөөсөө харан дуугүй байцгаав.

Вамба хэзэг түдгэлзснээ – Тэнэг хүн гэдэг тэнэг чигэрээ үлдэж ухаалаг хүмүүсийн зайлсхийх гай руу хүзүүгээ шургуулж явах тавилантай юм шив дээ. Нэг нутгийн ах дүү нар минь, урьд би ухаа шаргал өнгийн хувцас өмсөж, гэлэн сахил хүртэхээр зэхэж байтал ухаан минь муудаж тэнэглэж яваад өнгөрөх төдий юм үлдсэн гэдгийг дуулгая. Тэгээд манай сайн даянчийн малгай дотор оёотой байгаа буянч гэгээн ламтны номын ачаар би манай эзэн шударга үйлт Седрик түүний золгүй нөхдөд хорвоогийн болоод сэтгэл санааны талаас тайтгаруулж чадах болов уу гэж санана гэж хэлэв.

- Вамба үүнд тохирох уу, чи юу гэж бодож байна гэж Гуртээс Хар баатар асуулаа.

--Үнэндээ мэдэхгүй юм даа. Тохирч эс чадлаа гэвэл тэнэг явдлаа ухаан санаа нь залж чадаагүй анхны учрал болох байх гэж цаадах нь хариулав.

--За тэгвэл сайн хүн та жанч өмс. Цайзан дотор хэргийн байдал ямар байгаа тухай эзэн чинь чамаар бидэнд мэдээ өгөг. Тэнд цөөн хүмүүс байх учиртай. Тэгэхлээр гэнэтийн зоримог дайралт маш амжилттай болж болно. Ингэхэд цаг хавчуу байна, бушуухан явж үз гэж Хар баатар өгүүлэв.

Локсли үүнд, - Энэ зуур бид цайзыг ганц ч ялаа бидэнд мэдэгдэлгүй тэндээс үл гарахаар

чанд бүслэе. Олзны хүмүүст хүчирхийлэл тулгасан тухай бүрийнхариуг бид арав дахин хатуулж авна гэдгийг найз минь чи тэр зальхай этгээдүүдэд дуулгаарай Вамба гэж хэлэв.

Гэлэн хүний бүрэн хувцас өмсөж амжсан Вамба Рах vodiscum гэж хэлээд ихэмсэг төлөв дүртэй болон үүргээ гүйцэтгэхээр намбатайгаар алхан одов.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Агармаг хөлөг дөнгөж шогших болж

Адгийн адсага хурдлан давхих цаг бий

Ариун явдалтан салбадай болж

Алиа мунхаг гэлэн болох цаг бий.

Эртний ардын дуу

Алиа салбадай даянчийн жанч өмсөж зангилаа болсон олс бүслэн Реджинальд фрон де Бефийн цайзны үүдэн дээр хүрч очиход хэн болох тухай ирснийг нь хаалгач асуулаа. Салбадай хариуд нь: - Рах vodiscum! Би франциск хийдийн дорд гэлэн, энэ цайзны дотор байгаа золгүй хоригдлуудын сэтгэлийг тайтгаруулахаар ирлээ гэвэл хаалгач өөдөөс нь:

--Манай согтуу багшаас өөр чамархуу ийм уран шувуу лав хорин жил зориглож ирээгүй энэ газарт хүрч ирснийг бодоход чи их зүрхтэй гэлэн юм даа гэв.

--Өршөөл үзүүлж миний тухай цайзны эзэнд айлтгаж өгч үз. Надыг дуртай хүлээж авна гэдэгт итэг. Би бүх цайзаар нэг хадтал ном чанга дуудамц гэв.

--Үүнд чинь гялайлаа. Харин чиний үгийг дамжуулах гэж харуулан байраа орхилоо гэж эзэнд баллуулах юм болж гэм гэлэн хүн гэж чамайг эс харгалзан дор чинь харваж орхино шүү гэж хаалгач хэллээ.

Ингэж хэлээд тэр жижиг цамхагнаас гарч, хаалганы өмнө ариун явдалт гэлэн ирж даруй оруулах зөвшөөрөл гуйж байна гэж үзэгдээгүй сонинг дуулгахаар цайзны их танхим руу одлоо. Ариун явдалт хүнийг даруй оруул гэж эзэн нь тушаасанд хаалгач ихэд гайхаж харуулын хүнээр орондоо үүд мануулан зогсоогоод цаашид элдэв юм эрэгцүүлэлгүй авсан тушаалаа гүйцэтгэхээр явлаа.

Аймшигт Фрон де Бефийг үзээд Вамба мулгуу их зориг нь дутаж арай ч самгардсангүй. Хөөрхий салбадай нөгөө Рах vodiscum гэдгээ чичирхийлсэн дорой дуугаар өгүүлэв.

Харин алив англи язгуурын хүмүүс өмнө нь чичрэхийг фрон де Беф үзэж сурчихсан болохоороо хуурамч гэлэнгийн ийнхүү зүрх алдсан нь түүнд ямар ч сэжиг эс төрүүлэв.

--Чи юун гэлэн, хаанаас явж байна? гэж бээл асуувал салбадай өөдөөс нь дахин,

- Рах vodiscum! гээд би франциск гэгээний хүрээний өчүүхэн гэлэн ой дундуур явж байгаад дээрэмчдийн гарт орлоо. Тэд намайг таны өндөр шударга, шүүхээр цаазлагдах ял оногдсон хоёр хүний сүнснийг дааж буянт үйл үйлд гэж энэ цайз руу явууллаа гэв.

--За тийм байж гэж фрон де Беф дуугараад, ариун явдалт багштан та тэр дээрэмчид хэдий

хир хүн байсныг хэлж өгч чадах уу? гэвэл,

--Эрэлхэг ноёнтон минь тэднийг чинь маш олон гэх юм билээ гэж Вамба хариулав.

--Гэлэн чи зүгээр л тэд хичнээн хүн байгааг хэлчих, тэгэхгүй бол чиний жанч олс аль алин нь чамд өмгөөлөлт болохгүй шүү гэвэл хуурамч гэлэн өөдөөс нь:

--Үгүй би айсандаа бараг үхчихсэнгүй. Гэхдээ тэр йомен тариачид лав таван зуун хүн байгаа даг шүү гэв.

Энэ үеэр танхимд орж ирсэн сүмийн хорооны баатар дуу алдан:

--Юу гэнээ? тэр хэдгэнүүд төдий олноороо нисч ирлээ гэж үү? Тэдний хорт үүрийг няц дарах цаг тэгвэл ирж дээ гэв.

Бриан цайзны эзнийг хажуу тийшээ авч очин:

--Чи энэ гэлэнг таних уу? гэж асуувал:

--Үгүй энэ чинь эндхийн биш хол хийдийн хүн байна, би танихгүй гэж хариулав.

--Тэгвэл бидний даалгах гэж бодсон зүйлийг амаар бүү хэлж өг. Брасийн нэрийн өмнөөс чөлөөт багийг нь наашаа яаравчлан ир гэж тушаасан захидал хүргэж өгөг. Тэр зуур хэргийн учир юу болохыг энэ гэлэнд эс гардуулахын тулд саксоны гахайнуудыг нядалгаанд бэлтгүүлье гэв.

--За яах вэ тэгье гэж фрон де Беф хариулаад Седрик Ательстан хоёрын байгаа өрөөнд Вамбыг оруул гэж нэг зарцад хэллээ.

Энэ зуур Седрикийн тэсэж ядах нь улам бүр нэмэгдлээ. Дайралтанд орж байгаа юм уу цайз руу довтлоход улайран авирч яваа хүний байртай өрөөн дотуур холхино. Дуу алдаж сүрхий өөг хоолоо амгалан гээч шингээж адал явдлын шувтаргыг хайш хэрэг тэсвэртэйгээр хүлээн суугаа Ательстан юм хэлнэ.

Гянданд удаан хоригдох эсэх тухай түүний бодол сэтгэлийг онц зовоохгүй байгаа бололтой.

Салбадай тэдэн дээр орж ирээд – Рах vodiscum, Дунстан гэгээн, Денис гэгээн, Дюток гэгээн болоод бусад бүх гэгээдийн ивээл та бүхэнд хүрэх болтугай! гэвэл хуурамч гэлэнд Седрик:

--Морилогтун! Та бидэн дээр юу гэж ирээв? гэлээ.

--Би та нарын сүнсийг даах гэж ирлээ гэж салбадай хариулахад Седрик давхийн,

--Арай үгүй байгаа!Тэд хэдий хорсол хилэнтэй айж зовохыг мэдэхгүй ч гэлээ ийм харгис хэрцгий ёсон гажуу аллага явуулж зүрхлэхгүй гэж дуу алдав.

--Яая гэх вэ.Тэдний хүнч сэтгэлийг хөдөлгөх гэдэг туйлдсан орийг торгон цулбуураар тогтоох

гэж оролдохтой адил юм. Иймд сайн төрөлт Седрик, зоригт Ательстан та мөн ялгаагүй махан биеэрээ ямар нүгэл үйлдсэнээ нягтлан бод юу гэвэл та хоёр эрэлхэг номон хааны өмнө өнөөдөртөө очих болно гэж салбадайг хэлэхэд Ательстан хариуд нь:

--Би бэлэн байна. Тэдний хорсол хилэн юу бодож олсон бүхнийг тэсэж өнгөрүүлээд хоол идэхээр очихын адил үхлийг тайвнаар угтана гэв.

--За тэгвэл багш минь одоо тэр ариун ёслолыг үйлдэе дээ гэж Седрик өгүүлсэнд салбадай ердийнхөө дуугаар,

--Өвгөө та түр азна, юун их түргэн бэлэн зэлэн болчих гэв. Хав харанхуй руу үсрэхийн өмнө орчин тойрноо сайн эргэцүүлээд харсан нь дээр гэв.

- Үгүй нээрээ үүний чинь дуу танил юм байх чинь гэж Седрик хэлсэнд Вамба юүдэнгээ аван,

- Энэ бол таны үнэнч боол алиа салбадайн чинь дуу байна. Хэрэв та миний тэнэг зөвлөлгөөг түрүүн дуулсан болж гэм энд баригдаж суухгүй байхсан, ядаж одоо тэнэгийн зөвлөлгөөг дага, тэгвэл та энд удаан суухгүй, болно гэж хариулав.

--Үгүй яаж тэр вэ овт минь? гэж Седрик асуухад,

--Яах вэ, энэ жанч олс хоёрыг ав, миний хамаг ариун мяндаг эдэнд л байгаа хэрэг. Тэгээд цайзнаас тайван гэгч гарч од. Цув бүс хоёроо надад үлдээ би өөрийг чинь орлож үлдээд чиний орноос хаашаа харайхад хүрнэ вэ харайж үзэхээс гэлээ.

Энэ үгийг Седрик дуулаад, - Чи миний оронд үлдэх гэж үү? Үгүй, тэд чамайг дүүжлэж орхино шүү дээ, хөөрхий муу тэнэг минь! гэхэд Вамба өөдөөс нь,

- Яах вэ, дураараа болог, бурхан хэрхэн таална вэ тэр л мэдэг. Уитлиссийн хүү Вамба бодоход өвөг эцэг Ольдермены нь хүзүүндээ зүүсэн гинж ихэмсгээр зохиж байсны адил өөрөө гинжнээс догь гээч дүүжлэгдэж чадах байхаа гэв.

--За Вамба би чиний энэ саналыг хүлээж авья. Тэгэхдээ ганцхан нөхцөлтэйгээр шүү. Хувцсаа надтай биш Ательстан ноёнтой сольж орхи гэж Седрик хэлбэл Вамба хариуд нь,

--Дунстан гэгээнийг барьж андгайлахад ер үгүй, энэ надад үл таалагдах зүйл! Уитлиссийн хүү Хервардын хүүгийн амийг аврахын төлөө зовлон үзэж болно, харин эцэг нь миний эцэгтэй танил бус байсан хүний төлөө амиа алдах хэрэг надад юу байна? гэлээ.

--Муу шаар, Ательстаны өвөг дээдэс Английн эзэн хаанаар байсан юм шүү! гэж Седрик хэллээ.

--Тэдний хэн байсан нь надад ялгаагүй. Үүний өвөг дээдсийн төлөө хүзүүгээ хуга мушгиулахыг би хүсэхгүй байна. Иймд сайн эзэн минь миний саналыг бушуухан дагаж эсвэл энэ цамхагнаас гарахыг зөвшөөр гэвэл Седрик учирлан,

- Хөгшин модыг яах вэ хэтэг гээд орхичих, үнэнч Вамба минь сайн төрөлт Ательстаныг авар.

Дотор нь саксоны цус гүйж байгаа хэн бүхэн тэгэх үүрэгтэй юм шүү. Чи бид хоёр цуг хэрцгий дарангуйлагчдын хилэн хорслын золиос болъё. Ательстан суллагдан гараад манай омгийнхны дотор өшөө хонзон авах сэтгэлийг хөдөлгөн бидний хариуг дайснаас авах болно гэлээ.

Ательстан түүний гарыг барьж, - Үгүй эцэг минь зарцын үнэнч сэтгэлээр эзнээ аврах гэж олсон аргыг ашигласнаас бүтэн долоо хоног энэ танхимд ус талх хоёроор гол зогоож суух нь дээр гэж үзнэ гэв.

Эрхмүүд та нар ухаантай улсад тооцогдож би тэнэг гэгддэг. Гэвч Седрик өвөг Ательстан ах минь нөгөө тэнэг чинь шийдвэр гаргаж та маргааныг таслах болно. Жоноос өөр хүнийг дээрээ ер мордуулдаггүй. Жоны гүүтэй би яг аилхан гэж мэд. Би өөрийнхөө эзнийг аврах гэж ирсэн. Хэрэв эзэн миний тусыг хүлээж авахгүй гэвэл би гэртээ харилаа. Тэгээд л тэр. Ураг төрлийнхөө эзний төлөө л бус бол би дүүжлүүлэхийг зөвшөөрөхгүй гэв.

- Сайн төрөлт Седрик та яв, энэ завшааныг бүү алд. Та энэ цайзны гадна гарах юм болж гэм манай нөхдийн урам зориг сэргэж бидний аврагдах явдал түрэгсэнэ, та эндээ үлдвэл бид бүгд цөм балрах болно гэж Ательстаныг гуйхад Седрик салбадай руу хараад,

--Энэ хананы цаана тусалж тэнхрүүлэхийг горилох найдлага байна гэж үү?

гэж асуувал,

--Ямар шүү найдлага байгаа гэж санана ! гэж Вамба дуу алдаад,

- Миний навтсыг угласнаар та жанжны хувцас өмсөж байгаагаа мэдэж ав.

Энэ цайзны ханыг тойрон таван зуун хүн цугларсан бөгөөд өнөөдөрхөн би тэдний гол тэргүүлэгчдийн нэг байлаа шүү. Салбадайн малгай дуулга, шажигнуур маань өрлөг жанжны очирт тооцогдсон. Харин тэнэгийгээ ухаантай хүнээр солиод тэд их хожих нь уу, үгүй юу үзье. Тэд маань хэт их ухаан сууж орхиод эр зоригоо гээчих бий гэж байна шүү нээрээ. За баяртай эзэн минь. Хөөрхий Гуртэд өршөөнгүй байж, түүний нохой Фангсыг өрөвдөж үзээрэй. Миний овоодойг үнэнч... тэнэгийн ёсоор эзнийхээ төлөө амиа дурсгал болгон Ротервудийн хананд өлгөж орхиорой гэлээ. "Тэнэг" гэдэг үгийг Вамба үнэнээсээ ч юм шиг тоглоомоор ч гэлтэй хачин нухацтай хэлсэнд Седрикийн нүдэнд нулимс гүйлэгнэв.

- Үнэнч итгэл, хайр сэтгэл энэ ертөнц дээр чухалчлагдаж байх цагт л чиний тухай мөнх дурсаж байх болно. Ровена, Ательстан чамайг, мөн хөөрхий Вамба чамайгаа аврах арга олно гэж боддоггүйсэн бол би хялбархан ятгагдаж үүнийг зөвшөөрөхгүйсэн билээ гэв.

Тэд хувцсаа солив. Тэгтэл Седрикэд шинэ бэрхшээл тулгарч ирэв.

- Би төрөлх хэлнээсээ гадна хэдхэн норман өгүүлбэрээс цааш ямар ч хэл

мэдэхгүй, би яаж жинхэнэ гэлэн болж чадах билээ? Гэвэл Вамба өөдөөс нь:

- Хамаг учир хоёрхон үгэнд байдаг юм. Хүн юу ч гэж байсан "Рах vodiscum" гэж хариулаад

байгаарай. Уулзах санах адис хүртээх юм уу харах даа "Рах vodicum!" гээ л давган хэл, тэгээд л болно. Энэ үгс чөтгөрт шүүр, шидтэнд очир чухгийн адил гэлэн хүнд маш хэрэгтэй. Гагцхүү бүдүүн, ихэмсэг дуугаар л "Рах vodicum" гэхэд хэн бүхэн буугаад өгнө. Манаач, харуул, баатар дагуул, морьтой явган ялгаагүй хүн бүхэнд энэ үг тарина мэт хүчтэй. Хэрэв намайг маргааш дүүжлэхээр авч одвол(тэгтэл ч өдий л байна) би энэ үгийн чадлыг яргачид дээр туршиж үзнэ гэв.

Ательстан үүнд, - Сайн төрөлт Седрик баяртай! Тэнхээ тамираа сэлбэж юм ид, гэлэн хүн ер үгүй гэдэггүйг санаарай гэхэд Вамба,

--Өвгөө баяртай! "Рах vodicum" гэдгийг битгий мартаарай! гэлээ. Эдгээр захиа үгсийг дуулаад Седрик гарч одов. Салбадайн зааж өгсөн үгний далдын хүчийг удалгүй туршиж үзэхэд хүрлээ. Намхан бөмбөгөр адартаы гудмаар их танхим руу явж байтал өмнө нь гэнэт бүсгүй хүн харагдав.

Хуурамч гэлэн - "Рах vodicum!" гэж хэлээд бушуу хажуугаар нь өнгөрөхийг хичээсэн авч бүсгүй хүний ялдам дуу хариуд нь мөн латинаар,

--Эрхэм багш та мөн амгалан болтугай гэв.

--Би жаахан дүлий юм шүү гэж Седрик саксоноор хэлээд золигийн муу тэнэгийн зааж өгсөн юмыг! Эхлээд л дуугарахад бүдрээд орхидог байна шүү гэж аман дотроо үглэв.

Гэхдээ тэр цагт хуврагууд латинаар муу ойлгох нь олонтой, Седриктэй ярилцсан бүсгүй үүнийг сайн мэдэж байлаа.

Бүсгүй цаашаа саксон хэлээр, - Эрхэм багш та өршөөж шарх бүхий олзлогдсон хүн дээр очиж сэтгэл санааг нь түвшитгэж өгнө үү. Энэ сайн үйлийн төлөө танай хийд урьд ер үзээгүй их өглөг барьц авах болно гэлээ.

Седрик ихэд тэвдэж, - Би ердийнхээ буянг үйлдэж энэ цайзанд цаг үрж болохгүй болов охин минь. Би аль болох түргэн явах учиртай, олон хүний амь нас үүнээс шалтгаалах юм гэлээ.

--Багш ламтан минь таны хүртсэн санваарыг барьж гуйя. Золгүй хүнийг бүү орхи, зөвлөлгөө хайрлаж тус үзүүлэхээс бүү татгалз гэж бүсгүй шалахад,

- Чөтгөр чамайг авч Один Гора хоёрын сүнстэй цуг Ифринд суулгаж орхиосой! гэж Седрик унтууцан өгүүлэв.

Дахиад нилээд хэдэн тиймэрхүү үг лав хэлэх байсан боловч нөгөө буйд цамхагт суудаг байсан эмгэн Урфридийн ширүүн дуу гарч яриа гэнэт тасалдав.

Седриктэй ярилцаж байсан бүсгүй рүү, - Энэ чинь юу гэсэн үг вэ хонгор минь? Дээд гонхноос гарах, зөвшөөрөл өгч ач болсны хариуг чи ингэж барьдаг бий. Ариун явдалт хүнийг шврей бүсгүйн шалаанаас салахын тулд хараал тавихад хүргэж байдаг чинь гэв.

Хоёулангаас нь яаж ийгээд зугтаах шалтаг Седрик хайж, Еврей бүсгүй гэнээ? гэж дуу алдаад,

- Алив намайг явуулж үз бүсгүй! Бүү саатуул, зам тавь. Би дөнгөж аиун буян үйлдсэн, бузардахыг хүсэхгүй байна гэв.

- Багш та наашаа ир. Та эндхийн хүн биш. Зам заалгүйгээр энэ цайзнаас гарч чадахгүй. Наашаа ир би чамтай ярилцмаар байна. Чи харин явж намайг очтол өвчтөнг асарч бай. Тэндээс миний зөвшөөрөлгүй дахин холдох юм бол хохь чинь шүү! гэлээ.

Ревекка далд оров. Түүнийг гуйгаад байхаар нь Урфрида цамхагаас гарахыг зөвшөөрч, дараа нь шархтай Айвенгог асруулах болжээ. Олзлогдогсдод ямар аюул тулгарч байгааг Ревекка сайн ойлгож тэднийг аврахын тулд юухан ч хийх боломжийг алдахгүй байлаа. Энэ бурхан шүтээнийг огоорсон цайзанд лам хүн ирснийг дуулаад түүгээр дамжуулан аль нэг арга олохыг горилжээ. Энэ зорилгоор хуурамч гэлэнг гудамжинд хүлээж байсан хэрэг. Гэвч оролдлого нь үл бүтсэнийг бид үзлээ.

ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ

"Амнаас чинь гарч болох бүхэн

Алив бузар, шившиг, гуниг болой

Хийсэн бүхэн чинь нэгэнт илт..."

Хүрэмтэн юунд дуугүй байнам!

.....

"Бусдын гайгаар би хөнөөлд орсон

Бүх сэтгэл санаа минь харлаж гүйцсэн

Гашуун зовлонгоо хуваалцах

Ганц ч нөхөр надад үгүй.

Шуналт сэтгэлийн нүглээ наминчлан

Сонсоод та хариу айлдаж хайрла"

Крабб "Шүүхийн ордон"

Урфриде өвчтөний өрөөнд Ревеккаг хөөж орулаад Седрикийг хүчээр чирч тусгай жижиг өрөөнд оруулан үүд дагинатал түгжиж орхив. Тэгснээ тавиур дээрээс дашмагтай дарс, хоёр аяга авч ширээн дээр тавиад,

--Багш та саксон хүн юмаа? Бүү марга, битгий марга, гэж Седрик үгийг нь няцаах гэж яарахгүй байгааг харж хэлээд, - Хавчигдсан хөөрхий боолчуудын амнаас л юу гэхээс өөрөөр ховор дуулдах төрөлх хэлний аялгуу чихэнд чимэгтэй байна. Багш та саксон хувраг хэдий боловч эрх чөлөөт хүн. Чиний яриаг сонсоход надад сайхан байна.

- Саксоны хуврагууд энд ирдэггүй юм гэж үү! Миний нутгийн үгүйрч дарангуйлагдсан үр садан санаа сэтгэлийг тайтгаруулах тэдний шууд үүрэг шиг надад санагдана гэж Седрикийг хэлэхэд,

- Үгүй ирдэггүй юм. Ирлээ гэхэд нэг нутгийнхаа гомдол зовлонг сонсохоосоо байлдан дагуулагсдын ширээнд найрлан суухыг илүүтэйд үздэг. Юу гэсэн тэдний тухай ингэж ярьдаг юм билээ. Би өөрөө ч хүнтэй уулзах нь ховор юм хойно. Шөнө Фрон де Бефтэй хамт хөлчүүрдэг завхай Норман ламаас өөр хувраг хүн энд арван жил л лав үзэгдээгүй. Тэр ч мөн хуврагийн буян номыг хэрхэн үйлдсэн тухайгаа бурханд айлтгал тавихаар аль эрт нөгөө ертөнцөд одсон. Чи саксон хүн, бас саксоны хувраг, танаас би нэг юм асуух хэрэг байна гэлээ.

- Тиймээ би саксон, гэхдээ хувраг нэрээ хадгалахуйц өөдтэй хүн бишээ.

Намайг явуулж үз! Би өөрөө эргэж ирнэ эсвэл чиний наминчлалыг сонсож чадахтай өөр хувраг хүн ирүүлж өгөхөөр андгайлъя гэж Седрикийг гуйхад,

- Жаахан азна. Таны сонсож байгаа энэ дуу мөдхөн чийгтэй шорон дор булагдаж ийм болно. Харин би нүглээ наминчлалгүйгээр тийшээ одох дургүй байна. Тэгэхлээр амьд насныхаа хамаг аймшигийг чамд ярьж өгөх чадал дарс надад өгөх болтугай! Гээд аягаа дүүргэн ганц ч болов дусал газар унагаах бий гэсэн байртай шунагаар хоослов. Дарс уугаад тэнгэр өөд харан цааш нь,

- Дарс мансууруулах хэдий авч сэтгэл хөгжөөхөө нэгэнт больжээ. Багш гуай та ч мөн уу! Тэгэхгүй бол миний ярих гэж байгаа юмыг сонсоод тэсэж чадахгүй шалан дээр унаад өгөх байх шүү гэв.

Ийм ёозгүйгээр өгсөн дарснаас Седрик дуртайяа татгалзах байсан авч бүсгүйн дохих тун ч тэсэж ядсан, цөхөрсөн байртай байсан болохоор гуйсныг нь даган томоор балгав. Ингэж зөвшөөрсөнд бүсгүйн санаа амрах аятай яриагаа эхлэв.

--Багш минь одоо таны харж байгаа шиг би ийм хөөрхийлөлтэй амьтан төрөхөөсөө байгаагүй юм. Би эрх чөлөөтэй, жаргалтай, хүндлэгддэг, хайрлагддаг, өөрөө хайрладаг байсан. Одоо бол би золгүй дарангуйлагдсан муу боол. Гоо сайхан бай цагтаа би эздийнхээ шунал тачьяалын зугаа байгаад, гоо үзэсгэлэн минь гандан буурсан цагаас хойш тэдэнд өшигдөж, басамжлагдах амьтан болов. Миний хувь тавиланг ингэж урвахын шалтаг болсон омгийг гойдоор, хүн төрөлхтнийг ер нь үзэн яддаг нь гайхалтай зүйлүүдээ багштаан? Уур хорслоо хоосон хараалаар тайлж суудаг үрчгэр дорой эмгэн урьд нэгэн цагт олон мянган албат өмнө нь чичирсон торкильстоны өндөр төрөлт тайжийн охин байснаа мартаж чадна гэж үү? гэвэл, Седрик гэдрэг ухран:

- Чи Торкиль Вольфгангерийн охин гэж үү? Чи... чи тэгээд миний эцгийн найз, аян дайны нь нөхөр, өндөр төрөлт саксон хүний төрсөн охин гэж үү? гэв.

--Чиний эцгийн нөхөр гэнээ? гэж Урфрида дуу алдаад, - тэгвэл миний өмнө саксоны гэгдэгч Седрик тайж таарав аа, юу гэвэл сйн төрөлт Ротервудийн хорвоод гану хүүтэй, түүний нь нэр омгийнхны дотор цууриатаж байгаа билээ. Чи үнэхээр Ротервудын Седрик мөн бол над хувраг хувцас чинь юу юм бэ? Чи хүртэл эх орноо аврахаар оролдож цөхрөөд хавчлага дарангуйллаас хийдийн хананы цаана орж хорогдоо юу? гэхэд,

- Би хэн ч байсан ялгаагүй. Золгүй амьтан чи аймшигт гай хөнөөл, гэмт хэргийнхээ тухай цааш нь ярь. Чиний гэмт хэрэгтэн гэдгийг мэдэж байна. Чиний амьд үлджээ гэдэг чинь хүртэл гэмт хэрэг шүү дээ гэв.

Хөөрхий эмгэн хариуд нь – Тиймээ, би их нүгэл үйлдсэн хүн. Маш их хараалт хар хэргүүд цээжин дээр минь хүнд чулуу болон дарж амь тавин тарчлах зовлон хүртэл хариу төлөөс нь болж чадахгүй байна. Тиймээ, эцэг ах дүү нарынхаа ариун цусанд будагдсан энэ өрөөнүүдэд, энэ байшинд бас тэднийгээ алсан хүнтэй нөхцөн, зугаа цэнгэлийн нь боол болж хамт наргин амьдарч байлаа. Тэгэхлээр миний амьсгалах бүр, амьдралын маань эгшин бүр гэмт хэрэг байжээ гэв.

- Золгүй бүсгүй! гэж Седрик дуу алдаад, - Тэгэхлээр эцгийн чинь нөхөд түүний болоод хувгүүдийн нь хойтохыг даатган мөргөл залбирал хийхдээ алагдсан Ульрикийн нэрийг марталгүй дурдсаар, амь алдагсдын хойноос уй гашуу болж, ариун дурдатгалыг нь хүндэлсээр байхад чи амьд байж байжээ! Чиний хамаг элгэн садан хүмүүсийг хядсан, Торкил Вольфгангерийн өндөр дээд алдарт удмаас үр үндэс ганцыг ч үлдээхгүйн тулд нялхсын цусыг урсгасан хогийн муу хэрцгий дарангуйлагчтай амрагийн холбоотой байж байжээ! гэхэд,

- Холбоотой үнэн харин амрагийн бишээ. Энэ бузар дээвэр дорход орохноо тамд харин хайр сэтгэл байх зай бий байж магад. Үгүй тийм нүгэл надад байхгүй. Фрон де Беф түүний бүх үндсийг эс үзэн ядах хувь ч надад байгаагүй гэж эмгэнийг өгүүлэхэд,

- Үзэн ядах мөртлөө амьд байгаад байлаа гэж үү? гэж Седрик дуу алдан, - Хувьгүй амьтан Үгүй чиний гар дор хутга чинжаал юу ч байгаагүй гэж үү? Норманы цайзны нууц авсныхтай адил байдаг нь чиний аз болжээ! Торкилийн охин эцгийнхээ алчуурчинтай бузар холбоотой амьд байна гэж миний зүүд төдийд үзэгдсэн ахуул жинхэнэ саксон хүний илд чамайг нөхцөгчийнхөө өвөрт байхад чинь олж цавчих байсан билээ гэв.

- Чи үнэхээр Торкилийнхны нэр төрийг хамгаалах байсан гэж үү? гэж Ульфира хэлээд (үүнээс хойш хоёрдахь нэр Урфридаг нь бид орхиж болох юм) Олны ам чамайг алдаршуулсан шиг чи үнэхээр саксон хүн мөн шив? Юу гэвэл энэ хараал хүрсэн хананд хүртэл Седрикийн нэр дурсагддаг, тэгээд миний золгүй авгын өшөөг авагч ганц ч болов хүн амьд байна гэж бодож гутамшиг болсон өёүүхэн амьтан би баярлаж байдагсан. Өшөө хорслоо авсан цаг надад ч байсан. Дайснуудаа би хэрүүл маргаан руу түлхэж, хөлчүүрэх наргиан дунд тэднийг ясны өштөн болгодог байлаа. Тэдний цус урсахыг харж, амь тавин ёолохыг дуулж байсан. Седрик чи наашаа хар даа миний гундаж гүйцсэн гутамшиг царайнд Торкилийнхныг санагдуулмаар ямар нэг төсөө үлдэж үү гэхэд,

- Энэ тухай Ульрика чи бүү асуу гэж Седрик харамсаж, жигших байртай өгүүлээд, - Үхсэн хүний хүүрэнд чөтгөр шүглээд буг болохдоо амьд ахуйтай нь төстэй байдгийн адил байна гэвэл бүсгүй хариуд нь,

- За тийм байг. Гэтэл энэ бугийн царай нэг цагт ахмад Фрон де Беф, түүний хүү Реджинальд хоёрыг хооронд нь дайсагнуулж чадахтай байсан юм. Дараа нь болсон явдлыг тамын харанхуйд үүрд нуувал зохих авч үзэгсэд авснаасаа босон чанга орилолдох цаг байдгийг үзүүлэхийн тулд харанхуйг түр гэрэлтүүлж харуулья. Хэрцгий эцэг догшин харгис авиртай хүү хоёр хоорондоо удтал битүүгээр өшилцөн байгаад хөлчүүрэн наргихын цагт тэр нь дүрэлзэн босож ирээд намайг доромжлогч этгээд өөрийнхөө ширээнд найрлаж байгаад төрсөн хүүгийнхээ гарт алдаж билээ... Энэ дээвэр дор иймэрхүү нууц хадгалагдаж байдаг юм даа. Хараалт урц чи хажуулдан нурж унаад энэ муухай нууцыг мэдэх бүхнийг дарж алагтун! гээд тэнгэр өөд ширтэв.

- Тэр нөхцсөн хүнээ үхсэний дараа нүгэлт золгүй амьтан чи яав даа гэж Седрикийг асуухад,

- Өөрөө гадрал, бүү асуу. Би цагаас өмнө хөгшрөн нүүр царай гундтал амьдарч байлаа. Тэгтэл хүн бүхэн намайг элэг барьж, доромжлох болсон. Тэгээд миний өшөө авалт хорсол шивэгчний аар саар хов будлиан, арчаагүй болсон эмгэний дэмий зүхэлт төдийхнээр

хязгаарлагдах боллоо гэв.

- Ульрика, хорт муу үйлийн үрээр эдлэж байсан тэр жаргалынхаа тухай чи сэтгэлийнхээ гүнд харамссан хэвээр байгаа юм шиг надад санагдана, тэгсэн атал чи энэ ариун хувцас өмссөн хүнтэй яаж ингэж ярилцаж зүрхлэнэ вэ? Эдуард гэгээн өөрөө энд биеэр морилж ирлээ гэхэд чамд ямар тус хүргэж чадах вэ? бодооч золгүй амьтан чи? гэвэл Ульрика дуу алдан:

- Сүрхий зэмлэгч гуай жаахан азна! Саяхнаас аван ганцаар байхад төрөх болсон аймаар шинэ сэтгэл юу гээч вэ хэлж өг. Яагаад улирсан зүйл нүдний өмнө босож ирээд дийлж давшгүй их аймшиг төрүүлнэ вэ? Хорвоо дээр бурхнаас өдий их нүгэл зовлон үзэх тавилантай төрсөн хүнийг хойт насанд нь юу хүлээж байна вэ? Би өдөр шөнөгүй тарчлах аймшигт хий үзэгдэлтэй зууралдаж байснаас загалмай зүүгээгүй байсан өвөг дээдсийнхээ шүтээнд залбирвал дээргүй болов уу? гэж асуулаа.

Седрик бүсгүйгээс зэвүүцэн зайлж, - Би хувраг хүн биш, лам хувцастай авч би хувраг хүн биш гэлээ.

- Гэлэн ч бай хар ч хүн бай хамаагүй. Сүүлийн хорин жилийн дотор би хүнийг хүндэлж бурхнаас эмээх хэнтэй ч уулзсангүй. Аврал олох арга үнэхээр үгүй гэж үү хэлж өгөөч гэж Ульрика гуйвал Седрик өөдөөс нь:

- Миний бодоход чи гэмших цаг болжээ. Залбирал үйлдэж сайтар наминчил, бурхан чамд өршөөл нигүүслэл хайрлах болтугай. Би харин чамтай ингээд байж болохгүй, хүсэх ч үгүй байна гэв.

- Дахиад ганц хувь хүлээнэ. Миний эцгийн найзын хүү одоо намайг бүү орхи. Эсвэл миний амьдралыг залж яваа муу шулам чиний ийнхүү хатуу сэтгэлээр жигшиж үзсэний хариуг авах хорхой хүргэж мэдэх юм. Саксоны Седрикийг өөрийнхөө цайзанд ийм хувцастай байхыг нь Фрон де Беф танивал чи удаан амьд явна байх гэж санаж байна уу? Тэр чинь тэртэй тэргүй чам руу ан үзсэн шонхор шиг хялалзаж байгаа шүү дээ гэв.

- Яах вэ тэгэг. Хушуу савраараа намайг тасар татаг! Тэглээ ч гэсэн миний амнаас ганц ч худал үг гарахгүй. Үнэн үгтэй, ил шударга үйлтэй саксон хүн хэвээр үлдэнэ. Зайл надаас надад бүү гар хүр, намайг битгий саатуул. Фрон де Беф хүртэл завхай, адгийн амьтан чамаас илүү сэжиглэмээр гутамшиг санагдахгүй байна гэв.

- Ульрика үүнд, - За чинийхээр болог. Замаараа од, ихэмсэг аашлан өмнө чинь байгаа эмгэн, эцгийн чинь анд нөхрийн охин гэдгийг март. Өөрийнхөө замаар яв. Би ганцаар үлдэнэ. Гэхдээ өшөө авах нь миний хувийн хэрэг шүү. Хэн ч надад тус болохгүй, харин миний зүрхэлсэн хэргийн тухай хүн бүхэн сонсох болно. Баяртай! Чиний ийнхүү жигшин үзсэн чинь хорвоо ертөнцтэй уралдсан миний эцсийн холбоог тасаллаа. Миний үзсэн зовлон нэгэн овгийнхонд маань өрөвдөх сэтгэл төрүүлэх болов уу гэж би горилж байсан юм шүү дээ гэв.

Седрик бүсгүйн үгэнд сэтгэл уярч:

- Ульрика, энэ насандаа тун их юм үзэж дааж өнгөрүүлжээ. Нүд чинь нээгдэж, нүгэлт үйлээ

ухаараад гол ажил чинь гэмшин наминчлах болсон үед тэгээд цөхрөн цухалдах гэж үү дээ? гэвэл Ульрика хариуд нь,

Седрик чи хүний зүрх сэтгэлийг муу мэдэж байна. Миний амьдарсан шигээр амьд явахын тулд өшөө авах, цэнгэх цаглашгүй их шуналд сэтгэл нь автсан байх учиртай юм. Энэ чинь хүний сэтгэлд асар муу хор нөлөөтэй, орхих хүч үл хүрэх ундаан гэсэн үш. Хөгшин нас, цэнгэл өгөхгүй үрчгэр царай хүний сэтгэл татахаа болиод өшөө хорсол хий хоосон хараал зүхэл болж жижигрэн улирах ажээ. Тэгэхийн цагт гэмших сэтгэлийн зовлон ирж өнгөрснөө дэмий харамсан ирээдүйд итгэл тасрах юм байна. Гэвч энд гэмшиж суух газар үгүй... Харин чиний үг надад шинэ сэтгэл төрүүллээ.

- Үхлээс үл эмээх хүн юу ч хийхээс буцахгүй, чи үнэн үг хэллээ. Чи надад өшөөгөө авах замыг зааж өглөө, түүнийг би ашиглана гэдэгт чи үнэмшиж болно. Өнөө хүртэл хатаж хоцорсон цээжин дотор өшөө хорслоос гадна бас өөр шунал тачъяал өрсөлдөн байсан нь одоо ганц л өшөө авах нь зонхилов. Ульрикийн амьдрал ямар байсан ч гэсэн өндөр төрөлт Торкилийн охин гэгдсээр үхлээ гэж чи өөрөө сүүлд хэлэх вий. Энэ хараалт цайзны хэрмийн өмнө дайчдын баг цуглараад байна. Очиж тэднийг бушуухан дагуулан дайр. Цайзны дорнот булангийн цамхаг дээр улаан дарцаг харагдахын хамт зоригтой давшлаарай, тэдний сумыг үл харгалзан дайрч ирж болно. Юу гэвэл нормануудад цайзны дотор ажил бишгүй гарах болно.

Явж үз гуйя. Өөрийнхөө оногдол үүргийг биелүүл, би хувь тавилантайгаа больё гэв.

Ульрикийн төлөвлөгөөний тухай Седрик нарийвчлан асуумаар байсан авч энэ үеэр Реджинальд Фрон де Бефийн ширүүн дуу гарч,

- Нөгөө ажил мэдэхгүй муу гэлэн хаашаа алга болчихов? Миний зарц нарын сэтгэлийг урвуулах гэж оролдвол тарчлааж тавина гэдгийг бурхны нэрээр андгайлъя! гэх нь дуулдав.

- Цэвдэг сэтгэл тун айхавтар шиншээч байх юм даа! гэж Ульрика дуугараад, - Чи харин түүнийг бүү хайхар, бушуухан өөрсдийнхөн дээрээ оч. Саксончуудын дайчин уриаг дуусга, тэд дайчин дуугаа дуулаг. Миний өшөө авалт түүнд түрлэг болно гэв.

Ийнхүү хэлээд хажуугийн хаалгаар гартал Фрон де Беф өрөөнд орж ирлээ. Седрик биеэ албадан байж хүлцэнгүйгээр бардам зант бээлийг мэхийн хүндэтгэхэд цаадах нь хайш хэрэг хариу толгой дохиод,

- Гэмээ наминчилсан нүгэлтнүүд багш таныг тун удаан саатуулах шив? Гэхдээ тэдэнд энэ нь дээр. Энэ чинь тэдний сүүлчийн наминчлал болно. Хорвоог орхиход сэтгэл санааг нь шулуутгаж өгнө үү? гэхэд Седрик франц хэлээр чадан ядан ярихыг хичээж,

- Хэний гарт орсноо мэдэж байгаа болохоор хамгийн муу юм болно гэж тэд хүлээж байгаа ажээ гэхэд,

- Гэлэн энэ чинь юу гэсэн үг вэ? Чиний яриа саксон дуудлага руу ойртоод байх чинь? гэж Фрон де Беф хэллээ.

- Бёртон дахь Витольд гэгээний хийдэд би суусан хүн гэж Седрик хариулахад,

- Тийм бий. Чи уул нь норман хүн байсан бол дээр байхсан. Өөр элч байхгүй хойно яая гэх вэ? Бёртон дахь тэр Витольдийн хийд чинь ёстой хэдгэний үүр байгаа юм. Суурийг нь хүртэл тоног цаг аль эрт болоод байгаа юм. Мөдхөн хуяг, жанчны алин нь ч саксон хүнийг аварч чадахгүй цаг мөд ирнэ гэж бээл дуугарав.

Седрик уураа барьж чадсандаа чичирхийлсэн дуугаар, - Бурхан тааллаар болтугай гэхэд Фрон де Беф үүнийг айсны шинж гэж тооцов.

- Чиний сүнс чинь зайлж, манай цэргүүд манж цавны чинь өрөөнд дайраад орчихсон, танай зоорин дотор туйлж байх шиг чамд санагдаад явчих шив. Өнөөдөр надад нэг тус үзүүл, тэгвэл бусадтай чинь юу боллоо ч гэсэн чи дун дотроо орсон хясаа аятай аюулгүй тайван амьдарч болно гэлээ.

Седрик догдолсон сэтгэлээ барин, - Тушааж хайрла! гэв.

- За тэгвэл миний хойноос яв би чамайг хажуугийн хаалгаар гаргаж өгье гээд Фрон де Беф урагш том томоор алхах зуур араасаа яваа хуурамч ламд хэрхэн тухай заавар өгөв.

- Миний Торкильстон цайзыг бүслэж зүрхэлсэн энэ саксоны сүрэг гахайнуудыг гэлэн чи харж байгаа биз? Тэдэнд энэ бэхлэлтийн баг бэх бишийн тухай юм уу, ер нь аргалж байгаад дахин нэг өдөр шөнө хоёр эндээ хүлээж зогсох болгохоор юу дуртайгаа ярь. Тэр зуур чи энэ захидлыг хүргэж өгв. Алив байз чи бичиг уншиж чадах уу? гэхэд нь Седрик,

- Огт үгүй. Би судраа л уншиж чадна, тэгэхдээ дарь эх болоод Витольд гэгээний авралаар бурхны номоо цээжилсэндээ тэр шүү гэв.

- Тэр тусмаа сайн. За энэ захидлыг Филипп де Мальвуазений цайзанд хүргэж өг. Намайг өгүүллээ, сүмийн хорооны баатар Бриан де Буагильбер бичсэн, үүнийг Йорк руу аль болох түргэн хүргүүлнэ үү гэж намайг гуйлаа гээрэй. Гэхдээ бидний хувь заяаны тухай онц битгий санаа зов гэж түүнд хэлээрэй. Бидний морин туурайн чимээг дуулмагцаа зугтааж зайлдаг бүлэг новшнуудаас нуугдаж суухад хүрнэ гэдэг бодохоос ичгүүртэй юм. Манай холбоотныг амжиж иртэл энэ хогуудыг байранд нь байлгаж байх арга бодож ол гэж чамд хэлж байна шүү. Миний өш ч сэтгэл хөдөлж орхилоо, тэр чинь ан олзонд цадахаасаа нааш амардаггүй шонхор байгаа юм гэв.

- Ивээгч гэгээд, Англид байгаа таалал төгссөн бүх гэгээн хуврагуудыг барьж андгайлахад таны тушаалыг гүйцэтгэнэ! Миний нөлөө тэднийг барьж байж хүч хүрэх юм болж гэм энэ хэрэмний эндээс ганц ч саксон хүн зайлахгүй гэж Седрик хүлцэнгүй гэлэнгээс гармааргүй шийдмэг дуугарав. Фрон де Беф үүнд,

- Үгүй ер чиний дууны өнгө өөр болж саксоны сүргийг хүйс тэмтрэх гэж бүхэл сэтгэлээсээ хүсэх аятай даруй сэргээд явчихлаа, гэтэл энэ гахайнууд чиний нэг овгийнх шүү дээ? гэв.

Седрик хуурамч царай үзүүлэхдээ сурмаг биш болохоор зохих хариу хэлж өгч лав чадах

байсан Вамбаг дэргэдээ үгүйд үнэхээр харамсав. Гэвч хэрэгцээ гэдэг ухааныг нарийсгах тул хүмүүс хулгай үйлдвэл сүм хийд тэднийг шашны ивээлээс гаргаж, төр хээлийн гадна гаргадаг билээ гэж дуугарав. Фрон де Беф үүнд, - Бурхныг барьж андгайлахад чи мөш үнэн үг хэллээ. Энэ муусайн шаарууд францын дээрэмчидтэй адил тарган лам нарыг нүцгэртэл нь тоноод тавьчихаж чаддагийг би мартаж орхиж Сент-Ивск хийдийн ширээтийг барьж аваад царсанд хүлж мөргөл дуудуулах зуураа хармаа, хайрцаг савыг нь ухдаг чинь эд байхаа? Үгүй юм байна. Манай нөхдийн нэг Миддальтоны Готье тэгж дүрсгүйтсэн юм байна, ариун дагина минь. Харин Сент-Бийг талж цөгц, тахилын сав тэргүүтнийг нь аваад явчихдаг чинь саксончууд байсан нь үнэн байхаа? гэхэд,

- Тэд бурхан шүтээнээ умартагсад байсан юм гэж Седрик хариулав.

- Тэгээд бас танайхны сэм найрлахаар төхөөрсөн дарс пиво байсныг уучихсан гэдэг. Ингэхэд бурхан шүтээнийг ийнхүү гутаасны өшөөг авах нь чиний үүрэг гэлээ.

- Би өшөө авахаар андгай тавьсан бөгөөд миний тийнхүү андгайлсны гэрч бол Витольд бүлгээ гэж Седрик дуугарав. Энэ зуур Фрон де Беф түүнийг явган хаалгаар гарган ганц банз дээгүүр нь тавьсан шуудуу руу аваачлаа. Шудуугаар гараад гадаа хашааны нэг жижиг тавцан дээр очвол цаашаа газар доогуур тал руу гарах нүхтэй ажээ.

- За одоо бушуухан яв. Зөвхөн миний даалгасныг биелүүл, тэгвэл энд саксончуудын мах Шеффилдийн бойны газарт гахайн мах хямд байдаг шиг л сул болох бий, чи үзнээ. Ингэхэд чи зэгсэн наргианч гэлэн бололтой, нядалгааны дараа хүрч ирээрэй, танай хийдийнхнийг цөм унагааж хүрэхээр их сайн дарс тавинаа чамд гэхэд,

- Бид мэдээжээр дахиж уулзана гэж Седрик хариулав.

Бүр гарах үүдэнд хүрмэгц норман алтан зоос Седрикийн гарт атгуулаад, - Одоохондоо үүнийг ав, харин миний даалгасныг биелүүлэхгүй бол чиний арьсыг жанчтай чинь хамт хуулах болно гэдгийг санаж яваарай гэлээ.

Седрик газар доорхи гудмаас гарч, сэргэлэн талаар баяртай алхах зуур, - Та аль алиныг нь хуулаарай гэмгүй. Дахиад бид хоёр уулзахдаа илүү дээд хишиг хүртэж чадахааргүй байвал намайг цаазлаж болно гэв.

Тэгээд цайзны зүг эргэж алтан зоосыг чулуудаад,

- Итгэл эвдэгч муу норман чи мөнгөтэйгээ хамт тонил! гэв. Фрон де Беф энэ үгийг сонссонгүй, харин дагалдсан хөдөлгөөнийг хараад сэжигтэй мэт үүнд санагджээ.

Гадаад цамхагийн дэргэд байсан харуулд хандаж, - Алив харваачид тэр гэлэнгийн хойноос нэг сум явуулж орхи! гэж хашгирснаа үгүй боль доо гэж тэдний нумаа тэлэхийг харж өгүүлээд, - Харвах хэрэггүй. Өөр элч байхгүй хойно үүнд л итгэхээс биш. Тэр арай намайг хуурч зүрхлэхгүй байх. Тун ядвал манайд гинжтэй сууж байгаа саксон нөхөдтэй гэрээ хийхэд хүрнэ. Хөөе, хуягууд Ротервудийн Седрик, түүний анд Конингсбургийн ... хэн билээ нэр нь Ательстан билүү тэр хоёрыг над авч ир гэж тушаа. Эд нар норман баатрын хэлэхэд хэцүү,

сүүлдээ гахайн махны алт аманд үлдээсэн хачин нэртэй улс шүү. Наргианч хаан хүү Жоны хэлдэгчлэн энэ нэрсийг хэлсний дараа ам зайлчих дарс аль. Дор зэвсгийн өрөөнд дарс авч ир. Олзлогдогсдыг ч мөн тийш нь оруул гэлээ.

Тушаал даруй биелэгдэв. Өөрөө болоод, эцэг нь олж авсан элдэв олон зэр зэвсэг өлгөсөн танхимд Фрон де Бефийг ороход олзны хоёр саксон тэнд байж байлаа. Бахим царсан ширээн дээр дарс тавиастан харагдана. Фрон де Беф эхэлж дарс томоор балгаад дараа нь олзныхон руу эргэв.

Вамба малгайгаа нүдээ хүртэл дарж, шинэ хувцас өмссөн, танхимд сүүмгэнэсэн бүдэг гэрэлтэй байсан болохоор олзны гол хүн нь үгүй байсныг догшин бээл ажсангүй.

- За саксоны зоригтонгууд Торкильстонд зочлох ямар шүү санагдаж байна. Анжуугийн удмын хаан хүүгийн найрсаг дайллагыг үл ойшоох гэдэг юу болохыг одоо та нар ойлгов уу? Манай цагийг эзэлсэн хаан хүүгийн элэгсэг дотноор хүлээн авсныг яаж хариулснаа санаж байна уу? Золиосондоо зэгсэн юм өгөхгүй бол та нарт би яг энэ цонхны төмөр сараалжнаас хөлөөр чинь дүүжлэнэ гэдгийг бурхан, гэгээн Денисыг барьж андгайлъя. Та нар тэгээд элээ хэрээнд тоншуулж араг яс болтлоо тэнд дүүжлээстэй байх болно... Өөдгүй хар амиа аварч гарахын тулд олигтой юм өгөх үү, хэлцгээ саксон нохдууд? гэж Фрон де Бефийг асуухад хөөрхий Вамба өөдөөс нь,

- Би л сохор зоос ч өгөхгүй. Намайг хөлнөөс минь дүүжлэхээр таны амалж байгаагийн хувьд гэвэл муу ч үгүй юм биш үү. Надад салбадай овоодой өмсүүлсэн цагаас хойш миний тархийг уруугаа харчихсан гэлцдэг, тэгээд миний толгойг уруу харуулаад дүүжилж орхивол тархи минь дахиад байрандаа орж мэдэх юм даа гэв.

- Гэгээн Женевьева дагина минь, энэ хэн надтай яриад байна вэ? гэж Фрон де Беф дуу алдаад салбадайн толгой дээрээс Седрикийн малгайг алгадан унагаах зуур боолын ёозгүй тэмдэг мөнгөн хүзүүвч хүзүүнд нь байхыг харав.

- Жиль! Климент! Адгийн муу нохдууд! Юун хүн над дээр авч ирэв ээ? гэж норманы уур шатан хашгирлаа.

Дөнгөж сая өрөөнд орж ирсэн де Брас,

- Үүнд чинь чи янз нь хариулж чадах бололтой. Наадах чинь Йоркийн Исаактай эрүүл тулалдааны газарт эрэлхэгээр үзэлцсэн Седрикийн тулалдааны нөгөө хөгтэй тэнэг л байна гэхэд,

- За их сайн, үүний эзэн, Конингсбургийн энэ агт гахай хоёр амиа өндөр үнээр золиолж авахгүй болж гэм нэг газраас дүүжлэнэ, хамт дүүжигнэж байна биз яахав. Гэхдээ ганцхан золиос төлснөөр надаас мултрахгүй, цайзыг бүслэж байгаа бүлэг тэнүүлчдийг дагуулж одно гэж амлаг, өөрсдийнхөө чөлөөт эр ямбаа эвдэж бидний албат болно гэж гарын үсэг зураг. Мөдхөн ирэх улс орны шинэ байдалд эд нарт амьсгаалах эрх бид үлдээвэл өөрсдийгөө их азтайд тооцог, гээд хоёр зарцдаа, - Яв, жинхэнэ Седрикийг нааш нь авч ир. Энэ удаа би та нарыг шийтгэхээ болилоо. Юу гэвэл, саксон тайжийг энгийн муу тэнэгээс ялгахад нээрээ ч

бэрхтэй гэв.

- Гэвч эрхэм дээд баатар эр, бидний дунд саксон тайжаасаа олон тэнэгүүд, энд үлдсэнийг төдөлгүй мэдэх болно гэж Вамбаг өгүүлэхэд,

- Энэ залихай юу гэж чалчаад байна? гэж Фрон де Беф хэлээд зарц нар руу харахад тэд дороо хавьчин байж Седрик энэ л биш болж гэм хаашаа алга болчихсоныг мэдэхгүй гэж хулчийсхийн өгүүлэв.

- Бурхан өршөө! гэж де Браси дуу алдаад, - Тэр чинь лам хувцас өмсөөд оргочихсон байж таарлаа шүү! гэхэд,

- Ямар чөтгөр вэ? гэж Фрон де Беф хашгираад, - Ротервудийн агт гахайг би өөрөө хаалга хүртэл үдэж, цайзнаас өөрийнхөө гараар гаргаж өгсөн байх нээ? гээд Вамба руу эргэн, - Тэнэгээрээ өөрөөсөө долоон дор маанагуудыг мэхэлж чадсан чамд би гэлэн сахил хүртүүлнэ дээ! Зулайгий чинь бүх ёс гуримын дагуу хусаж өг гэж тушаана. Алив цаана чинь хэн байна? Дагзны нь арьсыг хуулаад цамхаг дээрээс хэрэмний гадаа гаргаад хаячих! ... Салбадай чиний цаашид яаж алиалахыг үзнэ дээ гэлээ.

- Яая гэх вэ, дээд төрөлт баатар таны үйл хэрэг үгнээсээ дээр юм гэж хөөрхий Вамба үхэхийнхөө өмнө хүртэл сурсан зангаараа хошигнон гонгонож, - Та үнэхээр намайг улаан малгайгаар мялаах юм болж гэм би жирийн нэг гэлэнгээс хамбын мяндаг хүртэх нь байна шүү дээ гэв.

Де Брас үүнд, - Хөөрхий амьтан, энэ чинь эцсээ хүртэл мэргэжилдээ үнэнч байхаар шийдэж шүү. Фрон де Беф та үүнийг бүү цаазал, надад бэлэглэж орхи. Миний чөлөөт багийг зугаацуулж байг. Зальхай амьтан чи үүнийг юу гэж бодож байна? Чи жаал зориг орж, надтай цуг дайнд мордоход зөвшөөрөх үү? гэхэд,

- Болноо, гагцхүү эзнээсээ асуулгүй болохгүй, харж байгаа биз дээ гэж Вамба хүзүүвч рүүгээ заан, - Энэ зүйлийг би түүний зөвшөөрөлгүйгээр авч болохгүй гэв.

- Өө Норман саксон хүзүүвчийг дор нь тас хуурайдана гэж де Брасийг хэлэхэд Вамба тосож аваад,

- Тэгэлгүй яахав өршөөлт эрхмээ. Үүнээс ч үндэслэж манайханд:

Англи царсыг норман хөрөөдөв

Англи орныг тэд боолчлов.

Орон нутгийн маань эзэн сууж

Одоо английн шөл амтлах болно

Балагт норман эзэрхэнбайх цагт

Баяр цэнгэл англи хүнд үгүй.

гэдэг үг явдаг билээ гэв.

Фрон де Беф үүнд, - Чи бас хачин хүн юмаа де Браси, бидэнд ноцтой аюул тулгараад байхад тэнэг яриа чагнан зугаацаж байх гэж! Биднийг залилчихсаныг үзэхгүй байна уу? Чиний найзархаад байгаа салбадайн ачаар бид холбоотондоо хэл дуулгаж чадсангүй. Тэднийг одоо даруй дайрахаас өөр юуг бид хүлээж болохтой байна вэ гэхэд,

- Тэгвэл харвах нүх рүү очъё. Тулалдааны өмнө намайг баргар царайлж байхыг чи хэзээ үзсэн юм бэ? Сүмийн хорооны баатрыг дууд хийдийнхээ алдар нэрийн төлөө тулалдаж байсныхаа тал хувийн төдий ч билээ эрэлхэгээр амь насаа хамгаалдаг. Чи өөрөө ч мөн хэрмэн дээр гар. Чамд баталж хэлэхэд саксоны дээрэмчид Торкельстон цайзны хэрмэн дээр гарна гэдэг үүлэн дээр хөөрөх гэж санасантай адилхан. Дээрэмчидтэй хэлэлцээ хийх нь дээр гэж бодож байгаа бол энэ шилтэй дарс гүнээ шохоорхон суугаа хүндэт саксон тайжийг дундын шугамаар ашиглахад яадаг юм? гэж де Браси хэлээд Ательстан руу эргэн аягатай дарс барьж, - Энэ нандин ундаагаар хоолойгоо чийглэж зориг ороод суллагдахын золиосонд юу амлахаа бидэнд хэлж орхи гэвэл Ательстан хариуд нь,

- Нэр төр эр зоригт үл харшлах замаар бол төлж дийлэх юмаа өгнө. Хамт зам яваа бүх хүмүүстэй цуг намайг тавьж орхи мянган маркийн золиос өгье гэв.

- Дээр нь цайзыг тойрон бөөгнөрч бурхны болоод хааны төрийн амгалан тайвныг алдагдуулж байгаа энэ новшнуудыг даруй зайлуулахыг бидний өмнө хариуцах уу? гэж Фрон де Беф асуувал,

- Чадлынхаа хирээр хичээнэ. Тэднийг холдуулах гэж мэрийе миний нэрлэсэн эцэг Седрик үүнд тус болох байж гэж найдаж байна гэж Ательстан хариуллаа.

- За тэгвэл энэ хэрэг тохирлоо. Чамайг хамт яваа хүмүүстэй чинь бид найртайгаар тавьж явуулъя. Чи хүний төлөө бидэнд мянган марк төлнө дөө. Төдий их мөнгө биш та нарын оронд өдий ялихгүй юм авахыг зөвшөөрсөнд саксон баатар чи бидэнд баярлах учиртай: - Харин энэ яриа еврей Исаакад хамаарахгүй шүү гэж Фрон де Беф хэллээ.

Энэ хэлэлцээрийн үеэр өрөөнд орж ирсэн сүмийн хорооны баатар, - Мөн охинд нь ялгаагүй гэхэд Фрон де Беф тосож аван,

- Үгүй тэд чинь ер нь саксоны хамт яваа улс биш шүү гэв.

- Тэд хэрэв бидний замын хань мөн байсан бол би өөрийгөө христос шашинтай хүн гэхээс ичихсэн билээ. Тэр бузар явдалтанг яах санж вэ өөрсдөө мэдтүгэй гэж Ательстан өгүүлэв.

- Золиосны тухай асуудал мөн Ровена авхайд үл хамаарна. Авхайн төлөө сайтар тулалдаж амжаагүй байж тийм сайхан олзноосоо татгалзсан гэж хэн ч намайг бүү хэлэг гэж де Браси хэлтэл, Фрон де Беф ярианд оролцон:

- Бидний хэлэлцээ энэ хараал идсэн салбадайд үл хамаарна. Би үүнийг гартаа үлдээж, надтай тоглох гэдэг хир байдгийг үзүүлэх санаа байна гэлээ.

Ательстан хариуд нь хэлбэрэлтгүй амгалангаар,

- Ровена авхай миний сүйт хүүхэн. Авхайг орхийг зөвшөөрсөнд орвол өөрийгөө тасар татуулсан нь дээр. Боол Вамба миний нэрэлсэн эцэг Седрикийн амийг аврахын тулд өөрийгөө золиосонд гаргасан юм. Иймд үүнийг өчүүхэн боловч муучлуулсанд орвол би өөрөө үхсэн нь дээр бизээ гэв.

- Чиний сүйт хүүхэн гэнээ? Ровена авхайг яам шиг дорд албатад өгөхөөр болсон юм гэж үү? гэж де Браси хэлээд, - Танай долоон хаанчлалын үе эргээд ирчихсэн юм гэж бодоогүй биз саксон чи! Анжу удмын хаан хүү ивээлдээ байгаа охидыг чам шиг ийм дорд язгуурын хүнд өгдөггүйг мэдэж ав гэвэл Ательстан хариуд нь:

- Сэхүүн зант норман минь, миний язгуур сурвалж чинийхээс аль эртний бөгөөд гутамшигт тугныхаа дор хулгайч, тэнүүлч бүхэл бүтэн багаар цуглуулан тэднийхээ цусыг худалдан амь зуугч нэг муу францыг бодвол цэвэр ариун бүлгээ. Миний өвөг дээдсийн дайн тулалдаанд эрэлхэг, ажил үйл зөвлөхдөө мэргэн, өдөр бүр ширээндээ чиний дагуулж явдгаас олон хүн суулган дайлдаг хаад байсан юм. Тэдний нэрийг ерөөлчид магтан дуулж хууль дүрмийг нь ахмадуудын зөвлөл баталж байжээ. Тэдний ясыг тавихад гэгээн хуврагууд ном хурааж, шарилан дээр нь суврага босгодог байсан билээ гэтэл, Фрон де Беф нөхрийнхээ ийнхүү таглуулсанд баярлан,

- За яав де Браси, дөнгөв үү чамайг? Саксон чамайг нилээд оноод хэлчих шив гэлээ.

- Тиймээ, олзлогдсон хүний онож хэлж чадах хирээр тэр шүү гэж де Браси үл тоомсорлосон дүр үзүүлэн өгүүлээд, - Хүлээтэй гартай хүн хэл амаа билүүдэхээс цаашгүй гээд Ательстан руу эргэн - Чи найз минь хэл амтай байлаа ч гэсэн Ровена хатагтай үүнээс болж илүү чөлөөтэй болохгүй дээ гэв.

Ательстан дөнгөж сая , үзэгдээгүй их урт үг хэлсэн тул үүнд хариу юу ч дуугарсангүй. Тэгтэл зарц ирж үүдэн дээр нэг гэлэн ирээд оруулна уу гэж гуйж байгааг дуулган яриа тасалдуулав.

- Энэ гуйлгачин хуврагуудыг ивээгч Беннет гэгээнийг бодон жинхэнэ гэл үү, зүсээ буруулсан мэхчин үү гэдгийг би мэдэх юмсан! Түүнийг нэгжиж үз боолчууд, та нарыг дахиад мэхэлчихсэн байх юм болж гэм нүдийг чинь ухаж аваад оронд нь халуун нүүрс хий гэж тушаана шүү гэж Фрон де Беф зандрав.

--Тэр ёстой гэлэн хүн биш байвал таны хилэн над дээр тустугай ноёнтон гэж Жиль хэлээд, - Таны дагуул Жослин түүнийг таниад Жорвогийн ширээт ламд үйлчлэгч Амвроси гэлэн мөн гэж баталж байна гэлээ.

- Оруул түүнийг гэж Фрон де Беф тушаагаад, - Лав наргианч эзэн нь бидэнд юм дуулгах гэж явуулсан биз. Лам нарын нэг чөлөөтэй тэнэж байгааг үзэхэд чөтгөрүүдийн баярт цуглаанд лам нар ажлаасаа түр чөлөөлөгдсөн байх нээ дээ. Олзны хүмүүсийг буцааж аваач. Саксон чи

Энэ дуулсан юмныхаа тухай сайн бодоорой гэв.

- Намайг хорихдоо хүндэтгэл үзүүлж, хоол унд, ор дэвсгэрийн талаар золиос төлүүлэх хүмүүсийг авч байх гуримын дагуу анхаарал тавихыг би шаардаж байна. Та нарын тэргүүлэгч гэж тооцогдож байгаа нэг чинь миний эрх чөлөөнд халдасныхаа төлөө биеэрээ хариуах болно. Би чамл гэрийн чинь даамлаар дамжуулан дуудлага илгээсэн. Тэгэхлээр миний юу шаардаж байгааг чи мэднэ, надад хариу өгөх учиртай. Май, миний бээлий энэ байна гэж Ательстаныг өгүүлэхэд Фрон де Беф өөдөөс нь,

- Би олзныхоо хүний тулалдах гэсэн дуудлагад хариу өгдөггүй. Морис де Браси чи мөн хариулах учиртай. Саксон тайжийн бээлийг тэр хананд байгаа бугын эврүүдийн нэгнээс өлгөчих. Эзэн нь суллагдах болтол тэнд өлгөөстэй байж байг. Гарсан хойноо бээлийгээ нэхэх юм уу, өөрийгөө ёс бусаар олзолж авсан гэх ахул, дайсныхаа өөдөөс очихоос хэзээ ч татгалзаж үзээгүй хүнтэй тулалдах болно гэдгийг христофор гэгээний бүсээр андгайल्या гэв.

Олзны саксончуудыг авч одсон даруй ихэд сандарч мэгдсэн Амвроси гэлэнг оруулав.

- Хуврагийн хажуугаар өнгөрөхдөө Вамба – Энэ чинь ёстой Рах vodiscum мөн байна. Бусад нь цөм хуурамч байсан гэв. Гэлэн цугларсан баатруудыг эрэгцүүлэн хараад – Гэгээн дарь эх минь арайхийж нэг аюулаас мултарч, жинхэнэ христос шашинтны дунд орж ирлээ гэхэд де Браси хариуд нь:

- Аюулаас мултарлаа гэдэг үнэн, харин жинхэнэ христос сүсэгтний хувьд гэвэл бүх еврей нарыг хараад үнэн голоосоо ой нь гутдаг хүчирхэг Реджинальд Фрон де Беф бээл энэ байна. Сарацинуудыг хайр найргүй хүйс тэмтрэгч, сүмийн хорооны Бриан де Буагильбер энэ байна. Эднийг муу христос шашинтан гэвэл өөр ямар улс чамд хэрэгтэйг бүү мэд гэв.

Де Брассийн хариултанд ёжлонгүй өнгө байсныг лам анзааралгүйгээр ,

--Манай шашин шүтлэгээр бидний лам багш болох Жорво хийдийн ширээт Эймерийн нөхөд холбоотон нь та нар билээ Христос шашинтан хүний нигүүлсэнгүй сэтгэл эр баатрын тавьсан андгай ёсоор түүнийг гайнаас гаргах та нарын үүрэг билээ. Юу гэвэл ариун явдалт августин хэлэхдээ ...гэтэл фрон де Бефүгийг нь таслан ,

--Наад дэмий үгийг чинь чөтгөр аваг чухам юу болсныг лам чи бушуухан хэлж орхи! Гэгээн багш нарын судраас иш татахыг дуулж суух зав бидэнд алга гэлээ.

- Бурхан минь гэж Амвроси гэлэн дуу алдаад, - Энэ нүгэлт харчууд юун амархан дүрэлзээд явчихдаг юм бэе? Зоригт баатрууд та нарт дуулгахад бурхан шашныг хүндэтгэн сүм хийдээс айж цагийг эзэлсэн их богд багшийн зарлигаас үл сүрдэх хэсэг нүглээ мартсан этгээдүүд... гэтэл Бриан хажуугаас нь:

--Багштан та сонсож бай. Наад бүх хэлэх гээд байгаа зүйлийг чинь бид мэднэ. Эсвэл урьдаас гадарлана, танай эзэн юу болоов, олзлогдоогүй биз, хэнд тэр вэ гэдгийг бушуухан хэл гэвэл Амвроси гэлэн,

- Тэгэлгүй яахав ширээт одоо чөтгөрүүдийн албагуудын гарт ороод байна. Тэд эндхийн ой модоор дүүрэн юм. Тэгээд сударт "миний шавь нар хуврагуудад бүү хүр алив гай түйтгэрбүү учруул "гэж бичсэнийг сонсох ч дургүй байна гэв.

--За эрхмүүдээ билний илдэнд шинэ ажил нэмэгдэх нь энэ гэж Фрон де Беф өгүүлээд, - Ингэхэд бидэнд туслах хүмүүс ирүүлэхийн оронд ширээт Эймер биднээс тусламж горилж байдаг юм. Танай эзэн тэгээд биднээс чухам юу хүсэж байгааг гэлэн чи ойлгогдохоор хэлээд өгөөч гэв.

- Сонсож хайрла, манай эрхэм дээд багш ламтныг тэр чөтгөрийн улбаатнууд балмадаар хүчирхийлэн барьж аваад бүх ачаа барааг нь талж хоёр зуун цэвэр алтан зоосыг нь дээрэмдсэний эцэст бас илүү их мөнгө шаардаж байна. Тэргүйгээр багшийг бузар савраасаа тавихыг тэд зөвшөөрөхгүй байна. Манай дээд багштан та бүхэнд найз нөхөддөө хандаж уул шаардаж байгаа золиос мөнгийг төлж өгөх юм уу түүнийг зэвсгийн хүчээр дайснаас булааж авна уу гж гуйж байна гэв

- Танай тэр ширээтийг чөтгөр алгадаасай! гэж Фрон де Беф уурлан,

- Тэр өнөөдөр өлөн элгээрээ хэт их юм балгачихсан байж таарна. Биднээс арав дахин илүү их мөнгөтэйг нь хэн бүхэн мэдсээр байтал аль нэг хувраг хүний төлөө норманы бээл түрийвчээ хоослоно гэж хэзээ байсан юм бэ? Биднийг бөөн дайсан бүсэлж орхиод юу юугүй дайрахыг нь хүлээж байхад түүнийг зэвсгийн хүчээр суллах гэж бид юу хийх юм бэ? гэхэд гэлэн өөдөөс нь:

- Би энэ тухай танд дуулгах гэтэл та тун их яараад үл хэлэх завдал өгөхгүй юм. Бурхан өршөө, би нэгэнт нас дээр гарчээ. Тэр бурхан шашинд харш тэнэгүүд бүр ч мангууруулж орхилоо. Тэд цайзыг бүсэлж аваад хэрэм рүү ойртож байна гэлээ.

- За тэгвэл хэрмэн дээр гаръя. Тэр новшнуудын юу хийж байгааг харъя гэж де Браси дуу алдав.

Хэрэмний дээд тавцангуудын нэг рүү харсан сараалжин цонхыг нээгээд тэндээсээ даруй танхимд үлдсэн улсад,

--Гэгээн Денисыг барьж андгайлахад хөгшин гэлэнгийн үг үнэн байна? Тэд том халх өргөж явна, ойн цоорхойд байгаа харваачид нь үер буулгах үүл шиг бараантаж байна гэж хашгирав.

Реджинальд фрон де Беф мөн тал руу хараад эврээ авч чангаар бүрээдсэн хүмүүст байр байраа эзлэхийг тушаалаа.

- Бусдаасаа нам хэрэмтэй өмнө талыг де Браси чи хамгаал. Сайн төрөлт Буагильбер та хамгаалах, давших ухаанд мэргэн хүн хойт хэрмийг дааж үз. Би өөрөө гадаа бэхлэлтэнд очиж зогсоно. Зоригт нөхөд минь ганцхан газар хамгаалах төдийгөөр бүү хязгаарлаарай гэж гуйя. Өнөөдөр бид газар газарт амжиж очих, хэн хэцүүдсэн хүнд туслах учиртай. Бид тоогоор цөөхөн авч эр зориг, самбаагаар энэ дутагдлыг нөхөж болно. Жирийн муусайн боолчуудтай үзэлцэж байгаагаа мүү мартаарай гэлээ.

- Сайн баатруудаа! гэж Амвроси гэлэн хөл үймээн дунд хашгиран, - Та бүхний хэн чинь ч хорвоогийн ширээт эрхэм дээд багш ламтан Эймерийн захисан үгийг дуулахгүй юм гэж үү? Сайн төрөлт Реджинальд гуй таныг гуйя. Миний үгийг дуул! гэв.

- Дуугүй бай! гэж догдолсон норман зандраад – Явж тэнгэрт залбиралаа унш, газар дээр бидэнд түүнийг чинь сонсох зав алга... Эй Ансельма, давирхай, тос буцалга гэж хэл. Энэ улайхдаа тулсан амьтдын толгой дээрээс асгана даа. Харваачдад ариухан сум өгөөрэй. Цамхаган дээр миний тугийг мандуул! Нөгөө бухын толгойтой хуучныг нь шүү. Хэнтэй үзэлцэх ёстойгоо муу шаарууд мөдхөн мэдэх болно гэв.

- Эрэлхэг ноётон би дуулгавартай байх тангараг өргөсөн хүн,

ширээтийнхээ даалгасныг биелүүлэх учиртай шүү дээ. Миний үгийг сонсож хайрла... гэж Амвроси гэлэн шалахад,

--Энэ чалчааг зайлуул! Гэж фрон де Беф хашгираад, - Үүнийг цамхагт хорьчих, тулалдаан дуустал эрхиэ эргүүлж сууг. Торкильстоны гэгээдэд мөргөл залбирал дуулах сонин байх биз. Тэдний чулуугаар сийлсэн цагаас хойш тэгж дахиж байсан удаа бараг үгүй болов уу гэвэл де Браси,

- Реджинальд гуай та гэгээдийг бүү доромжил энэ шааруудыг хөөж тараахаас өмнө тэдний туслалцаа бидэнд хэрэг болж болохтой гэв.

- Би харин тэднээс ямар ч тус горилохгүй байна шүү, харин авч ирээд хэрмэн дээрээс бүслэгчийн толгой руу унагаавал юу байгаа юм. Тэнд нэг их хүнд том, ганцаараа бүтэн баг дараад алчихаж чадахаар христороор гэгээн бий дээ гэж Фрон де Беф өгүүлэв.

Энэ зур дайсны хөдөлгөөнийг сүмийн хорооны баатар бүдүүлэг фрон де Беф, хөнгөмсөг де Браси хоёроос илүү их хянуураар ажиглаж байлаа.

-- Хорооныхоо нэрийг барьж андгайлахад энэ хүмүүс чинь эндээс гарна гэж санахын эрхгүй лут эмх замбараатай давшиж байна. Мод бут болгоныг хир чадамгай ашиглаж манай сумнаас яаж сүрхий нуугдаж байгааг нь хараач. Эдэнд туг таних тэмдэг харагдахгүй байгаа авч нэг баатар юм уу цэргийн эрдэмд сайн тайж хүн эднийг удирдаж байна гээд алтан гинжээрээ цохио хийхэд бэлэн байна гэв.

- Би тэр хүнийг харж байна. Баатар хүний дуулганы өд хуяг тэр гялалзаад байна. Хар хуягтай өндөр хүнийг харж байна уу? Зальхай йоменуудын тээр холын багийг удирдаж явна. Гэгээн Денисыг барьж андгайлахад бидний нөгөө залхуу хар гэж нэрлэсэн баатар мөн дөг шүү. Ашбийн эрүүл тулалдаан дээр энэ хүн чамайг эмээлээс чинь ховх цохисон шүү дээ, Фрон де Беф чи санаж байна уу? гэхэд фрон де Беф:

- Тэр тусмаа сайн, миний өшөөг тайлах гэж өөрөө нэхэж ирээ шив. Тэр лав нэг аймхай амьтан байж таарна. Тулалдааны талбар дээр үлдэж, тохиолдлоор оногдсон шагналаа авахаас айсан нь учиртай. Би түүнтэй тайж нар, жинхэнэ баатруудын дунд лав уулзаж чадахгүй байсан, тэгээд хогийн муусайн йоменчүүдийн дунд надтай тааралдаж байгаа нь маш баяртай

байна гэлээ.

Дайсан шийдмэгээр дайран орсон тул яриа үүгээр тасалдав. Баатар тус бүр цайзыг хамгаалахаар цуглуулж чадсан цөөн хүнээ дагуулан байр руугаа очиж тулж ирсэн дайралтыг тайван, батаар зогсон хүлээв.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Элэг баригдсан тэнэмэл овог

Эрдмийн чухгийг хадгалж байж

Эзгүй цөл ой мод, тэнгис далайгаас

Эрдэнэсийн нууцын санг олон чадаж

Энгийн нэг цэцэг өвөл хүртэл

Эдний гарт байхдаа ид шидийг олдог ажээ.

Марло "Мальтийн еврей"

Цаашдын яриаг ойлгоход уншигч авгайд эрх биш хэрэгтэй зарим зүйлийг дуулгахын тулд жаахан зүйл нөхөж дурдах учиртай боллоо. Талбай дээр хайхрах хүнгүй үлдсэн Айвенгог авч тэнхрүүлье гэж Ревекка эцгийгээ ятган яадаад Ашби хотын захад Исаакийн сууж байсан байшинд авч очсон байх нээ гэдгийг уншигч өөрөө лавтай гадарласан хэрэг.

Хэрэв өөр нөхцөлд бол Исаакийг ятгаж үүнийг зөвшөөрүүлэхэд ядах юмгүй, төрөлхийн зөөлөн сайн сэтгэлтэй хүний хүргэсэн ач тусыг мартаж чадахааргүй хүн ажээ.

- Шударга явдалт Авраам минь! гэж еврей дуу алдаад, - тэр сайн залуу, хатгамалтай хүрмээр нь цус шүүрэн хямд бишээр олдсон хуяган дээгүүр нь урсахыг хараад зүрх өвдөж байна. Харин түүнийг гэртээ аваачих гэдэг... чи юу ярьж байгаагаа сайн бодооч! Энэ чинь христос шашинтан хүн, манай хууль тэгэхэд биднийг буруу номтон өөр шүтлэгтэй зөвлөн наймаа арилжааны талаар л холбоотой байхыг зөвшөөрдөг шүү дээ гэвэл, Ревекка хариу марган:

- Тэгж битгий ярь хүндэт аав минь. Бид эдний тоглоом наргиан зугаа оролцох учиргүй нь үнэн боловч буруу номтон шархдаж, гайд учирвал тэрээр еврей хүнтэй ах болдог юм гэв.

- Энэ тухайд Йаков Тудель юу гэх байсныг би мэдэхгүй нь харамсалтай! Гэхдээ энэ сайн залуу үхлээ их цус алдах бий! Сиф Рубин хоёрыг дууд, үүнийг Ашби руу авч очиг гэж Исаак хэлэв.

- Үгүй түүнийг миний дамнуурган дээр тавиг, би өөрөө дан морь унаад харья гэж Ревекка хэлэхэд Исаак бөөгнөрсөн олон баатрууд, дагуулууд руу сэрдэх байртай харан:

--Тэгвэл энэ бузар нохдууд чам руу гөлийгөөд байх болно доо гэв.

Ревекка зарц нарт элдэв заавар өгөөд эцгийнхээ үгийг нэгэнт дуулахгүй болсон байлаа. Исаак гэнэт гарнаас нь шүүрч аван ихэд хэлмэгдсэн байртай,

- Шударга явдалт наран минь! Энэ залуу сэхэхгүй бол яах юм бэ? Манай гэрт байж байгаад үхвэл биднийг алсан гээд хүмүүс тасар татаж хаяна шүү дээ гэж шивнэлээ.

Ревекка ханцуйгаа эцгийнхээ гараас болгоомжтойгоор тавиулан, - Тэр үхэхгүй аав аа. Бид арчлаад авбал үхэхгүй, харин авахгүй бол үнэхээр хүмүүс болоод бурхны өмнө түүний амийг даах болно гэв.

- Урсаж байгаа цусыг нь харах надад тэсэхийн эрхгүй их шаналгаантай байна гэж Исаак дуугарад – Византийн Манассийн охин шударга явдалт Мирнам анагаах ухаан чамд зааж сургасан, эм тангын учир чиний эс андахыг би ямар мэдэхгүй байх уу даа. Тэгэхлээр дураараа бол. Миний охин сайн, надад өөрт минь, миний гэр оронд, Израилийн бүх хүн ардад баясгалант сайхан дуу бурхны ивээл болон заяасан хүн билээ гэв.

Гэхдээ Исаакийн болгоомжилдог дэмий бус байжээ. Ревеккагийн өгөөмөр сэтгэл гаргасан үйл Ашби руу буцах зам руу махчин араатан шиг авиртай Бриан де Буагильберийн анхаарлыг татжээ. Гоо сайхан еврей бүсгүйг хар нүдээ хужирлахын тулд сүмийн хорооны баатар хоёр дахин ч морио эргүүлэв.

Ревекка цаг алдалгүйгээр өвчтөнийг эцгийнхээ гарт оруулаад шархыг нь өөрийнхөө гараар угааж, боож өгөв. Тэр цагт анагаах ухааны нууцыг бүсгүйчүүл мэддэг, дайчдын зүрхийг сайхан нүдээрээ мөнхөд шархдуулдаг гоо бүсгүйчүүл шархдсан баатрыг асрах удаа олонтой байдаг байлаа.

Ялангуяа еврей эмнэлгийн арганд гойд сайн, хүнд шарх олох, өвчилсөн тухайдаа тэр цагийн хаад, хүчирхэг бээлүүд еврей нарыг гуйж анагаалгах нь цөөнгүй. Үнэхээр ч еврей эрдэмтэд эмнэлгийн талаар онцгой их эрдэмтэн, түүнийгээ асар нандигнан нууцаар нэг нь нөгөөдөө үе улиран үлдээдэг байсан байж болох юм.

Гоо сайхан Ревекка өөрийн овгийнхны сургаж өгч чадах бүхнийг ултай сайнаар сурчээ. Нэртэй еврей эмч нарын нэгний охин Мириам хэмээх хижээл бүсгүйгээр Ревекка анагаах ухааны мэдлэг болоод эмчлэх арга барилыг заалгажээ. Мириам Ревеккад төрсөн охин шигээ хайртай Мэргэн эцгээсээ уламжилж авсан бүх нууц эрдмийг Мириам Ревеккад зааж өгсөн гэж ярилцдаг. Мириам өөрөө тэр цагийн балар сүсгийн эрхшээлд автсан боловч эмчлэх хамаг нууцыг түүний авьяаслаг сурагч нь уламжилж авчээ.

Гоо сайхан төдийгүй гүн их мэдлэгтэй болохоор Ревеккаг нэгэн омгийнхон нь машид хүндлэн үзнэ. Хайртай сайн эцэг эх нь хүртэл охиндоо олон зүйл дээр тохирогдож, охиноо өөрийн овгийн ёс гуримнаас гадуур ихээхэн чөлөөтэй дураар байлгах бүлгээ.

Айвенгог цус их алдсаны улмаас Исаакийн гэрт авч ирэхэд ухаан ороогүй хэвээр байв. Ревекка шархыг нь үзэж, өөрийнхөө эмийг тавьж боосны дараа өвчин нь хүн халуурахааргүй, хөгшин Мириамын эм анагаах чадлаа алдаагүй л бол зочны амь насны төлөө онц айгаад байх зүйл үгүй маргааш ч гэсэн өөрсөдтэйгээ цуг Йорк руу явж чадна гэж эцэгтээ хэлэв. Ийм үг дуулаад Исаак баахан тулгамдав. Түүний өгөөмөр сэтгэл Ашбийгаас цааш гарахгүй ажээ. Өөрийнхөө буусан айлын еврей нарт шархдсан христос шажинт хүнийг дуртайяа захиж орхиод явах ажээ. Гэтэл Ревекка үүнийг эрс дургүйцэн хэд хэдэн ноцтой шалтгаан гаргаж, дурдав. Юуны өмнө нандин эмтэй шилээ бусдын гарт шилжүүлэхээс эрс татгалзав. Эмнэлгийн чухаг нууцыг задрааж мэднэ гэж болгоомжилжээ. Ричардын шадар хүн болохыг эцэгтээ сануулав. Англид Ричард хаан буцаж ирэх юм бол самуун дэгдээгч хаан хүүг мөнгөөр

тэтгэж байсан Исаакад өөрт нь хааны өмнө өмгөөлүүлэх нөлөөтэй хүн их хэрэг болох учиртай билээ.

Исаак бодолд автан байж – Ревекка чиний зөвөө. Ариун буянт Мириамын нууцыг задлах ахуул нүгэл болно. Арслан зүрхт Ричардын тухайд гэвэл дүүтэй нь миний сүлбэлдэж байсныг тэр мэдэх л юм болж гэм түүний гарт өртөснөөс зэрлэг арслангийн аманд орсон нь дээр. Иймд би чиний зөвлөлгөөг дагаж энэ залууг Йорк руу авч явъя. Шарх нь бүрэн эдгэртэл манай гэр үүний гэр болог. Тэгээд арслан зүрхт гэгчийг англид буцаж ирэхэд, тэр тухай цуу нэгэнт яваад байна. Хааны хилэнгээс намайг аврахад хадан хэрэм Уильфред Айвенго болно. Энэ чинь сайхан сэтгэлтэй залуу сайн хүн, тогтоосон хугацаагаа баримталж хүнээс зээлсэн юмаа эргүүлж өгдөг юм. Израил хүнд тус үзүүлдэг миний эцгийн хүү дээрэмчин, чөтгөрийн улбаатнуд дотор орчихоод байхад хамгаалж гаргасан билээ гэв.

Айвенго ухаан орж орчноо мэдрэхтэй болж ирэхэд үдэш нэгэнт болжээ. Өчигдөр өдрийн явдлыг нэг хэсэгтээ авцалдуулан бодох чадваргүй байлаа. Шарх нь өвдөж, ихэд тэнхээ алдрах ажээ. Жад сэлэмний цавчилтууд, хатуун ширүүн тулалдаан, дайралт санаанд үймэрч, дайчин уриа, зэр зэвсгийн хангинаан чихэнд дуулдана. Эцэстээ ихэд хүч гарган байж орынхоо хөшгийг ярав. Дорно дахины маягаар тансаг сайхан зассан өрөөнд байгаагаа үзэж ихэд гайхан утаж байх зуур эргээд Палестинид оччихсон юм шиг эхлээд санагдав.

Хүнд хөшиг сөхөгдөн дорнотын хийцтэй үнэт сайхан хувцас бүхий бүсгүй өрөөнд сэм орж ирэхэд энэ сэтгэгдэл бүр ч хүчтэй болов. Бүсгүйн араас бор царайтай зарц дагалджээ. Шархдсан баатар тэр гоо сайхан хий үзэгдэл шиг санагдах бүсгүйгээс юм асуух гэтэл зүүсэн бадмаараг нарийхан хуруугаа уруулдаа хүргэн дуугүй байхыг тушаав. Зарц ор руу ирж хучлагыг ярахад гоо сайхан еврей бүсгүй боолт байрандаа байгаа эсэх, шарх ямар шүү байгааг шалгаж үзлээ. Үүнийг бүсгүй ялдамхан энгийн даруугаар хийсэнд ёс гуримыг машид чандлан сахигч хэн боловч бүсгүй хүний чанарыг гутаасан зүйл ер олж чадахааргүй ажээ. Залуу сайхан хүүхэн эрэгтэй хүнийг асарч, шархыг нь өөрийнхөө гараар боож өгч байна гэдэг санаа хүртэл хүнд өвчтөн хүнд тусалж амийг нь аврахаар ирсэн боловч сайн хүний тухай ойлголтонд бүрмөсөн дарагдах ажээ. Өвчтөн асрахад байн байн хамжилцаж байсан хөгшин зарцад Ревекка хэд хэдэн янзын заавар өгсөнд шалмаг чадамгайгаар гүйцэтгэв.

Ревекка еврей хэлээр ярьсан бөгөөд үл мэдэх хэл ая тустай шидтэн бүсгүйн идтэй яриа мэт Айвенгод гойд сайхан сэтгэгдэл төрүүлэх ажээ. Сонсоход ойлгогдохгүй хэдий авч ярьж буй бүсгүйн уян дуу, дөлгөөн төв царай дуулж байгаа хүний зүрхийг уяруулан хөдөлгөх ажээ. Цаашид дахин асууж шалгаах гэлгүйгээр өөрт нь юу хийж өгөх хэрэгтэй гэсэн бүхнийг дуугүй дагахаар Айвенго шийдэв. Бүх эмчилгээ дуусаж, эмч нь болсон гоо бүсгүй явахаар завдахад сониучирхан сэтгэлээ барьж дийлэхгүй араб хэлээр бүсгүйд хандан:

- Эелдэг ааштай бүсгүй танаас гуйя. Та хичээж... гэж ам нээтэл гол төлөв бодлогошронгуй, гунигтай байдаг царай нь өөрийн эрхгүй инээмсэглэж түргэн гэрэлтэн залуугийн яриаг таслав. Айвенго Дорнот орнуудаар тэнүүчилж явахдаа араб хэл сурсан бөгөөд дорно зүгийн хувцас, тоорцогтой өмнө нь зогсож буй бүсгүйтэй энэ хэлээр ярих нь илүү тохирно гэж боджээ.

Бүсгүй өөдөөс нь эрхэм баатар, би Англид суудаг болохоороо хувцас хунар гарал үүслээр өөр

орных боловч англи хэлээр ярьдаг юм гэж хэллээ.

- Сайн төрөлт авхайтан та... гэж Айвенгог эхэлтэл Ревекка тосож аваад, - Эрхэм баатар, намайг сайн төрөлт гэж бүү өргөмжлөн дууд. Таны зарц бүсгүй чухамдаа саявтархан таа өөрөө өмөг түшиг үзүүлсэн нөгөө Йоркийн Исаакийн охин дорд еврей бүсгүй мөн болохыг идаруй мэдэж авсан нь дээр билээ. Ийм учраас Исаак түүний гэр орныхон танд аль чадахаараа анхаарал халамж тавьж асрах учиртай вь гэв.

Гоо Ревеккагийн үзэсгэлэн төгс царай цогтой нүдийг үнэнч баатар эхлээд ямар шүү сэтгэлтэйгээр ширтэж байсныг сайхан Ровшна мэдвэл таалах байсан уу, үгүй юу бү мэд. Ревеккагийн торгон цацаг мэт өргөн соромсог нүднийхээ галыг зөөлрүүлэн сүндэрлэх мэт болгосныг аль нэг яруу найрагч хүн бол лав милрэг модны саглагар мөчрийн цаана гялалзах үдшийн одтой зүйрлүүлэх байсан билээ. Айвенго харин еврей бүсгүйг түрийнхээрээ өргөмжлөн бодож эс чадахаар үнэн шүтлэгт католиг шашинтан хүн байжээ. Ревекка өөрөө үүнийг урьдаас гадарласан учраас эцгийнхээ нэрийг хэлэх гэж яарчээ. Гэхдээ Исаакийн гоо үзэсгэлэнт мэргэн ухаант охинд бүсгүй хүний сул зан бас байдаг л байлаа. Иймээс Айвенгогийн хүндэтгэн биширсэн, тэр ч байтугай энхрий дотно байсан зан маш түргэнээр хүйтэн хөндий, санамсаргүй тус үзүүлсэнд өнгөцдүү талархах сэтгэл болон хувирахыг үзээд бүсгүй гунигтай шүүрс алдав. Үнэндээ Айвенгогийн түрүүчийн харьцаанд ч гоо сайхан залуу хүн бүрийн зүггүй ёсоор биширдгээс илүү онц юм үзэгдээгүй боловч ганцхан үг шидийн тарина аятай хөөрхий Ревеккаг биширсэн баатрын сэтгэлийг асар хурднаар өөрчилсөнд гүнээ гомдмоор зүйл байлаа.

Жигшүүрт омгийн хүн төдийгөөр өөрийг нь үзэж байгааг харах хэдий хэцүү байсан авч өөрийн шашин шүтлэг, тэр цагийн нийт хүмүүсийн мухар сүсгийг дагадагт нь Айвенгог буруушаах санаа Ревеккад огт төрсөнгүй. Тэр ч байтугай гоо еврей бүсгүй баатрыг урьдын адил тэвчээртэй үнэнч сайнаар асран байлаа. Йорк руу яаралтай явалгүй болохгүй болсон Исаак өөрийг нь мөн авч яваад бүрмөсөн эдгэрч сайжиртал гэртээ байлгахаар шийдсэн тухай бүсгүй Айвенгод дуулгав. Айвенго ач тус болсон хүмүүстээ цаашид тээр болох дургүй байгаагаар шалтгаалан Айвенго энэ төлөвлөгөөг эрс эсэргүүцэв.

- Ашби юм уу ойр орчинд шархадсан нэг нутгийн хүнээ дахин зэр зэвсэг зүүж чадах болтол авч асрахыг зөвшөөрөх ямар нэг саксон тайж юм уу, адаглаад баян тариачин олдохгүй гэж үү? Намайг байлгахыг зөвшөөрөх саксоны хийд ойролцоо үшүй гэж үү? Адаглаад намайг Бёртонд хүргэж өгч болохгүй юу. Витольл гэгээний хийдийн ширээт манай төрлийн хүн надыг лав асрах бизээ гэж Айвенгог хэлэхэд Ревекка гунигтайгаар инээмсэглэн:

- Таны дурдсан газруудын адгийнх нь танд жигшүүрт еврей гэр орноос танд илүү тохиромжтой байх нь маргаангүй. Гэхдээ эрхэм баатар та эмчээсээ салах гэхгүй бол бидэнтэй цуг явах хэрэгтэй. Еврейчүүд хүн шархдуулах гэдэггүй боловч шарх эмчилж чаддагийг та мэднэ. Тэгээд ч манай гэр бүлд Саломан хааны үеэс уламжлан ирсэн эмнэлгийн зарим нууц хадгалагдан байдаг билээ. Тэр эмүүдийн нэгний анагаах чадлыг та биеэрээ туршиж үзсэн. Ямар ч буруу номтон эмч... уучлаарай, эрхэм баатар би эндүүрээд хэлчихлээ. Британын дөрвөн далай хоорондох нутагт нэг ч христос шашинт эмч таныг бүтэн сараас нааш хөл дээр чинь босгож хүч хүргэхгүй шүү гэвэл Айвенго тэсэж ядсан байдлаар,

- Чи бол хир хурдан босгож чадах вэ? гэж асуув.

- Миний заасныг тэсвэртэй, сайн биелүүлээд байвал найман өдрийн дараа болно гэж Ревекка хариуллаа.

- Ариун дагиныг нэрийг ийм газарт дурсах нүгэл биш ч түүнийг барьж андгайлахад би ч бусад баатрууд ч хэвтж байдаг цаг одоо биш билээ. Бүсгүй чи амласнаа гүйцэтгэвэл би чамайг шагнана. Хаа нэг газраас бүтэн дуулга мөнгөн зоос олж чамд өгнө гэвэл Ревекка хариуд нь:

- Би амласнаа гүйцэтгэнэ. Амласан мөнгөнийхээ оронд надад нэг том өршөөл үзүүлэхийг зөвшөөрвөл энэ цагаас аваад найм хоносны дараа та зэр зэвсгээ агсаж чадах болно гэв. Айвенго үүнд - Чиний хүслийг би гүйцэтгэж чадахтай байгаад чиний овгийн хүнд түүнийг хийж өгөх христос шашин баатрын нэр төрөнд харш бус аваас би баятай, дуртайяа биелүүлж өгнө гэв.

- За тэгвэл, еврей хүн, христос шашинтан, еврей нарыг адилаар төрүүлсэн их бурхны өршөөл ивээлээс өөр юу ч авахыг хүсэлгүйгээр христос шашинт хүнд сайн тус үзүүлж чадахтай байдагт л цаашид итгэж явна уу гэж ганцхан гуйх гэсэн билээ гэж Ревекка хэлэв.

- Үүнд миний эргэлздэг нүгэл байжээ гэж Айвенго хариулаад—Цаашид элдэв юм асууж, тээнэгэлзэлгүйгээр чиний эрдэм чадалд итгэн найм хоноод давтмал хуягаа өмсөх болов уу гэж хатуу найдлаа. Одоо харин сайн төрөлт саксон хүн Седрик түүний гэр бүлийнхний тухай мэдэж байгаа шинэ юм чамд үгүй биз, сайн эмч минь? Мөн нөгөө нэг гоо бүсгүй ... гээд Ровенагийн нэрийг еврейн гэрт дурсахаа төвдөхгүй байх мэттүгдчин:

- Эрүүл тулалдааны өдрийн хатан хаанаар сонгогдсон хүний тухай бас? гэв.

- Чухам гэвэл эрхэм баатар таны сонгож авсан бүсгүйн тухай юу, гэхдээ таны сонголтыг олноор эр зоригоос чинь багагүйгээр сайшаасан билээ гэж Ревекка дуугарав.

Ровенад сайн байдаг үнэн сэтгэлээ нуух гэж оролдоод улам тодоор илрүүлснийгээ мэдмэгц Айвенго хэдий их цус алдсан авч царай нь улайчихав.

Уг нь тэр бүсгүй биш, хан хүү Жоны тухай ярих гэсэн юм. Түүнээс гадна миний үнэнч сайн дагуул яасан, яагаад одоо миний дэргэд үгүй байгааг би мэдмээр байна гэж Айвенго хэлэв.

- Би харин эмчийн эрхээ ашиглан танд дуугүй байхыг тушаая. Та элдэв түгшүүртэй бодлоос салахыг хичээж үз. Харин би таны мэдэхсэн гэсэн зүйлийг дуулгахыг оролдоё. Хаан хүү Жон эндхийн баян чинээлэг гэгдэгч улсаас зэгсэн мөнгө үнэн худал овоор цуглуулж аваад тайж , баатар, хуврагуудаа дагуулан эрүүл тулалдааныг зогсоон яаралтайгаар Йорк руугаа буцсан. Ахынхаа хаан ширээг булааж эзлэх санаатай гэж улс ярих юм билээ гэж Ревеккаг хэлэхэд Айвенго дэвсгэр дээрээ өндийн:

- Англид ганц ч билээ үнэнч албат байгаа цагт Жон тэмцэлгүйгээр хаан сууж чадахгүй. Ричардын төлөө би хамгийн зоригт дайснуудтай нь тулалдах болно гэхэд Ревекка түүнд

аяархан хүрээд,

- Гэвч тэгж чадах болохын тулд та юуны өмнө миний үгийг дуулж, томоотой хэвтэх учиртай гэвэл,

- Үнэн, үнэн. Энэ үймээнт цагт болох хирээр томоотой хэвтэе... За тэгээд Седрик тэдний гэр бүлийнхэн юу болсон бэ? гэж Айвенго асуув.

- Тэдний гэрийн даамал дөнгөж сая манайд ирсэн. Седрикээс эцэг ноос авсан өртэй байсныг авахаар амьсгаадан гүйж ирсэн. Седрик, Конингсбургийн Ательстан хоёр хаан хүү Жоньхоос машинд хилэгнэн гарсан даруй гэртээ харихаар завдаж байгаа гэнэ гэдгийг тэр хүнээс дуулла гэвэл,

- Тэр найран дээр тэдэнтэй хамт ямар нэг бүсгүй байсан юм болов уу? гэж Уильфред асуусанд уул асуултыг нь Ревекка нилээд тодорхойгоор,

- Ровена авхай, хаан хүүгийн найран дээр очоогүй тэр гэрийн даамлын үгээр бол өмөг түшиг бологч хүнтэйгээ цуг Ротервуд руу явах гэж байгаа гэнэ. Таны үнэнч дагуул Гуртийн тухайд гэвэл... Гэтэл баатар өөдөөс нь:

- Уухай! гэж дуу алдаад, - Чи түүний нэрийг мэдэх юм уу? гэснээ тэр дороо - Үгүй очигдөрхөн тэр чамаас зуун алтан зоос авсан юм чинь мэдэхгүй ч яах вэ дээ гэлээ.

- Ревеккагийн царай ихэд улайн, - Тэр тухай битгий ярь! Сэтгэл зүрх даран өнгөрүүлэхийг илүүтэйд үзэх нууцыг хэл амархан илчилдгийг би өөрөө үзэж байна гэлээ.

- Тэр мөнгөний тухайд гэвэл би нэр төрөө бодон түүнийг эцэгт чинь эргүүлж өгөх учиртай гэж Айвенго төвөөр өгүүлэхэд,

- Та тааллаараа бологтун, харин найман өдөр өнгөрөхийг хүлээ, түүнээс нааш биеэ сайжрахад саад болмоор аль юмны тухай бүү бод, битгий ярь гэж Ревекка хэллээ.

- Тэгье сайн хүүхэн минь, чамтай үг зөрөх гэдэг миний зүгээс ач тусыг үл мэдэх явдал байхсан. Одоо хөөрхий Гуртийн хэрхсэн тухай ганц үг дуулчихаад цааш нь юуны ч тухай шалгаахаа больё гэхэд,

Харамсалтай нь Седрикийн тушаалаар түүнийг баривчилсан гэдгийг баатар танд дуулгаж болж байна гэж еврей бүсгүй хариулаад, энэ үг Уильфредэд хүнд сэтгэгдэл төрүүлж байгааг үзэн даруй цааш нь, - Гэхдээ ангийн даамал Освальд түүнийг эзний хилэнг өөрөө хөдөлгөхгүй бол Седрик түүнийг уучилна гэж надад хэлсэн. Юу гэвэл хэзээнээсээ сайнд тооцогдож ирсэн үнэнч зарц, энэ удаа ч мөн Седрикийн хүүд үнэнч сайнаа үзүүлснээр л буруутжээ. Харин Седрик цаашаа Гуртэд уурлаад болохгүй байгааг зарц нар үзвэл, тэд цөм, ялангуяа салбадай Вамба зам зуур Гуртийн оргоход тус болно гэж Освальд бас хэлсэн гэв.

Бурхны авралаар тэгж амжих болтугай! гэж Айвенго дуугараад, - Өөртөө сайн байгаа хүн бүрт гай авч ирэх тавилантай төрсөн юм шиг хүн юмаа би. Миний хаан эзэн намайг

дотночилон өршөөж, шадар хүнээ болгосон, тэгтэл харж байгаа биз. Түүний ачаар сүрхий яваа төрсөн дүү нь хаан ширээг булаах гэж өөдөөс нь зэвсэг барин босож байна. Миний сайн байснаас болж хамгийн гоо сайхан бүсгүй хавчилт шахалтанд орсон. Одоо манай эцэг хөөрхий боолыг зөвхөн надад сайн байлаа гээд алчих байх. Ямар золгүй хөөрхий амьтныг эмчлэх, аврах гэж бодсоноо харж байгаа биз, сайхан бүсгүй минь. Намайг авч нохой мэт мөрдөгч зовлон чамд тусаж энэрэнгүй сайн үйлст чинь гай болохоос өмнө санаа авч, намайг явуулж үз дээ гэв.

Ревекка үүнд, - Үгүй эрхэм баатар, чи ихэд тэнхээ тасарч сэтгэл санаагаар машид уруу байгаа болоод хувь тавиланг буруугаар тайлбарлаж байна. Эх орон чинь үнэнч сэтгэл хүчит гарын туслалцаа хамгаас илүү хэрэгтэй байгаа цагт чи эргэж ирлээ. Өөрийн болоод хаан эзнийхээ дайснуудыг давуу чадлаараа юу юунаас илүү гайхуулж байх цагт нь номхруулж өглөө. Тэгэхдээ чи өөрөө хүнд шархадсан үнэнч боловч бурхан чамайг өршөөж, жигшүүрт овгийнхны дундаас боловч чамд эмч туслагч илгээжээ. Иймээс сэтгэл санаагаар уналгүй, аль нэг гайхамшигт ялалтын төлөө чамайг хувь тавилан амьд мэнд үлдээсэн гэдэгт итгэ. За баяртай. Рубинээр өгүүлэх эмийг уугаад маргааш аян замд гарахад тэнхээ тамир авахын тулд сайтар унтахыг хичээ гэв.

Айвенго эдгээр учирласан үгэнд авгаж, Ревеккагийн зааврыг дагав. Рубины авч ирсэн тайвшруулах ундаан бие амрааж бөх сайхан унтуулав. Өглөө болоход өвтөн халуурах алив шинж үгүй болж ядаргаатай аяны бэрхшээлийг туулж чадахтай болсныг эелдэг зант эмч үзлээ.

Айвенгог эрүүл тулалдааны газраас авч ирсэн нөгөө моринд жуузанд суулгаж амгалан таатай явуулах бүх аргыг Ревекка хийжээ. Ганцхан юм л Ревеккагийн гуйлт хүртэл шархадсан баатрын ая тавыг зохих ёсоор анхаарахад саад болж байв. Исаакад газар сайгүй хулгайч дэрэмчид байх шиг санагдана. Норманы танхай тайж нар саксоны зоримог дээрэмчид өөрийн нь юмаар олз хийх дуртайг мэдэх тул Исаак тэднээс гал мэт айх ажээ. Иймээс бүхэл замын турш морьдын хурдаар довтолж түргэн зуур зогсон, хоол унд идэж уух цагийг хасна. Тэгсээр явж өөрөөс нь хэдэн цагийн өмнө гарсан боловч Витольд гэгээний хийдэд удтал найрлан зам зуур саатсан Седрик Ательстан нарыг гүйцээд түрүүлж чаджээ. Мириам эмгэний эмийн анагаах чадлын хүч асар их байсных уу, Айвенго гойд чийрэг сайн биетэй болоод тэр үү, энэ хурдан явалтанд төдий л их ядарсангүй. Гэвч Исаак хэт яарснаас хүнд уршиг гарлаа. Аль болох түргэн явах гэж цаг ямагт шамдуулахад хүргэж яваа хүмүүсийн дургүй хүрчээ.

Эдгээр хөлсний саксон зарц нарт энэ овгийнхны мөн шинж болсон өег хооллож, амгалан байхыг хичээх зан бас байсан бөгөөд норманууд саксончуудыг үүнээс болж идэмхи залхуу гэдэг билээ. Исаакийн мөнгөөр жаал наргиж авах горьдлоготой хүргэж өгөхийг зөвшөөрсөн атал хаана ч үдлэлт хийлгэхгүй болохоор нь ихэд урам хугарчээ. Эхлээд морьд ядарснаар шалтаг заан маргах гэж үзлээ. Хоол болгон дээр тэдний ууж байгаа дарс пивоны хэмжээнээс болж Исаак сүүлдээ хүргэж яваа хүмүүстэйгээ бүрмөсөн муудахад хүрэв. Иймэрхүү явсаар жинхэнэ түгшүүртэй цаг ирэхэд Исаакийн айж байсан нь ёсоор болж өөртөө сайн болгохыг хичээлгүйгээр найдаж, дургүйг нь хүргэсэн хөлсний хүмүүс түүнийг хаячихжээ.

Уншигч авхайн мэдэж байгаачлан яг энэ үеэр Седрик Исаакийг гүйцэж ирсэн дараа нь тэд

цөм де Браси түүний нөхдийн гарт орсон билээ. Эхлээд морин жуузыг хайхарсан хүн ер үгүй. Харин де Браси Ровена хатагтайг хайж тийшээ шагайжээ. Ровена авхайн оронд шархадсан баатар тэнд байхыг хараад гайхсан нь юун өгүүлэх! Айвенго өөрийгөө саксоны дээрэмчдэд олзлогдсон гэж бодон тэдний дунд сайн нэртэйдээ найдан даруй нэрээ хэлчихжээ.

Эр баатруудын нэр төрийн тухайд чанд ойлголтуудыг де Браси хэзээ ч бүрмөсөн үл огоорох бөгөөд хэдий хөнгөмсөг, задгай зайдан авиртай боловч арчаагүй байдалд орсон баатрын аль нэг талаар хүч түрч үл төвдөх бүлгээ. Мөн өөрийн эдлэнг эзэмших эрхтэй эзэн хүнийг аятай учрал тохиолдмогц фрон де Беф алахаас үл татгалзах нь лавтай тул Айвенгог түүний мэдэлд шилжүүлж чадахгүй байлаа.

Ингээд де Браси сайн муу хоёрын дундыг барих чадалтай хүн байсан тул зарц нарынхаа хоёрыг жуузны хоёр талаар яван хэнийг ч бүү ойртуулж гэж тушаажээ. Элдэв юм шалгаагаад байвал Ровена авхайн хоосон жуузанд дайралтын үед шархадсан нөхрөө суулгаж яваа юм гээрэй гэлээ. Торкильстон цайзанд ирээд сзмийн хорооны баатар, Фрон де Беф хоёр нэг нь Исаакийн мөнгө, нөгөө нь түүнийг охиныг шохоорхон хувийн ажил төрлөөр оролдож байх зуур Морис де Брасийн зарц нар Айвенгог шархтай нөхрөө хэмээн цайзны нэг тусгаар өрөөнд оруулжээ. Тэднийг гарч цайзны хэрэм хамгаал гэж гэрийн эзэн тушаахад мөн л ийм тайлбар өглөө.

- Шархтай нөхөр гэнээ! гэж бээл ихэд гайхан хилэгнэж – Дайчид өвчтөн сувилагч болж чөлөөт багийн байлдагчид цайз бүслэгдээд байхад үхэж байгаа хүн сахиж суудаг болсон бол эрчүүл, йоменууд бээлийн цайзыг дайрч, салбадай гахайнууд тулалдах дуудлага тайж нарт харуулах нь гайхмаар зүйл биш байх нээ! хараал хүрсэн залхуу новшнууд хэрмэн дээр гар! гэж зандраад – Та нарыг байраа эзэл гэж би хэлж байна! Тэгэхгүй бол хамаг ясыг чинь хэмх цохино шүү! гэлээ.

- Зарц нар нас барж байгаа хүнийг асар гэж тушаасан эзний өмнө зөвтгөж өгөх л юм болж гэм хэрмэн дээр гарахад өөрсдөө ч билээ дуртай байна гэж уруугаар хариу өчив.

- Үхэж байгаа хүн гэнээ, шаарууд! гэж Фрон де Беф хашгираад – Олигтойхон шиг тулалдахгүй юм бол бид цөм үхэж байгаа хүн болно гэж та нарт хэлж байна шүү! Танай наад өөдгүй нөхрийг чинь асрах өөр хүн би одоо ирүүлнэ. Хөөе Урфриде! Хараал хүртсэн эмгэн! Хөөе муу саксон шулмаа! Дуулахгүй байна уу чи? Тэр шархтай новшийг заавал асрамжлах хэрэгтэй юм бол очиж сувил, энэ залхуучуул зэвсэг бариг. За эрчүүл минь энэ хоёр халхавч, нум сэлтийг ав. Харвах нүхэн дээр очиж зогсоод сум бүрийг саксон толгойд зоож үзээрэй! гэв.

Хийх юмгүй уйдаж байсан де Брасийн зарц нар байраа эзлэхээр дуртайяа одож шархтай Айвенгог сувилах ажил Урфрида буюу Ульрикад оногдов. Гэтэл эмгэн энэ үед маш шаналгаатай зүйлүүд дурсан үзэж өнгөрүүлсэн дарлагдал доромжлолоо ухаарч өшөө авах найдлагад автан байсан тул өвчтөнийг асрамжлах үүргийг Ревеккад дуртайяа оногдууллаа.

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

"Зоригт дайчин цамхаг дээр гар.

Талбайг хар, тулалдааны тухай өгүүл"

Шиллер "Орлеаний авхай"

Аюул тулгарсан үед хүн сэтгэл зүрхээ уудлан ярилцмаар болох нь олонтой. Сэтгэлийн сэрэмжлэлийг мартагдуулж, илүү тайван цагт бол нуухыг хичээх сэтгэлээ биеэр илчлэн гаргадаг билээ. Дахин Айвенгогийн орны дэргэд ирэхдээ Ревекка өөрсдийн асар аюултай байдлыг үл харгалзан голгүй их баярлаж байгаадаа өөрөө гайхлаа. Судасны цохилт чагнаж, биеийн байдал асуухдаа Ревекка өөрийнхөө хүсэж байснаас илүү халуун дотно сэтгэлтэйгээ өөрийн эрхгүй илтгэхээр тун ч энхрий зөөлөн хүрч эелдэг ялдамхан ярьж байлаа. Бүсгүйн дуу тасалдаж, гар чичирч байснаа "Эелдэг зант хүүхэн та юу, энэ чинь" гэж Айвенго хөндийгөөр асуухад сай сэхээ авч өөрт нь төрж байгаа сэтгэл хэзээ ч харилцан байж үл чадахыг саналаа. Ревекка дуулах төдийгөөр санаа алдаад баатрын биеийн байдлын тухай цаашаа тайван нөхөрсөг өнгөөр асуух болсонд тун сайн, санаснаас хавьгүй дээр байна гэж Айвенго яаравчлан хариулаад,

- Хонгор Ревекка чиний эрдэм чадварын хүчээр л тэр шүү дээ гэж нэмж хэлэхэд хүүхэн дотроо:

"Намайг хонгор Ревекка гэж дуудлаа. Гэхдээ энэ үгийг яасан хайш хэрэг, тоомжиргүй өнгөөр хэлэв ээ! Жигшүүрт дорд еврей хүүхнээс байлдааны хөлөг, анч нохой нь илүү үнэтэй гэдэг даруй илт байна!" гэж бодлоо.

Айвенго үргэлжлүүлэн – Ингэхэд эелдэг аашт бүсгүй минь, өвчнөөс блж биеэ зовоохоос илүү сэтгэл түгшин шаналах нь тун хэцүү байна. Энд байсан миний манаач нарын ярьснаар би олзлогдоод байгаагаа гадарласан. Дөнгөж сая тэднийг хөөж явуулсан ширүүн дуугаар үзэхэд бид Фрон де Бефийн цайзанд байгаа юм байна гэж мэдлээ. Хэрвээ тайж ахуул эд бүгд юу болж дуусах, Ровена эцэг хоёрыгоо би ямар шүү янзаар хамгаалж чадах билээ? гэв.

"Еврей, еврей хүүхэн хоёрын тухай энэ дурсахгүй байна. Бид тэгээд ч үүнд ямар хүртээлтэй байх билээ? Энэ хүний тухай сэтгэлээ сул тавин хэт бодсоныг минь бурхан зүй ёсоор цээрлүүлж байна" гэж Ревекка дахин бодлоо.

Ийнхүү өөрийгөө буруушаагаад олж мэдэж чадсан бүхнээ Айвенгод яаран дуулгав. Гэхдээ олж мэдсэн зүйл төдий л их биш. Цайзанд бүх хэргийг сүмийн хорооны баатар Буагильбер, Фрон де Беф бээл хоёр захирч байна. Цайзыг гаднаас бүслэн байгаа чухам хэн болохыг мэдэхгүй. Одоогоор цайзан дотор христос шашны нэг хувраг хүн байгаа, тэр хүн илүү их юм мэдэж байж магад гэдгийг ярив.

- Хувраг гэнээ? гэж Айвенго баярлан дуу адаад – Ревекка, боломж байвал түүнийг нааш нь дууд! Өвчтөн хүн сэтгэл санаагаа тайтгаруулж өгнө үү гэж гуйж байна гэж хэл Юу дуртайгаа хэлээд нааш нь авч ирж үз. Би нэг юм хийх учиртай шүү дээ? Гэхдээ хэргийн байдал хаашаа

байгааг мэдэхгүйгээр би юу хийж чадах юм бэ? гэлээ.

Айвенгогийн энэ хүслийн дагуу шархтай баатрын өрөөнд Седрикийг авч очих гэж Ревекка оролдов. Гэвч хуурамч гэлэнг мөн отоож байсан Урфрида хажуугаас оролцож Ревекка үүнийг гүйцэтгэж эс чадсаныг би мэдэв. Ревекка Айвенго дээр буцаж очоод бүтэлгүйдсэн тухайгаа дуулгав.

Тэднийг хэрхэн хөдлөх шинэ төлөвлөгөө дөнгөж боловсруулж эхэлтэл цайзан дотор түрүүнээс хойш дуулдсаар байсан бүх шуугиан бөөн хөл, хөдөлгөөн болчихлоо.

Дээд хэрэмний шидэт ирмэг харвах нүх рүү болон бусад хамгаалах баатрууд руу очих махир шатаар зэвсэглэсэн зарц нарын яаруу нүсэр алхаа дуулдана. Дорд хүмүүсээ зориг оруулан, хамгаалалтыг зааварлаж байгаа баатруудын дуу бас дуулдана. Тэдний дууг зэр зэвсгийн хангинан үг хэлж өгч байгаа хүмүүсийн чанга хашгиралдах чимээ дарах ажээ. Илүү их аймшигтай зүйлийг илтгэсэн энэ шуугиан хэдий түгшүүртэй авч цаанаа бас ихэмсэг сүртэйг нинжин сайхан сэтгэлт Ревекка энэхүү бэрх аюултай үед ч гэсэн мэдэрхүйц соргог ажээ. Царай нь тэр аяараа зэвхий даасан авч нүд нь гялалзан, хилмэгдэх бахдах сэтгэлд авган чичирч, өөртөө ч юм уу, хамт байгаа хүндээ ч хандаж тэр үү, ариун үгнээс "Саадаг хавиралдаж, илд цууриатана..." гэж иш татна. Гэвч Айвенго тэрхүү сударт өгүүлэгдэх зүйлийг сонсоод байлдааны хөлөг аятай тэсэж ядан, энэ бүх дайчин чимээ шуугианыг илтгэн буй тулалдаанд оролцохсон гэж хамаг сэтгэл нь тэмүүлнэ.

- Би адаглаад цонх хүртэл мөлхөж чаддаг болоосой. Энэ тулалдаан яаж болохыг харах юмсан! Би нум олж аваад ганц сум тавих юм уу, өөрсдийгөө чөлөөлөхийн тулд балтаар ганц цавчих юмсан! Ямар ч тусгүй, огт дэмий, би тамир тэнхээ ч байхгүй, гар мухар! гэж байв.

- Сайн төрөлт баатар та бүү сэтгэл догдол, хамаг чимээ гэнэт тасраад явчихлаа дуулж байна уу? Тулалдаан болохгүй ч байж мэднэ шүү дээ гэж Ревекка хэлэхэд,

- Чи юу ч ойлгохгүй байна! гэж Уильфред унтууцан дуугараад – Ийнхүү чимээгүй болдог чинь дайчид хэрмэн дээр тус тусынхаа байрыг эзлээд одоо дайралт хүлээж байна гэсэн үг. Бидний саяны сонсдог чинь догшин шуурганы түрүүчийн дохио төдий зүйл. Хэдхэн минутын дараа шуурга байдал чадлаараа хэрхэн догширохыг үзнээ чи... Би яаж ийгээд тэр цонхны тэнд мөлхөж хүрэх юмсан! гэвэл,

- Тэгж турших сайн төрөлт баатар танд хар болно гэж Ревекка хэлснээ ихэд сэтгэл догдлон байгааг нь үзэж,

- Би өөрөө цонхны дэргэд зогсоод тэнд болох зүйлийг чадах хирээрээ хэлж өгье гэв.

- Үгүй хэрэггүй, хэрэггүй гэж Айвенго дуу алдан – Цонхны бүр, хананд байгаа жижиг нүх болгон руу харваачид шагайдаг юм. Аль нэг тэнэсэн сум... гэтэл Ревекка:

- Тэгвэл ч мөн сайн аа! гэж аман дотроо өгүүлээд цонх руу очих хоёр гурван гишгүүр дээр зоримог гарав.

- Ревекка хонгор Ревекка минь гэж Айвенго дуу алдаад, - Наадах чинь эмэгтэй хүний ажил ер биш. Алагдаж, шархдаж болохуйц аюулд биеэ бүү оруул, тэгвэл надаас л болсон гэж бодон би насан туршаа зовж шаналах болно. Адаглаад тэр хуучин бамбай авч халхлан сараалжин цаанаас аль болох бага цухуйхыг хичээж үз гэв.

Ревекка зааврыг даруй дагаж цонхны доод талыг хуучин бамбайгаар халхлан ард нь маш чадмагаар нуугдаж бараг ямар ч аюулгүйгээр цайзны хэрэмний цаана юу болж байгааг харан бүслэгчид хэрхэн дайрахаар зэхэж байгаа тухай Айвенгод хэлж өгч чадахаар боллоо. Хүүхний эзэлсэн байр гол барилгын буланд байгаа болохоор ийнхүү ажиллахад гойд тохиромжтой цайзны гадаа болох бүхнийг харж чадах төдийгүй, бүслэгч хүмүүс эн тэргүүлэн довтлох гэж байгаа бололтой гадаах хамгаалалт бас үзэгдэх ажээ. Энэ нь фрон де Беф түрүүн Седрикийг гаргасан явган хаалгыг хамгаалахдаа зориулсан жижиг цамхаг байлаа. Цамхаг бусдад хэрэмнээсээ гүн устай гуугаар тусгаарлагдсан, банзан дамнуургыг авахын хамт бэхлэлт хэрэм хоёр хялбархан таслагдаж болох ажээ. Гадаа бэхлэлт өөрөө хэрэмний явган хаалга руу харсан хаалгатай эргэн тойрон бат бэх хашаатай байв. Энэ бэхлэлтийг хамгаалахаар гаргасан хүмүүсийн тоогоор энэ талаас дайрахыг бүслэгдэгсэд онц их сэрэмжилж байгааг Ревекка мэдлээ. Бүслэгсэд ч мөн цайзны бүх хамгаалалтнаас хамгийн сул газарт тооцон гол хүчээ түүний эсрэг хуралдуулав.

Энэ бүгдийг Айвенгод даруй тодорхой хэлж өгөөд нэмж:

- Ойн цоохойд олон харваачид эгнэн зогсож байна, гэхдээ модны цааны харагдаж, цөөн нэг нь ил гарчээ гэв.

- Тэд ямар тугтай юм байна гэж Айвенго асуухад,

- Туг, далбаа би ер харахгүй байна гэж Ревекка хариулав.

- Хачин юм даа? гэж баатар дуугараад – Ийм цайзыг дайрахдаа туг далбаа огт мандуулахгүй байх гэдэг. Эдний тэргүүлэгч нь тэгээд ямар шүү хүн байна харагдана уу? гэхэд,

- Нэг хар хуяг, дуулгатай баатар л бүхнээс илүү ялгарч байна. Бүтэн зэр зэвсэгтэй ганц хүн ердөө л тэр бөгөөд янз нь цөмийг захирч байгаа бололтой гэж еврей хүүхэн хэллээ.

- Бамбайн дээр нь ямар сүлд байна гэхэд,

- Хар дэвсгэр дээр бамбай, хөндөлдсөн зурвас төмөр, цэнхэр өнгийн цоож дүүжлээстэй байх шиг харагдана гэхэд,

- Цэнхэр өнгийн гинж, цоож хоёр байна гэж Айвенго засаж хэлээд, - Хэн тийм сүлдтэй баыж болохсон билээ санахгүй байна. Энэ үед тэр чинь надад л сайн тохирмоор санагдана. Бамбайн дээр нь тэгээд юу гэж бичсэн байна? гэхэд,

- Энэ холоос би сүлдийг дөнгөж ялгаж байна, тэгэхдээ наранд гялбасан үед нь тэр шүү гэж Ревекка хариулав.

Шархтан цаашаа:

- Өөр удирдагчид нь харагдана уу? гэж шалахад,

- Эндээс надад хэн ч харагдахгүй байна. Гэхдээ цайзны бусад талаас дайрч байгаа нь эргэлзээгүй. Тэд одоо урагшаа хөдлөх шиг бололтой. Ойртож байна... Бурхан биднийг өршөө! Харахад ямар аймаар юм бэ? Урьд талын хүмүүс нь том бамбай, банзан хаалт, өргөж явна. Бусад нь явуут нумаа тэлэн дагаж байна. Тэд нумаа өргөлөө... Моксеев бурхан чи өөрөө төрүүлсэн хүмүүсийг уучил! гэв.

Хүүхний яриаг дайрах дохио гэнэт цуурайтаж таслав. Бүслэгчид эврээр тасхийтэл бүрээдэхэд хэрмэн дээрээс норман бүрээ, коор дуугарч, дайсны дуудлаганд эгдүүтэйгээр хариулна. Бүсэлсэн, бүслэгдсэн цөм улайран хашгиралдаж чих дөжрөм их шуугианыг улам их болгов.

Гэхдээ энэ өдрийн хувь заяаг хоёр тал ганц хашгиралдаанаар шийднэ гэж үл найдах ажээ. Бүслэгсдийн ширүүн довтолгоог бүслэгдэгсэд улайран няцаана. Ой модоор тэнүүчлэн нум сум "гар нийлэн" сум тавихад цайз хамгаалагчид хувь хиртэй ч гэсэн цухуйхад бүтэн алд дайтай урт мэргэн сумнаас зайлах арга ер байсангүй. Сум тус бүрийг сайта шагайхын хамт тун ойрхон жигд харвах тул мөндөр шиг бууна. Харвах нүх, ан болоод хамгаалагчдын аль нэг нь байж мэдэх цонх болгон руу сум арваадаараа тусах бөгөөд хоромхон зуур хамгаалагчдаас хоёр гурван хүн алагдаж, хэд хэдэн хүн шархдав. Гэвч Реджинальд фрон де Бефийн талынхан, холбоотнууд хурц зэр зэвсэг, цайзны бат бэхэд найдан бүслэгсдийн уур хилэнтэй тэнцэхүйц шургуугаар хамгаална. Тасралтгүй буух мөндөр шиг сумны хариуд холховч нум болон дүүгүүрээр хариу харвалцана. Бүслэгсдийн халхавч тун өчүүхэн амжилт олсон төдийд бахдан чангаар хашгирах сонсогдоно.

- Миний амь нас, эрх чөлөөг шийдвэрлэхээр бусад хүмүүс тулалдаж байхад би тэнхээ тамиргүй болсон гэлэн аятай энд зүгээр хэвьэж байх ёстой байдаг! гэж Айвенго дуу алдаад, - Сайн хүүхэн чи дахиад цонхоор шагай, гагцхүү болгоомжлоорой, харваачид харчих вий. Хараад тэд хэрэм өөд дайрч байна уу, үгүй юу хэлж өг гэв.

Ревекка дотроо залбиран зориг орж цонхны дэргэдэх байраа дахин хүлцэнгүй, зоримогоор эзлээд бамбайгаар биеэ даруй харагдахааргүй халхлав.

--Ревекка чи юу харж байна? гэж шархтай баатар дахин асуувал,

- Нисэж буй бөөн сум л харж байна. Тэд чинь нүд эрээлжлүүлээд харваачид өөрсдөө харагдахгүй байна гэхэд Айвенго өөдөөс нь:

- Тэр удаан тэгж байхгүй. Чулуун хэрэм, цамхагны өөдөөс дан нум сумаар юу тавих билээ? Гоо Ревекка минь, Хар баатар хаана байна? ямар шүү янзтай байна хараарай, юу гэвэл тэргүүлэгч ямар бол дорд хүмүүс адил байдаг юм гэвэл Ревекка :

- Үгүй, тэр ухраагүй байна, ухраагүй байна! Тэр байна би харлаа, гадаа бэхлэлтийн урьд цамхаг руу нэг баг дагуулаад очиж явна. Тэд хашаа, шонг унагаан, хаалтыг сүхээр чавчин нурааж байна. Баатрын дуулган дээр урт хар өд, тулалдааны талбар дээгүүр эргэн, хэрээ

аятай намирч байна. Хашаанд нүх гарчихлаа. Дайраад орлоо... Тэднийг буцаагаад түрж байна... Хамгаалагчдын түрүүнд Фрон де Беф бээл явна. Түүний аварга бие олны дундаас ялгарч байна... Дахин цоорхой руу дайрч гардан тулалдлаа... Иакив бурхан! Эсрэг салхинд туугдсан хоёр их далайн давалгаа аятай! гэж дуу алдав.

Өдий аймшигтай үзэгдлийг цааш харахаас нүд хальтрах аятай бүсгүй цонхноос холдож буруу харлаа.

Энэхүү хөдөлгөөнийг нь Айвенго буруугаар ойлгон, дахиад хар Ревекка, тэд гардан тулалдаж байгаа хойно одоо нумаар харвах нь цөөрсөн байх учиртай, дахиад хар, цонхны дэргэд зогсох одоо тийм их аюултай биш гэлээ.

Ревекка дахин шагайж, бараг харсан даруйдаа—Гэгээн шүтээн минь Фрон де Беф, хар баатартай тулалдлаа! Тэр хоёр сэтэрхий дээр халз тулалдан бусад нь зөвхөн харж хашгиралдаж байна. Шударга үнэн бурхан минь дарлагдсан олзлогдсон биднийг ивээж хайрла! гэснээ – Тэр уначихлаа гэж хашгирав.

- Хэн уначихав? Ариун дагиныг бодож хэн унасныг хэлж өгөөч! гэж Айвенго шавдуулахад Ревекка өөдөөс нь:

- Хар баатар гэж дуулдах төдий хариулсан даруй баяртайгаар хашгиран, - Үгүй, үгүй дайн тулалдааны бурхан өршөөж гялайлгалаа! Тэр дахин босон харайж, өрөөсөн гартаа хорин хүний хүчтэй юм шиг үзэлцэж байна. Сэлэм нь дундуураа хуга үсэрсэн юм байна... Тэр нэгэн, йомены балтыг шүүрч аваад Фрон де Бефийг эг сэггүй дэлсэн түрж байна. Аварга биет баатар бөхийн модчины сүхэнд өртсөн царс аятай ганхаж байна. Унаад орхилоо! Уначихлаа! гэхэд,

- Хэн тэр вэ? Фрон де Беф үү? гэж Айвенго дуу алдлаа.

- Тиймээ, Фрон де Беф гэж еврей хүүхэн хариулаад, - Түүнд хүмүүс туслахаар ухасхийлээ. Тэдний тэргүүнд сүмийн хорооны бардам баатар гарлаа. Тэд хүч хавсран хар баатрыг тогтоож байна. Одоо бээлийг цайзны хашаа руу чирэн оруулж байна гэв.

- Бүслэгчид хашаан дотор дайраад орчихсон шүү дээ гэж Айвенго асуухад,

- Тиймээ эзэлчихсэн! гэж Ревекка дуу алдаад, - Хамгаалагчдыг гадаа ханатай хашчихаж! Зарим нь шат тавьж, бусад нь дээш авирах гэж зөгий аятай эргэлдэн нэгнийхээ мөрөн дээр гарч байна. Тэдний дээрээс чулуу, дүнз мод унагааж байна. Шархадсан нэгийгээ гэдрэг аваачиж оронд нь шинэ дайчид даруй зогсож байна. Их бурхан та хүнийг ах дүүсийнхээ гараар өөрсдийгөө ийнхүү зэрэмдэглүүлж байхын тулд юунд өөртэйгаа адил төстэйгээр бүтээсэн юм бэ? гэв.

Айвенго үүнд, - Тэр тухай одоо бүү бод, тийм санаанд авгаж суух цаг одоо биш... Аль тал ухарч байгааг зүгээр хэл! Хэн дийлж байна? гэхэд Ревеккагийн бие зарсхийж,

- Шатуудыг унагаачихаж, дайчид няц дарагдсан чийгний хорхой аятай дор нь тэрийж хэвтэнэ!

... Бүслэгдэгсэд дийлжээ! гэхэд баатар дуу алдан,

- Үгүй, тэд эрэлхэг тулалдаж байна. За одоо хар баатар аварга балтаа барьсаар хаалга руу очоод цавчиж байна. Цохиж байгаа нүргээн нь тулалдааны шуугиан дундаас дуулдаж байна. Хэрмэн дээрээс түүний толгой руу чулуу дүнг унагаахад зоригт баатар түүнийг өд, хөвөн аятай ер анзаарахгүй байх юм! гэлээ.

Айвенго баяртайгаар тохой дээрээ өндийн, - Гэгээн Йоменыг барьж андгайлахад бүхэл ангид ийм ажил хийж чадах ганц л хүн бий гэж боддог юмсан гэв!

Ревекка цааш нь хаалга доргилоо! Хаалга шажигнаж түүний цохилтыг даахгүй хэмхэрч байна... Тэд цоорхойгоор дайч ороод цамхгийг эзэлчихлээ. Бурхан минь, хамгаалагчдыг барьж аван устай суваг руу чулуудаж байна. Хүмүүс та нарт хүний үнэр байвал нэгэнт эсэргүүцэх чадалгүй болсон нэгийгээ өршөөж үз! гэв.

- Гүүр яав? Цамхгийг цайзтай холбосон гүүр яасан бэ? Тэд түүнийг бас эзэлсэн үү? гэж Айвенго шалахад, Ревекка өөдөөс нь:

- Үгүй, Сүмийн хорооны баатар өөрөө шуудуугаар гарсан банзыг устгачихсан. Хамгаалагчдаас цөөн хүн түүнтэй цуг хэрмэнд орж амь гарсан. Энэ орилж бархирч байгааг дуулж байна уу? Бусдад нь ямар хувь тавилан оногдсоныг энэ илтгэж байна. Ялж дийлэхийг үзэх гэдэг тулалдааныг харахаас илүү айхавтар байдгийг би мэдлээ! гэв.

- Одоо тэд юу хийж байна? Дахиад хар! Энэ чинь цус асгарахыг үзээд муужирч байх цаг биш гэж Айвенгог хэлэхэд,

- Түр намжлаа гэж Ревекка хариулаад, - Манай нөхөд эзэлж авсан цамхаг дотроо бэхжиж авч байна. Дайсны сумнаас маш сайн хамгаалах тул бүслэгдэгсэд чухамхүү хор учруулахын тулд биш амар байлгахгүйн тулд л тийшээ ганц нэг сум тавьж байна гэлээ.

- Ийм эрэлхгээр гүйцэтгэж эхэлсэн ажлаа манай нөхөд лав орхихгүй билээ. Тэд нэгэнт их амжилт оллоо. Лав орхихгүй! Царсан хаалга, төмөр гинжийг балтаараа тас цавчдаг сайн баатарт би голлон найдаж байна... гээд аман дотроо, - Хачин юм даа. Ийм өгүүлшгүй хатан зориг гаргаж чадах хүн хорвоо дээр хоёр байна гэж үү? Хар дэвсгэр дээр гинж цоож хоёр байдаг... Тэр юу гэсэн утгатай байж болох вэ? Хар баатрын хэн болохыг мэдэх өөр шинж тэмдэг Ревекка чи харахгүй байна уу? гэхэд Еврей хүүхэн өөдөөс нь,

- Үгүй хамаг эдлэл нь хэрээний далавч шиг тас хар юм. Ямар ч тэмдэг ер харагдахгүй байна. Гэхдээ тулалдаанд түүний эр зориг хүч чадлыг нүдээр үзсэнээс хойш мянган дайчдын дотроос боловч ялган таних юм шиг санагдана. Тэр чинь найр наргианд оролцох гэж байгаа юм шиг тулалдаанд ухасхийн орох бөгөөд дайсны мэргэн цавчилт бүрд ганцхан булчин чадлынхаа хүчийг төдийгүй чин сэтгэл, мэрийлтээ гаргаж байх шиг харагдах юм. Цус асгаруулсан нүглийг нь бурхан өршөөж өгөх болтугай. Харахад нүд хальтрам авч бусад хэдэн зуун хүнийг дийлж чадах хүн харахад бахдам сүртэй ажээ гэв.

- Ревекка чи жинхэнэ эр баатар хүнийг дүрслэн өгүүлж байна. Тэд хөдлөхгүй байгаа бол

шинэ ялалт байгуулахаар хүчээ хуримтлуулж байгаа буюу шуудууг гатлах арга хайж байгаа бизээ. Хэдий л их бэрхшээл саад байх тусам яруу алдар төдий их мандах тул зүрх алдаж эмээх, цалгардаж аажуурах зоригт үйлсээсээ ухрахын аль нь ч энд байж таарахгүй. Гэр орныхоо нэр төрийг барьж ангдайгъя! Хайрт сайн бүсгүйнхээ нэрээр тангараглья! Ийм үнэн зөв хэргийн төлөө энэ зоригт баатартай ганц өдөр зэрэгцэн тулалдахын тулд би арван насаа өгөх, түүнийг гянданд хоригдож өнгөрөөхөөс татгалзахгүйсэн! гэв.

Ревекка цонхны дэргэдэх байрнаасаа холдон шархтай баатрын ор руу ирж, - Тоогүй дээ! хөдлөх гэж ингэтлээ тэсэж ядан бачуурах, биеэ сул дорой байхад ингэж шахаж зовоох гэдэг эдгэрэхэд чинь заавал саад болно доо! Өөрийнхөө шархыг эдгэрээгүй байхад бусад хүмүүсийг шархдуудах гэж чи яаж найдаж болох юм бэ? гэвэл,

- Ах ах Ревекка, эр баатарчуудын гавьяат үйлийн амтыг үзсэн хүн, дэргэд нь бусад хүмүүс эрэлхэг гавьяа байгуулж байхад нэг муу гэлэн юм уу бүсгүй хүн аятай зүгээр байх гэдэг хичнээн хүнд болохыг чи төсөөлж ч чадахгүй юм даа. Тулалдаан гэдэг бидний амь зогоох хоол, дайны утаа бол бидний амьсгалдаг агаар юм чинь. Ялалтын алдар сүрэнд хучигдалгүйгээр бид амьдардаггүй, амьдрахыг ч хүсэхгүй! Эр баатарчуудын жам ийм бөгөөд үүнийг дагаж баримтлахаар тавьсан тангарагтай, үүнийхээ төлөө амьдралд үнэнтэй чухаг бүгдийгээ золиосонд гаргадаг билээ гэвэл гоо сайхан еврей бүсгүй хариуд нь,

- Энэ чинь зоригт баатар минь нэр төр хөөцөлдүүлэх муу шуламд өглөг барьж, Молохын өмнө өөрийгөө шатааж байгаа хэрэг мөн биш үү дээ хөөрхий! Таны асгаруулсан бүх цус, үзэж өнгөрүүлэх бэрхүүэл гачигдал, мөн эрлэгийн элч таны жадыг хугалж байлдааны хамгийн хурдан хөлгөөс чинь өрсөхийн цагт бусдын нулимс асгаруулсны хариу шагнал танд юу үлдэх юм дээ? гэв.

- Юу үлдэх юм гэнээ? гэж Айвенго дуу алдаад, - Юу юу үлдэх юм гэж? Нэр алдар, яруу алдар! Алдар бидний шарилыг алталж бидний нэрийг мөнхжүүлнэ! гэв.

- Нэр алдар гэнээ гэж Ревекка давтан өгүүлээд, баатрын чийгтэй хар шарил дээр гашуудлын тэмдэг болон өлгөөстэй байдаг зэвэрсэн хуяг, эсвэл эрдэм муутай гэлэн явуулын хүнд сургаал болгон чадан ядан уншиж өгдөг элэгдэж баларсан бичигтэй шарилын чулуу л бусдад гай зовлон учруулахын үүднээс бүхэл насан туршаа зовж зүдрэн, аль энхрий сайхан бүхнийг огоорсны сайн шагнал юм гэж үү? Эсвэл үдшийн цагаар согтуу эрчүүлийн дунд тэнэмэл дуучдын хэлдэг найраглалын баатар болохын тулд өөрийн гал голомт, гэр бүлийн баяр баясгалан, амар жаргалтай, аж төрөхөөс сайн дураараа татгалзахаар гойдын их хүч сайхан юм аль нэг хэсүүлчин үлгэрчдийн бүдүүн бараг шүлэгт байдаг байна уу? гэв.

- Хервардын сүнсийг барьж андгайлахад, чи өөрийнхөө мэдэж чадахгүй юмны тухай ярьж байна гэж баатар унтууцан хэлээд, - Ариун сайхан бузар булай хоёрыг ялган танихад бидэнд ганц тус болдог эр баатруудын ариун зулыг чи унтрааж орхимоор байна уу. Эр баатрын сэтгэл гэдэг зоригт дайчныг эгэл бүдүүлэг эрчүүлээс ялгах бөгөөд амь насаа нэр төрөө асар дордод тооцож, алив гачигдал, зовлон зүдгүүрийг даван нэр төрөө хугалаас өөр юунаас ч эмээхгүй болгон сургаж байгаа юм. Ревекка чи христос шашинтан хүн биш болохоор, сайн төрөлт авхайчуудын хайртай хүн хир их сайнаа үзүүлсэн гавьяа байгуулахад тэдний ямар дээд нандин сэтгэл төрж догдлуудгийг мэдэхгүй байна. Эр баатрууд! Энэ чинь хамгийн ариун

нандин сэтгэлийн их булаг дарангуйлагсдын өмөг түшиг, доромжлогчдын өмгөөлөлт, эрх мэдэлтний дур зоргоороо авирлахыг дарах тулгуур юм гэдгийг хүүхэн чи ер мэдэх үү? Үүнгүйгээр тайж нарын нэр төр гэдэг хоосон үг байхсан. Эрх чөлөөг хамгийн сайнаар өмгөөлөн тэтгэгч нь баатарчуудын илд жад билээ гэв.

Бардам сэтгэлт хүүхэн сүүлчийнхээ үгийг маш гутрангүй өнгөөр өчсөн нь ард түмнийхээ доромжлогдсон байдлыг хир гүнзгийгээр ухаардгийг нь харуулах ажээ. Айвенго түүнийг нэр төрин асуудлыг ойлгохгүй төрсөн өндөр нандин сэтгэлээ гаргаж хэлэх чадваргүй гэж үзлээ гэсэн гашуун бодол бас үүн дээр нэмэрлэсэн ч байж болох юм.

Ревекка тэгээд дотроо "буруу номтны эр баатруудын тухай онц сайнаар өгүүлсэнгүй гээд миний дотор зөвхөн аймхай дэрд сэтгэл байдаг юм байна гэж бодож байгаа бол намайг тун муу мэдэж байна даа Иудины үр удмыг боолын байдлаас чөлөөлөхийн төлөө миний цусыг дусал дуслаар нь авах гэж бурхан таалбал би би хичнээн баярлахсан бол .Үгүй би юу хэлж байна аа ?Адаглаад ийм үнээр эцгийн минь түүнд ач тус болсон хүнтэй хамт хяхан хавчигчийн гараас мултарч болдогсон болоосой .тэгвэл бурхны таалсан ард түмний охин хойд зүгийн зэрлэг хүйтэн орны нэг жижиг тэргүүлэгчээс гаралтайгаараа гайхуулдаг буруу номтны салбагануур охидын алинаас ч доргүй эрэлхгээр үхэж чадахыг энэ сэхүүн зантай христос шашинтангууд мэдэх билээ " гэж бодов .

Ревекка шархадсан баатар руу хараад "Унтчихаж! Шарх , сэтгэлийн түгшүүрт энэлж ядраад түргэн намасхийх зуур нойронд автжээ. Үүнийг харж шохоорхох надад нүгэл гэж үү? Үгүй би сүүлчийн удаа ингэж байж ч магад билээ. Хэдхэн хувь өнгөрөхөд нойрон дундаа хүртэл илт байх зоримог авхаалжлаг сэтгэл нь энэ гоо сайхан царайг дахин амьдруулан сэргээхгүй болчихыг хэн мэдэх билээ? Царай нь шумайж, ам нь ангайн нүдэнд нь цус хураад гөлийчихнэ. Тэгвэл хараал идсэн энэ цайзны адгийн муусайн этгээд хүртэл энэ бардам сайхан баатрын хөлөөрөө гишигчиж чадах болно. Энэ тэгэхэд хөдлөх ч үгүй... Харин миний эцэг яахав? Аав минь! Залуу хүний алтан шаргал үсийг шохоорхон чиний буурал үсийг мартаж байгаа хойно муу охинтой хүн юм даа? Олзлогдсон харь хүний тухай эцгээсээ илүү ихээр бодож, Иудийн гай гамшгийг умартан буруу номтныг шохоорхож суугаад чинь Иегова намайг цээрлүүлж байгаа ч юм уу хэн мэдэх билээ? Үгүй зүрх минь тасаг бусаг болон тасарч цус алдран үхэх байлаа ч гэсэн энэ дорой сэтгэлийг би зүрхнээсээ сугалан хаяна!" гэж аман дотроо дуугарав.

Бүсгүй нөмрөгөөр биеэ нягт ороож шархадсан баатрын орноос харцаа буруулан цаашаа харж суугаад гаднын элдэв гай зовлонгийн эсрэг төдийгүй, дотор нь үймэрч байгаа нүгэлт сэтгэлийн эсрэг зоригоо чангалав. Үгүй гэхдээ гангалах гэж мэрийв.

ГУЧДУГААР БҮЛЭГ

Амьсгаа хурааж буй төрхий нь ажсаач!

Амь алдаж, уй гашуу тарихтай огт адилгүй

Ариун сэтгэл нь гургалдай шиг нисэн одлоо

Аясын салхинаа, өглөөний шүүдрээр

Анселын таалал төгслөө

"Эртний дуу"

Бүслэгсэд эзлэн авсан байран дээрээ батжиж, олзлогдогсод хамгаалалтанд бэлтгэж байх зуур сүмийн хорооны баатар Морис де Браси хоёр цайзны их танхимд уулзав.

Цайзны нөгөө талыг хамгаалж байсан де Браси:

- Фрон де Беф хаана байна? Түүнийг алагдсан юм шиг ярилцах нь үнэн үү? гэж асуулаа.

Сүмийн хорооны баатар үүнд хэв нэгээр - Үгүй амьд одоогоор амьд байгаа, тэгэхдээ бамбайн дээр зураастай бүхэн толгой мөрөн дээр байдаг. Тэр арван давхар төмөр хуягтай байлаа ч гэсэн гайт балтнаас аврагдахгүй байсан. Дахиад хэдэн цаг болоход фрон де Беф өвөг дээдэс рүүгээ одно. Хаан хүү Жон үүгээр хүчирхэг хамсаатнаа алдлаа даа гэвэл де Браси өөдөөс нь:

Харин чөтгөрт л их олз доо. Лха тэнгэр гэгээн сахиусыг доромжилж, тэдний үүрийг энэ муусайн йоменуудын толгой дээрээс унагах гэж алдас болсон юм ярих гэдэг ийм л байгаа юм даа гэв.

Сүмийн хорооны баатар хариу марган, - Дэмий үг! Чиний хэт сүсэг бишрэл чинь фрон де Бефийн бурхан шүтээн үл огоордогтой дүйсэн хэрэг. Нэг нь хэт сүсэглэн нөгөө нь огт үл сүсэглэдгээрээ та хоёр хоёул тэнэглэж байна гэж хэллээ.

- Бурхан өршөөг эрхэм баатар минь! Миний тухайд жаахан амаа татаж байгаарай. Чи болоод чиний хүрээнийхнийг бодвол, тэнгэрийн дагиныг барьж андгайлахад би илүү сайн христос шашинтан хүн. Сионы хийдийн баатруудын ариун хороонд буруу номтон цөөнгүй гэж ярилцдаг үнэнтэй бөгөөд Бриан де Буагильбер гуай тэдний нэг мөн гэж де Браси өгүүлэхэд сүмийн хорооны баатар өөдөөс нь:

--Амьтны яриа яах вэ, цайзыг яаж хамгаалах тухайгаа бодсон нь дээр... За шаарын йоменуудын тухай чи юу бодож байна гэхэд де Браси хариуд нь:

Ёстой чөтгөр шиг айхавгар тулалдах юм. Тэд чиний бараг нөгөө харваан дээр шагнал хүртсэн зальхай золигийн удирдлагын доор хэрэм рүү шигүү эгнээгээр тулж ирсэн. Би түүний нөгөө мөрөвч, эвэр хоёроор таньсан хөгшин Фицурсын гайхуулдаг улс төрийн бодлогын уршиг энэ

дээ, тэр л энэ муусайн боолчуудыг бидний эсрэг самуун дэгдээхэд түлхээд байгаа юм. Хэрэв үл даагдах хуяг өмсөөгүй байсан бол тэр шаар лав долоон удаа хөгшин буга аятай ажиггүй харваад алчих байлаа шүү. Миний өвч хуягийн ан бүр рүү урьтаж урт сум тусгаад байсан. Би давтамал хуягаа дорно тайлж испаний хөө хуяг өмсөж яваагүйсэн бол хэцүүдэх байлаа гэв.

- Үгүй гэхдээ та нар чинь байраа хамгаалж чадсан биз дээ? гэж Бриан асуугаад – Бид цамхгаа алдчихсан шүү дээ гэв.

- Энэ чинь хүнд хохирол доо! гэж де Браси өгүүлээд цамхгаар халхавч барьж новшнууд цайз руу тун ойртолоо. Эднийг сайн харж байхгүй бол нэг мэдэхэд хамгаалалт муутай булан, мартагдсан цонхоор орж ирээд гэнэ алдуулж мэднэ. Бид даанч цөөхөн болохоор газар бүрийг хамгаалж чадахгүй хэрэмний цаанаас бултайхын хамт шашны баярын өдөр тавьсан байнд тусдагаас олон сум буух юм гэж хүмүүс тэртэй тэргүй гомдол гаргаад байна. За тэгээд фрон де Беф үхлүүт байгаа хойно түүний бухан толгой, араатны чадал тус болох нь өнгөрч. Аргагүйн эрхэнд орж, олзны хүмүүсийг өгөөд энэ новшнуудтай найрамдвал яасан юм. Бриан гуай та юу гэж бодож байна? гэвэл,

- Юу гэнээ? гэж сүмийн хорооны баатар дуу алдан олзныхоо хүмүүсийг өгч хамаг амьтны доог болох гэж үү? Шөнийн цагаар хамгаалалтгүй явуулын хүмүүс рүү дайран олзолж чадаад гэгээн цагаан өдөр алиа салбадай гахайчны толгойлогч бөөн хулгайч, тэнүүлч араас бат бэх цайзаа хамгаалж чадах юм бол лут дайчид гэх үү? Иймд адгийн шившигтэй юм хийхийг зөвшөөрсөнд орвол урьдаар энэ цайз миний толгой дээрээс нураг гэлээ. Де Браси үүнд хэнэггүйгээр – За тэгвэл явж хэрмээ хамгаалъя. Турк ч бай, сүмийн хорооны баатар ч бай амьдралыг надаас илүү багаар үнэлдэг хүн арай төрөөгүй бий. Гэхдээ одоо эрэлхэг цэргүүдээсээ гар дор нэг дөчин хүн байж байгаасай гэж хүсэхэд шившигтэй юм ер үгүй болов уу гэж найдана. Дараа нь өнөөдөр хир их хэцүүдэж байгааг миний зоригт жадчид мэддэгсэн бол та нарын сэрийх жадны дээгүүр тугаа намирахыг мөдхөн харахсан. Тэгвэл бид энэ адгийн шааруудыг дор нь үгүй хийхсэн билээ гэв.

- Юуны ч тухай санааширч болно, гэхдээ байгаа гийчдийн хүчээр хир сайн хамгаалах аргыг бод. Эдний гол нь фрон де Беф бээлийн зарц нар олон мянган түрэмгий авирлалтаар нутгийн хүн ардын өшөөг хүргэсэн улс гэв.

- Тэр тусмаа сайн, тариачдын өшөө авалтнаас мултрахын тулд эд цусныхаа эцсийн дуслыг дуустал хамгаалах болно. За, Бриан де Буагильбер минь явж ажилдаа орьё. Амьд үлдэнэ үү үхнэ үү алин боловч Морис де Браси сайн төрөлт сурвалжит тайж хүний ёсоор тулалдахыг үзнээ гэж де Браси өгүүлэв.

- Байрандаа! гэж сүмийн хорооны баатар хариу дуугараад хоёул цайзыг хамгаалахын тулд болох бүхнийг хийхээр хэрэм рүү явав. Дайсны эзэлж амжсан цамхагны эсрэг хаалга хамгийн аюултай газар гэдэгт тэд санал нийлж байв. Тэр цамхаг чухамдаа гол хэрмнээс гүн устай сувгаар тусгаарлагдсан тэр саадыг гэтлэхээс нааш бүслэгсэд хэрэм рүү ойртож чадахгүй ажээ. Хэдий тийм боловч бүслэгдэгсэд анх эхлээд л удирдагчийнхаа төлөвлөсөн бодлыг баримталбал улайран дайрах замаар энэ газарт цайзыг хамгаалагчдын хамгаалж байгаа хүмүүсийг ашиглах брлно гэж де Браси сүмийн хорооны баатар хоёр бодож байлаа. Цайзны хамгаалагчид тоо цөөн тул гэнэт дайрвал түгшүүр зарлах манаач нарыг л хэрмэн

дээр үлдээв. Де Браси гадаа бэхлэлтийн эсрэг хаалгыг хамгаалах, сүмийн хорооны баатар хорин хүн гаргаж аваад хэрэмний довтлох аюулд учирсан аль ч газарт очиход бэлэн байхаар тохиров.

Энэ зуур бүслэгдсэн цайзны эзэн бие махбод сэтгэл санааны шаналгаанд автан үхлүүт хэвтэж байв. Тэрхүү сүсэг бишрэлтэй цагийн гаж буруу маягтны ердийн зуршлаар сүм хийдэд их өргөл барьц өргөн нүглээ цагаатгах гэж сэтгэлээ тайвшруулах юм ч Фрон де Бефэд байсангүй. Хэрцгий шунахай энэ хүний бүх нүглүүд дотор хар амиа хичээх зан гол байр эзлэх тул алт, газар эдлэнгийн үнээр нүглээ золин цагаатгуулахын оронд сүм хийд, хуврагуудаас хол тасархай байхыг дээрд үздэг байв. Огт өөр үндэстэйгээр шүтлэг үгүй болсон сүмийн хорооны баатар, бурханд үл шүтэж тогтсон гурим ёсыг үзэн яддагаа фрон де Беф өөртөө ултайгаар тайлбарлаж үл чадна гэдэг нь найзыгаа буруу ойлгож байлаа. Юу гэвэл сүм хийд энэхүү эд бараагаа хэтэрхий өндөр үнээр зардаг, худалдаанд гаргаж байгаа энэ цагаатгал нь Иерусалим хийдийн ахлах даргын тушаал шиг онц өндөр үнэтэй байдаг эмчид үнийг нь төлөхгүйн тулд уул анагаах ухааныг нь үгүйсгэж байгаа юм гэж Фрон де Беф хариулж чадахсан билээ.

Гэтэл хорвоогийн бүх эд баялаг үнэ цэнээ барах цаг ирж, бээлийн тээрмийн чулуунаас зөөлөнгүй зүрх хилмэгдэн шимшрэв. Бие халууран шаналах нь сэтгэлийн түгшүүрийг улам улам нэмэгдүүлнэ. Амьсгаа хураах энэхэн үед гэнэт сэргэсэн их хилмэгдэл, угийн хэлбэршгүй хатуу авирын зөрүүдтэй тэмцэлдэн өнгөрнө.

- Энэ гэлэнгүүд хаашаа алга болчихдог юм бэ?, хурал номоо асар их үнээр хурдаг лам нар алив ээ? Хөгшин фрон де Беф эд хөрөнгөө өвлөх хүүгээсээ төчнөөн их шимтэй хөрс, билчээр таслан авч хохирсон Анна гэгээний сүм барьж өгсөн хөл нүцгэн санваартнууд одоо хаана байна? Тэр ховдог нохдууд одоо хаана байна? Нэг газар зөөлөн дарс уугаад хөлчүүрч байгаа юу, аль нэг муу адгийн орны хажууд нөгөө илбээ үзүүлээд сууж байгаа бий!... Тэгэхэд тэдний ачит хүний өв залгамжлагч, уул билэг өргөсөн номын дагуу миний төлөө залбирал уншиж суух учитай ач тусыг үл санах муу шаарууд намайг золбин нохой шиг нүглээ наминчлаж, хонхны дуу дуулах боломжгүй үхүүлж байнаа! Сүмийн хорооны баатрыг нааш нь дууд, тэр чинь бас санваартан хүн, нэг юм хийж өгч магадгүй. Үгүй болж гэм диваажин хоёрын алиныг ч үл хэрэгсэх Бриан де Буагильберт дорхиноо чөтгөрт нүглээ наминчилсан нь дээр. Хуучны хүмүүс өөрөө өөрийнхөө төлөө залбирдаг байсан гэж би дуулсан, тийм хүнд хуурмаг этгээдүүдийг гуйх ч худалдаж авах ч хэрэггүй билээ. Харин би зүрхлэхгүй байна гэж бээл ганцаараа үглэнэ.

- Ямар нэг юм зүрхлэхгүй байна гэж Фрон де Беф өөрөө хүлээж байна гэж үү гэж гэнэт орны нь хажууд хэн нэгний чахарганасан дуу гарлаа.

Фрон де Бефийн санаа сэтгэл ихэд үймэрч, сэтгэл нь угийн сэв нүгэл ихтэй болохоор энэ асуултыг сонсохын хамт тэрхүү сүсэгт цагийн ойлголтоор насан барж буй хүнийг хүрээлэн энхжингийн орноо төрүүлж болох буянт сайн бодлоос төөрөлдүүлэхийг хичээгч эрэлхгүүдийн нэгний дууг дуулж байгаа юм шиг санагджээ.

Бие нь зарсхийснээ даруй ердийнхөө эрс шидмэг занг гарган,

- Хэн бэ? Миний үгний хариуд хар хэрээ гуаглах лугаа адил дуугаар хариулж зүрхэлдэг хэн бэ чи? Миний орны дэргэд ирж зогс, чамайг чи харья гэж зандрахад нөгөө дуу хариуд нь:

- Реджинальд фрон де Беф чиний муу зүгийн тэнгэр би байна гэв.

Амьсгаа хурааж буй баатар үүнд, - Чи үнэхээр чөтгөр мөн л юм бол биелсэн дүрээрээ миний нүдэнд үзэгдээд орхи. Намайг айна гэж бүү бодоорой. Эрлэг номон хааны шүүхийг барьж андгайлахад одоо надад төрж байгаа энэ хилмэгдэх сэтгэлтэй урьд хорвоогийн элдэв аюултай тэмцэж байсан шигээ үзэлцэж болдогсон бол тэмцлээс миний үл ухрахыг там энхжин хоёр гэрчилж чадахсан гэв.

Ёозгүй бараг ер бусын нөгөө дуу, - Реджинальд Фрон де Беф чи нүглийнхээ тухай тэрслүү хар амиа хичээдэг болон урсгасан цусныхаа тухай бод. Завхай зайдан Жоныг буурал болсон эцэг өгөөмөр сайхан сэтгэлт ахын нь эсрэг хэн хатгаж байна? гэв.

Чи ер нь эрлэг, лам, чөтгөр хэн ч байлаа гэсэн худлаа хэлж байна! гэж фрон де Беф дуу алдаад, - Жоныг бослого гарга гэж би хатгаагүй, би гануаараа биш. Дундад Английн бүх гүнт мужуудын сор болсон тавь орчим баатар, бээлүүд байсан юм. Улс орны дотор биднээс илүү сайн дайчид үгүй билээ. Зуугийн тал шахуу улсын үйлдсэн Нүглийг би ганцаараа хариуцах гэж үү? Худалч муу, чөтгөр чамайг би жигшиж байна! Яв, дахин ирж бүү зүрхлээрэй. Чи мөн үхэлт амьтан ахуул надад тайван үхэх боломж олго, чи шулам юм болж гэм цаг чинь болоогүй байна гэв.

Нөгөө дуу үүнд, - Үгүй чамайг тайван үхүүлэхгүй. Үхэхдээ чи өөрийнхөө хорт муу үйлийг, энэ ханан дотор тасардаггүй байсан ёолох чимээ, чиний цайзны шалыг нэвчиж байгаа цусны тухай бодох болно гэвэл Фрон де Беф худлаар муухай инээд алдан:

- Чиний аар саар өчүүхэн хорсол миний сэтгэлийг үймүүлж чадахгүй. Бузар явдалт еврейн хувьд миний үйлдсэн зүйл чухамдаа бурхны таалалд нийцсэн үйл мөн. Тэвэл сарацинчуудын цусанд гараа будсан хүмүүс яагаад ариун явдалтанд тооцогддог юм бэ? Миний устгасан саксон гахайнууд бол миний эх орон, миний овог удам миний феодал эзний дайсан байсан билээ. Ха-Ха! За харж байгаа биз. Чи намайг давж чадаагүй. За яав, зугтаав уу? Чиний амыг би таглаж чадаа биз гэтэл түрүүчийн дуу,

- Үгүй эцгийнхээ булай алуурчин чи чадаагүй! Эцгийнхээ тухай бод! Яаж үхсэнийг нь сана! Төрсөн хүүгийн нь гараар асгаруулсан цус найрын өрөөний шалаар нэг бялхаж байсныг санаж үз гэв.

Бээл нилээн удаан дуугүй байснаа – Уухай чи үүнийг бас мэдэх юм уу? Чи лам нарын ярьдгаар үнэхээр юм бүхнийг мэдэж байдаг муу зүгийн тэнгэр мөн байх нээ. Энэ нууцыг би миний өөрийн болоод намайг турхирч гэмт хэрэгт минь хамсаатан болсон бүсгүйн цээжинд үүрд булшлагдсан гэж бодож байсан билээ. Саксон шулам Ульрикийг явж ол. Бид хоёрын гэрч нь болсон тэр хэргийн тухай ганц тэр эмгэн л чамд өгүүлж чадна. Түүн дээр оч. Ульрика түүний шархыг угааж алагдсан биш ердийн үхлээр үхсэн хүний дүртэй болгож билээ. Түүн дээр оч гэж байна шүү би. Тэр намайг уруу татаж энэ бузар хэрэгт түлхээд түүнээсээ илүү бузар тан надад хүртээсэн билээ. Миний энэ эдэлж байгаа шаналгааны амтыг тэр үзэг, тамд

хүртэл үүнээс илүү дор байх гэж үгүй гэв.

Ульрика Фрон де Бефийн ор руу ойртож, - Тэр энэ зовлонг нэгэнт амссан. Энэ гашуун ундааныг эртнээс аван уусаар байгаа бөгөөд одоо чамайг мөн амтлахад хүрснийг үзээд гашуун нь дарагдлаа. Реджинальд чи дэмий шүдээ хавирч, нүдээ эргэлдүүлж байна. Гараа зангидаж заныхын хэрэггүй. Саяхан чиний гар нэрийг нь чи уламжлан авсан цуут овгийн чинь гар шиг ганц цохилтоор бухыг унагааж чадахтай байсан, одоо цаадах чинь минийхээс ялгаагүй дорой болжээ гэхэд,

- Шаарын муу хорон санаат тулам! Үхээрийн ёозгүй шар шувуу чи өөрөө хөнөөсөн хүнээ элдвээр доромжлох гэж ирсэн хэрэг үү? гэж фрон де Беф дуугарлаа.

Ульрика хариуд нь – Тиймээ , Реджинальд фрон де Беф алагдсан Торкиль Вольфгангерийн охин хядагдсан хүүхдүүдийн нь дүү Ульрика би байна. Фрон де Бефүүдийн хараал идсэн удмынхны хөнөөсөн миний эцэг гэр бүлийнхээ нэр төр аль бүхэн минь юу болсны төлөөсийг чамаас чий удам судраас нэхэх гэж би ирээд байна. Миний үзэж өнгөрүүлсэн бүх дарлал доромжлолыг бодож үзээд үнэн ярьж байнаа уу, үгүй юу? хэлээд аль. Чи миний хорон санаатай байсан, би чинийх болохыг хүсэж байна. Чиний амьсгалыг тасартал би чамайг элдэвлэж шаналгах болно гэв.

- Гутамшигт муу буг миний амьсгаа хураахыг чи үзэхгүй! Гэж Фрон де Беф дуу алдаад, - Хөөе Жиль Климент Юстес, Сен-Мор, Стивен! Энэ хараал идсэн муу шулмыг барьж аваад өндөр хэрмэн дээрээс чулууд! Энэ биднийг саксончуудад урваж худалдсан байна. Хөөе Сен-Мор Климент адгийн муусайн хулчгарууд, боолууд та нар хаашаа алга болчихов оо? гэж бачимдахад эмгэн хүйтнээр инээмсэглэн байж:

- За алив, зоригт бээл дахиад тэднийгээ дууд. Албатуудаа дуудаад удсан тухайд ташуур гяндангаар сүрдүүлээч. За хүчирхэг тэргүүлэгч гуай одооноос эхлээд чамд захирагдах, туслах хүн ер үгүй гэдгийг мэдэж ав. Энэ айхавтар чимээг сонсож байна уу гэж цайзыг тойрон дахин оволзох тулалдааны чих дөжрөм чимээ гарахад Ульрика гэнэт дууныхаа өнгийг өөрчлөн, - Энэ хашгиралдаан чиний гэр орны мөхлийг илтгэж байна. Фрон де Бефийнхний олны цус урсгасан гагнасан хүчирхэг чадал чиний хамгаас басамжлан үздэг өстөний гараар үр үндсээрээ ниргэгдэж байна. Тэнд чинь саксончууд байна шүү дээ Реджинальд аа! Муучлагдсан саксончууд чиний цайзны хэрмийг дайран эзэлж байна. Саксончууд чиний бэхлэлт, гал голомтыг дайран хөнөөж байхад чи юундаа нэвшүүлчихсэн боол шиг энд хэвтэнэ вэ? гэв.

- Бурхад, чөтгөрүүд минь гэж шархтай баатар хашгираад, - Миний хуучин чадал тэнхээ ядаж ганцхан хувийн төдий ч болов сэргэж тулалдаж байгаа газарт салгалж хүрээд зэрэг хэргэмдээ тохирсон үхлээр үхэх юмсан гэхэд,

- Тэр тухай эрэлхэг дайчин та бодохын ч хэрэг байхгүй гэж Ульрика хариулаад, - Чи шударга дайчин эрийн ёсоор биш тариачид нүхэнд нь мөчир шатааж утсан үнэг шиг үүрэндээ үхнэ гэв.

- Нүд хорсгосон муу эмгэн чи худлаа хэлж байна! Миний албатууд зоригт сайн эрс, миний

хэрэм өндөр, бат! Саксончууд үй түмээрээ ирж тэдний тэргүүлэгчид нь Хенгинст Хорса нар биеэр байлаа ч гэсэн миний дайчин нөхөд айхгүй. Сүмийн хорооны баатрын дайны уухай болоод, чөлөөт багийнхны хашгиралдах дуу тулалданы чимээг дарж байна. Бид ялалт байгуулж, цэнгэлийн түүдэг шатаахад чи түүн дотор шатна, нэр төрөө барьж андгайлахад чиний бие яс үс цөм шатна! Би харин чамайг хорвоогийн галаас тамын дөлөнд орж, чамаас дор шулам ер төрж байгаагүй чөтгөрийн оронд очсоныг чинь мэдэтлээ амьд байх болно гэлээ.

Ульрика хариуд нь, - Үзэж үнэмшлээ чи юугэж бодно вэ, бод... гэснээ өөрөө өөрийнхөө үгийг таслан, - Үгүй чи хэдий хүчирхэг эр чадалтай, зориг зүрхтэй боловч зайлж чадахаа өнгөрсөн хувь тавилангаа одоо мэдэж авч болно. Чиний энэ тавиланг би дорой гараар бэлтгэсэн хэдий авч тэр шүү. Өрөөн дотуур багширч байгаа утааг хар. Чи үүнийг нүдээ харанхуйлж, амьсгаагаа хураахаар давчдаж байна гэж бодож байж мэднэ. Үгүй, Реджинальд, үүний шалтгаан өөр юм. Энэ өрөөнүүдийн дор хураалттай байдаг мөчрүүдийг чи санаж байна уу? гэхэд фрон де Беф хагартлаа хилэгнэн,

- Бүсгүй чи нээрээ, түүнийг шатаачихсан гэж үү? Тийм байж таарлаа. Цайз тэр аяараа дөлөнд авгжээ! Фрон де Беф дуу алдав. Ульрика үүнд аймаар хүйтэн тоомжиргүйгээр,

- Тиймээ түймэр амархан хөгжиж байна. Хүмүүс гал унтраахаар ухасхийхийн хамт зоригтой дайр гэдэг дохио мөдхөн би бүслэгчдэд өгнө, баяртай Фрон де Беф. Эртний саксончуудын бурхан өнөөгийн эзэд хаадын хэлдгээр бол буг чөтгөр болох Миста, Скогула, Зернебок нар чиний амьсгаа хураахад ирж сэтгэл санааг чинь тайтгаруулагч болог. Ульрика чамайг орхиод явлаа. Харин Ульрика чий бузар үйлийн хамсаатан болж байсан шигээ цээлэлийг чинь хуваалцаж нэгэн замаар одно гэдгийг мэд, сэтгэл чинь жаал тайвширч магад. За ингээд хагацай, үүрд хагацай, эцгээ алагч минь! Энэ танхимын чулуу бүр хэл орж чамайг эцгийгээ алагч гэж шуугилдацгааг!! гэж хэлээд эмгэн өрөөнөөс гарч одон үүдний цоожинд том түлхүүр хоёр дахин эргэхийг Фрон де Беф сонсов. Амь аврагдах өчүүхэн горьдлогыг Ульрика тас хорьж орхилоо. Фрон де Беф ихэд бачимда албат зарц, холбоотнуудаа байдаг чадлаараа дуудаж гарав.

- Стивен, Сен-Мор! Климент, Жиль! Туслаарай авраарай! Зоригт Буагильбер! Эрэлхэг де Браси! Би Фрон де Беф та нарыг дуудаж байна! Урвагч муусайн боолчууд та нарыг би эзэн чинь дуудаж байна! Итгэл эвдсэн махчин баатрууд та нарын холбоотон хань нөхөр чинь байна! Намайг ингэж үхлүүт хаясны чинь төлөөсөнд та нарын хулчгар толгойд хараал хүрэг... Үгүй тэд дуулахгүй байна. Миний дууг тулалдааны их чимээ дарчихаад байна. Утаа улам өтгөрч, шалны завсраар дөл нэгэнт цухалзаж байдаг. Үгүй ядаж ганцхан удаа цэвэр агаар амьсгалах юмсан! гэв.

Цөхрөнгийн туйл болж балартахдаа золгүй тэрээр байлдааны тушаал нэг өгч үл ойлгогдох юм нэг үглэж, өөрийгөө хүн төрөлхтнийг тэнгэр бурхныг бүгдийг харааж зүхэж байв.

- За тэр битүү хар утаан дундаас галын дөл улалзаж харагдана гэж дуу алдаад, - Шулам миний өөдөөс өөрийнхөө дассан нөхцөлийн дор дарч байна. Хий юм чи зайл! Би өөрийнхөө нөхөд үгүйгээр чиний хойноос явахгүй. Цөм энэ цайзыг хамгаалагчид цөм чамд оногдох учиртай. Фрон де Беф ганцаараа чамд автахыг зөвшөөрнө гэж бодож байна уу? Үгүй шүү! Бурхан

шүтээнийг огоорсон сүмийн хорооны баатар завхуул муу де Браси, булай завхай амьтан Ульрика, миний бүх ажил төрөлд тусалсан зарц нар, саксон нохдууд, хараал хүрсэн муу еврей, миний олзныхон цөм бүгд надтай цуг явна... Ха-ха-ха! Гэж тачигнатал хөхрөхөд, хөндий өрөөнүүд цуурайтав. Өөрийн нь солиорсон, хөхөрсөн цуурайг тулалдааны чимээ дарж эс чадсанд фрон де Бефийн дуу хувирч, - Хэн энд хөхрөөд байна? гэж дуу алдав. – Хэн инээв! Ульрика чи юу? Хариул гэм муу шулам! Ядаж ганц үг дуугар, би бүгдийг уучлая. Ганцхан чи л ийм үед инээж чадна, би биш бол шулам биеэрээ л байдаг байх! Зайл! Зайл! гэж хашгичив.

Гэвч бид, бурхан шүтээнийг огоорсон, эцгээ алагчийн амьсгаа хураах зовиурт үзэгдлийг цаашид өгүүлэхээ больё.

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

"Алив урагшаа нөхөд минь тэр сэтэрхийгээр дайрч

Англи эрсийн биеэр энэ сэтэрхийг таглая

- Миний сайн йоменуудаа

...Удам судраараа англичууд

Уг төрх, хүмүүжлээрээ эрэлхэгчүүд гэдгээ үзүүл..."

Шекспир "V Генрих хаан"

Ульрикийн үгэнд Седрик онц найдаагүй хэдий боловч хар баатар, Йомен, Локсли хоёр уул амалсан зүйлийн нь тухай яаран дуулгав. Бүслэгдэж цайзан дотор хэрэгцээ болоход дайран орохыг хөнгөвчилж өгөх холбоотон бүсгүй байгаад тэд баярлав. Хэрмийг дайрч эзлэхийг оролдох хэрэгтэй, харгис хэрцгий фрон де Бефийн гарт орсон олзны хүмүүсийг гаргаж авах ганц арга энэ мөн гэдэгт Хар баатар, Локсли хоёр Седриктэй санал нийлж байв.

- Альфред хааны удам угсаа аюулд учраад байна гэж Седрикийн өгүүлэхэд Хар баатар дээрээс нь:

- Сайн төрөлх авхайн нэр төр, үл бүтэх этгээдийн гарт орсон байна гэв.

- Миний энэ мөрөвчин дээр байгаа гэгээн христофорын хөргийг барьж андгайлахад үнэнч зарц, хөөрхий Вамбагийн амийг л аврах хэрэг байна гэхэд түүий толгойноос ганц үс билээ унагуулахгүйн тулд би гар юмуу хөлөө тасдуулахаас буцахгүй! гэж зоригт Йомен дуу алдав. Даянч мөн:

- Би ч гэсэн ялгаагүй. Салбадайн төлөө, чухамдаа гэвэл өөрийнхөө мэргэжилд бүрэн эзэн болж хундага дарс болгоныг гахайн сайхан хэрчим махнаас илүү амттай, нандин болгож чаддаг тийм тэнэг салбадайн төлөө залбирах тулалдахаас буцахгүй ухаантай гэлэн ямагт олдоно гэж би хэлэх байна нөхөд минь. Залбирал уншихаа мартаж юм уу, шийдэж хэрэглэж чадахгүй болтлоо би түүний төлөө зүтгэнэ! гээд хүнд шийдмээ малчны шилбүүр аятай толгой дээгүүрээ эргэлдүүлэв.

- Ариун явдалт тахилчин та хэрэгтэй үг ярьж байна! гэж Хар баатар сайшаагаад, - Энэ чинь та биш Дунстан гэгээн өөрөө ярьж байгаатай адил үнэнч үг. За ингэхэд зоригт Локсли минь, сайн төрөлт Седрик гуай биднийг даргалан, дайралтанд дагуулж орох цаг болсон юм биш үү? Гэхэд Седрик өөдөөс нь:

- Үгүй би даргалж чадахгүй. Иймэрхүү бэхлэлтийг дайрах, хамгаалах ухаанд би мэргэн хүн биш. Тэргүүн эгнээнд тулалдахад би бэлэн байна. Харин биеэр цэргийн хүн биш цэргийн сахилга батыг сахих болон цайзыг довлон эзлэхэд дадмаг бусыг миний шударга хөршүүд мэднэ гэлээ.

- Тийм болж гэм сайн төрөлт Седрик гуай, харваачдыг даргалах ажлыг би дуртайяа хүлээн авч бурхны мэндэлсэн баярын өдөр тавих гахайн маханд шигтгэдэг хадааснаас цөөн сум хэрэмний цаанаас цухуйсан хамгаалагч бүрт хүртээх аваас миний багийнхны цугларсан энэ царсны мөчрөөс дүүжлэх эрх танд олголоо гэж Локсли өүүлбэл хар баатар хариуд нь,

- Зоригт Йомен та сайхан үг хэллээ. Эндхийн залуусын дотроос жинхэнэ англи баатрын хойноос дагахад бэлэн эрчүүл зохих тоогоор гарч ирвэл би өөрийнхөө эрдэм, тулалдах туршлагаа дуртай хэрэглэн цайзны хэрэм рүү удирдан дайръя. Би өөрийгөө шинэхэн баатар гэж зоригтой хэлж чадна гэжээ.

Үүргээ ийнхүү хуваарилж аваад тэргүүлэгчид дайралтанд орж, үр дүн нь ямар болсныг уншигч авгай нар мэдэх бүлгээ.

Гадаа цамхгийг эзлэн авмагц энэ баярт мэдээг Хар баатар Йомен Локслийд дуулгаад бүслэгдэгсдийг хянуур ажиглан зохих хүчээ хуримтлуулж, бэхлэлтийг булаан авах цаг өгөхгүй байхыг сануулав. Дайсны цайзнаас гарч дайралт хийхийг саатуулах нь баатарт тун чухаг байлаа. Норманы баатруудын бараа бологч туршлагатай дайчдын түрэлтийг зэвсэг муутай, сургууль ер үгүй сай дурынхан тогтоож хүч хүрэхгүйг ойлгож байлаа. Юу гэвэл тэд бүслэгсдээс зэр зэвсгээр давуу төдийгүй зөв арийн сахилга бат, удаан хугацааны цэргийн сургуулийн ачаар бий болдог тайван, итгэлтэй байдлаараа мөн давуу билээ.

Түр амсхийсэн цагийг баатар ашиглан урт сал хийхийг тушаав. Түүгээр шуудууг гатлах санаатай байлаа. Тийм сал хийх гэдэг цаашдын дайралтыг саатуулах боловч тэргүүлэгчид үүнд онц харамсангүйдээр бас Ульрикад бүслэгсдэд амалсан туслалцаагаа үзүүлэх цаг олгож байсан ажээ.

Сал бэлэн болмогц Хар баатар бүслэгсдэд хандан өгүүлсэн нь:

- За цаашаа хүлээгээд байх юм алгаа, нөхөд минь Нар хэвийж байна, та бүхэнтэй дахиад нэг өдөр өнгөрүүлж болохгүй ажил надад байна. Тэгээд ч Йоркоос морин цэрэг дайсанд туслахаар амжиж ирэхгүй бол маш гайхалтай хэрэг болно. Та арын нэг Локсли рүү гүйж очоод харвалтаа зэхэж хэрэмний нөгөө талаас дайрах гэж байгаа юм аятай алгуурхан ойрт гэж хэл. Английн бат эрчүүл та нар надтай эндээ үлдж сал усанд тавихад бэлэн бай. Миний хойноос дүнзэн дээгүүр зоригтой гараад цайзны хэрмийн тэр харагдаж байгаа гол хаалгыг хэмх цохиход тусал. Надтай цуг явах дургүй мөн тохирсон зэвсэгтү нэг чинь урьд цамхгийн дээр гарч юмаа олигтойхон тэлж, эсрэг талын хэрмэн дээр үзэгдсэн хүн бүрийг харваарай. Сайн төрөлт Седрик та үлдсэн хүмүүсийг даргална уу? гэвэл,

- Үгүй шүү! Хервардын сүнсийг барьж андгайлахад тушааж захирч би чаддаггүй хүн, харин чи биднийг хаашаа ч дагууллаа гэсэн тэргүүн эгнээнд тулалдахгүй бол намайг үр сад маань авсанд орсон хойно харааг. Энэ чинь миний мах цусны хэрэг, тэгэхлээр би бүхний урьд явах учиртай билээ гэж саксон тайж өгүүлэв.

Сайн төрөлт саксон та эрэгцүүлж үз. Давгмал, хөө хуяг алин нь ч байхгүй, ганцхан хөнгөн дуулгатай, зэр зэвсэг гэхээс ганцхан жад бамбай хоёртой л байна гэж баатрыг дургүйцэхэд Седрик хариуд нь,

- Тэр тусмаа сайн, энэ хэрэм өөд авирахад хөнгөн байна. Тэгээд ил цээжтэй саксон хүн давгмал ган хуягтай норманаас илүү зоригтойгоор тулалдаанд ордгийг эрхэм баатар танд өнөөдөр үзүүлнэ, та битгий сайрхлаа гэж бодоорой гэв.

- За тэгвэл бурхан өршөөг! гэж баатар дуугараад -- Хаалга онгойлгож сал усан дээр буулга гэв. Цайзны хаалга, суваг руу харсан гадаа цамхагны үүд гэнэт нээгдэв. Салыг усан дээр тавилаа. Дайсныг гэнэт балмагдуулахын чухлыг Хар баатар сайн ухаарч, салан дээр үсрэн гарав. Араас нь Седрик дагалдан нөгөө эргэд шаламгайлан хүрмэгц баатар балтаараа цайзны хаалга руу аянгын цохилт буулгаж гарав. Дээрээс нь буух сум, чулуунаас, урьд бэхлэлтнээс ухрахдаа сүмийн хорооны баатрын устгасан дүүжлүүр гүүр баатрыг нилээд халхлаж байв. Энэ гүүрний зарим банз яс модныхоо хамт хэрэмний дээд талд татагдан сойгдсон хэвээрээ ажээ. Баатрын хойноос дагалдан хөвүүр гүүрээр гарс ирсэн хүмүүст тийм хаалт үгүй тул хоёр нь шууд харвасан суманд алагдаж, бас хоёр нь сувагт унаад бусад нь яаравчлан цамхагт орж хоргодов.

Седрик Хар баатар хоёрын байдал үнэхээр аюултай байлаа. Гадаа цамхагт бүгсэн харваачид цайзыг хамгаалагчдыг сандаргаж хэрмийн нүх ан бүрийг тасралтгүй харван сайтар тусалж байгаагүй бол улам ч их аюултай байхсан билээ. Гэхдээ л Хар баатарт тулсан аюул хурам бүрт ихэссээр байлаа.

--Та нар ичихгүй байна уу? гэж де Браси цэргүүдээ зандран, - Энэ муу хоёр нохойг хэрэмний дор ингэж эзэгнүүлж байж та нар яаж харваачи гэж нэрлэгдэг юм бэ? Хэрэмний дэд шүднээс ховхолж доош нь унага. Царил, хөшүүрэг олж ирээд энэ шүдийг ховхол гэж ирмэгээс гадагшаа цөмөрсөн нэг том тоосгон шовгорыг заав.

Энэ үед Ульрикийн Седрикт ярьж байсан улаан дарцаг өнгийн цамхагийн цонхоор дэрвэхийг бүслэгсэд үзлээ. Зоригт Йомен Локсли урьдах цамхагт ажил хэрэг ямар болж байгааг үзэхээр хүрч ирээд тэр дохиог түрүүлж харлаа.

- Ялгуулсан Георгий! гэж хашгираад, - Георгий гэгээн английн төлөө байна! Зоригт Йоменууд урагшаа! Баатрыг та нар юунд сайн төрөлт Седриктэй орхичихсон юм бэ? Хөөе гэлэн, хэнэггүй толгой чи эрхийнхээ төлөө яаж тулалдаж чаддагаа үзүүлээч! Эрэлхэг йоменууд урагшаа! Цайз манайх боллоо. Бэхлэлтэн дотор бидэнд холбоотон бий. Улаан дарцгийг харж байна уу? Торкильстон цайз биднийх боллоо. Нэр төр, олз омгийг бодогтун! Ганцхан сайн хүч гаргаад дайрахад л цайз биднийх болно! гэв.

Ингэж хэлээд Локсли нумаа тэлэн де Брасийн тушаалаар асар том чулууг Седрик Хар баатар хоёрын толгой дээр унагаах санаатай хэрмэн дээгүүр хөдөлгөж байсан нэг дайчныг шувт харвав. Бас нэг цэрэг үхэж байгаа нөхрийнхөө гараас хэрэглэж байсан царилыг нь шүүрч аваад чулуун шүдний доогуур оруултал мэргэн сум дуулгыг нь нэвт тусан алж, хэрэмний хашилган дээгүүр даван устай суваг руу ойчив. Аймшигт харваачды сумнаас ямар ч хуяг дуулга аврахгүйг үзээд бусад дайчид балмагдаж эхлэв.

- Муусайн шаарууд айгаа юу? Алив тэр хөшүүрэг нааш нь аваад аль гэж де Браси хэллээ. Де Браси царил шүүрч аваад чулууны доогуур шургууллаа. Тэр нь асар том, хүнд тул доош унах ахуул бүслэгсдийн халх болж байсан дүүжлүүр гүүрний тулгуурыг хуга цохин сувгаар гарах завийг живүүлэхээр байлаа. Хүмүүс цөм хир аюултайг үзэж, хамгийн зоригтой эрчүүл

тэдний дотор эрэлхэг даянч ч далан дээр гарч зүрхлэхгүй байлаа. Локсли гурван удаа де Брасийг харвахад сум тухай бүр ган хуягнаас халт үсэрнэ.

- Энэ Испанийн хуягийг чөтгөр аваасай гэж Локсли амандаа үглэн, - Англи дархны хийсэн хуяг байсан бол миний сум зүгээр аль эрт торго юм уу өрмөг аятай нэвглээд орчих байсан гэснээ... хөөе, нөхдөө! Найз нараа! Сайн төрөлт Седрик, буцаагаарай! Наад чулуу чинь унаг! гэж байдаг чадлаараа хашгирав.

Баатрын үүд эвдэж байгаа балтны дуу байлдааны хорин бүрээний чимээг дарахуйц чанга байсан болохоор цаадуул нь дуулсангүй. Тулж байгаа аюулыг Седрикт мэдэгдэх юм уу хамт үхэхээр үнэнч Гурт салан дээр харайж гарсан хэдий авч энэ сэрэмжлэлт хэт хожимдох агсан билээ. Юу гэвэл том аварга том чулуу нэгэнт ганхаж эхэлсэн болохоор де Браси доош нь унагаачих байсан авч сүмийн хорооны баатар ирж чихэнд нь:

- Хамаг хэрэг өнгөрлөө де Браси цайз шатаж байна гэж хэллээ.

- Үгүй чи солиоров уу? гэж баатрыг дуу алдахад,

- Бүх баруун тал галд автлаа. Би унтраах гэж оролдоод үзсэн нэмэр алга гэв.

Энэ айхавгар мэдээг Бриан де Буагильбер өөрийн нь үндсэн гол шинж болсон шийдмэг амгалан байдлаар дуулгасан авч гайхаж хоцорсон нөхөр нь өөрөөр хүлээж авлаа.

- Гэгээн шүтээн минь! Одоо тэгээд яах вэ? Лимож дахь Николай гэгээнд алтан цөгц бүтээж өгөхийг амлая... гэтэл сүмийн хорооны баатар үгийг нь тасоан:

- Андгай тавихаа зогсож миний үгийг дуул. Хүмүүсээ авч доошоо буун гарч довтлох маягтай хаалгаа нээ. Гадаа салан дээр хоёрхон хүн байгаа тэр хоёрыг шуудуу руу түлхэж орхиод урьд цайз руу дайр. Тэр үеэр би гадаа хаалганд хүрч амжаад цамхгийг цаад талаас нь дайрая. Энэ бэхлэлтийг бид ахин эзэлж чадвал биднийг тэнхрүүлэхээр иртэл хамгаалан байж чадах юм уу, адаглаад ашигтай нөхцөлөөр бууж өгч болно гэлээ.

- Энэ чинь сайн санаа байна. Би үүргээ биелүүлнэ... Харин сэмийн хорооны баатар чи надаас урвачихгүй биз? гэж де Браси өгүүлэхэд Буагильбер хариуд нь:

- Май, миний гар бээлий хоёр энэ байна, урваж мэхлэхгүй. Харин яарах хэрэгтэй шүү! Бушуулж үзээрэй бурхан минь! гэв.

Де Браси хүмүүсээ яаралтай цуглуулж, доош гарах хаалга руу даруй очоод цэлийтэл нэхийг тушаав. Энэ тушаалыг биелүүлэхийн хамт Хар баатар аварга чадлаараа түрий барин де Браси болоод цэргүүдий нь эсэргүүцлийг үл хайхран дотогш дайран оров. Түрүүчийн хоёр хүн дороо нам унаж, бусдыг зогсоох гэж дарга нь хэдий оролдсон боловч дийлдэлгүй гэдрэг түрэгдсээр байлаа.

- Хар малууд! гэж де Браси хашгираад, - Бидний амь гарах ганц замыг та нар хоёрхон хүнд алдах гэж үү? гэхэд нэгэн хөгшин цэрэг хар баатрын цохилтноос дальдран зайлж:

--Үгүй энэ чинь чөтгөр биеэрээ байна шүү дээ гэв. Де Браси унтууцан - Чөтгөр биеэрээ байлаа ч гэсэн дээ! Чи тэгээд түүнээс там руу загтаж зайлах гэсэн юм уу? Цайз шатаж байна, новшнууд минь! Зориг нэмцгээ, үгүй бол намайг урагш гарга, тэр баатрыг би өөрөө дарая гэлээ.

Үнэхээр энэ өдөр де Браси баатар хүн гэдэг нэрээ хадгалж, дотоодын дайсагналт тэр аймшигт үед олж авсан нэр цуундаа тэнцэхүйц эр гэдгээ үнэхээр үзүүлэв. Хаалганы наадах хэрмийн дугуй адартай гудамжинд хоёр баатар халж үзэлцэв. Де Браси илдээр, Хар баатар хүнд балтаар хоёр биеэ улайран цавчих чимээ чулуун хэрмэнд нүргээнтэй гэгч цуурайтана. Эцэстээ де Браси бамбайгаараа хальт хаасан авч асар хүчтэй цавчуулаад чулуун шалан дээр тэрийн ойчив.

- Де Браси бууж өг гэж Хар баатар дуулганы хаалтан дээр нь аюулт чинжаал далайн өгүүлэв. (Иймд чинжаалаар баатрууд ялагдсан дайсны амийг таслах заншилтай тул энэ зэвсгийг нигүүлслэлийн хутга гэж нэрлэх бүлгээ)

- Морис де Браси бууж өг, эргэлзэх юмгүй дага, эсвэл чиний үхэх цаг иржээ гэлээ.

- Үл таних ялагчид бууж өгөх дургүй байна. Нэг бол нэрээ хэлж орхи эсвэл амийг минь тасал даа. Морис де Браси нэр усгүй ерпийн нэг хөдөөх эрд бууж өгсөн гэж хэн ч бүү яриг гэж де Браси сулхан дуугарав.

Дийлдсэн дайчны чихэнд Хар баатар хэдэн үг шивнэсэнд норман уул хямсгар, зөрүүд байдлаа даруй орхин хэдий баргар уруу царайлавч бүрнээ хүлцэн дагах болж,

--Бууж өгөн олзлогдоё гэвэл дийлсэн баатар,

- Урьд цамхагт очоод манай цаашдын тушаалыг хүлээж бай гэж захирангуй дуугарав.

Де Браси үүнд – шархтай олзлогдоод байгаа Уильфред Айвенгод даруй туслахгүй бол шатаж байгаа цайзны дотор үхнэ шүү гэдгийг эхлээд өөрт чинь дуулгая гэхэд Хар баатар,

- Уильфред Айвенго гэнээ! гэж дуу алдан, - Олзлогдоод үхэх болж байнаа! Түүний толгойтой үснээс ганц ширхэг галд өртсөн байвал энэ цайзныхан цөм надад амиараа төлөх болно, аль өрөөнд байгааг заагаад аль гэв. Тэр харагдаж байгаа ороомог шатаар дээшээ гарахад түүний өрөө рүү хөтлөөд оруулна... Таныг таалбал би заагаад өгье гэж хүлцэнгүй дуугаар өчихөд,

Энэ хоёр тулалдаж, дараа нь ийнхүү хэдэн үг солих зуур Седрик гол нуруу нь даянч болсон бүлэг дайчид тэргүүлэн де Брасийн самгардаж, цөхрөнгө байдалд орчихсон цэргүүдийг хавчин мэгдүүлэхэд зарим нь өршөөл гуйж бусад нэг нь эсэргүүцэхийг дэмий оролдон ихэнх нь дотоод хашаанд орж амь зулбалаа. Де Браси өөрөө босож дийлэгчэ гунигт харцаар үдэн,

- Тэр надад итгэхгүй байна! Үгүй би ямар түүний итгэлийг хүлээх юм хийсэн биш дээ гэж аман дотроо үглэнэ.

Шалан дээр хэвтэж байсан илдээ авч дагаж буусны тэмдэг бологон дуулгаа тайлаад суваг

дээгүүр гаран илдээ йомен Локслийд гардуулав.

Энэ зуур түймэр улам газар авч улбар туяа нь Ревеккагийн Айвенгог асарч байгаа өрөөнд алгуураар тусах боллоо. Дахин оволзсон. Тулалдааны чимээ баатрын нойрыг даруй сэргээв. Түүний чухалчлан гуйснаар, асрамжтай сайн сувилагч тулалдааны явцыг ажиглах, хэрмэн дор юу болж байгааг хэлж өгөхөөр цонхны дэргэдэх байраа эзлэв. Гэтэл хамаг юм нэг хачин униарт автаад хэсэг зууртаа хүүхэн юу ч харж чадсангүй. Сүүлдээ бөөн хар утаа өрөөнд урсан орж ирж тулалданы чих дөжрөм чимээг үл харгалзан "ус, ус!" гэж хашгиралдах дуулдахад тэд шинэ аюул тулгарч байгааг мэдэв.

- Цайз шатаж байна! Түймэр гарчээ! Бид яаж амь гарах билээ? гэж Ревекка хэлэхэд,

- Ревекка чи гүй, амиа авар, надад одоо аврал нэгэнт алга гэж Айвенго өгүүлбэл хүүхэн хариуд нь,

- Би чамаас холдохгүй, цуг үхье. Эсвэл цуг аврагдай. Агуу их өршөлт бурхан минь, эцэг минь, эцэг минь! Түүнд ямар гээч хувь тавилан оногдох бол? Гэлээ. Энэ үеэр үүд цэлийтэл нээгдэж сүмийн хорооны баатар босгон дээр зогсож байх нь тун аймаар дүртэй байлаа. Алтлагдсан давтмал хуяг нь цөм цөм цохигдож цусанд будагдсан, дуулган дээрх өдний зарим нь таслагдаж зарим нь хуйхлагджээ.

- Ревекка чамайг би арайхийж оллоо. Чамтай жаргал зовлонгоо хуваана гэсэн амандаа хүрч байгааг чи одоо харж байгаа биз? Бидэнд амь гарах ганц зам үлдсэн, чамд тэр замыг зааж өгөхийн тулд арав гаруй бэрхшээл саадыг давж ирлээ. Босоод даруй миний хойноос яв гэж түүнийг хэлэхэд,

- Би ганцаараа явахгүй. Чи үнэхээр бүсгүй хүнээс төрсөн чамд нигүүлсэнгүй сэтгэлийн дусал ч болов байдаг, хэрэв чиний зүрх наад төмөр хуяг шиг чинь хатуу биш ахуул миний хөгшин эцэг, энэ шархтай баатрын амийг аварч үз гэлээ.

Сүмийн хорооны баатар ердийн тайван ажиггүй байдлаар, - Алив баатар эрх хүн өөрийнхөө хувь тавиланд, эрт мэс юм уу, галын аюулд үртэн байлаа ч гэсэн захирадах ёстой. Тэр еврейг яадаг санж вэ надад ямар хүртээл байна вэ? гэж хариулсанд Ревекка өөдөөс нь:

- Хэрцгий дайчин чамаар амиа авруулсанд орвол галд шатаж үхсэн нь дээр! гэж дуу алдав.

- Ревекка чи хэрхэхийг сонгож шийдэхгүй, нэг удаа чи намайг ухруулсан, үхэх үйлтэй хэн боловч намайг хоёр дахин ухрааж чадахгүй гэж хэлээд айж чарлаж байгаа эмэгтэйг шүүрэн хойноосоо Айвенгогийн цухалдан хашгирах, зандрах, сүрдүүлэх, харааж зүхэхийг хайхралгүй гарч одов.

- Сүмийн хорооны нэр төрийг гутаасан адгийн муу нохой! Наад хүүхнээ даруй тавь! Урвагч Буагильбер! Энэ бол би, Айвенго чамд тушааж байна. Адгийн хар новш! Чи үүнийхээ төлөөсийг надад цусаараа өгөх болно! гэж хашгирав.

- Хэрэв чиний хашгирахыг дуулаагүйсэн бол Уильфред чамайг би олохгүй нь байна шүү гэж

Хар баатар өгүүлсээр энэ үеэр өрөөнд нь орж ирэв.

Уильфред өөдөөс нь, - Чи жинхэнэ баатар хүн юм бол саяны тэр хүүхнийг хулгайлсан хүний хойноос гүй. Ровена авхай, сайн төрөлт Седрик хоёрыг аварч үз. Миний тухай бүү санаа зов гэлээ.

Дүүжлээстэй цоожин сүлдэт баатар үүнд, - Бүхнийг дэс дараагаар хийнэ. Одоо харин чиний ээлж гээд Айвенгог тэвэрч, сүмийн хорооны баатар Ревеккаг аваад явсан шиг хялбархнаар өргөн хаалга хүртэл гүйж очоод хоёр Йоменд түүнийг асруулахаар өгөв. Өөрөө бусад олзныхныг аврахаар эргэж цайз руу ухасхийв.

Нэг цамхаг бүхлээрээ дөлөнд авгаж, бүх цонх, харвах нүхээр гал улалзана. Харин цайзны бусад хэсэгт нуман адар, хананы нь зузаан галыг саатуулж байв. Эндхийн чөлөөнд түймрийн дөлнөөс бараг илүү аймшигтай, хохироон сүйтгэгч хүмүүсийн уур хилэн дүрэлзэв. Бүслэгсэд цайзны хамгаалагчдыг өрөө өрөө дамжуулан шахан хөөж цусыг нь урсган, дарангуйлан эзэрхэгч фрон де Бефийн хэрцгий дайчдын эсрэг эртнээс аван хуримталсан өшөөгөө тайлж байв. Ихэнх нь амьсгаагаа тасартал үзэлцэж, цөөн нэг хүн өршөөл гуйвч цөм харагдаж байлаа. Хүн ёолох, зэр зэвсэг хангинах чимээ агаар доргиулж, үхэж байгаа шархадсан хүмүүсийн цуснаас шал хальтрамтгай болжээ.

Энэ бүх хөл үймээн дуун Седрик Ровена авхайг эрж бүх цайзаар гүйхэд үнэнч Гурт эзнийхээ хойноос даган түүн рүү чиглэсэн илд жадыг зайлуулан хувь бүрдийг амь дүйж явлаа. Ровена авхай амь гарах горьдлого бүрэн тасарч цөхөрч гүйцээд зайлах заяагүй болсон үхлийг хүлээн цээжиндээ загалмай бат тэврээд сууж байхад нь сайн төрөлт саксон тайж хүмүүжүүлэгч бүсгүйгээ азаар олж авлаа. Ровенаг Гуртийн хамгаалалтанд өгч гадаа цамхагт хүргэхийг тушаав. Тийшээ очих зам дайснаас чөлөөлөгдсөн, галд автаагүй байлаа. Энэ ажлаа дуусгаад шударга сэтгэлт Седрик саксон хаадын эцсийн үр угсаа болох хүнийг ямар ч үнээр гэсэн аврахыг хатуу шийдэн анд нөхөр Ательстаныг суллахаар яарав. Гэвч түрүүн өөрөө хоригдож байсан эртний танхимд түүнийг хүрэхээс өмнө овгой Вамба өөрийгөө хамт хоригдож байсан хүнийхээ хамт суллаж амжжээ.

Байлдааны чимээ шуугиан тулалдаан ид оволзож байгааг илтгэхийн хамт Вамба байдаг чадлаараа "Ялгуулсан Георгий гэгээн минь! Георгий гэгээн багш минь. Английг өршөө! Ура, бид дийллээ!" гэж хашгичин, үүнийгээ улам ч сүртэй болгохын тулд хориглож байсан танхим дэх зэвэрсэн зэр зэвсгийг хангинуулж гарчээ.

Хажуу өрөөнд нь байсан манаач Вамбагийн дэгдээсэн шуугианаас айж, гадаа хаалгыг тэлж хаяад дайсан хуучн их танхимд дайран орсон тухай сүмийн хорооны баатарт дуулгахаар гүйж одлоо. Тэр зуур олзныхон онцын саад үгүйгээр уул хажуу өрөөгөөр дамжин тулалдааны шувтрага болж байсан цайзны гадаа хашаа руу гарав.

Ихэмсэг Буагильбер цайзыг хамгаалагч цөөн тооны морьтой, явган дайчдаар хүрээлэн морьтойгоо байж байлаа. Тэд нар цуутай удирдагчаа тойрон хүчээ нэгтгэсэн нь энэ ажээ. Дүүжлүүр гүүрийг Буагильберийн тушаалаар буулгасан боловч дайсан эзэлжээ. Цайзны энэ хэсэг рүү түрүүн зөвхөн холоос сум тавьж байсан харваачид одоо хамгаалагчдын зугтаах замыг таслах, цайзыг шатаж гүйцэхээс өмнө олз омогноос хувь хүртэхийн тулд хаалга руу

дайрлаа. Энэ үеэр гадаа бэхлэлтийн зүгээс дайрч ирсэн бүслэгсдийн хагас дотоод хашаа руу дайран орж, амьд үлдсэн цайзны хамгаалагчид руу улайран довтлов. Ийнхүү тэд урьд хойт хоёрт хоёр талаасаа хавчигдав.

Гарцаагүй хавчигдаж зориг орж, аймшиггүй зоригт тэргүүлэгчийнхээ үлгэрээр урамшсан цайзны амьд үлдсэн хамгаалагчид хэдий тоогоор цөөн авч туйлын эрэлхгээр үзэлцэв. Тэд зэр зэвсэг маш сайн тул түрж байгаа олон бүслэгсдийг хэд хэдэн удаа ухраав. Сарацин боолчуудын нэгний морийг унасан Ревекка Буагильберийн жижиг багийн дунд байх бөгөөд сүмийн хорооны баатар орчин тойронд болж байгаа их хөл үймээнийг хайхралгүйгээр бүсгүйг аюулд учруулахгүйг цаг ямагт эрхэмлэж өөрийгөө хамгаалахыг үл хайхран ган тоногт гурвалжин бамбайгаа Ревеккагийн урьд барьж байлаа. Үе үе өөрийнхөө дайчин уухайг хашгиран урагш ухасхийж довтлогсдын түрүүчээс хэдийг хөсөр унагаад даруй бүсгүй рүү эргэж ирнэ.

Уншигч авгай нарын мэддэгчилэн Ательстан туйлгүй залхуу боловч аймхай биш эр билээ. Сүмийн хорооны баатар ингэтлээ чухалчлан хамгаалж байгаа морьтой бүсгүйн барааг хараад Ровена авхай мөн болохыг таниж эсэргүүцлийг үл харгалзан Буагильбер түүнийг хүчээр авч явах гэж байна гэж бодлоо.

- Эдуард гэгээний сүнсийг барьж андгайлахад биеэ тоосон энэ баатраас би Ровена авхайг булааж авна. Тэр миний гарт үхэх болно! гэж Ательстан дуу алдав.

- Та юу хийх гэж байнаа? гэж Вамба хашгираад – хүлээж үз. Хэт яарвал амьтны доог болно. Тэр чинь Ровена авгай огт биш болохыг андгайлъя. Хар л даа урт хар үстэй байна шүү дээ. За та нэгэнт хар цагааныг ялгаж чадахгүйгээс хойш өөрөө л учраа олж үз. Би таны хойноос дагахгүй. Хэнийг нь мэдэхгүй хүний төлөө ясаа яйчуулахыг больё. Үгүй та ядаж хуяг байхгүй, бодож үзээч, ган сэлэмний ирнээс торгон малгай хэзээ халх болж байсан юм бэ. За та хэт болчимгүй загнаж байж тархиа хагалуулна гэсэн үг дээ. Бурхан таныг өршөөг, зоригт Ательстан гуай! гээд барьж тогтоох санаатай зуурч байсан цамцны нь хормойг тавьж орхив.

Ательстан үхэж байгаа дайчны гараас шийдмийг нь даруй шүүрэн авч баруун зүүнгүй эргүүлэн сүмийн хорооны баатрын баг руу гүйлээ. Цохих бүрдээ цайзны хамгаалагчдын нэгийг хөсөр өнхрүүлэх нь гэнэтийн их хилэнд автан улайрсан төдий их чадалтай хүнд хялбархан ажил ажээ.

Төдөлгүй Буагильбер хоёр алхмын газарт хүрч,

- Итгэл эвдэгч сүмийн хорооны муу баатар чи наашаа эрэг! Чи гар хүрэх хувьгүй тэр бүсгүйг даруй нааш нь өг! Хуурамч, муу дээрэмчин чамайг наашаа эрэг гэж байна шүү! гэж чанга хашгирав.

- Муу нохой гэж Буагильбер шүдээ чахартал зуун өгүүлээд, - Сионы хийдийн баатруудын ариун хороог алдах болох муу үгээр дайрах гэдэг юу болохыг чамд үзүүлнэ дээ? гэв.

Ингэж хэлээд морио саксон тайж руу эргүүлж, хойт хөл дээр нь цоройлгон өөрөө дөрөөн дээрээ босон морио дахин урьд хөл дээрээ буухад хүндийн жинг нь ашиглан Ательстаны

толгой руу аймшигтайгаар цавчлаа.

Торгон малгай ган илднээс хамгаалж чадахгүй гэж Вамба үнэн өгүүлжээ. Төмөрлөсөн шийдмээрээ илдийг хаах гэж Ательстан дэмий оролдоод үзэв. Сүмийн хорооны баатрын хурц сэлэм түүнийг саваа шиг тас цавчаад золгүй саксон тайжийн толгой дээр буулгахад тэрээр хөсөр үхэтхийн ойчив.

- Уухай! Сүмийн хорооны баатрыг доромжилсон хүнийг бид ингэж залхаадаг юм! гэж Буагильбер дуу алдаад, - Надтай хамт амь гарахыг хэн хүсэж байна? гэж хашгирав.

Тэгээд дүүжлүүр гүүр рүү ухасхийн зогсоох гэж оролдсон харваачдыг сариулав. Түүний хойноос сарацинууд мордож амжсан тав зургаан хүн давхилаа. Баатар түүний багийн хойноос сум адил нүүгэлтэн хөвсөн тул ийнхүү ухрах нь маш осолтой байлаа. Гэвч Морис де Браси түүрүүнд тохиролцсон ёсоор эзэлж чадсан байж магад гэж горилон цамхаг руу очиход нь энэ саад болж чадсангүй.

- Де Браси, де Браси чи энд байна уу? гэж хашгирахад,

- Байнаа, гэхдээ би олзлогдсон гэж цаадах нь хариу дуугарав.

- Би чамайг аварч болох уу? гэж Буагильбер дахин асуувал де Браси өөдөөс нь:

- Үгүй би бууж өгч олзлогдсон, хэлсэн үгэндээ хүрнэ. Өөрөө амьд гарч үз. Шонхор нисэж ирсэн. Англиас гарч далайн цаана оч. Чамд цааш нь өөр юм хэлж зүрхлэхгүй байна гэв.

Сүмийн хорооны баатар үүнд, - За яамай, дуртай бол үлд. Харин би хэлсэн үгэндээ бас хүрэхийг санаарай. Ямар ч шонхор нисэж ирлээ ч гэсэн Темплстоугийн цайзанд, түүнээс хоргодож болно байх. Тэр чинь хоргодох багтай газар, үүрэндээ очиж байгаа цахлай адил би тийшээ явлаа гээд цааш давхин одоход бараа бологсод нь дагалдав.

Сүмийн хорооны баатрыг явсны дараа цайзны хамгаалагчдаас түүнтэй цуг амь зулбаж чадаагүй нь нь өршөөл үзэх найдлага үгүй болохоор амь тавин тэмцэв. Гал бүх байшингаар түргэн тархлаа. Гэнэт түймэр тавьсан эзэн Ульрика өнцгийн нэг цамхгийн дээр эртний домогт гардаг өс хонзонгийн дагина шиг гарч ирээд бөөгийн мөргөлтэй байх цагт саксоны үлгэрчид тулалдааны талбар дээр аялдаг байсан цэргийн дууг чангаар дуулав. Ульрикагийн урт үс задгай, туг тугаараа толгойг нь тойрон хийсэх бөгөөд өшөө хонзон авч, хөлгүй баярлаж бах нь сэтгэл ханасны цог нүдэнд нь гэрэлтэн хүний амьдралын замыг нэхэн зогсоох ид шид бүхий эгч дүү шулмуудын нэг шиг ээрүүлээ даллах ажээ.

Эргэн тойрон гал дүрэлзэн талбай дээр тулалдаан болж байхад Ульрикагийн дуудсан аймшигт дууны хэдэн бадаг олны ам дамжин хадгалагдаж үлджээ.

Эрэлхэг хөвгүүд,

Үзэсгэлэн гоо охидоо

Илдээ хурцалж

Бамбараа асаа!

Барьсан том хутгаараа бид

Хурим найрын мах огтлох гээгүй

Бамбарынхаа хурц дөлөөр бид

Шинэ бэрийнхээ дэрийг гийгүүлэх гээгүй

Гагцхүү илдээ хурцал,

Бамбараа асаацгаа гэж

Гай таригч муу ёртнууд

Бархиран хашгирч байнам.

Тэртээх үүлнээ цайзан дээгүүр

Морьтой баатрын хөлөг тодорно.

Тэнгэрээр морилогч чи сэтгэлээ бүү зовоо

Хуримыг чинь бэлтгэж байна би

Ордонд маань олон дайчин харь омгоос ирцгээнэ.

Одоогоор цайз минь

Хав харанхуйд хучигдан байна

Хэдий үүл манан дор

Цөм дарагдан байвч

Хэмжээлшгүй түймрийн дөл

Цусан өнгөөр дүрэлзэх болно

Хэрэм пайз шатаагч тэр хүн

Дөлтэй тугаар галлан байна

Хэцүү тулалдааны талбарт тэр хүн

Илд бамбай харшуулах нэн ч дуртай

Шархнаас хөөсрөн гарах цусыг

Шамдаж долоохдоо тун ч хорхойтой

Илдний үзүүр дуулгыг хага ярж

Ирт жад хуягийг цоо нэвтлэн

Орд харш цугаар түймэр авган

Орон цайз хүчинд эрсдлээ

Илд мэс зүүсэн та нар

Аз заяанаасаа бүү сүрд!

Илд мэс улаан цусыг

Архи дарс мэт увал ууг!

Эрэлхэг тулааны талбарт

Галан дунд чадлаа үз!

Эргэх халуун цус юугаан

Гүйж л байгаа цагт

Илдээ чанга атган

Энэрэх, имээхийг бүү мэд!

Удахгүй өшөө авалцах цаг

Улирч аяндаа өнгөрөх болно

Өшиж хонзогнох сэтгэл намдмагц

Өөрөө би ч нөхцөж арилнаа.

Дөл хөөрч, бүх саадуудыг даван үдшийн тэнгэр өөд алсаас харагдах нэгэн том галан багана болон дүрэлзэнэ. Өндөр цамхагууд дараа дараагаар нурж, шатанхай дээвэр, нуруу мод сэлт доош унаж ирнэ. Тулалдагчид цайзны хашаанаас шахагдан гарчээ. Ялагдагсдаа амьд үлдсэн цөөн хүн зэргэлдээ ой руу амь зулбан зугтаажээ. Дийлэгсэд, өөрсдийн нь болон зэр үэвсгийг нь улбар туяагаар гэрэлтүүлж байгаа түймэр рүү гайхсан, тэр ч байтугай сүрдсэн байртай харна. Саксон бүсгүй Ульрикагийн гунигт дүрс өөрийнхөө сонгож авсан тавцангийн орой дээр удтал харагдсаар байв. Эмгэн бах ханаж баярлан хашгирч, тавьсан галынхаа эзэн аятай гараараа даллаж байлаа. Сүүлдээ энэ цамхаг мөн аймшигтай нижигнэн нурж, дарлан

эзэрхэгч дайсныг нь хөнөөсөн дөлөнд Ульрика өөрөө үхлээ. Бүх цэрэг эрчүүл ихэд хилмэгдэн дуу гарах чадалгүй болж, хэдэн хувь орчим загалмайн залбирахаас өөрөөр хөдөлж эс чадна. Дараа нь Локслийн дуу гарч:

- Йоменууд баярлагтун, эзэрхэн дарлагч этгээдүүдийн голомт сөнөлөө! Олзоо бугат хамрын тэндэх ариун царс руу, цуглааны газарт аваач. Үүрээр бид эд бүгдийг хоорондоо болоод өшөө хонзон авах энэ их хэргийг гүйцэтгэхэд тусалсан холбоотнуудтайгаа шударгаар хуваан авна гэлээ.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хорвоогийн улс бүрд жам ёс гэж буй

Хотын горим, хаад эздийн зарлиг гэж бий

Ах захын ёс ойн дээрэмчдэд ч буй

Адамын үед харин тийм юм байсангүй.

Зөн олныг нэгтгэн атгахын тулд

Журам ёс гэгч хожуухан үүсчээ...

Эртний жүжгээс

Өглөөний нар царсан ойн цоорхойг гийгүүлэв. Ногоон навч дээрх шүүдрэн дусал сувд адил бөнжийн гялалзана. Согоо, өтгөн ширэнгэнээс янзгуудаа дагуулан ил цоорхойд гарч ирэхэд сүргийн түрүүнд ихэмсэг сүртэй алхаж яваа сайхан бугыг хэтэж олз болгох ганц ч анчин ойр хавьд байсангүй.

Дээрэмчид бугат хамрын тэндэх ариун царсны дэргэд цугларчээ. Өчигдрийн бүслэлтийн дараа тэд зарим нь нойроор, зарим нь дарсаар тэнхээгээ сэлбэй, олонхи нь тулалдааны энэ тэр учирлаас ярих бусдын яриаг чагнах юм уу олзоо бүртгэн шөнийг өнгөрүүлэв.

Олз омог тун үлэмж. Түймэрт их юм шатсан авч зоригт сайн эрчүүд мөнгөн сав, үнэт зэр зэвсэг, гоё сайхан хувцас хунар ихийг дээрэмдэж амжжээ. Тэгэхдээ хэн нь ч нэг бөөн овоолсон олзоо хуваалцахаас өмнө өчүүхэн нь ч нэг бөөн овоолсон олзоо хуваахаас өмнө өчүүхэн ч зүйл хувьдаа дур мэдэн завшихыг хичээсэнгүй.

Өвгөн царс модны до цуглааны газар байв. Тэгэхдээ энэ нь Гурт Вамба хоёрын анх түрүүн Локслийг дагуулж ирдэг мод биш байлаа. Энэ царс Торкильстоны цайзаас хагас мод хиртэй газарт ой бүрхсэн хөндийд байх ажээ. Аварга модны сүлжилдсэн мөчрийн дор зассан хүндэт суудлаа Локсли эзлэн харьяат ойн иргэд түүнийг тойрлоо. Хар баатрыг баруун гарынхаа суудалд залж, зүүн гартаа Седрикийг суулгав.

- Сайн төрөлт зочид та бүхэн миний хэт зоримгийг уучлаарай, энэ чинь миний хаанчлалын газар, тэгээд өөрийн эзэмшил газрын харьяанд эрх мэдлээ хэн нэг хүнд шилжүүлэн өгвөл миний зоригт албатуудын хүчирхэг чадлын минь тухай доогуур ойлголттой болж мэдэх билээ гэж Локсли хэлээд,

- Бурхан минь, манай хувраг хаана байна вэ? Христос шашинтан хүмүүс ажлынхаа өдрийг мөргөлөөр эхэлвэл зохистой билээ гэв.

Тэгтэл Копмангерстийн тахилыг харсан хүн ер үгүй боллоо.

Дээрэмчдийн удирдагч үүнд, - Бурхан өршөө! Манай гэлэн дашмаг дарстай жаахан саатан суусны улмаас л үгүй байгаа болов уу гэж найднам. Цайзыг эзэлсний дараа түүнийг харсан хүн байна уу гэвэл дээрэмчин хариуд нь:

- Нэгэн зоорины үүдтэй ноцолдон Фрон де Бефэд саксоны ямар дарс байдгийг амсаж үзнэ гэж бүх гэгээдийн нэрээр андгайлж байхыг би үзсэн гэлээ.

- За тэгвэл байдаг бүх гэдээд түүнийг тэнд уутлаа уух шуналаас гэтэлгэж өгсөн байх болтугай. Нурсан цайзны дор үхэж орхисон байх бий дээ. Дээрэмчин чи нэг баг аваад түүнийг сүүлчийн удаа харсан газартаа оч. Сувгаас ус авч, улайдсан чулуун дээр нь асгаарай. Би тэр оодон гэлэнгээ алдахгүйн тулд тэр балгасыг бүр онгичин үзэхэд бэлэн байна шүү гэв. Олз хуваахад хүн бүр байлцах дуртай авч тэргүүлэгчийн даалгасан зүйлийг гүйцэтгэхэд дуртай хүн олон гарлаа. Энэ нь дээрэмчин бүлгийнхэн багш ламдаа хир их сайны гэрч ажээ. Бид тэр зуур ажилдаа оръя гэж Локсли хэлээд, - Бидний зоригт үйлийн тухай цуу тархмагц де Браси, Мальвуазен болон Фхон де Бефийн бусад холбоотнууд биднийг эрж эхэлнэ, бид тэгэхлээр энэ газраас хурдхан шиг зайлсан нь дээр... гээд Седрик рүү хандан, - Сайн төрөлт Седрик гуай олзлыг хоёр хувааж таньсан байна. Бидний хүчин хавсран бүтээсэн хэрэгт оролцсон зарц нар болоод өөртөө юу таалагдсан зүйлээ авцгааж үз гэв.

Седрик үүнд, - Сайн санаат Йомен миний зүрх гунигт авгаад байна. Ариун буянт Эдуард хааны эцсийн үр угсаа болох Конингсбургийн Ательстан үгүй боллоо. Түүний үхсэнээр дахин хэзээ ч үл биелэх их найдвар мөхлөө. Түүний цус хүний цаашдын амьсгааг дэвжүүлж үл чадах цогийг унтраалаа. Миний зарц нар, намайг дагалдаж яваа цөөнхөөс бусад нь түүний хүндэт шарилыг эцсийн нь газарт үдэж өгөхөөр миний эргэж харихыг хүлээж байгаа. Ровена авхай Ротервуд руу харих гэж байгаа болохоор мөн хүрэлцэхүйц тооны зэвсэглэсэн зарц дагуул гаргах хэрэгтэй байна. Тэгэхлээр би бүр түрүүн эндээс явсан байвал зохих байлаа. Гэхдээ бурхан болоод Витольд гэгээнийг барьж андгайлахад би олз омог хүлээгээгүй, миний хүмүүсээс хэн нь үүнд хүрэхгүй! Би ганцхан бидний амь нас, нэр төрийг аврахад хүчин хавсарсан чамд болоод чиний зоригт эрчүүлд талархлаа илэрхийлэх учрал хүлээж байсан бүлгээ гэвэл Локсли хариуд нь,

- Яаж тэгж болох вэ, бид эхлээд л уул хэргийн тал хувийг бүтээсэн. Чамд өөрт чинь юу ч хэрэггүй юм бол айл хөргийнхөө болоод талынхандаа өгөх юм авч үз гэлээ.

- Би тэднийг өөрийнхөө сангаас шагнаж чадахаар баян билээ гэхэд Вамба хажуугаас нь:

- Зарим нэг нь өөрөө өөрсдийгөө шагнахаар ухаалаг байсан. Гар хоосон буцаагүй, хүн болгон ямар тэнэгийн овоодой өмсөх биү дээ гэв. Локсли үүнд, - Зөв д байна. Бидний дүрэм гурим бол зөвхөн өөрсдөө л заавал дагах учиртай зүйл гэж хэллээ.

- Ээ чи миний муу ядуу амьтан гэсээр эргэж салбадайгаа тэврэн, - Намайг аврахын тулд биеэ тамлуулж алуулахаас үл айсан чамайг би яаж шагнах билээ. Хүмүүс цөм намайг хаяад явчихад ганц ядуу салбадай л үнэнч хэвээр үлдсэн байдаг байна шүү гэв. Энэ үед хэлэх үгийг ширүүн тайжийн сормосонд нулимс мэлтгэнэв. Ательстаныг алагдах үед хүртэл Седрик ийнхүү догдлоогүй билээ. Алив салбадай аяндаа ийнхүү голгүй сайн байгаад талийгаачийн хойноос гуниглахаас илүү гүнзгий сэтгэл уяраам зүйл байлаа.

Салбадай эзнийхээ тэврэлтээс, - Чи ач тусын оронд ганцхан нүднийхээ гашуун усаар хариулах ахуул юу болох юм бэ? Би бас уйлчихвал яана! Тэгвэл би үүрэгт ажлаа яаж гүйцэтгэх юм бэ? Өвгөө чи үнэхээр намайг баярлуулах гэж бодож байгаа бол байна шүү, өөрийнхөө цагаас ганц долоо хоног завшиж чиний хүүд хүчин зүтгэсэн Гурт найзыг минь уучилж орхи гэлээ.

- Түүнийг уучлах гэнээ? гэж Седрик дуу алдаад уучлах төдийгүй хөхүүлэн шагнаана. Гурт ирж сөгд! гэхэд гахайчин даруй дагав.

Седрик түүнд очроор хүрэн, - Үүнээс хойш чи боол ч биш, хамжлага ч биш боллоо. Одоогоос аван чи чөлөөт иргэн, хот орон, ой мод, хээр тал дуртай газраас суух тул Вальбургемийнхээ эдлэнгээс нэг хэсэг газар шагналаа. Одоогоос эхлэн үүрд тэр газрыг надаас миний гэр бүлээс өөртөө, гэр бүлдээ хүлээж ав. Үүнд тотгор тавих хэн бүхнийг бурхан цээрлүүлтүгэй! гэв.

Нэгэнт боол биш чөлөөт иргэн, газрын эзэн болсон Гурт босон харайж, хочр дахин дээр гэгч үсрэв.

- Би дархан, хуурай хоёр олох юм сан! гэж дуу алдаад - Чөлөөт иргэний хүзүүвчийг бушуухан авч өгөөч! Миний сайн төрөлт эзэн минь, таны өгөөмөр хишиг миний хүчин чадлыг давхар нэмэгдүүллээ, одооноос эхлэн би таны төлөө хувь илүү урагштайгаар тулалдах болно. Сэтгэл минь эрх чөлөөтэй болж байгаа нь мэдэгдэж байна. Өөрөө өөртөө, өрөөл бусдад ч гэсэн огт ондоо хүн боллоо гээч гэснээ, - Эзнийхээ хөөрч бахдаж байгааг үзэн баярлаж хажууд нь цовхчиж байгаа үнэнч нохой руугаа эргэн, - За яав, Фангс, эзнийгээ чи таньж байна уу? гэвэл Вамба:

- Тэгэлхгүй яах вэ, Фангс бид хоёр ч чамайг танихтайгаа л байна шүү Гурт минь, өөрсдөө хүзүүвчнээс ангижраагүй юм чинь. Харин чи л биднийг одоо мартав бололтой. Чи өөрөө хэтэрхий их хөөрч орхив доо гэв.

- Үнэнч анд нөхөр чамайгаа мартахаас өмнө би өөрийгөө мартаж вий. Вамба чамд эрх чөлөөтэй байх нь дээр байсан болж гэм эзэн чамайг ч гэсэн чөлөөт иргэн болгох байсан болов уу гэлээ.

Вамба, үүнд, - Үгүй, Гурт найз минь чамд атаархаж байна гэж бүү бодоорой. Эрх чөлөөт иргэнийг тулалдаж явах зуур боол чинь дулаан пийшингийн хажууд сууж байдаг юм. Момсберийн Ольдгемийн тэнэг хүн хоолоо идээд сууж байх нь цэцэн хүний тулалдахаас дээр гэж хэлснийг чи өөрөө мэднэ шүү дээ гэлээ.

Морин төвөргөөн сонсогдож Ровена хатагтай хэдэн морьтой хүн, олон явган зарц дагуулсаар хүрч ирлээ. Авхайн суллагдсанд баярлан жадаа өргөн, саадгаа дэлдэх ажээ. Авхай өөрөө өнгөлөг сайхан хувцас өмсөж үүлэн бор морь унаад хуучныхаа ихэмсэг хээнцэр дүртэй явна. Гагцхүү ер бусын цонхигор царай нь үзэж өнгөрүүлсэн их зовлонг санагдуулна. Гоо сайхан царай нь гунигтай хэдий авч ирээдүйд итгэх найдлага дахин сэргэж, өнгөрсөн зовлонгоос гэтлэгдсэнд баярласандаа нүд нь цогтой гэрэлтэх болжээ. Айвенго амьд. Ательстан үхсэнийг авхай мэдэж байлаа. Айвенгогийн амьд гэдэг авхайн зүрхийг хөхүүн баярлуулах бөгөөд дараачийн учралд онц баярласан гэж болохгүй авч, өөрийн нь сэтгэл асран хүмүүжүүлэгч

Седрикийн хүсэлтэй зөрдөг ганц зүйлээр цаашид өөрийг нь зовоохгүй болсон гэдгийг ухаарахад арга буюу өөрийн эрхгүй сэтгэл амрах шиг санагдаж байв.

Локслийн сууж байсаг газарт Ровена ойртож ирэхэд зоригт Йомен бү хань хамсаатан нь босож авхайг тосон очив. Авхайн царай улайсхийж, баяр хүргэж гараа хөдөлгөснөө дор мэхийхэд задгай үс нь морины хийсэж буй дэлтэй түргэн зуур нийллээ. Асар их ач тус болсонд нь гүнээ талархаж байгаагаа Локсли болоод нөхдөд нь цөөн боловч халуун дотно үгээр илэрхийлэв.

Үгний төгсгөлд, - Бурхан та бүхнийг өршөөх болтугай! амь биеэ хохирохоос үл эмээн дарлагдан хавчигдсан хүмүүсийг өмгөөлсөн явдалд зоригт эрчүүл та нарыг хөхүүлэн шагнаж хайрлахыг бурхан багш түүний ариун гэгээн эхэд мөргөн залбирая. Өлссөн нэгэнд чинь өгөх хоол, цангаа гаргаж элбэг хүрэх дарс, пиво Ровена бийг санаж байгаарай. Хэрэв норманд та нарыг энэ нутгаас хавчаад гаргаж орхивол Ровенагийн аврагчид дураараа зугаацаж болох, хэний сум бугад туссаныг ганц ч манаач асууж үл зүрхлэх ой мод надад байдгийг санаарай гэв.

- Сайн төрөлт авхай танд баярлалаа. Өөрийнхөө болоод нөхдийнхөө өмнөөс баярлаж байна. Гэхдээ шагнал мөн. Ногоон ойгоор тэнэж явахдаа бид багагүй нүгэл үйлддэг улс. Ровена хатагтайг сулласан явдал бидний нүглийг цагаатгаж өгөх болтугай гэж Локсли өгүүлэв.

Ровена дахин дор мэхийж морио эргүүлсэн боловч Седрикийг Локсли болон түүний хань нөхөдтэй салах ёс гүйцэтгэхийг хүлээн зогсов. Тэгтэл огт санамсаргүйгээр олзлогдсон де Браситай халз тулгарчээ. Баатар модны дор элгээ эвхэж, гүн бодолд дарагдан зогсож байсанд анзаарахгүй болов уу гэж Ровена горьджээ. Гэтэл дээшээ харж авхайг үзмэгцээ ичсэндээ сайхан царай нь час улайв. Хувь хиртэй түдгэлзэн байснаа урагш алхаж авхайн морийг цулбуурдан өвдөг сөхрөв.

- Нэр төр гутаасан дайчин, олзлогдсон баатрыг Ровена хатагтай ганц удаа тольдож гийгүүлэхсэн болов уу? гэхэд Ровена хариуд нь,

- Эрхэм баатар таны энэ сэдсэн мэт үйл явдал чухамхүү гутамшиг нь ялагдахад биш, харж ялахад байхсан билээ гэвэл баатар өөдөөс нь,

- Ялалт уул нь зүрх сэтгэлийг зөөлрүүлэх учиртай. Золгүй тачъяалын эрхээр доромжлол хүлээлгэснийг минь Ровена авхай танаас уучлан хэтрүүллээ гэдгийг би дуулахсан, тэгвэл де Браси өөр зүй зохистой сайхан замаар тус болж чадахыг авхайтан та үзэхсэн билээ гэхэд,

- Эрхэм баатар таныг уучиллаа. Христос шашинт бүсгүйн сэтгэлээр уучиллаа гэж Ровена хэллээ.

- Энэ чинь уучлах сэтгэл огт үгүй байна гэсэн үг гэж Вамба хэлтэл Ровена цашаш нь:

- Тэгэхдээ таны болчимгүй авирласны улмаас гарсан бүх хор уршгийг би хэзээ ч уучлахгүй шүү гэв. Седрик дөхөж ирээд, - Наад цулбуураа тавь, энэ бүсгүйн морийг битгий барь. Гэгээн нарыг барьж андгайлахад хэрэв чи олзны этгээд биш байсансан бол би хөнгөн жадаараа

чамайг газартай хадаж орих байсан билээ. Харин энэ булай хэрэгт орооцолдсоныхоо хариуг Морис де Браси чи надад төлөх болно гэдгийг бат санаж яваарай гэлээ.

- Олзны хүнийг заналхийлэхэд амархан, тэгээд ч саксон хүнийг эелдэг байна гэж бодохын хэрэг үгүй гэж де Браси өгүүлээд гэдрэг хоёр алхам ухран Ровенаг явуулав.

Мордохын өмнө Седрик Хар баатарт халуунаар талархан Ротервудэд цуг морилно уу гэж урилаа.

- Хэсүүлчин баатрууд та нарын хамаг аз жаргал жадны үзүүрт байдгийг би мэднэ. Танд газар, эд баялаг алин нь ч хэрэггүй. Гэхдээ дайн гэдэг аль ч талаар эргэж болохтой бөгөөд бүх насаараа дайтаж, хэсүүчилж явсан хүнд тайван амьдрах нэг газар мөрөөдөгдөх учир байдаг. Сайн төрөлт баатар та эрэлхэг гавьяагаараа Ротервудэд нэг тийм газартай боллоо. Седрикхөрөнгө чинээгээ амархан засаж тохинуулахаар баян байдаг бүх юмаа эдэлж эзэмшихийг танаас баяртайча гуйж байна. Иймд Ротервуд очиж айлчны хувиар биш үр хүүхэд маань юм уу дүүгийн ёсоор морилно уу гэвэл баатар хариуд нь,

- Би ч гэсэн Седриктэй танилцаад баян боллоо. Саксончуудын сайн үйлийг үнэлж үзэж сурлаа. Шударга Саксон тайж чинь чи Ротервудэд мөдхөн очно. Тэгэхдээ таны заллагыг одоо хүлээн авахад хойшлуулшгүй чухал ажлууд саад болж байна. Харин хүрч ирсэн хойно чиний өгөөмөр сэтгэлийг шалгахаар тийм шагнал нэхэж магад юм шүү гэв.

- Урьгаад бүгдийг зөвшөөрлөө гэж Седрик уриалгахан дуугарч баатрын сунгасан төмөр бээлийтэй гарыг алгадаад, - Юу дуртайгаа ав, миний хамаг хөрөнгөний талыг ч хамаагүй ав гэлээ.

- За ингэж амархнаар битгий их юм амла. Гэхдээ би хүсэж байгаа шагналаа авна байх гэж найднам. Одоогоор баяртай! гэж дүүжлээстэй цоожин сүлдэт баатар өгүүлэв.

- Сайн төрөлт Ательстаныг оршуулж дуустал би Конингсбургт тэдний цайзанд байна гэдгийг дуулгах учиртай. Оршуулах ёслолд оролцох гэсэн өбүхэнд цайзны танхимуудын үүд нээлттэй байх болно. Ательстаныг норманы гинж, норманы илднээс аврах гэж хэдий ургүй боловч эрэлхэг зоригтойгоор зүтгэсэн хүнд энэ цайзны хаалга эгнэгт нээлттэй байх болно гэдгийг талийгаач хаан хүүгийн эх сайн төрөлт Эдифийн нэрийн өмнөөс дуулгая гэв.

Эзний дэргэд ердийн байраа эзэлсэн Вамба:

- Тиймээ тэнд хосгүй том дайллага болно. Сайн төрөлт Ательстан өөрийнхөө оршуулгын цайллага дээр идэж ууж болохгүй нь харамсалтай гэснээ тэнгэр өөд харан төв царайгаар, - Гэхдээ тэр одоо лав энхжингийн оронд оройн хоол дуртайгаар зооглож суугаа байх гэхэд,

- Дуугүй бай, түрүүлээд яв! гэж Седрик хэллээ. Вамбагийн саяхан үзүүлсэн тусыг зохисгүй тохуу хэлж уурласныг нь даруй зөөлрүүлэв.

Ровена гараа хээнцэрээр дохин хар баатарт баяр хүргэж, саксон Седрик аян замдаа сайн явахыг ерөөж тэд ойн өргөн чөлөөг даган хөдлөв.

Тэднийг дөнгөж холдтол ширэнгэн дотроос өөр нэг цуваа гарч ойн цоорхойг өнгөрөн Седрик, Ровена хоёр болон тэдний дагуулуудын хойноос одлоо. Энэ нь "Хойтохыг нь" уншуулахаар Седрил их өргөл барих аргаар ойролцоох хийдээс ирсэн лам нар ажээ. Ательстаны албатууд шарилыг нь мөрөн дээрээ дамнан Конингсбург дахь цайз руу нь алгуур гунигтай явахад лам нар хойноос нь даган мөргөл уншина. Тэд талийгаачийг эртний удам язгуур нь болох Хенгистийн ургийн бунханд оршуулах учиртай ажээ. Түүнийг нас барсан тухай дуугаар олон харьяатнууд нь цугларч шарилы нь хойноос гашуудан дагаж явлаа. Дээрэмчид түрүүн гоо сайхныг биширснийхээ адил үхлийг мөн өөрсдийнхөөрөө хүндэтгэн ёсолж босоцгоолоо. Лам нарын намуун унших залбирал, намбатай албаа дөнгөж сая тулалдаанд эрсэдсэн нөхдийг нь тэдэнд гэнэт санагдуулав. Гэвч аюул дунд зоримог үйлээр оролцон насаа барж байгаа хүмүүсийн ухаан санаанд иймэрхүү дурдатгал төдий удаан тогтдоггүй ажээ. Оршуулах уншлагын чимээ алсад сайн замхарч дуусаагүй байхад дээрэмчид дахин олзоо хуваах ажилдаа оров.

Локсли, - Сайн баатар таны эр зориг, хүчирхэг гар байгаагүйсэн бол бид лавтай дийлдэх байсан билээ. Иймд энэ бөөн эд хогшил дотроос юу таалалтайгаа ногоон царсны дурсгал болгон сонгож авна уу гэж Хар баатар өгүүлэхэд,

- Таны чин сэтгэлээсээ өгүүлсэнчлэн би үнэхээр дуртай хүлээн авъя. Харин эрхэм Морис де Брасийг миний мэдэлд өгнө үү гэв.

- Тэр хүн тэртэй тэргүй таны мэдлийнх бөгөөд энэ түүний их аз мөн. Тэргүйсэн бол энэ царсны хамгийн дээд мөчрөөс өдийд дүүжлээстэй байхсан билээ. Үүний чөлөөт багийн нөхдөөс нь аль болох олныг барьж ойролцоох мөчрүүдийг чимэглэх байсан юм. Гэхдээ энэ өөрөө олзны хүн, хэдийгээр энэ миний эцгийг алсан ч гэсэн үүнд би гар хүрэхгүй гэж Локсли хариуллаа.

Хар баатар тэгэхэд де Браси чи суллагдлаа! явж болно. Чамайг олзолж авсан хүн өнгөрсний өшөөг авахаас жигшин татгалзаж байна. Үүнээс дор юманд оров доо цаашид болгоомж сэрэмжтэй яв. Морис де Браси чамайг болгоомжил гэж сануулж байна шүү гэлээ.

де Браси дуугүй мэхийгээд явахаар завдтал йоменууд гэнэт басамжлан дооглож хөхрөлдөв. Бардам зант баатар зогсож тэдэн рүү эргэн гараа элгэндээ зөрүүлж цэх зогсоод,

- Дуугүй бай муусайн ноход! Одоо болохоор хуцах болов уу, буга үргээж байх цагт ойртож очихоосоо эмээж байсан биз! Та нарын басамжлахыг де Браси үл тоомсорлоно. Та нарт магтагдахыг үл хүснэ. Адгийн муу сайн тонуулчид овоохой үүрэндээ буцаж оч, та нарын муу үнэгэн нүхний хавьд эр баатруудын ариун үйл болж байхад дуу гарч бүү зүрхэл! гэжээ.

Йоменуудын удирдагч яаран оролцоогүй бол энэхүү танхай дайралтаар Морис де Браси бөөн сум зоолгож болох байв. Тэр зуур де Браси де Бефийн саравчнаас авч ирсэн, дээрэмдсэн олзны бараг хамгийн үнэтэй зүйл болох эмээлтэй морьдын нэгний цулбуурыг шүүрэн авч мордоод даруй ой руу давхиж одлоо.

Энэ явдлаас болсон үймээн дарагдахын хамт дээрэмчдийн тэргүүлэгч саяхан Ашбийд тэргүүлэгч харваачдын тэмцээнд шагнуулсан үнэт эвэр бүрээ мөрөвчөө хүзүүнээсээ аван хар

баагарт,

- Сайн төрөлт баатар та Английн Йомены хэрэглж яваа анчны энэ бүрээг бэлэг болгон авахаас сэжиглэхгүй бол бидни байгуулсан эрэлхэг гавьяаны дурсгалд зүүж явахыг гуйя. Таны дотор ямар нэгэн бодол байвал, сайн баатруудтаы олонтой тохиолддогчлон нөхөрсөг тусламж Трентомоос Тис хүртлэх ойд хэрэг болох ахуул тө зөвхөн энэ бүрээгээр ингэж: - "Уа-ха-хо-о" гэж бүрээдээрэй. Тэр даруй тусламж хүрээд очиж ч тун магад шүү гэв.

--Зоригт Йомен чиний бэлгэнд их баярлалаа. Надад хэдий бэрх юм учирлаа ч гэсэн би чи болоод чиний нөхдөөс өөр хүчин туслах хүн хэрэгтэй гэж баатар өгүүлэв.

Хар баатар эвэр цоорыг аван уул дохиог бүхэл ой цууриатгал хангинуулан бүрээдэв.

- Чи сайхан бүрээдэж байна, тун цэвэрхэн болж байна. Чи сайн дайчин шигээ мэргэн анчин биш байвал би энэ дороо газарт цөмрөг. Мөрийцөж хэлэхэд чи энэ насандэ нилээд ан намнажээ. Нөхөд минь энэ дохиог сайн цээжлэж ав, энэ бол дүүжлээстэй цоожин сүлдэт хар баатрын дохио шүү. Үүнийг дуулаад, туслахаар яаран очоогүй хэнийг ч болов би бүлгээсээ өөрийн нь нумны хөвчөөр ороолгон хөөх болно гэж Йоменыг өгүүлэхэд нөхөд нь:

- Манай тэргүүлэгч түм насалтугай! Дүүжлээстэй цоожин сүлдэт хар баатар мандтугай! Түүнд тус болох хичнээн дуртайгаа үзүүлэх завшаан гарч бүрээний дуу бурхны өршөөлөөр даруйхан дуулдаасай! гэж хашгирав.

Эцэстээ Локсли олзоо хуваах ажилд орж түүнийгээ магтууштай шударгаар гүйцэтгэлээ. Бүх олзны аравны нэг хувийг буян номын өглөг болгон сүм хийдэд тавилаа. Нэг хувийг нэг ёсны нийгмийн санд нийлүүлэв. Бас нэг хувийг амь үрэгдсэн нөхдийн бэлэвсэн эхнэр, өнчин үр хүүхэд болоод ардаа гэр оронгүй нөхдийг оршуулах, хойтохыг нь уншуулахад зориулав. Үлдсэнийг бүлгийн бүх гишүүдэд зэрэг эрэмбэ, гавьяа зүтгэлийг нь харгалзан хуваалаа. Эргэлзээтэй учрал бүхэн дээр дээрэмчдийн тэргүүлэгч оносон шийд гаргаж үг дуугүй дагах ажээ. Хуулиас давж гарсан энэ хүмүүс дотроо ийм шударга чанд дэглэм тогтоож чадсанд гайхаж, үзсэн харсан бүхэн нь тэдний тэргүүлэгчдийн шударга ухааныг өндрөөр үнэлж байсныг улам лавшруулах ажээ.

Хүн бүр оногдол олзоо авч, сангийн нярав дөрвөн биерхүү йомены хамт нийтийн санд зориулагдсан эд хогшлыг нэг нууц газар руу зөөж хийхэд сүм хийдэд оногдуулсан зүйл тэр хэвээр үлдэв.

- Манай зугаатай багш яасныг би мэдэх юмсан гэж Локсли хэлээд – Урьд нь хоол ундны өмнө залбирал унших юм уу олз омог хуваахад үгүй байдаггүй л юмсан. Бидний энэ амжилттай үйлийн олзны аравны нэг хувийг нэг тийшээ болгох явдал одоо түүний шууд үүрэг болоод байна. Гэлэн зарим талаар санваар зөрчсөний нь нүглийг энэ цагаатгаж магадгүй. Үүнээс гадна энд ойролцоо нэг олзны санваартан бий, түүний учир зүйг олоход манай гэлэн тус болоосой гэж бодсон юмсан. Ганцхан бид манай наргианч багшийг дахиж харахгүй болсон шиг надад санагдана гэлээ.

- Тэгвэл би гүнээ харамсах билээ. Найрсаг дайлсны болоод урцанд нь наргиантай сайхнаар

шөнийг өнгөрүүлсний хариуг барих учиртай хүн. Буцаж цайзны балгас руу очъё, тэнд нэг юм мэдэгдэж магадгүй гэж хар баатар өгүүлэв.

Энэ үгийг хэлж дуусмагц йоменууд чангаар хашгиралдаж хойноос нь зовж байсан хүн айсууг мэдэгдлээ. Түүний өндөр дуу холоос гарч:

--Хойшоо болцгоо хүүхдүүд минь! Лам багш болоод түүний олзны хүнд зам чөлөөтэй тавь! За дахиад жаахан! Олигтойхон шиг мэндлэ! Журамт тэргүүлэгч минь бүргэд шиг савартаан олзтой ирж байна гэж хашгирав.

Хөхрөлдөн байгаа олны дундуур зам гарган царс руу ихэмсгээр ойртож очлоо. Гартаа хүнд шийдэм, нөгөө гартаа золгүй хөөрхий Исаакийн хүзүүнд угласан хазаарын жолоог атгажээ.

- Үлгэрчин Аллен хаана байна? Миний гавьяаг дуурь болгох юм уу ядаж үлгэр болгож магтах хэрэгтэй байна. Үгүй тэр муу адгийн салбадай хийх юм огт үгүй цагт ямагт гар дор бүртэгнээд байх мөртлөө эр зоригийг магтан дуулах, хэрэгцээ болоод ирэхэд байдаггүй гээч гэж гэлэн хашгирав.

- Тоодон гэлэн чи хар өглөөнөөс аваад амаа халааж орхижээ. Янз нь чи хэнийг ингэж чирээд ирснээ өгч үзээч гэж тэргүүлэгчийг хэлэхэд:

- Өөрийн жад сэлмээр, өөртөө олзны хүн олж ирлэ. Журам дарга минь гэж Копмангерстийн тахилчин хариулаад, чухамдаа гэвэл нум, сүхээ гэх үү дээ. Гол нь би шулмын эрхшээлээс гаргасан уу, үгүй юу. Хэл чи еврей! чамайг "сүсэглэнэм" "эцэг болсон бурхан минь" "Дарь эх минь" гэж би чамд уншдаг болгоогүй гэж үү? Шөнөжин чиний эрүүл энхийн төлөө ууж, манай шашин мөргөлийн нандин учрыг би чамд тайлбарлаж өгөөгүй гэж үү? гэхэд,

- Буян болно. Энэ солиотой хүнээс намайг ангижруулж өгөөч! гэж хөөрхий еврей дуу алдлаа.

- Юу гэнээ еврей? гэж даянч дахин ширүүн дүр үзүүлж,

- Чи дахиад л шашин шүтлэгнээс ухарч байна уу? Дахиад буруу номын эрхшээлд орох гэвэл чамайг даа! Чи хэдийгээр гойдын тарган биш авч чамайг гал дээр шарж болно шүү. Исаак чи сайтар чагнаад намайг даган унш. "Дарь эх минь" гэтэл Локсли

– Үгүй төрөхгүй гэлэн, шашин шүтлэгээр тоглоом хийж болохгүй. Энэ олзныхоо хүнийг хаана яаж олсноо чи зүгээр ярь!гэлээ.

- Дунстан гэгээнийг барьж андгайлахад, үүнийг би арай илүү аятайхан юм олно гэж горьдсон газраас олсон билээ. Би жаал зугаа юм аварч болох эсэхийг үзэхээр зоорь руу орлоо. Аяга дарс тансгаар амтлан буцалгах ахуул эзэн хаад я гэсэн тэнцэнэ гэдэг үг байдаг хэдийн боловч хэтэрхий ихээр нэг дор буцалгах хэрэг юу байх билээ гэж бодоод нэг торх испани дарс тэвэрч аваад туслах олхоншиг хүн дуудахаар явлаа. Гэтэл залхуу золигуудыг хаанаас олох билээ? Сайн үйл үйлдэх цаг болоход эд ер хэзээний олддог биш. Гэнэт нэг бат бэх үүд харагдлаа. Уухай хамгийн шилдэг дарс энд байдаг байх нээ, тусгай өрөөнд шүү гэж би бодлоо. Айж сандарсан зууу ундааны даамал түлхүүрээ нүхэнд нь хийгээд зугтаасан байв. Нууц өрөөнд би

яваад ортол ер юу ч байдаггүй. Зөвхөн зэвтэй гинж шалан дээр хэвтэхээс гадна дийлдэгчийн өршөөлд шүтэн надад бууж өгсөн энэ муу еврей нохойноос өөр юу ч байсангүй. Энэ буруу номтныг тэнхрүүлээд дөнгөж ганц аяга дарс хүчээ сэлбэхин тулд ууж амжаад олзныхоо хүнтэй цуг зоориноос гарах гэтэл гэнэт тэнгэрийн дуу шиг айхавтар нүргээн гараад явчихлаа. Захын нэг цамхаг нураад орхих нь тэр. Тэгтэл цамхгууд дараа дараагаараа нурж эхлээд, хорвоо дээр амьд явах хоног дуусжээ гэж саналаа. Миний мэт санваартан хүн нөгөө ертөнцөд еврейтэй цуг одох нь зохисгүй гэж бодоод тархийг нь хага цохих гэж сүхээ далайсан боловч буурал үсийг нь хараад өрөвдлөө. Би дайны зэвсгээ хойш тавиад еврейг христос шашинд оруулбал бүр ч дээр гэж санан бишрүүлэн ятгах ажилд орлоо. Үнэхээр ч Дунстан гэгээний авралаар үр шимт хөрсөн дээр унажээ. Шөнөжин шашны номын далд нандин утгыг тайлбарласаар бүр ядарч гүйцэв. Би тамир сэлбэх гэж хааяа нэг балга дарс ууж байсан явдал тооцогдохгүй. Энэ Жильберт Виббальд хоёр гэрчилнэ. Намайг ямар байдалд олсноо эд хэлж өгөг, би бүр тамирдаж гүйцээд байсан гэв.

– Тэгэлгүй яах вэ, үнэхээр гэрчилнэ. Бид балгасыг онгичиж, Дунстан гэгээний авралаар зоорины хаалгыг олоход торхтой тал дундаа хүртэл хоосорсон, еврей дөнгөж голтой, гэлэн өөрөө хэлж байгаагаасаа хувь илүү тамирдаж орхиод байсан гэж Жильберт өгүүлэхэд гэлэн гомдож дургүйцэн:

- Тэр худлаа муу новш! Чи л нөхөдтэйгээ өглөөний хувьд гэж байгаад бүхэл торхыг уучих чинь билээ. Би харин ч гайгүй. Гол нь би еврейг өөрийн шашинд оруулсан, миний ярьсан бүх зүйлийг энэ надаас дээргүй сайн ойлгож авсан гэлээ.

- Еврей чи сонсож бай, энэ үнэн үү? Чи үнэхээр өөрийн шашнаас гараа юу гэж Локсли асуувал,

- Өршөөлт эрхэм та намайг нигүүсэлж үз! Энэ аймшигт шөнийн туршид хүндэт хувраг надад хэлсэн зүйлээс би ганцыг ч сонсож чадаагүй. Айх, гашуудах ганихрах зовлонд гүнээ автаад шаналж байсан болохоор гэгээн дээд эцэг авраам өөрөө ирээд сургаал айлдлаа ч гэсэн би түүнийг дуулж чадахааргүй байсан билээ гэж еврей өчив.

--Еврей чи худлаа хэлж байна. Чи худал хэлж байгаагаа одоо өөрөө мэдэж байгаа шүү дээ? Бидний бүх ярианаас чамд ганцхан үг сануулъя, чи хамаг хөрөнгөөрөө манай ариун хийдэд өргөл барихаар амласнаа санаж байна уу? гэж гэлэнг хэлэхэд Исаак түрүүчийнхээсээ илүү сандран:

- Өршөөлт эрхмүүдээ, бурхны нрээр тангараглахад миний амнаас тийм андгай үг хэзээ ч гараагүй! Би ядуу гуйлгачин өвгөн. Намайг өрөвдөж үзэн суллаж явуулна уу гэвэл Даянч тосож аваад,

--Үгүй, чи ариун сүм хийдэд амласан өргөлөө буцааж байгаа бол чамайг хатуу цээрлүүлбэл зохино гээд сүхээ өргөн бариулаар нь золгүй еврейг сайн цохиод авах гэтэл Хар баатар еврейг өмгөөлснөөр лам багшийн хилэнг өөртөө буулгав.

Кентийн гэгээн Фомийн нэрээр андгайлахад эрхэм залуу таныг би бусдын хэрэгт оролцдоггүй болгон сургана. Чиний төмөр хайрцганд орж нуугдсан чинь гайгүй! гэж

хашгирав.

- За боль доо, надад юунд нь уурлаж байна вэ? Чамд би хэзээний сайн анд нөхөр байсныг чи өөрөө мэднэ шүү дээ гэж баатрыг өгүүлэхэд лам хариуд нь,

- Би тийм юм ер мэдэхгүй. Чи хоосон чалчигч, давамгай зантай этгээд болох учраасчамтай зодоо хийх дур хүрч байна гэлээ.

- Яалаа гэж тэр билээ. Чи миний төлөө мацаг барих андгайгаа сайн дураараа зөрчсөнөө санахгүй байна гэж үү дээ? гэж баатар өгүүлэх нь саяхан өөрийг нь зочилж байсан хүнээ жаал цаашлуулах нь түүнд аятайхан янзтай ажээ.

Гэлэн лут том нударга зангидан – Ингэхэд байнаа найз минь би чамайг чихэн дундуур чинь байлгалаа шүү гэхэд,

- Тийм бэлэг би хүлээж авдаггүй. Харин зээлээр нэг алгадуулж болно. Харин тэгэхдээ чиний энэ олзны хүнийг ер авч байгаагүй их хүүтэйгээр төлж өгнө шүү гэлээ.

- Алив үзье л дээ гэж гэлэнг сүржигнэхэд Локсли оролцож,

- Зогс! гэж хашгираад, - Төрөхгүй гэлэн чи юу сэдээд байна? Манай ариун царсны дор хэрүүл өдөх гэнээ? гэхэд баатар өөдөөс нь тайвшруулан,

- Энэ чинь хэрүүл биш, зүгээр харилцан нөхөрсөг сорилт юм. За гэлэн чи чадах хирээрээ цохь. Би байрандаа зогсож чадна. Харин чи зогсож чадах нь уу үгүй юу үзье гэлээ.

Чи толгой дээрээ энэ төмөр хувинтай болохоор тэгж хэлэхэд амархан байна. Гэхдээ ялгаагүй, чи гуулин дуулгатай Голиаф биеэрээ байсан ч гэсэн унагана гэж лам хэллээ.

Даянч шөрмөслөг гараа тохойгоо хүртэл шамлан баатрыг бүх хүчээрээ цохив. Тийм хүчтэй цохиход том бух боловч унаад өгмөөр атал өрсөлдөгч нь харин хадан цохио адил огт хөдөлсөнгүй. Тахилчны нударга тэдний дунд бүр алдаршиж гүйцсэн бөгөөд олонхи нь түүний чадлыг тоглоом тохуугаар үнэхээр үзэлцэн амсан мэдсэн болохоор тойрон зогссон йоменууд сайшааж хашгиралдав. Баатар төмөр бээлийгээ аван, - Гэлэн чи харж бай би толгойдоо халхавчтай байсан авч гарт юу ч байхгүй. Сайн зогсоорой! гэвэл,

- Би ч гэсэн ялгаагүй. Салбадайн төлөө, чухамдаа гэвэл өөрийнхөө мэргэжилд бүрэн эзэн болж хундага дарс болгоныг гахайн сайхан хэрчим махнаас илүү амттай, нандин болгож чаддаг тийм тэнэг салбадайн төлөө залбирах тулалдахаас буцахгүй ухаантай гэлэн ямагт олдоно гэж би хэлэх байна нөхөд минь. Залбирал уншихаа мартаж юм уу, шийдэж хэрэглэж чадахгүй болтлоо би түүний төлөө зүтгэнэ! гээд хүнд шийдмээ малчны шилбүүр аятай толгой дээгүүрээ эргэлдүүлэв.

- Айлгах гэсэн хүнд хацраа тавьж өг гэсэн байдаг. Харин урьдаас хэлэхэд чи намайг байрнаас минь хөдөлгөх юм бол еврейгээс авах бүх золиосоо чамд бэлэглэнэ гэж лам хэлээд бардам, өдсөн байртай зогсов. Гэвч хувь тавилангаасаа мултрахын арга үгүй. Баатрын хүчтэй

цохилтонд гэлэн газар харуулдан өнхөрсөнд үзэгч олон ихэд гайхжээ. Харин гэлэн босож ирээд уурласан, гутарсан царай ер гаргасангүй.

- Ингэхэд, найз минь өдий их хүчтэйгээс хойш хянуур байх нь зүйтэй. Чи миний эрүүг мулталчихсан бол би одоо яаж мөргөл унших билээ? Үүдэн шүдгүй бол цоор ч тоглож болохгүй шүү дээ. За май, найрамдлын бэлэг болгож гар барья. Хойшид ингэж алгадалцахгүй, юу гэвэл надад хохиролтой юм байна. За тэгэхлэр харилцан дургүйцэлдэх явдал үгүй боллоо. Харин еврейгээс золиос авья уу гэвэл бөгтөр хүн авсанд ортлоо засагдахгүйн адил еврей хэзээд еврей хэвээрээ үлдэнэ гэв.

- Гэлэн чихэн дундуураа тавиулснаас хойш еврейг шашиндаа оруулна гэж би итгэхээ болившив гэж дээрэмчинг хэлэхэд,

- Дуугүй бай өөдгүй амьтан! Шашинд оруулах гэж чи тэнд юу чалчаад байна? Энэ юу гэсэн үг вэ? Намайг хэн ч хүндэлж үзэхээ больж! Цөм эзэд болоод зарц хүн ер үгүй болчихжээ. Сайн баатар намайг цохиход би хөл жаахан султай байлаа гэж чамд хэлж байна шүү залуу минь тэргүй бол би зогсож чадах л байсан. Энэ тухай чи цаашаа ярилцах дуртай байвал, би хариу барин чаддагаа чамд үзүүлээд өгье гэлээ.

- За больцгоо! Еврей чи золиосныхоо тухай бод. Бид христос шашны сайн сүсэгтэнгүүд, чамайг дундаа их удаан байлгаж болохгүйг өөрөө ойлгож байгаа. Чи завтай сууж хэдий хир золиосонд өгч чадахаа бод, би одоогоор өөр нэг олзны хүнийг байцаая гэж Локсли хэллээ.

Фрон де Беф бээлийн хүмүүсээс олныг олзолж авч чадсан уу? гэж Хар баатрын асуухад,

- Золиос төлж чадахаар ганц ч хүн олзлогдоогүй. Аймхай хэдэн шаарууд байсныг бид тавиад явуулчихсан, өөр эзэд олог. Хонзонгоо тайлах, олз олох талаар тэртэй тэргүй хангалттай болсон. Саяны миний дурссан олзны хүн тэднээс илүү. Түүний гоё хээнцэр хувцас, морины тоног хэрэгслээр үзвэл нөхцсөн бүсгүй рүүгээ явж байсан завхай зайдан хувраг хүн. За энэ хүрээд ирлээ гэж Локсли өгүүлэв.

Тэгтэл хоёр Йомен, манай хуучин танил, Жорвогийн хийдийн ширээт лам Эймерийг хөтөлж ирээд даргын ногоон сандлын өмнө зогсоов.

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

... Эр цэргийн чимэг болсон

Ларций яасан бэ?

Марций. Тэр чинь заримыг цаазлах

Нөгөөг цөлөх, тэрнээс золиос авах

Үүнийг өршөөх чухал шийдвэр гаргаж байна.

Шекспир "Кориолан"

Баригдсан ламын нүүр царай, галбир төрх нь гомрохсон, бардам ихэмсэг зан, самгардсан сүрдсэн байдал хослон хөгтэй харагдана.

Мөн энэ гурван сэтгэлгээ нь зэрэг илэрсэн дуугаар,

- Энэ юу гэсэн үг вэ эрхмүүдээ? Танай энд чинь ямар гээч дэг журам байна вэ хэлж өгөөч? Хувраг хүнтэй ингэж харьцаж байдаг, та нар чинь туркүүд үү, христос шашинтан улс уу? Сүм хийдийн санваартан хүнд халдах гэдэг юу гэсэн үг болохыг та нар мэдэх үү? Та нар миний хайрцаг савыг уудлаж их хамба ламтан хүртэл өмсөхөд зовох юмгүй маш нарийн нэхмэл захыг минь урж хаялаа. Миний оронд өөр хүн байсан бол та нарыг шуудхан л сүм хийдийн ивээлээс гаргаж орхих байсан, би харин муу юм санадаггүй хүн, та нар миний морийг даруй авчруулж, хамт яваа хүнийг суллан, ачаа барааг минь бүрэн бүтэн эргүүлж өгөөд Жорво хийдэд хурал хуруулахад зуун зоос өргөл барьж дараачийн гурван эрдэнийн баяр хүртэл мацаг барих ам өгвөл энэ балмад явдлыг би аргалан дарахыг бодъё яахав. Хойшид энэ тухай яриа гарахгүй болно гэвэл дээрэмчдийн толгойлогч өөдөөс нь:

- Хүндэт багш ламтан, таны зүгээс ингэж, ийм эцэг ёсны сургаал айлдахад хүртэл миний нөхдийн хэн нэг нь тантай ёс алдан харьцсан байна гэж бодоход надад харамсалтай байна гэв.

Локслийн зөөлөн үгэнд лам урам орон,

--Юуны харьцаа вэ та минь! Христос шашинтай хүн, тэр тусмаа хувраг, тэгээд Жорво хийдийн ширээттэй байтугай сайн үүлдрийн нохойтой ч тэгж харьцаж болохгүй. Жалгын Аллен гэгч нэг согтуу үлгэрчин намайг дөрвөн зуун зоосны золиос төлөхгүй бол бэрээдэж залхаах, тэрч байтугай ална гэж сүрдүүлсэн. Түүнээс гадна асар их үнэ хүрэх алтан гинж, эрдэнийн чулуу сэлт аль байдгийг дээрэмдэн авсны дээр үнэртэй ус бүхий хайрцаг, ус эргүүлэх мөнгөн хайч зэрэг нандин зүйлүүдийг бүдүүн хадуун гараараа эвдлээд хаячихсан... гэв.

- Жалгын Аллен ийм ариун өндөр мяндагтантай тийм бүдүүлгээр аашлана гэж байж болох уу даа? гэж тэргүүлэгч хэллээ.

- Эд бүгд чинь Никомдим гэгээний ариун судар шиг үнэн зүйл. Тэгэхдээ бас хойт нутгийн бүдүүлэг аялгуугаараа хараал тавин, энэ ойн хамгийн өндөр модноос намайг дүүжлэнэ гэж андгайлсан юм гэж ширээтийг хариулахад,

- Үгүй үнэхээр андгайлсан гэж үү? Тийм болж гэм миний бодоход багш ламтан та түүний шаардлагыг биелүүлэх хэрэгтэй байхаа. Юу гэвэл Жалгын Аллен гэдэг чинь нэг л юм хэлсэн бол түүндээ заавал хүрдэг хүн байгаа юм гэв.

Ширээт үүнд алмайрч орхиод худлаа инээсэн болж,

- Та тохуу хийж байна уу? Би ч өөрөө олигтойхон наргиа үгэнд их дуртай хүн. Гэхдээ энэ тоглоом бүхэн шөнийн турш үргэлжилсэн болохоор одоо зогсоох цаг болсон мэт гэлээ.

- Би одоо хүний наминчлал сонсож байгаа хувраг хүн шиг төв байна. Эрхэм ширээт та зэгсэн золиос төлөх хэрэгтэй, тэргүй бол танай шавь нар шинэ ширээт сонгож олоход хүрэх болно гэвэл та тэдэн дээрээ буцаж очихгүй шүү гэлээ.

- Үгүй та нар чинь христос шашинтай улс уу үгүй юу? Хувраг хүнд хандаж ийм үг хэлж яаж зүрхэлж байгаа юм бэ? гэж ширээтийг хэлэхэд дээрэмчин хариуд нь:

- Тэгэлгүй яах вэ, бид христос шашинтан, тэр ч байтугай өөрийн лам багштай. Алив манай наргианч гэлэнг дуудаад орхи, гарч ирээд тухайн учралд тохирсон үг ном судраас иш татаж эрхэм ширээтэд номлог гэв.

Согтуу нь нилээн гарсан даянч ногоон хүрэм дээгүүрээ гэлэн жанч нөмөрч латинаар урьд цээжлэж байсан хэдэн үг ой тойноосоо санан гаргаж, цугларсан олны дундаас урагшаа гараад,

- Хүндэт багш ламтан, өршөөлт таныг бурхан өршөөх болтугай гэж латинаар өгүүлээд,-- Манай ойд амар сайхан морилогтун! гэв.

- Энэ чинь юун булай багт наадам гэгч вэ? Нөхөр минь чи үнэхээр хувраг хүн юм бол миний өмнө зээлийн алиа аятай нүүр амаа үрчигнүүлж тонголзохын оронд энэ хүмүүсээс хэрхэн ангижрахыг надад зааж өгнө үү? гэлээ.

- Чиний суллагдаж болох үнэхээр ганцхан аргыг би мэдэх юм багш ламтан гуай. Бид өнөөдөр тэргүүн мэндлэгч Андрей гэгээний баярыг тэмдэглэж байгаа болохоор барьж авч байгаа юм гэлээ.

- Нэгэн адил санваартан сайн нөхөр минь сүм хийдээс арай үгүй биз дээ? гэж ширээтийг хэлэхэд,

- Сүм хийд энгийн иргэдээс ялгаагүй авч байгаа юм. Иймд буруу зөрүү гурим ёсыг сайшаан дагаж үз. Өөр ямар ч арга танд тус болохгүй гэж даянч хариулав.

Ширээт дуугаа зөөлрүүлэн, - Зугаатай анчдад би дуртай, үнэн голоосоо сайн байдаг. За больж үз, юунд ингэж их чанд аашилна вэ? Би өөрөө ан гөрөөний хэрэгт бузгай сайн, эврээр

бол царс болгон хариу цаариатахаар хангинатал цэвэр сайхан бүрээдэж чадна. Надтай жаал зөөлөн байж болохтой доо гэхэд,

- Энэ хүнд эвэр өг, тэр гайхуулж байгаа эрдмээ үзүүлээд орхиг! гэж Локелт өгүүллээ.

Ширээт Эймер дохио бүрээдсэнд тэргүүлэгч зөвхөн толгой сэгсэрнэ. Тэгэхэд,

- Эрхэм ширээт та бүрээдэж чаддаг юм байна, гэхдээ үүгээр биднийг аргацааж чадахгүй. Бид зөвхөн хөгжимдсөний төлөө чамайг суллахгүй. Тэгээд ч манай элдэв франц маяг оруулж английн эртний эвэр бүрээний аяыг эвддэг хүмүүсийн нэг юм байна. Үгүй ширээт үүнийхээ төлөө чи золиосон дээрээ нэмж тавин зоос торгуулна. Аргагүй хохь чинь, нохойн авын эртний аялгууг бүү эвд гэж хэллээ.

Лам үүнд дургүйцсэн дуугаар, - За найз минь миний таалалд тааруулах гэдэг хэцүү зүйл байх нээ. Харин миний золиосны хувьд л үг хэлээ хялбар шүү оролцохыг гуйя. Нэгэнт чөтгөр шуламд үйлчлэх хэрэгтэй болсон хойно дөрвөн зүгийн аль дуртай руу арван манаач үгүй сул тавихын тулд надаас хэдий хир юм авах санаатай байгаагаа шулуухан хэлж орхи гэхэд бүлгийн тэргүүлэгчийн туслах,

- Тэргүүлэгчээ, еврейгээс хэдий хир мөнгөн золиос авахыг ламаар хэлүүлж ламаас юу авбал зохихыг еврейгээр тогтоолговол зүгээр биш үү? гэж шивнэлээ.

-- Чи хэдийгээр ухаан муутай залуу боловч тун мэргэн юм бодож олжээ! гэж Локсли хариулаад, - Алив еврей чи цаашаа яваад ир! Жорво дахь баян хийдийн ширээт Эймер багштан энэ байж байна. Үүнээс хэдий хир мөнгөн золиос авч болохыг хэлж орхи. Энэ хийдийн орлого хэдий хир болохыг чи сайн мэднэ гэж батлахад бэлэн байна гэвэл Исаак өөдөөс нь:

- Би мэдэлгүй яах юм бэ? Лам багш нартай би байнга наймаа арилжаа хийж улаан буудай, хар будаа зэрэг элдэв үр шимийн зүйл бас их ноос худалдаж авдаг билээ. Тэр чинь их баян хийд. Жорвогийн ариун явдалт багш нар сайхан хоол зооглож амтат дарс уудаг улс. Над шиг адгийн муу ядуу хүнд тийм сайхан орон байр бас дээр нь тийм жил бүр, сар бүрийн орлого байдагсан бол олзноос суллагдахын тулд би маш их алт мөнгө өгөхсөн билээ гэвэл лам дуу алдан,

- А – а муу нохой! Бид баригдаж дуганы байгаа өргөтгөлийн өрийг өнөө хүртэл төлж дуусаагүй байгааг чи хэнээс ч илүү сайн мэдэх учиртай... гэтэл еврей үгий нь таслан:

- Мөн өнгөрсөн жил танай ердийн нөөц болох саксон дарс зооринд чинь нийлүүлсний өр бас байгаа, гэвч энэ ялимгүй явдал гэлээ.

- Энэ муу бузар нохой юун дэмий юм яриад байна вэ? Үүний үгийг чагнах юм бол манай хуврагуудад зөвхөн хүйтнээс хамгаалах төдийд л уухыг зөвшөөрдөг дарсандаа өр тавьсан байхнээ. Адгийн муу еврей гэгээн сүм хийдийн эсрэг нүглийн муухай гүтгэлэг хийж байхад христос шашинтан хүмүүс дуулаад түүнийг зогсоохгүй байж байна гэнээ! гэж ширээт өгүүлэв.

Локсли үүнд, -Эд бүгд чинь хоосон яриа, энэ хүн өөртөө онцын хохиролгүйгээр хэдий хир юм өгч чадахыг еврей тогтоо гэвэл Исаак өөдөөс нь,

- Зургаан зуун крон, энэ мөнгийг хүндэт ширээт ламтан өршөөлт танд элбэг төлж чадна. Үүнээс болж багштан хосорчихгүй гэв. Тэргүүлэгч ихэмсгээр –Зургаан зуун крон, за яахав надад болохтой санагдана. Исаак чи шударгаар шийдлээ. За тэгвэл зургаан зуун крон. Ингэж тогтлоо шүү эрхэм ширээт гуай гэвэл дээрэмчид тосон авч,

- Тогтлоо! Тогтлоо! Соломон хаан өөрөө ч гэлээ илүү мэргэнээр шийдэж чадахгүй байсан гэж хашгиралдав.

- Ширээт шийдвэрийг дуулаа биз! гэж тэргүүлэгчийг өгүүлэхэд,

- Эрхмүүд, та нар солиоров уу? Тэр их мөнгө би хаанаас олох юм бэ? Би тахилын цөгц мандал сэлтээ худалдлаа ч гэсэн үүний чинь дөнгөж хагаст л хүрэх хэрэгтэй. Гэхдээ манай хоёр гэлэнг эндээ барьцаанд үлдээж болох юм шүү гэж ширээт хэллээ.

- Энэ чинь дэндүү осолтой юм болно. Харин чи өөрөө манайд барьцааны хүнээр үлдээд тэднийг золиос мөнгөндөө явуулбал дээр. Тэр зуур бид чамайг өлсгөж зовоохгүй. Аяга дарс, ангийн шарсан мах хэзээ ч чамд олдож байхын дээр чи үнэхээр анчин хүн юм бол урьд хожид чиний үзээгүй сайхан аванд оролцуулж болно гэж тэргүүлэгчийг хэлтэл Исаак дээрэмчдэд нүүр олохыг хичээн ярианд оролцож:

- Эсвэл өршөөлт таныг таалах аваас, эрхэм дээд ширээт надад гарын үсэг хийж өгөхийг зөвшөөрвөл би бусдын итгэмжлэн өгсөн хөрөнгөнөөс зургаан зуун крон зээлж хэрэгэхээр Йорк руу хүн явуулж болно гэв.

Локсли үүнд, --наадах чинь чамд ямар ч гарын үсэг хийж өгнө, харин чи л нэг зэрэг өөрийн болоод ширээтийн золиосыг төлж таарах болно доо гэж Локслийг хэлэхэд,

- Өөрийнхөө төлөө гэнээ! Би чинь хоосорч гүйцсэн хүн. Би өөрийнхөө төлөө юу төлж чадах юм бэ? гэж еврей сандрав.

- Энэ тухайг харин ширээт мэдэж тогтоог гэж тэргүүлэгч маргаад, -Эймр багштан, энэ еврей өөрийнхөө төлөө олигтой золиос төлж чадах уу, та юу гэж бодож байна? гэсэнд ширээт тосож аваад,

- Энэ чадах уу гэнээ? Үгүй энэ чинь Йоркийн Исаак шүү дээ. Израйлын арван үеийнхнийг цөм ассирийн олзноос золионд авчихаж чадахаар лут баян хүн! Би өөрөө үүнийг онц сайхан танихгүй харин манай жасын даамал, нярав хоёр үүнтэй арилжаа хийдэг, тэгээд энэ новшийн Йоркод байдаг гэр орноор дүүрэн алт мөнгө бий гэх юм билээ гэв. Еврей үүнд,

- Багш ламтан та байз, уураа дарж үз. Би мөнгө хэнд ч албадаж өгдөггүйг санана уу гэж багштан танаас гуйя. Хувраг хүн, хар хүн, хан хүү, лам, баатар гэлэн ялгаагүй. Исаакийнд очиж үүд тогшин коос зээлдэхдээ иймэрхүү хүндэтгэлгүй өнгөөр огтхон ч ярьдаггүй билээ.

Тэгэхийн цагт зөвхөн " Исаак найз минь нэг тус болж үз. Би тогтоосон хугацаандаа өгнө. Ганц л өдөр хойшлуулвал бурхан намайг цээрлүүлэг" гэх юм уу, "сайн санаат Исаак чи хэзээ нэг цагт хүнд тус болж үзсэн бол гай зовлон учирсан энэ цагт хүнд тус болж үз" гэдэг үг дуулддагсан. Зээлийн хугацаа дуусаж намайг өрөө авахаар очиход бол өөр хэргээ, тэгэхэд би, "Хараал идсэн муу еврей" болчихно. Тэгээд манай овгийн ешипедийн хамаг цээрлэл үзтүгэй гэж зүхэн бүдүүлэг ширүүн харчуулыг харь орны ядарсан улсыг бидний эсрэг босгох гэж болох бүхнийг хийдэг юм гэлээ.

Локсли- Ширээт та сонс энэ хэдийгээр еврей хүн боловч энэ удаа үнэн үг хэлж байна. Иймд хараалаа больж өөрт чинь золиосны хэмжээ заан өгсний адил үүнд мөн тогтоож өг гэж хэлэхэд ширээт,

- Христос шашны хувраг, загалмай зүүгээгүй еврей хоёрыг нэгэн зиндаанд авч үзэхийн тулд ёстой *Latro famosus* байх хэрэгтэй дээ. (латин үг) (Сүүлд нэг цагт би учрыг нь тайлж өгнө) Гэхдээ та нар энэ новшийн золиосны үнийг тогтоож өгөөч гэж надаас гуйж байгаа бол шуудхан хэлэхэд мянган кроноос бага мөнгө авбал та нар алдах болно шүү гэлээ.

- Тогтлоо! Тогтлоо! гэж дээрэмчдийн тэргүүлэгчийг өгүүлэхэд хань хамсаатнууд нь тосож аваад,

- Тогтлоо! Христос шашинтай боловсронгуй хүн болохоо үзүүлж, бидний тусын тулд еврейгээс илүү зүтгэл гаргалаа гэлцэв.

- Эцэг өвгөдийн минь шүтээн аварч үз! гэж Исаак орь дуу тавин, - Явж явж та нар золгүй намайг хөнөөхөөр шийджээ дээ? Дөнгөж сая би охиноо алдлаа, тэгэхэд эцсийн амь зуулганаас минь та нар салгах гэж байх шив! гэхэд Эймер хариуд нь:

- Еврей чи үнэхээр үр хүүхэд үгүй юм болж гэм өөрт чинь бүр сайн, хэнд ч гэж мөнгө хуурахын хэрэг алга гэв.

- Яая гэх вэ ноёнтон, таны ёс гурим танд гэр бүл зохиохыг зөвшөөрдөггүй болохоор эцэг хүний сэтгэлд төрсөн үр нь хир дотно болохыг та мэдэхгүй байна. Миний янаг хайрт Рахилийн охин Ревекка минь! Энэ модны навч бүр зоос байгаад тэр бүгд миний өмч байлаа гэхэд чиний амьд мэнд байгаа, буруу номтны гараас мултарч чадсан гэдгийг дуулахын тулд тэр их баялгийг цөмийг өгөхсөн бүлгээ гэж Исаак өгүүлэв.

- Дээрэмчдийн нэг нь - Чиний охин чинь хар үстэй юу? Мөнгөн хатгамалтай торгон уужтай байгаагүй биз? гэж асуувал өвгөн түрүүн айж сүрдэн чичирч байсан шигээ сандран дагжиж,

- Тийм, тийм Иаковын ивээл чамд хүртэх болтугай! Тэр бүсгүйн тухай чи надад ямар нэг юм дуулгаж чадахгүй биз? гэхэд,

- За тагвэл бардам зант сүмийн хорооны баатар өчигдөр орой манай багийн дундуур дайрч гарахдаа аваад явсан байж таарлаа. Би хойноос нь нэг сум тавих гэж нумаа бүр тэлснээ бүсгүйг гайгаар оночихож магад гэж айгаад харваагүй юм гэж Йомен өгүүлэв.

Еврей хариуд нь, - Ээ халаг чи уул нь харвасан бол дээр байхсан! Чиний сум охины минь цээжийг шувт онохгүй яав даа! Харгис хэрцгий сүмийн хорооны баатрын гарт орсны оронд өвөг дээдсийнхээ бунханд хэвтэж байвал дээр байхсан. Мөн ч их үйл лайтай хүнээ дээ би. Ээ, чааваас гэж, манай гэр бүлийн нэр төр баларлаа! гэж дуу алдлаа.

Дээрэмчдийн тэргүүлэгч үүнд, - Нөхөд минь энэ хэдийгээр еврей хүн боловч учирсан зовлонд нь би өрөвдөж байна. Исаак чи шударгаар хэл, бидэнд мянган крон төлөөд үнэхээр сохор зоос ч үгүй үлдэх үү? гэвэл,

Локслийн ийн асуусанд . Исаакийн царай, зэвхийрч "Үгүй бас жаал зугаа юм үлдэж ч мэднэ" гэж дуугарахад хүргэв.

- За яамай, бид цаана цаана гэлцэх явдалгүй. Бриан де Буагильбер гуайн савраас хүүхдээ мөнгөгүйгээр гаргаж авна гэдэг мохоо зэвтэй сумаар хангал буга намнах гэсэнтэй адил найдлагагүй хэрэг. Бид чамаас ширээт Эймерээс авсантай адил, яахав бүр нэг зуун кроноор бага золиос авъя. Тэр зуун крон миний хувь байх учирлалгүйгээр түүнийг чамаас авахаа больё. Үүгээр бид еврей худалдаачныг христос шашны хуврагтан адил өндөр үнэлэх бас нэг их нүглээс зайлсхийх бөгөөд чиний өвөрт охиноо золиж авах таван зуун зоос бас үлдэх болно. Сүмийн хорооны баатар мөнгөн зоосны гялбаанп хар нүдний гялалзахаас багагүй дуртай. Буагильберийг мөнгөөрөө бушуухан татахыг оролд, тэгэхгүй бол их гай учирч мэднэ. Тагнуулуудын мэдээлснээр чи түүний ойр хийдэд олж уулзаж чадна. Миний хэлдэг үнэн биз золбоот нөхөд минь? гэхэд Йоменүүд ердийнхөөрөө тэргүүлэгчтэйгээ бүрэн санал нийлж байгаага илэрхийлэв.

Охин нь амьд мөнгөөр золиослон авах гэж оролдож болохтойг дуулсан Исаак сэтгэл тайвшран өгөөмөр сэтгэлт дээрэмчний хөлд сөхрөн уналаа.

Локсли гэдэргээ ухран:

- Алив бушуухан бос! гэж дуу алдаад, --Би англи хүн, дорно дахины ийм ёсорхолд дургүй. Над шиг өчүүхэн нүгэлт хүнд биш, бурханд мөргө гэвэл ширээт Эймер тосож аваад,

- Тиймээ Исаак бурхны өмнө, түүний хувраг санваартны өмнө өвдөг сөхөр, чин сэтгэлээр гэмшиж Роберт гэгээний сүмд олигтой өргөл барих аваас чамд болоод охин Ревеккад чинь санамсаргүй их өршөөл хүртээж болох юм. Тэр хүүний үйл тавилангийн төлөө би харамсаж байна, юу гэвэл, үнэхээр үзэсгэлэн гоо хүн билээ. Би Ашбийн эрүүл тулалдаан дээр түүнийг харсан. Бриан де Буагильберийн тухайд гэвэл би түүнд их нөлөөтэй юм. Чиний орноос үг хэлж өгөхөөр миний талархлыг юугаар татаж чадахаа чи сайн бод гэв.

Тэгтэл Локсли Исаакийг хажуу тийш нь аваачин,

- Энэ тухайд яасхийж хөдөлбөл зохихыг Исаак чи сайн бод. Энэ ламд,жаал тал засахыг хичээ гэж би зөвлөх байна. Энэ чинь нэр төрд дуртай, хар амиа хичээсний дээр зугаа цэнгэлийнхээ зарлаганд мөнгө их хэрэгтэй байдаг болохоор чи хялбархан таалалд нь нийцүүлж чадна. Чамайг их ядуу гээд байсанд чинь хурмын төдий боловитгэсэн гэж битгий бодоорой. Чиний мөнгөтэй хүүдийгээ хадгалдаг төмөр авдрыг би сайн мэднэ. Үгүй тэр юу ч биш! Чиний Йорк

дахь цэцэрлэгийн дорхи дүгрэг дээвэр адартай зорь руу орох нууц нүхийг тагласан алимны модон дорхи том чулууг би сайн мэднэ гэж хэлэхэд Исаакийн царай цайгаад явчихлаа.

Йомен цааш нь, - Гэхдээ чи надаас бүү айгтун, юу гэвэл чи бид хоёр хуучны найзууд шүү дээ. Чиний охин Ревекка Йоркийн шоронгоос мөнгөөр золиж аваад эдгэрч сайжиртал нь гэртээ байлгасан өвчтэй йоменыг санаж байна уу? Бие нь сайжирч танайхаас явах болоход чи замдаа хэрэгэл гэж мөнгөн зоос өгч билээ. Чи үнэхээр хэдийгээр мөнгө хүүлэгч боловч тэр удаа надад мөнгөн зоос өгсөн шигээ мөнгөө сайнаар гүйлгэж ер байгаагүй, тэр чинь өнөөдөр чамд бүтэн таван зуун крон хэмнэж өглөө шүү дээ гэж хэлэхэд Исаак өөдөс нь:

Тэгвэл чи өөрөө харвагч Дик гэж бидний нэрлэдэг байсан хүн байх нээ? Чиний дүү нэг л танил юм шиг надад санагдаад байсан юмаа тэр гэлээ.

Тэргүүлэгч үүнд, - Тиймээ, би өөрөө харвагч Дик, мөн Локсли гэгч байна. Чиний охины хувь заяаны тухай би үнэн голоосоо зовж байгаад итэг. Харин энэ ажилд тус болж чадахгүй. Ил талд миний сүм сүмийн хорооны баатрын жадны эсрэг юм болохгүй, цаадах чинь намайг нүд ирмэхийн зуургүй үгүй хийж орхино. Буагильбертэй Ревекка цуг байсныг мэдсэн бол тэгэхэд зогсоох гэж оролдох байсан билээ. Одоо тэгэхэд ганцхан зам байна, аргаар нь оролд. Аль чиний төлөө, би энэ ламтай наймаа тохирох уу гэж оролдох уу? гэхэд,

- Бурхан өршөөг... Дик явал дээр байна өөрөө мэд, төрсөн үрийг минь аврахад л ганцхан тус болж үз гэв.

Локсли эргэж Эймер дээр ирэхэд Исаак хойноос нь дагаж очив.

- Ширээт Эймер чамайг сайн дарс, аятайхан бүсгүйчүүлтэй хамт байхад санваартан хүний хирээс илүү ихээр дуралдаг гэж ярилцах юм билээ. Бас сайн үйлдрийн ноход, хурдан хөлөг моринд дуртай гэлцдэг. Гэхдээ дарангуйлагчийн зоргоороо хүчирхийлэл, харгислалд ууртай гэж харин хэзээ ч дуулаагүй юм байна. Тэгэхлээр ийм байна. Исаакийн охиныг суллаж явуулж гэж найз сүмийн хорооны баатрыгаа чи ятгаж өгөхийг оролдвол Исаак чамд зуун том мөнгөн зоостой хэтэвч өгөхөд бэлэн байна гэвэл ширээт өөдөөс нь:

- Энэ чинь нилээн нарийн төвөгтэй ажил, нэг талаас сайн үйл боловч нөгөө төлөөс еврейн ашиг тусын тулд зүйл болохоор миний сэтгэлд харш зүйл, гэхдээ үүнийхээ дээр еврей хийдэд ямар нэгэн өглөг барих юм бол, жишээ нь хуврагуудын нийтийн унтлагын байр барихад том юм өргөвөл би яах вэ өөртөө нүгэл хурааж охиноо гаргаж авахад нь тус болж болно гэв.

- Унтлагын байр барих хориод том мөнгөн зоосны төлөө юмуу, бурханд өргөх хоёр мөнгөн цөгцний төлөө тантай бид маргалдахгүй шүү гэж тэргүүлэгч өгүүлэв.

- Энэ амлалт биелэгдэнэ гэж хэн надад баталгаа өгөх юм бэ? гэж ширээтийг өгүүлэхэд тэргүүлэгч хариуд нь,

- Таны дэмжлэг оролцоотойгоор ажил төрлөө амжилттай төгсгөөд гэртээ ирмэгцээ Исаак танд бүгдийг шударгаар төлж өгнө гэж губерт гэгээний нэрийг барьж андгайлая. Би өөрөө үнийг хянах болно гэлээ.

Эймер, - За сайн байна, Исаак алив бичгийн хэрэгслэлээ нааш нь аль. Үгүй больё. Чиний бийрийг гартаа барьснаас би бүтэн хоног хоол ундгүй суусан нь дээр. Гэхдээ би өөрийг хаанаас олох билээ дээ? гэвэл Локсли:

- Багш ламтан та, еврейгийн бэхийг хэрэглэхээс сэжиглэхгүй бол үзэг бий, одоохон олоод өгье гэж хэлээд алс Хольдернесийн намаг өөд бүхэл сүргээрээ тэдний толгой дээгүүр өндөрт нисч явсан зэрлэг нугас руу нумаа тэлж харвалаа. Шувт харвуулсан шувуу далавчаа аяархан хөдөлгөсөөр хөсөр ойчив.

- Харж байна уу, ширээт Жорвогийн бүх хийд зуун жил хэрэглэж хүрэхээр нугасны олон өд байна. Танай гэлэнгүүдийн тооллын судар хөтөлдөггүй нь сайхан гэж Локсли өгүүлэв.

Ширээт тавлан сууж Бриан де Буагильберт өгөх захидлыг яаралгүй бичиж, нямбайлан дугтуйлаад еврид өгч:

--Энэ чамд бие хамгаалах бичиг болж Темлстоу дахь хийдэд нэвтрэн ороход төдийгүй охиноо суллаж авахад чинь хэрэг болно. Сайн баатар Буагильбер хүнд зүгээр тус хийдэггүй улсын нэг мөн гэж миний хэлж байгаад итгэн олигтойхон шиг шан амлаарай, мэдэв үү гэхэд тэргүүлэгч,

- За ширээт, би чамайг цаашид саатуулахаа больё. Чиний золиос гэж тогтоосон зургаан зуун кроныг Исаакаас зээлж авсан гэдэг баримт бичиг хийж өг. Би өөрөө түүнийг Исаакаас авна. Харин чи сүүлд нааш цааш чангааж өгөхгүй сунжруулсан байхыг дуулах юм болж гэм ариун Мария дагиныг барьж андгайлахад чамайг хийдтэй чинь шатааж орхино шүү. Тэглээ гээд уг тавилангаасаа нэг арван жилийн өмнө дүүжлэгдэх болжээ ч гэсэн хамаагүй гэв.

Ширээт түрүүчийнхээс ихээ дурамжхан боловч Иоркийн Исаакаас зургаан зуун крон зээлээр авсан, төдий хугацаанд заавал шударга үнэнээр төлж өгнө гэсэн гарын үсэг хийж өглөө.

Ширээт Эймер, одоо миний морь луусыг эргүүлж өгөөд дагалдаж явсан лам багш нарыг суллана уу! Мөн үнэт эрдэнийн бөгж, очир алмас болоод булааж авсан үнэт хувцас хунарыг буцааж аль гэхэд Локсли хариуд нь,

- Танай гэлэнгүүдийн хувьд гэвэл эрхэм ширээт гуай, бид тэднийг суллахгүй саатуулаад байвал шударга бус болохсон. Морь луусыг мөн танд өгнө. Иоркод эсэн мэнд явж хүрэхээр цөөн мөнгө ч бас өгнө. Энэ аялалд таныг зардалгүй болгож орхих гэдэг хатуу сэтгэл байхсан. Харин бөгж, гинж, тээг тэргүүтний хувьд гэвэл бид үнэнч сүсэгтэн улсын хувьд эрхэм багш таныг хорвоогийн хоосон өнгө мөнгөнд шунуузай гэж эмээж байгааг та өөрөө ойлгох учиртай. Та чинь хорвоогийн хоосон цэнгэл, сэтгэл санаа уруу татах бүхнээс ангид байх андгай өргөсөн хүн шүү дээ.. Тэгэхлээр бид бөгж, гинж болоод бусад харчуулын гоёлыг танд эргүүлж өгөн сэтгэлийг чинь нүгэл рүү татахын хэрэг юу байна? гэвэл ширээт өгүүллүүн:

- Юу сэдэж байгаагаа эрхмүүд сайн бодоорой! Энэ чинь сүм хийдийн эд хогшилд хуруу дүрнэ гэсэн үг. Уул эдлэлүүд ариун сахиустай, энгийн хар хүмүүс та нар түүнд гар хүрснээр ямар их гай дуулж болохыг би мэдэхгүй байна гэв.

Копмангерстийн даянч ярианд оролцон, - Эрхэм багштан тэр тухай би санаа тавья. Тэдгээр зүйлийг би өөрөө зүүх болно гэвэл эргэлзээг нь ийнхүү санамсаргүй тайлсны хариуд ширээт,

--Найз буюу нэгэн санваарт нөхөр минь, чи үнэхээр хуврагийн тоонд ордог ахуул өнөөдрийн энэ хэрэг явдалд оролцож байгаагаар, хийдийн даалуудын өмнө ямар хариуцлага хүлээх тухайгаа сайтар бодохыг зөвлөөт гэв.

Даянч өөдөөс нь, - Ширээт найз минь би тун жижигхэн хийдийн хүн болохыг мэдэж ав. Түүндээ би өөрөө тэргүүн даамал бөгөөд Йоркийн амбууд, гэлэнгүүд Жорвогийн ширээтээс эмээх явдал огт үгүй билээ гэхэд,

- Тэгвэл би жинхэнэ лам хүн биш байхнээ. Арун санваартны нэрийг дур мэдэн зээлдэж бурхны мөргөл залбирлыг доромжлон хилэнц хурааж явдаг этгээдийн нэг болж таарлаа гэж Ширээт өгүүлэв.

- Үгүй, зүгээр л би латин хэл нухаж толгойгоо эргүүлэх дургүй байсан юм. Харин чиний тэр бөгж болоод бусад новшнуудыг булааж авч хорвоод чиний хямсганах, хээнцэрлэхийг тас цохисон явдлын хувьд гэвэл би зүй ёсны хэрэг гэж үзэж байна гэж даянчийн өгүүлэхэд,

- Миний үзтэл чи ичгүүрээ алдсан нэр зээлдэгч этгээд байна! гэж ширээт уурандаа багтран дуу алдаж, чамайг сүм хийдийн ивээлээс гаргалаа гэв.

Даянчийн хилэн мөн бадарч, - Чи өөрөө хулгайч, буруу номтон! Би чиний доромжлолыг, тэр дундаа шавь нарынхаа дунд хүлцэн өнгөрүүлэхийг хүсэхгүй! Нэгэн санваартан болох намайг муучлахдаа чи ичихгүй байна уу? Би чиний хамаг ясыг яйчаад өгье гэж хашгичав.

- Уухай гэж Локсли дуу алдаад, - Лам багштан иймэрхүү янзаар үг хэлээ ололцох болов уу? За гэлэн чи боль! Ширээт чи нүгэл бүхнээ бурхны өмнө наминчлаагүйгээ өөрөө мэдэж байгаа, тэгэхлээр манай даянч руу давшлахаа зогс. Даянч чи дуулж бай, багш ламтанг найртайгаар явуулах, энэ чинь золиосоо төлж орхилоо шүү дээ гэв.

Хилэгнэж, лам хэлээр халь мулт хараал хэрүүл болсоор байгаа гэлэнгүүдийг йоменүүд арайхийн салгав. Ширээт илүү зөв шуудхан ярих авч даянчийн үг хүчтэй, оновчтойгоор давах ажээ. Сүүлдээ дээрэмчдийн багштай хэрүүл хийж байгаагаар нэр хүндээ алдаж байгааг ширээт ухаарав. Замын нөхдөө дуудаж дагуулан замдаа орлоо.

Локсли еврейгээс өөрийн болоод ширээтийн золиосыг төлнө гэсэн баталгаа гарын үсэг авахаар үлдсэнд,

- Исаак Йорк дахь нөхдийнхөө нэгнээс мянга нэг зуун крон ав гэсэн гарынхаа үсэг бүхий баримт бичиж өгөв.

- За баяртай, Дик, чамайг би сайхан сэтгэлтэй хүн гэж чадахгүй, мөн хорон муу санаатай гэж хэлж зүрхлэхгүй, хүсэх ч үгүй байна гэж Исаак дараа нь өгүүлэв.

Тэгээд ойгоор замчилж өгөх, мөн хамгаалагч болох гэсэн хоёр биерхүү йомены хамт замдаа

гарлаа. Энд болсон бүх явдлыг машид сонирхон ажиглаж суусан хар баатар мөн дээрэмчинтэй салах ёс гүйцэтгэж эхлэв. Хуулиас давж гарсан эдгээр хүмүүсийн дунд ноёрхож байгаа гурим журмыг үзэхэд гайхсанаа илчлэхгүй байж чадсангүй. Үүний хариуд Йомен

- Тиймээ эрхэм баатраа, муу модноос сайн жимс ургах учир байдаг, мөн цөг гэдэг ганцхан гай тарьдаг ч юм биш. Хууль зүйнээс даварч гарсан хүмүүсийн дотор зоргоор байдлаа зохицуулан даруугаар ашиглаж байгаа хүмүүс яриагүй байгаагаас гадна нөхцөл байдалд хавчигдсан ийм ажил эрхлэх болсондоо зарим нь бүр харамсдаг билээ гэв.

- Одоо би лав тэдний нэгтэй үг сольж байнаа даа? гэж баатрын асуухад дээрэмчид хариуд нь:

- Эрхэм баатар бидний хэн бүхэнд хувийн нууц бий. Та миний тухай юу гэж бодно вэ, тааллаараа бологтун. Таны талаар надад ч зарим таавар байна, гэхдээ та бид хоёрын хэн хэн нь оноогүй байж тун болох юм шүү. Би нэгэнт нууцаа тайлж өгөхийг танаас гуйхгүй байгаа болохоор миний өөрийнхийгөө ярьж өгөөгүйд битгий гомдоорой гэлээ.

- Зоригт йомен та намайг уучлаарай, чиний ийнхүү зэмлэдэг зүйтэй. Гэвч бид дахин учрах, тохиолдол гарч мэдэх юм. Тэгвэл нэг нэгнээсээ нуухгүй шүү. Одоо тэгээд бид бодоход сайн нөхөд ёсоор салж байгаа биз? гэхэд Локсли өөдөөс нь:

- Май миний гар энэ байна нөхөрлөлийн тэмдэг болгож барья. Би одоогоор хэдий дээрэмчин боловч энэ бол шударга англи хүний гар шүү гэж би зориг бардам хэлж чадна гэлээ.

- Май миний гар энэ байна, би чамтай гар барихыг их завшаанд үзэж байгаагаа дуулгая. Юу гэвэл муу үйл зоргоороо үйлдэх боломжтой байсан атал сайн үйл хийж байгаа хүн зөвхөн хийсэн сайн үйлийнхээ төлөө төдийгүй хийж үйлдэж болох бүх мууг тэвчсэнийхээ төлөө сайн үг дуулах учиртай бүлгээ. Зат зоригт дээрэмчин баяртай! гэлээ.

Эдгээр дайны сайн нөхөд ийнхүү салж одов. Зүүлттэй цоожин сүлдэт баатар аян дайныхаа бат их хөлгийг унан ой дундуур одлоо.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Жон хаан

Анд нөхөр минь сонс, чамд хэлэхэд,

Алив бүх замыг минь тэр могой шиг хааж байна

Явсан газар болгонд яг тэр бүртэгнэх юм.

Ярьсан үг минь харин ойлгомжтой байна уу?

"Жон хаан"

Йоркийн цайзанд хаан хүү Жон их найр хийлээ. Ахынхаа хаан ширээг эзлэхэд тус болно гэж горилсон бүх тайж, лам нарыг урьжээ. Түүний аргат овжин хамсаатан Вальдемар Фицурс зочдыг илэрхий тэмцэлд босгохыг хичээн дунд нь эргэлдэнэ. Гэвч хуйвалдааны голлох хэдэн хүн үгүй байснаас болон уг хэрэг удааширлаа. Энэ бодлогоо амжилттай гүйцэлдүүлэхийн тулд Фрон де Бефийн хахир шургуу зан, шийдсэн зориг, Морис де Брасийн хөгжүүн эрэлхэг чадал, Бриан де Буагильберийн байлдааны туршлаганд түшиглэхгүй горьгүй байлаа. Хаан хүү Жон хайртай зөвлөгчтэйгээ тэдний ийнхүү үгүй байгаад дотроо хараавч тэдэнгүйгээр хөдөлж эс зүрхлэнэ. Еврей Исаак мөн нэг тийшээ алга болчихоод, түүгээр дамжуулан нутгийн еврейгээс зэгсэн их мөнгө зээлэх гэсэн горьдлого үүгээр тасарчээ. Ийм эгзэгтэй үед мөнгө дутагдах гэдэг сүйрэлд хүргэж болох байлаа.

Торкильстон цайз унасны маргааш өдөр де Браси, Буагильбер болон тэдний холбоотон Фрон де Беф нар олзлогдсон юм уу алагдсан гэдэг цуу хотоор дэгдлээ. Энэ цууны тухай Фицурс биеэр хаан хүүд дуулгаад баатрууд тун цөөн хүнтэйгээр Седрик рүү дайрах гэж байсан болохоор тун ч үнэний хувьтай болов уу гэж үзэж байгаагаа нэмж хэллээ.

Өөр цагтсан бол иймэрхүү хэргийг хаан хүү их наргиантай зүйлд тооцох байсан авч энэ удаа уул ажил өөрийн нь үйл хэргийн бүтэлд саад болсон болохоор үүнд оролцогсдыг буруушаав. Хууль дүрмийг дагах хэрэгтэй болоод хувийн өмчинд халдашгүй тухай сүржин ярьж, чухамхүү Альфед хааны амнаас гарах үгийг хэлж байв.

- Зоргоороо дээрэмчид! Би нэг цагт английн хаан болох юм бол тэгж хууль даврагчдыг өөрсдийн нь цайзны дүүжлүүр хөөргөнөөс өлгөж байх болно! Гэж хаан хүү хашгичин байв.

Хаан хүүгийн албан ёсны зөвлөгч үүнд хүйтнээр хариу өгөхдөө,

- Гэхдээ английн хаан суухын тулд гэгээн дээдэс минь, бидний хамгаалах гэж сайшаалтай хүчин зүтгэл гаргаж буй хуулийг эдгээр зоргоороо дээрэмчид байн байн зөрчиж байгаа ч гэсэн үүнийг нь та хүлцэнгүй өнгөрүүлэх төдийгүй өмгөөлж ивээх хэрэгтэй билээ. Гэгээн дээдэс таны хүслийг болхи саксончууд хэрэгжүүлэн, ноёдын цайзны дүүжин хөөргийг дүүжлүүр болгочих юм болж гэм бидэнд их ашиг гарах вий, хэлэх ч үг алга! Тэр Седрик чинь иймэрхүү санаа толгойд нь төрж яг болохоор хүн. Эгнээндээ Фрон де Беф бээл, де Браси,

сүмийн хорооны баатар үгүйгээр эндээсээ хөдлөх гэдэг бидэнд аюултай болохыг та мэднэ. Гэтэл бид бас урахын эрхгүй хэт аашилсан билээ гэв.

Хаан хүү Жон унтууцан духаа алгадаад, өрөөн дотуур том том алхан холхино.

- Адгийн шаарууд, урван тэрслэгчид! Ийм үед намайг орхих гэж байх уу? гэв.

- Завхай зайдан амьтад гэвэл илүү таарна, юу гэвэл чухаг хэргийн оронд дэмий зүйлээр хөөцөлдөж байна гэж Вальдемар өгүүлэв.

- Одоо тэгээд яах вэ? гэж хаан хүүг асуухад Фицурс өөдөөс нь:

- Бүх зохих захирамжуудыг би нэгэнт өгсөн. Өмнө нь ажил төрлийг аварч болох бүхнийг хийлгүйгээр ийм урагшгүй юмны тухай дуулгах гэж гэгээн дээдэс дээр би ирэхгүйсэн билээ гэв.

- Вальдемар чи хэзээнээс миний сайн зүгийн тэнгэр байсан. Би ямагт ийм тэргүүн захирагчтай байвал миний хаанчлал энэ орны он тооллын судар бичигт магтагдан дуулагдах болно. За чи тэгээд чухам ямар захирамж өгөв дөө? гэхэд:

- Морис де Брасийн тэргүүн туслагч Луй Виншельбрадыг бүрээдэж багаа цуглуулан, даруй мордож тугаа хийсгэн манай нөхдийг тэнхрүүлэхээр Фрон де Бефийн цайз руу давхи гэж би тушаалаа гэвэл хаан хүү Жон өөрийгөө доромжилж байна гэж бодсон муухай ааштай эрх хүүхэд аятай царай нь улайлаа.

- Бурхны мэлмийг барьж андгайлахад, Вальдемар Фицурс чи арай хэтэрч байгаа юм биш биз? Яаж зүрхлэнэ вэ? Бүрээ татаж, туг хийсгэх гэнээ, бид өөрсдөө энд сууж тэр талаар ямар ч тушаал өгөөгүй байхад тэр шүү! гэхэд Фицурс дотроо эзнийхээ хоосон ихэмсэглэх занг хараан байж,

- Өндөр дээд эзэнтэн та өршөө, гэхдээ удааширч болохгүй байлаа. Хувь хурам бүр үнэтэй байсан болохоор би өөрөө тушаал өгч болох юм гэж үзсэн билээ гэв.

Хаан хүү ихэмсгээр – Фицурс, чамайг би өршөөе. Болчимгүй яарсны бурууг зөв сайн санаа зөвгөнө... Үгүй энэ чинь хэн харагдаж байна вэ? Загалмай барьж андгайлахад де Браси биеэрээ байна. Бидний өмнө энэ ямар хачин байдалтай ирж байна вэ! гэв.

Үнэхээр де Браси мөн байлаа. Хурдан давхисандаа царай нь улайж, давируул нь цус болжээ. Бүр зэр зэвсэг нь саяхан шургуу тулалдааны ул мөртэй, хугарсан, хонхойсон олон газраацусанд будагдаж шавар болсон, хөлөөсөө толгойгоо хүртэл зузаан тоосонд дарагджээ. Дуулгаа тайлж ширээн дээр тавиад, авчирсан мэдээгээ дуулгаж зүрхлэхгүй байх мэт хувь хиртэй дуугүй зогсов.

- Де Браси энэ чинь юу гэсэн үг вэ? Хэл, би чамд тушааж байна? Саксончууд самуураа юу? гэж хаан хүү асуув.

Фицурс мөн хаан хүүтэй бараг ам уралдан, - де Браси чи яриач, чи хэзээний зоригтой эр

байсан шүү дээ. Сүмийн хорооны баатар хаана байна? Фрон де Беф яасан бэ? гэхэд де Браси хариуд нь:

- Сүмийн хорооны баатар зугтасан. Фрон де Беф бээлийг та бүхэн дахин олж харахгүй болсон, өөрийнхөө цайзны улайдсан балгасан дотор улайдмал авсанд талийгаач болсон. Би ганцаар амь гарч энэ тухай дуулгахаар хүрч ирлээ гэв.

- Чи хэдийгээр түймэр дөлийн тухай ярьж байгаа боловч ийм мэдээг сонсоод жихүүдэс хүрч байна шүү гэж Вальдемарыг өгүүлэхэд,

- Бүр муу мэдээ цаашаа дуулгана гэж Браси хэлээд,

- Хаан хүү рүү ойртож очоод намуун нухацтай дуугаар,

- Ричард энэ Англид байна. Би түүнтэй уулзсан, ярилцсан гэлээ.

Хаан хүү Жоны царай зэвхийрч гуйвснаа цээж рүүгээ буудуулсан хүн аятай болоод унахгүйн тулд царсан вандангийн түшлэгнээс шүүрч авлаа.

- Де Браси, чи солиорч байна, тийм юм байж таарахгүй гэж Фицурс дуу алдлаа.

- Энэ яриагүй үнэн зүйл, би түүнд олзлогдсон, тэр надтай юм ярьсан гэж де Брасийг өгүүлэхэд,

- Чи Ричард Пантагенеттай ярилцаа юу? гэж Фицурс цааш нь шалгаав.

- Тиймээ, Ричард Плангенеттай, арслан зоригт Ричардтай, Английн хаан Ричардтай ярилцсан гэж де Браси хариулбал Вальдемар өөдөөс нь:

- Чи түүнд олзлогдоо юу? Тэгэхлээр тэр, хүчирхэг цэрэг толгойлж яваа байх нээ? гэж асуулаа.

- Үгүй тэр цөөхөн чөлөөт Йоментэй байсан. Тэндээс салж одох гэж байгаа тухай үг хэлж байхыг нь би сонссон. Торкильстон цайзыг авахад нь туслах л гэж тэдэнтэй нийлсэн юм билээ гэв.

- За тийм байж, үүнд чинь Ричардын дүр бүхлээрээ илэрч байна. Жинхэнэ хэсүүлчин баатар, өөрийнхөө чадал, самбаанд найдан алив явдалд оролцохдоо ямагт бэлхэн. Гэтэл улсын чухал ажил задгайрч өөрийн нь амь нас хүртэл аюулд байдаг. Де Браси чи тэгээд юу хийх санаатай байна? гэж Фицурсийг асуухад,

- Би юу? Ричардыг миний чөлөөт багийн хүчийг ашиглана уу гэж гуйсан, тэр хүлээж аваагүй. Хүмүүсээ Гуль руу аваачиж, хөлөг онгоцон дээр суулган Фландри руу явна. Цаг төр үймээнтэй байгаагийн ачаар цэргийн хүнд хаана ч хийх юм олдоно. Вальдемар чи яах вэж? Улс төрийн бодлого орхин жад барьж надтай цуг одох цаг болсон юм биш биз? гэвэл,

- Тэгнэ гэхэд би хэт хөгширчээ. Морис тэгээд ч надад бас охин байна гэж Вальдемар хариулав.

- Фицурс охиноо надтай суулгаж орхи. Илднийхээ тусламжтайгаар би түүнд өндөр язгуур гаралд нь тэнцэхүйц бүхнийг хангаж өгч чадна гэж де Брасийг гуйхад, Фицурс хариуд нь:

- Үгүй, би эндхийн Петр гэгээний сүмд хоргодох санаа байна. Ингэхэд их хамба нь миний ойрхон төрлийн хүн юм гэв. Эднийг ярилцаж байх зуур гэнэтийн мэдээнд алмайрч орхисон хаан хүү Жон сэхээ авч өөрийн талынхны яриаг анхааран сонсов.

"Эд надаас хөндийрч байна, салхи дөнгөж хүчтэйхэн үлээхийн хамт сарнин одох хуурай навчих шиг. Ёстой шуламны хүчин гэгч байх гэж! Энэ шаарууд намайг орхиж одохоор үнэхээр яахын ч арга үгүй болно гэж үү!" гэж дотроо боджээ.

Баахан дуугүй байснаа худлаа инээд алдахад царай, дууны нь өнгө чухамхүү шулмын овжин байртай болж, тэдний яиаг таслан,

- Ха-ха-ха найз нөхөд минь! Үнэндээ би та нарыг ухаалаг, зоригтой хүмүүс гэж үзэж байсан юм шүү. Тэгээд юу болж байна? Тэгэхэд эд хөрөнгө, эрх ямба амьдралын баяр баясгалангаас чухал гэвэл уул сэдсэн сайн үйлийн бүх сайхан үр ашгаас ухарч байх шив. Тэгэхдээ ганцхан зоримог алхам хийгээд л бид ялж болох ийм үед няцаж байдаг гэхэд де Браси,

- Таны чухам юунд тулгуурлах санаатай байгааг ойлгохгүй байна. Ричардыг эргэж ирсэн тухай мэдээ тархаад орхихын хамт яахын зуургүй олон цэрэг түүнийг тойрон цугларна. Бид тэгээд л дуусах нь тэр. Дээд ноёнтон таныг франц руу зугтаах, юм уу, хан эх дээрээ очиж өмгөөлөл эрэх нь дээр гэж зөвлөмөөр байна гэхэд хаан хүү Жон дээрэнгүйгээр,

- Би хэнээс ч өмгөөлөл эрдэггүй хүн. Би ахдаа ганц үг хэлэхийн хамт л надад ямар ч аюул учрахгүй. Де Браси чи, Вальдемар чи, та хоёулаа надаас өчүүхэн эргэлзээгүйгээр хөндийрч байгаа ч гэсэн та хоёрын огтлуулсан толгой Клиффордийн хаалган дээр өлгөөстэй байхыг харахад надад онц таатай байхгүй шүү. Ричардын өмнө нэр нүүрээ олж болохоор болбол зальтай хамба лам намайг барьж өгөхгүй гэж чи Вальдемар бодож байх шив. Эндээс Гуль орох зам зуурт Роберт Эстотвиль, Эссекс гүн хоёр талынхаа хүмүүсийг дуудаж цуглуулаад хуарагнан байгааг де Браси чи янз нь мартсан бололтой. Миний үгэнд итэг, ганцхан Эстотвиль чамайг бүх чөлөөт багий чинь хамт Гомбрын усанд живүүлчихэж элбэг чадах олон цэрэг бий дээ гэж хэлэв.

Фицурс, де Браси хоёр бодолд автан өөд өөдөөсөө харлаа.

- Бидэнд ганцхан лам үлдэж байна гэж хаан хүү хэлээд царай нь харанхуй шөнө адил барайн,
- Бидний айж сүрдэж байгаа хүн ганцаар тэнүүчилж явна. Түүнийг нэг газар отох хэрэгтэй байна гэвэл де Браси яаран,

- Энэ хэргийг би л хийхгүй. Ричард намайг олзлон авсан боловч өршөөсөн. Би түүний дуулганы ганц өдийг боловч гэмтээхийг хүсэхгүй гэж хариулав.

- Хаан хүү Жон ёозгүйгээр тачигнатал инээж, - Үгүй хэн чамайг түүнд хор хүрэг гэж гуйж байгаа юм бэ? Чи аягүй бол түүнийг алуулахаар ятгаж байсан гэж ярьж мэднээ. Үгүй хамгийн дээр нь шорон. Хаана тэр гянданд сууна. Австрит юм уу Англид уу ялгаа юу байна?

Бидний уул хэргээ сэдэхэд байсан тэр байдалдаа л Ричард эргэж орно. Ричардыг Германд олзлогдоод байх болно гэж горилоод л бид энэ хэргийг өдүүлсэн шүү дээ. Манай төрлийн Роберт Кардифер цайзанд суусаар нас барсан шүү дээ гэв.

- Тийм ч тиймээ, гэхдээ танай өвөг Генрих хаан ширээнд, гэгээн дээдэс таны сууж чадахаас илүү баатар заларч байсан билээ. Иймд хамгийн сайн шоон бол түлхүүр нь хонхчинд байдаг гяндан шүү. Сүмийн доод зоорин дахь нууц өрөөнөөс илүү дээр юм хаана байх билээ? За өөр хэлэх үг надад үгүй гэвэл де Браси,

- Шорон ч бай, авч бай хамаагүй, би л оролцохгүй гэж хэллээ.

- Адгийн муу шаар! Бидний энэ зөвлөлгөөний тухай чи түүнд арай ховлохгүй юм байгаа биз дээ? гэж хаан хүү Жон асуувал,

- Би хэзээ ч хов хутгаж яваагүйн дээр намайг хүн адгийн шаарт минь хүрэхэд бас дасаагүй билээ гэж де Браси дээрэнгүйгээр өгүүлэв.

Вальдемар ярианд оролцон, - За больж үз эрхэм баатар, их эзэнтэн та зоригт де Брасийг уучил, би үүнийг ятгаж чадна гэж найдаж байна гэвэл,

- Уран цэцэн үгээн дэмий гарздах бий Фицурс гэж де Браси маргав.

- За больж үз эрхэм сайн Морис минь. Үргэсэн морь шиг хажуу тийшээ бүү огло үсэр. Танд айгаад байх юу байна? Тэр Ричард... үгүй, уржигдархан л та түүнтэй тулалдааны талбар дээр нүүрээрээ учирвал хамгаас илүү завшаан гэж баярлахаар байсан шүү дээ. Чиний тэр тухай мөрөөдөж байхыг би зуу дахин дуулсан юм байна гэж юмны аясыг сүрхий олдог овжин Фицурс өгүүлэхэд де Браси өөдөөс нь:

- Тиймээ ил тулалдаанд нүүр нүүрээрээ гэсэн шүү. Гүн ой дотор түүн рүү дайрах юмсан гэж би хэдийд ярьж байлаа? гэв.

- Чи үүнээс айж байгаа юм бол юун эр баатар байх билээ? Ланселот де Лак, Тристрам нар тулалдаанд тийнхүү их алдаршсан гэж санана уу? Тэд чинь аварга эрс, баатрууд руу уухайлан замгүй зэрлэг ойн гүнд дайрч байж алдаршсан юм гэж Фицурс хэллээ.

- Тиймээ, харин Тристрам, Ланселотын хэн нь ч гардан тулалдаанд Ричард Плантагенетийг дийлэхгүй гэдгийг батлая. Нэг хүний өөдөөс хочул явна гэдэг тэдний заншилд байгаагүй хэрэг гэж де Браси өгүүлэв.

Фицурс үүнд, - де Браси чи солиорсон байна шүү? Чи чинь хаан хүү Жонд хүчин зүтгэхээр мөнгөөр хөлслөгдсөн чөлөөт багийн хөлсний дарга шүү дээ. Чиний эзний хувь, заяа, нөхдийн чинь хувь тавилан, өөрийн чинь амь нас, бид бүгдийн нэр төр чухамхүү утсанд торж байгаа цагт дайсан чинь хаана байгааг мэдсээр байгаад чи тээнэгэлзэж байдаг юу гэсэн үг вэ гэвэл де Браси баргар царайлан,

- Тэр миний амь насыг өршөөсөн гэж би танд хэлж байна шүү. Тэр намайг нүднээсээ

зайлуулж, миний хүчин зүтгэлийг авахгүй гэсэн нь үнэн. Тэгэхлээр би түүнд захирагдах, шударга үнэнч байх алба үгүй. Гэхдээ би түүний эсрэг гар хөдөлж л чадахгүй гэлээ.

- Үгүй тэгэхийн шаардлага алга. Луй Винкельбрадыг шадруудаасаа хориод хүнтэй явуулчих гэхэд,

- Таны өөрийн чинь хог шаарууд бишгүй бий. Миний хүмүүсээс нэг нь ч энэ хэрэгт оролцохгүй гэж де Браси хэллээ. Хаан хүү Жон: - Үгүй, де Браси чи мөн зөрүүд хүн юм аа? Үнэн шударга зүтгэнэ гэж өчнөөн төчнөөн амласныхаа эцэст чи намайг үнэхээр орхиж байна гэж үү? гэвэл де Браси өөдөөс нь:

- Би таныг орхих дургүй байна. Эрүүл тулалдааны дайны талбарт бол танд эр баатар хүний ёсоор хүчин зүтгэхэд бэлэн байна. Харин энэ сэдэж байгаа дээрэмчин маягийн үйл миний өргөсөн андгайд харш юм даа гэв.

- Вальдемар наашаа ир гэж хаан хүү Жон хэлээд – Би ер ямар гээч золгүй хаан хүү вэ? Миний эцэг Генрих хаан үнэнч зарц нартай байжээ. Хуврагуудын дотроос нэг тэрслүү этгээд дургүйг нь хүргэх боллоо гэж хэлэхийн хамт л фом Бекетийн цус мөргөл уншиж байсан бурхны нь дэргэд асгарсан. Траси, Морвил, Брито нарын зоригт үнэнч зарц нар! Та бүхний нэр мартагдаад эрэлхэг үйлээр та нартай тэнцэх хүн үгүй болжээ. Реджинальд Фицурсийн хүү үлдсэн боловч тэр эцгийнхээ үнэнч зүтгэл, эр зоригийн алиныг ч уламжилж авсангүйдээ гэж хэллээ.

Вальдемар Фицурс үүнд, - Үгүй энэ хоёр чанарын алин нь ч надад дутагдсан юмгүй. Энэ аюултай хэргийг гүйцэтгэх өөр хүн үгүй бол би өөрөө дааж авлаа. Эцэг маань нэртэй үнэнч зүтгэгч гэж алдаршаад хүнд цээрлэл үзсэн боловч миний хийх ёстой болж байгаагаас илүү хөнгөн аргаар үнэнчээ нотолж үзүүлсэн билээ. Миний хувьд арслан зоригтын эсрэг жад өргөхөд орвол бүхэл бүтэн бүлэг этгээд рүү дайрах нь хялбар байхсан. Манай холбоотнуудын сэтгэл урмыг өөдрөг байлгахыг де Браси чамд даалгая. Хаан хүүгийн бие хамгаалагч байгтун! Би та нарт аятай мэдээ ирүүлж чадвал бидний өдөөсөн хэрэг лавтай бүтнэ. Алив хиа, манай гэр рүү гүйж очоод дагуулыг бүх юм бэлэн болгоод хүлээж бай гэж хэл. Стивен Ветроль, Дюжем, Торсон болон Спайнгуагийн ах дүү хоёр Спирсийг даруй над дээр ир гэж дууд. Бас тагнуулч Гуг Бардоныг бас дуудаг... Баяртай эзэнтэн, баяртай гээд өрөөнөөс гарч одов. Хаан хүү Жон, - Миний ахыг барьж олзлохоор одож байна, гэхдээ аль нэгэн саксон тайжийн эрх чөлөөг эвдэхээр одож байгаадаа сэтгэл зовохгүй байна шүү. Бодвол бидний зааврыг чанд биелүүлж манай эелдэг Ричардын биетэй зохих ёсоор хүндэтгэн харьцах бизээ гэж Морис де Брасид хэлэхэд, цаадах нь хариулахын оронд зөвхөн инээвхийлэв.

- Ариун дагинын нэр барьж андгайлахад, - бид түүнд нарийн заавар өгсөн. Бид цонхны тэрүүхэн гүнд зогсож байсан болохоор чи бидний яриаг харин сонсоогүй байж мэдэх юм. Ричардыг хайрлаарай гэж түүнд чандлан тушаасан миний зорилгоос давах юм болж гэм Вальдемарын хохь болж! гэвэл де Браси өөдөөс нь:

--Тэгвэл түүн дээр очиж гэгээн дээдэс таны зорилгыг давган хэлсэн нь дээр биш үү? Таны үгийг би дуулаагүй гэвэл Вальдемар мөн дуулаагүй байж болох юмаа? гэв.

Хаан хүү унтууцаж, - Үгүй, үгүй! Тэр дуулсан, миний үгэнд итгэ. Тэгээд ч надад чамтай бас ярих хэрэг байна, наашаа ир Морис, мөрийг чинь түшье гэлээ.

Ийнхүү нөхөрсөг янзаар бүхэл танхимийг тойрон алхах зуур хаан хүү доорхи дотно яриа дэлгэв.

- Де Браси хонгор минь чи энэ Вальдемар Фицурсийн тухай ер юу гэж боддог вэ? Миний дэргэд ерөнхий захирагч байх горьдлоготой юм. Ричардыг барьж авахыг маш дуртай зөвшөөрч байгаагаар үзвэл манай гэр бүлийг онц хүндэтгэж үздэггүй бололтой хүн, тийм чухал албан тушаал тохож өгөхөөсөө өмнө бид сайтар бодно. Чи харин энэ эзгүй даалгавраас зоримог татгалзсанаараа бидний сэтгэлд юм хийчихлээ гэж бодож байж болох юмаа, үгүй шүү. Морис, чиний шулаан шударга, бат сэтгэлийг үзээд би харин ч илүү ихээр хүндэтгэх боллоо. Бидэнд хүчин зүтгэхээс хүн татгалзаж, тэр үгнээс даврагчдыг бид илүү хүндэтгэх болдог удаа бас байна. Миний золгүй ахыг баривчлах гэдэг ерөнхий захирагчийн хэргэмээр шагнуулахаар их гавьяа биш гэж би бодож байна. Харин чи эр баатар хүний ёсоор татгалзсанаараа өрлөг жанжны очирьг барих гавьяатай боллоо. Энэ тухай де Браси чи бодож зохих үүргээ биелүүл гэж хэллээ.

Хаан хүү дээрээс гарахдаа де Браси, - Шарвагануур муу эзэрхий! Чамд итгэсэн хүн ч муугаа үзнэ дээ. Ерөнхий захирагч шүү! Үгүй ер өө! Чиний сэтгэлийг залах гэж оролдох хүнд хэцүүхэн үүрэг ачаа оногдох бий гэж аман дотроо үглэснээ, - Харин Английн өрлөг жанжин гэдэг чинь хөөцөлдөөд үзэж болох үнэхээр сайхан буюу гэж жанжны очирьг шүүрч авах гэсэн мэт гараа сарвайн ихэмсэг дүртэй болов.

Де Брасийг өрөөнөөс гарахын хамт хаан хүү Жон зарцаа дуудан,

- Манай ахлах тушаалт Гуг Бардоныг Вальдемар Фицурстэй ярилцсаныхаа дараа шуудхан наашаа ир гэж хэл гэв.

Хаан хүү хэсэг зуур сэтгэл түгшин өрөөн дотуур хурдан хурдан алхан холхиж байтал ахлах туршуул түүн дээр орж ирлээ.

- Бардон чамд Вальдемар юу гэж тушаав? гэж хаан хүү асуухад,

- Хойт зүгийн шигүү тайгыг сайн мэдэх, хүн морины мөр мөрдөж чадах хоёр зоригтой сайн хүн ирүүл гэсэн гэв.

- Тоодон гэлэн чи хар өглөөнөөс аваад амаа халааж орхижээ. Янз нь чи хэнийг ингэж чирээд ирснээ өгч үзээч гэж тэргүүлэгчийг хэлэхэд:

- Чи тийм хүмүүс олж чадах уу? гэвэл тагнуулуудын тэргүүн,

- Эзэнтэн та сэтгэл бүү зов. Нэг нь Гексамширийнх, тэр чинь тайндель, тевнотделийн хулгайч нарыг анч нохой шархадсан бугын мөрийг үнэртэхээс илүү чадмаг барьдаг хүн, нөгөөх нь Йоркширийнх, энэ насандаа Шервудийн ойд цөөнгүй ан намнасан, зөрөг бүрийг, гарам тус бүрийг, ойн цоорхой гуу жалга бүрийг бүр Ричмонд хүрэн хүртэл андахгүй хүн гэж

хариулав.

- За сайн гэж хаан хүү дуугараад, - Вальдемар өөрөө тэдэнтэй явах нь уу? гэвэл,

– Тэгэх гэж байна эзэнтэн гэж Бардон хэлэв.

- Өөр хэн хамт байна? гэж хаан хүү хайш хэрэг дуугаар асуухад,

– Түүнтэй цуг том чийрэг Торсби, харгис хэрцгийгээрээ ган зоригт Стивен гэж нэрлэгдсэн Ветроль , бас хуучин Ральф Миддльтоны багт байсан хойт нутгийн гурван хүн байна. Тэднийг Спайнгуагийн ах дүү нар гэдэг юм гэвэл,

- Сайн байна гэж хаан хүү дуугараад хэсэг зуур дуугүй байснаа, - Бардон чи Морис де Брасийн хойноос хатуу харгалзах хэрэгтэй, гэхдээ өөрт нь хар авахуулж болохгүй. Ямар шүү янзтай явж, хэнтэй юм ярьж, юу сэдэж байгааг нь үе үе бидэнп айлтгаж бай. Хариуцлага сүүлд өөрт чинь оногдох учраас аль болох нарийн мэдэхийг хичээгээрэй гэхэд Гуг Бардон мэхийн ёслоод гарч одов.

- Морис надаас урвах юм болж гэм энэ байр байдлыг нь үзэхэд ч магадгүй байгаа шигээ урван худалдах юм бол тэр үед Ричард өөрөө Йорк хотын хаалган дээр ирчихээд байлаа ч гэсэн би толгойг нь авна даа гэж хаан хүү Жон өгүүлэв.

ГУЧИН ТАВДУГААР БҮЛЭГ

Энгүй мухар сүсэг хэрцгийллийн

Дөлийг дэвэргэн хөгжөөж шатаасанд орвол,

Эзгүй хээр догшин барыг сэрээх,

Олон арслангийн олзыг амнаас нь булаах дээр

Үл мэдэх зохиолч

Йоркийн Исаакийг эргэж үзье. Дээрэмчний бэлэглэсэн луусыг унаж, хоёр Йомен дагуулан Темплстоу хийд рүү охиноо аврахыг оролдохоор одов. Нурсан Торкильстон цайзнаас уул хийд нэгэн өдрийн газар байх тул тэд гэгээтэй хүрэхийг горилжээ. Иймд ой шувтрахын хамт газарчаа мөнгөн зоосоор шагнан буцааж эцэж ядарсан, өчүүхэн чадлынхаа хирээр зүтгэж буй луусаа хурдлуулж гарав. Гэвч Темплстоуд дөрвөн мод ойртож ирээд бие нь муудаад, арахийн явж худалдааны жижиг сууринд хүрэв. Тэнд анагаах эрдмээрээ нэрд гарсан нэг еврей хувраг суудаг байжээ. Натен Бен-Израиль зовж яваа нөхрөө еврей нарын заншлын дагуу маш дотноор хүлээж авлаа. Даруй хэвтүүлж, айж хэлмэгдэн ядрах, зодуулж нүдүүлэхийн дээр зовж энэлсэндээ хөөрхий өвгөн халууран чичирч эхэлснийг нь дарах эм өгч уулгав.

Маргааш өглөө нь Исаак босож замдаа орохыг завдсан авч Натан үүнийг зөвхөн зочломтгой гэрийн эзний хувиар төдийгүй эмчийн хувьд тийнхүү болгомжгүй хөдөлбөл амь насаа алдаж мэднэ хэмээн хориглов. Амь наснаас илүү чухаг юм Темплстоуд орох явдлаас хамаарна гэж Исаакийг маргахад Натан ихэд гайхан:

- Темплстоу гэнээ? гэж дахин судсыг нь барьж үзээд, - халуурч байгаа юм үгүй шиг, гэхдээ дэмий ярьж, жаахан удаан солиорсон байх юм гэж үглэв.

Исаак цааш нь, - Би яагаад Темплстоу орж болдоггүй юм бэ? Тэр бол еврей нарыг үзэн яддаг хүмүүсийн орон байр гэдэг талаар Натан чамтай маргах зүйл алга. Гэхдээ худалдааны чухал ажлаар бид заримдаа буруу номтны цусанд дуртай дайчидтай харилцаж, хийдийн хороныхны сум болоод Ионнитийн баатруудын жанжны газарт очих хэрэг гардгийг чи мэднэ шүү дээ гэв.

- Мэднэ, мэднэ гэхдээ энэ хийдийн дарга буюу тэргүүн хамба Лук Бомануар одоо тэнд байгааг чи мэдэж байна уу? гэж Натан асуувал,

- Үүнийг би мэддэггүй шүү! гэж Исаак дуугараад, - Парист суудаг манай омгийнхноос сүүлчийн удаа дуулснаар бол Бомануар францын нийслэлд байгаа Саладин султан хааны эсрэг цэрэг мордуулахыг Филиппээс гуйж байна гэж дуулсан гэв.

- Түүнийхээ дараа өөрсдийнхнийхээ гэнэгүй байхад Англид мөрдөн мөшгөх, залхааж цээрлүүлэхээс гараа далайсаар хүрч ирсэн. Одоо хийдэд орохдоо өргөсөн андгайгаа зөрчсөн хүмүүсийн эсрэг уур хилэн нь бадран, чөтгөрийн хүүхдүүд түүний өмнө чичирж байна. Энэ хүний нэрийг чи лав урьд дуулаа биз? гэж Бен-Израиль өгүүллээ.

Исаак хариуд нь: - Тиймээ, энэ нэрийг би сайн мэднэ. Буруу шашны хуулийг зөрчсөн эндэгдэл бүрт алах ял оногдуулах дуртай гэж буруу номтон ярилцдаг. Миний овийнхон түүнийг сарацинуудыг, улайран хядагч, израилийн хүвгүүдийн эзэрхийлэн дарангуйлагч гэж нэрлдэг юм гэхэд Натан эмч,

- Сайн нэр өгч! Сүмийн хорооны бусад баатруудын алт мөнгө юм уу цэнгэл амлан зөөлрүүлж болдог, харин Бомануар огт тийм хүн биш. Янаг амрагийн явдлыг үзэн ядаж эд баялагийг үл тоомсорлон тэднийхний ярьдаг зовлон хатуужил эдлэхийг чин сэтгэлээсээ эрмэлздэг юм. Тэр хатуужил зовлонг түүнд болоод хань хамсаатнуудад нь Иаковын бурхан бушуухан буулгаж өгөх болтугай. Энэ бардам сэтгэлтэй хүн Иудейн хөвгүүдийг эсрэг төмөр гараа сунгаж, еврей хүнийг алах сарациныг алахтай адио бурханд таалалтай хэрэг гэж үзнэ. Миний анагаах сайн аргыг хүртэл шулмын гаралтай гэж гүтгэн муучилдаг. Үүнийг нь бурхан залхаан цээрлүүлэх болтугай! гэв.

Ямар ч гэсэн, Бомануарын царай хөөрөгний цог шиг уулзаж долоо дахин илүү улайдсан байлаа ч гэсэн Темплстоу орох хэрэгтэй гэж Исаак хэлээд юунд тийнхүү яарч байгаа учраа Натанд ярьж өглөө. Эмч Исаакийн үгийг анхааран чагнаад өрөвдөж байгаагаа илэрхийлэв.

Исаак, - Миний саатаж болохгүй учрыг чи үзэж байгаа биз? Эдний дээд дарга тэр Лук Бомануарын энд байгаа явдал Бриан де Буагильберийн хорон санаагаа гүйцэтгэхэд саад болж мэднэ. Миний хайрт охин Ревеккаг тэр надад өгч мэдэх юм шүү гэхэд Натан бен Израиль:

- Тэгвэл яв л даа. Хянуур байж үзээрэй дээ. Гэхдээ болж өгвөл тэргүүн хамбын нүдэнд өртөхгүй байхыг хичээ, юу гэвэл түүний өглөө оройн дуртай зугаа нь манайхныг бузраар шившиглэн дарлах явдал мөн. Буагильбертэй нүүр нүүрээрээ учраа ололцсон нь чамд дээр байж мэднэ. Учир нь энэ хараалт буруу номтнууд дотроо нэгэн санаатай бус гэдэг, цуу явдаг юм... За найз минь, манайхыг төрсөн эцгийнхээ гэр шиг бодож эргэж ирээд ажил төрлийнхөө тухай дуулгаарай. Мэргэн Мириамын шавь, буруу номтнууд анагаах эрдэм чадлыг нь чөтгөр шулмын хүчин гэж гүтгэн муучилсан Ревеккаг авч ирнэ гэж би бат найдаж байна гэв.

Исаак нөхрөөсөө цаг хир яван Темплстоу дахь хийдэд хүрч ирлээ.

Сүмийн хорооны баатруудын хийд түрүүчийн даамлын хүчин зүтгэл гаргасны ачаар энэ хийдэд бэлэглэсэн шимт нуга, билчээрийн дунд байх ажээ. Барилга нь бат бэх. Хийдийг сайтар батлан бэхэлжээ. Хар хувцастай мөрөн дээрээ алман сүх тавьсан манаач дүүжин гүүрний дэргэд зогсоно. Мөн иймэрхүү ёозгүй бараатай хүмүүс хэрэмний дагуу хойш урагш алхах нь амьд эр цэргийн улс гэгээнээсээ илүү хий юмс шиг санагдана. Энэ хийдийн бүх дорд мяндагтан хар өнгийн хувцас өмсөх бүлгээ. Урт цагаан нөмрөгтэй, толгойгоо бөхийлгөн элгэндээ гараа зөрүүлсэн баатрууд үе үе хашаан дотуур өнгөрнө. Нэг нэгэнтэйгээ учирвал дуугүй, алгуур ёсорхуу мэхийнэ. Дуугүй байх гэдэг бибиаль судрын заалтан дээр үндэслэсэн эдний гуримнуудын нэг ажээ.

Бомануарын нөлөөгөөр аль эртний зугаатай задгай амьдрал болж хувирсан хэрцгий ширүүн гурим дахин баримтлагдах болжээ.

Исаак хийд дотор хэрхэн нэвтэрвэл дэр вэ гэж эрэгцүүлэн хаалганы дэргэд зогсов. Сүмийн хорооны баатруудын дахин сэргэсэн мухар сүсэгт гурим өөрийн нь золгүй овгийнхонд хуучин задгай зайдан байдлаас нь илүү аюултайг Исаак сайн ойлгож байлаа. Ялгаа гэвэл урьд зөвхөн эд баялгаасаа болон доромжлол, өргөц барьц өгөх хяхалт үзэж болох байсан бол одоо хийдийхнийг мухар харгис сүсэглэлийн үзэн ядалт, мөрдөлтөнд өртөж болох байв.

Энэ үеэр Лук Бомануар хүрээний цэцэрлэг дотор зугаалан Палестинаас хамт ирсэн хийдийнхний нэгэн гишүүнтэй сэтгэлийн гунигт зүйл хөөрч байв.

Тэргүүн хамба нас ахимаг. Урт сахалт шөрөвгөр өтгөн хөмсөг нь эрт буурал оржээ. Гэвч нүдэнд нь насанд үл дарагдан буурах гал цог гялалзана. Урьд аймшигт дайчин эр явсан бөгөөд эцэнхий нүүрний нь ширүүн дүрэнд дайчин догшин шинж үлджээ. Үүний хамт энэхүү хэрцгий санваартны царайнд хатуужин туйлдсан ариун явдалдаа эрсдсэн байдал хослон тогтжээ. Гэхдээ л бие байдал, нүүр царай нь цаанаа л ихэмсэг сүртэй. Олон орны хаадын ордонд чухаг суурь эзэлж, хийдийн нь тугийн дор хуаран ирдэг язгууртан баатруудыг захирч сурсан байр харгал илэрхий. Нуруу өндөр гоолиг нас ахисан гэлтгүй цэ ажээ. Бүдүүн цагаан цэмбээр хийсэн нөмрөгний зүүн мөрөн дээр найман үзүүртэй улаан загалмайг бернардан хийдийн бүх гуримыг баримтлан оёжээ. Элдэв үнэт үсээр эмжиж чимсэн зүйл ер үгүй. Тэргүүн хамбын өндөр насыг хүндэтгэн хүрмийг нь маш нарийн үзүүрсгээр доторлосон нь хийдийн гуримаар зөвшөөрөгдсөн зүйл ажээ. Үүнээс цааш хээнцэрлэж таарахгүй байжээ. Гартаа сүмийн хорооны баатруудыг зурхад голдуу гаргадаг өвөрмөц маягийн таяг тулсан байв. Булцууны нь оронд гөлгөр цагираг түүн дээр дундаа найман үзүүр бүхий хийдийн тэмдэг болох загалмайтай бөгж сийлжээ. Өндөр мяндагтны юм ярилцаж байгаа хүн мөн ижил хувцастай. Гэхдээ даргатайгаа онц зулгайдан харилцах нь тэдний хооронд хувцаснаас цааш тэнцүү юм үгүйг гэрчилнэ. Хүрээний даамал (энэ хүний мяндаг тийм бүлгээ) тэргүүн хамбатай зэрэгцэж ч явахгүй, хамбыг юм ярихдаа эргэж харахад хүрхээргүйгээр хоцросхийж явна.

- Миний аян дайны болоод ажил үйлийн амжилтанд оролцсон анд нөхөр ганц Конрад чамд л би сэтгэлийнхээ зовлонг илтгэн хэлж болно. Энэ орны нутагт хөл тавьсан цагаасаа хойш би үхэж, ариун явдалтны ёсоор талийж амрахыг хир их мөрөөдөх болсноо ганц чамд ч хэлж болно. Англи оронг хараад сэтгэл дүүрэн байх ганц ч юм олж үзсэнгүй. Эндхийн бардам нийслэл дахь манай гол дуганын хүнд бат дээвэо дорхи манай нэгэн санваартнудын шарилаас бусад нь л тийм байх шүү. Загалмайн аян дайны тэр эрэлхэг дайчдын хөргийг харан би дотроо: "Зоригт сайн Роберт де Рос! Хүндэт Уильям де Маршал! Гантиг тасалгаага нээж, өөрийн ариун хийдийн уналтыг үзсэнд орохноо зуун мянган буруу номтонтой тулалдахад ядарсан нөхрөө мөнх амруулахаар хүлээн авна уу?" гэж дуу алдсан гэв.

Конрад Монфитчет үүнд, - Яриагүй зөв, эд бүгд цөм ариун үнэн бүлгээ. Манай английн нэгэн санваартангууд францынхаас илүү их нүгэл үйлддэг юм гэвэл тэргүүн хамба хариуд нь:

- Яагаад гэвэл эндхийнхэн арай баян юм. Хэрэв би чамд жаахан сайрхаж орхивол миний анд нөхөр уучлаарай. Миний яаж амьдарч, манай хийдийн гурим бүрийг чанд даган, чөтгөр шуламтай тэмцэж, залгиж орхимоор хүн эрэлхийлэн биднийг тойрч архирагч арслан мэт муу шуналыг хэрхэн дарж байсныг чи мэднэ. Надад тулгарч ирсэн тухай бүрийд шунал

хорхойслыг нь би аиун дурсгалт Бернад гэгээний сургасан тэр ёсоор дарж байсан. Тэгээд ариун дуганыг барьж андгайлахад миний хичээл зүтгэл миний амьдрал, бас махбод тэр ч байтугай булчин шөрмөс ясан дахь тархи, өмгийг хүртэл барьж гүйцлээ. Чи болоод манай хийдийн чанд сахилгыг сахигч хэдхэн хүнээс гадна сэтгэлийнхээ гүнд нэгэн санваартан гэдэг ариун нэрийг өгч болохоор хүн, ариун сүмийн нэр барьж андгайлахад надад харагдахгүй байна. Манай дүрмэнд юу гэж хэллээ, э тэд түүнийг яаж биелүүлж байна? Дүрмэнд заахдаа хоосон гоёл бүү зүү, малгайдаа өдгүй бай, алтан давируул, шармал хазаар сэлт бү хэргэл гэсэн. Тэгэхэд манай хийдийн дайчдаас өөр хэн хмгийн их хээнцэрчүүл болоод байна? Дүрэм тэднийг нэгэн шувууг барихад нөгөө шувууг хэрэглэх анг нум сум буюу алман сүхээр намнахыг хориглож анчин эвэр бүрээ үлээх, тэр ч байтугай ан хөөхдөө морио давирахыг буруушаадаг билээ. Тэгээд яаж байна? Сүмийн хорооны баатруудаас өөр хэн шонхортой анд гарч, харваж, ойоор ан авлан бусад хоосон цэнгэл хөөцөлдөж байна? Тэднийг даамлын тусгай зөвшөөрөлгүгээр ямар нэг юм унших, ийтийн зоогны цагт унших судраас бусад алив нэгэн ном уншихыг хориглодог. Гэтэл тэд үлгэрчдийн шалиг дууг чих тавин шохоорхож, хоосон өгүүллэгүүд амтархан уншиж байна. Муу зүгийн шид, буруу номыг үндсээр нь үгүй хийхийг тэдэнд заасан байхад Еврей нарын хорт буруу ном, буруу номтон сарацинуудын эрэг төлөг сурч байдаг сураг байна. Дүрэм тэднийг хоол ундаа татаж, үндэс будаа тэргүүтнээр голлан махыг долоо хоногт гурван удаагаас дээш бүү ид гэсэн байхад ширээ даахааргүй тансаг амттан өрөөстэй харагдах юм. Тэд ганцхан ус л уух учиртай, гэтэл наргианч архичингуудын дунд сүмийн хорооны баатар шиг уух гэдэг үг дэлгэрчихсэн байх юм. Алс дорнодын орны гайхалтай цэцгүүдээр дүүрсэн энэ цэцэрлэгийг аваад үзсэн ч тэр дээ. Энэ чинь христос шашны гэлэн хүн хэрэгцээт ногоогоо тарьдаг даруухан талбайгаас илүү мусульманы аль нэгэн захирагчийн эмсийн хүрээлэнг тойрсон цэцэрлэгтэй адил юм. Манай дүрмийг зөрчих явдал үүгээр хязгаарлагддаг бол бас ямай, Конрад минь! Эхлээд манай хийхэд эгч дүүсийн ёсоор хамаарагдаж байсан буянт бүсгүйчүүлтэй бидний харилцахыг хориглодгийг чи мэднэ. Дүрмийн дөчин зургадугаар зүйлд хүн төрөлхтний язгуурын өшт дайсан диваажин орох замаас олон хүнийг бүсгүйчүүлийн тусламжтайгаар хазайлгсан гэж заасны үндсэн дээр хориглодог бүлгээ. Манай хийдийг үндэслэгчид буянтан хайрласан ариун нандин сургаалын нэгэн ёсны ноён нуруу болох сүүлчийн бүлэгт төрсөн эгч дүү, эхтэйгээ энхрийлэлцэхийг буруушаадаг. Одоо манай хийдийнхэнд ямар муухай хар нүгэл шүгэлж байгааг ярихаас, тэр ч байтугай бодохоос ичгэвтэр байна! Тус хийдийг үндэслэн байгуулагч буянтан Гуго де Пайен, Готфрид де Сент Омер болон бусдаас түрүүлж сэтгэл барилдан хийдэд зүтгэхэд биеэ зориулахаар шийдсэн долоогийн сүнс диваажинд хүртэл амр заяа үзэхгүй байгаа. Конрад, тэр нар миний шөнийн зүүдэнд тольдогдож байдаг. Тэдгээрийн хувилгаан мэлмий нэгэн санваартан ах дүүсийнхээ хилэнц төөрөгдөл болод шунал тачъяалын ичгүүрт булайд зууралдан автсаны төлөө нулимсаар хайлж байна. "Боменуар чи унтаж байна! Сэр! Дуганы хананд өмхий хөгц суужээ. Бүсгүй хүний харцыг могойн хэл лугаа адилд үзэн зайлсхийх учиртай хийдийн хорооны дайчид өөрийн омгийн төдийгүй хараал хүрсэн буруу номтон, хэт хараалт еврей нарын охидтой илтэд нүглээр нөхцөх авай Бомандар чи унтаж байна! Бос үнэн хэргийн төлөө өшөө ав! Эрэгтэй эмэгтэй нүгэлтнийг үгүй хий! Финиасын илдээр зэвсэглэ!" гэж тэд айлдаж байна. Тэр үзэгдэл сарниж би сэрснийхээ дараа хуяг дуулга хангинах, тэдний цаасан цагаан хэвнэгийн хормой намиран байхыг би харсан билээ. Конрад, би тэгээд тэдний айлдсан ёсоор дуганын ханыг хөгцнөөс цэвэрлэж хорт өвчин халдсан чулууг нь гаргаж хаях болно гэлээ.

Мон Фитчет үүнд, - Эрхэм багштан та болгоож хайрла, хэвшил болоод цагийн удаанд энэ хөгц гүнзгий шингэжээ. Чиний шинэчлэлт мэргэн зөв боловч алгуур хянуураар хийвэл дээр бус болов уу? гэхэд хэрцгий өвгөн хариуд нь,

- Үгүй Мон Фитчет, үүнийг би гэнэт явуулна. Манай хийд хүнд байдалд орж, түүний хамаг ирээдүй өнөөгийн үеэс хамаарах болоод байна. Манай дээдсийн саруул ухаан, амь биеийг орхин буянт үйлд шамдаж байсан нь газар сайгүй бидэнд хүчирэг шавь нар бий болгожээ. Манай дээрэнгүй авир, манай эд баялаг, хээнцэр амьдрал, хүчирхэг дайснуудыг бидний эсрэг босгож байна. Бид хурааж хуримтлуулсан их эд баялгаа гаргаж хаях хэрэгтэй юу гэвэл эд баялаг энэхүү хорвоогийн хүчтнүүдийн шунал дурыг татахаас цаашгүй. Бид алиа бардам дээрэнгүй аалийг орхих ёстой. Юу гэвэл энэ бусдыг гомдоодог зүйл. Бидний нэрийг хорвоод бузарлаж байгаа завхай зайданг бид үндсээр нь тас цохих учиртай. Тэгэхгүй бол миний үгийг санаарай. Сүмийн хорооны баатруудын хийд газрын хөрснөөс арчигдаж манай хойч үе түүний ул мөрийг ч олохгүй болно гэв.

- Тийм гай зовлонгоос бурхан өршөөж хэлтрүүлтүгэй! гэж хүрээ даамал залбирлаа.

- Болтугай! гэж тэргүүн хамба ёсорхуу айлдаад,

- Гэхдээ бид бурхны ивээлийг хүртэж чадах юм үйлдэх учиртай. Одоо үеийнхний нүглийг тэнгэрийн хүчин, хорвоогийн эзэд хаадын алин нь тэсвэрлэж чадахгүй гэж Конрад чамд би хэлж байна шүү. Бидний орд харш барьж байгаа хөрс бамбалзаж байна. Хэдий их дээш өргөмжлөгдөх гэж тэмүүлэх тусмаа ёроолгүй их гүн рүү бид төдий амархан нурж унана. Хуучин байдалдаа эргэн орон, загалмайн үнэнч хамгаалагчид зорьсон үйлийнхээ төлөө зөвхөн муу шуналаа тэвчээд зогсдоггүй, амьдралын бүх төв уух, баяр цэнгэл тэр ч байтугай гэр бүлийн барилдааг хүртэл золиосонд гаргадаг болохыг үзүүлж өгөх хэрэгтэй байна. Бусад хүмүүст аргагүй зүй ёсны болох олон баяр баясгалан ариун дуганыг хамгаалахад биеэ зориулсан дайчдад харж хэлтүүлшгүй нүгэлт зүйл болохыг хатуу санах хэрэгтэй гэж хэллээ.

Энэ үед цэцэрлэгийн зөргөөр элэгдсэн хувцастай дагуул гарч ирав. Энэ хийдэд шинээр орж туршилтанд байгаа хүмүүс ахмад баатруудын хуучин хувцсыг өмсөх учиртай ажээ. Дагуул тэргүүн хамбад хичээнгүйлэн мэхийж ёслоод үг дуугарах зөвшөөрөл хайрлахыг хүлээн дуугүй зогсов.

- За тэр шүү, христос ёслолд хүлцэнгүй хувцас өмсөж, дээд багшийнхаа өмнө хичээнгүйлэн дуугүй зогсох нь хоёр өдрийн өмнө миний дайралдахад тоть шиг эрээн гоёл өмсөөд харайж явснаасаа илүү аятайхан харагдаж байгаа биз дээ! Юу гэж ирээв хэл? гэж тэргүүн хамба айлдлаа.

- Сайн төрөлт багш ламтан, үүдэн дээр еврей хүн ирээд санваартан Бриан де Буагильбертэй юм ярих зөвшөөрөл гуйж байна гэж дагуул өчив.

- Надад энэ тухай илтгэх гэж ирдэг чинь зөв байна гэж тэргүүн хамба хэлээд, - Бидний байх үед хүрээ даамал бүр бусад санваартны адил хийдийн жирийн гишүүд бөгөөд өөрсдийн дур зориг гэж үгүй багшийнхаа хүслийг дагаж байх учиртай. Тэр Буагильберийн тухайд гэвэл түүний ажил төрлийг мэдэж байх явдал бидэнд онц чухал байгаа юм гэж цуг яваа хүндээ

хандаж өгүүлэв.

- Эр зоригтой сайн баатар гэж улс ярилцах юм билээ гэж Конрадыг хэлэхэд,

--Тэр цуу үнэн. Бид загалмайн баатар дээдсээсээ эр зоригийн хувьд дутахгүй байна. Гэхдээ тэр санваартан Бриан манай хийдэд орохдоо бараг урам нь хугарсан хүн шиг надад санагдсан. Хорвоог умартаж, сахил хүртэхдээ үнэнхүү сэтгэлийн дагуу бус гэмээ наминчлан сэтгэлээ тайтгаруулахыг эрэлхийлэхэд хүргэсэн ямар нэгэн бүтэлгүйтлээс болсон юм шиг байсан. Тэр цагаас хойш сүрхий идэвхтэй зоримог дэслэгч болж хувирсан. Тэр дургүйцэж, явууллага хийж, бидний эрх мэдлийг булаалдагчдын тэргүүлэгч болсон. Бидний эрх мэдлийн тэмдэг хуулийн загалмай хэвээр бөгөөд зөрсөн хоёр очирын нэг нь дорой буурайд тулгуур түшиг болох, нөгөө нь гэмтнийг гэсгээхэд тзориулан бидэнд заяасныг тэр мартсан билээ гээд дагуул руу эргэн, - Дамиан, еврейг нааш нь авчир гэлээ. Дагуул дор мэхийгээд эргэж одон хэдхэн хувийн дараа Йоркийн Исаакийг дагуулан хүрч ирэв.

Хүчирхэг эзний дуудлагаар ирсэн зэрлэг боолчуудын хэн нь ч гэсэн Исаакийн, тэргүүн хамба руу дөхөж очсон шиг төдий их бишрэн хэлмэгдсээр хаан ширээ рүү ойртохгүй билээ. Гурван алхмын газар хүрмэгц Бомануар таягаараа дохин бүү ойрт гэж тушаав. Еврей сөхөрч газар үнсээд босож гараа элгэндээ зөрүүлэн толгойгоо унжуулан дорно дахины боолчуудын дээрээ зогсов.

- Дамиан, манаачийг биднийг дуудмагц ирэхэд бэлэн бай гэж хэл. Биднийг эндээс гартал нааш нь хүн бүү оруул гэж тэргүүн хамба тушаалаа.

Дагуул доор мэхийгээд холдов.

Дээрэнгүй зант өвгөн, - Еврей чи хичээнгүйлэн сонс. Бидний сахил, мяндаг чамтай удаан ярилцахад зохисгүйн дээр бид хэнтэй ч тэр үг, цагийг дэмий үрэх дургүй билээ. Миний тавих асуултанд аль болох товч хариул. Харин чи үнэн зөв яриарай, миний өмнө ов заль зохиохыг оролдвол хэлийг чинь бузар амнаас чинь суга тат гэж тушаана шүү би гэхэд Исаак нэг юм хариулахаар завдсан авч тэргүүн хамба цааш нь:

--Чамаас юм асуугаагүй байхад амаа тат бузар новш! Манай нэгэн санваартан Бриан де Буагильбертэй уулзах ямар хэрэг чамд байгаа юм бэ? гэлээ.

Исаак хэлмэгдэж, зовсондоо учраа олохгүй юу хийвэл зохихоо мэдэхгүй болов. Болсон бүх явдлыг үнэнээр нь хэлбэл хийдийг гүтэгсэнд тооцож мэднэ. Ярихүй болж гэм Ревеккаг хэрхэн аварч гаргах билээ? Исаакийн үхтэл сүрдсэнийг Бомануар мэдээд өршөөн, жаахан зориг оруулав.

- Золгүй еврей чи өөрийнхөө тухай бүү ай, шулуун үнэнээр ярь. Дахин асууя, Бриан де Буагильбертэй чи юун хэрэгтэй яваа юм бэ? гэхэд,

- Би түүнд захидал өгөх гэсэн юм. Эрэлхэг баатар багш ламтан танд зүрхлэж айлтахад, сайн төрөлт баатарт уул захидлыг Жорво хийдийн ширээт Эймер гуай, өгүүлсэн билээ гэж еврей дорой дуугаар хэлэв.

- Ийм л цагт чи бид хоёр амьдарч байна шүү дээ. Конрад минь! гэж тэргүүн хамба хэлээд цистерцианы хувраг хүн ариун хийдин дайчинд захиа илгээхдээ бурхан шашингүй еврейгээс дээр илч олддоггүй байна. Алив захидлыг нааш нь аль! гэв.

Еврей захидлыг багтай хадгалахаар хийсэн цалам малгайныхаа хуниасыг чичирхийлсэн гараар тайлан өөрөө хамбад гардуулах санаатай ойртохыг завдлаа. Гэтэл Бомануар ширүүнээр,

- Гэдэргээ, муу нохой! гэж зандраад, - Буруу номтонд би илднээс өөр юмаар хүрдэггүй. Конрад чи түүнээс захидлыг аваад өг гэв.

Ширээтийн ийм аргаар Бомануар гартаа аваад бүх талаас нь нарийвчлан үзсэнээ ороосон утсыг нь задлаж эхлэв. Конрад машид хүндэтгэнгүй боловч эмээсэн байртайгаар,

- Багш ламтан та тэгээд лацыг нь эвдэх юм уу? гэж дуугарахад, Бомануар хөмсөг зангидан,

- Юунд эвдлэхгүй байх билээ? Манай дүрмийн дөчин хоёрдугаар бүлэгт сүмийн хорооны баатар төрсөн эцгээсээ ч билээ тэргүүн хамбад мэдэгдэлгүйгээр захидал авах ёсгүй бөгөөд авсан захидлыг заавал түүний дэргд уншина гэж заасан байдаггүй гэж үү? гэв.

Захидлыг эхлээд өөрөө гүйлгэн уншсанаа царай нь гайхаж хилмэгдсэн дүртэй болон хувирч дахин уншсаны эцэст Конрад руу сарвайн бичигтэй самбарыг алгадаж дуу алдан,

- Христос шашны нэгэн хуврагаас нөгөө захидал бичих мөн сайхан сэдэв байна, юу гэж хэлэх вэ? Ялангуяа нилээн дээгүүр мяндагтан хүмүүст гээд гараа тэнгэр өөд ихэмсгээр өргөн – Бурхан багш та хийдэд хорвоо дэр залран ирж сайн үрийг хэвэгнээс ялгаж хайрлахсан бол? гэв.

Мон – Фитчет багшийнхаа гараас захидлыг авч уншив.

- Конрад чи чанга унш гээд Исаак руу эргэж чи сайн чагна, юу гэвэл бид чамайг байцаах болно гэж тэргүүн хамба өгүүлэв. Конрад тэгээд доорхи зүйлийг дуудав. " Жорво дахь гэгээн марийн цистерциан хийдийн даамал Эймерээс ариун сүмийн хорооны эрхэм баатар Бриан де Буагильберт эрүүл энх болоод янаг амрагийн явдалд өлзий хийморьтой ботугай гэж ерөөн бичив. Миний хувьд гэвэл, анд минь, энэ үед ямар нэгэн хууль ёс бурхан шүтээнийг огоорсон бидний биеийг баривчлан золиос мөнгө тогтоохоор үл эмээх хүмүүсийн гарт олзлогдсон байна. Үүний ялдалд бид Фрон де Беф бээлд учирсан гай болоод чамайг хар нүдээрээ илбэдсэн гоо сайхан шидэт еврей бүсгүйтэй зугтаасныг чинь дууллаа. Чиний олзлогдохоос аврагдан гарсанд бид чин сэтгэлээсээ баярлав. Гэхдээ тэр Эндорийн шинэ шидтэн бүсгүйтэй аль болох хянаар байхыг чамаас гуйя. Юу гэвэл хар нүд, улаан уруулын тухай юу ч тухайлах танай тэргүүн хамба та нарын наргианч цэгэлийг зогсоож, нүгэл хилэнцийг таслахаар норманаас танай руу ирж яваа гэдгийг бид хувийн замаар мэдэж чадсан билээ. Иймд хянуур байхыг хичээнгүйлэн зөвлөө. Ревеккагийн эцэг Йоркийн баян еврей Исаак чамд үг хэлж өгөөч гэж намайг гуйж байна, тэгээд энэ захидлыг түүнд гардуулан тэр бүсгүйн төлөө золиос ав гэж чамд зөвлөж, тэр ч байтугай гуйж байна. Юу гэвэл энэ еврей хүүхний төлөө зуугийн тал хүрэх бүсгүйчүүдийг ч арай аюул багатай нөхцөлөөр худалдан авч хүрэхүйц их мөнгө

төлөх юм. Дахиад учрахыг хүртэл хүлээж байж үз. Тэгээд бид жинхэнэ анд нөхрийн ёсоор наргина. Тэгэхдээ хундага дарсыг бас мартаггүй. Юу гэвэл "Дарс хүний сэтгэлийг баясгадаг" мөн "чиний гоо сайханд эзэн хаан тайтгарна" гэж сударт бичсэн байдаг бүлгээ.

Ийнхүү сайхан учрахыг билэгдэн чамд эрүүл энхийг ерөөе. Өглөөний мөргөлийн цагаар дээрэмчдийн үүрэнд бичив.

Жорво дахь гэгээн марийн хийдийн ширээт Эймер.

Жич: "Чиний алтан гинж надад чимэг болсонгүй. Хулгайч нарын гарт орсон, одоогоос аван дээрэмчдийн нэгний хүзүүнд гялалзах болно. Тэрээр нохойгоо дууддаг шүглээ түүнээс дүүжлэн зүүх байх" гэжээ.

- Конрад чи үүнд юу гэмээр байна? Дээрэмчдийн үүрэнд шүү! Тиймэрхүү ширээтэд хамгийн тохирсон байр байна. Бидний дотор Эймер шиг хуврагууд бий болсон хойно ариун газарт бидэнд бурхны цээрлэл бууж, бид хотуудыг дараа дараагаар нь алдан, буруу номтон газар нутгийг алхам алхмаар булаан авч байгаад гайхах юм алга. Ганцхан л тэр "Эндорийн шинэ шидтэй бүсгүй" гэж юу хэлж байгааг нь би мэдмээр байна гэж нөхрөөсөө шивэгнэн асуулаа.

Тэр цаг шалиг харчуулын далд утгатай үгсийг Конрад хамбаас илүү сайн мэдэх, өөрөө ч нэгэн цагт хэрэглэж явсан байж болох учир, тэргүүн хамбыг ийнхүү мухардуулсан үгийн утгыг, олонхи хар хүн нөхцсөн бүсгүйнхээ тухай ярихдаа энэ үгийг хэрэглэдэг гэж тайлбарлав. Зөрүүд мухар сүсэгтэн энэ тайлбарт сэтгэл ханасангүй.

- Үгүй Конрад үүнд илүү чухаг нууц байна. Энэ чинь хууль ёсон зөрчсөн бөөн явдал байж болохыг чи угийн цагаан цайлганы улмаас тухайлах ч үгүй байна. Йоркийн Ревекка гэдэг чиний лав дулсан байж таарах нөгөө Мириамын шавь байх учиртай. Харж бай, еврей өөрөө үүнийг хүлээж бай гээд Исаак руу хандан чангаар,

- Ингэхлээр чиний охин Бриан де Буагильберт олзлогдоод байгаа юм шив? гэхэд дагжин буй Исаак хариуд нь:

- Тийм эрхэм баатар, хүндэт багш ламтан ядуу хүнээс хир хэмжээний золиос шаардагддаг юм бол, би... юу бэлэн... гэж дуугарвал тэргүүн хамба:

- Дуугүй бай! Чиний охин хүн анагаадаг байсан уу, үгүй юу? гэвэл Исаак нилээн зоримгоор:

- Тэгэлгүй яах вэ, өршөөлт эрхэм ээ. Бурхнаас түүнд хайрласан сайхан билэг авьяасыг баатар Йомен дагуул, харц ардууд сайшаан залбирдаг билээ. өөр бусад алив арга тус болохгүй байсан хүмүүсийг эрдмээрээ анагааж өгч байсныг олон хүн гэрчлэнэ. Израилийн бурхан түүний зүтгэлийг ивээж байдаг юм гэж хариуллаа.

Бомануар гащуунаар инээвхийлэн Конрад руу харж,

- Харж байгаа биз, анд минь. Хүн төрөлхтий дайсны арга өв ямар шүү байна дээ? Хойт насанд мөнх жаргал эдлэхийн оронд, хорвоогийн амьдралыг өчүхэн удаашруулах төдийгөөр

сүнсгийг нь хөнөөх урхи тавьдаг байна шүү. Манай ариун дүрмэнд: "архирагч арсланг цөхрөлтгүй дарж бай" гэдэг учир энэ. Арслан руу дайръя, хөнөөгчийн эсрэг хөдөлье! гэж дуу алдан ариун бус хүчнийг заналхийлэх мэт таягаар өргөн сэгсрэв. Тэгээд еврей рүү эргэн, - Чиний охин тарнидах, ном унших, сахиус зүүлгэх зэрэг домын аргар эмнэдэг биз? гэхэд,

- Огт үгүй шүү. Зоригт баатар, багштан минь, нандин чадал бүхий эмээр эмчилдэг юм гэж Исаак хариулав.

- Тэр эмийн жорыг танай охин хаанаас олж авсан юм бэ? гэж Бомануар асуухад,

- Мэргэн Мириам зааж сургасан билээ гэж Исаак түгдэрсхийн хариулав.

- Аа муу зальхай еврей! гэж тэргүүн хам дуу алдаж загалмайлан залбираад, - Тэр чинь бүх христос шашинтан хар муу увьдсыг нь сайн мэдэх нөгөө Мириам байж таарна. Түүний биеийг шившгийн баганын дэргэд шатааж чандрууг дөрвөн зүг цацсан билээ. Тэр шулмын шавийг би бас тэр ёсоор болгохгүй аваас намайг болоод миний хийдийг мөн тэгэх болтугай. Муу увьдсыг гаргаж, өнгө үзэмжээрээ гэгээн сүмийн баатруудын сэтгэлийг татдагийг нь болиулж өгнө дөө, би! Дамиан, энэ еврейг хаалганаас гадагш гаргаж хөө! Энэ хэрэв цааргалах юм уу эргэж ирэх гэвэл дор нь алаарай. Үүний охиныг христос шашны гуримын дагуу өөрсдийн өндөр мяндагт зохицох хирээр цээрлүүлнэ гэв.

Хөөрхий Исаак гуйж царайлах, өгөөмөр шан өгөхөөр амлахыг нь хайхралгүй шилэн дээрээс нь шүүрч аваад чирсээр гаргаж хаяв. Анд эмчийнхээ гэрт буцаж очоод түүгээр дамжуулан охиныхоо хувь заяаны тухай ямар нэгэн сураг дуулахыг хичээхээс өөр зам түүнд үлдсэнгүй. Өнөө хүртэл охиныхоо нэр төрийн төлөө айж байсан бол одоо амьд насны нь төлөө зовох болов.

Энэ зуур тэргүүн хамба Темплстоу хүрээний даамлыг өөр дээрээ дуудаж ирүүлэхийг тушаав.

ГУЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Би махчин биш, Цөм хуурмаг аашаар амьдардаг

Хуурмаг зангийн ачаар гуйлгачин амьд явдаг.

Ордны бараа бологч харин хэргэмтэй ч газартай ч

Эр цэргийнхэн, хувраг санваартны

Аль алин нь хуурмаг ааший нь сайн мэднэ

Хуурмаг зангаас хэн ч салахгүй

Сүм хуаран, төрд шударга үнэнээр

Юунд ч хүрэхгүй юм чинь

Хорвоо үүн дээр тогтоож байдаг бүлгээ.

Эртний жүжиг

Темплстоу хүрээний их лам буюу даамал Альберт Мальвуазен нь бидний мэдэх Филипп Мультвуазены төрсөн дүү юм. Ахтайгаа адил Бриан де Буагильбертэй их дотно бүлгээ. Сүмийн хороонд байсан завхай зайдан хүн чанаргүй хүмүүсийн дотор Темплстоугийн Альберт арга буюу тэргүүн байрын нэгийг эзлэх боловч зоригт Буагильберээс өөрийн муу ааль, мяндаг тушаал горилон сэтгэлээ хуурамч буян, номч, сүсэг бишрэлийн дүрээр халхлах ажээ. Тэргүүн хамба ийнхүү гэв гэнэт хүрч ирээгүйсэн бол Темплстоуд ямар ч цалгар осолтой байдал олж үзэхгүй байхсан. Тэр ч байтугай одоо тэгж гэнэдсэн хойноо ширүүн багшийнхээ зэмлэлийг ихэд хичээнгүйлэн, гүнээ гэмшсэн байртай сонсож, урьд задгай зайдан байдал ноёрхож байсан хүрээндээ сахил санваарыг их л чандлан баримтлуулах болсонд Лук Бомануар даамлын ёсч буянчийг анх ирсэн өдрүүдийнхнийгээ бодвол ихээ дээгүүр үнэлэх болжээ.

Бүх байдлаас үзэхэд хийдийн санваартны нэгтэй янаг амрагийн холбоо бүхий, олзлогдсон еврей бүсгүйг Альберт Мальвуазен хүрээндээ орогнуулсныг мэдмэгц ийнхүү овоогоор бодож байсан нь эрс хувирав. Альбертыг дуудсан ёсоор ирмэгц тэргүүн хамба ер бусын ширүүнээр угтан,

- Гэгээн хийдийн хорооны баатруудын эндэх хүрээнд бидний нэгэн санваартан хүн авчирсан эрхэм даамал таны зөвшөөрөлтэйгээр орогнуулсан еврей омгийн бүсгүй байна гэж Бомануар ширүүнээр хэллээ.

Альберт Мальвуазен ихэд тулгамдлаа. Золгүй Ревеккаг байТэгвэл шингийн хамгийн хол, нууц хэсэгт байрлуулж, хүн амьтанд мэдэгдэхгүй бүх аргыг хэрэглэсэн ажээ. Нөмрөн ирсэн аюулыг зайлуулж эс чадвал Буагильбертэй хоёул балрах цаг ирсийг тэргүүн хамбын харцаар

МЭДЭВ.

- Та юунд дуугүй байна? гэж тэргүүн хамбыг шавдуулахад Мальвуазен гүнээ хүлцэнгүй дуугаар,

- Би хариу айлдаж болохсон болов? гэсэн нь чухамдаа энэхүү асуултаар жаахан юм эрэгцүүлэх цаг хожихыг хичээжээ.

- Ярь! Сүмийн хорооны баатрууд бүсгүйчүүлтэй ойртохыг хориглосон манай ариун дүрмийн бүлгийг чи мэдэх үү? хэл гэхэд,

- Мэдэлгүй яах вэ, өндөр дээд багштан минь. Хорооныхоо дүрмийн нэн чухал зүйл ангийг мэдэхгүй байсан аваас би хэрхэн ийм өндөр мяндагт хүрэх билээ? гэв.

- Тэгвэл дахиад асууя. Манай нэгэн сахилтнуудын нэгэнд нөхцсөн тэр дундаа муу увьдаст бүсгүйг нааш нь авч ирэхийг зөвшөөрөн энэ хүрээний ханыг яагаад бузарлуулдаг билээ? гэхэд,

- Муу увьдаст гэнээ? гэж Альберт Мальвуазен давгаж асуугаад, - Загалмайн хүчин бидниг ивээх бүлгээ? гэж дуу алдав.

- Тэгвэл өргөн андгайг зөрчсөн тийм явдал тэргүүн хамба ширүүн өгүүлээд, - Яг тийм. Бузар мөнгө хүүлэгч Йоркийн Исаакийн охин, хар муу увьдаст Мириамын шавь Ревекка одоо чиний хүрээний дотор байж байгааг чи үгүй гэж мэлзэж зүрхлэх үү? гэв.

- Эрхэм багш таны мэргэний ачаар миний нүдийг хаасан хар хөшиг ариллаа. Бриан де Буагильбер шиг зоригт сайн баатар энэ хүүний гоо үзэсгэлэнд хэрхэн тэгж ихээр татагдсаныг би ухаарч ядаж байсан билээ. Тэдний цаашид улам ойртоход саад болох зорилгоор л хүүхнийг би хүрээнд орогнуулсан бөгөөд эс тэгвэл бидний нэгэн санваарт эр зоригт хүндэт хүн хэцүү нүгэлд учрах аюул ороод байсан бүлгээ гэж хүрээ даамал өчив.

- Тэгвэл өргөсөн андгайг зөрчсөн тийм явдал тэдний хооронд өнөө хүртэл гараагү юм шив? гэж хамбыг асуухад, даамал машид хилмэгдэн цочиж, загалмайлан залбираад,

- Юу, манай ариун хүрээн дотор уу? Гэгээн Магдалины болоод арван мянган ариун явдалт дагина биднийг өршөөх болтугай! Үгүй! Бүсгүйг би хүрэндээ орогнуулж осол үйлдсэн гэхэд манай нэгэн санваартны тэр еврей бүсгүйд мунхгаар сайн болсон сэтгэлийг таслан цагаатгахыг горилсондоо тэр билээ. Буагильберийн тэр хүүхэнд янаг сайн нь тун хачин, зүй ёсноосгадуур тул би түүнийг өөрийн эрхгүй ухаан солиорсонд тооцон зэмлэж хатуулах биш өрөвдөх зөөлөн аргаар эдгэрүүлэхэд хялбар гэж үзсэн билээ. Гэвч тэр завхай еврей хүүхэн муу увьдастайг эрхэм хүндэт мэргэн банш та илрүүлснээс хойш Буагильберийн үл ухагдах мунхаг тачъяалын учир үүгээр тайлбарлагдах юм байна гэв.

--Тийм байж таарна! Тийм байж таарна! гэж Бомануар дуу алдаад, Шулмын муу овонд автах гэдэг ямар байдгийг Конрад чи харж байгаа биз Бүсгүй хүн рүү зөвхөн нүдээ хужирлах, гоо сайхан гэддэг зүйлийг нь шохоорхох гэж харахын хамт нөгөө дайсан, нөгөө архирагч арслан тэр үеэр биднийг эзэмдээд авдаг байна. Дээр ямар нэгэн сахиус, дом тэргүүтэн хөнгөмсөг

наргианаар хэлсэн хэргийг туйлд нь хүргэж тавина. Энэ хэрэгт санваартан Бриан цээрлэлээс илүү өрөвдөл төрүүлэхээр залхаан шийтгэхийн оронд дэмжлэг үзмээр болсон байж болох юм. Бидний сургал залбирал энэхүү мунхралаас нь гаргаж, төөрөлдсөн түүнийг санваартны эгнээнд эргүүлэн оруулж болохтой юмаа гэв.

Конрад Мон-Фитчет үүнд, - Манай гэгээн нэгдэлд хүвгүүдийн маань туслалцаанд онцгой их шаардагдаж байгаа энэ үед хороо, шилдэг дайчдынха нэгийг алдах ахул их харамсалтай зүйл болохсон. Бриан де Буагильбер өөрийн гараар гурван зуу хүртэл сарацин устгасан хүн гэвэл тэргүүн хамба,

- Тэрхүү хараал идсэн нохдын цус гэгээнд болоод хаад тэнгэрүүдэд аятай таатай өргөл болно. Тэдний гэгээн туслалцааны ачаар нэгэн санваартан нөхрийг маань төөрөлдүүлсэн хорлолыг зайлуулах гэж хичээнэ. Энэхүү шинээр гарч ирсэн Далилын тавьсан торыг Буагильбер, Филистимляндүүдын хүлсэн олсыг эртний Самсон баатар тасар татсаны үлгэрээр тасчин хаяад буруу номтныг дахин мянгаар нь хядах болно. Харин ариун сүмийн баатрыг хорлосон бузар увьдаст бүсгүйн тухайд гэвэл түүнд эрхиш алах ял оногдуулбал зохино гэлээ. Тэргүүн хамбын хилэн өөрөөс нь болоод Буагильберээс хэлтэрч өөр хүнд туссанд хүрээ даамал баярласан бөгөөд харин Бомануарыг хэтэрхий давамгай аашлах бий гэж эмээн, - Гэхдээ английн хууль... гэтэл тэргүүн хамба үгийг нь тас дайран,

- Английн хууль шүүгч бүрд өөрийн эрх хэмжээний газар шүүлт, залхаалт явуулахыг зөвшөөрсөн байдаг юм. Өөрийн нутаг дэвсгэр дээр илрүүлсэн муу увьдастныг бээл бүр баривчлах, шүүх, цаазлах эрхтэй билээ. Тэгээд сүмийн хорооны тэргүүн хамбад нэгэн хүрээнийхээ дотор ийм эрх эдлэхийг үл зөвшөөрөх гэж үү? Үгүй! бид түүнийг шүүж, тогтоол гаргана. Муу увьдаст бүсгүй газрын хөрснөөс үгүй болон түүний учруулсан гайг бурхан өршөөж хэлтрүүлнэ. Их танхимийг муу увьдаст бүсгүйг шүүхэд бэлтэг гэв.

Альберт Мальвуазен мэхийгээд гарч одов. Гэхдээ их танхимийг шүүх явуулахад бэлтгэж зас гэж тушаахаасаа өмнө хэрэг хаашаа хандах төлөвтэйг дуулгахын тулд Бриан де Буагильберийг эрж олохоор явлаа.

Гоо сайхан еврей бүсгүйн хатуу эсэргүүцэлтэй Бриан дөнгөж сая тулгараад багтран уурлаж байхад нь дайралдав.

- Юун мунхаг хэрэг вэ? Урсах бөөн цус, дүрэлзэх дөлөн дундаас өөрийнхөө амь насыг гаргуунд гаргаж байж аварч өгсөн хүнийг түлхэх гэдэг яасан ч тусыг үл боддог амьтан бэ? гэж тэр дуу алдаад, - Бурхны нэрээр андгайлахад, Мальвуазен энэ хүүхнийг эрж байх зуур алдар хөндөл моднууд эргэн тойрон тагчинан бөөн бөөнөөрөө унаж байсан. Би хэдэн сумны бай болж цонхны тавиур руу шаагих мөндөр аятай миний хуягийг дэлдэж байхад би өөрийн биеийг үл бодон бамбайгаараа хүүхнийг халхалж байсан билээ. Эд бүгдийг би өөрийн нь төлөө туулж өнгөрүүлсэн атал энэ зөрүүд зантай хүүхэн одоо намайг яагаад тэгэхэд үхэх боломж өгсөнгүй вэ? гэж зэмлэн өчүүхэн талархал илчлэхгүйгээр үл барам хариу сэтгэлтэй болох өчүүхэн ч найдлага өгөхгүй байна. Энэ овгийг зөрүүд зантай болгон заяасан чөтгөр үүнд шүгэлж орхисон юм аятай гээчгэв.

Хүрээ даамал үүнд, - Минийхээр бол та хоёр аль алинд чинь шулам шүгэлсэн бололтой.

Тачьяалаа барьж чаддаггүй юмаа гэхэд хянуур болгоомжтой барьж байгаарай гэж би хичнээн удаа танд зөвлөлөө! Ийм зоригт баатарт сэтгэлтэй сайн байгаага илтгэхээс татгалзахыг нүгэл гэж үзэх христос шашинтан охид хорвоо дээр үй олон бий гэж би танд дахин давтан хэлээгүй билүү. Тэгэхэд үгүй шүү, та өөрийн сэтгэлийг заавал энэ зөрүүд, ааштай еврей хүүхэд өгөх хэрэгтэй байсан юм гэнэ! Таны муу увьдсаараа хорлосон гэж хөгшин Лука Бомануарын хэлдэг үнэн байх гэж бодож эхэлсэн шүү, нээрээ гэв.

- Лука Бомануар гэнээ? гэж Буагильбер зэмлэнгүйгээр дуу алдаад, - Мальвуазен чи өөрөө ингэж хянуур болгоомжтой байдаг хүн юм бий! Тэр хөгшин солиот Ревеккагийн хүрээнд байгааг юунд чи олж мэдүүлэв? гэхэд,

- Би яах юм бэ? Хэргийг нууц байлгахын тулд би өчүүхэн ч зүйлээр осолдсонгүй атал хэн нэг нь шинжиж мэдээд хов хүргэчихсэн байна. Чөтгөр ч тэглээ гэсэн ганцхан өөрөө л үүнийг мэдэх байх. Би чамайг хаацайлах гэж чадах хирээрээ оролдсон. Чи зүгээр өрөвдөж, муу хараалд автсан хүнд тооцож байна. Ревекка харин муу увьдастан хүн үүнийхээ төлөө цээрлэл үзэх учиртай гэхэд,

- Үгүй шүү, бурхныг барьж андгайлахад би тэгэхэд хүргэхгүй гэж Буагильбер өгүүлэв.

- Би мөн бурхныг барьж андгайлахад тэгэх ёстой бөгөөд тэгнэ чиг! гэж Мальвуазен хэлээд, - Чи ч тэр, өөр хэн ч гэсэн хүүхнийг аварч хүч хүрэхгүй. Еврей бүсгүйг цаазлах явдал сүмийн хорооны баатруудын янаг амрагийн бүх нүглийг ариутгах золиос болно гэж Бомануар урьдаас нэгэнт шийджээ. Түүний эрх мэдэл хир ихийг чи өөрөө мэднэ. Иймд өдий мэргэн буянт үйлийг бүтээхийн төлөө Бомануар түүнийгээ заавал ашиглах болно гэв.

- Ийм учир утгагүй мухар харгислал хийгдсэн байсан байж болоход манай хойт үеийнхэн хэзээ ч үнэмшихгүй шүү! гэж Буагильбер сэтгэл түгшин өрөөн дотуур хойш урагш холхино.

Мальвуазен тайвнаар, - Тэд юунд итгэж, юуг үл үнэмшихийг би мэдэхгүй. Харин манай үед лам хар ялгаагүй зуун хүн тутмаас адаглаад л ерэн ес нь манай тэргүүн хамбын шийдвэрийг дуулаад болтугай гэнэ гэдгийг би сайн мэдэж байна гэлээ.

- Ингэхэд би нэг арга оллоо. Чи анд нөхөр шүү дээ. Альберт надад тус болж үз. Бүсгүйг орлуулахаар зохион байгуул, би түүнийг хол нэг аюулгүй нууц газар авч одье гэж Буагильберийг хэлэхэд,

- Тэгье гэж бодлоо ч гэсэн чадахгүй. Тэргүүн хамбын зарц түүний талынхан бүх хүрээгээр дүүртэл байна. Тэгээд ч илэн далангүй ярихад өөрөө зэмгүй мултрах горьдлоготой байлаа ч гэсэн би энэ хэрэгт хутгалдах дургүй байна. Чиний төлөө би бишгүй их осолтой юм хийсэн тэгээд аль нэг еврей бүсгүйн сайхан нүднээс болж хүрээ даамлын мяндгаа алдах дур огт алга. Миний зөвлөлгөөнийг сонс! Энэ тэнэг явдла орхиод өөр ямар нэг зүйлээр оролд. Буагильбер чи бод, чиний өнөөгийн байдал ирээдүй ч инь хоорондоо ямар шүү байр эзлэхээс чинь хамаарах бүлгээ... Чи зөрүүд аашлаж, Ревеккад шунан тачаалдаж байгаага орхихгүй бол өөрийгөө хорооноос хөөн гаргах эрх Бомануарт өгөх болно гэдгийг санаарай. Цаадах чинь тийм тохиолдлыг ер өнгөрөөхгүй. Дээд эрх барих очырыг хөгшин гартаа амь тавин зуурдаг бөгөөд тэр очырыг авах санаа эрмэлзлэл чамд буйг сайн мэднэ. Тэр тусмаа муу

увьдаст еврей хүнийг өмөөрсөн гэдэг сайхан шалтаг гаргаж өгөх юм бол чамайг зайлшгүй хөнөөж тавина. Нэгэнт түүнд хориг тавьж чадахгүйгээс хойш энэ удаадаа бууж өг. Харин түүний очир өөрийн чинь чийрэг гарт орсон хойно еврей охидыг дураа ханатал энхрийлэх юм уу, түүдэг дээр татахыг чиний таалал мэдэх хэрэг гэв.

Буагильбер үүнд, - Мальвуазен чи ямар хүйтэн сэтгэлтэй гэтэл түүнийг цааш нь илүү муу үг хэлчихэж магад хэмээн хүрээ даамал яаравчлан тас дайрч, - Анд нөхөр вэ гэж үү хэмээн нэмэн хэлж өгөөд, - Тиймээ, би хүйтэн сэтгэлтэй нөхөр мөн учраас чамд сайн зөвлөлгөө өгч чадна. Ревеккаг аврах арга үгүй гэдгийг давтан хэлье. Чи өөрийгөө мөн түүнтэй цуг хөнөөх болно гэдгийг дахин хэлье. Тэргүүн хамбын өмнө гэмшиж түүний хөлд сөхрөн ингэж хэл... гэтэл,

- Түүний хөлд ч сөхрөхгүй шүү! Аяг аашиг өвгөнд очиж бүгдийг шулуухан хэлнэ гэлээ. Мальвуазен цааш нь тайвнаар, - За яах вэ тэр олзлогдсон еврей хүүхэнд халуун хайртайгаа хэл. Янаг тачъяалынхаа тухай чи хэдий их ярих тусам л чиний сэтгэл булаагч гоо бүсгүйг цаазлан уул хэргийг дуусгахаар болгох гэж тэр яарах болно. Тэгэхдээ бас сахил санваараа умартсныг хүлээснээр нөхдийнхөө зүгээс ямар ч өршөөл энэрэл бүү горил. Ирээдүй эзлэх гэж горилж байсан хүчирхэг өндөр мяндаг тушаалын оронд Фландри Бургунди хоёрын явагдах жижиг тулалдаануудад оролцогч хөлсний дайчин л болж хувирна даа гэв.

Бриан де Буагильбер хувь хиртэй эргэцүүлэн бодсоноо Мальвуазен чи үнэн үг хэлж байна. Мунхаг сүсэгт өвгөнд өөрийнхөө эсрэг өдий хүчирхэг зэвсэг өгөхгүй. Ревекка чи мөн өөрийн нь төлөө би нэр төр ирээдүйгээ гаргуунд гаргахаар гавьяагүй бүсгүй. Би түүнийг хаяна. Ганцхан тэр юу яахгүй л юм болж гэм... би түүнийг хувь тавиланд нь даатгах болно гэв.

- Чи нэгэнт ийм ухаалаг шийдвэр гаргасан хойно ямар ч болзол бү тавь. Бүсгүй хүн гэдэг бид чөлөөтэй цагт зугаа гаргах тоглоомноос цааш юу юм бэ? Амьдралын жинхэнэ зорилго бол нэрээ дээш өргөмжлөгдөх хүслэнгээ хангах явдал мөн. Нэр алдар эрх ямбын төлөө урагшлах замд чинь саад болохгүйн тулд энэ еврей хүүхэн шиг хэдэн зуун эмзэгхэн биетэй амьтад үхэж байг... За одоо би чамайг орхиод явлаа, биднийг ийнхүү нөхөрсгөөр ярилцан буйг хүн харах учиргүй юм. Явж танхимийг шүүхийн хуралдаан хийхэд бэлтэг гэж тушаая гэв.

--Юу ийм хурдан уу? гэж Буагильбер дуу алдсанд хүрээ даамал хариуд нь,

- Тиймээ, шүүгч урьдаас оноох ялаа тухайлчихсан бол шүүх ер нь хурдан явагддаг юм шүү гэв.

Буагильбер ганцаар үлдээд:

- Ревекка чи надад маш их үнээр олдох нь дээ. Энэ хоёр нүүрт цэвдэг сэтгэлтний зөвлөж байгаачлан чамайг орхих хүч надад яагаад байдаггүй юм бэ? Чамайг аврах гэж би дахин нэг хүч гаргаад үзье. Харин сайхан мэдээрэй? Чи дахиад л намайг түлхэх юм бол миний өшөө авалт хайр сэтгэл шигээ хатуу байх болно. Хариуд нь зөвхөн зэмлэл жигшил үзэхийн тулд Буагильбер амт нас, нэр төрөө золиосонд гаргаж таарахгүй гэж шивнэлээ. Хүрээ даамал зохих тушаал дөнгөж өгч дуустал Конрад Мон Фитчет хүрч ирэн еврей бүсгүйг муу увьдастай учир даруйхан шүүе гэж тэргүүн хамба айлдаж байгааг дуулгав.

Хүрээ даамал үүнд, - Энэ ял тулгалт үнэн байдалд илтэд нийцэхгүй байна. Манай еврей эмч аль бахыг тэр гэх билээ. Өвчтөнийг эмнэхдээ тэд сайн хэдий боловч тэдний муу увьдастайд тооцож байгаа хүн хэн ч үгүй гэвэл Мон Фитчет хариуд нь:

- Тэргүүн хамбын бодол өөр байна. Ингэхэд Альберт би чамтай илэн далангүй ярилцъя. Бриан де Буагильбер манай үйл хэргээс хөндийрэх юм уу, манай хүрээ дотроо зөрчилд авган донсолсонд орвол муу увьдастай ч бай, үгүй ч бай нэг еврей хүүхэн үхэг. Буагильбер хир их өндөр язгууртай, дайн тулалдаанд хир их алдаршсаныг чи өөрөө мэднэ. Манай санваартнуудын олонхи нь түүнийг хир их хүндэтгэн үздэгийг мэднэ. Гэхдээ тэргүүн хамба түүнийг еврей бүсгүйн арганд орсон хүн биш, хамсаатан нь үзвэл эд бүгд ер тус болохгүй шүү гэлээ.

- Тэр бүсгүйг орхи гэж дөнгөж сая би түүнийг ятгалаа гэж Мальвуазен хэлээд, гэхдээ Ревеккаг муу увьдас гаргасан гэж ял оноож болохоор тийм шалтаг байгаа юм уу даа? Баталгаа хэтэрхий улгүйг үзээд манай тэргүүн хамба шийдвэрээ өөрчилж магад юмаа даа гэхэд Мон Фитчет өөдөөс нь марган,

- Тэр баталгааг лавшруулж өгөх хэрэгтэй Альберт. Баталгаа олох хэрэгтэй... Ойлгож байна уу? гэв.

Хүрээ даамал ойлгож байна. Би өөрөө ч гэсэн хийдийнхээ дэвжиж дээшлэх хэрэгт бүх аргаар зүтгэхэд бэлэн. Гэтэл цаг даанч бага байна. Болмоор гэрч этгээдүүд би хаанаас олох юм бэ? гэхэд Конрад дахин:

- Тэднийг олох хэрэгтэй гж би хэлж байна шүү, Мальвуазен. Энэ чинь хийдэд болоод өөрт чинь ашигтай болно. Эндхийн энэ Темплстоу чинь баян хүрээ бишээ. "Бурхны ордон" гэдэг нэртэй хүрээ үүнээс хоёр дахин баян чинээлэг юм. Манай хөгшин эзэнд би нилээд нөлөөтэйг чи мэднэ. Бидэнд энэ хэрэгт туслахаас үл татгалзах хүмүүс ол. Тэгвэл чи Кентийн үржил шимт нутагт "бурхны ордон" хүрээний даамал болно. За юу гэмээр байна?гэлээ.

Ингэхэд Буагильбертэй цуг ирсэн зарц нарын дотор би аль эртнээс мэдэх хоёр этгээд бий. Урьд тэд миний ах филипп Мальвуазенгийн зарц байгаад фрон де Бефийнд зарцлагдахаар шилжсэн билээ. Энэ хүүхний муу увьдсын тухай тэд юм мэдэж магадгүй дээ гэвэл,

- За тэгвэл бушуухан явж тэднийг ол. Альберт чи сонс тэдний маргасныг сануулахад хэдэн ширхэг алтан зоос хэрэгтэй болбол мөнгө бүү хайрлаарай гэв.

- За тэгвэл түргэлж үз гэж Фон – Фитчет хэлээд,

- Үд гэхэд шүүх ажилдаа орох хэрэгтэй. Загалмай зүүснээ буцаж буруу номондоо, мусульман шашиндаа орсон Хамет Альфагийг шатааснаас хойш манай эзнийг өдий их шамдуу байхыг би шөр үзээгүй гэж хэллээ.

Хоригдож байгаа өрөөний нь нууц шатаар хүний хөлийн чиеэ гарахыг Ревекка дуулав. Цамхаг дээрээс хүнд хонх үд дунд болсныг мэдэгдэн дуугарав. Хөлийн чимээгээр үзэхэд хэд хэдэн хүн бололтойд тачъяалт Буагильберийн ирэхээс юу юунаас илүү айж байсан хүүхэн баярлав.

Үүд нээгдэж Конрад Мон Фитчет хүрээ даамал Мальвуазен хоёр алман сүх бүхий хар хувцастай хуягууд дагуулан орж ирлээ.

- Хараалт муу омгийн охин чи босож бидний хойноос яв! гэж хүрээ даамал өгүүлэв.

- Хаашаа, яах гэж тэр вэ? гэж Ревеккаг асуухад Конрад өөдөөс нь:

- Хүүхэн чи асуух бус зөвхөн үг дагах л хэрэгтэй! Гэхдээ чамайг шүүхээр авч явж байгаа, тэнд чи манай ариун хийдийн тэргүүн хамбын өмнө очно, гэмт хэргийнхээ тухай өглөг өгөх болно гэдгийг мэдэж ав гэлээ.

Ревека бишрэнгүйгээр залбиран, - Авраам бурхандаа залбиран магтая. Шүүгч гэдэг хэргэм хэдий манай омогтой дайсагнагч талынх ч гэсэн өмөг түшиг болох болов уу гэдэг горьдлого төрүүлж байна. Би та бүхний араас машид дуртайяа дагана. Зөвхөн толгой дээгүүрээ гивлүүр нөмрөхийг зөвшөөрнө үү гэв.

Тэд ёсорхуу алгуур алхан шатаар бууж урт хонгилоор яван хоёр самбартай хаалгаар шүүх явагдах учиртай их танхимд оров. Их заалын дорд талаар дүүрэн дагуул, йоменүүд чихсэнд Ревеккаг дагаж яваа улс нь олны дундуур арайхийн чихэлдэж өнгөрөв. Заасан газар руу нь Ревекка толгойгоо бөхийлгөн гараа элгэндээ зөрүүлээд очиж явахдаа олны дотроос нэг хүн гарт нь жижиг сайрны тасархай атгуулахыг ажигласангүй. Бараг өөрөө ухааралгүйгээр түүнийг аваад цааш явахдаа түүн рүү ганц ч хялам хийсэнгүй. Энэ аймшигт хуралдаан дээр өөрт нь сайныг хүсэх хүн байгааг үнэмшиж нилээд зориг орлоо. Толгойгоо өргөөд үзсэн зүйлийг бид дараа бүлэгт өгүүлэх гэж оролдоё.

ГУЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ

Гуниг зовлонгийн төлөө

Гутарч гашиудахыг хорьдог нь харгис хууль

Баяр жаргалыг хараад

Баясан инээхийг хорьдог нь харгис хууль

Гэмгүй хүнийг цээрлүүлж

Гэмтэн харгисуудын эрхийг

Дээд тэнгэрийн болгодог нт харгис хууль

"Дундад зуун"

Өчүүхэн ч гэм буруугүй зол муутай Ревеккаг яллах учиртай шүүх танхимын нөгөө талын тавцан дээр суужээ. Хэрэгтний эгц өөдөөс харсан өндөр түшлэгт сандал дээр сүмийн хорооны тэргүүн хамба, хээнцэр цагаан хувцастай заларчээ. Тэрээр хорооныхоо загалмайг дээр нь сийлсэн таяг гартаа барьсан байв. Хөлний нь дэргэдэх ширээн дээр хоёр тахилч суусан нь шүүхийн хуралдааны явцыг тэмдэглэх үүрэгтэй ажээ. Тэдний хар жанч мухар толгой хүлцэнгүй байр нь хүрээнд байнга суудаг болон тэргүүн хамбынха амар мэндийг мэдэхээр хүрч ирсэн баатруудын дайчин дүртэй маш эрс үзэгдэнэ. Тэргүүн хамбын буудлын ард хүрээ даамлын мяндаг бүхий дөрвөн хүн сууж цааших вандан суудлууд дээр хорооны жирийн гишүүд суун тэдний цаана нь уул тавцан дээр цагаан хувцастай дагуулууд зогсжээ.

Ийнхүү сүр жавхаа ихтэй байв. Тэргүүн хамбын дэргэд баатрууд ердийн эрэлхэг дайчин байртай нүүр царайгаа хувраг хүнд зохимжтой ихэмсэг төв байлгахыг хичээнэ. Бүх танхимд балт сүхтэй манаач нар, тэргүүн хамба болоод муу увьдаст еврей хүүхнийг үзэх гэж ирсэн хүмүүс дүүрчээ. Гэхдээ ихэнх үзэгчид Темплстоу хүрээнийхэн болох учир хар хувцас өмсчээ. Хөрш нутгийн тариачдыг мөн шүүхийн танхимд оруулсан нь уул сургамжтай зүйлийг аль болох олон хүн үзээсэй гэж Бомануар хүссэн ажээ. Тэргүүн хамбын том цэнхэр нүд гялалзаж гүйцэтгэж буй чухаг үүргээ ухамсарласан ихэмсэг царайтай ажээ.

Мөргөл уншиж хурал нээлээ. "Ирж бурхныг мган дуул" гэдэг мөргөлийн сүртэй дуу цуурайтав. Энэ мөргөлийг сүмийн хорооныхон хорвоогийн дайсантай тулалдахдаа их дуулдаг болохоор хар зүгийн хүчний эсрэг үзэлцэж заавал дийлж гарах итгэл төгс байгаа тухайн учралд мөн хамгаас илүү тохирно гэж Лука Бомануар үзжээ. Хэдэн зуун эрэгтэйчүүдийн аргил дуу дугананд цуурайтан их усан уналт мэт нүргэлэв.

Мөргөл дуулж төгсмөгц тэргүүн хамба хурсан бүгдийг алгуур эрэгцүүлэн харвал хүрээ даамлын мяндагтны суудлын нэг эзгүй байв. Тэр нь баатруурын суусан вандан сандлуудын нэгний дэргэд зогсож буй Бриан де Буагильберийн суудал ажээ. Нүүрээ халхлах гэсэн юм шиг зүүн гараараа нөмөргөө өргөн баруун гартаа илд барьж үзүүрээр нь царсан шалан дэр

ямар нэгэн тэмдэг зурна.

Тэргүүн хамба түүнийг өрөвдөнгүй харж аяархнаар:

- Золгүй амьтан. Бүсгүй хүний хөнгөмсөг харц, хар хүчний туслалцаатайгаар эр зоригт, хүндэт дайчин эийг ийм байдалд хүргэж чаддаг байна шүү, харж байгаа биз бидний өөдөөс харж чадахгүй байгааг. Бас хүүхэн рүү ч харж зүрхлэхгүй шалан дээр буруу номын тэмдэг ийнхүү улайран зурж байхыг үзвэл энэ үед түүнийг шулам тарчлаасаар байгаа ч юм уу хэн мэдэх билээ. Бидний амь насыг хорлож сүнсийг хөнөөх муу санаа агуулаагүй байгаа? Гэхдээ чөтгөрийн хорлол бидэнд аюулгүй, хүн төрөлхтний дайснаас бид айхгүй! гэв.

Эдгээр үгийг зөвхөн эзний дотнын хүн Мон-Фитчетэд шивэgnэн өгүүлжээ. Дараа нь тэргүүн хамба өндөр дуугаар бүх хуралдагсдад хандан,

- Хувраг сахилт эр зоригт эрчүүл, баатрууд, өдөр мяндагтан, манай гэгээн хийийн нөхөд, ах дүүс, шавь нар минь ээ! Сайн язгуурт буянч ариун загалмайтан дагуулуудаа. Мөн нэгэн шашинтан ах дүү алив хэргэм зэргийн хүмүүсээ! Энэ хурлыг бид хувийн эрх мэдэл дутагдсаны учир хуралдуулж байгаа бус гэдгийг мэдтүгэй. Юу гэвэл бурхны хүлцэнгүй өчүүхэн, боол миний бие гартаа атгуулсан энэхүү очирын хүчээр манай ариун хийдийн ашиг тусад хамаарах бүх хэргийг шүүж залхаах эрх бүхий бүлгээ. Манай дайчин ариун нийгэмлэгийн дүрмийг боловсруулсан гэгээн ламтан Бернард уул дүрмийн тавин ес дүгээр бүлэгт дурдахдаа санваартнууд зөвхөн тэргүүн хамбын хүсэл тушаалаар л хуралдан зөвлөлдөж болно гэсэн бөгөөд бид болон бидний түрүүн энэхүү ариун мяндгийг хүлээсэн лам багш нарт, манай хийдийн тэргүүнд юун тухай, хаана ямар газарт цугларахыг тогтоож өг гэж заажээ. Тэгэхдээ санваартан ах дүү нарын саналыг сонсоод өөрсдийн үнэмшлийн дагуу үйлд гэж заасан байдаг. Гэвч галзуу чоно сүрэг рүү нь дайря нэг хурга аваад явчихад сайн малчин хүн бол нөхдийгөө нум сум, дүүгүүртэйгээ ирж өштөнг дарахад туслаа гэж бүх нөхдөө дуудаж цуглуулах учиртай. Манай дүрмийн хэн бүхний сайн мэдэх зүйл ангид "арсланг бүхий л аргаар бүр давтан дарж бай" гэсэн байдаг. Иймийн тулд бид Йоркийн Исаакийн охин Ревекка нэртэй, муу увьдас бузар мэрэг төлгөөрөө алдартай еврей бүсгүйг бид энд авч ирээд байна. Энэ муу увьдсаараа энгийн нэг хүний багш баатрын цусыг хөөргөж ухаан санааг нь балартуулжээ. Хар хүнийг бус ариун сүмд зүтгэхэд биеэ зориулсан баатрыг жирийн нэг баатар төдийгүй манай хийдийн хүрээ даамал өндөр хэргэм, нэр хүндтэй хүнийг тэр шүү. Манай нэгэн санваарт Бриан де Буагильберийг төдийгүй энд сууж байгаа хүмүүс цөм загалмайн эр зоригт үнэн зүтгэлт хамгаалагч, ариун газарт олон сайхан гавьяа байгуулсан хүн гэж сайн мэднэ. Санваартан нөхдийнхээ дунд эр зориг дайчин гавьяанаасаа дутуугүй мэргэн ухаанаараа тодорсон тул энэхүү очирыг барих хүнд үүргээс бурхан намайг чөлөөлж таалахын хамт уламжлан барих хүн гэж түүнийг манай хийдийн баатрууд тооцож заншсан билээ. Энэ сайн төрөлт баатар манай хийдийн дүрмийг гэнэт зөрчиж, өргөсөн андгайн эсрэг, хань нөхдөө үл тоомсорлон, өмнөө нэгдмэл сайхан ирээдүйг үл ойшоож еврей хүүхэнтэй нөхцөөд түүний төлөө амь насаа дүйн, эцэст нь нааш авч ирж манай хийдийн хүрээнүүдийн нэгэнд орогнуулсныг дуулаад муу увьдаст шулмын хорлолоос өөр юу гэж бид үүнийг үзэх вэ? Хэрвээ бид өөрөөр бодож болох байсан бол түүний өндөр хэргэм, хувийн эр чадал алдар нэрийн алин ч түүнийг хатуугаар цээрлүүлж хорт муу үйлийг тас цохиход бидэнд саад болохгүйсэн билээ. Юу гэвэл энэ харамсалтай явдалд манай хийдийн дүрмийг зөрчсөн

гэмт хэрэг хэд хэд байна гэж бид үзэж байгаа юм. Нэгд баатар өөрийн зоргоор аашилсан. Хоёрт сүм хийдээс ангижирсан хүнтэй нөхцсөн. Гуравт харь орны бүсгүйчүлтэй ойртсон. Эдгээр бурхан номд харш бүх бузар хэргийн төлөө Бриан де Буагильберийг хэдийгээр манай хийдийн баруун гар баруун нүд байсан ч гэсэн бидний дотроос хөөн зайлуулбал зохих байсан бүлгээ гэв..

Хамба лам дуууй болсонд бүх хурагсад намуухнаар дүнгэнэлдэж дургүйцэв. Тэргүүн хамбын үгийг сонсон инээж эхэлсэн байсан зарим залуу хүмүүс одоо номхорч түүний юу гэхийг зүрх шимшрэн хүлээв.

- Манай дүрмийн өдий олон нэн чухаг зүйл ангийг өөрийн зоргоор зөрчсөн сүмийн хорооны баатарт оногдох хүнд цээрлэл ийм байхсан билээ. Харин залуу охины гоо сайханд хөнгөмсгөөр шохоорхсон төдийд муу ов хараалын хүчээр шулмын эрхшээлд орсон баатрыг бол бид цээрлүүлэхээсээ илүү нүгэл хилэнцийн нь төлөө харамсан гашуудалтай. Гурим бус авираасаа ангижрахад нь тус болох шийтгэл түүнд оногдуулаад бүрэн мөсөн хөнөөхөд ойртсон шулмын биелэл рүү нь бид хамаг хилэнгээ хандуулбал зохино. Иймд эдгээр үйлийн гэрч байсан хүн бүр урагшаа гарч, манай шүүх тэр бузар явдалт бүсгүйг цээрлүүлснээр зогсож болох нь уу аль сэтгэл харамсан байж нэгэн санваартан нөхрөө залхаахад хүрэх нь үү гэдгийг тунгаахаар сайтар яригтүн гэв.

Хэд хэдэн хүнийг дуудан гаргавал шатаж байгаа байшингаас Ревеккаг аврахын тулд Буагильбер хэрхэн амь дүйж байсныг өөрсдөө үзсэн гэж гэрчлэв. Энэ явдлыг нарийвчлан ярихдаа ер бусын үйл явдалд ихэд хэлмэгдсэн борчуулын заншлаар давуулж ярив. Бүх л гайхалтай хачин юманд дуртайгийн дэр ийнхүү гэрчлэх нь өндөр мяндагтан хүнд илтэд таатай байгаа гэж бодохоос улам ч давамгайдуулах ажээ. Үүний ачаар Буагильберийн өөртөө учруулсан аюул тэдний яриагаар бол өгүүлшгүй их болчихлоо. Баатрын Ревекаг аврах гэж гаргасан эр зориг тэдний гэрчилж байгаагаар үзвэл, нарийн нэг хянуур болгоомжийн хүрээнээс төдийгүй, үнэнч сайн баатруудын агуу их гавьяа зүтгэлийн хүрээнээс төдийгүй, үнэнч сайн эр баатруудын агуу их гавьяа зүтгэлийн хүрээнээс хальж гарчээ. Гоо бүсгүйн зэмлэж буруушаасан хатуу үгийн хариуд бишрэнгүй зөөлөн байсныг нь тун ч хэтрүүлэн ярьсанд бардам дээрэнгүй зантайгаараа нэрд гарсан хүний тухайд төдий их боолын хүлцэнгүй байдалд нь үнэхээр ер бишийн зүйл шиг санагдав.

Дараа нь Темплстоу хийдийн даамал дуудагдаж, Буагильберийн Ревеккатай цуг хүрээнд хэрхэн хүрэлцэн ирсэн тухай ярив. Мальвуазен тун хянуураар очиж, Буагильберийн сэтгэлийг хөндөхгүйг аль болохоор хичээ авч яриандаа үе үе баатрын ухаан санааг аль нэгэн талаар төөрөлдсөнд тооцож байгаагаа үзүүлсэн үг хавчуулж байв. Ревеккаг нөхцсөн хүнтэй нь хүрээндээ өөрөө хүлээж авсандаа даамал хүндээр шүүрс алдан гэмшив.

- Өөрийн энэ осол бурууг зөвтгөж хэлэх миний ганц үгийг би өндөр дээд тэргүүн хамба багшийн өмнө наминчлал дээрээ айлтгасан билээ Хэдийгээр би буруу хэрэг үйлдсэн боловч муу санаа агуулж хийгээгүйг багштан мэдэж байгаа. Багшийн таалж оногдуулах элив шийтгэлийг би үзэж өнгөрүүлэхэд баяртай байна гэв.

Бомануар үүнд, - Санваартан Альберт чи зөв хэллээ. Чи төөрөлдөж явсан нөхрөө хөнөөдөх замд нь зогсоох зөв болол агуулсан учир хэдий буруу үйлдсэн боловч чиний санаа муу

байгаагүй, чи морийг зогсоох гээд жолооноос нь шүүрч авахын оронд дөрөөнөөс нь барьсан хүн шиг юм хийжээ. Тийм янзаар бол зөвхөн өөрийгөө хорлоод зорьсондоо хүрэхгүй байж болно. Манай буянч үндэслэн байгуулагч биднийг "эцэг болсон бурхан минь" гэдэг залбирлыг өглөөний мөргөлийн үеэр арван гурван удаа оройн мөргөл дээр есөн удаа унш гэж сургасан байдаг. Чи харин үүнийг хувь илүү уншиж бай. Сүмийн хорооны баатар долоо хоногт гурван удаа мах идэхийг зөвшөөрдөг. Энэ цээрлэлүүдийг чи зургаан долоо хоног эдлэх хэрэгтэй гэв.

Темплстоу хийдийн даамал хуурмагаар гүнээ хүлцэнгүй дүр үзүүлж эзний өмнө газар хүртэл мэхийгээд хуучин байрандаа очиж зогсов.

- За одоо санваартан ах дүү нар чинь энэ хүүхний өнгөрснийг гүнзгий уудлан үзэж, муу увьдас гаргаж хүмүүсийг хорлох чадвартай эсэхийг нь магадлаж үзэх хэрэгтэй. Энэ бидний дуулсан бүхнээс үзэхэд манай төөрөлдсөн санваартан шидийн урхинд орж, чөтгөрин хорлолын нөлөөгөөр үйлдсэн бололтой гэв. Шүүхийн хурал дээр байлцсан хүрээ даамлуудын дөрөв дэх нь Герман Гудольрик байлаа. Нөгөө гурав нь Конрад-Мон Фитчет, Альберь Мальвуазен болон Бриан де Буагильбер өөрөө байлаа. Герман нас ахимаг нүүрээрээ мусульманы сэлмэнд цавчуулсан шархнуудтай, дайчин дүртэй хүн бөгөөд нөхрийнхөө дунд нилээд нэр хүндтэй ажээ. Тэрээр босож, тэргүүн хамбад мэхийвэл даруй үг хэлэхийг зөвшөөрөв.

- Өндөр дээд багштан, энэ тулгагдаж буй бүх гайхалтай хэрэг болоод энэ бүсгүйд өгсөн золгүй хайр сэтгэлийнхээ тухай эрэлхэг Бриан де Буагильбер өөрөө юу бодож байгааг би санваартан нөхдийнхөө өөрийн нь амнаас дуулмаар байна гэхэд тэргүүн хамба,

- Бриан де Буагильбер чи манай нэгэн санваартан Гудольрикийн асуултыг сонсов уу? Хариу өчихийг чамд тушааж байна гэлээ. Буагильбер тэргүүн хамбын зүг эргэж харсан боловч дуугүй хэвээр зогсоно.

- Үүнийг шулам хорлоод дуугаргахгүй болжээ. Тонил муу шулам! Манай ариун хийдийн бэлэг тэмдэг болсон загалмай барьж чамд тушаая. Бриан де Буагильбер чи өч! гэж тэргүүн хамба хэллээ.

Улам бүр дүрэлзэн байгаа уур хилэн жигшлээ илчлэх ахуул ямар ч ашиг гарахгүйг Буагильбер мэдэн их л хүчлэн дарж байлаа.

- Өндөр дээд багштан, ийм зэрлэг, тэнэг ял тулгалтанд Бриан де Буагильбер хариу хэлж чадахгүй, харин нэр төр нь хөндөгдсөн бол түүнийгээ биеэрээ, христос шашны тусын тулд цөөнгүй тулалдсан энэ илдээр хамгаалах болно гэж Бриан де Буагильбер хариулав.

- Нэгэн санваартан Бриан чи хуучин байлдааны гавьяагаараа гайхуулж бидний өмнө нүгэл үйлдсэн боловч бид уучлая. Юу гэвэл мөн өөрийнхөө гавьяагаар гайхуулах гэдэг шулмын түлхэц мөн. Гэхдээ чи өөрийнхөө өмнөөс биш, бурхны тусламжтайгаар бид дотроосоо цэвэрлэн хаях тэр хүний нөлөөгөөр ярьж байгаа болохоор бид чамайг өгөөмөр сэтгэлээр уучилж байна гэж тэргүүн хамба өгүүлэв.

Бриан де Буагильбер тэргүүн хамба руу жигшсэн хилэнт харц чулуудсан авч биеэ барьж юу ч дуугарсангүй.

Тэргүүн хамба цааш нь, - За ингэхэд манай нэгэн санваартан Гудольрикийн асуултанд шууд хариулт өгөгдөөгүй боловч бид мөрдөлгө цааш нь үргэлжлүүлэх болно. Гэгээн ивээгчийнхээ өршөөлөөр бид бурхан шашинд энэ харш хуйвалдааны эцсийг нь хүртэл илрүүлнэ. Энэ бүсгүйн үйл амьдралын тухай юм мэдэж байгаа хүмүүс урагшаа гарч тэр тухайгаа бидэнд гэрчилж өгтүгэй гэв.

Танхимын тэртээ буланд ноцолдон шуугилдах дуулдсанд юу болсон тухай тэргүүн хамбыг асуувал олны дунд нэг эрэмдэг хүн байна, хэрэгтэн бүсгүй урьд түүнийг явж чаддаг болтол шидэт эмээр анагааж өгсөн юм гэнэ гэв.

Олны дотроос саксон гарлын ядуу тариачин урагшаа түлхэгдэн гарлаа. Мэдээ алдсан биетэй еврей хүүхнээр эмчлүүлэн эдгэрсэндээ шийтгэл оногдохыг хүлээн үхтэл айжээ. Харин бүтэн эдгэрээгүй, хөөрхий амьтан өнөө хүртэл дөнгөж таягтай явдаг ажээ.

Хоёр жилийн өмнө Йоркийн Исаак гэдэг баян еврейнд мужааны ажил хийж байхдаа гэнэт өвдөөд хэвтсэн, тэгэхэд Рвекка халуун ногооны үнэр бхий нэг тос түрхэн эмчлээд эдгээсэн. Жаал сайжраад ирсэн хойно нь тэрхүү үнэт тосноосоо нэг сав, гэртээ Темплстоугийн ойролцоо байдаг эцэг дээрээ эргэж ирэхэд хэрэглэх мөнгө өгсөн гэж уйлан хайлан байж, тун дургүйгээр ярьлаа. Гэвч - Өршөөлт багштан танд айлтгахад, энэ бүсгүйн гайгаар еврей хүн болж төрсөн нь үнэн авч миний хувьд лав муу санаа агуулж байсан байж болшгүй. Мөн үүний өгсөн эмийг түрхэх бүрдээ би "эцэг болсон бурхан минь" "Сүсэглэнэ" гэдэг мөргөл уншдаг байсан, эмийн чадал үүнээс болж ер буураагүй шүү гэв.

- Дуугүй бай, боол чи цаашаа тонил! Чам шиг ийм малууд шулмын домч нараар эмчлүүлж, чөтгөрийн биелэл болсон этгээдийн тусын тулд ажиллаж байвал таарна даа! Хүн төрөлхтний дайсан чинь шулмын гэгээг анагаах аргыг бүх нийтэд хэрэглэн нэвтрүүлэхийн тулд өөрсдөө өвчин тусагадаг юм гэж чамд хэлээд байна шүү. Чиний ярьж байгаа тэр эмнээс одоо үлдсэн үү? гэхэд тариачин эр чичирхийлсэн гараар өврөө уудлан таган дээр нь еврей хэлээр хэдэн үг бичсэн жижигхэн хайрцаг гаргаж ирэв. Энэ нь тэнд байсан хүмүүсийн ихэнхэд уул эмийг шулам өөрөө найруулжээ гэдгийн илт баталгаа мэт санагдана. Бомануар загалмайлан залбираад хайрцгийг авч дорно дахины хэл сайн мэдэх тул "Иудын удам угсааны арслан ялав" гэж түгдрэлгүй уншив.

- Шулмын хүч гайхалтай их юм! гэж тэргүүн хамба дуугараад, - Ногоог бидэнд чухаг хэрэгтэй хоол ундны холин судрын ариун сургаалыг бурхан шашныг дайрах зэвсэг болгож чадсан байна шүү. Энэ шидэт тос чухам юугаар хийгдсэнийг бидэнд хэлж өгч чадах эмч хүн энд байна уу? гэж асуув.

Өөрсдийгөө эмч гэж өргөмжилдөг хоёр хүн, нэг нь гэлэн, нөгөө нь үсчин урагш гарч тосыг үзээд, христос шашны хэрэглэхийг зөвшөөрсөн бүх эмүүдийг сайн мэдэхгүй байна, иймд нууц муу увдсын хороор хийсэн болов уу гэж тааж байна гэж тэд хэллээ. Энэхүү эмч нарын магадалгааг дуусмагц өвчнийг нь өдий сайн анагааж өгсөн тосыг эргүүлж өгнө үү гэж саксон тариачин гуйсанд тэргүүн хамба хөмсөг зангипдан,

- Чиний нэр хэн билээ? гэж асуув.

- Сиеллийн хүү Хигг гэж тариачин хариулав.

- За тэгвэл Сиеллийн хүү Хигг чи дуулж бай. Бузар буруу номтнуудаас анагаах эм авч эдгэрсэнд орвол тахир дутуу байсан нь дээр. Еврейгээс бэлэг авах юм уу хөлсөөр ажил хийж өгсөнд орвол гартаа зэвсэг барин эд баялгийг нь булааж авсан нь дээр юм шүү. Яв, миний айлдсанчлан хийтүгэй гэж Бомануар хэллээ.

- Оо-хо өршөөлт багштан таны тааллаар болтугай! Таны сургаалыг дагана гэдэг миний хувьд хожигджээ. Би чинь эрэмдэг хүн шүү дээ, харин надад хоёр дүү бий, тэд еврей нарын удирдагч баян еврей Натан Бен Израилийд ажил хийдэг билээ. Тэгээд еврейгийн ажил хийсэнд орохноо дээрэмдэж орхисон нь дээр гэдэг багштан таны үгийг би тэнэд дамжуульа гэж тариачин хэллээ.

- Тэр шаар юун дэмий юм чалчаад байна? Хөөж гарга! Гэж өөрийн сургаалаасаа хийсэн ажил хэргийн чанартай дүгнэлтийг хэрхэн няцаахаа мэдэхгүй зандрав. Сиеллийн хүү Хигг олны дотор хутгалдсан авч гарч явсангүй ачтан бүсгүйнхээ хувь заяа хэрхэн шийдэгдэхийг хүлээв. Сэтгэлийнхээ гүнээс хилмэгдэн буй ширүүн шүүгчийн баргар харцтай дахин тулгарах аюул байсан хэдий авч хүүхний хэрэг хэрхэн шувтрахыг сонсохоор үлдлээ. Тэгтэл Ревеккаг гивлүүрээ авч гэж тэргүүн хамба тушаав. Хүүхэн анх удаа ам нээж өөрийн нь омгийн бүсгүйчүүл "Хүний" хүмүүсийн дэргэд нүүрээ ил гаргах заншилгүйг хүлцэнгүй төв дуугаар өчив. Бүсгүйн урсгал зөөлөн дуу, даруу хариулт хуралдсан хүмүүст өрөвдөх сэтгэл төрүүллээ. Гэвч өөрийн үүрэг гэж үздэг зүйлээ гүйцэтгэх хэрэг болоход алив сэтгэлийн хөдөлгөөнөө дарахыг онцгой гавьяа гэж үдэг Бомануар тушаалаа давглаа. Хуягууд хүүхний толгой дээрээс гивлүүрийг хуу татан авахыг завдан ухасхийтэл Ревекка өөрөө босоод,

- Байз, та нарын охин хүүхэддээ хайртайг чинь барьж андгайлан гуйя. Золиг гэж, та нарт охин хүүхэд байж таарахгүйг би мартаж орхиж! Адаглаад гаргасан эхчүүдээ бодож, эх дүү нартаа хайртай сайн байдгаа санаж ёс зүйг сахихын тулд өөрийнхөө дэргэд, та надыг ийнхүү муучлахад бүү хүрэг! Яах вэ би таны үгийг дагая гэж гүнээ гашуудан дагасан байртай дуугарсанд Бомануарын өөрийн нь зүрх хүртэл чичрэв. Та өөрийнхөн дотроо ахмад дээд хүн, таны тушаалаар золгүй бүсгүйн нүүрийг би өөрөө үзүүлье гэж Ревекка хэллээ.

Ревекка гивлүүрээ авч ичингүйрсэн боловч нүүр бардам байртай тэдний өөдөөс харлаа. Бүсгүйн гайхам гоо үзэсгэлэн бүхэнд гайхагдаж, баатруудын арай залуу нэгүүд нь дуугүй өөд өөдөөсөө харлаа. Буагильберийн ухаангүй дурласны учрыг бүсгүйн хуурмаг муу увьдастнаас илүү, энэхүү ер бусын гоо үзэсгэлэн нь сайнаар тайлбарлаж байгаа юм биш үү? гэж эдний харц хэлэх мэт. Хүүхний нүүр царайны байдал Сиеллийн хүү Хиггэд онцгой сэтгэгдэл төрүүлжээ.

Хигг, орох хаалгыг манаж байсан хуягт – Намайг гарга, гаргаад аль гэж хашгираад, - Эндээс явахыг зөвшөөрч үз, тэгэхгүй бол энэ бүсгүйн эсрэг мэдүүлэг өгсөндөө гэмшиж би үхэх нь байна гэв. Түүний дуу алдахыг Ревекка сонсоод,

- Больж үз, хөөрхий минь, тайвшир гэж өгүүлээд, - Үнэнийг хэлснээр чи надад хор хүргэхгүй,

мөн нулимс, өрөвдөлтөөр надад тусалж чадахгүй. Боль үз, гуйя. Гэртээ харьж биеэ арчил гэв.

Хуягууд Хиггийг өрөвдөж, ийнхүү чанга үгэлснээр дээдсийн уурыг хүргэх бий гэж эмээн танхимаас гаргахаар шийдэв. Гэвч өөрөө дуугүй байх ам өгсөн тул үлдээв. Юу гэж гэрчилбэл зохихыг Альберт Мальвуазен урьдаас зааж сургасан хөлсний хоёр хүнийг дуудав. Тэд хоёул хүнч сэтгэлгүй адгийн амьтад байсан авч олзлогдсон бүсгүйн гойд үзэсгэлэн тэднийг хүртэл алмайруулжээ. Эхний үед хоёул жаахан балмагдсан бололтой. Гэвч Мальвуазен тэдэн рүү тун ч нухацтайгаар харсанд даруй сэхээ авч дахин итгэл төгс яриатай боллоо. Хэт өрөөсгөл биш шүүгчид бол хартай санагдаж болохуйц нарийн тодорхойгоор хэд хэдэн гэрч мэдүүлэг өгөв. Тэрхүү мэдүүлгийн зарим нь оргүй зохиомол бусад нь зүй ёсны, ердийн явдлуудын тухай байв. Гэвч тэр бүгдийн тухай маш нууцархаг байраар, машид нарийвчлан ярих тул хамгийн гэм хоргүй явдал хүртэл ёозгүй зэвүүн учиртай санагдах ажээ. Манай үед бол тиймэрхүү гэрчийн мэдүүлгийг байж таарахгүй, болшгүй гэж хоёр ангилахсан бүлгээ. Гэвч тэр бүдүүлэг, мухар сүсэгтэй цагт бүх л гэрчийн мэдүүлэг гэм буруугийн баталгаа гэж үзэгдэж байжээ.

Жишээ нь: Ревекка заримдаа үл мэдэгдэх хэлээр аман дотроо нэг юм шивэгнэдэг, улсын зүрхийг догдолтол уярам сайхан дуулж эхэлдэг, үе үе ганцаараа ярьж хариу сонсохыг эрэлхийлэх байртай дээшээ хардаг, заримдаа хувцас нь ердийн шударга бүсгүйнхтэй адилгүй гойд учиртай харагддаг, бөгжин дээр нь нууц тэмдэгтэй, уужаа гайхам хачин хээгээр хатгамалсан байдаг гэх зэргийн юм гэрчүүд ярьж байлаа.

Ердийн юмсын тухай энэ бүх яриаг машид хичээнгүйлэн сонсож Ревеккагийн хар зүгийн хүчинтэй холбоотойн шууд баталгаанд тооцсонгүй, гэхдээ лам нотолгоонд оруулав. Хэдий илтэд зохиомол боловч илүү ноцтой мэдүүлгүүд ч байлаа. Гэлээ гэхдээ бүдүүлэг сонсогчид түүнийг бүрэн итгэн байв. Цэргүүдийн нэг нь хамт Торкильстонд ирсэн шархтай хүнийг Ревекка хэрхэн анагаасныг үзсэн гэлээ. Түүний хэлснэр Ревекка шархан дээр нь нэг тэмдэг зуран, тарни (бурхны авралаар түүнийг нь ойлгосонгүй) унштал гэнэт шархнаас сумны төмөр зэв сугаран гарч цус урсгах нь зогсоод шарх эдгэрч үхэж байсан хүн мөчийн дараа өөрөө хэрмэн дээр гарч, гэрчлэгчид өөрт нь дайсан руу чулуу дүүгүүрдэх оньс тавихад тусалж байсан гэнэ. Торкильстонд авч ирсэн шархай Айвенгог Ревекка арчилж байхыг үзсэнээр үүнийг ийнхүү зохиож ярьсан бололтой, эцэст гэрч богцон дотроосоо өөрийн нь үгээр шархан дотроос гайхалтайгаар гарч ирсэн зэвийг гаргаж мэдүүлгээ батлав. Уул зэв бараг хагас жин шахуу хүнд зүйл байсанд мэдүүлэг хэдий хачирхалтай авч үнэн зөвийн эргэлзээгүй баталгаа санагджээ.

Ревеккаг Буагильбертэй ярилцах үедээ цамхгийн тавцангийн ирмэг дээр үсэрч гараад доош харайхаар завдаж байхыг нөгөө гэрч үзсэн байжээ. Нөхрөөсөө дордохгүйн тулд энэ этгээд мэдүүлэхдээ, Ревекка тэр ирмэг дээр зогсоод цасан цагаан хүн болж, Торкильстон цайзыг гурав эргэн ниссэнээ дахин цамхаган дээр бууж бүсгүй хүний дүртэй болсон гэв.

Ядуу, царай дорой эмгэний муу увьдастайг нь илчлэхийн тулд эдгээр бүх мэдүүлгийн тал хувь нь боловч хүрэлцээтэй бүлгээ. Ревеккагийн, залуу гайхам, гоо үзэсгэлэн хүртэл өөрөө угийн еврей хүн болж төрснөөр улам хүндэрсэн эдгээр гэрчилгээний хүндийг дийлж эс чадав.

Тэргүүн хамба зөвлөгч нарынхаа саналыг хураагаад одоо оногдуулахаар завдан буй цаазлах ялын эсрэг хэлэх юм байна уу? гэж Ревеккагаас ёсорхуугаар асуулаа.

Сайхан еврей бүсгүй сэтгэл догдолсондоо чичирхийлсэн дуугаар, - Та бүхний өрөвч сэтгэлийг хөдөлгөх гэж дэмий, гутамшигтай зүйл болохыг харж байна. Өвчтөн шархтан хүмүүсийг эмчлэх гэдэг бид бүхний сүсэглэгч бурханд эс тааладаж таарахгүйг тайлбарлаад дэмий. Миний эсрэг энд өгсөн мэдүүлгийн олонхи нь илтэд худал гэдгийг нотлоод ашиг алга, энэ хүмүүсийн хэлсэн бүхэнд та нар янз нь итгэж байгаа бололтой. Мөн миний хувцас, миний хэл, миний зан заншил та нарт бол гаж буруу атал миний ард түмний төрөлх чанар гэдгээр зөвийг олох гэж оролдоод хэрэг алга. Би золтой л манай эх орон гээд хэлчихсэнгүй, харамсалтай нь бид эх оронгүй билээ. Тэр байтугай би өөрийгөө зөвтгөхийн тулд энд зогсож намайг хэрхэн худлаар гүтгэн ял тулгаж, хүчирхэн дарангуйлагч өөрийг нь эрхшээлд автсан хүн болгож ярихыг чагнан буй хавчин дарлагчаа л илчлэн мэдүүлэхгүй. Бид хоёрыг тэнгэр шүүх болтугай, гэхдээ олзлогдсон өмөг түшиг, арга чадалтай болсон бүсгүй миний биенд энэ амилсан шулмын шахаж тулгаад байсан зүйлийг дуулж байсанд орвол ямар ч цээрлэлийг үзэж өнгөрөөх нь надад хөнгөн билээ. Энэ хүн та нартай нэгэн шүтлэгтэй, тэгэхлээр үүнийг үг бүр золгүй еврей бүсгүйн андгай тангарагнаас та бүхэнд илүү үнэтэй ажээ. Тийм болохоор надад тулгасан ялыг үүнд оногдуулах гэж оролдоод тус гарахгүй. Гэхдээ би түүнээс, Бриан де Буагильберээс энэ бүх тулган буй зүйлүүд худлаа биш гэж үү? Эд цөм хөнөөх чадалтай юм шиг оргүй дэмий, санаанд багтахгүй булай гүтгэлэг биш үү? гэдгийг асууя гэлээ.

Цөм таг дуугүй боллоо. Хүн бүхний харц Бриан де Буагильбер рүү хандлаа. Тэр эс дуу гарах ажээ.

- Чи эр хүн юм бол чи үнэхээр христос шашинтан хүн юм бол хэл дээ? Дуугараач! Чиний өмсөж яваа хувраг хувцас, өвөг дээдсээс чинь уламжлан ирсэн нэр, чиний бардаж гайхуулдаг эр баатар хүний ёсыг барьж гуйя. Эхийн нэр төр, эцгийн чинь шарил, ясыг барьж гуйя! Энд яригдсан зүйлүүд үнэн үү үгүй юү? хэлж халь, гуйя чамаас гэвэл тэргүүн хамба,

- Чиний тэмцэлдэн буй хүн төрөлхтний дайсан чамайг бүрэн дийлж орхиогүй бол нэгэн санваартан минь бүсгүйд хариу хэл гэв.

Буагильбер эсрэг тэсрэг шуналуудад авган царай нь хувирч татвалзана. Эцэстээ ихэд хүчлэн байж Ревеккад хандан:

- Бичиг, бичиг... гэж дуугарав.

- Бомануар үүнд, - Уухай, маргашгүй гэрчилгээ гэдэг чинь ёстой энэ дээ. Хөөрхий хүн муу увьдаст авгаж гүйцсэн, зөвхөн л нэг гайтай бичиг, бодвол үүнийг үг дуугарахгүй бичиг бүхий сахиусны тухай дурдахаас цаашгүй болжээ гэж хэлэв.

Харин Ревекка энэ үгийг өөрөөр ухаарав. Гартаа барьсаар байсан сайрны тасархай руу хялам хийж хараад, - "Өмгөөлөн тулалдах хүн гаргахыг гуйя" гэсэн байхыг уншив.

Буагильберийн хачин хариултын дараа танхимд тэр чигээрээ дүнгэнэн шуугилдсан нь Ревеккад тэрхүү цаасны тасархайг унших төдийгүй устгах зав өглөө. Шивэр авир яриа намдахад тэргүүн хамба өндөр дуугаар,

- Янз нь шулмын эрхшээлд байсаар байгаа бололтой, энэ золгүй баатрын мэдүүлэг Ревекка

чамд ямар ч ашиг болсонгүй. За өөр хэлэх юм байна уу, чамд гэвэл Ревекка хариуд нь, - Танай харгис хатуу хуулийн дагуу амь аврагдах ганц зам л надад үлджээ. Чухамдаа амьдрал надад маш хатуу хэрцгий, ялангуяа сүүлийн үед гойд хүнд байсан авч, бурхан нэгэнт аврагдаж мэдэх өчүүхэн найдлага өршөөж байгаа хойно бурхны хишгээс би татгалзаж болохгүй. Танай тулгасан бүх ялыг би үл хүлээн өөрийгөө гэм буруугүй, танайхны мэдүүлгийг худал хуурмаг гэж хэлж байна. Бурхны шүүлт тогтоохыг шаардаж байна. Миний өмгөөлөгч ял тулгагч этгээдтэй тулалдаж миний үнэн зөвийг ялалтаараа нотлож үзүүлэг гэж хэлэв.

- Еврей, тэгэд бас муу увьдаст бүсгүйн өмгөөлөгч болохыг хэн зөвшөөрөх юм бэ, Ревекка? гэж тэргүүн хамбыг асуухад Ревекка хариуд нь,

- Бурхан надад өмгөөлөгч өгнө. Найрсаг зочломтгой, өгөөмөр сэтгэл, эрх чөлөөний орон болсон бүх алдарт Англи нутагт нэр төрийн тлөө хэрэгт амь дүйхэд ямагт бэлхэн хүмүүс олонтой энэ газарт шударга үнэний төлөө тулалдахыг хүсэх хүн гарахгүй байж таарахгүй. Эрүүл тулалдаан хийхээр тогтоохыг би шаардаж байна гэлээ.

Ревекка хатгамалтай бээлийгээ гараасаа авч маш төв, угийн намбатай байдлаар тэргүүн хамбын хөл дор хаясанд нийт олноор гайхан бахдав.

ГУЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

"Эрүүл тулалдаанд чамайг би дуудлаа

Эгц халз хоёул тулан үзэлцэж

Эр зориг цэргийн эрдмээ үзүүлнэ"

Шекспир "II Ричард хаан"

Ревеккагийн гоо үзэсгэлэн, царайны байр Лук Бомануарт өөрт нь хүртэл гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. Тэр төрөлхийн харгис, тэр ч байтугай ширүүн хүн биш байв. Гагцхүү, үүрэг гэдгийн тухайд ташаа боловч хөөрүү дээгүүр ойлголттой, цэх шударга хүн бөгөөд санваарыг хатуу сахин амьдарсан хүчирхэг эрх мэдэл эзэмшиж ирсэн, мөн буруу номтон буруу шашинтныг устгах үүрэг өөрт нь тохогдсон гэдэгт бат үнэмшсэний уршгаар сэтгэл зүрх нь алгуураар хатуу цэвдэг болжээ. Хэдий орь ганцаардмал, өмөг түшиггүй авч гайхам чийрэг, эр зоригтойгоор биеэ өмгөөлөн, өмнө нь зогсож буй үзэсгэлэн төгс залуу бүсгүйг хараад хамбын нүүр царайны ширүүн дүр зөөлрөх мэт болж ирэв. Ямагт нугаршгүй хатан болд байдаг сэтгэл нь хэрхэн ингэж ер бусаар зөөлөрсөнд эргэлзэх аятай хоёр дахиж загалмайлан залбирав. Эцэст ам нээж,

- Залуу бүсгүй ээ, миний чамайг өрөвдөж байгаа сэтгэл миний муу овоор надад нөлөөлсөн хорлолын үр мөн ахуул бурхны өмнө чиний нүгэл маш зузаан ажээ. Гэхдээ миний энэ сэтгэл, өдий гоо сайхан биенд ийм хөнөөл хор агуулагдаж байгаад дургүйцсэн зүй ёсны эмгэнэл мөн байж таарах вий. За охин минь гэмшиж үз, муу увьдастайгаа хүлээж, буруу шашин шүтлэгээ орхин, авралын энэ ариун тэмдгийг үнс, чиний энэ амьд яваа эцэг хойтын чинь үйл цөм сайн болно. Чамд сахилт бүсгүйчүүлийн нэгэнхийдэд шавилан сууж, гэм нүглээ наминчлан цагаатгаж, зохих ёсоор гэмших цаг тэнд олдоно. Үүнийг хий, тэгээд амьд яв. Монсеевийн шүтлэг юугаараа чамд тэгж амь насаа өгөхөөс буцахааргүй их үнтэй чухаг юм бэ? гэж хэллээ.

Ревекка хариуд нь,

- Энэ бол миний эцэг дээдсийн шүтлэг. Энэ нь гал дөлөн үүлэн дотроос, тэнгэр дуугарч цахилгаан цахиулан Синайск уулын оргил дээр хорвоод бууж ирсэн билээ. Та бүхэн үнэхээр христос шашинтан мөн ахуул өөрсдөө мөн үүнд итгэж байгаа. Гэвч та бүхнийхээр бол тэр шүтлэг шинээр солигдон, харин миний багш нар надад тэгж заагаагүй билээ гэв.

- Миний номч багш урагшаа гарч энэ зөрүүд бузар шүтлэгт хүүхэнд юуг... үнэмшүүлж өгөг гэж Бомануар хэлтэл, Ревекка хүлцэнгүй дуугаар,

- Таны үгийг тасалсан болж гэм өршөөгөөрэй. Гэвч би бүсгүй хүн, шашин шүтлэгийн тухай маргаан хийж чаддаггүй. Харин бурхны тааллаар би өөрийнхөө шүүлт тогтоож өгөх талаар миний гуйсанд хариу айлдаж өгөхийг гуйя гэв.

- Хүүхний бээлийг надад аваад аль. Өдий чухаг хэргийн барьцаа гэхэд тун ч өчүүхэн бага зүйл санж гэж Бомануар нарийхан бээлийн торгон эдийг ажин байж өгүүлээд, - Бидний хүнд

болд бээлийн дэргэд чинийх хичнээн их нарийн хэврэг байгааг Ревекка чи харж байгаа биз? Чиний хэрэг чинь Сионск хийдийн үйл хэрэгтэй харьцуулан үзвэл мөн ийм л зүйл. Юу гэвэл чи бүхэл хийдийг эрүүл тулалдаанд дуудлаа гэвэл Ревекка өөдөөс нь,

- Мөн тэр жингийн тавган дээрээ миний гэмгүй цагааныг нэмэрлэж орхи, тэгвэл торгон бээлий төмрөөсөө хүнд болно гэв.

- Ингэхлээр чи гэмээ хүлээхээс татгалзаж зоригт дуудлага дахин хийж байгаа юм биз дээ? гэж асуухад,

- Дахин хийж байнаа, өндөр төрөлт эрхэм ээ гэж Ревекка хариуллаа.

- За тэгвэл бурхны таалаар тийм болтугай, бурхан багш үнэнийг ялгаж өгөх болтугай гэж тэргүүн хамба айлдвал бүх хүрээ даамлууд, тэдний дагаж хурсан олон цөмөөр,

- Болтугай гэж давган дуугарав.

- Санваартан ах дүү нараа, бурхны шүүлтээр явуулахыг энэ бүсгүйд татгалзах бүрэн эрх бидэнд байсныг та бүхэн мэднэ. Энэ хэдийгээр загалмай зүүгээгүй еврей хүн авч өмгөөлөх хүнгүй ганцаараа амьтан юм. Энэ бүсгүй манай нигүүлсэнгүй хуулийн ивээлийг эрэлхийлсэн тул бид татгалзаж чадсангүй. Түүнээс гадна бид зөвхөн хувраг хүмүсээр зогсохгүй эр баатрууд, дайчид болохоор тулалдаахаас зайлсхийх гэдэг шившигтэй зүйл. Иймд уул хэргийн байдал гэвэл, Йоркийн Исаакийн охин Ревекка хэргийн олон тооны ноцтой баримтаар манай хийдийн сайн төрөлт баатруудын нэгийг муу увдсаар татсан гэдэг ял тулгагдаж, өөрийгөө зөвтгөхийн тулд бурхны шүүх болох эрүүл тулалдаанд биднийг дуудлаа. Тэгэхлээр хувраг ах дүү нар минь энэ болох гэж буй тулалдаанд манай талыг хамгаалах хүн болгож хэнд энэхүү дэнчин болсон бээлийг гардуулбал зүгээр гэж санана? гэж тэргүүн хамба асуувал хүрээ даамал Гудольрик өгүүлрүүн,

- Бриан де Буагильберт гардуулъя, тэгээд ч хэний талд үнэн мөн байгааг бүхнээс илүү тэр мэдэж байгаа юм чинь гэлээ. Тэргүүн хамба үүгд, - Ганцхан манай нэгэн санваартан Бриан увьдас, сахиусны хүчинд автсан хэвээр байгаа бол яах вэ? Гэхдээ харин энэ үгийг бид зөвхөн хянуур болгоомжийн үүднээс л хэлж байгаа билээ. Юу гэвэл энэ болоод өөр ямар ч чухаг хэргийг бид манай хийдийн хэний хэнээс нь ч илүү дуртайгар түүний хүчит гарт найдан даалгахсан билээ гэв.

Хүрээ даамал Гудольрик хариуд нь, - Эрхэм дэд багштан, бурхны шүүх дээр үнэн хэргийн төлөө эрүүл тулалдаанд орж байгаа баатрыг ямар ч сахиус дийлэх учиргүй гэвэл тэргүүн хамба зөвшөөрч,

- Нэгэн санваартан чи зөвөөр шийдлээ. Альберт Мальвуазен та энэ дэнчиг Бриан де Буагильберт гардуул. Санваартан Бриан чамайг эрүүл тулалданд зоригтой эр гэж үнэн зөв нь ялахад үл эргэлзэх энэхүү хэргийг даалгаж өглөө. Ревекка чамд өмгөөлөн тулалдах хүнээ олоход чинь хоёр өдөр гаргаж өгье гэв.

- Та надад тун амархан хугацаа өгч байна даа. Би, та бүхэнтэй шашин шүтлэг, өөр харь орны

хүн. Миний төлөө, бас тэгээд алдарт дайчин гэж нэрд гарсан баатрын эсрэг амь нас, нэр төрөө гаргуунд гарган тулалдах хүн олоход бэрх байх вий гэж Ревеккаг хэлэхэд,

- Бид илүү удаанаар хойшлуулж чадахгүй. Тулалдаан биднийг байхад болох учиртай гэтэл чухал хэргийн учир бид эндээс гурав хоногоос хэтрэлгүй мордоход хүрч байна гэв.

- За бурхан тааллаар болтугай. Бүх горьдлогыг бурханд залбиран даатгая, бүхэл бүтэн зуун, нэг хурам, хоёр бурханд бол ижил бүлгээ гэж Ревекка дуугарав.

Тэргүүн хамба: Бүсгүй чи зөв хэллээ. Гэвч хэн ингэж дагинын дүр үзүүлж чаддагийг бид сайн мэднэ. Тэгэхлээр туталдахад тохиромжтой газар, мөн хрэг болбол цаазлах газар сонгож авах л үлдээд байх шив. Энэ хийдийн хамба хаана байна? гэлээ. .

Альберт Мальвуаен гартаа Ревеккагийн бээлийг барьсан хэвээр Буагильберийн дэргэд зогсон нэг юм хүчлэн ятгаж байлаа.

- Юу болоод байна, наадах чинь дэнчинг гардаж авах дургүй байна уу? гэж хамбыг асуухад,

- Үгүй их багштан, энэ дуртай байна, дэнчинг гардаж авлаа гэж Мальвуазен хариулаад бээлийг өөрийнхөө жанчин доогуур овжин шургуулаад,

--Тулалдах газрын тухайд гэвэл манайд хийдийн ойролцоох Георги гэгээний талбар нэ зорилгот бүхнээс илүү тохиромжтой болов уу гэв.

- За сайн, Ревекка чи тэр талбар дээр өөрийнхөө өмгөөлөгчийг гаргах хэрэгтэй. Чи үүнийг гүйцэтгэхгүй буюу чиний өмгөөлөгч бурхны шүүлтэн дээр ялагдах ахуул чи гаргасан тогтоол ёсоор муу увьдастан гэж цаазлагдах болно. Манай шүүх, түүний шийдвэрийг бичиж, уул бичгийг нийтэд дудаж өгтүгэй. Уул тогтоолыг мэдээгүйгэр хэн ч бүү шалтаг зааг гэв.

Бичээчийн үүрэг гүйцэтгэж байсан хоёр гэлэнгийн нэг нь хийдийн баатрууд иймэрхүү зорилгоор цугларсан тухайд бүх үйл явдлыг тэмдэглэдэг тал дэвтэрт хуралдааны тогтоолыг бичиж дууссаны хамт нөгөө гэлэн нь тэргүүн хамбын оноосон ялын тогтоолыг уншиж сонсгов.

- Йоркийн Исаакийн охин Ревекка нь Сионы хийлийн ариун хорооны баатруудын нэгийг муу увьдсаар хорлон биедээ татсан болоод бусад хөнөөлт үйл үйлдсэн нь илчлэгдсэн боловч өөрийн гэм бурууг эс хүлээв. Энэ өдөр өөрийн нь эсрэг өгсөн гэрчийн мэдүүлгүүдийг худал, өш хорслын үүднээс гүжирдсэн зүйл гэв. Өөрийн бие эрүүл тулалдааны хэрэгт арга буюу үл тэнцэхийн учир, бурхны шүүлтээр хэргийг ялгахын тулд өөрийн өмгөөлөгчийг гаргах, өөрийн нь өмгөөлөгч жинхэнэ эр баатруудын ёс гуримын дагуу тулалдааны дэнчин тавьж, бүх гарлага, зарлагыг өөрөө хариуцан авлаа. Уул дэнчиг хийдийн ариун хорооны өндөр язгуурт тайж Бриан де Буагильберт гардуулсан бөгөөд энэ баатар хийдийнхээ нэрийн өмнөөс, мөн хэрэгтэн бүсгүйн хорлол, хараалаас болж өөрөө хохирсны учир амь биеэ хамгаалан дээр дурдсан тулалдаанд оролцох учиртай блгэ. Үүний учир өндөр дэд багштан лам, хүчирхэг ноён бээс Лук Бомануар уул хүсэлтийг ёсоор болгон хайрлаж, бүсгүйг орондоо биеэ бүрэн төлөөлөх өмгөөлөгч гаргахыг зөвшөөрөн өнөөдрөөс аван гурав дахь өдөр уул тулалдааныг

хийхэр тогтоож, тулалдах газарт Темплстоу хийдийн ойролцоох Георги гэгээний талбарыг сонгож авлаа. Үүнээс гадна уул хэрэгтнийг эрүүл тулалдаанд өмгөөлөгчөө төлөөлүүлэн гаргахыг тэргүүн хамба тушааж, эс гүйцэтгэвэл муу увьдас гаргасан, хараал үйлдсэн тухайд хууль ёсоор цаазлагдах болов. Мөн хийдийн өмгөөлөгчийг тогтсон хугацаанд тулалдааны талбар дээр ирэхийг тушааж эс гүйцэтгэвэл адгийн муу урван тэрслэгч болгоно. Үүний хамт мөнхүү сайн төрөлт ноён өндөр дээд багш ламтан уул тулалдаан дээр биечлэн заларч, уг явдалд нийцэх бүх гурим занглыг дагуулан мөрдүүлнэ гэж айлдав. Бурхан багш үнэн зөв хэргийг ивээх болтугай гэв. Тэргүүн хамба, --Болтугай! гэхэд байлцсан бүх хүмүүс дагаж дуугарав.

Ревекка юу ч хэлсэнгүй, залбиран тэнгэр өөд харлаа. Тэгээд хань нөхөддөө хэл өгч ямар байдалд ороод байгаагаа дуулган өөрийн нь өмнөөс тулалдах хүн ол гэж гуйх боломж өгвөл зохиыг их хамбад хүлцэнүйгээр өчив.

--Энэ зүй ёсны шударга хэрэгт итгэн явуулж болох хүн өөрөө сонгож ав, чиний байгаа тасалгаанд тэр хүнийг бид чөлөөтэй оруулна гэж тэргүүн хамба хэллээ.

- За шударга хэрэгт дуртайн үүднээс юм уу өгөөмөр их шан авахын тулд золгүй бүсгүйн үйлийг бүтээгээд өгөх хүн та нарын дотор байна уу? гэж Ревекка хэллээ.

Хүмүүс цөм дуугарсангүй. Еврей нарт талтай гэж сэжиглэгдэхээс эмээн гүтгэгдсэн хоригдол бүсгүйд тал өгөхийг хамбын дэргэд хэн ч зүрхэлсэнгүй. Ийнхүү айх нь тун хүчтэй тул амалсан шанг авах шуналыг хүртэл захирах ажээ. Харин өрөвч нигүүлсэнгүйнтухай ярих ч юм байсангүй. Хэдэн хурам хиртэй Ревекка өгүүлэхүйеэ бэрхээр сэтгэл түгшин хариу хүлээснээ эцэст нь:

- Англи шиг ийм оронд адгийн муу гэмт хэрэгтэнд үзүүлэхээс эс татгалздаг тусыг хэн ч надад хүргэхийг хүсэхгүйгээс болж амь биеэ аврах эцсийн ядарсан аргыг хүртэл би хэрэглэж чадахгүй гэж үү дээ? гэж дуу алдав.

Тэгж байтал Снелийн хүү Хигг дуугарч

- Би хэдийгээр тахир дутуу боловч энэ бүсгүйн өршөөлт тусламжийн ачаар ядан чадан хөдлөхтэй болсон билээ. Би чиний хэргийг бүтээе гэж Ревекка руу харж өгүүлээд, - Өөрийн өчүүхэн чадлын хирээр түргэлэхийг хичээе. Миний хэл чамд хор хүргэснийг цагаатгаж чадахаар хурдан хөлтэй ч байсан бол хичнээн их баярлахсан билээ. Чиний нигүүлсэнгүйн ачийн тухай би ярихдаа тэр чамд улам хор болно гэж даанч бодсонгүй дээ гэж хэллээ

- Зүгээр хамаг үйл бурхны таалалд бий. Түүний зурсан зургийг ёсоор болгоход дун хорхой хүртэл начин шонхроос доргүй хэрэг болно. Йоркийн Исаакийг эрж ол. Май морь худалдаж авах мөнгө ав. Хүн илгээхэд энэ элбэг хүрэлцээтэй. Миний захидлыг түүнд хүргэж өг. Энэ үхлээр үхэхгүй, надад өмгөөлөгч олдоно гэж би бат итгэж байна, тэнгэр өөрөө ийм сэтгэл надад төрүүлж байгаа юм уу бүү мэд. Сайн яваарай, чиний хурдан шалмагаас үхэх амьдрах хоёр минь шалтгаалах боллоо гэж Ревекка өгүүлэв.

Тариачин эр еврей хэлээр хэдхэн үг бичсэн захидлыг бүсгүйгээс авлаа. Бузар зурвасанд бүү

гар хүр гэж цугларсан хүмүүсийн олонхи нь түүнийг ятгалаа. Гэвч ачит бүсгүйдээ тус болохоор Хигг хатуу шийджээ. Түүний хэлснээр Ревекка түүний биеийг аварсан, одоо сүнсийг нь хөнөөх гэж хэрхэвч хүсэхгүй ажээ.

- Би манай хөрш Батаныхаас сайн морь олж аваад Йорк руу давхина гэв.

Гэтэл аз дайрч, хийдийн хаалганаас дөрвөн мод хиртэй явж байтал хоёр морьтой хүн дайралдсаныг хувцас хунар гозгор шар малгайгаар нь еврей хүмүс гэж даруй танив. Зэрэгцэж иртэл тэдний нэг өөрийн нь хуучин эзэн Йоркийн Исаак, нөгөө нь еврей нарын эзэн Бен-Израиль байлаа. Хүрээнд сүмийн хорооныхны ихчүүл тэргүүн хамбын удирдлагын дор хуралдаж муу увьдаст бүгүйг шүүж байгааг тэд дуулжээ. Иймд тэд хүрээ рүү мордсон боловч жаал дөлсхийж байжээ.

- Бен Израиль минь юунаас болсон юм бүү мэд миэий сэтгэл түгшиж байна. Манай овгийн хүмүүст муу увьдас гаргасан ял тулгах нь олонтой, тийм гүтгэлгээр еврейчүүдийг хөнөөх хорт үйлээ халхалдаг бүлгээ гэж Исаакийг өгүүлэхэд эзэн хариуд нь:

- Анд миь чи тайвшир, чи баян болохоор буруу номтонтой хэзээ я ая зүйгэ ололцох боломжтой. Тэгэхлээр дуртай цагтаа алив хөнгөвчлөлтийг худалдан авч чадна. Урьд цагт Соломоны тамга хар зүгийн хүчийг дарах их чадалтай байсны адил эдгээр буруу номтны бүдүүн бараг оюун ухааныг мөнгө захирдаг юм... Үгүй энэ юун таяг тулсан хөрхий ядуу хүн бидний өмнөөс ирж явна вэ? Тэр лав надаас зөвлөлгөө асуух гэж яваа байхаа гээд Снеллийн хүү Хигг руу хандан, - Найз минь чамайг эмнэж тус болохоос татгалзахгүй, харин их зам дээр гуйлга хийдэг гуйлгачинд би хэзээ ч юм өгдөггүй, тэгэхлээр замаараа од. Энэ чинь юу вэ? Зарим мөч чинь мэдээгүй болсон юм уу? Гэхдээ чи гараараа хоолоо олж идэж чадахгүй. Үнэндээ ч чи зарлага хийж чадашгүй, сайн малчин байшгүй, цэрэгт чамайг авахгүй, гэвч тохирохоор тийм ажлууд байдаг л юм гэснэ яриагаа таслан Хиггийн өгсөн захидлыг гуйлгэж хармагц хүндээр ёолоод муужран луусан дээрээсаа хөсөр хөлбөрөн унасан Исаак руу эргэн, - Анд минь юу болов оо! гэж дуу алдав.

Эзэн машид сандран буун харайж нөхрийгөө ухаан оруулах гэж бүх аргуудыг хэрэглэв. Тэр ч байтугай хармаанаасаа хануурын хутга гаргаж иртэл хичээнгүйлэн аргалсан хүн нь сэхэж малгайгаа хуу татаж хаяад замын шорооноос атгаж толгой дээрээ асгав.

--Гуниг гаслан болгосон үр минь? Чи үхэж, миний буурал үсийг авсанд оруулан, сэтгэл зүрх цөхрөн харалсны учир би бурхан тэнгэрийг харааж зүхсээр амьсгаа хураавал хэн нэг хүнд хэрэг болох юм гэж үү? гэхэд гайхаж хоцорсон эмч үүнд,

Юу болов оо анд минь, юунд ийм үг хэлж байна? Үгүй охин чинь ингэхэд амьд биз дээ? гэж асуулаа.

- Амьд гэхдээ шулмууад олзлогдон байгаа, тэд охиныг минь тамлан цаазлахаар тогтжээ. Бага залуу насыг нь ч, гайхам гоо үзэсгэлэнг нь ч хайрласангүй шүү! Миний буурал толгойд тэр минь ургаж байгаа ногоо, далдуу модны навчин титэм мэт ганц чимэг байсан биш үү... Тэр тэгээд ганцхан шөнийн дотор гандах болж байдаг! Янаг хайраас минь төрсөн үр! хөгшин болсон хойноо тулах үр минь! Рахилаас гарсан Ревекка минь! Эрлэг хар сүүдээ чам дээр

нэгэнт тусгажээ! гэж Исаак дуу тавилаа.

- Үгүй чи захидлаа уншаад орхи, түүнийг аврах арга бид бас олж мэднэ шүү дээ гэж еврейнүүдийн эзэн өгүүлэхэд Исаак өөдөөс нь,

- Чи өөрөө уншиж үз, анд минь. Миний нүд нулимсанд бүрэлзэж гүйцлээ гэв.

Эзэн захидлыг аваад еврей хэлээр дуудсан нь:

- "Адоникамын хүү Исаак буруу номтны нэрлэдгэр Йоркийн Исаак таны амгаланг айлдая. Танд бурхны ивээл хүрч энх амгалан байх болтугай. Он улиран сайхан жаргал эдлэх болтугай. Эцэг минь би өөрөө үл гадарлах муу увьдас гэдгийг гаргаж хараал хийсэн хэргээр цаазлагдах учиртай болов. Эцэг минь, боломж байвал гурав хоногийн дараа Темплстоу хийдийн ойролцоох талбар дээр буруу номтны заншил ёсоор миний төлөө жад сэлмээр тулалдах чадалта хүн ол. Манай өвөг дээдсийн бурхан түүнд дорой буурайг өмгөөлөн гэм нүгэлгүй хүнийг өмгөөлөхөд хүчин сэлбэж өгч болох юм. Тийм хүн олох боломжгүй аваас миний омгийн хүүхнүүд намайг үхсэнд тооцон гашуудаж залбираг, юу гэвэл би анчны суманд өртсөн буга, хадлангийн хадуурт дайралдсан цэцэг шиг эрсдэх болов. Иймд намайг аврахад юу хийж болох, аврах арга зам байна уу, үгүй юу бодоорой. Буруу номтны дотор намайг өмгөөлөхөөр зэвсэг барих нэг дайчин эр бий. Тэр бол Седрикийн хүү, буруу номтны Айвенгл гэж нэрлэдэг Уильфред билээ. Гэхдээ тэр одоогоор хуяг дулга өмсөх тэнхээ суугаагүй байгаа. Гэлээ гэхдээ энэ тухай түүнд дуулгаарай, юу гэвэл тэр өөрийн омгийн хүчирхэг хүвгүүдийн дунд нэр хүндтэй, тэдэндээ хайрлагддаг хүн болохоор надад өмгөөлөх хүн олж өгч чадах билээ. Ревекка үхсэн ч, амьд байсан энэ хойтохдоо уул тулгасан зүйлд гэм нүгэлгүй гэдгийг мөн Седрикийн хүү Уильфредэд дуулгаарай. Бурхны таалал тийм байгаад чи охиноо алдах юм болж гэм харгис хэрцгий, цус урссан энэ оронд эцэг минь бүү үлд, Кордов руу явж, Срацин Боабдилийн сууж буй хаан ширээний өмгөөлөлд амар жимэр суугаа дүү дээрээ очоорой, юу гэвэл Мавар хүмүүс Иаковын үр садад английн буруу номтноос хавьгүй зөөлөн байдаг билээ" гэжээ.

Исаак захидал дуудахыг овоо тайвнаар снссон боловч Бен-Израилийг дуусахын хамт дахин уй гашуундаа автан хувцас хунараа урж толгой дээрээ шороо цацан,

- Охин минь, охин минь махнаас минь тасарсан ма! Яснаас минь тасарсан яс! Гэж орь дуу тавьж гарлаа.

- Уужирч үз, уй гашуугаар юунд ч тус болохгүй. Явж тэр Седрикийн хүү Уильфредийг ол. Өөрийн эр чадлаар чамд тус болдоггүй юмаа гэхэд сайн зөвлөлгөө өгч мэднэ. Учир нь тэр залуу буруу номтны арслан зүрхт гэж нэрлэдэг Ричардад тун шадар хүн, тэгэхэд хааныг эргэж ирсэн гэдэг цуу улс даяар улам бүр тархсаар байна. Магадгүй тэр залуу хааны мутар, тамга бүхий зарлиг олж өгөөд ариун сүмийн нэрийг хороондоо зээлдэн олгохыг зүрхэлсэн цусанд шунахай хүмүүсийн хорт үйлийг зогсоож магадгүй гэж Бен-Израиль өгүүлэв.

- Би түүнийг эрж олно, заавал олно. Тэр чинь сайн залуу, Иаковын хавчигдан зарлагдсан үр садыг өрөвдөж үздэг үн гэж Исаак хэлээд, - Гэхдээ тэр одоогоор зэвсэг барих чадалгүй, өөр ямар христос шашинтан хүн дарангуйлагдсан еврей бүсгүйн төлөө тулалдахыг хүсэхсэн

билээ! гэвэл Бен-Израиль хариуд нь,

- Үгүй чи чинь христос шашинтангуудыг огт мэдэхгүй юм аятай ярьж байх чинь! Чи алтны үнээр өөрийн биеийг аюул хөнөөлөө хол байлгадагчилан, тэдний эр чадлыг мөн худалдаад авч болно, чамд алт бий. Зоригтой бай, тайвширч Уильфред Айвенгог эрж олохоор морд. Би мөн гар хумхин суухгүй, юу гэвэл чамд ийм их гай учраад байхад нь орхивол амьдын хар нүгэл болно. Одоо олон дайчид, чадалт эрчүүл цуглараад байгаа Йорк хо руу би явъя. Танай охины төлөө тулалдах дуртай хүн олох нь лавтай. Юу гэвэл аль тэдний шүтээн, мөнгөний төлөө тэд хэдий цагт боловч газар эдлэн барьцаанд өгөхийн адил амь насаараа дэнчин тавихад бэлэн байдаг билээ... Анд минь, чиний нэрийн өмнөөс тэдэнд өгөхөд хүрч болох амлалтаас чи буцахгүй биз? гэвэл Исаак хариуд нь:

- Тэгэлгүй яахав анд минь. Миний их гаслангийн цагт сэтгэл тайтгаруулах х үн илгээсэнд бурхан багшдаа гялайлаа. Юу хийвэл зохихыг өөрөө мэдтүгэй. Миний толгой ч бүр эргэж гүйцэж, янаг хайраас минь төрсөн үр үхэх юм бл мий тэр бүх алт юундаа хэрэгтэй юм бэ? гэв.

- За баяртай, чиний бүх санасан хэрэг сэтгэлчлэн бүтэх болтугай гэж Бен-Израиль хэллээ.

Тэр хоёр хагацахын өмнө тэврэлдээд, хоёр тийш салж одов. Эрэмдэг хүн зам дээр үлдэж хэсэг болтол тэдний хойноос харлаа.

- Муусайн ноход!Намайг нэг ядарсан боол, турк юм уу өөрсөдтэй нь адил еврей аятай ч тоож үсэнгүй. Би тэгэхэд бурхны авралаар эрх чөлөөт иргэн уран мужаан хүн билээ. Надад адаглаад нэг мөнгөн зоос хаячихаж болмоор пдоо. Эдний муруй сарий, тэгэхдээ бас сайн хүмүүсийн сэрэмжилж, хэлсэнчлэн өөрт минь гай болж мэдэх бичгийг зөөх албагүй. Улаан өндөгний баяраар очиж наминчлах үед ламтан намайг элдвээр сүрдүүлэн нүглээ цагаатгахын тулд авснаасаа хоёр дахин илүү өргөл өгөхөд хүрвэл жаал хүүхний өгсөн зоос юун их олз болох билээ. Аягүй бол намайг еврейн шуудан гэж хочлоод үхэн үхтэл салахгүй болно. Янз нь тэр хүүхэн намайг үнэхээр муу увьдсадаа оруулсан даг шүү. Үгүй түүнтэй дайралдсан бүхэн еврей, христос шашинтан ялгаагүй тийм л болчихдог, цөм түүний үгэнд ордог билээ. Үгүй тэгээд хөөрхийн тухай бодохын хамт амь насыг нь аврахын тулд мужлагаа, бүх хогшил хөрөнгөө өгөхөд бэлэн байх юм аа гэв.

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

"Царайчилж гуйгаад нугаршгүй охин юм

Чамтай би бардам сэтгэлээрээ тэмцэлднэм"

Сьюард

Ревеккаг шүүсэн (шүүх гэж түүнийг нэрлэж болох аваас) өдрийн орой харанхуй тасалгааны нь үүдийг нэг хүн аяархан тогшлоо. Гэвч хүүхэн оройн мөргөлөө уншиж байсан тул үүнийг огтхон ч хайхарсангүй. Тэгээд залбирлаа магтаал дуулж төгсгөсөн нь:

Гаслагаас зайлж Израиль түмэн

Боолын гинжийг тасладаан

Гайхам сүрт бурхан биднийг

Хөтөллөө гэж итгэж явсаан!

Гамшиг бүрхсэн хорвоо дээгүүр

Дайны утаа үүл шиг суунаглаж

Галын дөл шөнийн турш

Сүртэй нь аргагүй улалздаг байсаан!

Онцын мэргэн бурхан гэгээнээ шүтэж

Эрс эмсийн магтаал дуун ч цууриатсаан

Одоо гэгч түмэн гамшгийн үе эхэлж

Ид шид чинь устан бурхан ч чамайг мартжээ.

Хуурамч аз жаргалын жаран гялбаж

Бидний сэтгэл гэнэт автгаас

Хурам зуур чи, үүл манангаараа

Хааж байгаарай

Түнэр харанхуйд чигээ алдахад минь

Чи биднийг тэсвэрт сургаж

Түргэн зуур гэрэл гэгээгээ

Хайрлаж л байгаара!

Энэхүү магтаалын дуу намдахын хамт үүд дахин болгоомжлон тогших дуулав.

- Чи миний нөхөр бол орогтун, өстөн аваас орохыг чинь хориглох хүч надад үгүй гэж Ревекка хариу дуугарав.

Бриан де Буагильбер орж ирэн, - Би байна. Нөхөр өстөн алин болох нь бидний энэ уулзалт юугаар төгсөхөөс хамаарна гэв.

Энэ хүний даруулгагүй их шунал тачааллыг хамаг гай зовлонгийнхоо гол шалтгаан гэж үздэг болохоор Ревекка сэтгэл түгшиж үл итгэсэн авч төдий л их айж сүрдээгүй байртай гэдрэг ухрах нь түүнээс аль болох хир холхон байх, хэрхэвч бууж өгөхгүйгээр шийдсэнийг гэрчилнэ. Өөдөөс нь эгцлэн харж, цэх зогсохдоо алив өдөж барьсан шинжгүй, уур зэвүүг нь хүргэхгүйг хүсэхгүй байгаа бололтой. Гэхдээ хэрэг болбол биеэ эцсийнхээ боломжийг дуустал хамгаалах санаатай байгаа нь илт байв. Сүмийн хорооны баатар үүнд – Ревекка чамд надаас айх шалтгаан алга, чухам гэвэл чамд надаас айх юм ер үгүй гэв.

- Би айгаагүй байна, эхэм баатар аа! Миний сүсэг бат, би танаас айхгүй байна гэж Ревекка хариулахад дээр гарсан амьсгаа нь уул зоримог үгтэй нийцэхгүй байлаа. Буагильбер үнэнхээр, - Үгүй, юунаас ч чи айх юм билээ? гэж батлан өгүүлээд, - Миний түрүүчийн ухаангүй аашилдаг маань одоо болшгүй болсон. Үүдний цаана миний мэдлийн биш хуягууд зогсож байна. Ревекка чамайг тэд цаазлах газарт аваачна. Тэр болтол харин чамайг хэнд ч дарлуулахгүй, миний түрүүчийн ухаангүй, үнэхээр ухаан алдсан тэнэг дурлал дахин элдвээр аашлахад хүргэлээ гэхэд тэд намайг ч тэгүүлэхгүй гэв.

- Хар хорын энэ оронд үхэл надад хамгийн бага аюул билээ, бурхны аврал гэж еврей бүсгүй дуугарав.

- Нээрээ ч үнэн шүү гэж сүмийн хорооны баатар зөвшөөрөөд, - Үхлийн үүд гэнэт нээгдвэл баг сэтгэлт хүнд түүний тухай болоод айдас хүрэх юм байх учиргүй. Жад юм уу сэлмэнд өртөх надад юу ч биш, өндөр цамхган дээрээс үсрэх юм уу чинжаал хутгаар өөрийгөө хатгах гэдэг чамд янз нь хүнд зүйл биш бололтой. Бид хоёрын тус тусдаа шившиг гэж үздэг зүйлийг бодохноо эд юу ч биш юм байна. Би хоёулангийнхээ тухай ярьж байгааг анхаараарай. Нэр төрийн тухай миний ойлголт чинийхтэй нэгэн адил тэнэг зүйл байж тун магадгүй, гэвч бид хоёр түүний төлөө үхэж чадна гэв.

- Чи бас золгүй хүнээ ? гэж Ревекка дуу алдаад чухам дотроо хүлээн зөвүүрдөггүй, шүтлэгийн тухай амь насаа дүйх тавилантай юм гэж үү чи? Энэ чинь хамаг эд баялгаа хоол болохгүй юмаар солихтой адил гэсэн үг шүү дэ. Харин миний тухай чи тэгж бүү бод. Чиний энэ шийдмэг чинь хүмүүсийн үзэл санааны хувирамтгай долгион дээр ганхаж байхад минийх өнө мөнхийн хадан цохион дээр суурилж байгаа юм шүү гэв.

Больж үз. Ийнхүү номчирхож суух цаг одоо биш. Гуниг гутрал өөрөө шилэн авдаг, цөхрөлт

мухардалт баяртайяа тосон авдаг хурдан, хөнгөхөн үхлээ бус эдгээр хүмүүсийн шулмын мунхаг бишрэл дээр чиний гэмт хэрэг гэгдсэн зүйлийн төлөө оногдуулсан аймшигт алгуур үхлээр өнгөрөх учиртай болсон шүү гэж сүмийн хорооны баатрыг өгүүлэхэд Ревекка өөдөөс нь,

- Миний хувь тавилан тийм боллоо гэхэд тэр хэний гай вэ? Өөрийгөө өргөмжлөх сэтгэлийн үүднээс намайг хүчээр нааш нь чирч ирсэн, одоо ямар зорилгын улмаас юм бүү мэд, өөрийнхөө надад учруулсан гашуун хувь тавилангийн аймшигтай хэцүүг давруулан ярьж сүрдүүлэхээр ирсэн тэр хүний гай яриагүй мөн хэмээн маргалаа.

- Намайг үүнд буруутай гэж бүү бод, битгий тэгж санаарай. Чамайг сумнаас хамгаалж байсан шигээ энэ аюулаас би мөн өөрийн цээжээр дуртайяа хамгаалахсан билээ гэж сүмийн хорооны баатар өгүүлэв.

- Гэм буруугүй хүнд өршөөл үзүүлэх шударга санаагаар тэгж үйлдсэн болж гэм би чамд баярлалаа гэж хэлэхсэн. Гэвч түүнээс хойш чи тэр явдлаараа тоогүй олон удаад эд хав болгосон болохоор чиний түүнийхээ хариуд шаардаж байгаа гутамшгийн үнээр аврагдсан амьдрал надад жигшүүртэй санагдах болчихлоо гэж Ревекка хэллээ.

- Зэмлэхээ больж үз, Ревекка. Өөрийн минь зовлон надад хүрэлцээтэй байна, дайран давшилж түүнийг бүү гүнзгийрүүл дээ гэхэд нь,

- Эрхэм баатар та тэгээд юу хүсэж байгаа юм бэ? гэж еврей хүүхэн асуугаад, - Товчхон шиг хэлээрэй. Чи өөрийнхөө учруулсан гай зовлонг харж шохоорхох гэж ирээгүй юм бол ярь. Тэгээд өршөөл үзүүлж намайг орхи. Хорвоогоос мөнхөд шилжин, хоромхон зуур боловч аймшигтай, түүнд сэтгэлээ засаж бэлтгэх цаг надад маш цөөн байна гэлээ.

- Чамайг ангижруулахсан гэж хүсэж буй их гай зовлонд намайг буруутай гэж Ревекка чи тооцсоор байгаа юм байна гэж Буагильбер хэллээ.

- Эрхэм баатар, таныг би зэмлэж буруушаах хүсэл алга. Чиний даруулгагүй шунал тачааллын хар гайгаар би ийм хөнөөл зовлонд учраагүй гэж үү? гэвэл сүмийн хорооны баатар яаран хариу маргаж,

--Чи эндүүрч байна. Энэ чинь худлаа. Миний урьдчилан харж чадахгүй байсан, мий зориг хүслээс гадуур болсон зүйлийг надад тохож байна. Өөрөө хэдэн уда зүрх зориг бадарч тулалдсан хийгээд биеэ ямар ч хэрэггүйгээр хатуулан зовоохыг тэнэг хүмүүс биширдгийн уршгаар байгуулсан гавьяанаасаа хэт өндөр өргөмлөгдөж одоо саруул ухаан санаатай бий болоод манай хорооны олон зуун гишүүдийг захирч байгаа тал ухаантай өвгөнийг гэнэт яваад ирнэ гэж би хэрхэн мэдэх билээ. Бид тэгэхэд үүний мухар сүсгээс чөлөөтэйгээр бодож сэтгэдэг хүмүүс билээ гэв.

--Гэхдээ чи шүүгчдийн тоонд байлцсан, миний огт гэм буруугүйг мэдсээр атлаа надад ял оноохыг эсэргүүцээгүйгээр барахгүй миний санаж байгаагаар уул оноосон ялыг батлахын тулд бурхны шүүх дээр өөрөө тулалдахаар болоогүйсэн билүү гэж Ревеккаг хэлэхэд сүмийн хорооны баатар,

--Ревекка тэвчиж үз! Ингэхэд таны омгийн хүмүүсээс өөр аль ч ард түмэн хувь заяаг төчнөөн их хүлцэнгүйгээр тэсвэрлэж чаддаггүй шүү дээ гэв.

- Тийм гунигт чадварыг израиль муу цагт эзэмшсэн бүлгээ гэж Ревекка дуугараад, - Хүний зүрх гэдэг галын хүчинд автах ган бодлын адил гай зовлонгийн эрхшээлээр хүлцэнгүй болдог бөгөөд төрсөн орныхоо эрх чөлөөт иргэн байхыг больсон хүн харийнхны өмнө өөрийн эрхгүй толгой бөхийхөд хүрдэг ажээ.

Бид бүхэнд туссан хараал ийм юм даа эрхэм баатар минь. Бидний гэм буруу, эцэг өвгөдийн маань нүгэл хилэнцээр ийм болсон гэдэг эргэлзээгүй. Харин өндөр сурвалж, үе залгамжлах эрх дураараа ид бах болгодог та нар өөрсдийнхөө үзэл үнэмшлийн эсрэг бусдын сухар сүсгийг өөгшүүлж суух нь юун их шившиг вэ! гэж хэллээ.

Буагильбер өрөөн дотуур сэтгэл догдлон хойш урагш алхаж – Ревекка, чиний үгэнд гашуун үнэн байгаа юм. Гэхдээ би чамтай зэмлэлцэж маргалдахаар ирээгүй. Буагильбер нөхцөл байдлаас болон хааяа төлөвлөгөөгөө өөрчлөх авч ертөнц дээр хэнээс ч няцдаггүй болохыг мэдтүгэй. Мигий хүсэл эрмэлзэл уулын түргэн урсгалтай адил, хадан цохио замд дайралдлаа гэхэд хэсэг зуур шулуун замаасаа хазайж болох авч урагш их далай руу тэмүүлэх замаа заавал олдог юм. Өмгөөлөн тулалдах хүн шаард гэж дээр нь бичээстэй байсан сайрны тасархайг чи санаж байна уу? Буагильбер биш бол өөр хэн түүнийг бичсэн гэж чи бодож байна? Өөр хэнд чи тийнхүү өрөвдөх сэтгэл төрүүлж чадах байсан бэ? гэв.

- Цаазлан хороохыг түр хойшлуулснаас цааш юу ч биш гэж Ревекка хариулаад, - Түүний ашиг гэж надад бага юм. Өөрөө өдий их гай зовлон толгой дээр нь тохоод, эцэстээ авсны ирмэг дээр авч ирсэн бүсгүйн төлөө чи өөр юу ч хийж чадахгүй байлаа гэж үү? гэв.

- Чиний тулд хийх гэж байсан зүйл маань энэ төдийхөн огт бусаа. Хөгшин тэнэг. Мухар сүсэгтэн харгис Гудольбрик хэрэгт оролцож гай тариагүй бол хийдийн нэр төрийг хамгаалах дайчны үүргийг хүрээ хамбад биш жирийн нэг гишүүнд даалгах байсан. Тэгвэл байлдааны бүрээ анх тасхийн дуугарахын хамт би өөрөө мэдээжээр адал явдал эрж хэсүүчлэгч баатрын дүрээр тулалдааны талбар дээр ирж, зэвсгийн хүчээр өөрийгөө чиний өмгөөлөгч гэж зарлахсан билээ. Бомануар миний өөдөөс нэг биш, энд байгаа санваартнуудаас хоёр гурван хүн гаргалаа гэхэд нэг жадаар дараалан эмээлээс нь ховх татаж хаяна гэдэгт би эргэлзэхгүй байна. Ревекка би ингэх л санаатай байсан юм. Би чиний гэм нүгэлгүйг баталж чадаад өөрөөс чинь ялалтынхаа хишиг шанг горилох агсан бүлгээ гэв.

- Эрхэм баатар эд бүгд чинь хоосон сайрхалт байна. Юу хийж чадах байснаараа чи гайхуулж байвч эрс өөрөөр үйлдэхийг илүү тохиромжтойд үзсэн. Чи миний бээлийг гардаж авсан. Тэгэхлээр миний өмгөөлөгч, над шиг ийм ганцаардмал амьтанд өмгөөлөгч олдог юмаа гэхэд тулалдааны талбар дээр ирээд чамтай үзэлцэх болж байна. Чи тэгэхэд одоо хүртэл миний өмөг түшиг сайн нөхрийн царай гаргаж байдаг гэж Ревекка өгүүлэхэд сүмийн хорооны баатар хариуд нь,

- Үгүй, би үнэхээр чиний сайн нөхөр, өмөг түшиг байх хүсэлтэй байна. Тэгэхдээ би үүгээр юунд хүрч болох, чухам гэвэл нэр алдра хэрхэн муухайгаар зайлшгүй бузарлахад хүрэхийг өөрөө бодоод үз. Өөрийн хамаг нандин чухаг зүйл бүхнээ чамайг аврахын тулд гаргуунд

гаргахын өмнө хэд хэдэн болзол тавимаар байна. Чи битгий үүнд зэмлээрэй гэхэд Ревекка,

- Ярь л даа. Би чиний үгийг ойлгохгүй байна гэв.

- За яах вэ, лам багшдаа нүглээ наманчлахаар ирсэн хилэнцэт хүн шиг би илэн далангүй ярья. Ревекка, эрүүл тулалдааны талбарт би очихгүй бол мяндаг тушаал, сайн нэрнээсээ салж, өнөө хүртэл чармайн эрхэмлэж явсан бүхнээ, тухайлбал нөхдийнхөө итгэл хүнд болоод одоо мухар сүсэгт харгис өвгөн Лук Бомануарын эзэмшиж байгаа, би өөрөө бол эрс өөрөөр эзэмших хүчирхэг эрх мэдлийг уламжлан авах найдвараа алдах болно. Чиний өмгөөлөгчтэй би тулалдахаар гарахгүй юм болж гэм надад оногдох хувь тавилан тийм л байна. Надад ийм шулмын урхи тавьсан Гудодвбрикийг чөтгөр алгадаасай! Чам шиг ийм ариун санаатай, гоо сайхан хүнийг муйхраар гүтгэсэнд итгэж байгаа, зөнөж гүйцсэн харгис өвгөний нүүр өөд чиний бээлийг чулууудах гэтэл намайг хорьж зогсоосон Альберт Мальвуазен мөн хараал хүрэггэлээ.

- Одоо тэгээд энэ олон сүр бадруулсан, нялуун үгний хэрэг юу байгаа юм бэ? Гэм нүгэлгүй бүсгүй хүний цус урсгах, юм уу, хорвоогийнхоо эрх ашиг, горьдлогоо гаргуунд гаргахыг чи сонгож авах учиртай байсан. Энэ тухай яриад байх юу байна? Чи сонгодгоо нэгэнт сонгосон гэж Ревекка өгүүлэв.

Баатар ойртож очин арай зөөлөн дуугаар, - Үгүй, Ревекка би хараахан сонгож аваагүй байна. Үгүй шүү. Чи өөрөө энэхүү сонголтыг хийх учиртай болсныг мэдтүгэй. Би хэрэв тулалдааны талбарт очих аваас дайчин нэр алдраа хамгаалах учиртай болно. Тэгэхлээр чамд өмгөөлөгч байсан ч, үгүй ч ялгаагүй чи багананд хүлэгдэж түүдэг дээр шатаж үхэх болно. Юу гэвэл арслан зүрхг Ричард, түүний шадар баатар Уильфред Айвенгогоос өөр тулалдаанд надтай эн дүйх юм уу, дийлэх эр баатар хүн хараахан төрөөгүй бүлгээ. Гэхдээ Айвенго хараахан хуяг өмсөх чадалгүй байгаа, Ричард харь хол газар шоронд буй. Иймд би эрүүл тулалдаанд гарвал чиний гоо сайхан чинь хөөрүү сэтгэлтэй нэгэн залууг өмгөөлөгчөөр гарахад хүргэлээ ч гэсэн чи үхэх болно гэв.

- Чи юунд нэг юмаа улиглан яриад байгаа юм бэ? гэвэл,

- Юу хүлээж байгааг чи сайн ойлгоосой гэж сүмийн хорооны баатар өгүүлэв.

- За наадхынхаа санааг ил гаргаадах, юу байх нь вэ үзье гэж еврей бүсгүйг хэлэхд Буагильбер цааш нь,

Би гарч, тэр гайт тулалдааны талбарт үзэгдэх ахул чи нүгэлтэг\нгүүдэд оногддог алгуур тарчилгаат

- Эрхэм баатар, та тийм дэмий юмны тухай бүү бод. Зүгээр хаан ширээг түшиж буй хатан эх, хаан хүү Жон дээр бушуухан оч. Английн хааны төрийг хүндэтгэхийн үүднээс танай тэргүүн хамбыг ийнхүү зоргоороо аашлахыг тэд зөвшөөрөхгүй. Үүгээр чи надад знэхээр өмөг түшиг үзүүлж өөрөө алив осол аюулд үл учран, надаас элдэв шан нэхэх хэрэггүй болох юм гэж Ревекка хариуллаа.

- Би тэдэнтэй ярихыг хүсэхгүй, ганцхан чамд л хандаж байна гэж хүүхний хувцасны хормойноос шүүрэн,

Юунаас бол чи ийм ойлголт хийж байна вэ? Би чухамхүү шулам өөрөө биеэр байлаа гэхэд үхэл шулмаас бүр дор байх шүү дээ. Мий өрсөлдөгч зөвхөн үхэл мөн гэв. Даруулгагүй баатрыг хэт уурлуулахаасаа Ревекка болгомжловч түүний эрэлтийг хүлээн зөвшөөрөхгүйгээр үл барам талтай дүр ч билээ хуурмагаар үзүүлэхгүй гэж хатуу шийдэн – Эдгээр гайг би цэгнэж үзэхгүй. Эр хүн шиг байж шашин шүтлэгээ санаач. Та нарын ажил үйлээс илүү амнаас чинь хэзээд үл салах нигүүлсэнгүй сэтгэлийг танай шашин үнэхээр номлодог ахул чиний өгөөмөр сэтгэлийг өөдгүй муу арилжаа болгон хувиргах шан төлөөс нэхэлгүйгээр аймшигт үхлээс намайг хэлтрүүл өг гэв.

Үгүй! гэж дуу дээрэнгүй зант сүмийн хорооны баатар дуу алдан босон харайж, - Үүгээр чи намайг мэхлэхгүй! Олсон алдар нэр, ирээдүйн хүндэтгэл, эрх мэдлээ гаргуунд гаргана гэвэл зөвхөн чиний төлөө л тэгнэ, бид зөвхөн цуг л аврагдвал аврагдана гээд дахин дуугаа намсган,

- Ревекка чи дуулж бай. Англи, еврей гэдэг бүх дэлхий биш шүү дээ. Бид амьдарч болохоор өөр орон бас бий, тэнд би эрх мэдэл эрмэлзэх хүслэнгээ биелүүлж болно. Палестин руу явъя. Тэнд миний найз Конрад бээс гэж миний нэгэн адил бидний төрөлхийн саруул ухааныг гинжлэгч мухар сүсэгнээс чөлөөтэй сайн нөхөр минь бий. Бид өөрсдөө жигшин үздэг энэ мухар сүсэгтэн харгисуудад дор үзэгдэж суусанд орвол Саладинтай холбоо сүлбээтэй болсон маань илүү дээр гээд өрөөн дотуур том томоор алхлан, - Би өндөр өргөмжлөгдөх шинэ зам нээнэ. Өөрийн хөвгүүдийн тооноос хөөж гаргасан хүний нүсэр алхааг еврей дуулах болно, гайгүй. Загалмайн нэрээр Палестиныг хамгаалуулахаар еврей хичнээн сая хүн явууллаа ч гэсэн, сарацинын хичнээн арван мянган сэлэм тэднийг няцаасан ч энэ муу маягтай зөнөг юу хийж, юу гэж ч байсан хамаагүй, бүх ард түмэн өрсөлдөн байгаа тэр оронд хэн ч надаас илүү гүнзгий цөмрөн орж, би болоод миний хойноос гал ус руу орохоос үл буцах нөхдийн маань адилаар тэнд баттай суурьшиж чадах өөр хэн ч байхгүй. Ревекка чи тэгээд хатан хаан болно. Би эр чадлаараа чамд байлдан олж өгөх хаан ширээг кармель уулан дээр засаж, тэргүүн хамбын очрын оронд миний гарт хааны сүлд атгаастай байх болно гэлээ.

- Мөрөөдөл дан мөрөөдөл, хоосон санаашрал! гэж Ревекка дуугараад, - Энэ санаашрал биелдэг байжээ гэхэд, надад ер хүртээлгүй. Юуны өмнө чамайг хичнээн их эрх мэдэлтэй боллоо гэхэд би түүнийг чинь хуваалцаж чадахгүй. Эх орноо хайрлах сэтгэл, шашин шүтлэг минь, бат, миний хувьд чухаг зүйл болохоор харь омгийн бүсгүйд шунан тачаалдсан төдийгөөр хүчин зүтгэхээр андгайлсан хийдээс холбоо таслан эх орноо дуртайяа орхиж байгаа хүнийг би хүндэлж чадахгүй. Эрхэм баатар та намайг аварсны хөлсийг бүү тогтоо, өгөөмөр сайхан сэтгэлээр байгуулах гавьяаг бүү наймаал, золгүй надад хувийн ашиг завшааны үүднээс биш чухамхүү нигүүлсэхийн учир өмөг түшиг үзүүл. Английн эзэн хаанд дуулга. Ричард миний гуйлт залбиралтыг анхааран тольдож тарчлан тамлагчдын харгислалаас намайг аварна гэж хэлэв.

Хэрхэвч үгүй ! Үгүй гэж сүмийн хорооны баатар хилэгнэн хашгираад, - Хийдтэй холбоо таслах боллоо гэвэл зөвхөн чиний л тулд, харин чи миний хайр сэтгэлийг түлхэх ахул надад ганцхан дээш тэмүүлэх, надад ганцхан эрмэлзэх маань үлдэнэ. Би өөрийгөө тэгж маллуулахгүй! Чи намайг Ричардад бөхөлзүүлэх гэж хүсэв үү? Тэр бардам сэтгэлт хүнээс

өршөөл гуйж байх гэж үү? Хэзээ ч тийм юм болохгүй ээ, Ревекка! Сүмийн хороо миний дүрээр Ричардын хөлд сөхрөхгүй! Хийдээс би холбоогоо тасалж болно. Харин хэзээ ч түүнийг гутаах юм уу гуйван худалдахгүй, бүлгээ гэв.

- За тэгвэл хүмүүсээс тусламж горилох хэрэгтэй болохоор миний хамаг найдвар бурхны өршөөлд байх ажээ гэж Ревекка дуугарав.

- Чи их бардам сэтгэлтэй хүн юм. Би ч бас тийм гэдгийг мэдтүгэй. Тулалдааны талбар дээр би бүрэн зэвсэгтэйгээ гарах ахул хорвоогийн ямар ч татлаа миний бүх хүч чадал, эрдмээ хэрэглэхэд саад болж чадахгүй. Чиний хувь заяаг тэгэхэд ямар болохыг бодож үз! Чи аймаар тарчил, дүрэлзсэн гал дээр хуйхлагдана. Энэ сайхан дүрээс юу ч саяхан амьд хөдөлж явж байсан амьтан гэж хэлэхээр сүг ч үлдэхгүй болно... Үүнийг Ревекка чи бүсгүй хүн ийм хувь оногдлын тухай бодлыг тэсвэрлэж чадахгүй. Чи миний хүслийг дагах л болно доо! гэж сүмийн хорооны баатар өгүүлэв. Еврей бүсгүй үүний хариуд:

- Буагильбер, чи бүсгүй хүний сэтгэлийг ер мэдэхгүй буюу эсвэл эмэгтэй хүний хамаг нандин чанараа алдсан нэгтэй л учирч явжээ. Өөрийн үүрэг юм уу хайр сэтгэлээсээ болон зовохын цагт бүсгүй хүний хатуу зүрх гаргадаг шиг тийм эр зоригийг, бардам баатар чи ямар ч аймаар их тулалдаанд гарч байгаагүй гэдгийг батлан хэлье. Би өөрөө эрх танхи өссөн төрөлхийн аймхай, бие махбод өвдөх зовлонг тэсвэрлэхдээ маш муу эмэгтэй. Гэвч бид хоёр тэр гайт тулалдааны газарт чи тулалдахаар, би цаазлуулахаар очихын цагт миний эр зориг чинийхээс хавьгүй илүү байна гэдэгт би бат итгэж байна... Баяртай би чамтай цаашаа үг уралдуулахыг хүсэхгүй байна. Израилийн охин хорвоо дээр өнгөрсөн болж байгаа цөөн цагаа өөрөөр зарцуулна. Ард түмнээс минь царайгаа буруулсан авч үнэнхүү сүсэглэн залбирсан хүнийг хэзээд нигүүлсэгч бурханд би мөргөх учиртай гэв.

Сүмийн хорооны баатар хэсэг зуур дуугүй байснаа ам нээн – За ингэхлээр бид хагацах болж. Юу гэж бурхан биднийг энэ хорвоо дээр учруулав аа? Чи юунд христос шашинтай сайн төрөлт эцэг эхээс эс төрөв? Үгүй тэнгэрийг барьж андгайлахад хаана яма шүү байдалд би дахин нүүр учрах тавилантайг бодохоос, би чиний хавчигдан хяхагдсан омгийн хүн болж эс төрөв өө гэж харамсах болж байна. Чиний гар жад, бамбайн алиныг ч мэдэхгүй, зоостой авдар уудалж жижиг язгууртны өмнө нуруу бөхөлзөн, гагцхүү өртөншүүдийг айлгаж явсан ч болоосой!... Ревекка чамд л ойр байж амьдрах, чиний үхэлд гүйцэтгэх болж байгаа аймшигт үүргээс зайлсхийхийн тулд би иймд хүрч, ийм юм хүсэх болсон байна шүү гэвэл Ревекка өөдөөс нь,

- Өөр шиг чинь хүмүүсийн хавчилт хяхалт иймд хүргэсэн еврей нарын тухай чи ярьж байна. Бурхны хилэн тэднийг эх нутгаас нь хөөн гаргасан авч хөдөлмөрт дуртайн ачаар эрх мэдэлтэй болох ганц зам нээгдсэн, тэр зам дээрээ тэд саад хавчилт дайраагүй билээ. Израилийн ард түмний эртний түүхийг уншаад үз, улс үндэстнүүдийн дотор Иегов төдий их гайхамшигт үйлийг бүтээлгэж байсан тэдгээр израиль хүмүүсийн дунд худалдаачин, мөнгө хүүлэгчид байж уу, үгүй юу, хэлээрэй, бардам баатар минь. Манайхны дунд сурвалжит нэртэн цөөнгүй бөгөөд тэдний дэргэд та нарын гайхуулдаг тайж угсаагаа гэдэг чинь хушны дэргэдэх хулуу л гэсэн үг гэв.

-Өөрийнхөө омгийн эртний адар цуугийн тухай ярихдаа Ревеккагийн хацар улаа бутарч

байснаа, сүүрс алдаад цааш нь ярихдаа дахин цонхийв.

- Одоо нэгэнт үгүй болсон Иудийн их ноёд тийм байсан бүлгээ. Тэдний алдар нэр хадагдсан өвч мэт гишгэгдэж, замын тоостой хутгалджээ. Гэхдээ их сурвалжит удмын үр сад, өндөр язгуур, гарлынхаа нэрийг гутаахгүй хүмүүс бас бий. Тэдний нэгэнд Адоникомын хүү Исаакийн охин орно. За баяртай! Хүний цусны үнээр олсон хүнд ямбанд би үл атаархана, хойт зүгийн буруу номтноос гарсан чиний зэрлэг язгуур, сурвалжинд үл атаархана, чиний ам хэлнээс үл салах хэдий авч ажил үйл, сэтгэл санаанд чинь үл орших танай шашинд ч эс атаархана гэж хэлэв.

- Тэнгэрийг барьж андгайлахад би үнэхээр муу увьдаст автагдсан юм шиг болчихлоо! гэж Буагильбер хэлээд

- Өөрсдийн нь хамжааргагүй шунал тачаалын шууд уршиг болох зүйлийг хувь хүмүүс тавиланд тохох нь цөөнгүй байдаг гэж Ревекка хэлээд – Гэхдээ миний зуурд үрлийн гай болсон Буагильбер чамайг би уучилж байна. Чи сэтгэл санаа чангатай, агуу сайхан эрмэлзэл үе үе чамд төрдөг. Гэвч энэ сэтгэл арчилгаа муутай цэцэрлэг адил хичээл муутай эзэнд заяаж, хогийн өвс түрэн, эрүүл сайн үндсүүдийг давамгайлсан юм байна гэлээ.

- Тийм шүү Ревекка, би яг чиний хэлдэг шиг хүн. Даруулгагүй, зоргоороо, гэхдээ, олон мунхаг тэнэгүүд, овжин харгис авиртангуудын дотроос өөрийг минь товойлгож өгсөн хүч чадлаа хадгалж чадсандаа бардам байдаг хүн, бага наснаасаа аван би цэргийн эрдэм сурч, өндөр зорилго руу тэмүүлэн түүнийгээ цуцалтгүй шургуу мөрдөж явна. Бардам, нугаршгүй хувиршгүй энэ хэвээрээ л би байх болно. Хорвоо үүнийг үзэх болно, би түүнд өөрийгөө үзүүлнээ... За Ревекка чи намайг уучилж байна уу? гэхэд,

- Хороогдох хүн яргачнаа уучилж болох хирээр чи сэтгэлээсээ уучилъя гэв.

- Баяртай гэж сүмийн хорооны баатар дуугараад өрөөнөөс гарч одов.

Хүрээ даамал Альберт Мальвуазен хажуугийн өрөөнд Буагильберийн буцаж ирхийг тэсэж ядан хүлээж байв.

- Чи яасан их удав аа? Би бүр хичнээн их сэтгэл түгшив. Тэргүүн хамба Конрад юм уу тэдний туршуулаас наашаа орох гэвэл, юу болох байв? Өршөөнгүй зан гаргасныхаа хариуд бид хүнд юм үзэх байсан даа!... За чи юу болов анд минь? Чи, арай чамай хөл дээрээ тогтож, царай нүүр чинь шөнө шиг барайгаад юу болов? Буагильбер чиний бие зүгээр биз? гэж Альберт хэлсэнд сүмийн хорооны баатар хариуд нь,

- Цагийн дараа цаазлагдахаа мэдэж байгаа золгүй хүний бие хир сайн байж болох хирээр л эрүүл сайн байна. Үгүй ер нь түүнээс хувь илүү дор байна, юу гэвэл алагдах ял заагдсан зарим хүн амь наснаасаа хагацахдаа хэргээ барсан хуучин хувцас хаяхаас хялбар байх юм байна.

- Чи солиорчээ! гэж Мальвуазен дуугараад, - Тэгж аашилснаар чи өөрийгөө хөнөөвч, өөрт чинь янз нь их дотно еврей хүүхнийг аварч чадахгүй. Чиний оронд хийдийн нэрийг

хамгаалах хүн Бомануар томилоод яллагдсан хүүхэн ялгаагүй үхэх болно гэвэл,

- Дэний үг. Би өөрөө түүний өмгөөлөгчөөр гарна гэж сүмийн хорооны баатар бардам өгүүлээд, - Миний жадны хүчийг давж чадах дайчин манай бүх хороонд үгүйг Мальзуавен чамайг мэдэх байх гэж санаж байна гэлээ.

Овжин зөвлөгч үүнд, - Харлаа, чиний тэнэг төлөвлөгөөг биелүүлэх учрал, завдал чамд ер өгөхгүй гэдгийг чи бодохгүй байна. Лука Бомануарт очиж сахил санваар сахих андгайгаа буцлаа гэж хэл, зоргоороо өвгөн түүний дараа чамайг удаан эрх чөлөөтэй явуулах нь уу үгүй юу үзээрэй. Энэ үгээ хэлж дуусаагүй байхад шахуу байхдаа чи хүрээний гяндан болох цамхгийн тушаа зүүн алд газар дорхи харанхуй зооринд орж шүүх цагийг хүлээх болно. Чамайг тэгээд олхиогүй муу баатар гэж шүүнэ. Тэгээд чамайг үнэхээр муу увьдаст автжээ гэж үзэх ахул гавлаж гинжлээд алс нэгэн сүмд аваачиж тусгай өрөөнд хорино. Тэнд чи элдэв тарни номлол сэлтэд толгой эргэж гүйцээд, шулмыг хөөн гаргахын тулд үргэлж шивших ариун рашаад нэвт норчихсон сүрлэн дээр хэвтэх болно доо. Чи тулалдааны талбар дээр гарч очих учиртай, тэгэхгүй бол Бриан би баларна шүү! гэв.

--Үгүй, би эндээс мултран гарч зугтаая! Хүний мухар сүсэг, тэнэглэлийн хор шингэж амжаагүй хол нэгэн орон руу оргож амь гаръя. Юу ч гэсэн энэ сайхан хүүхний ганц ч болов дусал цус миний буруугаар асгарахгүй гэж Буагильберийг өгүүлэхэд Мальвуазен хариуд нь,

- Чи зугтааж чадахгүй, ухаангүй авирласнаар сэжиг төрүүлсэн тул хүрээний хэрэмнээс чамайг гаргахгүй. Очоод үз л дээ. Хаалга руу очиж, дүүжлүүр гүүр буулга гэж тушаа, үгийг чинь дагах нь уу, үгүй юу үз. Чи гайхаж, гомдож байна уу? Тэгсэн нь чамд л сайн юм. Чи зугтааснаар ямар ч ашиг олохгүй. Өвөг дээдсийнхээ нэрийг гутааж, өөрөө хийдээс хөөгдөнө. Сүмийн хорооны эгнээнд тэргүүн дайчин байсан Бриан де Буагильберийг олны өмнө урвагч гэж зарлаад, үзэгч олон чиний нэрийг доромжлон шуугилдах үед аян дайны нөхөд чинь ичиж, зовсондоо хаашаа орох юм бэ? Сайн бодоорой. Францын хааны ордон хир их гашуудах бол! Палестинд байхад яггүй төвөг учруулж, адсан нөгөө баатар нэг еврей хүүхнээс болж сайн адар нэр төрөө өөрөө хөнөөж, төдий их хохирлын үнээр ч гэсэн уул хүүхнээ аварч чадаагүйг дээрэнгүй Ричард ямар их баяртайгаар сонсох бол гэвэл баатар хариуд нь:

- Мальвуазен чамд баярлалаа. Миний сэтгэлийн гол эмзэг судсыг чи хөндөж чадлаа. Юу л болбол болог, харин "урвагч" гэдэг үг Буагильберийн нэртэй цуг хэрэглэгдэхгүй, бурхны авралаар Ричард өөрөө юм уу гайхуулдаг шадруудын нэг нь миний эсрэг тулалдааны талбарт гараасай. Үгүй тэнд хэн ч ирэхгүй. Гэм буруугүй ганцаардмал бүсгүйн төлөө хэн ч амь насаа дүйхийг хүсэхгүй гэлээ.

- Энэ хэрэг үүгээр төгсвөл чамд улам сайн гэж хүрээ хамба хэлээд, - Өмгөөлөгч нь ирэхгүй бол золгүй бүсгүйн үхэлд чи биш алах ял оноосон тэргүүн хамба буруут болно.

Энэ хэргийн хариулага түүнд оногдох бөгөөд тэр өөрөө үүнийг гэм нүгэл биш, өргөмжлөн магтвал зохих гавьяа гэж үзэх болно гэж хэллээ.

- Тэр үнээн, хүүхний өмгөөлөгч ирэхгүй бол би зөвхөн л сүржин үзэгдлийн нэг хэсэг болно. Чухам гэвэл бүрэн зэвсэгтэй морь унаж гарч ирээд цаашид болох явдалд гар бие оролцохгүй

гэж Буагильберийг хэлэхэд,

- Тэгэлгүй яах вэ? Шашны ёслолын үед барьж явдаг ялгуусан Георгийн хөрөг шил л үүрэг гүйцэтгэх юм шүү дээ гэж Мальвуазен тосож өгүүлэв.

- За яах вэ миний түрүүчийн шийдсэнээр болог. Тэр хүүхэн чамайг түлхэж, үл тоомсорлон дорд үзсэн. Юу боллоо гэж би тэгээд өөрийн алдар нэр, өөр бусад хүмүүсийн хайр хүндийг гаргуунд гаргах юм бэ? Мальвуазен, би тулалдааны талбарт гарнаа гэж сүмийн хороны дээрэнгүй баатар өгүүлэв.

Энэ үгийг хэлээд танхимаас яаран гарахад уул таатай шийдвэрийг нь бататгах, харж хандахаар хүрээ даамал хойноос нь дагалдав. Буагильберийг хожим хийдийн тэргүүн болох цагт өөрөө их ашиг завшаан гарахыг горилох учир түүний амжилтанд хүрээ даамал ихэд сонирхсон ажээ. Нөхрийнхөө сэтгэл санааны сайн эрмэлзлийг дарахдаа Мальвуазен хар амиа хичээсэн зальт этгээд, эргэлдсэн олон санаатай, хөхүүл хөөрүү хүнтэй тэмцэж байгаагийн давуу талтай бүлгээ. Гэлээ гэхдээ Буагильберийг нэгэнт шиддсэн хэвээрээ байлгахын тулд түүний бүх уран ов шаардагдлаа. Нөхрийгөө дахин оргож зугтаах санаа төрөх вий гэж үргэлж ажих, тэргүүн хамбатай нүүр учрхаас нь сэрэмжлэх учиртай байлаа. Эд бүгдийн дээр, Бриан тулалдааны талбарт гарах хэрэгтэй. Ревеккагийн хувь заяанд энэ ямар ч нөлөө үзүүлэхгүй гэсэн мөртлөө нэр төрөө алдаж шившиглэгдэхээс гарах ганц зам энэ мөн гэж үе үе элдвээр ятган үнэмшүүлж байв.

ДӨЧДҮГЭЭР БҮЛЭГ

Хаан Ричард дахин дүрээ олон

Хар сүүдрүүд тонилогтун!

Шекспир "III Ричард хаан"

Одоо хар баатрын адал явдлыг эргэж үзье. Өгөөмөр сэтгэлт дээрэмчний царснаас холдоод зэргэлдээх гэгээн Ботольфийн хийд гэдэг нэртэй чинээлэг, бас даруу нэгэн хүрээ өөд чиглэв. Торкильстон цайзыг унасны дараа Айвенгог тийш нь аваачжээ. Уильфред, түүний аврагч хоёрын хооронд юу болсон тухай бид нуршихгүй. Ганцхан удтал чухагчлан ярилцсаны эцэст ширээт тал тал тийшээ элч мордуулсан бөгөөд Хар баатар өглөө мордохоор завдахдаа вамба салбадайг газарчаар авч явах болсныг өгүүлсүгэй. Мордохын өмнө баатар Айвенго дээр орж,

- Чи бид хоёр талийгаач Ательстаны цайз Конингсбургт уулзъя. Чиний эцэг Седрик сайн төрөлт садангаа оршуулахаар тийшээ одсон. Тэнд би чиний саксон ургуудтай учирч, ойр танилцах болно. Эрхэм Умльфред чи мөн тийшээ оч, би чамайг эцэгтэй чинь эвлэрүүлэхийг бодъё гэлээ.

Ийнхүү хэлээд Хар баатар Айвенготой эелдгээр салаад цаадах нь амь аврагчдаа хань бараа болохыг чин голоосоо эрмэлзэв. Хар баатар харин энэ тухай дуулах ч дургүй байлаа.

- Өнөөдөр сайн амар, маргааш ч чи бас мордож чадахгүй байх байхаа. Шударга Вамбагаас өөр дагуул надад хэрэггүй. Энэ миний сэтгэл санааны байдлаас болон гэлэн юм уу, салбадайн үүрэг гүйцэтгэж явах болно гэж баатар өгүүлэв.

- Би танд чин сэтгэлээсээ зүтгэхэд бэлэн байна. Ательстаны хойтохын ёслол дээр би байлцмаар байна, юу гэвэл хоол унд өег, амттай байхгүй болж гэм өөрөө заавал амалж ирээд тогооч даамал нараас хэрэг асуух хүн. Тэр чинь үзэхэд болохоор явдал. Миний уран цэцэн үг хомс санагдаад манай эзэн Седрикийн өмнө таныг эрэлхгээр өмгөөлөх болов уу гэж би найдаж байна гэлээ.

- Чиний уран үг хүч хүрэхгүй болсон газарт миний эр чадал юугаар тус болж болохсон билээ, салбадай? Энэ оньсого надад тайлж өгч үзээч гэхэд Вамба хариуд нь,

- Ингэхэд, эрхэм баатар, хошин үг их хэрэг бүтээж чадна. Хүний эв олдог, ажигламтгай овжин эр болж гэм хөршийнхөө аль нүд юм харахдаа муухныг мэдэж аваад дур зоргоороо аашлан дэвэрч ирэхийн нь цагт харалган талыг нь барьсхийж байдаг юм. Эр чадал гэгч бол шулуухан туучдаг хүчирхэг зүйл. Далайн түрлэг, догшин шударга түүнд юу ч биш, сэлүүрээр зүтгэсээр яваад эцсийн эцэст эрэгт хүрсэн байдаг. Иймд би сайн төрөлт эзнийхээ сэтгэл санаа амгалан цэлмэг байх цагийг л ашиглах бөгөөд шуурга догширсон цагт эрхэм баатар та намайг хаацайлах болов уу гэж горьдоно гэв.

- Та өөрийгөө нэрлэж таалсанчлан эрхэм дүүжлээстэй цоожин сүлдэт баатар та хэтэрхий чалчаа, залхуу хүрэм тэнэг хүн газарчаар авсан шиг байх юм. Гэхдээ энэ ойн зөрөг бүрийг

ямар ч анчингаас доргүй сайн мэднэ. Түүнээс гадна хөөрхий энэ хүн ган болд мэт үнэнч итгэлтэй болохыг та өөрөө харсан билээ гэж Айвенго өгүүлэв.

- Зүгээр, надад зам зааж өгч л чадвал болох нь тэр. Намайг зам зуур зугаацууллаа гэхэд юу нь муу байх вэ. За Уильфред баяртай. Биеэ сайжруул, сайн нөхөр минь. Адаглаад маргаашаас нааш мордохыг би чамд хориглож байна, мэдсэн биз гэж баатар хэллээ.

Ингэж хэлээд Уильфредэд гараа өгвөл цаадах нь хүндэтгэн үнслээ. Ширээттэй салах ёс үйлдээд ганц Вамбыг дагуулан мордов.

Эргэн тойрсон ойн гүн рүү тэднийг далд ортол Айвенго хойноос ь харж байгаад сүмд эргэж оров. Гэвч төдөлгүй өглөөний мөргөл дуусмагц ширээттэй уулзъя гэж хүнээр хэлүүллээ. Өвгөн сандран гүйж ирээд бие нь ямар байгааг сэтгэл зовон лавлав.

Айвенго-үүнд, - эхлээд санаж байснаас хамаагүй дээр байна. Цус гоожсоноос болоод миний бодож байсан шиг тийм их хүнд шарх байгаагүй юм уу, эсвэл эм өдий их сайн тус болов уу, миний бие тун сайн, хуяг дуулга өмсөж чадмаар санагдаж байна гэв. Энэ чинь их завшаан мөн, юу гэвэл тун элдвийн юм санаанд үймрээд, би цаашаа энд гар хумхин сууж чадахгүй боллоо гэв. Ширээт үүнд, - бурхан өршөө, Саксоны Седрикийн хүү манай хийдээс шархаа эдгэрээгүй байхад мордох гэж үү. Би тиймд хүрвэл ичгэвтэр юм болно гэлээ.

- Гэгээн багш минь, бие аян замд гарч чадахаар байгаагаас гадна аргагүй шаардлагатай болоогүйсэн болж гэм танай зочломтгой хийдээс би өөрөө ч мөн мордох дургүй байна гэж Айвенго хэллээ.

- Юу чамайг ингэж гэнэт явахад хүргэж байна? гэж Ширээтийг шалгаахад,

- Ямар нэг гай зовлон учрахыг хүлээж муу совин татан шаналав, юунаас болов гэж шалтгааныг нь дэмий эрэх явдал гэгээн багш танд ер хэзээ ч тохиолдож байгаагүй гэж үү? Нарлаг өдөр үер борооны шинж болсон хар үүл гэнэт дээгүүр нь өнгөрч байгаа ногоон нуга аятай сэтгэл санаа чинь хэзээ ч барайж байгаагүй гэж үү? Тийм совин татахыг бид анхааран үзвэл зохилтой, ойртон буй аюулын тухай авралт сахиус бидэнд дохио өгч байж мэднэ гэж та бодохгүй байна гэж үү? гэж баатар өгүүлбэл Ширээт загалмайлан залбираад,

- Үгүй гэхгүй, тийм явдал тохиолддог, тэр нь тэгээд бурхны сэрэмж байдаг бүлгээ. Тиймэрхүү совин дэмий төрдөггүй. Ашиг тус, үйлс хийморийн шинж байдаг. Чи харин шархтай, чадал тэнхээ байхгүй байж хойноос нь дагахыг хүсэж байгаа хүндээ юугаар тус болж болох юм бэ? Дайсан довтоллоо гэхэд чи түүнийг хамгаалах чадал байхгүй шүү дээ гэв.

- Ширээт та эндүүрч байна, надад чадал овоо байгаа бөгөөд үзэлцэхийг хүссэн хэнтэй боловч тулалдаж сайн чадна. Тэгэхийн хэрэггүй байжээ гэхэд зэвсгээс өөр аргаар би түүнд хэрэгтэй байж чадахгүй гэж үү? Саксончууд норман нарт дургүй гэдэг хэн бүхэнд илт, Ательстаны үхсэнд сэтгэл үймрэн, дарс их ууж толгой эргэсэн үед нь саксончуудын дунд тэр гэнэт орвол юу болохыг яаж мэдэх вэ? Тийм цагт түүний очих нь маш аймаар үр уршигтай байж мэдмээр надад санагдана. Би тэгээд нэг бол гай зовлонг сэрэмжлэн зайлуулах, эсвэл түүний хувь тавиланг хуваалцахаар шийдлээ. Би энэ санаандаа хүрч чадахын тулд миний байлдааны

хөлгийнхөө арай зөөлөн явдалтай морь олж өгөхийг танаас гуйя гэв.

- Хүндэт ширээт, яая гэх вэ, би испани гүүгээ чамд өгье. Жороо юм, Сент-Альбаний хийдийн ширээтийн морь шиг номхон бус нь тоогүй. Гэхдээ миний Шүүр (жороо гүүгээ би тэгж нэрлэдэг юм) хамгийн номхон, хамгийн ам зөөлөнтэй унаа гэж батлахад бэлэн байна. Ганцхан явуулын илбэчингүүдэд л илүү их дуулгавартай адгуус байж мэдэх юм. Тэр чинь өрөөстэй өндөгнүүд дунд бужигнаж хүртэл чаддаг юм. Шүүрээ унаж яваад би бүхэл бүтэн номлол зохиосон, хийдийн санваартнууд болоод христос шүтлэгтэн олны аль алинд адил сургамжтай сайн номлол болсон гэв.

- За тэгвэл багш ламтан та Шүүрийг одоохон эмээллүүлээд миний зэр зэвсгийг авч ир гэж Гуртэд хэлнэ үү гэв.

- Эелдэг эрхэм минь, Шүүр эзнийхээ нэгэн адил зэр зэмсгийн талаар огтхон ч туршлагагүй мал гэдгийг ганцхан харгалзаж үзээрэй. Таны хуяг дуулгыг үзээд ялангуяа түүний хүндийг нуруун дээрээ мэдээд орхихоор яахыг нь би хэлж мэдэхгүй шүү. Тэр Шүүр чинь тун ухаантай адгуус, алив илүү хүнд зүйл тээж явахыг хэрхэвч хүлээхгүйдэг. Нэг удаа би хөрш ламынхаас латинаар бичсэн ганц боть түр аваад мордсон чинь тэр хүнд номыг уншлагынхаа хөнгөн судраар сольтол хашааны хаалгаар гарч өгөөгүй билээ гэж ярив.

- Гэгээн багштан таны морийг би илүү хүнд ачаагаар зовоохгүйн дээр ярдаглаад байвал өөрт нь муу болно гэдэгт итгэж үз гэж Айвенго өгүүлэв.

Энэ үгийг хэлэх үед баатрын гуталд хоёр том алтан давируул Гурт бэхэлж байлаа. Унасан хүний эрхшээлийг дагасан нь дээр гэж тэр давируул ямар ч моринд итгүүлж чадахуйц эд ажээ.

- Эелдэг эрхэм чинь уучлаарай! Миний Шүүр давируулд тун дургүй. Би тэр тухай хэлэхээ мартчихаж. Зүгээр, жаахан хүлээсэн нь дээр. Би манай нярвын гүүг авч ирүүлэхээр хүн явуулья, тэднийх энхүүхэн эдлэнд суудаг. Ганц цаг хиртэй л хүлээх болно, тэр морь харин номхон байж таарна, түүгээр мод зөөдөг, овъёосоор ер тэжээдэггүй юм даг гэв.

- Баярлалаа багш ламтан, таны анх түрүүчийн саналыг хүлээж авсан нь дээр гэж би бодож байна, тэгээд ч танай Шүүртийг нэгэнт хаалга руу хөтлөөд ирсэн харагдана. Гурт миний зэр зэвсгийг авч явна, бусдаар бүү сэтгэл зов. Би түүни нуруун дээр илүү ачаа тээхгүй болохоор тэр ч мөн намайг уурлуулахгүй бизээ. За баяртай гэв.

Айвенго шатаар хөнгөн шалмаг гүйж буув. Ширээтийн олон үгнээс төвөгшөөн бушуухан мордсон боловч ламтан өрөөс нь нүсэр бие, хижээл насныхаа хирээр түргэн дагаж Шүүрийнхээ сайн чанаруудыг үргэлж магтан, гамтай зөөлөн эдлэхийг баатраас гуйна.

Уильфред харин ширээтийн чухаг зөвлөлгөө, уран хошин үгийг сонсохооргүй сэтгэл их зовж байсан тул мордонгуут хоцрохгүй явахыг Гуртэд тушаагаад Хар баатрын мөрөөр ой руу хөдлөв. Лам, хийдийн хаалган дээр зогсон, хойноос нь харж,

Гэгээн дагина минь! Юунд би Шүүрээ түүнд итгэж унуулав аа? гэж дуу алдаад, - Гүүгий

минь гэмтээж орхивол над шиг бие өвддөг хүн түүнгүйгээр яах юм бэ? гэснээ гэнэт санаа авч, - Гэлээ гэхдээ хуучин англи нутгийнхээ сайн сайхны төлөө би согогтой хөгшин ясаа хайрлахгүйн адил миний Шүүр бас тэр үнэн хэрэгт зүтгэг. Тэд тэгээд манай ядуу хийдэд ямар нэгэн өгөөмөр өргөл өгөхийг зүйтэйд бодож ч болох юм. Хорвоогийн ихэс дээдэс өчүүхэн хүмүүсийн хүргэсэн тусыг хялбархан мартдаг болохоор тэгж өргөл барихгүй байлаа ч гэсэн хамаагүй, зөв ажил хийсэн гэдэг бодол надад шагнал болно. Одоо чинь санваартнуудыг өглөөний зоогонд дуудах цаг яг болчихоод байх шив. Үгүй энэ дуудлагад тэд өглөө, үдийн мөргөлд ирдгээсээ илүү дуртай цуглардаг шиг надад санагдах юм гээч! гэж дуугарав.

Гэгээн Ботольдийн хийдийн ширээт тгээд гэлдэрч, зоогны өрөөнд орон, хуврагуудын өлөөний зоогонд зориулж давсалсан сагалмай загас пиво хоёр тавьсан ширээний голд, амьсгаадсаар ихэмсэг дүртэй суув. Тэгээд хийд одоо өгөөмөр их өглөг барьц авна гэж горьдож болохтой болсон тухай бүүр түүр үг цухуйлгаж гарлаа. Өөр цагт болж гэм иймэрхүү үг нийтийн сонирхлыг татах байсан авч загас тун их давстай, пиво зэгсэн хатуу, хуврагуудын эрүү шуурхайлан хөдөлж байсан болохоор зохих ёсоор анхаарч сонссонгүй. Он тооллын бичигт, ширээтийн далд утгатай үгийг анхааран авсан ганц хүн Диггори гэлэнгийн тухай дурдсан байдаг. Гэлэнгийн шүд сүрхий өвдөж өрөөсөн талаараа л юм зажлантай байсан тул там тум дуулж, тэр ч байтугай, эрэгцүүлэн бодсон гэдэг.

Энэ зуур Хар баатар газарчийнхаа хамт ойн ширэнгээр алгуур урагшилсаар байлаа. Эрэлхэг баатар хайр сэтгэлд автсан яруу найрагчдын дуу амандаа нэг аялж, хамт яваа хүнээсээ хөгийн юм нэг асууж явлаа. Үүний ачаар тэдний яриа шог, наргиантай, дуутай ажээ. Тэдний ярианы тухай ядаж барагцаа ойлголт уншигч нарт өгөхсөн гэж хүснэм.

- За тэгээд нуруу чилгэр,

Салбадай ердийнхөө эрээн мяраан хувцастай боловч сүүлийн үеийн явдлууд түүнийг модон тлдээ хурц сэлэм, гонзгой бамбайгаар солиход хүргэжээ. Торкильстоныг дайрах үел салбадай уул мэргэжлийнхээ дагуу тийм эрдэмтэй байх албагүй хэдий ч гэсэн энэ зэвсгийг яггүй сайн эзэмшдэг нь мэдэгдсэн билээ. Чухамдаа Вамбагийн согогтой тал зөвхөн ямар ч байдалд тогтож сууж чаддаггүй хачин тэнцүүргүй, ямар ч юмыг дэс дараатайгаар сэтгэж чаддаггүйд байдаг билээ. Гэхдээ шалмаг овжин гойдын тэсвэр, буурь суурь үл шаардагдах ажлыг сайн гүйцэтгэж чадна. Морин дээр сууж явахдаа ганц ч хором тайван байхгүй, эмээл дээрээ эргэлдэж, мориныхоо дэлэн дээр нэг гарч, хондлой дээр нь нэг суун, хоёр хөлөө өрөөсөн тал руу нь унжуулан сандалй\йлж үзсэнээ буруу хараад мордчихно. Ёстой сармагчин шиг маяглаж, нүүр амаа үрчигнүүлнэ. Тэгсээр явж морио бүр залхааж гүйцсэнд цаадах нь булгиад хаячихсанд ногоон дээр тэрийгээд ойчив.Энэ явдал баатрын инээдийг их хүргэсэн бөгөөд змын хүн нь үүний дараа жаал номхорчээ.

Бидний энэ ярьж байгаа үед энэ наригианч хоёр эртний дуу аялж явлаа. Дүүжлээстэй цоожин сүлдэт баатар зэгсэн аятайн дуулах бөгөөд салбадай зөвхөн эвлэг бүдүүн хоологоор дагана. Дууны агуулга иймэрхүү ажээ.

Баатар

Анна Мария минь нар мандлаа,

Анна хайрт минь гэгээ гарлаа,

Манан арилж шувууд жиргэлээ

Миний хайрт Анна чи босож үз дээ!

Анна минь бос, үүр гэгээрчээ

Анчны брээ хангинахыг дуулав уу?

Ой мод, хад цохио, дуган цууриатаж байна.

Анна Мария минь босож үз, нар манджээ!

Вамба

Амраг Гибаль минь эрт байна.

Амтаг нойрноосоо би сэрж болохгүй!

Сэрээд боссон хойно юу намайг

Сайхан зүүд шиг баясгах юм бэ?

Анчин бүрээгээ улам сайхан үлээг

Үүрийг шувуу жирргэн дуулж угтаг,

Нойрон дундаа би тэднээс жаргалтай байдаг.

Намайг зүүдэлж гэж Тибаль чи бүү андуураарай.

Хоёул дахилтыг дуулж гүйцсэний дараа Вамба, ---Сайхан дуу шүү. Салбдайн овоодойгоо барьж андгайлахад тун сайхан сургамж мөн. Гурт бид хоёр үүнийг их дуулдагсан. Урьд бид хоёр, хамт өссөн нөхөд, одоо тэр харин бурхны өршөөл, эзний энэрлээр өөрөө өөртөө ноён, эрх чөлөөт хүн болжээ. Нэг өдөр бид энэ дуны аянд автаж, нойрмогоор аялан бүтэн хоёр цаг хэвтэж орхиод сайн аахуулсан билээ. Түүнээс хойш энэ аяыг дуулахын хамт яс минь янгинаад явчихдаг юм. Гэхдээ эрхэм таны тааллыг даган, би Анна Мариягийн хэсгийг дуулав аа гэв.

Тэгээд салбадай өөрөө өөр дуу гаргасанд баатар аяыг нь дагаж дэмжив.

Баатар Вамба хоёул

Хуучны дуунд өгүүлснээр

Хөгжүүн сайхан харчуул ирж

Бэлэвсэн Викомбаг бэр гуйж гэнэ.

Бүтэлгүй хариу өгч бүсгүй ер чадах уу?

Тэгээд эртний дуунд өгүүлснээр

Тиндалийн баатар бас байлцжээ.

Өвөг дээдсийн алдраар түрээ барьжээ.

Өнөөх бүсгүй татгалзах аргагүй байжээ.

“Эцэг минь ноён, өвөг минь тайж” гэж

Ихэмсгээр баатар гайхуулж гарчээ.

Сайхь эмэтэй зоримог татгалзахыг дуулж,

Сайрхуу баатар мөрөөрөө тонилжээ.

Вамба

Балар эртний дуунд өгүүлснээр

"Би Уэльсийн удам" гэж нөгөө нь хэлжээ.

Удам судар сантай гэж сүрхий андгайлжээ.

Үгүй гэх арга бүсгүйд алга байжээ.

"Иорган Гриффит хью Даюд Йюдер Рейс билээ би" гэж

Машид сүржин яриагаар эхэлж гэнэ.

"Өдий олон хүнтэй яаж зэрэг ханилах билээ би" гэж

Өнөөх бүсгүй даруухан өчиж гэнэ.

Өнө эртний дуунд өгүүлснээр

Өөр нэг нь Кентийн тариачин байжээ.

Олз омгоо бүсгүйд тоочин ярьжээ.

Үгүй гэх ам түүнд алга байжээ.

Хоёул

Хоёр тайж хоосон буцжээ.

Харин тариачны тухай бид дуулсан,

Кент нутагтаа тэр олз омогтой суудаг гэнэ

Хэрхэвч үгүй гэхийн ам байх аргагүй гэнэ.

- Нандин царсны зочломтгой эзэн юм уу, түүний багш нариганч гэлэн Йоменуудын магтсан чиний энэ дууг сонсоосойгэж би хүсэж байна гэж баатрыг өгүүлэхэд Вамба хариуд нь,

- Би үүнийг ер хүсэхгүй байна. Таны наад мөрөвчнөөс унжиж байгаа эврийн оронд яахав юм биз дээ гэв.

- Энэ чинь Локслийн нөхөрсөг сайхан сайхан сэтгэлийн бэлэг, харин үүнийг ашиглах хэрэг надад бараг гарахгүй болов уу? Гэхдээ хрээг болбол үүнийг үлээгээд охихын хамт тэр алдарт йоменүүд бүхэл бүтэн багаараа тэнхрүүлэхээр гарч ирнэ гэдэгт би итгэж байна гэв.

- Энэ эврийн ачаар биднийг тэд хэдийд боловч хохиролгүй өнгөрөөхийг би мэдэхгүй байсан ахул, бурхан өршөөж хэлтрүүл гэх билээ гэж салбадай сөргөв.

- Чи юу гэж хэлэх гэж байна? Нөхөрсөг сайн сэтгэлийн энэ тэмдэг үгүй ахул тэд нар биднийг дайрна гэж чи бодож байна уу? гэж баатар асуулаа.

- Би юу ч хэлэхгүй, ганцхан чулуун хана төдийгүй ногоон навчих бас чихтэй байх нь буй... Харин эрхэм баатар та нэг оньсого тайл. Ямар цагт дүүрэнд орохноо хоосон дарсны шилтэй, цүдийтэл дүүрэнд орвол шалчгар хоосон хэтэвчтэй явбал дээр байх вэ? гэлээ.

- Хэзээ ч дээр байхгүй байхаа гэж надад санагдана гэж баатрыг өгүүлэхэд,

- Ийм хариултын төлөө чамд дүүрэн шил, цүдийсэн хэтэвчийн алиныг ч эс хялайлгавал таарна. Шилийг Саксон хүнд дамжуулахаасаа өмнө хоосолж, мөнгийг ногоон ой руу явахаасаа өмнө гарган гэртээ үлдээвэл дээр байдгийг мэдтүгэй гэлээ.

Дүүжлээстэй цоожин сүлдэт баатар, чи тэгэхлээр манай нөхдийг жинхэнэ дээрэмчид гэж тоойож байгаа юм биз дээ? гэж асуувал,

Үгүй, өршөөлт эрхэм минь би тэгж хэлсэн гэж үү? Хүн хол аянд мордох ахул, хэтэвчийг нь авч орхивол моринд хөнгөн, аль гай зовлонгийн үндэс болсон зүйлээс ангижруулах ахул амь насаа аврахад өөрт нь хялбар болно. Иймээс тиймэрхүү тус үзүүлж болох хүмүүсийг би муу үгээр хараахгүй байна. Ганцхан сайн банаат хүмүүст илүү ажил удахгүйн тулд замынхаа богцыг гэртээ үлдээж хэтэвчээ мөн авдрандаа нуудаг гэв.

- Чиний ингэж ярьж байгааг үл харгалзан бид тэдний төлөө мөргөх учиртай, найз чинь гэхэд,

- Тэдний төлөө залбирахад ч би үнэн голоосоо бэлэн байна. Тэгэхдээ энд биш хотод залбирсан нь дээр гэж Вамба хэлээд – Аягүй бол нөгөө шамбалын оронд тэд царсны хонгилд

суулгаад мөргөл уншуулсан ламтай адил муу юм бидэнд ч учруулж мэдэх талтай гэв.

- Вамба чи юу дуртай үгээ хэл, гэхдээ тэр йоменүүд Торкильстонд чиний эзэн Седрикэд их тус хүргэсэн дээ гэж баатрыг өгүүлэхэд,

- Тэр үнээн, гэлээ ч гэсэн ялгаагүй бурхан багштай тооцоогоо хийдэг тэр үндсэн дээрээ л хөдөлсөн дөө гэж Вамба хариуллаа.

- Юун тооцоо вэ, Вамба? Алив яриач гэж хамт яваа хүн нь шаардсанд салбадай хариуд нь,

--Юун тооцоо вэ гэвэл, миний хөгшин нярав дансаа нэрэлдэгчлэн тэд бурхантай давхар тооцоо хийдэг юм. Тэр нь аль болох бага өгч ихээхэн шүү авахад оршино. Сайн үйл бүхэнд төлөөс бий гэсэн ариун номын ёсоор бүрэн гүйцэд эдэлнэ гэж тэд боддог байхаа гэхэд нь,

- Вамба чи үлгэрлээд тайлбарла, би тооны ухаанд муу тэр талаар юу ч мэддэггүй хүн гэж баатар хэллээ.

Вамба хариуд нь, - Та юм гадарлахдаа тийм муу юм болж гэм, тэр шударга эрчүүл тоог тэнцүүлж, сайн үйл бүхнийхээ хирээр арай муу юм үйлддэг болохыг өршөөлт эрхэм танд хэлж өгье. Жишээ нь гуйлгачин гэлэнд нэг мөнгөн зоос өгөөд тарган ламаас зуун алтан зоос авах... эсвэл ядуу бэлэвсэн эхнэрийг мөнгө цаасаар туслаад сайхан хүүхэн ой дотор барьж үнсэх ухаантай гэтэл баатар үгийг нь таслан,

- Энэ хэргүүдийн чинь аль нь сайн, аль нь сайнгүй юм бэ? гэж асуулаа.

- Үгүй харин сүрхий оньсого байна даа? гэж Вамба дуу алдаад, - Ухаалаг хүнтэй явахад оюун санаа хурдан гүйх болдог нь хартал илт байна. Эрхэм баатар та хэзээ ч бүдүүн даяанчтай шөнөжин согтуурч наргихдаа хүртэл үүнээс ухаалаг юм хэлээгүй гэж би андгайлахад бэлэн байна... За яриагаа үргэлжлүүлье. Манай ойн найз нар заримда ядуу хүнд байшин барьж өгөх мөртлөө зэргэлдээх цайзыг шатааж орхино. Дуганын дээврийг засаад, тахилын савыг ухна, ядуу хүнийг шоронгоос гаргах мөртлөө бардам шүүгчийн учрыг олж орхино. Үүнийг хэлэхэд Саксон тайжийг сулаж тавихдаа норман бээлийг нь шгааж хаяна. Сайн санаат хулгайчид, хмгийн эелдэг дээрэмчдэд хэлэх үг алга, гэхдэ ихээхэн нүгэл сэтгэлийг нь зовоож байх цагт тэдэнтэй учирвал дээрдээ гэв.

- Яагаад тэр вэ, Вамба? гэж баатрыг асуухад,

- Яах вэ тийм цагт тэдний дотор гэмшил төрж бурхны өмнө нүглээ цагаатгахад бэлэн байдаг юм. Харин тэд тэнгэртэй эвлэрч гүйцээд өөрсдөө тооцоо тулгаж байгаа хүнийг бол ч бурхан өршөөг дөө хөөрхий. Тэднийг Торкильстонд тийнхүү буянт үйл үйлдсэний дараа гарт нь өртсөн явуулын хүн муугаа үзнэ дээ... гэлээ гэхдээ Вамба дуугаа намсган, баатар руу ойртож,

- Явуулын хүнд манай дээрэмчдээс илүү халтай этгээдүүд бий юм шүү гэв.

- Хэн юм бэ тэр этгээдүүд? Манайд чинь чоно баавгай ер байдаггүй шүү дээ? гэж баатар хэллээ.

Тиймээ, гэхдээ манайд чинь Мальвуазенгийн зэвсэгтэй зарц нар гэж байдаг, дотоодын самуунтай цагт тав зургаан тийм сайн эрчүүл чинь бүхэл бүтэн сүрэг лут чононуудтай тэнцэнэ шүү. Та үнэмшиж үз. Тэд одоо олз омог хайж гарсан Торкильстоноос зугтаасан цэргүүд бас тэдэнтэй цуг шинжилж яваа. Иймд тэдэнтэй дайралдах юм болж гэм Торкильстод эр зориг гаргасны төлөөсийг хүндээр төлөхөд хүрэх вий. Эрхэм баатар гуай, хоёрын зэрэг тийм этгээд бидэнтэй дайралдлаа гэхэд та яах вэ? гэхэд,

- Тэд бидний замыг хөндөлдөх гэж оролдвол муусайн шааруудыг жадаараа газартай хадаж орхино доо Вамба гэв.

- Тэд дөрвүүл байвал яах вэ?

- Мөн ялгаагүй жадаараа хишиг хүртээнэ.

- Тэд зургуул, бид одоогийнх шигээ хоёулахнаа байвал та Локслийн эвэр бүрээний тухай санахгүй гэж үү? гэж Вамбаг асуухад,

- Олигтойхон ганц баатар намрын навчис хийсэх гэж байгаа салхи шиг хөөж охих тийш новшнуудын эсрэг үзэлцэхэд тусламж гуйж байх гэж үү? гэж баатар дуу алдав.

- Тэгвэл айхавтар чанга дуугардаг тэр эврийг сайтар үзэх зөвшөөрөл танаас гуйя гэж хэллээ.

Баатар мөрөвчнийхээ тээгийг тайлж, зам яваа хүнийхээ сониуч хүслийг ханган эвэр бүрээгээ өгсөнд Вамба даруй хүзүүндээ зүүж орхив.

- Хө-хө-хө! Одоо би ч гэсэн хүнээс доргүй нөгөө дохиог бүрээдэж чадна гэж Вамбаг хөөрөхөд,

- Уухай, тийм бий, муу зальхай амьтан! Аль тэр бүрээ нааш нь өг! гэж баатар хэллээ.

- Эрхэм баатар бүү сэтгэл зов, би хаяж үрэгдүүлэхгүй. Эр зориг мангуу, хоёр цуг аялж явахад эврийг мангууд зүүлгэвэл зохино. Юу гэвэл бүрээдэхдээ илүү сайн байдаг юм гэв.

- Аядаарай муу зальхай, чи хэтэрхий их маяглаж байна шүү! Миний уурыг хүргэв ээ, сайхан мэдээрэй гэж Хар баатрыг өгүүлэхэд,

- Эрхэм баатар та намайг бүү сүрдүүл гэж салбадай хариулаад уурссан баатраас нилээд холдож, тэгвэл мангуу зугтааж арилаад эр зоригийг ой дотор өөрөө замаа хайх болгоно шүү гэв.

- Үүгээр чи намайг чадлаа аргагүй үнэн. Тэгээд ч үнэнийг хэлэхэд чамтай муудалцах зав надад алга. Яах вэ, эврээ авч бай, харин бушуухан яв гэж баатар өгүүлэв.

- Та намайг гомдоогоод байхгүй биз? гэхэд,

- Гомдоохгүй гэж байна шүү, муу зальхай амьтан гэв. Вамба хулгасхийн дүүжлээстэй цоожин сүлдэт баатарт ойртож,

- Үгүй эхлээд та баатар хүний ам өг гэхэд,

- За чамд баатрын ёсоор ам өгье. Одоо бүү саатуул, зам удирд гэв.

- За яамай гэж салбадай дуртайяа баатар руу ойртож.. За тэгвэл эр зориг дахиад маанагтай нөхөрсгөөр зэрэгцэн одъё. Хэргийн учир гэвэл таны нөгөө бүдүүн даянчийг байлгасан шиг тэгж алгадуулахад би дургүй юм. Багштан тэгэхэд мэргэн оногдсон түүдэг шиг хөсөр өнхрөөд явчихсан шүү! За мангуу нэгэнт эврийг авсан хойно, эр зоригт жаахан гар хөлийнхөө чилээги гаргаж, арслан зогдороо сэгсэрч үз. Би эндүүрээгүй бол тэр бусдын дотор сайн эрчүүл биднийг хүлээж байна. Биднийг өртжээ.

- Чи яагаад тэгж бодов? гэж баатар асуухад,

- Ногоон мөчрүүд дотор, нэг, хоёр ч удаа дуулга гялсхийхийг хараад тэгж бодлоо. Шударга улс байсан болж гэм ил зөргөөр явах учиртай. Тэр төгөл чинь иймэрхүү ажилд харин яг тохирсон газар даа гэв.

Ингэж амжсан нь сайн боллоо.Юу гэвэл яг тэр агшинд замын хажуугийн бутнаас баатрын толгой цээж рүү харвасан гурван сум шүнгэнэн ирэв. Эхний нь сумт дуулганы ган халхавчинд тусаж халтираагүйсэн бол лав тархийг нь шувт харвах байлаа. Нөгөө хоёр сум тольт гарт нь байсан бамбай хоёрт тусав.

- Зэвсэгчид гялайлаа, миний хуяг дуулгыг бат хийжээ. Вамба урагшаа! Эдэнтэй үзэлцье гэж баатар хашгираад шууд бут руу давхилаа. Төгөл дотроос өөдөөс нь зургаа долоон морьтой хүн гарч, жадаа бөхийлгөн хар хурдаараа дайрав. Гурван жад баатрыг хатгаад ан цамхаг мөргөсөн адил үйрээд явчихлаа. Хар баатрын нүд халхавчны нарийн хараавчийн цаанаас хилэнгээр дүрэлзэж дөрөөн дээрээ ихэмсгээр босоод,

- Энэ юу болж байна? гэж зандарлаа

Хариу хэлэхийн оронд цаад дайчид илдээ хуга татан: Хар эзэрхий үх! гэж дуу алдан тал талаас нь дайрав.

- Уухай! Май тэгвэл, май тэгвэл! гэж хар баатар дуу алдах бүрдээ нэг хүн хөсөр өнхөртөл буулган – Манай энд бас урван тэрслэгчид бий болоо юу? – гэлээ.

Дайснууд зоригтой хэдий авч цавчих бүрий үхэл авч ирэх хүчирхэг газраас арга буюу ухрав.Ганцаар бүх дайснуудаа дарах төлөвтэй харагдана. Тэгтэл өнөө хүртэл холхон байж байсан цэнхэр хуяг дуулгатай баатар дайрч ирлээ. Тэр хүн морио давиран ухасхийж жадаа баатар руу биш морь руу нь чиглүүлэн сайн хөлгийг үхлүүт шархдуулав.

Морио хажуулдан унаж өөрийгөө мөн унагаахад Хар баатар:

- Энэ чинь адгийн хорон арга шүү!гэж хашгирлаа

- Яг энэ үеэр Вамба бүрээ татлаа. Уул хэрэг явдал маш хурдан болсон тул тэгэх зав өнөө хүртэл түүнд байсангүй. Бүрээний гэнэтийн дуу алуурчдыг дахин ухрахад хүргэлээ. Вамба

зэр зэвсэг муутайгаа үл харгалзан урагшаа дайран орж хар баатарт тусалж босгов.

Тэргүүлэгч нь бололтой цэнхэр хувцаст баатар – Адгийн муусайн хулчгарууд та нар ичихгүй байна уу? Энэ салбадайн дэмий үлээсэн жирийн нэг эвэр цоорны дуунаас айж зугтаах гэж үү? гэж дуу алдан,

Энэ үгэнд тэд зориг орж нуруугаараа бүдүүн царс түшээд ганц сэлмээр үзэлцэж байгаа хар баатар руу дахин дайрлаа. Хорон санаат баатар хүчирхэг дайснаа тал бүрээс довтлох өстөнөөс самбаачлан хамгаалж байгаа үеийг ашиглан өөр жад барьж модтой хадаж орхихыг завдан хар хурдаараа ухасхийв. Гэтэл Вамба энэ удаа ч мөн садаа боллоо. Гойдын чадалгүй авч Вамба сүрхий овжин тул дайчид өөрийг нь хайхрахгүй байгааг ашиглан Цэнхэр хувцаст баатрын морины хөл рүү илдээрээ цавчин довтолгоогий нь саатуулж чаджээ. Морь хүн хоёр хөсөр өнхрөв. Хөлөөсөө толгойгоо хүртэл зэвсэглэсэн дайчид тал бүрээс нь тэвдүүлэх тул Хар баатрын байдал маш аюултай хэвээр ажээ. Илдээрээ довтлогчдоос зогсолтгүй хамгаалан тамир нь барагдаж эхэлж байтал гэнэт мэргэн сум өстөнгүүдийн нь хамгийн томыг унагаагаад орхилоо. Тэр даруй Локсли, наргианч гэлэнгийн удирдсан олон йоменүүд ойн цоорхой руу дайран ирж тулалдаанд шууд оролцон үл бүтэх этгээдүүд төдөлгүй толгой дараалан алагдах нь алагдаж, зарим нь үхлүүт шархтай хэвтэж байв.

Аврагчдынхаа ач тус болсонд талархахдаа Хар баатар маш ихэмсэг сүртэй ажээ. Урьд ийм байдал ер үзүүлээгүй болохоор цаадуул нь дээгүүр хэргэмтэй гэж санахаасаа илүү зоригт дайчин эр л гэж санаж байжээ.

- Үнэнч зүтгэлт нөхөддөөгүн талархаж байгааг илэрхийлэхийн өмнө энэ гэнэт гарч ирсэн дайснууд хэн болохыг мэдэх надад их чухаг байна. Вамба чи цэнхэр баатрын дуулганы халхавчийг сөхөөд орхи, тэр энэ бүлгийн ахлагч бололтой гэв.

Салбадай алуурчдын тэргүүлэгч рүү гүйж очив. Тэр нь мориндоо дарагдаж унахдаа бэртээд зугтаах эсэргүүцэх ч чадал үгүй болсонг байжээ.

- За эрэлхэг дайчин минь, би чиний морь маллагч болсон шиг дагуул чинь болоод үзье. Би чамайг мориноос буулгасан, би мөн дуулгыг чинь тайлж өгнө дөө гэж Вамба хэлээд цэнхэр баатрын дуулгыг тун ч эрээ цээргүй хуу татвал олны өмнө буурал үс, ийм байдалд үзнэ гэж Хар баатар огт бодоогүй танил царай гарч ирэв.

- Вальдемар Фицурс! гэж тэр гайхан дуу алдаад, - Чам шиг өндөр хэргэм, сайн нэртэй хүнийг ийм булай хэрэгт юу хатгаж оролцуулав? гэвэл, олзлогдсон баатар өөдөөс нь эгцлэн харж,

--Ричард эрх ямба эрмэлзэх, өшөө хорсол тайлах сэтгэл юунд хүргэж болохыг мэддэггүй бол хүнийг таньж мэдэхдээ муу л байна даа гэлээ.

- Өшөө хорсол тайлах гэнээ? гэж Хар баатар давтан хэлээд, --Үгүй би хэзээ ч чамайг гомдоож яваагүй шүү дээ. Юун төлөө надад өширхөж байгаа хэрэг вэ? гэхэд,

--Чиний суухыг татгалзсан охиныхоо төлөө тэрээ, Ричард. Чиний адил өндөр сурвалжит норман хүнд энэ чинь хүнд доромжлол биш үү? гэв.

--Чиний охин гэнээ? гэж Хар баатар асуугаад, -Цус урсган дайсагналцахад хүргэнэ гэхэд хачин л шалтаг байна. Эрхмүүд ээ, хойшоо болцгоо, би энэ хүнтэй ганцаарантай нь ярилцах хэрэг байна. За Вальдемар Фицурс одоо яг үнэнээ ярь, үнэнээ хүлээ, энэ урван тэрслэх явдал руу хэн чамайг түлхэв? гэхэд,

- Чиний эцгийн хүү.Эцгийнхээ үгийг дуулдаггүй байсан гэж тэр чамайг цээрлүүлж байгаа нь энэ билээ гэж Вальдемар хариулав.

Ричардын нүд хилэгнэн дүрсхийсэн боловч сайн сэтгэлээр уураа дарлаа. Духаа барьж, бардам зан ичих хоёр хослон илрэн дийлэгдсэн бээлийн царайг ширтэн хувь хиртэй зогслоо.

- Вальдемар чи өршөөл гуйхгүй юу? гэж хааныг асуухад,

- Арслангийн саварт орсон хүн өршөөл гуйгаад ашиггүйг мэддэг билээ гэж Фицурс хариулав.

- За тэгвэл гуйлгагүйгээр өршөөл үз. Арслан үхэдлээр хооллодоггүй юм. Амь гасыг чинь хэлтрүүлэе, гэхдээ чи гурав хоногийн дотор Англиас зайлж шившгээ норман цайзандаа очиж нуухаар од, мөн энэ итгэл эвдсэн олхиогүй хэрэгтэй уялдуулан Анжуйн Жоны нэрийг хэзээ ч дурсахыг бүү зүрхэл гэдэг болзол тавина. Миний тогтоосон хугацаанаас хойш англи нутагт байж байх ахул үхэх болно. Манай гэр бүлийн нэр төрийг өчүүхэн ч болов үг цухуйлган гутаах ахул сүм хийдэд ч гэсэн надаас нуугдаж, миний гараас гарч чадахгүй гэдгийг гэгээн Георгийн нэр барьж андгайлъя! Чамайг би өөрийн чинь цайзны цамхагнаас хар хэрээний идэш болгон дүүжилж орхино шүү... Локсли танай йоменүүдийн суларсан морьдыг барьж, ирсэн харагдана. Энэ баатарт нэг морь өгөөд гэм хоргүй тавьж явуул! гэлээ.

- Үг дуугүй дагах учиртай хүний дуу гарч байна гэж би бодоогүйсэн болж гэм энэ новшийг урт аяны бэрхшээлээс ангижруулахын тулд нэг сайн сум хойноос нь дуртай тавихсан гэж йомен хариулав.

- Локсли чи жинхэнэ англи сэтгэлтэй хүн юм. Миний үгийг дагах учиртай чи зөв зөгнөжээ. Би английн хаан Ричард байна! гэж Хар баатар өгүүлэв.

Арслан зоригт Ричардын өндөр хэргэм, эрхэм дээд зан чанартай дүйж агуу сүртэй хэлэгдсэн энэ үгийг дуулмагц бүх йоменүүд нэгэн хүн мэт өвдөг сөгдөж албат харьяатын хүндэтгэлээ илэрхийлэн гэм буруу хэрэг үйлдсэнийхээ төлөө өршөөл уучлал үзүүлэхийг хичээнгүйлэн гуйв.

Ричардын царайд гэнэт хилэгнэх дүр үгүй болж, йоменүүд рүү найрсгааг харан-Босоцгоо нөхөд минь, сайн нөхөд минь босоцгоо! гэж өршөөнгүй өгүүлээд –Та нар Торкильстон цайзны хэрмэн дээр миний гайд учирсан албатуудад үнэнчээр зүтгэн тусалсан хийгээд эзэн хаанаа өнөөдөр аюулаас аварснаар ой мод болон ил талд та нарын зоргоороо аашилж байсныг цагаатгалаа. Миний харьяат нар босоцгоо, цаашид ч мөн надад үнэнч сайн албатууд байгтун. Зоригт Локсли чи.. гэтэл,

- Эзэн хаан та намайг цаашид Локсли гэж бүү дууд, ихэд цууд гарсан болохоор эзний өндөр дээд сонорт ч мөн хүрсэн байж мэдэх нэрийг минь мэдтүгэй... Би Жервудийн ойн Робин Гуд

билээ гэв.

- Тэгвэл дээрэмчдийн хаан, сайн эрчүүлийн толгойлогч байх нээ? Ийм нэрийг мэдэхгүй хүн хэн байх вэ. Бүр Палестин хүртэл цууриатсан шүү! Гэхдээ цуут дээрэмчин минь миний үгүй хойгуур, түүнээс болон самуун цагийн дундуур үйлдсэн хэргийн ганцын ч төлөө чамаас ял асуухгүй гэдэгт итгэж болно гэлээ.

Вамба ярианд ердийнхөөрөө арай хамжааргатай байдлаар оролцож,

- Муур яваад өгсөн хойно хулганад зовох юмгүй гэдэг цэцэн үг аргагүй үнэн юм даа гэв.

- Өө Вамба чи мөн энд юм уу. Би аль түрүүнээс хойш чиний дууг дуулдахгүй болохоор зугтааж амь зулбасан юм байх л гэж санаж байлаа шүү дээ гэж Ричард хэллээ.

- Би зугтааж амь зулбана гэж үү? Тэр ч хол байнаа? Мангуу, сайн дураараа эр зоригоос салж байхыг хаана үзсэн юм бэ? Миний илдний ирэнд өртсөн сайхан бор морь тэр хэвтэж байна. Уг нь энэ эрүүл саруул зогсож, эзэн нь хэвтэж байсан бол дээр байхсан. Эрээн хүрэм гэдэг ган хуягтай адил хурц жаднаас сайн хамгаалдаггүй болохоор би эхлээд жаахан базаахгүй байсан нь үнэн.

- Тун чухаг цагт гээч, Вамба. Чиний үнэнч сэтгэлийг би мартажгүй гэж хаан хэлэв.

Хааны хажуухан нүглээ наманчилъя, нүглээ наманчилъя гэж нэг хүн латинаар хүлцэнгүй дуугараад-Бусад Латин цөм толгойноос гараад явчихлаа! Асар хүнд нүглээ би өөрөө гэмшин наманчилж, намайг цаазлахаар авч одохын өмнө нүгэл хилэнцийг минь хэлтрүүлэхийг л ганц гуйя гэв.

Ричард эргэж харвал наргианч даянч сөхрөн сууж эрихээ эргүүлэх бөгөөд саяхны нүдэлдээнд багагүй хөдөлсөн бороохой хажууд нь ногоон дээр хэвтэж байв. Өөрийн нь бодлоор гүнээ хэлмэгдэн гэмшсэн харагдах царай гаргаж, нүдээ эргэлдүүлэн, хоёр завжээ Вамбаагийн хэлснээр хавтаганы бүч шиг доош унжуулжээ. Гэхдээ ийнхүү гүнээ гэмшин буйн бүх шинж цаанаа итгэл муутай даянчийн царай юу юугүй инээд алдчих гээд байх байртайгаас гадна нүд нь сэргэлэн гялалзаж, хэлмэгдэж гэмшиж байгаа нь үзтэл хуурмаг байлаа.

- Дүрсгүй гэлэн чи юундаа ингэж гутарч орхив! Эх дагина болсон Дунстан гэгээнд хир хичээнгүйлэн мөргөдгийг чинь танай хамба лам мэднэ гэж айж байна уу?... Битгий ай анд минь, Английн хаан Ричард лонх дарс уулгаж суугаад орж мэдсэн нууцаа хэзээ ч задруулдаггүй билээ гэж Ричардыг өгүүлэхэд (Рочин Гудийн тухай ардын дуульд дуртай бүхний Тук гэлэн гэж мэддэг) даянч хариуд нь,

- Үгүй гэгээн дээд эзэн минь, хамбын бэрээ биш хааны балтнаас би сүрднэм. Миний энэ нударга дээд тэнгэрийн төлөөний хүний чихэнд аймшиггүйгээр хүрч алдас болсныг санахаас хэлмэгдэж байна гэв.

Ричард, -Ха-ха! гэж инээд алдаад-Мөөн тэр тухай зовж байгаа юм бий дээ! Түүний дараа өдөржин чих дөжрөөд байсан боловч тэр алгасаныг чинь би бүр мэдэж орхиж. Айхавтар

буулгасан үнэн хэдий боловч эдгээр сайн хүмүүсээр гэрч татахад би чамд мөн тэр янзаар хариу бариагүй гэж үү? Гэхдээ намайг өөртөө бас л өртэй гэж үзэж байгаа бол одоохон... гэтэл,

- Өө үгүй шүү, хариултыг та гүйцэд, бүр давуулаад өгсөн билээ! Их эзэнтэн та бурхны ивээлээр бүх өрүүдээ тэгж яв цав төлж байх болтугай! гэж гэлэн хариулав.

- Дандаа л нударгаар өрөө таглаад байж болдогсон болж гэм миний авцаатангууд сан хөмрөг хоосорч гүйцсэнд гомдол гарахгүйсэн билээ гэж хаан өгүүлэв.

Даянч дахин уруу царайлж, - Гэлээ гэхдээ тэр бурхан номд харш алгадалтын төлөө надад ямар цээрлэл ирэхийг би мэдэхгүй байна гэж хэлэхэд хаан хариуд нь,

- Тэр тухай ярих ч явдал байхгүй анд минь.. Элдэв буруу номтон, тэсрлүү этгээдүүдийн гараас өчнөөн төчнөөн цохилт үзэж явсан болохоор Компангерстийн тахилчин шиг ариун явдалт хүний ганцхан алгадсанд гоморхоод байх шалтгаан байхгүй. Харин би чамд санваараа тайлах зөвшөөрөл олж өгөн, урьд Дунстан гэгээний бурхан тахилыг хамгаалж байсан шигээ бидний биеийг хичээнгүйлэн хамгаалуулахаар шадар цэргийнхээ тоонд оруулж авбал өөрт чинь ч, ариун сүм хийдэд ч дээр биш юм биз? гэлээ.

Гэлэн үүнд, - Эзэн хаантан та намайг өршөөж, тийм хайр хишиг хүртээхгүй байхыг хичээнгүйлэн гуйя. Намайг ер хичнээн их залхуу амьтан болсныг та мэддэгсэн бол уу! Дунстан гэгээн (бурхны өмнө биднийг өмгөөлөх болтугай) намайг ямар нэг буга хөөцөлдөж яваад заримдаа мөргөх залбирахаа мартаж орхиход гүнгэрваандаа тайван заларч л байдаг юм. Мөн дэмий ажил эрхлэн шөнийн цагаар дуганаа орхин явах удаа байдаг. Дунстан гэгээн ер юм гэхгүй! Модоор сийлсэн хэдий авч хамгийн тайван эзэн, үнэнхүү амгаланг тогтоогч мөн буюу. Би эзэн хааныхаа дэргэд бие хамгаалагч, йомен боллоо гэвэл их л нэр төртэй сайхан өршөөл гэхдээ намайг ойд очиж ан хийхээр жаахан холдоод орхихын хамт л бөөн эрэл болж: "Нөгөө шуналын нохой гэлэн хаашаа алга болчихов?" гэх юм уу "хараал идсэн муу Турк хаашаа алга болсон юм, хэн мэдэх вэ?" гэлцэх болно. За тэгээд ойн манаач нар бас. "Энэ муу санваараа авахуулсан шаар ганцаараа бүх анчдаас илүү олон ан хөнөөчихлөө гээч!" гэлцэнэ. Товчхон хэлэхэд өршөөлт эзэн минь намайг хуучин байранд минь орхиж үз. Компангерстийн Дунстан гэгээний ядуу санваартан надад өршөөл үзүүлэх, буян үйлдэх таалалтай байгаа бол алив бэлгийг гүнээ талархан хүлээж авна гэв.

- Ойлголоо гэж хаан дуугараад,-Шашны буянт санваартан яамд миний Варнклиффийн ойд ан агнах эрх олголоо. Гэхдээ харин улирал бүрд гурван хангал бугаас илүүт агнахыг зөвшөөрөхгүй. Гэвч энэ эрхээ чи урвуулан ашиглаж, гучаадыг намнах болно гэдэгт би христос шашны баатар Английн хаан хэргэмээ барьж андгайлахад бэлэн байна гэв.

- Тэр ч мэдээжийн хэргээ их эзэнтэн Дунстан гэгээний авралаар таны өгөөмөр хишийг арвижуулах арга би олно гэж даянч хариуллаа.

- Үүнд би эргэлзэхгүй байна анд минь. Английн мах дангаараа аргаад амт муутай байдаг болохоор чамд жил бүр нэг торх испани дарс, нэг торх мальвази дарс, гурван торх хамгийн сайн эль дарс авчирч өгч байх тушаал манай няравт өгнө. Үүгээр чи амныхаа цангааг

гаргахгүй байвал ордон руу очиж миний ордны даамалтай танил тал бодоорой гэвэл,

- Дунстан гэгээнд өөрт нь юм хайрлахсан бол уу? гэв.

- Дээр нь бас ёслолын овоодой, нарийн торгон жанч, бурхны ширээний бүтээлэг автугай гээд хаан загалмайлан залбирч за энэ тухай үг уралдуулахаа болжё. Мөргөл залбирал бурхны алдрыг мандуулахаас урьтаж хувийн наргиан цэнгэлийг бодон бурхныг хилэгнүүлэх явдалгүй гэхэд гэлэн баяртайгаар тосон авч,

- Өөрийнхөө тахисан шүтээний хувьд би баттай хэлж чадна !гэвэл,

- Чи зүгээр өөрийнхөө өмнөөс л хариулбал дээр бий гэж хаан ширүүн дуугаран балмагдсан гэлэнд даруй гараа сунгасанд өвдөг сөхрөн үнсэв.

- Миний тэнийлгэсэн гарыг чи зангидсанаас нь дор хүндлэх юмаа. Үүний өмнө зөвхөн сөхөрлөө, тэгэхэд зангидсаны нь өмнө газар тэрийгээд явчихсан билээ гэж хаан Ричард хэлэв.

Харин даянч иймэрхүү тоглоом тохуу яриа тэр болгон оновчтой байдаггүйг үзээд цааш үргэлжлүүлэхээс айжээ. Эзэд хаадтай ярилцах учрал тохиолдсон хүнд хянуур болгоомж огт илүү зүйл биш билээ. Иймд хариу өчихийн оронд хаантанд дор мэхийн мөргөөд гэдрэг ухрав.

Энэ үеэр тэдэн дээр хоёр шинэ хүн нэмж ирэв.

ТӨГСГӨЛИЙН ДӨЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Эр зоригт эрхмүүдийн амрыг эрье

Эд агуурсаар баян биш ч бид хэзээний наргианч

Хангал бугын билчээр болсон газарт

Харин тэнүүн сэтгэлээр та бүхнийг уръя.

Өршөөлт эрмхүүд минь өөдөө морилцгоо!

Макдональд

Шинэ ирэгсэд нь Ботольфийн ширээтийн гүүг унасан Уильфред Айвенго, баатрын өөрийн нь байлдааны хөлгийг унасан Гурт хоёр ажээ. Эзэн хааны хувцас хунар цус болсон, ойн цоорхойд түүнийг тойрон зургаа долоон үхсэн хүн байхыг хараад Уильфредийн гахйсан нь тун их. Ойн чөлөөт йоменүүд буюу дээрэмчид бололтой тул хаанд сүрхий аюултай бараа бологчид шиг санагдахаас өөр аргагүй олон хүн Ричардыг тойрон байгаад бас багагүй гайхав.

Ричардтай хааны ёсоор юм уу, хэсүүлчин Хар баатар гэж ярилцвал зохихын алиныг мэдэхгүй байтал хаан өөрөө түүнийг төвөгтэй байдлаас гаргаж,

Уильфред чи бүү ай, энд намайг Пантагенетийн Ричард гэж илээр нэрлэж болно, юу гэвэл

Дээрэмчдийн зоригт тэргүүлэгч урагш гарч, -Эрхэм Уильфред Айвенго гуай, их эзэнтний хэлсэн дээр нэмж хэлэх үг надад алга. Гэхдээ сүүлийн үед зовлон үзсэн хүмүүс дотроос хаан эзэнд биднээс илүү үнэнч шударга зарц нар үгүй байсан билээ гэж би бардам хэлье гэв.

- Сайн эр чи эдний нэг болохоор үүнд эргэлзэх юм алга гэж Уильфред хэлээд, -Үгүй энэ аймаар үзэгдэл чинь юу гэсэн үг вэ? Энэ юун үхсэн хүнүүд вэ, миний хаан эзний хуяг яагаад цус болно вэ? гэж асуув.

- Бидэн рүү урвагчид дайрсан юм. Айвенго тэгээд энэ зоригт эрчүүдийн ачаар урван тэрслэлт зохих залхаалт үзлээ гээд Ричард инээмсэглэв, -Ингэхэд чи ч мөн урвагж гэдэг нь дөнгөж сая миний санаанд орлоо, тэгэхдээ бүр хамгийн дуулгавартай урвагч мөн. Чамайг шархаа эдгэртэл Ботольф гэгээний хийдийг орхин мордож болохгүй гэж бид хатуу хориглоогүй гэж үү? гэлээ.

- Шарх эдгэрээд дөнгөж шалбархай төдий юм үлдсэн. Харин өндөр төрөлт эзэн хаан ганцаар аялж, илд жадны хирээр олох зүйлийг л үнэлж үздэг жирийн хэсүүлчин баатрын амь наснаас илүү үнэ цэнэгүй юм шигээр адал явдалд оролцон амь биеэ дүйж үнэнч зарч нарынхаа зүрхийг юунд шимшрүүлдэг юм бэ? гэж Айвенго өгүүлэв.

- Пантагенетийн Ричардад өөр алдар нэрийг үл эрэлхийлэх бөгөөд илд жадны ирээр олох зүйл надад хамгаас үнэтэй. Тийм сайн илдний ирээр ганцаар байгуулсан ялалтыг

Плантагенетийн Ричард зуун мянган цэрэг толгойлон байгуулсан ялалтнаас илүүд үзэж бахархагддаг билээ гэж хаан хэллээ.

- Хаантан та өөрийн төр улсын төлөө бодож болгоогтун. Улирах өдөл болгон таны оролцож таалдаг эдгээр тулалдаануудын нэгэнд эзэн хаанаа алдаж орхих юм болж гэм улсын дотор дотоодын дайн дэгдэж, таны албат нарт түмэн зовлон учрах аюул тулгарч байна гэж Айвенго өчив.

- Миний төр улс, миний албат нар гэнээ? гэж Ричард унтууцан асуугаад, Эрхэм Уильфред би тэнэг аашилж байгаа гэвэл тэд чинь мөн надад ийм хариу барьдаг юм гэхэд болно. Жишээ нь: Надад хамгийн үнэнч зарц Уильфред Айвенго гэж бий. Тэр миний зарлигийг дагахгүй мөртлөө хаан харин өөрийн нь зөвлөлгөөг ёсчлон дагасангүй гэж хааныгаа донгоддог билээ. Бид хоёрын хэн нь хэндээ гомдол мэдүүлэх шалтгаар илүү байна? За миний үнэнч Уильфред чи намайг уучлаарай, би өөрийнхөө ирснийг дэмий нууж байгаа хэрэг биш. Өчигдөр чамд Ботольфийн хийдэд тайлж өгсөнчлөн би хэсэг зууртаа нам чимээгүй байх учиртай. Миний хань нөхөд үнэнч албат нар цэргээ цуглуулж амжих чөлөө өгөхөд энэ хэрэгтэй бүлгээ. Юу гэвэл Ричард иржээ гэдэг хүн бүхэнд ил болох цагт дайсныг шууд сүрдүүлж, зэхэж бэлтгэсэн самууныг илд сугалалгүйгээр дарахуйц их цэрэг цуглуулсан байх учиртай юм. Эстотвиль, Богун хоёр Йорк руу хөдлөхүйц их цэрэг цуглуулж амжтал нилээд хоног хэрэгтэй. Эхлээд өмнө зүгээс Солсбери болоод Варвикск гүнгийн хошууны Бошангаас хэл авах хэрэгтэй. Дараа хойноос Мультон, Персигээс мэдээ дуулна. Энэ зуур ерөнхий захирагч ноён лондонгийн багтай дэмжлэгийг олсон байх учиртай. Миний гэнэт гарч ирэх явдал өөрийн минь сайн илд, Робины мэргэн сум, Тук гэлэнгийн бороохой, миний мэргэн Вамбагийн анчны эвэр бүрээтэй нийлээд намайг аварч эс чадах их аюулд учруулж болох биээ гэв.

Уильфред хүлцэнгүйгээр мэхийв. Эзэн хааныхаа эр баатрын цогтой хийморьлог авиртай тэмцэлдэхэд огт тусгүйг тэр мэдэж байлаа. Иймд залуу баатар санаа алдаад дуугүй болов. Ричард харин уул зэмэлийн зөвийг мэдэрч байсан авч түүнийг дуугүй болгосондоо их л сэтгэл халуун, Робин Гудтай яриа үүсгэв.

- Үгүй ингэхэд дээрэмчдийн хаан танайд чиний нэгэн зиндааны хаанд идэж орхимоор нэг юм олдохгүй биз, энэ урвагчид намайг их ажиллуулж хоол идэх дур хүргэчихлээ гэв.

Робин Гуд хариуд нь, -Үнэнийг хэлэхд их эзэнтэн танд худал хэлэх дургүй байна, хэлэх ч үгүй, манай хоол хүнсний гол нөөц... гээд хэлэхээ түвдэхгүй байх бололтой түгдэрлээ.

- Английн мах биз дээ лав? гэж Ричард хөгжилтэйгээр тосож хэлээд,-Түүнээс дээр ямар хоол байх билээ? Тэгээд ч хаан гэр орондоо тогтож суухгүй,ангаа өөрөө намнадаггүй ахул ангийн мах алагдсан хойноо дайралдлаа гэж онц их гомдоллох хэрэггүй бизээ гэв.

--Тийм болж гэм их эзэнтэн та Робин Гудийн багийнхны цуглардаг өөр нэг газар морилон гийгүүлбэл ангийн мах хүрэлцээтэй байх вий. Мөн даруулж уух аяга сайн эль, зэгсэн сайн дарс ч олдоно гэлээ.

Дээрэмчин тэргүүлэн зам удирдаж, хөгжилтэй хаан хойноос нь дагав. Робин Гуд түүний ойн нөхөдтэй ийнхүү санамсаргүй хоол идэх болсондоо хааны зоогийн ширээнд гял цал болсон

бараа бологчдын дунд өргөн найранд суухаасаа лав илүү баярлаж байгаа бололтой ажээ. Арслан зоригт Ричард шинэ хүмүүстэй танилцаж, гэнэтийн адал явдалд оролцоход юунаас ч илүү дуртай бүлгээ. Тэгэхдээ бэрх аюул тулгараад, түүнийг давах гэдэг түүнд амьдын жаргал байлаа. Хувийн эр чадлаараа олсон алдар нэр түүнд төр улсаа мэргэн бодлогоор засаж олох нэр алдраас хавьгүй үнэтэй ажээ. Иймд түүний хаанчлал нь огторгуйгаар харван өнгөрөхдөө нүд гялбам боловч хэрэггүй гэрэл цацруулаад харанхуйд замхран бүрмөсөн унтардаг солирын хурдан гялбаатай төстэй байсан билээ. Түүний баатарлаг гавьяа ерөөлч үлгэрчдэд түмэн дууны сэдэв болсон авч түүхчид хойч үед сургамж болгон өгүүлэх дуртай үр бүтээлтэй ямар ч үйл бүтээгээгүй билээ.

Харин одоо замд санамсаргүй учирсан хүмүүсийн дунд Ричардын хамаг сайн чанар илэрч, хөгжүүн наргианч сайхан сэтгэлтэй, алив гарал язгуур, хэргэм зэргийн хүмүүст ижил найрсаг сайн байлаа.

Аварга том царсан дор төрийн нь гол хуулиудыг зөрчсөн авч энэхэн үед бие хамгаалагчид, ордны бараа бологчид нь болсон хүмүүсээр хүрээлүүлэн английн хаанд бүдүүн бараг зоог яаравчлан төхөөрөв. Дуу, уран хошин үг, олз омогт зоримог, дээрмийн тухай сайрхуу яриа эхэлж түүндээ улайран эд бүгдийг жинхэнэ эзэн хааны өмнө ярьж байгаагаа хэн ч санахгүй болов. Өөрийн нэр хүндийг хадгалах гэж наргианч гэлэн бусдаас илүү бодсон юмгүй инээж, шалиг үг ярив. Робин Гудийн угийн суруул ухаан нь энэ наргианыг бушуухан дуусгах хүсэл төрүүлэхээс гадна бас Уильфред Айвенгогийн сэтгэл догдолж, хөмсөг зангидаж эхлэхийг тэр ажлаа.

- Манай эр зоригт эзэн хаантай цуг байх бидэнд хэдий их завшаан боловч өнөөгийн нөхцөл байдалд улс төрд асар үнэтэй цагаа бидний дунд байж үрээсэй гэж би үл хүснэ гэж Робин Уильфредэд шивнэлээ.

Уильфред мөн аяархнаар, - Сайн Робин Гуд чи зөв санаа гаргалаа. Тэгээд ер нь эзэн хааныг хэдий наргианч хөгжилтэй байх цагт боловч тоглоом тохуу болцгоох гэдэг нэг л цагт хумсаа гаргау наргианч хүнийг самардаад авч мэдэх арслангийн зулзагатай тоглохтой адил хэрэг билээ гэвэл,

- Үүнээс чинь л айж байна гэж Робин Гуд дуугараад,

- Миний хүмүүс төрсөн төрх, уг эрхэлдэг ажлаараа ширүүн дориун, хаан сэтгэл сайхантай боловч түргэн зантай. Юухнаар хилэнгий нь хөдөлгөчихөж болох, миний сайн эрс хилэгнэлийг нь хэрхэн өнгөрүүлэхийг урьдаас тааж гадарлах ч арга алга. Энэ наргианыг яаж ийгээд зогсоох цаг болсон санж гэв.

- За тэгвэл нэг арга бодооч, юу гэвэл миний тэр тухай цухуйлгасан үг улам удаашруулах уурыг нь хүргэж байна гэж Айвенго хэллээ.

- Ингэхэд би эзэн хаанаас дөнгөж саяхан хүртсэн өршөөл, хишгийг алдаж мэдэхээр хийх ёстой болж байна гэж Робин Гуд бодол болж дуугарахад, - За яах вэ, Христофор гэгээнийг барьж андгайлахад юу л болбол болог. Түүнийг алдахаас айгаад өөрийн нь ашиг тусын төлөө зүтгэхгүй байвал өршөөлийг нь хүртэх хувьгүй байхсан. Алив Скетлок явж тэр бутны цаана

очоод норманы дохио нааш нь бүрээд, бушуухан шиг хөдөлж үзэхгүй бол сайхан мэдээрэй!
гэв.

Скетлок тэргүүлэгчийн үгээр явж таван хувь өнгөрөөгүй байтал бүрээний нь дуу тасхийж найрлагсдыг сандран босголоо.

Тээрэмчин сэрдхийж, Энэ чинь Мальвуазены дохио байна гээд нумаа шүүрлээ. Даянч лонхоо унагаан бороохойгоо авлаа. Вамба нэг хошин үг хэлж байснаа тагларан илд бамбайгаа эрэв. Бусад хүмүүс цөм зэвсгээ барилаа.

Ийм аюул ослоор дүүрэн амьдрал эхэлж байгаа хүмүүс хоол унд идэж суугаад шууд байлдаанд орох удаа цөөнгүй дайралдах бөгөөд Ричардын хувьд бол ийм өөрчлөлт улам ч таатай зүйл билээ. Дуулга болоод хоол идэхийн өмнө тайлсан зарим юмаа авч ир гэж хашгираад өмсөхөд Гуртийг тусалж байх зуур зайлшгүй болно гэж тооцон байгаа энэ тулалдаанд үл оролцохыг Уильфредээс гуйж хилэгнэн сүрдүүлж байлаа.

Миний төлөө Уильфред чи зуу дахин тулалдсан, түүний гэрч би биеэр байна. Өнөөдөр Ричард өөрийн анд нөхөр, албатынхаа тухай хэрхэн үзэлцэхийг харж тайван суун намайг баярлуул гэв.

Тэр зуур Робин хүмүүсээ туршуулд гаргаж байгаа мэтээр тал тал тийш явуулж, наргиан ч тарж, найр бүрмөсөн дууссаныг үзмэгц бүрэн зэвсгээ агсаж гүйцсэн Ричард руу очин өмнө нь өвдөг сөхрөөд өршөөхийг гуйв.

- Бас юуны төлөө тэр вэ? гэж Ричард унтууцан асуугаад,

- Өмнөх бүх гэм бурууг чиньхэлтрүүлснээ бид дуулгасан биш билүү. Аль эсвэл чи бидний үгийг салхинд хийсэж явдаг өд шиг хөнгөн юм гэж санаж байна уу? Бодвол чи чинь түүнээс хойш арай бас буруутаж амжаагүй шүү дээ? гэхэд,

- Хэргийн учир гэвэл, эзэн хаанаа би өөрийн нь ашиг тусын тулд мэхэлснийг гэм нүгэлд тооцвол буруутан болох билээ. Бидний сая сонссон бүрээний дуу Мальвуазенгийнх огтхон ч биш наргианыг зогсоох бодлоор би өөрөө бүрээд гэсэн юм. Юу гэвэл өөр чухал ажлуудад хэрэгтэй үнэтэй цагийг чинь үрж байна гэж бодсон билээ гэж Йомен өчив. Ингэж хэлээд Робин босож гараа элгэндээ зөрүүлэн хүлцэнгүй гэхээсээ илүү хүндэтгэх байртай хааны юу гэхийг хүлээв. Өөрийн бурууг ухаарч байгаа боловч цэвэр сайхан сэтгэлийн үүднээс үйлдсэнээ бат итгэж байгаа нь илт байв. Ричардын царай хилэнгээр бадран улайв. Гэвч түргэн зуур дүрсхийсэн нь тэр бөгөөд шударга үнэнийг бодох сэтгэл даруй түүнийг дарав.

- Энэ чинь шервудийн хаан ангийн мах, дарсаа английн хаанаас харамласан хэрэг шив. За яамай зоригт Робин! Наргиант Лондод манайд зочлохоор очиход чинь би арай гар тавиутай эзэн байх бий. Гэхдээ сайн эр чиний зөв. За тэгээд мордож замдаа орьё! Уильфред ч тэсэж ядсаар бүтэн цаг болж байна. Сайн санаат Робин, чиний бүлэг дотор зөвлөлгөө өгөөд зогсдоггүу, алхам бүрийг чинь удирдах гэдэг, чамайг өөрийнхөө дураар хөдлөхийн хамт л золгүй хүний царай үзүүлдэг тийм дотно нөхөр чамд бий юу? Хэлээч? гэлээ.

Тэгэлгүй яах вэ, надад жижиг Жон гэдэг хочтой туслагч бий. Тэр одоо бидэнтэй цуг байхгүй, Шотландийн хил рүү холын ажилд явсан. Их эзэнтэн танд үнэнээ хэлэхэд түүний тулган зөвлөх надад тээртэй санагдах удаа олон. Гэхдээ эргэцүүлэн бодоод зөвхөн эзнийхээ ашиг тусын төлөө санаа зовдгийг нь мэдэх тул түүнд уурлаж чаддаггүй юм гэж Робин хариулав.

--Шударга Йомен чиний зөв. Миний нэг талд чухаг зөвлөлгөө өгч баргар, уруу царайлан хавчдаг Айвенго, нөгөө талд миний ашиг сонирхлын үүднээс намайг мэхэлдэг чи байх юм болж гэм христос шашинтай болоод буруу номын алив орны хаадын адил би зоргоороо хөдлөх боломжоор тун бага байхсан... За эрхмүүд ээ явах л болсноос хойш хөдөлье! Конингсбург руу сэтгэл тэнүүн хөдөлье. Энэ тухай дурсахаа больё гэж Ричард өгүүллээ.

Зам зуур ямар нэгэн отолт байвал даруй мэдэгдэх, бас тэр зүгт явуулсан, гэхдээ тийш очих зам лав аюулгүй байж таарна. Үгүй гэхэд та нарт аюулын тухай даруй сэрэмжлэн мэдэгдэнэ. Тэгээд ухарч, өөрөө толгойлон тийшээ хөдлөхөөр шийдсэн харваачдын хүчирхэг багтай нийлж болно гэж Робин Ричардад хэлэв.

Өөрийг нь аюулаас ийнхүү сэрэмжилсэнд Ричардын сэтгэл уярч, дээрэмчдийн тэргүүлэгчдийн хэрэглэж, өөрийг нь мордоход хүргэсэн залинд дургүйцэх сэтгэл бүрмөсөн арилав. Хаан Робин Гудэд дахин гараа өгч, өнгөрснийг нь бүрэн хэлтрүүлсэн, хойшид өршөөлтэй сайн байхаа давтан хэлээд мөн ойн хуулийг зоргоороо урвуулан хэрэглэсний гайгаар английн олон йоменүүдийг самууруулахад хүргэж буй явдлыг хязгаарлахаар хатуу шийдэж байгаагаа ярилаа.

Гэхдээ Ричардын сайн санаа зуурдаар эцэслэснээс нь болон биелэгдэж амжаагүй билээ. Ой модыг хамгаалах тухай болоод ангийн шинэ дүрмийг баатар ахыгаа нас барсны дараа хаан ширээнд суусан Жон хаан ихэд хатууруулсан бүлгээ. Робин Гудийн тухайд гэвэл түүний цаашдын хувь заяа, урван тэрслэгчийн гарт үхсэн тухай урьд нэгэн цагт ширхгийг нь хагас зоосоор худалдаж агсан гот үсгээр бичсэн хуучны дуунуудаас олж

өөрийнхөө эрх чөлөөнөөс илүү ихээр үнэлдэг гэж та намайг бодно гэж үү? Эсвэл мий эцэг үүнийг ганц охиныхоо нэр төрөөс үнэтэйд тооцох гэж үү? Эдгээрийг хвч үз, хатагтай. Эд надад огт хэрэг байхгүй, хойшид би хэзээ ч эрдэнийн чимэг зүүхгүй билээ гэв.

Ревеккагийн сүүлчийн хэлсэн үгний өнгөнд Ровена хирдхийн, - Тэгвэл та зовлонтой хүн юмаа? Үгүй манайд үлдээч дээ? Ариун номын багш нар таныг итгүүлж үнэмшүүлэн буруу шашныг чинь орхиулж чадна, би өөрөө таны эгчийн оронд эгч больё гэвэл Ревекка мөн л түрүүчийнхээ тайван гунигт дуугаар,

Үгүй, хатагтай тэр болшгүй зүйл. Эцэг дээдсийнхээ шашныг би очиж суух орныхоо цаг уурт тохируулан хувцсаа халах адил сольж чадахгүй. Тэгэхдээ надад зовлонтой байхгүй. Үлдэж байгаа амьдралаа зориулах гэж буй түүнийхээ таалалд би нийлүүлж чадвал тэр миний сэтгэл санааг тайтгаруулж өгөх болно гэв.

Ингэхлээр танайд бас сүм хийд байдаг, та тэгээд тэдний нэгэнд очиж хоргодох санаатай байгаа юм уу? гэж Ровена асуулаа.

Үгүй хагагтай гэж еврей бүсгүй хариулаад, - Гэвч манай ард түмний дунд Авраалын үеэс эхлэн манай өдрүүдийг хүртэл санаа сэтгэлээ бурханд, ажил хэргээ хүмүүсийн энэрэх сайн үйлд зориулсан бүсгүйчүүл байсан юм. Тэд өвчтөнийг асарч, өлсгөлөнг хооллож, ядууг тэтгэдэг юм. Ревекка мөн эд бүгдийг хийх болно. Хэрэв эзэн үхлийн савраас бүсгүйнхээ хувь зачаны тухай сонирхон асуух учрал гарвал үүнийг дуулгаж үзээрэй гэв.

Ревеккагийн дуу чичирхийлж өөрийн нь илэрхийлэх гэж бодсон зүйлээс илүү их юм илтгэсэн гүн их энхрийллийн өнгө цухуйлаа. Хүүхэн Ровенатай бушуухан салах ёс гүйцэтгэхийг яарав.

- Та сонсож бй, еврей христос шашинтан адилаар буй болгосон бурхан танд амьдралын хамаг сайн сайхныг өгөөмрөөр хайрлах болтугай. Бидний сууж хөдлөх хөлөг онгоц биднийг зогсоолд дөнгөж хүрмэгц л хөдлөх болно гэж Ревекка хэлээд өрөөнөөс гарч одсонд ямар нэг хий юм өөр дээр нь орж ирээд гарсан адил Ровена машид гайхан хоцорлоо. Энэ ер бусын гийчин бүсгүйн тухай гоо үзэсгэлэнт саксон авхай даруй нөхөртөө дуулгасанд авхайн яриа түүнд гүн их сэтгэгдэл төрүүлжээ.

Айвенго Ровенатайгаа удтал жаргалтай сайхан амьдарлаа. Ханилан суухын тулд төдий их зовлонт шалгавар үзсэндээ хоёр биенээ тэд улам ч их хайрлах бүлгээ.

Гэхдээ харин Ревеккагийн гоо сайхан өгөөмөр сэтгэлийн тухайд дурталгал Айвенгогийн санаанд Альфредийн удам угсаа үзэсгэлэнт бүсгүйд таалагдахаас илүүтэй олноор орж ирдэг байсан эсэхийг хэт тодорхой уудлан үзвэл осолтой билээ.

Ричардын үед Айвенго өөдрөгөөр албан хааж, түрүүчийн адил хааны өршөөл, хайрыг хүлээж байлаа. Арслан зоригт өөрөө Лиможийн ойролцоох Шалга цайзны дэргэд алагдаж зуурдаар таалал төгсөөгүйсөн болж гэм Айвенго хамгийн эрхэм дээд хүндэтгэлийг хүлээхсэн бизээ. Энэхүү өгөөмөр сэтгэлтэй авч болчимгүй явдалтай, халуун цочмог эрмэлзэлтэй хааныг нас барснаар Уильфред Айвенгогийн хамаг дээгүүр санаа эрмэлзэл нурж унасан бүлгээ. Ричардын өөрийн тухайд гэвэл Шведийн арван хоёрдугаар Карл хааны тухай Жонсоны бичсэн шүлэг яг онох ажээ.

Алс нэгэн цайзны дэргэд харь язгуурт

Алуурчны муу гарт тулалдаан дунд үрэгдэв

Алдар сүрт нэр нь хойч бидэнд

Ахуй явдлын сургамжит домог болон үлдэв.